ЗОНХАВА ЛУВСАНДАГВА

ИХ БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ



Улаанбаатар 2007 он

1
2
3
4
5
6
8
9
10
11

Монголын Бурханы Шашны Төв-Гандан Тэгчэнлин Хийд
Өндөр Гэгээн Занабазарын нэрэмжит Монголын Бурхан Шашны Их Сургууль
Азийн Буддистуудын Энхтайвны Бага Хурал

ЗОНХАВА ЛУВСАНДАГВА

ИХ БОДЬ МӨРИЙН ЗЭРЭГ



III дэвтэр
(Амарлингуй оршихуй ба үлэмж үзэхүй ухаан)

Түвд хэлнээс орчуулсан: доктор (Ph.D), гавж Т.Булган
Ариутган шүүсэн: гавж Ө.Гүндсамбуу
гавж Д.Цэрмаа
Эрдэм шинжилгээний зөвлөх:
академич Г.Лувсанцэрэн

Улаанбаатар 2007 он

"Цастын орны мэргэдийн оройн чимэг хэмээн алдаршсан Зонхава Лувсандагва (1357-1419) богдын туурвисан "Их бодь мөрийн зэрэг" хэмээх энэ их бүтээл нь "Гурван төрөлхтний мөр" буюу хүний оюун ухааны гурван их үе шатаар дамжуулан сэтгэл оюуны гэгээрэхүйн их хутагт хүрэх арга замыг Бурхан Буддхагийн заасан гэгээн үзэл онол, явдал мөрийн суртгаалд үндэслэн Хутагтын орны мэргэд дээдсийн оюуны бүтээлийн охь шимээр баяжуулан, хүний оюуны хөгжлийн дээд шатанд хүрэх арга замыг арга билгийн үүднээс тодорхойлон тайлбарласан гүн ухаан, оюун сэтгэлгээ, анхааран авах бясалгалын аньс шимийг хураасан оюуны их бүтээл болгөө"

Copyright © Т.Булган 2007
All rights reserved
No part of this work may be reproduced by any means
without the priority written permission of the publisher

"Их бодь мөрийн зэрэг" III дэвтэр, 2007

Түвд хэлнээс орчуулсан: доктор (Ph.D), гавж Т.Булган
Ариутган шүүсэн: гавж Ө.Гүндсамбуу
гавж Д.Цэрмаа
Эрдэм шинжилгээний зөвлөх:
академич Г.Лувсанцэрэн
Техник редактор: З.Эрдэнэжаргал
Компьютерт оруулж, хянасан: Э.Болор, Соёмбо, Баяраа, гэлэн Эрдэнэсайхан
Компьютерт эхийг бэлтгэсэн: С.Адъяа, З. Болдбаатар

ISBN

Хэвлэлийн эхийг "Нью Майнд" ХХК-д бэлтгэв. 2007 он

ГАРЧИГ

Удиртгал i
Редакторын үг xxii

[А] 1§ Амарлингуй оршихуй ба үлэмж билиг........ 1
2§ Бясалгалын бэлтгэл ажил........ 17
3§ Сэтгэлээ төвлөрүүлэх 35
4§ Живэл, дошигролыг амарлиулах нь 45
5§ Амарлингуй сэтгэлийг бясалгах нь 61
6§ Амарлингуй нь бодь мөрийн гишүүн болох нь 81

[Б] 7§ Үлэмж үзэхүйн ухаанд суралцах шаардлага 89
8§ Зөв эш сурвалжид шүтэх 95
9§ Үнэнийг ухаарах шатууд 101
10§Хоригдохуунутгаабуруутодорхойлсоннь........ 107
11§Шүтэнбарилдахуйбахоосончанар........ 115
12§Ухаанааршинжихнь........ 131
13§Шалгадагухаанаартогтоохнь........ 137
14§Хуранүйлдэхүйгшинжихнь........ 153
15§Хоригдохуунутгаабуруутайлбарласаннь........ 163
16§Хоригдохууныжинхэнэутга........ 169
17§ Өөрийн үндэст болон хэтрүүлэгч хоёрын ялгааг буруу тайлбарласан нь 187
18§ Өөрийн үндэст, хэтрүүлэгч хоёрын ялгааг буруу тайлсныг няцаах нь 193
19§ Өөрийн үндэст, хэтрүүлэгч хоёрын ялгааг тайлбарлах нь 207
20§Өөрийнүндэстийгшүүмжлэхнь........ 219
21§ "Модон тэрэг"-ийг шинжих нь 227
22§Өөрчлөнчанарүгүйбодгаль........ 237
23§Өөрчлөнчанараасхоосонбодасюмс........ 255
24§Үлэмжүзэхүйнялгал........ 271
25§ Амарлингуй, үйлэмж хоёр хослон орох нь 293
Ерөнхий утгын хураангуй 301
Очирт хөлгөнөө суралцахуй 303

Хавсралт 1 :
Түвд эх........ 309

Хавсралт 2 :

Дэлгэрэнгүй гарчиг 657
Ном зүй 663
Зарим үгийн тайлбар 676
Индекс 693
Ерөөлийн үг 695

УДИРТГАЛ

"Амарлин оршихуй болон үлэмж үзэх ухааныг бясалгахуй"

Эрхэм номын нөхөр, уншигч та бүхний оюун билгийн далай мэт хүү санд тань гэгээрэх хутагийн нэгэн дусал нэмэхээр санаа сэдэж, "Цастын мэргэдийн оройн чимэг" хэмээн алдаршсан Зонхова Лувсандагва (1357-1416) богдын туурвисан "Гурван төрөлхтний анхааран авахын эрэмбэ бүгдийг хоцроолгүй хураасан их бодь мөрийн зэрэгийн үүднээс төгөлдөр хувьтийг бурханы газраа хөтлөх ёсон ошвой" /"Их бодь мөрийн зэрэг" буюу "Ламрим чэнмо"/ хэмээх хүн төрөлхтөн тэргүүтэн эх болсон хамаг амьтныг мунхаг харанхуйн хүлээснээс гэтэлгэж, сэтгэл оюуны дээд амгаланд хүргэх, гэгээрэн хөгжих арга зам, уедис ухааныг тайлбарласан оюуны их бүтээлээс зарлигийн ханьцашгүй ачит сайн багш нараас сонссон эш номлол болон, олон мэргэд дээдсийн тайлбар, орчуулга зэрэгт дулдуйдан түшиж, гурван дэвтэрт багтааж, түвд хэлнээс эдүгээ цагийн монгол хэлнээ чадлын хэрээр хичээн орчуулан хүргэж байгаа билээ. Үүний өмнө 2004 болон 2006 онд уг бүтээлийн бага, дунд, их төрөлхтний гурван мөрийг хоёр боть болгож хэвлүүлж олны хүртээлд хүргэснийг мэргэн уншигч та бүхэн болгоох ажаам.

Энэ удаа эл их бүтээлийн "Сүүлийн хоёр барамидад суралцах ёс" буюу "Амарлин оршихуй ба үлэмж үзэхүйг бясалгахуй" хэмээх төгсгөлийн хоёр бүлгийг орчуулан барьж байна. Зонхава богд энэ бүлэгтээ урьд үзүүлсэн "Их төрөлхтний мөр"-ийн үргэлжлэл буюу бодьсадва нарын суралцах зургаан их явдал мөрийн сүүлийн хоёр болох "бясалгалын барамид" болон "билиг барамид" хоёрыг тусгайлан үзэж, гүн ухааны нарийн онол, арга зүйн үүднээс дэлгэрүүлэн тайлбарлажээ. Учир нь энэ хоёр мөрд гэгээрэхүй хутагийг олох арга билиг, сэтгэл бодрол, ухаарал, ойлголт, бясалгал бүтээл, үзэл онол зэргийг багтааж, буддын өөрийн ертөнцийг үзэх үзэл, философи сэтгэлгээний үүднээс үлэмж нягтлан тайлсан гүн ухааны бясалгал, онолын бүтээл болохыг дээрхийн олон мэргэд тодлон айлдсанаас илэрхий харагдана. Энд өгүүлэх "амарлин оршихуй бясалгал" нь жирийн нэгэн мод чулуу зэрэг дээр сэтгэлээ үзүүрсгэн төвлөрүүлэхээсээ илүүтэй, чухамдаа ертөнцийн зовлонг үүдэгч- мунхаг нисваанис бүхнийг арилгах буюу "Мэргэдийн" болон "Нисваансыг тийн арилгах" гэх зэрэг чухал хэрэг тустай зоригдол орон вишайг тухайлж, хэрхэн сэтгэл санаагаа зөв төвлөрүүлэх, улмаар сэтгэлийн ариусал, оюун ухааны зөв чиглэлд одох сэтгэлийн дадал, чадлыг эзэмших явдлыг "Тогтсон есөн сэтгэл" зэрэг бясалгалын арга ухааны үүднээс нээн үзүүлжээ. Мөн энд өгүүлэх "Үлэмж үзэхүйн ухаан" нь чухамдаа дээрх "амарлин оршихуй бясалгал"-ын зоригдол орон буюу бясалган бүтээх зүрхэн утга болсон шүтэн барилдахуй буюу хоосон чанарын утгыг оносон билиг ухаан юм. "Үлэмжийн чанар" гэдэг ердийн нэгэн чанар бус, чухамдаа ертөнцөд гутамшиг доройтол бүхнийг үүдэгч "минимхийлэн баригч", "би-д баригч" мунхаг сэтгэл," "бодьгалийн би буй", "номын би буй" гэх мэт үзэх "эдрэх" буруу" үзэл бүхнийг ёзоороос нь үлдэн дарагч болсон "шүтэн барилдахуй",," бодгалийн би үгүй чанар", "номын би үгүй чанар" хэмээгдэх хоосон чанарыг заажээ.

Эдгээрээс үндэслэн энэ бүлгийн агуулгыг нийтэд нь "Хоосон чанарыг онох бясалгал" гэж нэрлэмээр санагдана. Орчуулгыг оролдох явцдаа болон зарим уншигчид судлаачдын ирүүлсэн санал зэргээс сэдэвлэн, ялангуяа англи, орос зэрэг хэл дээр хэвлэгдсэн орчуулгын бүтээлүүдэд тулгуурлан бүлгүүдийн хуваарлалт, зарим

агуулгын утга санааг харьцуулж тусгасан болно. Мөхөс миний бие энэхүү их бүтээлийг орчуулах гэж мунгинах явцдаа уг их шастарын гүн агуу утгыг огт ухаараагүй, ухаарсан гэх ч буруугаар будилж зөрүүлсэн, эрхэм зарлиг шастаруудын үг утгын ялгааг оножмэдэхгүйгээс эргэж буцаж эргүүтсэн зэрэг түмэн зүйлийн алдас гэм байгаа тул эрхэм ухаантан мэргэд, уншигч, судлаач та бүгдийн өмнө түмэнтээ хүлцэл өчиж, алдаа оноог минь ариутган шүүж, ашдын номын цагаан үйлсэд минь тус болох авралт шүүмжлэл, ачит зөвлөгөө, санал бодол юугээ харамналгүй буулгахын айлтгал өргөмү.

Чингээд эл ботийн гүн нарийн утга санааг ойлгоход тустай дөхөмтэй болох болов уу гээд уг бүлгийн ерөнхий агуулгыг тоймлон сийрүүлж бичвэй. Болгоон соёрхоно уу.

АМАРЛИН ОРШИХУЙ БА ҮЛЭМЖ БИЛИГ

Энэ үест сүүлийн хоёр барамидад суралцах гэдэг нь бясалгал дияаны мөн чанарт "амарлин оршихуйг" болон билиг оюуны мөн чанарт "үлэмж үзэхүйн ухаан" хоёрыг бясалган бүтээх явдал ажээ. Тийнхүү тэр хоёрыг бясалгах явдал нь их төрөлхтөн нарын суралцан бүтээх бодьсадва нарын явдал мөр болсон зургаан барамидын дотор багтах бясалгал барамид болоод билиг барамид хэмээх сүүлийн хоёр барамидад тус тус хураагдана. Энд дээрх хоёр барамидад суралцан бясалгах ёсыг дараах үндсэн зургаан зүйлээр тайлбарлан үзүүлжээ. Үүнд:

А. Амарлингүй болоод үлэмж үзэхүйг бясалгах тус эрдэм: Ер нь их, бага хөлгөний ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөн эрдэм бүгдээр амарлингүй сэтгэл болоод үлэмж үзэхүй ухааны үрд төрдөг болохыг "Хутагт тааллын магад тайлбар"-аас: "Майдар аа, Аливаа Сонсоод сонсогчид, Бодисадва болон Ялгуусан бурхад нарын ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөн буянт эрдэм ном бүгдээр амарлин оршихуйг болоод үлэмж үзэхүй ухааныг бясалгасаны үрд төрнө" хэмээн мэдээрэй гэж зарлигласан буй.

Б. Амарлингүй болоод үлэмж үзэхүйд бясалгал бүхэн хураагдах ёс: Үлгэрлэвээс, Гол модонд салаа мөчир, навч, цэцэг, үр жимс гээд хэмжээлшгүй ихээр ургасан байна. Харин тэр бүгдээр ургах, оршихын аньс нь үндсэндээ байдаг адилаар, хэдийгээр их бага хөлгөнөөс айлдсан эрдэм бясалгал тоолшгүй олон байв ч, тэр бүгдийг багтаасан их аньс, үедис бүгдийн дээд нь амарлин оршихуй болоод болоод үлэмж үзэхүйд суралцан бясалгах мөн хэмээжээ.

В. Амарлингүй болоод үлэмж үзэхүйн мөн чанар: Тэр хоёрын чанарын талаар судар шастараас олонтаа айлдсан байна. Үүнд: Амарлингүйн мөн чанарын тухай "Тааллын тайлбар"-аас: "Тэрээр ганцаар аглагт оршиж, сэтгэлээ дотогшоо баттай тогтоох буюу сэтгэлээ сайтар бодох ёстой зоригдол орон (вишай) руу чиглүүлж үйлдэнэ. Алив сэтгэл чиглэсэн түүндээ анхааралтай сэтгэлээр хандана. Түүнийгээ үргэлжид сэтгэлдээ үйлдэнэ. Түүнийгээ улам цааш сэтгэлдээ үйлдэх болой. Тэр адилаар оршиж, олон дахин үйлдсээр "бие машид боловсрох" болон "сэтгэл машид боловсорох" бясалгал төрөх тэр цагт түүнийг амарлингүй сэтгэл (амарлин оршихуй) хэмээх буюу. Тэр адилаар бодисадва нар амарлингүйг баттай эрж үйлдэх мөн" хэмээн айлдсан дагуу болой. хэмээжээ.

Үлэмж билгийн мөн чанарын тухай дээрх "Судар"-аас: "Тэрхүү машид боловсорсон бие болон машид боловсорсон сэтгэлийн бясалгал тэдгээрийг олсны

дараа тэдгээрт оршиж, сэтгэлийн намба дүрийг огоорч, санах учиртай тэрхүү номоо, дотоод бясалгалын эдлэх орон буюу тусгал дүрс мэтээр болгоож тус тус оножс үйлдэх мөн. Тийнхүү бясалгалын эдлэх орон болсон тусгал дүрс тэдгээрийнхээ мэдэгдэхүүн утгыг тийн ялгах, сайтар тийн ялгах, огоот онох, огоот ажиглах, тэсвэрлэх, хүсэх, өвөрмөц онцлогийг ялгах, үзэх, шинжих, тийн мэдэх зэрэг тэр бүгдийг үлэмж үзэхүй хэмээмой. Тиймээс бодисадва нар үлэмж үзэхүйд мэргэн мөн хэмээн айлдсан болой". хэмээсэн байна.

Г. Амарлингүй болоод үлэмж үзэхүй хоёуланг бясалгах хэрэгтэйн учир : Чингээд юуны учир амарлингүй болоод үлэмж үзэхүйг хоёуланг бясалгах хэрэгтэй талаар иин айлджээ. "Үлгэрлэвээс, шөнө хана туурган дээрх зургийг харахаар зул барих үед зул нь машид тунгалаг болоод хөдөлгөөнгүй байх хоёр төгөлдөр байвал зураг маш тодорхой үзэгдэх болно. Зулын гэрэл тунгалаг тод боловч салхи үлээгээд байвал дүрс нь тод харагдахгүйн адил гүн гүнзгий утгыг мэдэхийн тулд хоосон чанарын утгыг зөв таньсан ухаан болоод зоригдол бодолдоо ёсчлон тогтсон сэтгэл хоёр төгс байж л хоосон чанарыг тодорхой үзнэ.

Сэтгэлдээ бусад зүйл рүү цацруулалгүй тогтоосон, үл атгаглах бясалгал байвч мөн чанараа мэдэх ухаан байхгүй бол хоосон чанарыг үзэх нүднээс хагацсан бясалгалыг хичнээн дадуулавч мөн чанарыг оножс мэдэхгүйд хүрдэг. Мөн би-үгүй буюу хоосон чанарыг ухаарч мэдсэн үзэл онолтой ч нэгэн үзүүрт батад тогтсон сэтгэл байхгүй аваас өөрийн эрхгүй хөдлөх атгагын хийгээр сэтгэл хямарч ахуй ёсны мөн чанарыг тодорхой мэдэж чадахгүй болно. Иймээс амарлингүй болон үзэхүй хоёулаа хэрэгтэй болно." хэмээсэн буй.

Д. Эрэмбэ зэргийг магадлах ёсон: "Бодичарияаватара"-гаас:

Машид амарлингүй төгөлдөр үлэмж үзэхүйгээр
Нисваанисыг тийн дарж үйлдэхийг мэдээд

Эхлээд амарлингүйг эрэлцэж үйлдэх хэмээн зарлиглан заасан тул амарлингүйг бүтээгээд цаашид түүнээ шүтэн байж үлэмж үзэхүйг бясалгах мөн. Е. Тус тусын ёсноо суралцах ёс:

А.АМАРЛИН ОРШИХУЙД СУРАЛЦАХ ЁС:

Бурууд одох сэтгэлийн зааныг
Бодлын багананд баттай аргамжиж
Банахуйн сураар сайтар хүлээд
Ухамсарын ташуураар зэрэгчлэн эрхшээ

"Төв үзлийн зүрхэн шастраас/

1. Амарлин оршихуйд суралцах ёс: а/ Амарлингүйн чуулганыг шүтэх /2-р бүлэгт/,б. Түүнээ шүтэж амарлингүйг бясалгах ёсон/2-5-р

бүлэгт/, вБясалгаж амарлингүй сэтгэлийг бүтээх хэмжээ/5-6-р бүлэгт/ а. Амарлингүйн чуулганыг зургаан зүйлээр үзүүлжээ. Үүнд:

1" Зохилдох оронд орших" гэдэг нь таван эрдэм төгөлдөр орон байна.а/ "Хоол унд, хувцас хунар тэргүүтэн төвөггүй хялбар олдох "сайн олзот" байх, б/ араатан

гөрөөс зэрэг догшин хүн, амьтан болоод дайсан этгээд үл орших "амгалан тайван газар" орших, в/ өвчин зовлон үүдэхгүй сайн хөрс шороот "сайн нөхцөлт нутагт амьдрах", г/ зөв ёс суртахуун болон зөв үзэл бодолтой зэрэг "сайн нөхөртэй нөхөрлөх", д/ өдөр олон хүнгүй, шөнө дуу чимээ багатай орон газар бол сайн болой.

2" Хүсэл шунал багатай байх гэдэг нь номын хувцас тэргүүтэн олон сайн сайхан зүйлд илүү шунахгүй байх явдал болно.

3" Ханах мэдэлтэй байх гэдэг нь номын хувцас хэр тааруу нэгийг олох зэргтээ үргэлжид ханах мэдэлтэй болой.

4" Элдэв ажлыг огоот тэвчих гэдэг нь арилжаа наймаа зэрэг тааруухан ажил болоод гэргийтэн ба хувраг нартай шадарлан ижилсэж нөхөрлөх ба эм барих, зурхай зурах тэргүүтнийг огоорох болно.

5" Шагшаавад ариун байх гэдэг нь тус тус гэтлгэгч болон бодисадвын санваар хоёулангийн өөрчлөн болон амлашгүйн сургаалын суурийг үл зөрчих ба хэрвээ сэрэмжгүйн эрхээр алдавч даруй түргэн гэмшиж номын ёсоор жич даруй засч үйлдэх болой.

6" Хүсэл шунал зэрэг асар атгагуудыг тийн огоорох нь алж хөнөөх, хүлж зодох зэрэг хүсэл шуналт сэтгэл зэргийн энэ насны гэм эргүү болоод муу заянд унагах зэрэг хойд насны гэм эргүү зэргийг эргэцүүлж санана.

2. БЯСАЛГАЛЫН БЭЛТГЭЛ АЖИЛ

Энэ үесийн амарлингүй бясалгах ёсыг 2-5-р бүлгүүд буюу "Бясалгалын бэлтгэл ажил", "Сэтгэлээ төвлөрүүлэх", "Живэл, дошигролыг амарлиулах" зэрэг бүлгүүд болон "Амарлингүй оршихуйг бясалгах" бүлгийн эхний хэсгүүдэд тус тус тайлбарлажээ. Бясалгал хийхэд биеийн явдал ямар байх талаар "Бясалгалын бэлтгэл" хэмээх хоёрдугар бүлэгт үзэхдээ: "Бясалгалын дунд болон сүүлчийн зэрэг"-ээс айлдсан мэтээр машид зөөлөн амар суудал дээр "найман ном төгөлдөр биеийн явдлыг" үйлдэх болой. Үүнд: 1" Хөлөө Вайрочана (Намбарнанзад) бурханы завилгаа мэт бүтэн завилгаа юмуу хагас завилгааны алин нэгээр үйлдэх мөн.,2" Нүдээ хэтэрхий их бүлтийлгэхгүй, хэтэрхий анилгүйгээр хамрын үзүүрт чиглэсэн байна.3" Биеийн хувьд хэтэрхий гэдийхгүй, хэтэрхий тонгойхгүй тэгшхэн шулуун суугаад дурдан санах сэтгэлээ дотроо агуулан сууна.4" Мөр нь тэгш тэнцүүхэн байна.5" Толгой нь их дээшээ биш, их доошоо биш ганцхан тал руугаа гудайлгахгүй, хамраасаа хүйсээ хүртэл тэгшлэн чиглүүлэнэ.6" Шүд, ам нь өөрийн байх байранд байлгана.7" Хэлээ дээд шүднийхээ дэргэд шахаж байрлуулна.8" Амьсгалаа гадагш, дотогш авахдаа дуу чимээ гаргах юм уу, хэтэрхий хэржигнүүлэх, хүчтэй амьсгалахгүй байх, юу боловч нааш цааш амьсгалах нь үл мэдэгдэх шахам, аажуу талбиун хүчлэлгүй амьсгалах мөн. "Сонсогчийн газар"-аас: Бурхадын зөвшөөрсөн ширээ, жижиг ширээ суудал болон өвс дэвссэн дэвсгэр дээр завилах зэргээр суухад таван учир шалтгаантай буй хэмээн айлджээ. Үүнд:

1. Биеэ сайтар хянаад явдал мөрдөө сурваас машид боловсрол төрөх ба мөн түүнтэй зохилдох нэгэн болж түргэнээс түргэн "машид боловсрох" эрдмүүд төрөх,2. Удаан хугацаанд сууж сурах ба тэрхүү явдалдаа бие алжаахаа болих,3. Эл явдал нь тэрсүүд гадны эсэргэлдэгч нарын явдалтай адилгүй нийт бусын болох,

4. Суудал үүнийг үзээд бусдад сүсэг төрөх,5. Эдгээр явдал мөрийг бурхан болоод бурханы сонсоод сонсогч нараас зөвшөөн шүтсэн зэрэг эдгээр таван учир

шалтгааныг мэдэж завилан суухыг зарлиглажээ. Биеэ тэгш шулуутган суух нь нойр хүрэх, балартах зэрэг төрөхгүйн тухайд айлджээ. Энэ мэтээр эхлээд биеийн найман явдал болоод ялангуяа, хийн хэмжээг хэрхэн тааруулах ёсоор бүтээгээрэй.

Бясалгалын зоригдол: Бясалгалын зоригдол орны талаар Бурхан бээр дөрвөн зүйл бий гэж үйлджээ. Үүнд:/а/ Түгээмэл зоригдол,/б/ Явдлыг ариусгах зоригдол,/в/ Мэргэдийн зоригдол,/г/ Нисваанисыг тийн арилгах зоригдол болой.

"Мэргэдийн зоригдолууд" нь эдгээр номоос ангид "бодгалийн би"-г хоридог учир "би-үгүй"-г онох үлэмж үзэхүйн ухаан төрөхөд даган зохилдох амарлингүйн зоригдохуун орон болдгоороо маш ач холбогдолтой."Нисваанисын асар арилгах зоригдолууд" нь нисваанисын үндсэн ерөндөг болдог учраас их чухал билээ. хэмээжээ.

3. СЭТГЭЛЭЭ ТӨВЛӨРҮҮЛЭХ:

Хэрхэн сэтгэлдээ түүнийг тушаах ёсон: "Бясалгал дияан гэдэг нь бодол зоригдохуун дээрээ нэгэн үзүүрт болж орших хувь юм. Энэ нь бодол зоригдохуундаа үргэлжид тогтох нэгэн хэрэгтэй гэсэн утга буюу.

Дурдан санах сэтгэл доройтвоос бодох юмаа мартаж алгасраад тэр даруйд бодол санаа алдагдах тул бодол зорилгоо үл мартах, дурдан санах нь язгуур болно. Дурдан санах сэтгэл нь зоригдохуун орноо ойртуулахдаа дээр номносон мэт бодлын шүтээнээ тодруулах буюу наанадаж ургуулах төдий төсөөлөн мэдэх, аажмаар барих орноо хүчтэйгээр мэдрүүлж өгнө. Харин сэтгэлийг нөрдөн урамшуулах юм уу, шинээр олон зүйлийг шинжлэхгүй зөвхөн тогтоох болой. Дурдан санахуйн талаар "Хотол хураангуй"-гаас: Дурдан санахуй гэж юу вэ? Мэдсэн зүйлээ санах, сэтгэлдээ мартахгүй байх болон алгасарахгүй байх үйлт болой" хэмээн гурван ялгамжаа төгөлдөр болохыг айлджээ.

Үлгэрлэвээс, Их догшин зааныг маш бөх бат модонд юмуу, багананд маш бөх, хатуу сураар аргамжин байж, заан сургагч нэгэн түүнийг номхруулж сургах адилаар үйлдвээс сайн. Бүр эс болвол нарийн сур, ташуур зэргээр дахин дахин цохиж, зодсоор номхруулдаг мэт. Эмнэг догшин их заантай адил сэтгэл түүнийг дээр номносон мэт "бодол зоригдлын бат багананд санахуйн сураар хүлээд, түүнээ үл тогтон сууваас ухамсарын дэгээгээр урхидан авчраад ягуу ягуухнаар эрхшээн үйлдэх хэмээсэн ба, "Төв үзлийн зүрхэн"-ээс

Буруүд одох сэтгэлийн зааныг
Бодлын багананд бат бэх аргамжаад
Ханахуйн сураар сайтар хүлээд
Ухамсарын ташуураар зэрэгчлэн эрхшээ хэмээх зэргээр айлдсан буй.

4. ЖИВЭЛ,ДОШИГРОЛЫГ АМАРЛИУЛАХ НЬ:

Дошигролын тухай "Хотол хургаангуй"-гаас: "Дошигрол гэж юу вэ? Гуа сайхан бэлгэ шинжийн дагалдан явах хүсэл шуналын аймагт багтаж сэтгэлийг үл амарлиулах ба амарлингүй сэтгэлийг тогторлох үйлт" хэмээн тодорхойлжээ. Түүнээ гурван зүйл буйгаас (1) Сэтгэлд таатай, гуа сайхан вишайнууд, (2)Намба төрхийн хувьд сэтгэл огт тогтворгүй буюу гадагш сарнисан хүсэл шуналын аймгийн нэгэн хувьт болох тул шунах байдлаар зоригдолдоо хандах байдлууд, (3) Чадлын хувьд сэтгэл санаа бодож

буй зүйл рүүгээ чиглэж тогтоход саад хийдэг. Сэтгэл бодлын орон руугаа хандах гэтэл дүрс, дуу зэрэгт шунах догшигрол төрснөөр өөрийн эрхгүй тэдэнд сэтгэл татагдан, алгасарч одно.

"Живэл" нь сэтгэл бодлын орноо барих нь суларч, бодож буй зүйлээ маш тодорхой буюу баттай мэдэхээ больж, улмаар хэдий сэтгэлийн тунгалаг хувь байвч бодол зоригдохуун нь ямар ч тодорхойгүй болсноор живэл төрдөг байна. "Бясалгалын дунд зэрэг"-ээс ч: "Хэзээ нэгтээ харалган сохор байх юм уу, харанхуйд орсон хүн шиг байх юм уу, эсвээс нүдээ аних зэрэг тохиолдолд сэтгэлд бодлын орон тодорхойгүй болж үзэгдэж харагдахгүй болох тэр цагт живэл болно гэж ухаараарай хэмээжээ.

Сэтгэлээ танин барьж живэл, дошигролыг хорих: Асуулт: Чингэж живэл, дошигролыг хорихын тулд сэтгэлээ илт өдөөснөөр хэрхэн тэр хоёрыг хорих вэ? Хариулт: Сэтгэлийн живэх байдал хэтэрхий дотогшоо хураагдан лавширснаар бодлын орноо алдахад хүрдэг. Тийм нөхцөлд сэтгэлээ гадагш цацруулахын үндэс болсон (сэтгэл сэргээх) баясалгалант зүйлийг сэтгэлдээ бодох хэрэгтэй. Жишээ нь, бурханы үзэсгэлэнт лагшинг харах гэх мэтээр. Гэхдээ нисваанис төрөх зугаа цэнгэлийг бус болой. Мөн нарны гэрэл гэгээ зэргийг сэтгэлд ургуулан бодвоос живлээс сэргэж ирдэг.

Тиймд живлийг дарахад чухал эрөндөг гэвэл чухаг дээд гурав болон бодь сэтгэлийн тус эрдэм болон чөлөө учралыг олохын тус эрдэм зэргийг дурдан санаж, нойр хүрч зүүрмэглэвээс хүйтэн усаар шавшиж толгойгоо сэргээх зэргээр суралцах хэрэгтэй. Эдгээр нь тус эрдмийн зүгийг тус тус ажиглах, шинжлэх бясалгалын чадал олсонтой харгалзана. Хэрхэн тэр бясалгалыг төрүүлэх вэ? Таван гэмийг тэвчихийн үүднээс найман хуран үйлдэхүйг шүтэх үндэсээс төрөх болой. Таван гэм нь: Бэлтгэлийн үест залхуу гэмтэй буюу. Тэрээр бясалгалыг холбож нийлүүлдэггүй учраас. Бясалгалд хичээхийн үест үвдисаа умартах нь гэмтэй буюу. Зоригдохуунаа умартваас сэтгэлээ бодолдоо тэгш агуулж чадахгүй. Тэгш агуулахад живэл, дошигрол гэмтэй буюу. Тэр хоёр бээр сэтгэлийг (үйлнээ) эдлэхүүн болгохгүй учраас. Живэл дошигрол гарсан үед үл хичээх нь гэмт мөн. Чингэснээр тэр хоёрыг амарлиулж үл чадна. Живэл, дошигролоос хагацсан цагт хуран үйлдэх сэтгэл гэмт буюу. Живэл, дошигрол хоёрыг нэг гэж тоолвол тав болно. Тус тус тоолвол зургаан гэм ч болохыг "Бясалгалын зэрэг"-ээс айлджээ.

Тэдгээрийн эрөндөг болсон "хуран үйлдэх найман тэвчил" зэргээс залхуугийн эрөндөгт сүсэг, эрмэлзлэл, чармайлт, машид боловсорсон эдгээр дөрвөн зүйл бий. Цаашлаад умартах; живэл, дошигрол, хуран үл үйлдэх; хуран үйлдэхийн эрөндөгт дурдан санах; живэл, дошигролыг онох ухамсар, хуран үйлдэхийг бат агуулах; тэгш агуулах зэргээр тус тус байна.

5. АМАРЛИН ОРШИХУЙГ БЯСАЛГАХ НЬ:

"Амирлан оршихуйг бясалгах " хэмээх тавдугаар бүлэгт энэ үесийн жинхэнэ бясалгалын ёсыг (2) Түүнээ шүтэж оршсон сэтгэл төрөхийн эрэмбэ зэрэгт (а) Оршсон/ тогтсон/ сэтгэл төрөх бодит эрэмбэ зэрэг,(б) Түүнийг зургаан хүчээр бүтээх ёсон,(в) Түүнээ дөрвөн сэтгэлд үйлдэгч байхын ёсон гэсэн гурван зүйлээр тус тус заасан

байна. Үүнд:

(а) Есөн тогтсон сэтгэл төрөх зэрэг :

1. "Тэр хийгээд түүнээ сэтгэлээ агуулах" нь гадна талын орон бүхнээс сэтгэлээ үнэхээр хурааж дотоод бодолдоо чиглүүлэх (тушаах) явдал болно. 2. "Үргэлжид агуулах" нь сэтгэл анхлан чиглэсэн зүйлээсээ өөр зүйл рүү алгасрахгүй байх ба тэр бодол дээрээ үргэлжид тогтох буюу. Түүний үргэлжлэлд алгасрахгүй байх хэмээжээ. 3. "Барин авч агуулах" нь умартаж алгасрах ба гадагш алгасарч байгааг мэдээд жич дахин бодолдоо хадах явдал мөн. "Алгасарч буйгаа түргэн ухаараад Түүнийг жич дахин барьж үйлдэх" хэмээжээ. 4. "Ойр агуулах" нь, "Бясалгалын анхны зэрэг"-ээс: Өмнөх сэтгэлийн алгасралыг мэдэж тэвчих ба сэтгэлээр алгасрахыг тэвчиж тэрхүү бодолдоо шамдан агуулах хэмээсэн буй. 5. "Номхотгон үйлдэх" нь бясалгал дияаны тус эрдмийг санаж түүнийг бясалгах явдал болно. ["Судрын аймгийн чимэг"-ээс] "Чингээд тус эрдэмтэйг ухаарснаар, Бясалгал дияанаар сэтгэлээ номхотгох хэмээжээ. "Сонсогчийн газар"-аас: Дүрс тэргүүтэн таван орон, гурван хор, эр, эмийн шинж алин нэгнээ сэтгэл алгасардаг. Эхнээс л тэдгээрийн гэм буруутайд бариад тэдгээр арван зүйлд сэтгэлээ сарниулахыг зөвшөөрөхгүй байхыг номножээ. 6. "Амарлиулан үйлдэх" нь алгасрах буруутай зүйл гэж үзээд, бясалгалд үл баясах явдлыг амарлиулах явдал билээ. ["Судрын аймгийн чимэг"-ээс] Алгасрахуйг гэмтэйд үзэх учир, Түүнээ үл баясахыг амарлиулан үйлдэх хэмээжээ. 7. "Тийн амарлиулан үйлдэх" нь шунах тачаах, амгалангүй сэтгэл төрөх, балартах, нойр хүрэх байдал зэрэг гарваас түргэн амарлиулан үйлдэх мөн. ["Судрын аймгийн чимэг"-ээс] Шунах, зовинох зэрэг сэтгэлүүд, Сэргэвээс тэр даруй амарлиулж үйлдэх буюу хэмээжээ. 8. "Нэгэн үзүүрт үйлдэх" нь ямарваа шамдлагагүйгээр орохын тухайд шамдах явдал болно. ["Судрын аймгийн чимэг"-ээс] Чингээд боомтлон хичээх бээр, Сэтгэлд илт хуран үйлдэх зэргээр, Өөрөө өөрийн аясаар гарсныг олох хэмээжээ. 9. "Тэгш агуулах" нь Сэтгэл тэгширч тэгш агуулан үйлдэх мөн гэж "Бясалгалын зэрэг"-ээс айлдсан билээ. "Нэг дамжлагад үйлдэхүйг" дадуулсаар ая зөндөө өөрийн эрхээр орох ба өөрийн эрхтэй болчихсон байдаг гэж "Барамидын үвдис"-аас айлджээ.

(б) Түүнийг зургаан хүчээр бүтээх ёсон: "Зургаан хүч" болвоос 1 Сонсохын хүч, 2* Санааны хүч, 3* Дурдан санах хүч, 4* Ухамсарлах хүч, 5* Хичээнгүйн хүч, 6* Огоот ижилсэх хүч болой. Тэдгээр нь ямар сэтгэлийг бүтээх ёсны хувьд гэвэл, 1* Сонсохын хүчнээс "агуулах сэтгэл" төрдөг. Сэтгэлээ сэтгэхүүн дээрээ агуулах үвдисыг бусдаас сонсох төдийд даган барих ба анхандаа сэтгэхүүн бодолдоо чиглэх төдий байдаг. Учир нь өөрөө дахин дахин санаж, дадаж сураагүй үе байдаг. 2* Санааны хүчнээс "үргэлжид агуулах сэтгэл" төрдөг. Анхалж бодолдоо чиглэсэн байдлаа үргэлжлүүлэн дахин дахин санаж суралцсанаар, үргэлжлэл өчүүхэн төдийд золгож чадах чадлыг эхлэн олж байгаа үе болой. 3* Дурдан санахын хүчээр "барин агуулах сэтгэл" болоод "шадар агуулах хоёр сэтгэл" төрнө. Сэтгэхүүн бодолдоо алгасран алгасраваас өмнөх бодлоо санаж дотогш хураана. Эхнээсээ л санах хүчийг гаргаваас бодлоосоо алгасарах явдал гарахгүй болой. 4* Ухамсарлах хүчээр "номхотгох" болон "амарлиулан үйлдэх хоёр сэтгэл" төрнө. Атгаг сэжиг, шадар нисваанисын бэлгэст сарних явдлын гэмийг ухамсарлаж гэм бурууг үзэх тул тэр хоёрт сарних явдлыг гаргахгүй болно. 5* Хичээнгүйн хүчээр "асар атгаг амарлих" ба "нэг үзүүрт үйлдэх хоёр сэтгэл" үүсдэг. Атгаг ажиг сэжиг болоод шадар нисваанис нарийн гарахад ч хичээнгүйлэн тэвчиж зөнд нь үл тавина. Тэр мэтээр үйлдсэнээр живэл, дошигрол зэрэг нь бясалгалд тотгорлож*

чадахаа больж, ургэлжид бясалгал диян төрөх болдог. 6 Огоот ижилсэх хүчээр "тэгш агуулах сэтгэл" бүтдэг. Өмнөх явдалд ихэд дадаж ирсний хүчээр шамдлагагүй ая зөндөө бясалгал төрнө. Тэдгээр нь "Сонсогчийн газрын"-ын таалал дагуу мөн. Үүнээс өөрөөр номносон үзэгдэвч сэтгэл итгэж бүү үйлд.*

(в) Түүнээ дөрвөн сэтгэлд үйлдэгч байхын ёсон : "Сонсогчийн газар"-аас "Тэрхүү есөн оршсон сэтгэлд дөрвөн сэтгэлдээ үйлдэхүй (анхаарал) байдаг гэж мэдээрэй. (1) Хянан орох, (2) Завсарт тотгорлож орох, (3)Тухайн үест тотгоргүй орох, (4) Ая зөнд бүтээн (шамдалгүйгээр) орох эдгээр болой. Тэрхүү агуулан орох ба үнэхээр агуулан үйлдэх хоёрт "хянан орох сэтгэлд үйлдэхүй" байна. Хураангуйлан агуулан үйлдэх, ойр агуулан үйлдэх, номхотгон үйлдэх, амарлиулан үйлдэх, ойр амарлиулан үйлдэхэд зэрэгт (тавд) "завсарт тотгорлон орох сэтгэлдээ үйлдэхүй" байна. Нэгэн дамжлагаар үйлдэхүйд "үест тотгоргүй орох сэтгэлд үйлдэхүй" байна. Бясалгалд хуран үйлдэхүйд "шамдалгүйгээр орох сэтгэлд үйлдэхүй байна хэмээжээ.

6. АМАРЛИНГУЙ НЬ БОДЬ МӨРИЙН ГИШҮҮН БОЛОХ НЬ

Бэлэг чанарыг тус тус мэдэх үүднээс бүдүүн байдалт мөрийг бясалгахад өмнө заавал дээр номносон амарлангуй сэтгэл түүнийг олсон байх шаардлагатай. Есөн сэтгэлээс эхлээд сэтгэлдээ үйлдэхүйг эс олох хүртэлхийг сэтгэлдээ үйлдэхүйн үйлийн анхдагч болдог. Сэтгэлдээ үйлдэхүйг олоод нисванисаа арилгахаар бэлэг чанарыг тус тус онох сэтгэлдээ үйлдэхүйг бясалгахуйг нисванисаа тийн арилгагч үйлийн анхдагч гэж зарлиглажээ. Иймд бэлэг чанарыг тус тус мэдэхээр бясалгахад өмнө нь сэтгэлдээ үйлдэхүйг олох мөн.

..."Газрын бодит суурь"-т эш татсанаар Хүсэлт ертөнцийн нэгэн үзүүртэд машид боловсрол байхгүй ч, машид боловсрол олоогүй байхад амарлангуй сэтгэл төрөхгүй гэж "Тааллын тайлбар" тэргүүтнээс айлдсан бий. б) Амарлингуй сэтгэлд шүтэж хүсэл шуналаас ангижрах ёсон: Хүсэл шуналыг тэвчих анхдугаар дияаны орныг олохыг хүсвээс л амарлингуй түүнээ шүтсэн үлэмж үзэхүй ухааныг бясалгана. Ертөнцөд "би-үгүй" үзэл өчүүхэн ч байхгүй гадаад номтон (тэрсүүд) болоод "би-үгүй" үзэл төгөлдөр энэ номынхон гэж хоёр буй. Асуулт: "Би-үгүйн"- утгыг бясалгаад нисваанисыг тэвчиж эс чадваас юуг нотлон буулгаж утгыг бясалгаснаар нисваанисыг тэвчих вэ? Хариулт: Ийм мөрөөр хүсэлт орны ил нисваанис бас бусыг тэвчиж болом за. Гэхдээ "хүсэл шуналаас хагацах" хэмээсэн тул гол нь хүсэл шуналын өрөндөг болгох үүднээс тэвчих шаардлагатай. Хүсэл шунал гэдэг энэ үест хүслийн таван эрдэмд шунаж тачаах мөн тул түүний өрөндөг болгож олон талаас нь хүслийн эрдмийг гэмтэй гэж үзээд тэрхүү шунал тачаалын баригдахуун орныг няцаахын үүднээс бясалгаж үйлдсээр хүсэл шуналаас ангижирна. Хэдийгээр хүслийн гэм болоод анхдугаар дияаны эрдмийг эндүүрэлгүй тус тус онох буюу бэлэг чанарыг тус тус онох магадлал баттай байвч өмнө нь амарлингуй сэтгэл төрөөгүй байвал гэм, эрдэм тэр хоёрыг шинжилж хичнээн бясалгасан ч нисваанисыг тэвчиж үл чадна. Мөн амарлингуйг бүтээсэн ч тус тус шинжлэн эс үйлдвээс хичнээн бясалгавч нисваанисыг тэвчин үл чадах тул амарлингуй болон үлэмж хоёуланг бясалгахын үүднээс тэвчих хэрэгтэй. Энэ бүгд бол нисваанисыг тэвчих ерөнхий агуулга болой....Тэр мэтийн Дияаны дөрвөн орны болон дүрсгүй дөрвөн орны диян бясалгалууд болон таван зөн мэдэл зэрэг нь гадаад, дотоод нийтийнх мөн тул хэдий тэр адилын онцлог ялгаатай диян бясалгалыг олсон

ч тэр төдийгээр орчлонгоос гэтлэхгүй. Түүгээр барахгүй тэдгээр нь зовлонд хүлэгч мөн тул зөвхөн амарлих сэтгэл төдийгээ ханан мэдэж хязгаарлалгүй, тус тус онох үлэмж үзэхүй буюу "би-үгүй" үзлийг эрэлцээрэй. хэмээжээ.

Б. Үлэмж үзэхүй ухаанд суралцах ёс:

Алин шалтгаанаас төрөх тэр л үл төрөх буюу
Тийм болвоос л түүнээ өвсбээн чанар буй бус
Алин шалтгаанд харгалзах түүнийг хоосондномнов
Алин хоосон чанарыг түүгээр жиших буй.

/Мадойва лусын айлтгасан судраас/

7.ҮЛЭМЖ ҮЗЭХҮЙН УХААНД СУРАЛЦАХ ШААРДЛАГА:

а. Үлэмж үзэхүйн чуулганыг шүтэх: Эрхэм зарлиг бүхний аньсыг эндүүрэггүй болгоосон мэргэдийг шүтэж хиргүй гол ном судрыг сонсоно. Сонсох, санахын ухаанаар хоосон чанарыг онох үзэл онолтой болох явдал нь заавал байх шаардлагатай үлэмж үзэхүйн үндсэн нөхцөл шалтгаан бөлгөө. "Ахуй ёс"-ны утгыг "эцсийг нь хүртэл мухарлах үзэл онол байхгүй бол" үнэмлэхүй утгыг онох үлэмж үзэхүйн ухаан төрнө гэж байхгүй. Энэ адилын үзэл онолыг гүлзгай утганд үл итгэх, магад утганаа итгэх итгэлээр эрэх хэрэгтэй. Тиймд гүлзгай ба магад утгын ялгааг ухаж магад утгат эрхэм зарлигийн утгыг оножмэдэх хэрэгтэй.

Гэвч шалгадаг төрөлхтөн болсон "Их тэрэгчний ёсыг нээгч" дээдэс нарын зарлиг таалдыг тайлсан шастар ном, эш сурвалжийг үл шүтвээс хөтөчгүй харалган хүн аюул осолтой газар руу дөтлөх адил болно. Иймд эндүүрэггүй таалдын тайлбарыг судалж үзээрэй.

8. ЗӨВ ЭШ СУРВАЛЖИД ШҮТЭХ

1.Гүлзгай (удирдахуй) утгат болон магад утгат эрхэм зарлигийг ялгаж мэдэх: Хоосон чанарыг мэдэхийг хүсэгчид Ялгуугсаны эрхэм зарлигийг шүтэх хэрэгтэй. Элдэв шавь нарын санааны эрхээр эрхэм зарлиг ч олон янз байдаг тул ямар зарлигийг шүтэж гүн гүнзгий утгыг судлах вэ? Магад утгат эрхэм зарлигийг шүтэж хоосон чанарыг онох учиртай.Чингэвэл магад утгат гэж юуг хэлэх, бас гүлзгай утгат гэж алиныг хэлэх вэ? Өгүүлж буй утгын үүднээс эдгээрийг ялгана. "Үнэмлэхүй утгыг зааснаар магад утгат гэх ба янагуухүй утгыг заасан бол гүлзгай утгаж зарлиг" гэж үзнэ. Ийм болохыг "Лодоймэсадвын үзүүлсэн судар"-т айлдахдаа: Магад утгат судрын аймаг гэж алин бэ? Гүлзгай утгат судрын аймаг гэж алин бэ? Алин янагуухүй утгыг заан үзүүлсэн судар тэдгээр нь гүлзгай утгат хэмээмой. Алин үнэмлэхүйг зааж үзүүлсэн тэдгээр нь магад утгат хэмээмой. Алин үг, үсэг элдэв зүйлийг заасан тэдгээр судрууд гүлзгай утгат болой. Алин гүнзгий тул ухахад бэрхийг үзүүлсэн тэдгээр нь магад утгат хэмээмой хэмээжээ.

2) Нагаржуна(й) гэгээний таалдын тайлбар хэрхэн гарсан тухай: Чухам ямар таалдын тайлбар номыг шүтэх вэ? Ялж төгөлдөр нөгчигсөн бурханы шашин номын

зүрхэн болсон "буй үгүй"-н туйлшрал бүхнээс хагацсан гүн гүнзгий утгыг тайлбарлав хэмээн олон судар, тантраас сайтар тодорхойлж эш бошиг үзүүлсэн гурван газраа Нагаржуна гэгээн (төв: Лүдүв, монг: Лусын бүтээлчин) хэмээн төгс алдаршсан түүний шастаруудыг шүтэх бөлгөө. Түүний гол эш номонд шүтэж, хоосон чанарыг онох ухааныг бясалгах хэрэгтэй. Буддын тогтсон таалын аймгийн Төв үзлийн философийн / Мадхьямика/ их сэтгэгчид болох Буддхапалита (Санжайжан), Бхававивека (Лэгданжэд), Чандракирти (Даваадагва), Шантаракшида (Шиванцо) нараас Арьядэва (Пагвалха) гэгээнийг Нагаржуна багштай адил болгоолт хэмээн нотолсон бий. Тиймээс урьдын дээдэс бээр "Эцэг, хөвгүүн" тэр хоёрыг бусад төв үзэлтэн нарынхаа "Анхдагч" буюу "Эх гол номын төв үзэлтэн" хэмээж бусдыг нь "Зүгийг баригч төв үзэлтэн" гэдэг. Төв үзлийн аймгийг дотор нь "Хэтрүүлэгч" (төв: Талжүрва, самг: Прасангика) болон "Өөрийн үндэст" (төв: Ранжүдва, самг: Свантантрика) гэж хоёр ангилж "Тодорхой үг" (Pasana-pada)-тээс тодорхойлсон буй.

9. ҮНЭНИЙГ УХААРАХ ШАТУУД

3) Хоосон чанарын үзлийг нотлон буулгах ёсон: Хоосон чанарыг онохын тулд эхлээд орчлонгийн гэм эргүүг санаж сэтгэл ганграх ба улмаар түүнийг орхих бодол төрсөн байх чухал. Чингэхдээ зовлонгийн (самсара) үндсийг буцаахгүй бол түүнийг огоорч чадахгүй нь ойлгомжтой тул сансрын үндэс гэж юу болохыг тунгааж мэднэ. Ийнхүү "эвдрэх үзэл буюу мунхаг сэтгэл" нь зовлонгийн үндэс болохыг сайтар ухаж мэдээд түүнийг бүр ёзоороос гаргаж хаях, тэвчих бодлыг баттай төрүүлэх учиртай. Тэрхүү "эвдрэх үзлийг буцаана" гэхэд, түүнийг барих "би"-г байхгүй болохыг онох ухаан төрөх эсэхээс хамааарна гэж ойлгож ирвэл нөгөөх "би"-гээ хаах хэрэгтэй гэж үзэх болно. "Би"-г буй гэхэд эсэргүүцэгч ба үгүйсгэж нотлох эш үндэслэл, учир шалтгаан зэрэгт түшиглэн байж магадлал нэгнийг олно гэдэг нирвааныг хүсэгчдэд зайлшгүй байх ёстой арга билээ. Тийнхүү би болоод минийх хэмээх мөн чанар огт байхгүйг таньсан үзлийг олж, тэрхүү утгыг дадуулж бясалгаснаар номын лагшинг олно.

10. ХОРИГДОХУУН УТГАА БУРУУ ТОДОРХОЙЛСОН НЬ

б) Хоосон чанарыг бодитой нотлон буулгах: (а) Хоригдохуунаа сайтар мэдэхийн учир шалтгаан : Үлгэрлэвээс "Энэхүү бодгаль буй бус" гэдгийг мэдэхийн тулд үгүйсгэгдэх үндэс болсон тэрхүү бодгаль чухам яагаад буй болох" болсныг мэдэх хэрэгтэйн адилаар, "би-үгүй" болоод "өөрийн мөн чанар үгүй" хэмээх утгыг онохын тулд ч үгүйсгэгдэх үндэс болсон "би" болоод "өөрийн мөн чанар" хэмээх тэдгээр учрыг сайтар тунгааж ойлгох хэрэгтэй. Ер нь хоригдохуун утгаа сайн ухаарахгүй бол хэдий үгүйсгэвч утгаа зөвөөр магадалж чадахгүйд хүрдэг учиртай. "Бодисадвын явдалд орохуй"-гаас: Нэрийдсэн утгаа эс ухаарваас, Түүний бодит бус утгыг барих бус" хэмээн айлдсан мэт болой. Чингэхлээр хоригдохуунаа сайтар ойлгож авах нь маш хэрэгтэй. Түүнийг эс мэдвээс л нэг бол мөнхийн үзэл, нөгөө бол тасархайн үзэл лавтайяа төрдөг байна. 1/ Хоригдохуунаа хэтэрхий хэтрүүлэн тайлбарласныг хорих, 2/ Хоригдохуунаа

хэтэрхий явцуу тайлбарласныг хорих болой.

а/ Үзэл баримтлалыг өгүүлэх: Иймийн учир үзэл онолыг нотлон буулгах ёс болвоос энд үзүүлэх хоёр үнэнийг магадлан ухаарах явдал билээ. Үүнийг төв үзэлтнээс бусад бодгаль хэн бүхэн харшуулж үзэх бөгөөд үл харшлах ёсыг олж чадаагүй байна. Нарийн ухаарал, саруул оюун төгөлдөр мэргэн ухаант Төв үзэлт хэмээх тэрбээр хоёр үнэнийг онох аргад мэргэн тул огт харшлахын хиргүйгээр нотлон буулгаж ялгуугсаны таалалын оройд хүрсэн бөлгөө. Түүнээ шүтэн байж өөрийн багш болон номонд машид гайхамшигт бишрэл хүндэтгэл төрсөн учраас гулзгай хуудам гэмээс ангижирсан болно. Иймээс "Ухаантан нар аа" Өөрийн мөн чанараар хоосон байх гэдэг чинь шүтэн барилдаж гарсан утга мөн буюу. Тус хэрэг үйлдэх чадлаас хоосорсон бодас байхгүй гэсэн утга бус болой" хэмээн яруу тод дуугаар дахин дахин дуурсган зохиодог.

б/ Тэдгээр нь үл таарах ёсыг үзүүлэх: Харин ухааны олон оронд сайтар мэргэжээгүй манай аймгийн бодит өгүүлэгч нар Төв үзлийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд тэд "хамаг ном өөрийн мөн чанараар ерөөс бүтэхгүй хоосон болчихвол хүлээс тонилохуй зэрэг сансар, нирваны ухагдахуун бүгдийг томъёолж болохгүйд хүрнэ" гээд зөвхөн энэ тал дээр Төв үзэлтэнтэй тэмцэлддэг. Ийнхүү Бодит өгүүлэгч болоод Төв үзэлтэн хоёр нийт бусын тогтсон таалалын ёсны онолын хувьд тэмцэлдэх буюу. Мөн чанараар хоосон болоход (үүнд) сансар нирваны ухагдахуун бүгд агуулагдаж болох уу? үгүй юу гэдэг зөвхөн энэ асуудал дээр л тэмцэж иржээ. Өөрийн мөн чанараар бүтэх гэдэг тоосон төдий байхгүй хэдий ч, төрөгдөхүүн ба төрүүлэгч, хаах ба бүтээх зэрэг сансар, нирваны агуулга бүгд оршин байж болохыг хүлээн зөвшөөрөх нь Төв үзлийн гол онцлог ялгамжаа юм. "Хорин дөрөвдүгээр бүлэг"-ээс: Алин шүтэн барилдаж гарсан түүнийг, Хоосон чанарт хэмээн номложээ, Тэр нь шүтэж оршихыг нэрлэсэн агаад, Тэр нь Төв мөр мөн болой, Алин шүтэж эс гараагүй, Ном хаана ч үгүй, Тиймээс хоосон чанаргүй, Ном хаана ч үгүй буюу" хэмээж шүтэн барилдаж гарсан л бол өөрийн мөн чанараар хоосон болох, шүтэн барилдсан мөн учраас л зөвхөн өөрийн мөн чанараас хоосон болохыг зарлиглажээ. Ийнхүү шүтэн барилдахуйн утга болвоос өөрийн мөн чанаргүй хоосон чанарын утга мөн хэмээх номнол нь Хутагт Нагаржунай багшийн нийт (ер) бусын ёс болой.

11. ШҮТЭН БАРИЛДАХУЙ БА ХООСОН ЧАНАР

/а/ Төв үзэлтний ялгамжааг танин барих: Чингэвээс хоосон чанарыг баримтлах ёсноо сансар, нирваан бүгдээр хэрхэн таарах вэ? Хамаг бодасыг өөрийн мөн чанараар хоосон гэж өгүүлэх нь шүтэн барилдаж гарсан тул ийн өгүүлж тийн номносон болой. Тиймээс шүтэн барилдах тэр утганд л таарах хэрэг. Тийн таарах учраас зовлон ч оршиж таарна. Зовлон гэдэг шалтгаан нөхцөлд шүтэн байж л үүддэг учиртай. Шүтэн барилдаж гараагүй бол зовлон гэж орших учиргүй. "Тэмцлийг няцаагч"-аас:

Алин шүтэн барилдаж гарсан бодас
Тэдгээр л хоосон чанарт хэмээгдэх ба
Алин шүтэн барилдаж гарсан түүнийг
Өөрийн мөн чанаргүй (үгүй) хэмээн өгүүлэх хэмээжээ.

Шалтгаан нөхцөлд шүтэн байж л хотол нисваанисын болоод асар арилсан ном юмс төрөх, түрдэхийн шүтэн барилдлагаар орших ба өөрийн мөн чанар үгүй болох хоёр нь суурь зохилдож хурах нэгэн бөлгөө. Үгээр зогсохгүй, тэр адилын шүтэн барилдах мөн чанар бол өөрийн мөн чанаргүй мөн гэж онох энэхүү хосгүй учир шалтгаанд одох нь зөвхөн Төв үзэлтний ялгамжаат ном гэдгийг мэдээрэй. Шүтэн байж төрөх, шүтэн байж түрдэх ёсыг өөрийн мөн чанараар бүтэх "ёст" мэт барьж, мөн чанарыг хорьсон ухаанаар төрөх, түрдэхийн шүтэн барилдахуйг няцаана гэвэл "Бурхан нь буг чөтгөр болж буух" гэсний үлгэр болж Төв үзлийн утгыг зүй ёсоор онохын их тотгор болмуй

за. Тиймээс хамаг юмст өөрийн мөн чанараар бүтсэн (өөсбээн бүтсэн) мөн чанар гэж тоосон төдийд ч байхгүй гэх ойлголт төрөхөд шалтгаан нөхцлийн барилдлагатай гэх ойлголт төрөх учрыг өөрийн ёсноо үгүйсгэвээс бусдын нигуурыг харах хэрэгтэй болно. Өөрийн ёсны шалтгаан нөхцлийн тухай сайн ойлгосон болович өөрийн мөн чанар байхгүй талаар өөрийн ёсны ойлголт олоогүй байтлаа хоосон чанарын утгыг мэдчихлээ гэж яривал төв үзлийг эдүгээ болтол олоогүйн шинж гэж ойлгоорой. Тиймд ухаантан мэргэд нар аа! Үнэн утгат эрхэм зарлиг болоод түүний утгыг тайлсан тайлбар шастарууд болон төв үзлийн зөв гол номлол сурттаалуудаас "хоосон чанарын утга бол шүтэн барилдахуйн утга" хэмээн айлдсан нь ухаант Төв үзэлтний гол ялгамжаа болой. Ялангуяа Буддхапалида, Чандракирти багш нар бээр хутагт эцэг, хөвгүүдийн таалал бүгдийг үлдээлгүй тайлсан хамгийн нарийн орон болсон шүтэн барилдахуйд суурилж өөрийн чанар байхгүй гэж ойлгож мэдэх ёс ба өөрийн мөн чанараар хоосон болох нь шалтгаан үр дагавар болж ургах ёсноос өөр бусдаар хөтлөгдөх учиргүй гэдэг магадлалыг ухаараарай.

/б/ Тэдгээр ёсоор түүнийг хэрхэн хорьсон нь: Тэр адил Нагаржуна багшийн ёсноо ном, юмс өөрчлөн (өөрийн мөн чанараар) чанараар бүтэх гэж тоосон төдийд ч байхгүй гэнэ. Хэрэв өөрчлөн чанараар бүтэх болвоос сансар, нирваны агуулга оршихгүйд хүрнэ. Тэрхүү агуулгыг хүлээн зөвшөөрөхгүй байх аргагүй бөгөөд хүлэгдэх, гэтлэх зэрэг агуулга бүхэн түүнд магадтай багтах учраас өөрчлөн чанар байхгүй гэж хүлээн зөвшөөрөх шаардлагатай. "Та нар бодит зүйлст өөрчлөн чанар байхгүй болохоор өөр юу ч байхгүй болно гээд хүлэгдэх, гэтлэх болоод төрөх, түрдэх тэргүүтнийг хаахад "үнэхээр" гэх зэргийн ялгааг найруулах шаардлагагүй, зөвхөн өөрчлөн чанарыг үгүйсгэх ухаан зэргээр үгүйсгэнэ гэвэл, өөрчлөн чанар байхгүй түүнээ л хүлэгдэх, гэтлэх, төрөх, зэдрэх тэргүүтний агуулга таарах учраас үгүйсгэхгүй гэж яаж санана вэ?.

Товчилбоос, өөрчлөн чанар үгүй болон хүлэгдэх, гэтлэх, төрөх, түрдэх тэргүүтэн харшилна гэж үзвээс, өөрчлөн чанаргүй хоосон чанарт сансар, нирваны хамаг агуулга багтах гэдэг хоёр үнэний алин ч болохгүйд хүрэх тул төв үзлийн нэгэн онцлог түүнийг та хорих болох нь ээ. Тэдгээрийг харшлахгүй гэж үзвээс, мөн чанарыг хорьсон ухаанаар хоригдохуунаа ямар нэг "ялгамж" найруулах шаардлагагүйгээр төрөх, түрдэх, хүлэгдэх, гэтлэх тэргүүтнийг хориход үнэн учир шалтгааны шаардлагагүй. Тиймээс өөрчлөн чанарыг хорьсон ухаанаар шалтгаан үрийг хорино гэдэг өөрчлөн чанаргүй болвоос төрөх, түрдэх гэдэг байхгүй гэсэнтэй адил буюу.

/в/ Түүнээ Төв үзэлтэн хэрхэн хариу тавьсан нь: Өөрчлөн бүтсэн мөн чанар буй бус (байхгүй) гэхээр, тэгвэл өөр юу байх вэ гэж өгүүлэх энэ чинь ямар ч эргэлзээгүйгээр өөрийн мөн чанар буй бус (байхгүй) болоод ногоо буй бус (байхгүй) гэх хоёрын ялгааг ялгаж мэдээгүйтэй холбоотой нь тодорхой байна. Ногоо буй гэх ба ногоо өөрчлөн чанараар бүтэх хоёрыг ч ялгаж чадаагүй учраас л буй аваас л өөрчлөн чанараар буй (байх) ёстой. Эсвэл өөрчлөн чанараар буй бус (үгүй) болвоос, (өрөөс) буй бус (үгүй) болно гэж үзсэн нь тодорхой байна. Эс чингэвээс өөрчлөн чанараас бүтсэнийг хорих ухаанаар буй төдий болоод төрөх, түрдэх тэргүүтнийг хэрхэн хорих вэ гэх үү? Тиймээс хэзээ ногоо тэргүүтнийг буй (байна) гэж үзэх тэр хүртэл өөрчлөн чанараар бүтсэн л гэж өгүүлэх ба өөрчлөн чанараар бүтэх өрөөс байхгүй гэхээр огт байхгүй юм шиг өгүүлэх нь хоёр хязгаарт (туйл) эргэлзээгүй унах мөн тул бодит

өгүүлэгчийн ухааралтай ялгалгүй нэгэн болно.

Түүний хариуд шалтгаан үрийг төрүүлэх тэргүүтний үйл, үйлдвэр зэрэг нь өөрчлөн чанарт буй аваас үл орших бөгөөд зөвхөн өөрчлөн мөн чанаргүй байхад л таарах болохыг айлджээ. "Өөрчлөн чанар байхгүй" болон "байхгүй" хоёрыг тодорхой ялгаж мэдэх учиртайг "Тодорхой үгт"-ээс: Эсэргүүцэл: Ийн хэмээн Хэрэв та энэ мэтээр бодит юмс өөрчлөн чанаргүй гэж агуулваас алин ялж төгс нөгчигсөн бээр өөрийн үйлдсэн үйлийн тийн боловсролыг (үр) өөрөө амсах болно хэмээн айлдсан бүхнээ эл ёсоор үгүйсгэж, үйлийн үрийг басамжлах учир та үгүйсгэгчийн эрхэм болох буюу. Хариулт: Өгүүлсүгэй. Би үгүйсгэгч бус аа. Би болвоос буй болоод буй бус хоёрт өгүүлэгчийг хориглож хоёр үгүй мөр болсон нирвааны хот балгадад одохыг тодорхой үйлдэгч мөн. Би болвоос үйл, үйлдэгч, үр жимс тэргүүтэн буй бус аа гэж өгүүлсэн бус аа. Тэгвэл юу хэмээвээс, Эдгээрийг өөрийн мөн чанар үгүй болой хэмээн агуулсан болой. Эсэргүүцэл : Яавч өөрчлөн чанаргүй болвоос үйл, үйлдэгч болж таарахгүй учир гэм нь илхэн байгаа бус уу.Хариулт: Тэр тийм бус аа. (Харин) Зөвхөн өөрчлөн чанартай л болчихвол үйл үйлдвэр үзэгдэхгүй болох учиртай. Зөвхөн өөрчлөн чанаргүй учраас л үйл, үйлдвэр үзэгдэх мөн" хэмээн айлджээ. Тийнхүү огт байхгүй болоод өөрчлөн чанаргүй байхын ялгааг ойлгоогүйгээс буй ба үгүйн хязгаарт унах бий. Эл явдлыг хорихдоо бид "Огт байхгүй гэж өгүүлээгүй ч буй бус аа гэж хэлсэн буюу. Буй гэж эс өгүүлсэн ч байхгүй биш ээ гэж өгүүлсэн мөн" Ийн өгүүлэх төдийд горилсон ч (шунаваас) зөвхөн харшилсан болох тул Төв үзлийн утга өчүүхэн төдийг ч үл багтаана. Бусдыг хорихын цагт өөрийн мөн чанар буй, буй бус хоёрын талаас нь авч үзэж хорих юм бол тэр хоёр бие биенээ үгүйсгэх ёстой гэж өөрсдөө үздэг шиг тэр хоёрын аль нь ч болохгүй гэсэн тийм утгаар илэрхийлдэг билээ.

12. УХААНААР ШИНЖИХ НЬ:

/а/ Ухааны шинжлэлд тэсэх, эс тэсэхийг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх: Ухаанаар ажиглахад тэсэх, эс тэсэх гэдэг хоосон чанарыг шинжих тэр ухаанаар олдох, олдохгүй гэх тэр утга билээ. Тэр талаар "Дөрвөн зуутын тайлбар"-аас:Бидний тийн шинжлэл нь өөрчлөн (өөрийн) мөн чанар байгаа эсэхийг чухалчлан хайж буй үйл билээ. хэмээн айлдсан мэтээр дүрс тэргүүтнээ төрөх, түрдэх зэргийн өөрчлөн мөн чанар буй, үгүй эсэхийг л эрж хайж буй шинжлэл ажгуу. эрэв өөрийн мөн чанараар бүтсэн аваас тэрээр баригдах, олдох ёстой байтал олдохгүй байна. Үлгэрлэвээс, Зүүн зүгт хумх (бумба) байвал олдоно гэж бодсон эрэлчин бээр зүүн зүгт хумх эрэхийн цагт олдохгүй бол тэрээр зүүн зүгт хумх байна гэхээ үгүйсгэнэ. Хумх байна гэдгийг юунд үгүйсгэх билээ. Түүнтэй адил "өөрийн мөн чанараар бүтсэн төрөх буй аваас олдоно" гэж үзээд Төв үзлийн ухаанаар хайгаад "тийн төрөхийг олж чадаагүй тэр ухаанаар л" "өөрчлөн буюу өөрийн мөн чанараар бүтсэн төрөх"-ийг үгүйсгэхээс бус, "төрөх төдий нэгэн"-ийг юунд үгүйсгэх вэ?.

/б/ Шалгадаг ухаанаар бүтэх, эс бүтэхийг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх: Дүрс тэргүүтнийг авч үзэхдээ шалгадаг ухаанд баригдаагүй бол зөвшөөрдөггүй, шалгадаг ухаанд баригдсан бол зөвшөөрдөг билээ. Асуулт: Чингэвэл "хамаг зүйлс ертөнцийн шалгадагаар болохгүй" хэмээсэн нь хэрхэн тохирох вэ? Хариулт: Үүний утга нь ертөнцийн харах мэдрэхүй зэрэг мэдрэхүй сэтгэлүүд нь хоосон чанарыг (оносон) шалгадаг ухаан болж чадахгүйг үзүүлснээс бус хамаг мэдэгдэхүүн

бүхэн шалгадаг ухаанаар мэдрэгдэхийг үгүйсгээгүй болно. Тийм учрыг "Орохуйн тайлбар"-т: Чингэхлээр хоосон чанарыг мэдэхэд зөвхөн хутагт нарын шалгадаг ухаан хэрэгтэй. Хутагт бусууд нь үл болмой. Хэдий ертөнцийнхэн эсргүүцэл гаргана гэж үзээд, хоосон чанарыг шинжихэд ертөнцийн ухаанаар буюу шалгадагаар болно гэж үзвэл л тийм байж болох ч Хэрвээ ертөнцийн шалгадагаар мэдэх болвол, Ертөнц хоосон чанарыг үзэх учир, тусгай хутагтын Хэрэг юун хутагтын мөрөөр ч юу хийх Тэнэгүүд шалгадагаар мэдэх нь зохисгүй болюу хэмээжээ

Тэдгээрийг зөвөөр, сайтар таньж мэдэхгүй бол явдлын зүгт сайн магадлалд төрөхгүйд хүрнэ. Ихэнхдээ басамжлах, дорд үзэх үзэл болчих тул ухаантан мэргэд бүхэн энэхүү ёсны "янагуухийн талаарх агуулга, тодорхойлолт"-ыг мэргэн ухаанаар тунгаагаарай.

14. ХУРАН ҮЙЛДЭХҮЙГ ШИНЖИХ НЬ

/в/ Дөрвөн хязгаараас төрөх мөн, бусыг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх: "Өөрийн мөн чанараар бүтэж төрөх" гэдэг нь үнэмлэхүйгээр төрөх мөн тул түүнийг зөвшөөрөхдөө зөвхөн нэрийдлийн хувьд зөвшөөрч болох талтай. Үнэмлэхүйгээр төрөх гэгчийг хорьсон шиг хорих шаардлагатай гэдэг бол энэхүү багшийн таалдын эрхэм дээд нь мөн тул өөрийн мөн чанараар бүтсэн төрөхүй гэдэг нэрийн төдий ч байж болохгүй гэж үзэх хэрэгтэй. Мөн өөрчлөнгөөр өөрийн чанараар үл төрсөн буюу төрөхийн мөн чанар байхгүй гэхээр (ерөөс) төрөх гэж байхгүй нь албатай гэж барьснаар "шүтэн барилдаж төрөх" болон "өөрчлөнгөөр үл төрөх" хоёрыг харшуулан тэмцэлдээд "чих байхгүй", "зүрх байхгүй" гэж айлдсан байна гэдэг. "Өөрчлөнгөөр үл төрөх" хэмээхийн "өөрчлөн" хэмээх үгийг сонсолгүйгээр "үл төрөх" хэмээснийг барьж бодох вий гээд "чих байхгүй" гэж "өөрчлөн" хэмээх тэрхүү үгийн утгыг ухаарахгүйд хүрэх вий гээд "зүрх байхгүй" хэмээн айлджээ. Мөн "Лусын хаан Мадойва айлтгасан судар"-аас:

Алин шалтгаанаас төрөх тэр л үл төрөх
Түүнээ төрөхийн өөрчлөн чанар үгүй буюу
Шалтгаанд шүтсэн алин түүнийг хоосон (чанарт) гэж номнов
Алин хоосон чанартайг ийн мэдэж жиших мөн

хэмээсний эхний мөрөөр бурхан бээр: "Шалтгаанаас төрсөн тэр л үл төрөх" хэмээн айлдаж үл төрөхийн ёсыг заажээ. Хоёрдугаар мөрөөр: "Түүнээ төрөхийн өөрчлөн чанар үгүй" хэмээн хоригдохуундаа ялгааг нь гаргаж "өөрчлөн чанар үгүй болой" гэжээ.

/г/ Бодасын буй, буй бус зэрэг дөрвөн талыг хорихоод эсэргүүцэл гарахгүйг үзүүлэх: Асуулт: Төв үзлийн гол номоос бодас юмсын өөрчлөн чанарт болохыг /1/ буйгаас, /2/ буй бусаас, /3/ хоёулангаас, /4/ хоёул бус зүйлээс байхгүй гэж дөрвөн хязгаараас үгүйсгэнэ. Ер энэ дөрөвт багтахгүй үзэгдэл юмс байхгүй тул эл учир шалтгаанаар бүгдийг үгүйсгэх болох нь ээ?. Хариулт: Дээр өгүүлсэн мэт ер бодит зүйл байхаас өөрийн мөн чанараар бүтсэн бодит зүйл нь хоёр үнэний хаана ч багтахгүй гэж хориглоно. Харин тусыг үйлдэх бодит зүйлсийг нэрийн төдийд байхыг үгүйсгээгүй болой. Бодит зүйлс үгүй боловч хуран эс үйлдсэн юмс өөрийн мөн чанараар бүтсэн "бодит бус юмс" гэж үзвээс мөн тэр адилын "бодит бус юмс"-ыг ч үгүйсгэнэ. Улмаар тэр мэтийн бодит зүйлсийн буй, буй бус хоёуланг няцааж, хоёуланг бусын өөрийн мөн чанараар бүтсэн байхыг ч үгүйсгэх тул дөрвөн хязгаараас хорих ёсыг энэ мэтээр

мэдэж аваарай.

15. ХОРИГДОХУУН УТГАА БУРУУ ТАЙЛБАРЛАСАН НЬ

2/ Хоригдохуунаа (хаагдахуун) хэтэрхий явцуу тайлбарласныг хорих: ...Тиймээс үзэл онолоо баттай·сайн мэдэхийн цагт хамт төрсөн мунхагийн баримтлах утгыг нь байхгүй болохыг баттай мэдэх явдлыг гол орноо болгож авах, түүний дашрамд хамаг нэрийдэл томъёог баримтлах сэтгэлийн орнуудыг хашраан сөхөөх учиртай зэргийг таньж мэдэлгүйгээр хамт төрсөн мунхагийн баримтлах орныг сөхөөх явдлыг орхигдуулаад "бодгалийн би үгүй"-г хорих гээд "мөнх, ганц, өөрийн эрхэт би болон, "номын би үгүй"-г хорино гээд хувьгүй нарийн тоос хэмээх баригдахуун", хувьгүй агшин хэмээх баригч, гурван ялгамжаа төгөлдөр мөн чанар зэрэг зөвхөн тогтсон гаалльıг өгүүлэгч нарын нэрийдэн томъёолсон зүйлсийг хорино гэж үзвэл тэр болгон таарахгүй. Чингэлгүйгээр үзэл онолоо баттай танин мэдэхийн үест тэр төдийгөөс эхлэн таньж мэдээгүй бол бясалгахын цагт ч тэдгээр төдий ч нэгийг баттай мэдээгүй гээд тэр цагт тэр төдийг л бясалгах хэрэг гарна. Үзэл онолоо баттай мэднэ гэдэг бясалгаж мэднэ гэсэн утга билээ. Тиймээс бясалгаад илт болгох ба бясалгаж дадуулсаар эцэст хүргэнэ гэдэг ч тэр төдий хэмжээнд хүрэх ёстой. Тэр мэтээр хотол нэрийдлийг мэдсэн тэр л нэрийдлийн төдий хоёр "би-үгүй"-г оносноор хамт төрсөн нисваанисыг буцаана гэж үзвэл хэтэрсэн болно. "Орохуй"-гаас:

"Би үгүй"-г онохын цагт мөнхийн "би"-г тэвчих бөгөөд
Энд л "би"-д барихын шүтээн гэж үл үзэх
Тиймээс "би-үгүй"-н ухаанаар "би"-г үзэхийг
Ёзооρоос нь үлдэн хөөх хэмээх машид гайхамшигтай

Өөрийн гэрийн туурганаа могой асахыг хараад
Энд их заан алга байна гэх бодлоос салж
Могойн аюулаас гэтэлж байна гэх нь
Аяа, хоохой! Бусдын инээд болохоос өөр газаргүй хэмээжээ.

16. ХОРИГДОХУУНЫ ЖИНХЭНЭ УТГА:

1/ Хоригдохууны жинхэнэ утгыг танин барих: Ер нь хоригдохуунд:а) Мөрийн хоригдохуун ба б)Учир шалтгааны хоригдохуун гэж хоёр буй. а) Мөрийн хоригдохуун. "Төвийн хязгаар"-аас:

Нисваанисын түйтгэр болон
Мэдэгдэхүүний түйтгэр гэж үзүүлэв
Тэр бүхэнд хамаг түйтгэрүүд багтах ба
Тэдгээрийг дарваас гэтлэх (нирваан) мөн хэмээн айлдсан мэт нисваанисын болон мэдэгдэхүүний түйтгэр хоёр буй. Эдгээр нь мэдэгдэхүүнд багтдаг хоригдохуун

бөгөөд эдгээрийг байхгүй болгосноор амьтан бүхэн гэтэлж нирваанд хүрнэ.

б) Учир шалтгааны хоригдохуун. "Тэмцлийг няцаагч"-аас:

Жич заримууд хувилгасан бүсгүйг
Бүсгүй хэмээн
Буруүд барих ба хувилгаан адил гэж

Хорьж үйлдсэн энэ нь тэр мэт буюу хэмээснийг "Түүний өөрийн тайлбар"-аас: "Бас зарим эрчүүд хувилгасан бүсгүйг өөрчлөн чанараар хоосон байтал үнэхээр бүсгүй хэмээн буруугаар ухдаг бий. Чингэж буруугаар барьж, бас түүнээ шунах, тачаах сэтгэл төрдөг. Түүнчлэн залрагсад, түүнчлэн залрагсадын шавь нар, Сонсоод сонсогч нараас ямар нэг хувилгаан дүрд хувилан үзүүлэхдээ тэдгээрийн буруу бодлыг буцаадаг билээ. Ийнхүү хувилгаан дүр адилын миний үгээр бусад бүх бодит юмс нь хувилгасан бүсгүй мэт өөрчлөн чанартай гэх аливаа үзлийг буцаана" хэмээн айлджээ.

17. ӨӨРИЙН ҮНДЭСТ БОЛОН ХЭТРҮҮЛЭГЧ ХОЁРЫН ЯЛГААГ БУРУУ ТАЙЛБАРЛАСАН НЬ

(2) Өөрийн үндэст болон Хэтрүүлэгч төв үзэлтэн нар хоригдохууныг хэрхэн хорих: (а) Өөрийн үндэст болон Хэтрүүлэгч нарын утгыг бодитой барих: Буддхабалида багшийн тайлбарт "Хэтрүүлэгч, Өөрийн үндэст" гэж хоёр ялгаж Хэтрүүлэгчийг тусгайлан авч үзсэн нь тодорхойгүй байна. Гэсэн ч "Үндсэн билиг -ээс:

Өөрөөс бус, бусдаас бус
Хоёроос бус, шалтгаангүйгээс бус
Бодас зүйл алин юу байлаа ч

Төрөх нь хэзээ ч буй бус хэмээн айлдаж "бусдын ёсыг үгүйсгэхийн үүднээс дөрвөн төрөхүйг няцаан зохиожээ. Түүнийг Бхававивека багш бээр "өөрийн ёсыг бүтээх ба бусдын зүгийг няцаах аль ч чадал байхгүй гээд, гэм буруүг тоочин няцаасан" гэцгээдэг. Гэвч Чандракирти багш бээр тэр мэтийн гэмүүд Буддхабалида багшийн ёсноо үл таарах учир шалтгааныг дэлгэрэнгүй тайлбарлаж бусад төв үзэлтэн нарт төв үзлийн онол сэтгэлд зөв төрөхийн арга болгож Хэтрүүлэгчийн ёсыг судлах хэрэгтэй гээд мөнхүү Өөрийн үндэстийн ёс таарахгүй хэмээн хориглож Хэтрүүлэгчийн аймгийг тодруулан тайлбарлажээ.а/Баримтлалыг өгүүлэхэд дөрөв: /1/ Хэтрүүлэгч болон өөрийн үндэстийн талаар олон томъёолол бий. Гэхдээ тэр бүгдийг хэн номнож чадах билээ. Түүнээс зарим нэгийг номносугай. Үүнд Заянанда бандида бээр "Орохуйн тайлбар номлол"-доо: Асуулт: "Тэр талаар хэрвээ заримууд Хэтрүүллийг (танжур/ reductio ad absurdum argument), учир шалтгааны нотлол (данцэг/syllogistic reasoning) гэж үзвээс, тэрээр шалгадгаар бүтсэн зөв мөн үү. Гэхдээ тийн эс бүтсэн мөн. Энэ талаар эхнийхээр болно (бүтсэн) гэвэл тэр цагт хоёулаа бүтэх учраас бусдын ам авсан (тангараг) гэж юунд өгүүлэх. Удаахаар гэвэл бусдын ам авсан болж таарахгүй учраас бусдын ам авсан гэж хэрхэн өгүүлэх вэ?

Түүний хариуд: Шалгадгаар бүтсэн алин болвоос л хоёулаа бүтсэн мөн болой" хэмээн тэр ямагт үл мэдэх үед ийнхүү эсэргэлдэгч бээр бүтээгч нотлол өгүүлэх цагт тэрхүү нотлол нь шалгадгаар бүтсэн (нотлогдсон) байх боловч бусад шалгадгаар бүтээж, түүгээр мэдэж болно. Бусдын сэтгэлийн ялгамжаа нь илт болон жишиж мэдэх

сэтгэлийн орон бус болой. Өөрийгөө ч гэсэн шалгадгаар бүтээж мэднэ. Эндүүргийн шалтгаанаас удаан хугацааны туршид барьсан учир хуурмаг болжээ. Тиймээс цаад наад эсэргэлдэгч нарын шалгадаг гэж үзсэний хүчээр бодит юмсын мөн чанарыг хүлээн зөвшөөрдөг болно. Тиймээс бусдууд хэрхэн ам авахын эрхээр бусдын зүгийг сөхөөнө" гэжээ.

19. ӨӨРИЙН ҮНДЭСТ, ХЭТРҮҮЛЭГЧ ХОЁРЫН ЯЛГААГ ТАЙЛБАРЛАСАН НЬ:

2/ Өөрийн ёсыг номнох нь: Хэтрүүлэгч нар өөрийн үндэстийн ёсыг сөхөөг гаргаад өөрийн ёсоо байгуулсан түүнийг хэлэхэд тэр хоёуланг нь ухаарч болох тул түүнийг өгүүлсүгэй. Энэ талаар "Тодорхой үгт"-ээс олонтаа айлдсан тул үг олон болох вий гэж эмээгээд энэ үест гол зүйлүүдийг номносу.Түүнээ хоёр зүйл: а/ Өөрийн үндэстийг бодитойгоор сөхөөх ёс: ...Түүний утга нь: "Бурхан бээр Өвөрмөц өгүүлэгч нарт "дуу бол мөнх бус шүү" хэмээн андгайлахад махбодиос гарсан дуу гэж номтод бариваас "Өвөрмөц өгүүлэгчид "үл бүтэх". Огторгуйн эрдмийн дуу хэмээн номтод бариваас өөрийн ёсноо эс бүтэх. Тэрчлэн Өвөрмөц өгүүлэгч бээр, тодруулан үйлдэгчийг дуу нь мөнх бус гэж андгайлаад, үйлдсэн дуун хэмээн номтод бариваас тодорхой үйлдэгч болохгүй. Урьд байсан нөхцлөөс тодорхой үйлдэгч дуун хэмээн номтод бариваас өөрт эс бүтнэ. Чингэхдээ өөр, өөрийн ёсны нийт бусын бодлыг номтод барьж болохгүй ээ. "Номт" гэдэг бол эсэргэлдэгч хоёр талаас тусгайлан шинжлэн үзэж байгаа зүйлийн суурь учраас хоёулангийн "зохилдох үзэгдэл" болж бүтсэн нэгэн байх хэрэгтэй. Ингэж "номт" нь зохилдох үзэгдэл болох шаардлагатайн адилаар "ном" болох мөнх бус нь ч гэсэн тусгай ялгааг гаргаагүй ерөнхий нэгэн зүйл байх хоёулаа бүтсэн байх хэрэгтэй. Ямар ч жишээг татахдаа, зохилдох үзэгдэл нэгэн бүтээгдэхүүнийг бүтээхийн (нотлогдохууныг батлах) өмнө байх хэрэгтэй.

Тэр жишээний дагуу Төв үзэлтэн нар нүд тэргүүтнийг дотоодын төрөн түгэхүй буюу дүрс тэргүүтэн гадаадын төрөн түгэхүйнүүдийг "өөрөөсөө төрөх нь байхгүй" гэдгийг өөрийн аймгийн бодит өгүүлэгч нар бүтээхдээ "үнэн нүд тэргүүтэн " хэмээн номтод бариад өөрт үл бүтээх, "хуурмаг нүд тэргүүтэн "хэмээн номтод бариад гадаадынханд үл бүтээх тул энэ мэтийн ялгааг орхиж нүд, дүрс төдий нэгнийг номтод агуулваас төв үзэлт болон бодит өгүүлэгч хоёулаа "өөрөөсөө төрөх байхгүй" тэргүүтнийг тусгайлан шинжих суурь болж өгнө. Тиймээс хоёуланд "зохилдох үзэгдэл" болох шаардлагатай болно гэж санаарай. Зохилдох үзэгдэлд бүтэхийн утгын хувьд ч хэрхэн гадны эсэргэлдэгчдэд төрсөн шалгдаг ухаан нь төдий чинээгээр дотоод эсэргэлдэгчдэд ч тэр адилаар шалгадаг ухаан төрөх аж.

20. ӨӨРИЙН ҮНДЭСТИЙГ ШҮҮМЖЛЭХ НЬ

б/ Тэр бидэнтэй адилгүй ёс: "Түүнийг бүтээх"-дээ, "номт" (subject) болох "нүд", "үлгэр" (the example) болох "хумх", учир шалтгаан (the reason) болох "өөрийгөө үл үзэх", "бүтээгдэхүүн ном" (the predicated quality) болох "хөх өнгө тэргүүтнийг үл харах" зэргүүдийг өөрийн ёсноо ам үл авах буюу. Бусдын авах төдий мөн тул учир болоод албатай тэргүүтнийг зөвхөн гадаад эсэргэлдэгчид бүтнэ хэмээсэн утга бус аа. Тэгвэл юун хэмээвэл, тэдгээрийг өөрийн ёсонд ам авсан нь байхгүй ч, тэдгээрийг бүтээхийн шалгадаг өөрийн мөн чанараар бүтсэн мэдэгдэхүүнийг илт мэднэ гэдэг өөрийн ёсонд

томъёо тэдий ч үгүй билээ. Өөрчлөн буй гэж өгүүлэгч тэдгээрийн хувьд бүтсэн гэдэг нь тэрхүү шалгадгаар бүтсэнээ магадтай харгалзах тул хоёуланд зохилдох үзэгдэлд бүтсэн, өөрийн мөн чанараар бүтсэн гэдгийг оносон шалгадаг байхгүй учир хоёулаа үл бүтсэн болж бусдад алдаршсан буюу бусдад бүтсэн хэмээгджээ.

(б) Тэр хоёрыг даган барьж үзэл онолыг үндэснээ төрүүлэх:

Хэтрүүлэл (reductio) нь: "Гал нь түлээнд өөрчлөнгөөр буй аваас өөрчлөн чанар нь нэг болон тус тус хоёрын аль нэг болно. Хэрвээ "нэг болвоос гал өөрөө өөрийгөө шатаах болно" хэмээх тэргүүтэн бусдын ам авсныг учирт байгуулж гадны этгээдийн үл зөвшөөрөх зүйлийг хаях энэ мэт мөн тул үгээр жишиж бусад хэтрүүллийг ч ухаараарай. Тиймээс гадны эсэргэлдэгч нар хэдий бодит өгүүлэх тогтсон таалдаа эс орхих тэр хүртэл өөрийн мөн чанараар бүтсэн мэдэгдэхүүнийг мэдэж бүтээнэ гэдэгтээ баригдаж утгын бүтээгч шалгадаг байна гэж үздэг. Хэзээ нэг цагт зарим бодит юмс өөрийн мөн чанараар бүтээгүй гэдгийг шалгадгаар мэдээд ирэхээр бодит өгүүлэх тогтсон таалдаа орхидог билээ. Тэр мэт хутагт эцэг, хөвгүүн тэдгээрийн даган барихдаа төв үзэлтэн "хэтрүүлэгч", "өөрийн үндэст" нарт харилцан адилгүй хоёр ёс буй. Тэр хоёрын алиныг дагах вэ? хэмээвээс, Энд хэтрүүлэгч ёсыг даган барина. Үүнийг дээр номносон мэтээр нэрийдэлд тэдийд ч мөн чанараар бүтсэн өөрчлөнг хориглож түүнийг хориход сансар, нирвааны агуулга бүгдийг сайтар барих чухал хэрэгтэй тул тэрхүү хоёр ёсыг сайтар ухаарах учиртай. Бодас мэт өөрийн мөн чанараар бүтсэн өөрчлөнг ам авбаас ахуй ёсыг шинжлэх ухаан ба шинжилгээ шаардлагатай гэж энэ хоёр багшийн гол номоос олонтаа айлдсан тул хутагт эцэг, хөвгүүний гол номуудтай сайтар жигдрүүлж тэр ёсноо ам авах ба тэр тусмаа дээр номносон мэт магадтайгаар "Хэтрүүлэгч" ёсны зүг ам авах хэрэгтэй.

21. "МОДОН ТЭРЭГ"-ИЙГ ШИНЖИХ НЬ:(Бодгалийн би-үгүйг онох):

(а)Бодгалийн "би-үгүй"-г нотлон бүүлгах: "Орохуй тайбар"-д судраас эшлэн :"Би" хэмээх нь шумнасын сэтгэл гэж, Та түүнийг мэдэх буюу, Хурсан цогцос энэ хоосон бөгөөд, Үүнээ амьтан буй бус аа, Хэрхэн гишүүд цуглаж нийлснээ, Шүтэж модон тэрэг гэж өгүүлдэг шиг, Тэрчлэн цогцосуудад шүтэн байж, Янагуух амьтан хэмээх болой" хэмээх зэргийн үүднээс тайлжээ.

/1/ Модон тэрэгнээ өөрчлөн үгүй ч харин нэрийдэлд буйг үзүүлэх: "Орохуй"-гаас:"Модон тэрэг нь өөрийн гишүүнээс ангид бус /1/, Ангид бус нь бус /2/, түүнтэй төгөлдөр ч бус /3/, Гишүүн ч бус /4/, гишүүд нь ч тэр бус /5/, Хурсан тэдий ч бус /6/, хэлбэр дүрс нь ч тэр бус /7/ адил" хэмээн модон тэрэг нь өөрийн гишүүдтэй нэг болон эсвэл ангид байх зэрэг долоон зүйлээр "буй бус" тул зөвхөн нэрийдэл тэдий зүйл мөн. Түүнтэй адилаар "би" болоод "цогцос" хоёр ч мөн тийм болохыг айлджээ.

Энд модон тэрэг өөрийн мөн чанараар бүтсэн өөрчлөнтэй байх аваас нэгэн байх буюу эсвээс ангид тус тус байх долоон зүйлийн аль нэгээр буюу өөрчлөн буй үгүйг шинжигч ухаанаар ямар ч эргэлзээгүй бүтсэн байх хэрэгтэй. Гэтэл тэр долоогийн аль нэг нь болж тийн бүтээгүй (мэдрэгдээгүй) байгаа тул түүнээ өөрчлөн чанар байхгүй байна. Модон тэрэг нь гол мод, хүрд (дугуй), шаантаг (хадаас) зэрэг гишүүдээс бүрдэнэ. Модон тэрэг нь тэдгээр бүхэнтэй нэг мөн чанартай бус. Нэг гэвэл түүний гишүүд олон байгаатай адилаар модон тэрэг ч мөн олон болж таарна. Мөн

нөгөө талаас модон тэрэг нэг байгаатай адилаар тэдгээр гишүүд ч нэг болж болно. Ингэхээр үйлийг үйлдэгч (эзэн) болон үйл, ажил хоёр нэг зүйл болчих зэрэг гэм гарна. Өөрийн гишүүдтэйгээ өөрийн мөн чанараар бүтсэн ангид тусдаа ч бус. Үлдсэн хоёр зүгийн хувьд "Орохуй"-гаас:

Хэрвээ хурсан төдий нь модон тэрэг болвоос
Хэсэг бусаг байгаа нь модон тэрэг мөн болох
Алин гишүүнт бус болвоос тэдгээр гишүүд
Үгүй болох тул хэлбэр дүрс төдий нь модон тэрэг бус аа

хэмээсэн мэт "гишүүд цугласан төдий" болоод гишүүдийн ялгагдах "хэлбэр" хоёрын л модон тэрэг гэж үзэх бий. Гэтэл модон тэрэг нь өөрийн гишүүдийн цугларал, нийлэмж төдийд ч үл таарна.

22. ӨВӨРЧЛӨН ЧАНАР ҮГҮЙ БОДГАЛЬ:

/а/ "Би нь цогцостойгоо нэг" хэмээх зүгийг хорих: 1. "Би"- гээ байна гэж өгүүлэх утгагүй болох. "Би" болон цогцос хоёр нь нэг өөрчлөн чанартай гэвэл би гэж ам авах нь утгагүй. Цогцосын тоотой адил зүйл болж хувирна. Үлгэрлэвээс, "сар болон туулайт" хэмээхтэй адил. Үүнийг үндсэн билэгт ч айлдсан буй. "Үндсэн билгийн" "Хориндолдугаар бүлэг"-ээс : Чухал авагчаас (цогцосоос) ангид, Би байхгүй гэж үзэх цагт, Чухал авагч нь би мөн болох тул, Таны "би" чинь үгүй болох буюу хэмээжээ.

2. "Би"-нь олон болох гэм гарах. "Би" болоод цогцосууд нь өрөвчлөн нэг болвол нэг бодгальд гэхэд олон цогцос байдаг шиг "би"-ч мөн олон болж болно. "Би" нэгээс цаашгүйтэй адилаар цогцос ч бас нэг болохын гэм гарна. "Орохуй"-гаас ч: Х э р в э э цогцос нь "би" мөн болвоос,Тэрээр олон учир "би" ч олон болох хэмээжээ.

3.Төрөх, түрдэх (эвдрэх). "Хорин найм дугаар бүлэг"-ээс: Хэрвээ цогцос "би" болвоос, Төрөх, түрдэх мөн болох хэмээсэн ба, Энэ мэтээр "би"-нь цогцостойгоо нэгэн болвоос "би" гэж ам авах нь утгагүй болох, "би" нь олон болох, үйл үйлдвэр нэг болох, үйлдсэн үйлийн шим барагдах, үйл үйлдээгүйтэй учрах, төрлөө дурдан санах үгийг өгүүлэх зэрэг үл зохилдох зургаан зүйл гарах учир нэг гэж ам авч болохгүй нь ээ.

/б/ "Би нь цогцостойгоо тусдаа" хэмээх зүгийг хорих: Асуулт: Ингээд "би" болоод цогцос хоёр өөрчлөн нэг биш гэж бодьё. Харин өөрчлөн тус тусдаа (ангид) болвол ямар гэм гарах вэ? Хариулт: Энэ талаар "Хориндолдугаар бүлэг"-ээс: Хэрвээ цогцоснуудаас ангид аваас, Цогцосны бэлэг чанар үгүй болно хэмээх гэмийг айлджээ. Үүнд "би" нь цогцосноосоо мөн чанараар бүтсэн ангид зүйл болвол цогцосны бэлэг чанар нь төрөх, эвдрэх, орших гуравтай төгөлдөр болохгүй ээ. Үлгэрлэвээс, "Морь нь үхрээс тусдаа бүтсэн учраас үхрийн бэлэг чанартай төгөлдөр биш шүү дээ. Мөн байлаа ч тэрээр "би" гэж нэрийдэн сэжихийн суурь буюу "би"-д баригч атгагийн орон болохгүй нь ээ. Хуран үйлдсэн учраас. Үлгэрлэвээс, "Огторгуйн цэцэг буюу гаслангаас ангжирсантай адил"" хэмээн бусдад алдаршсан найруулгын "Тодорхой үгт "-ээс

айлджээ.

/г/ Түүнээ шүтэж "бодгаль нь илбэ адил" гэж ухаарах: Үүнийг "Бясалгалын хаан судар"–аас айлдсан дагуу үйлдсүгэй. Ийн өгүүлрүүн:

Хэрхэн зэрэглээ, гандирсын балгад,
Илбэ, зүүд тэр мэтээр адилтгаж
Шинж байдлыг бясалгахад мөн чанараар хоосон тул
Хамаг ном юмс бүгдийг тэрчлэн мэдэхтүн хэмэхх зэргээр буй.

2/ Түүнчлэн "минийх" гэдэг ч өөрчлөнгөөр байхгүй болохыг үзүүлэх: Тийнхүү өөрчлөн буй, үгүйг хайх ухаанаар "би"-гээ эрэхэд долоон зүйлийн алинд ч үл олдох тул тийнхүү "би"-д өөрчлөн чанар эвдрэх (байхгүй болох) тэр цагт "энэ чинь нөгөө "би"-гийн нүд тэргүүтэн болно" гэж ухаанаар хаанаас олдох билээ. Тийм болохоор "минийх" гэдэг маань ч өөрчлөн үгүй болох нь ээ. Бүтээлчид бээр "би" болоод "минийх"-ийн өөрчлөнг хэзээ ч үл (зорих) тухайлах болсноор орчлонгоос тийн гэтлэх болохыг номнох болой. "Арван наймдугаар бүлэг"-ээс:

Би ямагт нь буй бус болохоор
Минийх гэдэг хаанаас байх хэмээх зэргээр өгүүлжээ.

"Би"-д өөрчлөн байхгүй гэдгийг олох хүчээр л "минийх" гэсэн өөрчлөн үгүй онох болно гэдгийн сэжиг бодлыг таслан дээр өгүүлснээс мэдэж аваарай.

23. ӨӨРЧЛӨН ЧАНАРААС ХООСОН БОДАС ЮМС

(Номын би -үгүй чанарыг ойлгох):

1/ Өөрөөс төрөхийг хорих: Ногоо нь өөрийн мөн чанараас төрөх болвол төрөх нь утгагүй болно. Төрөх гэдэг хаана юу болж төрөх түүнийхээ мөн чанарыг олдог ёстой. Ногоо өөрийн мөн чанарыг олчихсон байдаг шүү дээ. Үлгэрлэвээс, "Илт тодрох ногоотой адил хэмээвээс, Төрөх нь хязгааргүй болох бөгөөд, Төрчихсөн хөрөнгө дахин төрөх тул, Тэр хөрөнгө нь дахин дахин төрөх хэрэгтэй болно". Тиймээс хөрөнгө төдий нэгэн үргэлж төрөхөд хүрэх тул ногоо тэргүүтэн төрөхийн чөлөө олдохгүй гэм гарна.

2/ Бусдаас төрөхийг хорих: Асуулт: "Гэсэн ч бусад (ангид) болох дөрвөн шалтгаанаас үр төрж болно гэж айлдсан тул бусдаас төрж болно биз дээ? Хариулт: Өөрчлөн тус тусын шалтгаанаас үр төрдөг болвол галын оч гэрэл ч зузаан харанхуйгаас төрж болох нь ээ. Бусад учраас. Мөн үндэс шалтгаан болох, болохгүй элдэв зүйлээс үр болох, болохгүй элдэв зүйл төрөх нь ээ дээ. Бусад чинь адил мөний тул хэмээжээ. Түүний утга нь "ногооны хөрөнгөнд өөрийн мөн чанараар бүтсэн өөрчлөн байна" гэж ам авбал "тутарга будаа нь өөрийг нь төрүүлж гаргах учиргүй гал зэргүүдээс өөрийн мөн чанарын үүднээс өөрчлөнгөөр тус тусдаа одох ёс" ба "өөрийн үндэс болох тутарга будааны хөрөнгөөс өөрчлөн тусдаа одох ёс" хоёуланд хэзээд адил үзэгдэнэ. Тиймээс тэр мэт эгүүсгэгч бусдаас өөрчлөнгөөр тус тусдаа байдал ургахтай адилаар тутрага будааны өөрийн хөрөнгөөс тусдаа үзэгдэхийн үест ч тус

тусдаа байх хувь нь тэр мэт үзэгдэнэ. Тус тусдаа үзэгдэх ёс тэдгээрийг өөрийн мөн чанарын үүднээс бүтсэн өөрчлөн мөн болвоос гал зэргээс үл төрөх ба түтрагаяы хөрөнгөнөөс бүтэх ялгамжааг хэзээ ч гаргаж чадахгүй.

3/ Хоёулангаас төрөхийг хорих: "Хоёулангаас төрнө" гэж өгүүлэгч нар нь шавар хумх нь шавраас төрдөг нь өөрөөсөө төрж буй хэрэг. Шаварчин зэргээс төрж буй нь бусдаас төрж буй хэрэг гэж өгүүлэх бий. Дотроо ч гэсэн "Лхайжэн бусад төрөл тутамдаа ч зөвхөн амь голтой нэгнээс төрөл авах учраас Лхайжэн болон амь хоёр нь нэг болно. Тиймийн учир өөрөөс төрсөн мөн. Эх, эцэг болоод нүгэл, буяны үйлийн үр зэргээс төрсний хувьд бусдаас төрсөн болоно" гэж өгүүлнэ. "Зөвхөн би-гээс ч төрөх" байхгүй. "Зөвхөн бусдаас ч төрөх" байхгүй. Харин "Хоёул чуулснаас төрөх" гэх эдгээрийг дээр номносон ухаанаар эвдлэх бөгөөд "өөрөөс төрөхийн талыг" өөрөөс төрөхийг хорьсон ухаанаар хаана. "Бусдаас төрсөн" гэхийг бусдаас төрөхийг хорьсон ёсоор хаах болой. "Орохуй"-гаас: Хоёулангаас төрөх нь ч, Ухааны мөн чанар биш гэдгийг номносон, Тэдгээр гэмүүд дээрээс бууж ирэх учир, Энэ нь ертөнцөөс нөгчигсөн тэр ямагтад ч байхгүй, Тиймээс тус тусаас төрж бүтэх нь үгүй болой хэмээжээ.

4/ Шалтгаан нөхцөлгүйгээр төрөхийг хорих: "Мөн чанараас төрнө" гэж өгүүлэгч (Локояата) нараас "линхуа цэцгийн үндэс ёзоор ширүүн боловч навч дэвүүр нь зөөлөн байхыг хичээж бүтээгчийг үзсэнгүй" гэх бий. Мөн заримууд "тогос зэргийг хараад өнгө зүс, хэлбэр дүрсийг хэн урласныг үзсэнгүй гэх ба тиймээс бодас юмс төрөхдөө "зөвхөн мөн чанараас гарна" гэж өгүүлдэг. Эдгээр нь таарахгүй л дээ. "Үндэс шалтгаангүй төрвөөс" нэгэн орон зай, нэгэн цагт орших төрөл нь хамаг л орон зай, цаг үед ч орших хэрэгтэй болно. Эсвэл өрөөс байхгүй байх хэрэгтэй болно. Энэ орон цагт "төрөх" ба энэ орон цагт "төрөхгүй" гэх тийм учир шалтгааны үндсийг байна уу, байхгүй юу" гэж үзэх шаардлага огт байхгүй. Тогосны отог хэрээнд ч байх хэрэг тохиох вий. Товчилвоос, нэгээс төрсөн бол хамгаас төрөх буюу эсвээс хэзээ ч төрж болохгүйд хүрнэ. Үрийг олохын тухайд ертөнцийнхөн үндэс шалтгаанд олонтаа шамдах хэрэггүй болох нь ээ.

(в) Тэдгээр үзлийг дадуулснаар түйтгэрийг тэвчих ёсон

Тийнхүү "би" болоод "минийх" хэмээхийн өөрийн мөн чанараар бүтэх нь тоосон төдий ч байхгүйг ухаарч түүний утгыг бясалгаж дадуулснаар "би" болоод "минийх" хэмээн барих, эдрэх үзлийг буцаана. Түүнийг буцааснаар чухал авагч хүсэл зэрэг "дөрвөн авахуй" буцна. Түүнийг буцааснаар авахуйн шалтгаанаас "хүрьцахуй" төрөхгүй тул хүрьцахуй шалтгаанаас цогцос хуралдаж төрөл авахгүй болсноор гэтлэх болно. "Хорин наймдугаар бүлэг"-ээс: "Би" болоод "минийх" амарлих тул, Минимхийлэн барих, минийх гэж үзэх үгүй болох хэмээсэн ба, Гадаад, дотоодын бодас юмст, "Би" болоод "минийх" хэмээх барагдаж, Чухал авахуй хоригдох бөгөөд, Тэр барагдваас төрөл барагдах хэмээн айлджээ.

Хоосон чанарыг оносноор тэд бүгдийг буцаах учиртайг дээрх "Шастар"-аас: Алины тухайд цацрал бүгдийг амарлиулах нирвааны мөн чанар болсон хоосон чанарт шүтэж цацралаас хагацана. Цацралаас хагацсанаар атгагаа буцаана. Атгагаа буцааснаар нисваанисаа буцаана. Үйл нисваансаа буцааснаар төрөхүйг буцаах тул зөвхөн хоосон чанар нь хамаг цацралыг буцаах мөн чанарт тул гаслангаас нөгчигсөн нирваан болой хэмээн маш тодорхой айлдсан бий. Ийнхүү хоосон чанарын үзэл бол зөвлөнт орчлонгийн үндсийг таслагч бөгөөд тонилохуйн мөрийн амин сүнстэй адил

гэдгийг үнэхээр баталж үзүүлсэн тул үүнээ баттай ухаарлыг олох хэрэгтэй.

24. ҮЛЭМЖ ҮЗЭХҮЙН ЯЛГАЛ:

Товчилвоос, их хөлгөний ёсноо Нагаржунай, Асанга хутагт нарын гол номын ёсыг дэлгэрүүлэн тайлбарласан үзэл онолын хоёр ёсноос өөр үзэл онол байхгүй билээ. Энэтхэг, Түвдийн дээдэс мэргэд бүтээлчид ч энэ хоёрын тайлбар дагуу хоёр үзлийн аль нэгийг нь магадалж түшсэн үзэгдэх тул огтхон ч эргэлзэлгүй энэ хоёрын үзэл онолын аль нэгийг өөрсдийн ёсны дагуу суралцаарай. Энэ ёсыг сайтар мэдэж гол номоос гарсан дагуу бясалгаж үйлдвээс л маш гайхамшигтай болно. Их хөлгөний эрхэм зарлигуудаас гүн утгын хураангуйлан заасан нижгээд олон буй ч, тийн заагаагүй ч олон бий. Тиймээс заасан гол номоос авах хэрэгтэй бөгөөд хураангуй аваас дэлгэрэнгүйгээс нь авах хэрэгтэй. Улмаар агуу явдлын зүгээс ч мэдэж авах хэрэгтэй. Гүн болоод агуу их хоёрын аль алин нь байхгүй тийм зүгийг даган барьж болохгүй. Үүнийг болгоож мөрийг заагч багшийн бэлэг чанар төгс төгөлдөр байх хэрэгтэй гэж хамаг хөлгөний мэргэд олонтаа айлджээ.

25. АМАРЛИНГУЙ, ҮЛЭМЖ ХОЁР ХОСЛОН ОРОХ НЬ:

Ямар нөхцөлд тэдгээрийг хослон барилдсан гэх вэ? Тэр адилыг олохоос өмнө тус тус атгалан агуулах бясалгал нь өөрийн хүчээр үл атгаглаж орших ганц хувийг ч татаж чадахгүй. Харин агуулах, шинжлэх хоёр бясалгалд тус тус шамдаж бясалгаж чадах хэрэгтэй байдаг. Тиймд тус тус онох шинжлэх бясалгал үйлдэж тэр хоёрыг олсноор л амарлингуйдаа татагдаж хослон барилдсан болно.хэмээжээ.

б. Ялангуяа Очирт хөлгөнөө суралцах ёс: Тийнхүү Судар (сутра), дандар (тантра) хоёрын "нийтийн мөр"-ийг судалсны дараагаар эргэлзэлгүйгээр "Нууц тарнийн хөлгөн"-өө (самг: tantrayana) ороорой. Энэхүү мөр нь буюу маш ховор чухаг ном бөгөөд хоёр буяны чуулганыг түргэнээ төгс төгөлдөр үйлдэх бөлгөө.Эхлээд дандрын аймгийн үндэснээс үүсэх зэргийн бурхадыг хүрдийг бүрэн гүйцэд номносон дагуу бясалгах хэрэгтэй. Дандрын мөрийн нийт бусын тэвчигдэхүүн нь цогцос, язгуур, төрөн түгэхүйд "өөрийн дураар шунах" буюу "эгэлд үзэх атгаг" билээ. Түүнийг тэвчихэд орон, бие, төгс эдлэлээ ялгамжаатай үзэгдэл болгон үйлдэх нь "Үүсгэлийн зэрэг" болно. Тэр мэт эгэлийн атгагийг арилгах, түүгээр бурхан бодисадва нар цаг үргэлжид адиститлэх бөгөөд хэмжээлшгүй буяны чуулганыг амар хялбар төгсгөж үйлдэх тул төгсгөлийн зэргийн сав болдог. Цаашлаад дандрын аймгийн үндэснээс гарсан дагуу "Төгсгөлийн зэрэг"-ийг бясалгах хэрэгтэй. Тиймээс ханьцашгүй егүзэрийн мөрийн бие төгс төгөлдөр болсон хоёр зэргийн увдисыг барьж үйлдээрэй. Энд эдгээрээр нэр төдий үүднээс дандрын ёсноо орох зүг төдий нэгийг үзүүлсэн болой. Дэлгэрэнгүйг "Нууц тарнийн мөрийн зэрэг"-ээс мэдэх хэрэгтэй. Тэр адилын ёсоор суралцваас судар, дандрын аньс бүхнийг хураасан, мөрийн бие огоот төгс төгөлдөр ёсноо суралцаж чөлөө учрал олсоны хэргийг төгс үйлдэх бөгөөд Ялгуугсаны үзүүлсэн дээдийн ном их эрдэнийг өөр, бусдын үндэснээ дэлгэрүүлэн үйлдэх чадалт болмой.

Редакторын үг

Богд Зонхова гэгээнтний айлдаж туурвисан "Их бодь мөрийн зэрэг" их бүтээлийг Т. Булган багш мэргэн уншигч Та бүхэндээ зориулж, мэдлэг оюуны тань боловсролд туслах үүднээс бүрэн эхээр нь Түвдийн номын хэлнээс, эдүгээ цагийн Монгол хэлнээ орчуулан барьж байгаа билээ. Одоо уг бүтээлийн төгсгөлийн хоёр бүлгийг орчуулж гүйцээн, удиртгал бичиж, монгол – англи, англи – монгол хэл дээр буддын ухааны зарим нэр товъёо, ном зүй, эх бүтээл зэргийг хавсарган та бүхэндээ барьж байгаад нь бид баяртай байна. Миний бие, гавж Ө. Гүндсамбуугийн хамт уг бүтээлийн орчуулгыг ариутган шүүх редактораар ажиллаж ирсэн болно. Энд үзүүлж байгаа "Амарлин оршихуй ба үлэмж үзэхүй" хэмээх хоёр бүлэг нь чухамдаа Бурхан багшийн ертөнцийг үзэх үзэл буюу жинхэнэ гүн ухааны үзэл онолыг тухайлбал хоосон чанарын үзэл онолыг тайлбарласан гүн ухааны тайлбар бүтээл билээ. Зонхава богд бурхан багшийн гүн ухааны үзлийн зүрхэн болсон хоосон чанарыг тайлахдаа гадаад, дотоодын олон тогтсон таалал, философийн ёсны олон аймгуудын үзэл баримтлалуудыг хооронд нь харьцуулан жиших, буруу баримтлал зэргийг шүүмжлэх, зөв дүгнэлт зэргийг учир шалтгаан, нотлолын үүднээс шинжилгээ анализ хийж тайлбарлажээ. Чингэхдээ хоосон чанарыг шүтэн барилдахуйн гүн гүнзгий үзэл онолтой барилдуулж, Бурхан багшийг тогтсон тааллын аймгийн хамгийн дээд болох Төв үзлийн /Мадхъямика/ фиолософикийн ёсноо авч үзсэн чухал онцлогтой билээ. Тэрээр энэ утгаа тодотгон "Мөрийн гурван зэрэг" бүтээлдээ:

Ахуй ёсыг онох ухаан төгөлдөр бус болвол
Алив машид гарахуй болон бодь сэтгэлд машид шамдавч
Ажрах сансрын зовлонгийн үндсийг тасалж чадахгүй тул
Алин шүтэн барилдахуйг онохын арганаа шамдаарай

хэмээн чухалчилсан байдаг.

"Амирлан ахуйн аймаг" нь үймэрсэн сэтгэлийг тогтооход чухал тустай бөгөөд энэхүү номыг уншсанаар сэтгэлээ тогтоох, билгүүнээ нээх, миний дайсан болсон гомдох, гутрах, уурлах омгорхох, мунхрах, амин хувиа хичээх зэрэг муу атгаг бодлыг дарж, олон амьтанд асран нигүүлсэхүй зэрэг энэрэнгүй сэтгэлийг төрүүлэх, юмны мөн чанар, ертөнцийн утга учрыг мэдэж зовлонгоос ангижрахад ач тустай ном билээ. Энэхүү утга гүнзгий, хүн амьтанд их тустай дээдийн номыг хичээл, ухаанаа зарж, сурч судлан орчуулсан, олон түмэндээ хүргэсэн буянд тань даган баясаад энэ номын уншсан, сонссон, сурсан судалсан хүмүүс бүгдээр амарлан оршихуйн эрхэм бясалгалыг түргэн олоод, түүнээс улбаалан хоосон чанарын эрдмийг түргэнээ олох болтугай гэж ерөөл талбъя.

/Занабазарын нэрэмжит Бурханы шашны Их Сургуулийн профессор, гавж Д.Цэрмаа, Шунлайв, гавж Ө.Гүндсамбуу нар 2006.12.15/

АМАРЛИНГУЙ ОРШИХУЙ БА ҮЛЭМЖ БИЛИГ

1

АМАРЛИНГУЙ ОРШИХУЙ БА ҮЛЭМЖ БИЛИГ

(2) Сүүлийн хоёр барамидад суралцах ёсон

V. Амарлингуй (амарлих орон) сэтгэлд суралцах ёсон

А. Амарлингуй болоод үлэмж үзэхүйг бясалгах тус эрдэм

Б. Амарлингуй болоод үлэмж үзэхүйд бясалгал бүхэн хураагдах ёсон

В. Амарлингуй болоод үлэмж үзэхүйн мөн чанар

Г. Амарлингуй болоод үлэмж үзэхүй хоёуланг бясалгах хэрэгтэйн учир

Д. Эрэмбэ зэргийг магадлах ёсон

Е. Тус тусын ёсноо суралцах (2-25 дугаар хэсэг)

---оОо---

V. Амарлингуй (амарлин оршихуй) сэтгэлийг бясалгах ёсон

(Их төрөлхтний мөрийн зэргээс Бодисадвын явдалд орж дияаны мөн чанарт амарлингуй сэтгэлд (амарлин оршихуй) суралцах ёсон)

(2) Сүүлийн хоёр барамидад суралцах ёсон

Их нигүүлсэл төгөлдөр оройн дээд богд дээдсийн өлмийд бишрэн мөргөмүй.

Ялангуяа сүүлийн хоёр барамидад суралцах гэдэг амарлингуй сэтгэл (амарлин оршихуй) болон үлэмж үзэхүйн ухаан хоёрыг бясалгаж бүтээх ёсон билээ. Тэр хоёрыг бясалгаж бүтээх явдал нь "бясалгал болоод билиг барамид" хэмээх сүүлийн хоёр барамидад тус тус хураагдах ажгуу.

Үүнд зургаан зүйл:

А. Амарлингуй болоод үлэмж үзэхүйг бясалгах тус эрдэм

Б. Амарлингуй болоод үлэмж үзэхүйд бясалгал бүхэн хураагдах ёсон

В. Амарлингуй болоод үлэмж үзэхүйн мөн чанар

Г. Амарлингуй болоод үлэмж үзэхүй хоёуланг бясалгах хэрэгтэйн учир

Д. Эрэмбэ зэргийг магадлах ёсон

Е. Тус тусын ёсноо суралцах (2-25 дугаар хэсэг)

А. Амарлингүй болоод үлэмж үзэхүйг бясалгах тус эрдэм

Их, бага хөлгөний ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөн эрдэм бүгдээр амарлингүй сэтгэл болоод үлэмж үзэхүй ухааны үр мөн билээ. *"Хутагт таалын магад тайлбар"-аас:*

Майдар аа, Аливаа Сонсоод сонсогчид, Бодисадва болон Ялгуусан бурхад нарын ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөн буянт эрдэм ном бүгдээр амарлингүйн бясалгал болоод үлэмж үзэхүй ухааны үрд төрнө хэмээн мэдээрэй гэж зарлигласан буй.

Эргэлзээ: Амарлингүй болоод үлэмж үзэхүй хоёр чинь "бясалгалаас төрсөн ухаан"-ыг олсон хэн нэгний үндсэнд байх эрдэм биш үү? Дээрх эрдэм бүгдийг тэр хоёрын үрд төрөх гэсэн нь яаж таарч байна вэ?

Хариулт: Жинхэнэ амарлингүй болоод үлэмж үзэхүй нь саяын хэлдэг шиг "бясалгалаас төрсөн ухаан"-ыг олсон хэн нэгний сэтгэл дэх эрдэм гэвэл их, бага хөлгөний эрдэм бүгд тэр хоёрын үр биш гэх тал бий. Гэхдээ сэтгэл нь буяны бодол зоригдолд нэгэн үзүүрт болж чадахаас дээшхи аливаа самади бясалгалууд нь амарлингүй сэтгэлийн зүгт хураагдах ба, үнэмлэхүй болоод янагуух утгыг тус тус ялгах буянт ухаанууд нь үлэмж үзэхүйн зүгт тус тус хураагдана. Үүнийг болгоож гурван хөлгөний эрдэм бүгд амарлингүй болоод үлэмж үзэхүйн үр болно гэж номносон байх тул харшлахгүй.

Энэ талаар *"Их хөлгөнөө сүсэг бясалгах судар"- аас:*

Язгуурын хөвгүүн ээ, Ийнхүү эдгээр зүйлийн эрдмүүд төрөх буюу бодисадва нарын их хөлгөнөө сүслэх сэтгэл зэргүүд их хөлгөнөөс төрсөн бай ялгалгүй, тэр бүгдээр үл алгасрах сэтгэлийн үүднээс болон утга болоод номыг үнэн зөв бодох ухаанаас төрсөн учрыг мэдээрэй хэмээн айлджээ.

"Үл алгасрах сэтгэл" гэдэг нь амарлингүйн зүгийн нэгэн үзүүрт сэтгэл мөн. "Утга болоод номыг үнэхээр бодох" гэдэг нь үлэмж үзэхүйн зүгийн тус тус онох ухаан болой.

Тиймээс хоёр хөлгөний эрдэм бүгдийг тус тус онох ухаанаар ажиглаж шинжлэх болон нэгэн үзүүрт бодол сэтгэл хоёроор бүтээх учиртай аж. Зөвхөн тогтоох юмуу эсвэл, шинжлэх бясалгал хийх зэрэг өрөөсгөл дангаар бүтээх бус аа.

"Таалын тайлбар"-аас:

Төрөлхтөн бээр үлэмж үзэхүй болон
Амарлингуйг дадуулж үйлдвээс
Муу авирт орны хүлээс ба
Бэлгэсийн хүлээснээс гэтлэх буюу хэмээсэн буй.

Энд өгүүлэх "муу авирт орон" гэдэг нь буруу оронт ухааныг улам ихээр дэврээж сэтгэлд орших муу авьяас болно. "Бэлгэс" гэдэг нь чанх буруу орон вишайд шунаж, урьд хойно ирэх муу авьяасыг сэргээгч аж. *"Билиг барамидын үвдис"-аас* Эхнийхийг үлэмж үзэхгүйгээр дарах ба удаахийг амарлингуй сэтгэлээр дарна" хэмээн номножээ.

Эдгээр нь амарлингуй, үзэхүй хоёрын нэр зүүсэн төдийхний тус эрдэм болно. Энэ хоёрын нэрийг зүүгээгүй ч гэсэн утга адилхан бясалгал дияаны болон билиг ухааны тус эрдмийг өгүүлсэн бол тэр бүгдийг энэ хоёрын тус эрдэм гэж ухаарай.

Б. Амарлингуй болоод үлэмж үзэхүйд бясалгал бүхэн хураагдах ёсон

Үлгэрлэвээс, гол модонд салаа мөчир, навч, цэцэг, үр жимс хэмжээлшгүй их байж болно. Харин тэр бүгдээр оршихын аньс нь үндсэндээ байдаг адилаар их, бага хөлгөнөөс айлдсан эрдэм бясалгал тоолшгүй олон байв ч тэр бүгдийг багтаасан их аньс увдис бүгдийн дээд нь амарлингуй болоод үлэмж үзэхүй мөн билээ.*"Тааллын тайлбар"-аас:*

Би бээр Сонсоод сонсогч нар, бодисадва нар, бурхадын самади бясалгалын элдэв олон номуудыг заасан тэдгээр алин бүхэн амарлингуй болоод үлэмж үзэхүйн язгуурт хураагдана гэж мэдээрэй хэмээжээ. Тиймээс бясалгалыг эрхэмлэгч нар нь тоолшгүй олон тодруулсан ялгал бүхнийг лавлан мэдэж чадахгүй тул бясалгал бүхний ерөнхий үндэс болсон амарлингуй, үлэмж хоёрыг судлах ёсноо лавтай яа суралцан цаг үргэлжид шүтэж үйлдэх буюу.

"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс:

Тийнхүү Ялж төгөлдөр нөгчигсөн тэрээр бодисадваа нарын хэмжээлшгүй олон тус тусын бясалгалыг заан үзүүлсэн ч амарлингуй болоод үлэмж үзэхүй хоёрт л хамаг бясалгал түгэх тул амарлингуй болоод үлэмж үзэхүй хослон орох зөвхөн энэ замыг өгүүлэн үйлдсүгэй хэмээжээ.

Мөн *"Бясалгалын дунд зэрэг"-ээс:*

Тэр хоёрт бясалгал бүхэн хураагдах тул егүүзэр бүтээлчин бүгдээр

цаг үргэлжид амарлингуй болоод үлэмж үзэхүйг л магадтай шүтэж үйлдээрэй хэмээн айлдсан дагуу болой.

В. Амарлингуй болоод үлэмж үзэхүйн мөн чанар

Амарлингуйн мөн чанарын тухай *"Тааллын тайлбар"-аас*:

Тэрээр ганцаар аглаг оршиж, сэтгэлээ дотогшоо баттай тогтоох буюу сэтгэлээ сайтар бодох ёстой зоригдол орон (вишай) руу чиглүүлж үйлдэнэ. Алив сэтгэл чиглэсэн түүндээ анхааралтай сэтгэлээр хандана. Түүнийгээ үргэлжид сэтгэлдээ үйлдэнэ. Түүнийгээ улам цааш сэтгэлдээ үйлдэх болой. Тэр адилаар оршиж, олон дахин үйлдсээр "бие машид боловсрох" болон "сэтгэл машид боловсорох" бясалгал төрөх тэр цагт түүнийг амарлингуй сэтгэл (амарлин оршихуй) хэмээх буюу. Тэр адилаар бодисадва нар амарлингуйг баттай эрж үйлдэх мөн хэмээн айлдсан дагуу болой.

Түүний утга болсон арван хоёр эрхэм зарлигийн утгыг хэрхэн магадлах ба цогцос тэргүүтэн алин нэгэн утгыг зоригдлын (бодлын) орон болгож түүндээ зорих ба, бодох сэтгэлээ бусад зүйлд алгасруулалгүй, дурдан санахуй болон ухамсарлахуй зэрэгтэй бодол юугаа үргэлжид нөхөрлүүлвээс сэтгэл аяндаа зоригдол орон дээрээ чиглэж тогтох болно. Бие, сэтгэл машид боловсрох бясалгалын баясгалан амгалан төрөөд ирэхээр тэр бясалгал нь амарлингуй сэтгэл болж хувирна. Энэ үед чухамдаа сэтгэл маань бодол зоригдлоосоо алгасрахаа больж дотроо барих төдийд л төрдөг болж ирнэ. Харин тухайн орны хоосон чанарыг оножухаарах нь энэ үест хамаарахгүй болно.

Үлэмж билгийн мөн чанарын тухай *дээрх "Судар"-аас:*

Тэрхүү машид боловсорсон бие болон машид боловсорсон сэтгэлийн бясалгал тэдгээрийг олсны дараа тэдгээрт оршиж, сэтгэлийн намба дүрийг огоорч, санах учиртай тэрхүү номоо, дотоод бясалгалын эдлэх орон буюу тусгал дүрс мэтээр болгоож тус тус оножүйлдэх мөн. Тийнхүү бясалгалын эдлэх орон болсон тусгал дүрс тэдгээрийнхээ мэдэгдэхүүн утгыг тийн ялгах, сайтар тийн ялгах, огоот онох, огоот ажиглах, тэсвэрлэх, хүсэх, өвөрмөц онцлогийг ялгах, үзэх, шинжих, тийн мэдэх зэрэг тэр бүгдийг үлэмж үзэхүй хэмээмой. Тиймээс бодисадва нар үлэмж үзэхүйд мэргэн мөн хэмээн айлдсан болой.

Эл сударт тус тус оногч билиг болсон үлэмж үзэхүйг хүчирлэн мэлзэлгүй маш тодорхой номносон үүнийг үзээд хятадын хамба Хуушаан

"Энэ судар чинь юу ч ухаараагүй юм байна" гээд хөлөөрөө дэвсэлсэн гэдэг. Хуушаан тэрээр "атгаг бүгд нь бэлгэст баригч ухаан" гэж үзэж үл хэрэгссэн байх бөгөөд, харин чингэхийн оронд "сэтгэлдээ юу ч бодохгүй байх нь гүн утгыг бясалгаж байгаа явдал" гэх зэргээр зохисгүй зүгийг гаргажээ. Түүний ёсыг дагагчид машид олон гарсан үзэгдэнэ.

Дээрх тайлбарын дотор буй "тийн ялгана" гэдэг "янагуухийг ялгах", "машид тийн ялгах" гэдэг "үнэмлэхүйг ялгах" болой. "Билиг төгөлдөр сэтгэл атгаг болж болох тул бэлгэст барихын үест огоот атгаг байх ба, үнэхээр онохын үест л огоот шинжигч байж болно" хэмээн Асанга хутагт заасан буй. "Атгаглах" нь "наалдуулан (дөтлөн) онохын утгат буюу. "Шинжлэх" гэдэг нарийвчлан онох буюу. "Бэлгэст барих гэдэг нь үнэхээр бүтсэн гэж барих бус, мэдэгдэхүүнээ зүслэн таних" болой. Тиймээс янагуух болон үнэмлэхүйг ялгаж мэдэх ухаанд огоот атгаглах ба огоот шинжлэх гэж тус тус хоёр хоёр буй. "*Тааллын тайлбар*"-т заасан адилаар *"Хутагт чухаг дээд үүлэн судар"-аас ч:*

Амарлингуй бол нэгэн үзүүрт сэтгэл буюу
Үлэмж үзэхүй бол үнэхээр тус тус онох болой хэмээн тодорхой айлдсан буй.

Майдар гэгээн *"Судрын чимэг"-тээ:*

Номын нэрийг хураасан үүнийг ч
Амарлингуй сэтгэлийн мөр гэж мэдээрэй
Үлэмж үзэхүйн мөр нь тэдгээрийн утгыг
Тийн шинжлэх гэж мэдээрэй хэмээсэн ба,

Үнэхээр оршихуйд шүтэж
Сэтгэлдээ сэтгэлээ агуулан тогтоох болон
Ном, юмсыг машид ялган мэдэхээр нь
Амарлингуй болоод үлэмж үзэхүй мөн

хэмээн үнэн бясалгалд шүтэж сэтгэлээ тогтоохыг амарлингуй гэх ба ном, юмсыг сайтар ялгаж танин мэдэхийг үлэмж үзэхүй болно гэж айлджээ. Судраас тийнхүү зарлигласан утгыг тэр ёсоор тайлбарласан учир судрын утгыг өөр утгаар тайлж болохгүй болой. *"Бодисадвын газар"-аас:*

Өгүүлшгүй бодас төдий болон утга төдий бодол зоригдолд сэтгэлээ баттай тушааж, цацрал бүгдээс хагацсан буюу сэтгэлийг үргэлжид алгасруулагч

бүхнээс салсан хур мэдлийг сэтгэлдээ үйлдэж, бодол зоригдол бүхнээ санаад, дотоод бясалгалаар бэлгэс шинж дээр сэтгэлээ тогтоон хураах ба тогтоогоод дэлгэрүүлэх зэргээр нэгэн дамжлагаар бясалгал болтол үйлдэх түүнийг л "амарлинг оршихуй бясалгал" хэмээх болой. Үлэмж үзэхүй гэж юу вэ? Амарлингуйд төгс дадсан бясалгалыг сэтгэлдээ үйлдэх тэрээр санах учиртай тэдгээр ном, юмсын бэлгэс шинжийг сэтгэлдээ үйлдэх ба ялгах, машид ялган үйлдэх, номыг машид ялган дэлгэрүүлсээр мэргэшин ухаандаа оруулах хүртэлх тэр бүгдийг "үлэмж үзэхүй" хэмээмой хэмээн дээрхтэй адилаар айлдсан байна.

Үгээр судар болоод шастар хоёулангийн тааллыг урьдын адил тайлаад дээрх амарлингуй болон үлэмж үзэхүйн талаархи ойлголтоо лавтай бататгаж аваарай. *"Бясалгалын дунд зэрэг"-ээс ч*

Гадна талын орноо тийн алгасарахыг амарлиулаад дотор талын бодолдоо үргэлж өөрийн эрхээр орохуйяа баясгалантай болох, маш боловсрох, төгс сэтгэлд орших зэрэг нь амарлингуй мөн" хэмээжээ. Тэрхүү амарлингуйд оршихын цагт зөвхөн тэр ямагт утгыг тийн шинжлэх түүнийг үлэмж үзэхүй мөн хэмээжээ.

"Билиг барамидын увдис"-аас ч:

Янагуух болон үнэмлэхүйн алин болох зэргийг огт атгаглаж бодолгүйгээр, тусгал дүрс адилаар буух тусах нь амарлингуй бясалгалын зоригдол орон болно. Янагуух болон үнэмлэхүйн алин эсэхийг атгаглаж бодох зэргээр тусгал дүрс адилаар буух нь үлэмж үзэхүйн зоригдол болно хэмээн үнэмлэхүй болоод янагуух утганаа үл атгаглаж, тогтоох сэтгэлийг амарлингуй гэх ба, энэ хоёр орныг магадалж шинжих ухааныг үлэмж үзэхүй болохыг айлджээ.

"Тааллын тайлбар"-аас ч:

"Ялж төгөлдөр нөгчигсөн өө, Хэдэн зүйл амарлингуйн бодол зоригдол байна вэ? Зарлиг болрууун, Нэг зүйл буюу, энэ мэт буюу. Тийн үл атгаглах тусгал дүрс болой. Хэдэн зүйл үлэмж үзэхүйн бодол зоригдол байна вэ? Зарлиг болрууун, зөвхөн нэг зүйл. Тийн атгаглах тусгал дүрс болой. Тэр хоёулангийн бодол зоригдолд хэдэн зүйл вэ? Зарлиг болруун, Хоёр зүйл буй. Бодасын хязгаар болон тус хэрэг огоот бүтсэн болой хэмээн айлдсан таалал болой.

"Хотол хураангуй"-гаас: "Бодасын хязгаар" гэдгээр янагуух ба үнэмлэхүй хоёуланг айлдсан гэжээ. Шандэва бээр (Раднакарашанти) дээр

номносон мэт "амарлингуй, үлэмж билиг хоёрт тус тус үнэмлэхүй болон янагуух зоригдол буй" гэжээ. Амарлингуй, үзэхүй хоёр нь бодлын орны хувьд тус тус ялгагдахгүй байж болно. Хоосон чанарыг оносон амарлингуй сэтгэл ч байж болох, хоосон чанарыг оноогүй үлэмж үзэхүй ч бас бий. Гэхдээ сэтгэл гадна орноо гүйх явдал амарлиад, бодол зоригдолдоо орших болсныг амарлингуй гэнэ. Үлэмжийн буюу илүү ялгааг мэдэх үүднээс үлэмж үзэхүй хэмээсэн буй.

Заримууд сэтгэлээр үл атгаглан орших буюу ухааны тодорхой хувь нь иргүй мохоо байхыг амарлингуй гээд, тодорхой хувьтай, иртэй байхыг үлэмж үзэхүй гэж үздэг нь таарахгүй зүйл ээ. Бурханы зарлиг болоод бурхадыг орлоочдын ном шастар, Асанга гэгээний *"Гол номууд"* болон *"Бясалгалын зэрэг"* тэргүүтэн ном судар болон амарлингуй болоод үлэмж үзэхүйн бэлэг чанарыг агуу ихээр тайлбарлан үзүүлсэн зэргээс *"сэтгэлийн зоригдол бодол нэгэн үзүүрт болгосон бясалгалыг амарлингуй"* ба *"мэдэгдэхүүний утгыг асар сайтар ялгагч ухааныг үлэмж үзэхүй"* хэмээн айлдсантай харшилж байна.

Ялангуяа үл атгаглах сэтгэлд тодорхой хувь байх, байхгүй гэдэг нь бясалгалын үед живэлт буй, үгүйг ялгасан болохоос амарлингуй болоод үлэмж хоёрын ялгаа огт биш. Амарлингуйн бүх бясалгал дээр ч живэлтээс ангижирсан байх учиртай. Живэлтээс ангижирсан бясалгал бүхэнд сэтгэлийн тунгалаг тодорхой хувь лавтай ирдэг учиртай.

Тиймээс үнэмлэхүйд зорьсон бясалгал болоод билиг мөн гэдгийг орон болсон хоёр "би-үгүй" алин нэгнийг тэрхүү ухаан онох, эс онохын талаас танин барих болохоос сэтгэл амгалантай, тунгалаг байх, атгаглан орших, эс орших зэргийн үүднээс танин барьж болохгүй. Учир нь "би-үгүй" буюу хоосон чанар зэрэгт ухааны ам зүглээгүй амгалант, тунгалаг, үл атгаглагч бясалгалууд тоолшгүй олон байдаг.

Энэ мэтээр ахуй ёсыг оносон үзэл онолыг олоогүй ч гэсэн сэтгэлээр юу ч атгаглан барьснаар болно гэх нь илт тохиолдоно. Хэдий хоосон чанарыг ухаараагүй ч үл атгглах бясалгал төрөх хоёр харшлах зүйл огтхон байхгүй. Түүний агаарт сэтгэл ээлэгдэх болсны хүчээр хийгээ (махбодь) үйлнээ эдэлдэг, эзэмшдэг болж ирнэ. Чингээд ирэхээр сэтгэлд амгалан баясгалан төрөх жамтай тул амгалан төрөхөд ч үл харшилна. Тэр төрөөд ирэхээр амгалан баясгалангийн амсуурга тодорхой болсны хүчээр сэтгэлд тунгалаг тодорхой хувь ургадаг байна. Тиймээс ийнхүү буй болсон тунгалаг тодорхой, үл атгаглах бясалгал бүхэн хоосон чанарыг ононо гэдэг үнэмлэхүй нотолгоо гарахгүй байна.

Тиймд хоосон чанарыг оносон бясалгалд ч амгалан, тунгалаг, үл атгаглах буй. Хоосон чанарт толгой зүглээгүй бясалгалд амгалан, тунгалаг, үл атгаглах гарах нь машид олон тул энэ хоёрын ялгааг салгаж мэдэх шаардлагатай.

Г. Амарлингүй болоод үзэхүй хоёуланг бясалгах хэрэгтэйн учир

Юуны учир амарлингүй болоод үлэмж үзэхүйг тус тус бясалгалгүй хоёуланг бясалгах хэрэгтэй хэмээвээс, номнож үйлдсү.

Үлгэрлэвээс, шөнө хана туурган дээрх зургийг харахаар зул барих үед зул нь машид тунгалаг болоод хөдөлгөөнгүй байх хоёр төгөлдөр байвал зураг маш тодорхой үзэгдэх болно. Зулын гэрэл тунгалаг тод боловч салхи үлээгээд байвал дүрс нь тод харагдахгүйн адил гүн гүнзгий утгыг мэдэхийн тулд хоосон чанарын утгыг зөв таньсан ухаан болоод зоригдол бодолдоо ёсчлон тогтсон сэтгэл хоёр төгс байж л хоосон чанарыг тодорхой үзнэ.

Сэтгэлдээ бусад зүйл рүү цацруулалгүй тогтоосон, үл атгаглах бясалгал байвч мөн чанараа мэдэх ухаан байхгүй бол хоосон чанарыг үзэх нүднээс хагацсан бясалгалыг хичнээн дадуулавч мөн чанарыг онож мэдэхгүйд хүрдэг. Мөн би-үгүй буюу хоосон чанарыг ухаарч мэдсэн үзэл онолтой ч нэгэн үзүүрт батад тогтсон сэтгэл байхгүй аваас өөрийн эрхгүй хөдлөх атгагын хийгээр сэтгэл хямарч ахуй ёсны мөн чанарыг тодорхой мэдэж чадахгүй болно. Иймээс амарлингүй болон үзэхүй хоёулаа хэрэгтэй болно. *"Бясалгалын дунд зэрэг"-ээс:*

Амарлингүйгаас хагацсан, дан ганц үлэмж үзэхүй байвал егүзэрийн сэтгэл вишай орондоо тийн алгасрах болдог. Салхинд тавьсан зул адил батгүй болно. Тэгээд ч билиг билгийн гэгээ маш тунгалаг бус болно. Тиймээс хоёуланг нь адилхан шүтэж үйлдээрэй.

Чингэх учиртайг *"Хутагт огоот их нөгчигсөн судар"-аас:*

Сонсоод сонгогч нар, Тэрчлэн залрагсадын язгуурыг үл үзэхийн учир нь бясалгалын хувь хэмжээ их хэдий ч ухааны хувь хэмжээ өчүүхэн бага байдаг гэж бодисадва нар үзэх боловч тодорхой бус байдаг нь ухааны хувь машид их ч бясалгал нь өчүүхэн бага байдаг. Бурхан бээр хамгийг болгоох бөгөөд амарлингүй болоод үлэмж үзэхүйг адил тэгш төгс төгөлдөр болсон тул болой хэмээн зарлиглажээ.

Сэтгэл нь амарлингүй сэтгэлийн хүчээр салхигүй газар барьсан зул адил асар атгагийн салхинд үл хөдлөх болой. Үлэмж үзэхүй нь буруу үзлийн тор бүгдийг

тэвчсэн тул бусдад дийлдэшгүй. *"Даваа донмэгийн айлтгасан судар"-аас*

Ийм хэмээн, амарлингуйн хүчээр хөдлөх үгүй болох
Үлэмж үзэхүй бээр уул лугаа адил болох хэмээсэн мэт болой.

Иймээс сэтгэл нь бодлоосоо үл алгасарч хаана ч гилбэлэн ив илхэн суух нь амарлингуйн оромдсон журам мөн. "Би-үгүй"-н хоосон чанарыг оноод, "би"-д үзэх зэрэг буруу үзэл бүхнийг тэвчиж чинадын тэмцэгч нарт үл чирэгдэх уул мэт болдог нь үлэмж үзэхүйн оромдсон журам тул тэднийг тус тус ялгаж үйлдээрэй.

Амарлингуй бүтээхээс өмнө тус тус онох билгээр би-үгүйн утгыг шинжлэвч салхинд тавьсан зул адил сэтгэл маш их гэгэлзэх тул би-үгүйн ерөнхий утга донж тодорхой бус байдаг. Аль ч нөхцөлд амарлингуйг бүтээх үест шинжлэвээс хэтэрхий гэгэлзэх гэм буцах болсноор "би-үгүй"-н утга донж тодорхой болно. Учир иймээс үлэмж үзэхүйн үл хөдлөх сэтгэлийн хувь нь үл атгаглагч амарлингуйгаас төрнө. Харин ахуй ёсыг онох хувь нь амарлингуйгаас төрөх бус аа.

Үлгэрлэвээс, зул нь дүрсийг тунгалаг тодорхой гэрэлтүүлж байгаа хувь нь өмнөх зулын гол болон галаас төрсөн болохоос салхинаас халхлах хөшиг зэргээс төрөөгүй хэрэг. Гэхдээ зулны хөдөлгөөнгүй, тогтуун байх хувь нь хөшиг зэргээс хамаардаг шүү дээ. Тэр мэтээр живэх, дошигрох зэргээс шалтгаалж сэтгэл үл тогтох байдлаас ангижирсан амарлингуйн сэтгэл төгөлдөр билгээр шинжиж байж үнэмлэхүй утгыг мэднэ хэмээн болгоосон буй. *"Номын үнэн хураангуй"-гаас:*

Сэтгэлээ тэгшитгэн тогтоогоод үнэмлэхүй утгыг ёсчлон мэдэх мөн хэмээн айлджээ.

"Бясалгалын анхдугаар зэрэг"-ээс:

Сэтгэл ус адил мяралзах тул амарлингуйн суурь байхгүй бол тогтоно гэж үгүй. Тогтоогүй сэтгэлээр үнэмлэхүйн утгыг ёсчлон мэдэж чадахгүй. Ялж төгөлдөр нөгчигсөн бээр ч тогтсон сэтгэлээр үнэмлэхүйг ёсчлон болгоож маш онох болой хэмээн зарлиг болов хэмээжээ.

Амарлингуйг бүтээснээр "би-үгүй"-г ёсчлон шинжих ухааны гэгэлзэх гэм бүгд буцахаар барахгүй мөнх бус болоод үйлийн үр, орчлонгийн гэм эргүү, асрахуй, нигүүлсэхүй, бодь сэтгэлийг судлах зэрэг тус тус онох ухаанаар шинжлэх бясалгал бүгдэд ч зоригдол бодлоосоо алгасарахын алдаа гэмээс

буцаж, өөр өөрийн аливаа бодол зоригдолд бүхэндээ алгасралгүй орох тул алин үйлдсэн буян бүхэн маш хүч ихтэй болдог. Амарлингуйг эс олохын өмнө нь голдуу бусад зүйлд алгасрал байх тул буяны ажил бүгд хүч багатай болдог. *"Бодичарияаватара"-д:*

Сэтгэл нь машид алгасарсан хүмүүн
Нисваанисын соёот шүдний хавцалд орших хэмээсэн ба,

Урин тоолох, хатуужил зэргийг
Өнө удаан хугацаанд судлавч
Сэтгэл бусдад алгасран үйлдвээс
Тэр ямагтыг бүгдээр утгагүй болно хэмээсэн мэт болой.

Тиймээс сэтгэлээ бусад руу алгасруулалгүй нэгэн бодол дээр тогтоож үл атгаглан бясалгалыг бүтээх хэрэг нь сэтгэл юугаа буянт сайн бодол дээр агуулж хэрхэн хүссэнээр сэтгэлээ эдлэх чадал олохын тухайд билээ.

Тийнхүү сэтгэлээ нэгэн бодол зоригдолд чиглүүлэн тогтоож чадвaас нэгэн сайн сувгаар ус татах мэт хэмжээлшгүй олон буяны зоригодолд хэрхэн хүрсэн дагуу одох болно.

Цаашдаа амарлингуйг бүтээснээр үнэмлэхүй болоод янагуухийн орныг тухайлах билиг болон өглөг өгөх сэтгэл, боомтлох сэтгэл, тэсвэрлэх, хичээнгүйлэх, сүслэх, уйсах зэрэг хэмжээлшгүй их буяныг хураах, бас хэмжээлшгүй их гэмийг хариулах бодол ухаануудыг судлах шаардлагатай болно. Цаг үргэлж ганцхан бодол дээр хадагдаж тогтоно гэж бодвол амарлингуйг бүтээхийн хэрэг тусыг ойлгоогүй болж, улмаар буяны үйлст их дорвижилгоо ахиц гарахгүй гэж мэдээрэй.

Тэр мэтээр явдлын зүг болон үзэл онолын зүгийн тус тус онох билгээр шинжлэх бясалгалыг орхивоос нэгэн үзүүрт тогтсон сэтгэлээр бясалгахад ахиц машид бага гарна. Ялангуяа би-үгүйн утганаа өнө удаан, хүчтэй хатуу магадлалыг төрүүлэх арга болсон тус тус онох билгээр шинжлэн судлах үнэмлэхүйд зорьсон үлэмж үзэхүйн ухаан байхгүй бол амарлингуйд хичнээн удаан дадаж сурсан ч нисваанисын ил гарсан толгойг дарах төдийхнөөс хэтрэхгүй, нисваанисын хөрөнгийг ёзоороос нь тасалж чадахгүй. Учир иймээс зөвхөн амарлингуй төдийг бясалгаад зогсохгүй үлэмж үзэхүйг ч бясалгах шаардлагатай болно. *"Бясалгалын дунд зэрэг"-ээс:*

"Бясалгалчин нар зөвхөн амарлингуй төдийд дадаж сурснаар хилэнцийг тэвчиж чадахгүй. Ганц нэг нисваанисийг даран чадсан төдийд л барагдана.

Билгийн гэгээ ургахгүй бол муу авьяасыг баттай дарж чадахгүй болой.

Тиймээс *"Хутагт тааллын магад тайлбар"-аас*:

Бясалгалаар нисваанисийг тийн дарах
Билгээр далд нуугдсан авьяасыг сайтар дарах хэмээн зарлиг болжээ.

"Хутагт бясалгалын хаан судар"-аас:

Бясалгал түүнийг дадуулж болох ч
Тэр бээр "би"-д барих хуран мэдлийг эвдэж үл чадах
Тэр хожим нисваанист чирэгдэн машид хямрах буй
Самадийг бясалгахын сацуу үлэмж үзэл үгээр

Номын "би-үгүй"-г тус тус онох буй за
Хэрэв тус тус шинжлэн бясалгах аваас
Үр нирваан олохын үндэс болох
Бусад ямар ч үндэс нирваан үл болох хэмээн айлджээ.

"Бодисадвын аймаг сав"-аас:

Аливаа бодисадвын номын аймгийн номын зүйлийг сонсоогүй байж, бас хутагтын номхотхуун номыг сонсоогүй байж зөвхөн бясалгал төдий нэгнээр болчихно гэж бодддог чинь омгийн эрхэнд орж илт өөрийгээ дарахын унал болох агаад төрөх, өтлөх, өвдөх, үхэхийн зовлон болон гаслах, цөхрөнгөө барах, зовох шаналах, сэтгэлээр гутрах, хямрах тэрсэхийн аюулаас үл гэтлэхэд хүргэнэ. Зургаан зүйлийн зовлонгоос гэтэлж үл чадна. Зовлонт цогцосоос ч төгс үл гэтлэнэ. Үүнийг болгоож Бурхан бээр Ийн хэмээн бусдаас дагуулан зохилдож сонсох нь өтлөх үхэхээс гэтэлгэнэ" хэмээн зарлиг болов хэмээн айлдсан буй.

Тийм учраас түйтгэр бүхнийг арилгах билиг билгийг олохыг хүсвээс л амарлингүй сэтгэлд оршин байж үлэмж үзлийг бясалгаж үйлдээрэй. *"Хутагт чухаг дээд давхарлага судар"-аас* ийн зарлиг болруун:

Шагшаавадад оршиж бясалгал олох
Бясалгалыг олоод билгийг дадуулж үйлд
Билгээр асар арилсан билиг билгийг олох
Асар арилсан билиг билгээр шагшаавад хотол чуулган болох хэмээжээ.

"Хутагт их хөлгөнөө сүсэг бясалгах судар"-аас:

Язгуурын хөвгүүн ээ, билигт шадарлан үл ойртвоос, бодисадва нар их хөлгөнд сүжигтэй байна гэх, их хөлгөн нь ингэж төрнө хэмээн би өгүүлж үл чадна хэмээн зарлиг болгожээ хэмээн айлдсан тул болой.

Д. Эрэмбэ зэргийг магадлах ёсон

"Бодичарияаватара"-гаас:

Машид амарлингуй төгөлдөр үлэмж үзэхүйгээр
Нисваанисыг тийн дарж үйлдэхийг мэдээд
Эхлээд амарлингуйг эрэлцэж үйлдэх

хэмээн зарлиглан заасан тул амарлингуйг бүтээгээд цаашид түүнээ шүтэн байж үлэмж үзэхүйг бясалгах мөн.

Эргэлзээ: Тийн болохыг *"Бясалгалын анхдугаар зэрэг"-ээс:* Түүний зоригдолд батгүй болой хэмээн амарлингуйн зоригдлыг лавтай тодорхойлж болохгүйг үзүүлжээ. Дээр номносон мэт амарлингуйн зоригдолд номын нэр болоод номын чанар хоёулаа байх тул эхлээд "би-үгүй"-н утгыг ухаараад түүнийгээ бясалгах мөн. Чингэвээс сэтгэл бусдад үл алгасрах амарлингуй болоод хоосон чанарыг тухайлсан үлэмж үзэхүй хоёулаа нэгэн цагт төрж болох юм биз. Гэвч эхлээд заавал амарлингуйг эрэлцээд дараа нь үлэмж үзэхүйг бясалгана биз дээ?

Хариулт: Амарлингуй нь үлэмж үзэхийн өмнө одох учир "би-үгүй"-г онох үзэл онолын ухаарал төрөхөд өмнө нь амарлингуйг одуулах шаардлагагүй. Амарлингуйг олоогүй ч үзэл онолтой байх нь үзэгдэнэ. Бас тэрхүү үзэл онол руугаа сэтгэл урвах амсуурга мэдэл төрөхөд ч өмнө нь одуулах хэрэггүй. Амарлингуй байхгүй ч тус тус онох билгээр дахин дахин шинжлэн дадуулсаар сэтгэл урвах байдал төрнө гэдэгтэй харшлахгүй. Хэрвээ харшилна гэвэл мөнх бус, орчлонгийн гэм эргүү, бодь сэтгэлийг судлах зэргээр сэтгэл урвахын амсуурга төрөх болгон нь амарлингуйд харгалзах болж бүр хэтийдэлд ч хүрэх адилхан учир шалтгаанууд бий болно.

Чингэхэд амарлингуй нь үлэмж үзэхүйд ямар хэрэгтэй юм бэ гэвэл, Энэ талаар *"Тааллын тайлбар"-аас* айлдахдаа: Тус тус онох билгээр тийн ялгах ба асар тийн ялгах бясалгал тэр хэзээ байх хүртэл буюу машид боловсорсон бие сэтгэл үүсэж хараахан чадаагүй байгаа тэр хүртэл үлэмж үзэхүйтэй даган зохилдсон сэтгэл байдаг юм. Түүнээс цааш машид боловсрол төрөөд ирэхээр үлэмж үзэхүй болно" гэж зарлигласан тул амарлингуйг олоогүй байж, тус тус онох билгээр шинжлэх бясалгал хэдий чинээ үйлдэвч түүний эцэст машид боловсорсон бие, сэтгэлийн амгалан баясгаланг төрүүлж чадахгүй.

Харин амарлингуйг олчихоод тус тус онох билгээр шинжих бясалгалыг үйлдсэнээр сүүлдээ машид боловсролыг төрүүлж чадах тул амарлингуй нь түүний үндэс болох учиртай бөгөөд дараа номлосугай.

Тиймээс нэгэн бодол дээр тогтолгүй шинжлэх, тус тус онох ухааны хүчээр машид боловсролыг төрүүлж чадвал үлэмж үзэхүй болж болно. Гэсэн ч вишайн хувьд хоосон чанарын тухайлавч, сэтгэлээ нэгэн бодолд агуулсны эрхээр машид боловсролыг төрүүлэх гэдэг амарлингуйг бүтээх ёсноос үл хэтрэх тул тэр төдийгөөр үлэмж үзэхүйг оллоо гэж хэлж болохгүй. Тэр мэт эхлээд би-үгүйг ухаарахыг эрэлцээд түүний утгыг дахин дахин шинжлэн үйлдсэн ч өмнө нь амарлингуйг бүтээгээгүй учир түүнээ шүтэн амарлингуйг бүтээх гэж үгүй.

Шинжлэлгүйгээр агуулан бясалгаж, түүнээ шүтэж амарлингуйг бүтээж болох ч амарлингуйг судлах ёсноос ангид үлэмж үзэхүйг судлах ёс байхгүй тул хожмоо үлэмж үзэхүйг хайх хэрэг гарна. Тиймээс урьдаар амарлингуйг олоод түүнээ шүтэж үлэмж үзэхүйг бясалгах зэргээс үл хэтрэх болно.

Тиймээс үлэмж үзэхүйг төрүүлэхдээ тус тус онох, шинжлэх бясалгалаар машид боловсролыг төрүүлж эс үйлдвээс өмнө нь амарлингуйг олж түүнээ шүтэж үлэмж үзэхүйг бясалгах үнэнхүү учир шалтгаан юу ч үгүй үгүйсгэгдэнэ. Энэ мэтийн эрэмбэ зэргээр бясалгах нь маш зохисгүй мөн.

"Тааллын тайлбар"-аас: Амарлингуйг олсноо шүтэж үлэмж үзэхүйг бясалгах учиртайг дээр заасан дагуу айлдсан буюу. Урдахдаа шүтэж хойтхи нь төрнө хэмээн зургаан барамидын самади бясалгал болон билиг ухааны зэргүүд болоод үлэмж бясалгалын суртгаалд шүтэж үлэмж билгийн суртгаал төрдөг зэрэг нь өмнө нь амарлингуйг бясалгаж дараа нь үлэмж үзэхүйг бясалгахын зэрэг билээ.

Өмнө нь Асанга гэгээний "*Бодийн газар*" болон "*Сонсогчийн газар*"-аас үзүүлсэн мэт "амарлингуйд шүтэж үлэмж үзэхүйг бясалгана" гэж айлдсан ба Вхававивека гэгээний "*Төв үзлийн зүрхэн*", Шантидэва гэгээний "*Бодичарияаватара*", Камалашила гэгээний "*Бясалгалын гурван зэрэг*" шастаруудаас болон Ишдавга (Занакирти), Шандэва (Раднакарашанти) зэрэг мэргэд ч гэсэн "өмнө нь амарлингуйг олсны дараа үлэмж үзэхүйг бясалгана хэмээн зарлиглажээ.

Учир иймээс, Энэтхэгийн зарим мэргэд бээр "амарлингуйг тусгайлан эрэлгүй эхнээс нь тус тус оногч билгээр шинжилж үлэмж үзэхүйг олно" гэх нь "Их тэрэгчин" нарын номтой харшлах тул ухаантан нарын сэтгэл итгэмжлэх орон болохгүй байна. Амарлингуй болоод үлэмж үзэхүйн эрэмбэ тэдгээрийн

дагуу эхлээд шинээр үүсгэхийн цагт тэр мэтээр үйлдэхэд, үлэмж үзэхүйг эхэлж бясалгаад дараа нь амарлингуйг бясалгах эрэмбэ нь батгүй гэдэг нь сүүлдээ харагдаж байна.

Асуулт: "Хотол хураангуй"-аас: Заримууд үлэмж үзэхүйг олох болохоос амарлингуйг олоогүй буюу. Үлэмж үзэхүйд шүтэж амарлингуй хичээн үйлдэх хэмээн айлдсан нь юу вэ?

Хариулт: Энэ болвоос анхдугаар дияаны бэлтгэлд (нирдог) багтах амарлингуйг олоогүй гэж хэлсэн бус. Анхдугаар дияаны бодит сууриас (ойши) дээшхи амарлингуйг олоогүйг хэлж байгаа хэрэг. Дөрвөн үнэнийг илт оножбайж түүнээ шүтэж, анхдугаар дияанаас дээшхи амарлингуйг бүтээдэг билээ. *"Газрын бодит суурь"-аас:*

Мөн зовлонгийн үнэнээс мөрийн үнэн хүртэл үнэхээр ямарчлан болгоож сайтар ухааравч, анхдугаар дияан тэргүүтнийг эс олох буюу. Бясалгалд суунгуут сэтгэл тогтох буюу тийн ялгаж чадахгүй. Тэрхүү үлэмж билиг ямагтад шүтэж үлэмжийн сэтгэлд наалдаж төрнө хэмээжээ.

Ер нь томъёо төдий хэмээгээд хялбар болгож "есөн сэтгэлийг амарлингуй" гэх ба "дөрвөн тийн ялгахуйг үлэмж үзэхүй" хэмээн айлдсан байх ч жинхэнэ амарлангуй нь саяын номносон мэт "машид боловсрол" төрснөөр тооцогдох ёстой болно.

2

БЯСАЛГАЛЫН БЭЛТГЭЛ АЖИЛ

Е. Тус тусын ёсноо суралцах ёсон (2-25 дугаар хэсэг)

1. Амарлингуйд суралцах ёсон
  а. Амарлингуйн чуулганыг шүтэх
  б. Түүнээ шүтэж амарлингуйг бясалгах ёсон
    1) Бэлтгэл ажил
    2) Бодит суурь
      а) Биеийн явдал мөр юу адил байхыг бясалгах
      б) Бясалгалын эрэмбэ зэргийг номнох
        (1) Бясалгалыг гэмгүйгээр бүтээх ёсон
          (а) Сэтгэлээ бодол зоригдолд тушаахын өмнө хэрхэн үйлдэх
          (б) Бодол зоригдолд тушаах үест хэрхэн үйлдэх
            1/ Сэтгэлээ юунд тогтоох суурь зоригдол орноо бодитоор танин барих
              а/ Ерөнхий зоригдол орон
                /1/ Зорих орныг бодитой үзүүлэх
                  /а/ Түгээмэл зоригдол
                  /б/ Явдлыг ариусгах зоригдол
                  /в/ Мэргэдийн зоригдол
                  /г/ Нисваанисыг тийн арилгах зоригдол
                /2/ Ямар бодгаль, ямар зоригдол бодлыг бодитой үзүүлэх
                /3/ Зорих орны нэрийн зүйлийг үзүүлэх
              б/ Тухайн үест буух зоригдол орныг бодитой барих ёсон

- - - о О о - - -

Е. Тус тусын ёсноо суралцах ёсон (2-25 дугаар хэсэг)

1. Амарлингуйд суралцах ёсон (2-6 дугаар хэсэг)
  2. Үлэмж үзэхүйд суралцах ёсон (7-24 дүгээр хэсэг)
  3. Тэр хоёрыг хоёлуулан суралцах ёсон (25 дугаар хэсэг)

Е. Тус тусын ёсноо суралцахуй

1. Амарлингуйд суралцах ёсноо гурав:
   а. Амарлингуйн чуулганыг шүтэх
   б. Түүнээ шүтэж амарлингуйг бясалгах ёсон
   в. Бясалгаж амарлингуй сэтгэлийг бүтээх хэмжээ

а. Амарлингуйн чуулганыг шүтэх

Бүтээлчин бээр эхлэн амар тайван бөгөөд түргэнээр амарлингуйг бүтээхийн үндэс болсон амарлингуйн чуулганыг шүтэж үйлдэнэ. Түүнээ зургаан зүйлээс:

1" Зохилдох оронд орших" гэдэг нь таван эрдэм төгөлдөр орон байна. а/ "Хоол унд, хувцас хунар тэргүүтэн төвөггүй хялбар олдох "сайн олзот" байх, б/ араатан гөрөөс зэрэг догшин хүн, амьтан болоод дайсан этгээд үл орших "амгалан тайван газар" орших, в/ өвчин зовлон үүдэхгүй сайн хөрс шороот "сайн нөхцөлт нутагт амьдрах", г/ зөв ёс суртахуун болон зөв үзэл бодолтой зэрэг "сайн нөхөртэй нөхөрлөх", д/ өдөр олон хүнгүй, шөнө дуу чимээ багатай орон газар бол сайн болой. *"Судрын аймгийн чимэг"-ээс:*

Ухаантны бүтээлийн орон нь
Сайн олзот газар ба амар тайван нутаг
Сайн хөрс шороот сайн нөхөр зэрэг нь
Бясалгалын амгалант төгс эдлэл болно хэмээн айлджээ.

2" Хүсэл шунал багатай байх гэдэг нь номын хувцас тэргүүтэн олон сайн сайхан зүйлд илүү шунахгүй байх явдал болно.

3" Ханах мэдэлтэй байх гэдэг нь номын хувцас хэр тааруу нэгийг олох зэргтээ үргэлжид ханах мэдэлтэй болой.

4" Элдэв ажлыг огоот тэвчих гэдэг нь арилжаа наймаа зэрэг тааруухан ажил болоод гэргийтэн ба хувраг нартай шадарлан ижилсэж нөхөрлөх ба эм барих, зурхай зурах тэргүүтнийг огоорох болно.

5" Шагшаавад ариун байх гэдэг нь тус тус гэтлгэгч болон бодисадвын санваар хоёулангийн өвөрчлөн болон амлашгүйн суртгаалын суурийг үл зөрчих ба хэрвээ сэрэмжгүйн эрхээр алдавч даруй түргэн гэмшиж номын ёсоор жич даруй засч үйлдэх болой.

6" Хүсэл шунал зэрэг асар атгагуудыг тийн огоорох нь алж хөнөөх, хүлж зодох зэрэг хүсэл шуналт сэтгэл зэргийн энэ насны гэм эргүү болоод

муу заянд унагах зэрэг хойд насны гэм эргүү зэргийг эргэцүүлж санана.

Мөн орчлонгийн сэтгэл зохисгүй тэр бүгдээр эвдрэхийн жамт мөнх бус бөгөөд нэн удалгүй би тэдгээрээс салах тул түүгээр юу хийх вэ, юунд их шунана вэ? хэмээн бясалгаж шунал хүслийн атгаг муу бүгдийг тэвчиж үйлдэх буюу.

Эдгээрийг *"Бясалгалын дунд зэрэг"*-ийн таалал дагуу номлов. Дэлгэрэнгүйг *"Сонсогчийн газар"* шастараас үзээрэй. Эдгээр зургаан зүйл нь зөв сайн бясалгал шинээр төрөх болоод төрснийг доройтуулахгүй бататгах ба дээш дээш нь аривжуулахын шалтгаан нөхцөл, аньсыг хураасан бөгөөд ялангуяа ёс суртахуун ариун байх, шунал хүслээ гэмтэйд үзэх, зохилдох орноо орших зэрэг нь гол зүйлүүд болно.

Гэвш Донбава гэгээнээс: Бид зөвхөн увдис гэсээр уршигдах буюу. Зөвхөн увдис хайсаар бясалгал эс бүтээх тэрээр "үндэс" болох юуг ч бүтээхгүй учраас л уршигдах мөн гэжээ.

"Үндэс" гэдэг нь дээр өгүүлсэн "зургаан чуулган" тэргүүтэн болно. Мөн эхний дөрвөн барамид нь тавдугаар бясалгалын чуулганд багтана хэмээжээ. "*Бясалгалын анхдугаар зэрэг"-ээс:*

Амарлингуй нь олз тэргүүтнээ шунах хүсэл тачаалыг үл үзэх бөгөөд тангараг журмаа сайтар сахиж, зовлон тэргүүтнийг ая зөнд нь явах ёсноо хичээнгүйлэн шамдваас түргэн бүтнэ. Тиймээс *"Хутагт тааллын магад тайлбар"* зэрэг тайлбаруудад ч өглөг тэргүүтэн нь дээдийн дээд уг үндэс болно гэж заасан хэмээн айлджээ.

"Мөрийн зул"-д айлдахдаа:

Амарлингуйн гишүүдийг доройтуулчихаад
Асар сайнаар шамдан хэдий бясалгавч
Мянга түмэн жил боллоо ч
Бясалгал дияан үл бүтэх болой

хэмээн айлдсан тул амарлингуй, үлэмж үзэхүйн бясалгалыг зүрхний мухраас хүсэгч нар амарлингуйн гишүүн буюу чуулганы талаар *"Сонсогчийн газар"*-аас айлдсан арван гурван зүйл зэрэгт шамдваас маш их хэрэгтэй болно.

б. Түүнээ шүтэж амарлингуйг бясалгах ёсноо хоёр:

1) Бэлтгэл ажил

2) Бодит суурь

1) Бэлтгэл ажил. Дээр номлосон бэлтгэлийн зургаан ном болоод ялангуяа бодь сэтгэлээ өнөд бясалган түүний гишүүн болгож бага, дунд төрөлхтний нийтийн бодол зоригдлын мөн чанарыг судалж үйлдээрэй.

2) Бодит суурьт хоёр:

а) Биеийн явдал мөр юу адил байхыг бясалгах

б) Бясалгалын эрэмбэ зэргийг номнох

а) Биеийн явдал мөр юу адил байхыг бясалгах.

"Бясалгалын дунд болон суулчийн зэрэг"-ээс айлдсан мэтээр машид зөөлөн амар суудал дээр "найман ном төгөлдөр биеийн явдлыг" үйлдэх болой. Үүнд:

1" Хөлөө Вайрочана (Намбарнанзад) бурханы завилгаа мэт бүтэн завилгаа юмуу хагас завилгааны алин нэгээр үйлдэх мөн.

2" Нүдээ хэтэрхий их бүлтийлгэхгүй, хэтэрхий анилгүйгээр хамрын үзүүрт чиглэсэн байна.

3" Биеийн хувьд хэтэрхий гэдийхгүй, хэтэрхий тонгойхгүй тэгшхэн шулуун суугаад дурдан санах сэтгэлээ дотроо агуулан сууна.

4" Мөр нь тэгш тэнцүүхэн байна.

5" Толгой нь их дээшээ биш, их доошоо биш ганцхан тал руугаа гудайлгахгүй, хамраасаа хүйсээ хүртэл тэгшлэн чиглүүлэнэ.

6" Шүд, ам нь өөрийн байх байранд байлгана.

7" Хэлээ дээд шүднийхээ дэргэд шахаж байрлуулна.

8" Амьсгалаа гадагш, дотогш авахдаа дуу чимээ гаргах юм уу, хэтэрхий хэржигнүүлэх, хүчтэй амьсгалахгүй байх, юу боловч нааш цааш амьсгалах нь үл мэдэгдэх шахам, аажуу талбиун хүчлэлгүй амьсгалах мөн.

"Сонсогчийн газар"-аас: Бурхадын зөвшөөрсөн ширээ, жижиг ширээ суудал болон өвс дэвссэн дэвсгэр дээр завилах зэргээр суухад таван учир шалтгаантай буй хэмээн айлджээ. Үүнд:

1. Биеэ сайтар хянаад явдал мөрдөө сурваас машид боловсрол төрөх ба мөн түүнтэй зохилдох нэгэн болж түргэнээс түргэн "машид боловсрох" эрдмүүд төрөх,

2. Удаан хугацаанд сууж сурах ба тэрхүү явдалдаа бие алжаахаа болих,

3. Эл явдал нь тэрсүүд гадны эсэргэлдэгч нарын явдалтай адилгүй нийт бусын болох,

4. Суудал үүнийг үзээд бусдад сүсэг төрөх,

5. Эдгээр явдал мөрийг бурхан болоод бурханы сонсоод сонсогч нараас зөвшөөн шүтсэн зэрэг эдгээр таван учир шалтгааныг мэдэж завилан суухыг зарлиглажээ.

Биеэ тэгш шулуутган суух нь нойр хүрэх, балартах зэрэг төрөхгүйн тухайд айлджээ. Энэ мэтээр эхлээд биеийн найман явдал болоод ялангуяа, хийн хэмжээг хэрхэн тааруулах ёсоор бүтээгээрэй.

б) Бясалгалын эрэмбэ зэргийг номнох

"Бодь мөрийн зэрэг" болон *"Дундад (төвийн) хязгаар"* зэрэг шастаруудаас их зонхидоо "таван гэмийг тэвчих, найман хур мэдлийн шүтэхийн" үүднээс амарлингуйг бүтээнэ" хэмээн айлдсан байна. Мөн Гэвш Лагсарвагаас дамжсан увдисууд болон *"Сонсогчийн газар"* зэргүүдээс "Зургаан хүч", "Дөрвөн сэтгэлд үйлдэхүй", "Есөн сэтгэл" зэргийн үүднээс бүтээхийг номносон байна. *Мэргэн Ёндондагва* бээр:

Сэтгэл тогтоох есөн арга болон сэтгэлд үйлдэх дөрөв зэрэгт хураасан ба зургаан гэм болоод түүний өрөндөг найман хуран үйлдэхүй энэ бүгдийг бясалгал бүхний арга мөн. *Судрын олон аймгууд болон "Судрын аймгийн чимэг", "Дундад хязгаар", Асанга гэгээний "Газрын аймаг" болон "Бясалгалын гурван зэрэг"* тэргүүтэн бясалгал хийх аргыг заасан бүгдтэй нэгэн адил хэмээгээд, Эхлээд бясалгалын чуулганыг бүтээх эдгээр аргуудад шамдваас бясалгал самадийг лавтай бүтээнэ. Өнөөдрийн бясалгалын гүн гүнзгий арга увдис гэж алдаршсан бүхэнд эдгээрээс нэр төдий ч үл үзэгдэнэ. Бясалгалын чуулган төгөлдөр бус болж, дээр нь эдгээр аргууд байхгүй бол хичнээн өнө удаан шамдавч бясалгалыг бүтээж чадахгүй." хэмээн өөрийн зохиосон *"Бодь мөрийн зэрэг"*-тээ номносон бөгөөд үүгээрээ үндсэн гол номуудаас айлдсан бясалгалыг бүтээх ёсыг зөв магадлаж олохыг үзүүлжээ.

Ер нь гурван хөлгөний мөрийн зэргээр хөтлөх ёс журмыг Асанга хутагт бээр *"Газрын аймаг"*-таа дэлгэрэнгүй номносон учир бясалгалыг заасан энэ ном маш дэлгэрэнгүй нэгэн болой. Зарим номонд дэлгэрэнгүй номносон байхад, нөгөө номонд дэлгэрэнгүй номноогүй байх тул амарлингуй болоод үлэмж үзэхүйг хоёуланг *"Сонсогчийн газар"*-аас мэдэх хэрэгтэй гэж *"Нотлон буулгах хураангуй"*-гаас айлдсан тул *"Сонсогчийн газар"* шастараас маш дэлгэрэнгүй номножээ.

Майдар гэгээн бээр ч *"Судрын аймгийн чимэг", "Дундад хязгаар"* зэрэг бүтээлдээ "сэтгэл тогтоох есөн арга болоод тэвчихийн найман хуран

үйлдэхүйн" талаар айлдсан буй.

Тэдгээрийг дагаж ловон Харибадра (Сэнгэсамбуу), Камалашила (Бадма анцүл), Шантидэва(Шивалха) зэрэг Энэтхэгийн олон мэргэдүүд бясалгал бүтээх эрэмбэ зэрэг олныг зохиожээ. Бурханы лагшин, дусал, үг үсэг зэргийг бяалгах бодлын орны хувьд ялгаатайгаас бусдаар бясалгалын ерөнхий агуулгууд нь дээрхи гол шастаруудаас номносон болоод дандраас номносонтой сайн таардаг.

Ялангуяа, бясалгалын таван гэм зэрэг гэм буруу, тэдгээрийг хэрхэн арилгах ёс зэргийг судрын аймгийн зүгээс маш дэлгэрэнгүй үзүүлсэн байна.

Гэтэл гол ном шастарт заасан дагуу анхааран бясалгах, мэдэх явдал нь өдрийн од мэт үзэгдэх агаад өөрийн ухааны гэм хирийг тэдгээр номонд тохчихоод "тэдгээрийг гадны ухаарлын торыг таслах төдий тул" гээд "харин жинхэнэ утгыг заасан увдис тусдаа бий" гэх ба тэдгээрт заасан бясалгал бүтээлийн зэргийг анхааран авах үест ч юу юм бол гэж тээнэгэлзэх төдий байдал ч үл үзүүлэх нь" харагдана.

Энэхүү увдиснаа дээд гэгээчүүдийн болгоож бясалгасан бүгд болон зөвхөн гол номоос гарсан бүгд давхарласан болно. Мөн энэ үест ч бясалгал бүтээх ёсыг их гол номоос авч номнох болой.

Ийнхүү бясалгалын эрэмбэ зэргийг номноход хоёр:

(1) Бясалгалыг гэмгүйгээр бүтээх ёс

(2) Түүнээ шүтэж орсон (тогтсон) сэтгэл төрөхийн эрэмбэ зэрэг

(1) Бясалгалыг гэмгүйгээр бүтээх ёсноо гурав:

(а) Сэтгэлээ сэтгэхүүн (зоригдол) оронд тушаахын өмнө хэрхэн үйлдэх

(б) Бодол сэтгэхүүнд тушаах үест хэрхэн үйлдэх

(в) Бодол сэтгэхүүнд тушаасны дараа хэрхэн үйлдэх

(а) Сэтгэлээ бодол сэтгэхүүнд тушаахын өмнө хэрхэн үйлдэх.

Юуны түрүүнд бясалгал үйлдэхэд үл дурлах болоод түүний эсрэг зүгт дурлагч залхуугаа дарахгүй бол ерөөс бясалгалд орж чадахгүй. Ганц нэг удаа оролдовч үргэлжлүүлэн хийж чадалгүй түргэн доройтоход хүрдэг. Тиймд юун түрүүнд залхуугаа дарах чухал хэрэгтэй шүү. Чингээд бие, сэтгэл баясгалан амгалангаар дэлгэрэх "машид боловсрол"-ыг олж өдөр, шөнө бүхнээ буянд шамдахдаа уйдахаа болисноор л залхуу буцдаг. Ийм

байдалд хүрэхэд машид сайтар боловсрохын үндэс болсон бясалгалд үргэлж шамдах хичээнгүйг туурвих шаардлагатай.

Түүнийг төрүүлэхэд бясалгалыг чухалчлах үргэлжийн хүчтэй эрмэлзлэл байх учиртай. Эрмэлзлэл төрүүлэхийн үндэс болгож бясалгалын тус эрдмийг мэдсэн, сэтгэл татах баттай сүсэг хэрэгтэй. Тиймээс эхлээд бясалгалын эрдмийг санах, сүсэглэх сэтгэлийг дахин дахин дадуулж үйлдэнэ.

Эдгээр эрэмбэ зэргийг анхааран үзвээс маш тодорхой болох тул аньсын дээд гэж бариарай. Энэ талаар *"Дундад хязгаар"-аас:*

Орон ба түүнээ орших зэргээр
Үндэс болоод үр дагавар болно хэмээн айлджээ.

Тэрхүү "орон" гэдэг нь эрмэлзлэл буюу шамдах орон болно. "Орших" гэдэг нь туурвих хичээнгүй болой. Эрмэлзэхийн "үндэс" эрдэмд сэтгэл итгэмжлэх сүсэг болой. Шамдаж хичээсний "үр дагавар" нь "машид боловсрох" болой. Энд бясалгагдахуун буюу бясалгалын эрдэм гэдэг нь амарлингуйг бүтээвээс сэтгэл баясгалантай, бие жаргалтай болж дээшлэх тул үзэх номонд амгалантай оршиж бие, сэтгэлийн сайтар боловсролыг олдог.

Чингээд буяны бодолд алин хүссэнээр сэтгэлээ эдэлж чадахад хүрэх ба өөрийн эрхгүй буруу орноо алгасрах явдал арилснаар гэмт явдал гарахгүй болно. Алин үйлдсэн буян хүч ихтэй болоод амарлингуй сэтгэлд шүтэж зөн мэдэл, рид хувилгааны эрдэм бүгдийг бүтээх чадалтай болно.

Ялангуяа, түүнээ шүтэж байж үнэмлэхүй үзлийг онох үлэмж үзэхүйн ухаан төрснөөр зовлонгийн үндсийг түргэн тасалж чадах зэрэг эрдэм төрөхийг санаж бясалгал үйлдэх хүчтэй эрмэлзэл хүслийг нэмэгдүүлж бясалгана. Ийм түвшинд хүрээд ирэхээр дотроосоо бясалгал хийхийг үргэлжид шаардах болох тул бясалгал хийх улам хялбар болох ба хийсэн хойноо ч дахин дахин бясалгалд орох тул доройтохгүй болж ирнэ.

(б) Бодол сэтгэхүүнд тушаах үест хэрхэн үйлдэхэд хоёр:

1/ Сэтгэлээ юунд тогтоох суурь зоригдол орноо бодитоор танин барих

2/ Хэрхэн сэтгэлдээ түүнийг тушаах ёсон

1/ Сэтгэлээ юунд тогтоох суурь зоригдол орноо бодитоор танин барихад хоёр:

а/ Ерөнхий зоригдол орон /бодох зүйл/

б/ Тухайн үест буух зоригдол орныг бодитой барих ёсон

а/ Ерөнхий зоригдол оронд гурав:

/1/ Зорих орныг бодитой үзүүлэх

/2/ Хэн чухам юу бодохыг бодитой үзүүлэх

/3/ Бодох орны ижил зүйлийг үзүүлэх

/1/ Зорих орныг бодитой үзүүлэх. Бурхан бээр бясалгалын дөрвөн зүйлийн зоригдол айлдсан буй.Үүнд:

/а/ Түгээмэл зоригдол

/б/ Явдлыг ариусгах зоригдол

/в/ Мэргэдийн зоригдол

/г/ Нисваанисыг тийн арилгах зоригдол

/а/ Түгээмэл зоригдол

Үүнд дөрвөн зүйл буй. *"Атгаг сэлтэст дүрс (тусгал) хөрөг"* Дүрс хөргийг тухайлах үүднээс хоёр зүйл буй. Эхнийх нь үлэмж үзэхүйн зоригдол, удаах нь амарлингуйн зоригдол орон болно. Дүрс хөрөг гэдэг аливаа бодож байгаа орон түүний өөрийн шинж тэмдэг бодитойгоор бус түүний намба дүр ухаанд ургаж үзэгдэхийн нэр бөлгөө. Түүийг зорьж ажиглахын үест ажиглан үйлдэгч атгаг бодол байх тул "атгагтай дүрс хөрөг" гэдэг.

"Атгаггүй дүрс хөрөг" Бас түүнийг ажиглалгүй сэтгэлээ түүн дээр тогтоох үест ажиглагч атгаг гарахгүй тул "үл атгаглах дүрс хөрөг" гэдэг.

"Бодит хязгаарт" Аливаа сэтгэхүүн орны үүднээс агуулахыг "бодит хязгаарт" болно. "Энэ төдийгээр хязгаарлаж үүнээс цааш бусад байхгүй" хэмээх "янагуухийн бодит хязгаар" болоод зөвхөн "энэ мэтээр орших бусдаар үл орших" хэмээх "үнэмлэхүйн хязгаар" гэж хоёр зүйл бий. Түүний дотор "янагуухи хэмээхэд, таван цогцост багтах хамаг хуран үйлдэхүй болон арван найман язгуур ба арван хоёр төрөн түгээхүйд багтах хамаг юмс үзэгдэл хийгээд дөрвөн үнэнд хамаг бодит мэдэгдэхүүн бүгд тус тус багтана гээд үүнээс цааш бусад үгүй болой" гэх мэт. "Үнэмлэхүй" хэмээхэд тэдгээр мэдэгдэхүүний үнэмлэхүй чанар ба хоосон чанарын утгыг учир шалтгааны үүднээс нотлох утгууд багтана.

"Тус хэргийг огоот бүтээх" нь үр дагаврын үүднээс агуулжээ. Тэдгээр мэдэгдэхүүн орны дүрс хөргийг амарлингуй болон үлэмж, үзэхүйн үүднээс тэр бүхнийг сэтгэлдээ үргэлж сэтгэх, дадууж бясалгах, мөн олон дахин тунгааж бодох зэргийн хүчээр өөр өөрийн муу орноос ангижирч сэтгэл орших болой.

/б/ Явдлыг ариусгах зоригдол

Үүнд таван зүйл буй. Гуа үзэсгэлэн бусыг бодохдоо үс, шүд зэргийн дотор байх гучин зургаан зүйлийн гуа бусууд болон үрчгэр, хорчгор зэрэг гадна талын үзэсгэлэн бус, ариун бусын байдлаа ухаандаа ургуулж, сэтгэлдээ санах болой.

"Асрахуй" нь элгэн садан, өст дайсан болон тэдний (алин ч биш) дундад гэх гурвууланг тухайлан бодож эн тэгш хандаж тус амгаланг бүтээх сэтгэл болно. Асрахуй сэтгэлийн зорихуун орон түүний үүднээс буюу, зоригдохуун орноо тухайлах асрахуй сэтгэлээ барих хэмээн орон ба оронт хоёуланг асрахуй хэмээн айлдсан буй.

"Шүтэн барилдахуйг зорих" нь гурван цагт төрсөн шүтэн барилдлахуйн ном төдийд шүтэж ном төдий үр гарах төдийгээс бусдаар, тэдгээрээс ангид үйлийг үйлдэгч болон үрийг амсагч байхгүй хэмээх утгыг тийнхүү зорин бодож сэтгэлдээ барих болой.

"Мэдэгдэхүүний язгуур тийн ялгалыг тухайлах нь" Шороо, ус, гал, хий, огторгуй, тийн мэдрэхүй (сүнс) зэрэг зургаан язгуурын хувийг тус тус ялгаж тэдгээрийг зорин сэтгэлдээ барих болой.

"Амьсгалаа оруулж гаргахаа зорих нь" Хийгээ гадагш, дотогш гүйлгэн тоолох зэргээр ажиглахын үүднээс сэтгэлээ өөр зүйл рүү алгасрахгүй тогтоон бодох болой.

/в/ Мэргэдийн зоригдол

Үүнд таван зүйл буй. *"Цогцос" нь* дүрст цогцос тэргүүтэн таван зүйл болой.. "Түүнээ мэргэжих" нь цогцсоос ангид тусдаа би болон минийх хэмээх байхгүй гэж мэдэх болой.

"Язгуур орон" нь нүд тэргүүтэн арван найман мэдэгдэхүүн мөн. "Түүнээ мэргэжих" нь тэдгээрт язгуур орнууд өөр өөрийн хөрөнгөөс төрөх нөхцөл шалтгаантайг мэдэх болой.

"Төрөн түгэхүй" нь нүд тэргүүтэн арван хоёр түгэн төрөхүй мөн. "Түүнээ мэргэжинэ" гэдэг зургаан дотоод төрөн түгэхүй нь зургаан тийн мэдрэхүйн **эзэт** шалтгаан болохыг, гадны зургаан төрөн түгэхүй нь зорих бодлын шалтгаан болохыг, даруйд хаагдсан сэтгэл нь даруйдын шалтгаан болохыг тус тус мэдэж ухаарах болой.

"Шүтэн барилдлага" нь арван хоёр гишүүн мөн болой. "Түүнээ мэргэжих" гэдэг тэдгээрийн мөнх бус, зовлонт, би-үгүй чанарт зэргийг мэдэх явдал болно.

"Орон ба орон бус" гэдэг нь буянаас сэтгэлд зохист, тийн боловсрол (үр) гарах тул орон болно. Нүглээс сэтгэлд зохисгүй муу боловсрол буюу орон бус гарах зэргийг орон бус гэнэ. "Түүнээ мэргэжинэ" гэдэг тэдгээрийг мэдэх явдал. Эдгээр нь шүтэн барилдахуйд мэргэжих өвөрмөц орон бөгөөд энэ үед ялгаа нь харилцан адилгүй үндэс шалтгаануудыг мэдэх болой. Амарлингуй сэтгэлийн зоригдол болох энэ үест, цогцос тэргүүтэн эдгээрийг алин онох ёстой нэг сэтгэхүүн орны үүднээс сэтгэлдээ барих учиртай.

/г/ Нисваанисыг тийн арилгах зоригдол.

Үүнд хоёр зүйл буй. *"Нисваанисын хөрөнгийг доройтуулж үйлдэх төдий орон"-д* хүсэлт ертөнцийн газраас Юу ч үгүй хэмээх орныг хүртэлх, төрөн түгэхүй хүртэлх, доод орны бүдүүн болон дээд орны нарийн нисваанисыг тухайлах багтана.

"Хөрөнгийг язгуураас нь тэвчих орон"-д дөрвөн үнэний мөнх бус тэргүүтэн арван зургаан орон багтана. Амарлингуй сэтгэлээр эдгээрийг зорин бодохын үест ажиж шинжилгүйгээр эдгээр орны намба дүрийг ургуулан бодох эсвээс, сэтгэлээр магадлан мэдэх алинаар нь ч сэтгэлдээ барина.*"Бясалгалын дунд зэрэг"-ээс:* "Гурван зоригдол орон байх"-ыг үзүүлжээ. Үүнд: 1* Арван хоёр эрхэм зарлиг бүгдээр хоосон чанарт чиглэсэн, заасан, буулгасан болой хэмээн бүгдийг хураангуйлан түүнийг сэтгэлдээ тогтоох,.

2* Яахнаа ч ном бүгдийг хураагч болсон цогцос зэргийг бодох,

3* Үзэх, сонсох зэргээр бурханы дүрс, лагшин зэргийг сэтгэлд тогтоож бодох болой.

Цогцос тэргүүтнийг тогтоон бодохдоо хурсан бүхэн таван цогцост хурдаг жамыг мэдэж цаашлаад тэдгээрийн дотор хэсэгчлэн хураагдах зэргийг сэтгэлээ тогтооно. Тэр мэт тус тус ялгаж бодоод ирэхээр тус тус онох билиг төрөх мэтээр хураан бясалгаж сурах ч бас бусад юм руу одохгүй, бодолдоо сэтгэл хураагдах бясалгал ч төрдөг. Энэ болвоос *"Илт ном"(Авхидхарма)*ын увдис болой.

Тэрчлэн хамаг ном, юмс нь язгуур орон болон төрөн түгэхүйд хурах ёсыг мэдээд, тэдгээрт хураадсан түүнээ сэтгэлээ агуулах болой.Ер нь "явдал мөрийг ариусгах бодлууд" нь сая номносон мэт хүсэл шуналыг үлэмж эдлэгч нарын хүсэл шуналыг буцаахад хялбар, бас түүнээ шүтэж бясалгалыг олоход хялбар тул нилээд онцлог ялгаатай бодол болдог.

"Мэргэдийн зоригдолууд" нь эдгээр номоос ангид "бодгалийн би"-г

хоридог учир “би-үгүй”-г онох үлэмж үзэхүйн ухаан төрөхөд даган зохилдох амарлингуйн зоригдохуун орон болдгоороо маш ач холбогдолтой.

“Нисваанисын асар арилгах зоригдолууд” нь нисваанисын үндсэн ерөндөг болдог учраас их хэрэгтэй билээ. “Түгээмэл зоригдохуун” нь дээрх бодлуудаас тусдаа зүйл бишээ. Иймийн учир хэрэг тустай амарлингуй сэтгэлийн бодол зоригдолд шүтэж, бясалгал бүтээх жамтай тул жирийн нэг чулуу, мод зэргийг тухайлан бодож бясалгал бүтээнэ гэх нь бясалгалын бодол зоригдохууны мөн чанарыг таньж мэдээгүйтэй холбоотой болох нь тодорхой байна.

Заримууд“сэтгэлээсэтгэхүүнбодолдоотушааж,түүнээсэтгэлээтогтооно гэвэл үнэнд барисан болно” гээд “тэр адилаар сэтгэлээ тушаалгүйгээр, бас суурь, зоригдол оронгүйгээр тогтоон барихыг хоосон чанарын бясалгал болно” гэж үзэх ч байна. Энэ мэт бодол нь хоосон чанарыг бясалгах ёсыг ерөөс ухаараагүй шинжийг илтгэнэ. Тэр мэтээр үзвэл тэр цагт сэтгэл байхгүй болох тул хоосон чанарын бясалгал ч байхгүйд хүрнэ. Буй аваас л ямар нэгэн сэтгэлд мэдрэгдэх мэдэгдэхүүн байх хэрэгтэй. Мэдэгдэхүүн болно гэдэг тухайн ухааны зоригдохуун (вишай) болсонд оршино. Орон (вишай), зоригдохуун, мэдэгдэхүүн гэх зэргүүд нэгэн утгатай билээ.

Тиймэрхүү бясалгалыг үнэнд баригч гэж үзэх учир тэр ёс зохисгүй болно. Мөн хоосон чанарын бясалгал болно, болохгүй гэдгийг ахуй ёсыг оносон үзэл онолыг агуулсан талаас бясалгал мөн, бишийг тодорхойлохоос бус, ямар нэг орон вишайг атгаглах эсвээс, огт атгаглахгүй байх талаас тодорхойлж болохгүй. Дэлгэрэнгүйг дараа номносугай.

Зоригдохуун оронгүйгээр тогтоож болно гэж үзэх тэр ч гэсэн, өөрийн сэтгэлээ ямар нэг зүйлд яагаад ч цацруулахгүй барина гэдэг бодлыг өмнө нь тавиад сэтгэлээ барих хэрэгтэй тул, бодлоо санах төдий нэг болгоод ямар нэг бусад юм руу сэтгэлээ цацруулалгүй барьж магадлах шаардлагатай. Тиймээс л зоригдохуун орон байхгүй гэж үзэх нь өөрийн амсуурга мэдрэхүйтэй харшилж байна. Ийм учраас бясалгал бүтээх олон ном судраас олон янзын зоригдохуун орон байхыг номносон агаад тэдгээрийн хэрэгцээ шаардлагын талаар өмнө номносон тул сэтгэлээ тогтоох бодол зоригдохуунд мэргэжээрэй.

“Бясалгалын зэрэг”-ээс: “Амарлингуй сэтгэлийн зоригдохуунд магадлал үгүй” хэмээжээ. *“Мөрийн зул”-аас:* ”Алин нэгэн зоригдохуун оронд” хэмээсэн нь нь заавал тодорхой нэг зоригдохуун орныг магадлан барих албагүй гэсэн утга болно. Аль зорисон бодол бүхнээ мэднэ гэж заасан бус аа.

/2/ Хэн чухам ямар зоригдол барихыг үзүүлэх

Хүсэл шунал ихтэй хүнээс эхлээд атгаг муу санаа ихтэй хүн байвал гээд, *"Намдү бээр айлтгасан судар"* аас эшлэн *"Сонсогчийн газар"*-т дурдахдаа:

Намдү, Хэрвээ бясалгалч гэлэн болон бясалгалыг эдлэгч тэрээр зөвхөн хүсэл шуналыг эрхлэгч нэгэн болвоос гуа бусын бясалгалд сэтгэлээ ойртуулан тушаагаарай. Уурлах хилэгнэх дуртай болвол асрах сэтгэлийг бясалгах буюу. Мунхагийг эдлэгч нэгэн бөгөөс ийм шалтгаанаас шүтэн барилдах жам болой. Омог дээрэнгүй нэгэн бөгөөс язгуурын орны тийн ялгалд сэтгэлээ шадар тушаах явдал болой" хэмээсэн ба, "Асар атгаглагч нэг болвоос амьсгалаа оруулах, гаргах зэргийг дурдан санаж сэтгэлээ шадар тушаах буюу. Тийнхүү зохилдон таарах бодол дээр сэтгэлээ шадар тушааж үйлдээрэй хэмээн айлджээ.

"Сонсогчийн газар""-аас:

Алин хүсэл тачаал уур, мунхаг, омог, асар атгаг зэргийг эдлэгч бодгаль хэн бээр ч юуны эхэнд зөвхөн явдал мөрийг ариусгах бодлоор явдал юугаа ариусгаж судлаарай. Түүний дараагаар сэтгэл оршихыг онох ба тэдгээр зоригдохуун бодлуудыг тус тус магадлах тул омтгойролгүй тэдгээр бодолд хичээж үйлдээрэй хэмээн айлдсан тул баттай тэдгээр зоригдохуунд шамдаарай.

Хувь тэнцүү эдлэгч болон багахан нисваанист хүмүүс дээр номносон бодол зоригдол тэдгээрээс алин таатайг сэтгэлдээ барьж болох тул заавал тухайлах албагүй. *"Сонсогчийн газар"-аас:*

Хувь тэнцүү эдлэгч тэрээр сэтгэлдээ ойр дөт оршихын тухайд алин таатай нэгнээ хичээх буюу явдлаа ариусгахын тухайд бус болой. Хувь сацуу эдлэгч түүнтэй адилаар өчүүхэн нисваанист ч тэр дагуу мэдээрэй хэмээн айлджээ.

"Шунал тачаал зэрэг тав нь хувь ихтэй байх" нь урьд төрөлдөө шунал тачаал зэргийг үргэлж шүтэж байсан, дадаж сурсан, олон дахин үйлдсэн зэргээс шалтгаалдаг аж. Хэдий хүсэл тачаал зэрэг таван орон өчүүхэн бага гаравч тэдгээр тав чангарч, үргэлжид удаан хугацаанд төрдөг. *"Хувь тэнцүү эдлэх"* гэдэг урьд төрөлдөө шунал зэргийг үргэлжид үл шүтсэн, дадаж эс сурсан, олон дахин эс үйлдсэн ч тэдгээрийг гэмтэйд үл үзсэн, үл хаширсан тул тэдгээр орноо шунах тачаахын хувь ихдэх, өнө удаан хугацаанд төрөхгүй ч болохоос бус тачаал тэргүүтэн тав огт төрөхгүй бус аа. *"Нисваанис бага байгаа"* гэдэг бусад төрөлдөө ч хүсэл шунал зэргийг үргэлжид шүтэлгүй,

гэмтэйд үзэх болсноор хүсэл шуналын их орон, олон орон, үлэмж их зэрэгт шүлэнгэтэх нь үгүйрч багасах ба, дунд болоод бага зэргийн орноо ерөөс шунал төрөхгүй болдог. "Шунал хүсэл их хувьтай" гэдэг өнө удаан байх ба "хувь тэнцүү эдлэх" гэдэг хэтэрхий удаан биш байх, "нисваанис бага" гэдэг түргэнээс түргэн сэтгэл оршихыг онох зэргүүд болой. "*Мэргэдийн зоригдол*"-д ямар хүн хэрхэн хичээх талаар *"Намдү айлтгасан судар"-аас:*

Намдү! Бүтээлчин гэлэн, бүтээлчний явдалт тэрээр, хурсан бүхэн өөрийн бэлэг чанарт гэж хотолд мунхрах буюу. Би, амьтан, амь нас, төрөлхтөн, жам ёсноо болоод бодгалийн бодит бүхнээ мунхарсан нэгэн болвоос, цогцост мэргэшихээр сэтгэлээ дөтлүүлэн тушаах болой. Үндэс шалтгаанд хотол мунхарсан нэг болвоос, язгуурын орноо мэргэших болой. Шалтаг бүхнээ мунхарсан бөгөөс, төрөн түгэхүйд мэргэших болой. Мөнх бус, зовлон, би-үгүй-д бүхнээ мунхарсан бөгөөс, шүтэн барилдахуйд мэргэших, орон ба орон буст сэтгэлээ ойртуулан тушаах болой" хэмээн айлдсан дагуу эдгээр таван бодлууд голчлон мунхагийг буцаах болой.

"*Нисваанисыг арилгах зоригдол бодол*"-д ямар бодгаль сэтгэлээ тушаах талаар дээрх "*Судар*"-аас:

Хүсэлт ертөнцийн хүсэл тачаалаас хагацахыг хүсэгч нэгэн бээр, хүсэлт ертөнцийн бүдүүн болон дүрстийн нарийнд зорих болой. Дүрстээс шунал хүслээ буцаахыг хүсэгч нэгэн болвоос, дүрсийн бүдүүн зэрэг болон дүрсгүй ертөнцийн нарийнд сэтгэлээ ойртуулан тушаах болой. Эвдрэх чуулган бүгдээс сэтгэл уйсч, тонилохуйг хүсэгч нэгэн бээр зовлонгийн үнэн, бүхэн гарахуйн үнэн, хорихуйн үнэн, мөрийн үнэнээ сэтгэлээ шадарлан тушаах болой хэмээжээ.

Эдгээр бодол зоригдохуунууд нь үлэмж үзэхүйн шинжлэх бясалгал болон амарлингуйн агуулах бясалгал хоёулангийн орон мөн учраас зөвхөн амарлингуйн тухайлах орон болохгүй. Гэсэн ч нэг хэсэг нь амарлингуйг шинээр бүтээх зоригдохуун болох ба бас нөгөө хэсэг нь амарлингуйг бүтээснийг ялгаж өгөх зоригдохуун болж байдгийг амарлингуйн бодол зоригдлын үест номнож барина.

/3/ Бодлын орны ижил зүйлүүд

Алин сэтгэлдээ барих суурь болсон бясалгалын зоригдол шүтээнийг урьд номносон бодол зоригдлын дүрс хөрөг юмуу намба байдлыг ухаандаа ургуулах үзэгдэл тэдгээрийн нэрийн зүйлийн талаар *"Сонсогчийн газар"-аас айлдахдаа:*

Дүрс хөрөг түүнийг дүрс хөрөг хэмээх мөн. Гэвч бясалгал дияаны шинж тэмдэг, дияаны эдлэх орон, дияаны арга, дияаны үүд, сэтгэлдээ үйлдэхүйн шүтээн, дотор талд тийн онох бие болоод үзэгдэх хөрөг гэх мэтээр нэрлэдэг. Тэдгээр нь бодит мэдэгдэхүүнтэй зохилдох дүрс хөрөг түүний нэрийн зүйл мөн гэж мэдээрэй хэмээн айлджээ.

б/ Тухайн үест буух зоригдол орныг бодитой барих ёсон:

Хэдийгээр олон бодлыг номлосон боловч тэдгээрээс энэ үест чухам алийг нь шүтэж амарлингуй сэтгэлийг бүтээх вэ хэмээвээс, тэдгээр нь урьд дурдсан судрын аймаг шиг нэг байх албагүй бөгөөд бодгаль өөр өөрсдийн бодол зоригдлыг тус тусдаа үйлдэх хэрэгтэй. Ялангуяа, наад захын сэтгэл амарлингуйг лавтайяа бүтээхэд хүсэл шунал ихтэй нэгэн гэхэд тодорхой зоригдохуун бодлыг үйлдэх хэрэгтэй.

Эс чингэвээс амарлингуйг даган зохилдсон бясалгал болж болох ч жинхэнэ амарлингуй сэтгэлийг олж чадахгүй. Явдлыг ариусгах зоригдлыг хичнээн судлавч маш удахаас цааш амарлингуйг бүтээж чадахгүй гэж айлдсан бий. Харин тэр бодлоо бүр орхичихвол огт юу ч бүтэхгүйг хэлээд яах вэ. Ялангуяа, атгагийн гэм ихтэй хүмүүс лавтайяа ихийг бясалгаж үйлдэх хэрэгтэй. Хувь тэнцүү эдлэгч буюу багахан нисваанистай хүмүүн нь урд номлосон мэт дээр өгүүлсэн бодол зоригдлуудаас алин сэтгэлд таатайгаа бодлын шүтээнд үйлдээрэй.

Мөн эдүгээгийн бурхадыг илт болгоох дияан болон бясалгалын хааныг даган барихыг *"Бясалгалын дунд болон сүүлийн зэрэг"-ээс:* Бурханы лагшинг зоригдохуун болгож дияаныг бүтээж болно хэмээн айлджээ. Жанчүвсамбуу багш (Бодхибхадра) бээр:

Энэ үест амарлингуй сэтгэлд хоёр буй. Амаа дотогш чиглүүлж бодох ба гадагш чиглүүлэн бодно. *Амаа дотогш чиглүүлэх бодолд хоёр зүйл:* Биеэ бодох ба биенээ шүтсэнийг бодох буй. *Тэрхүү биеэ бодоход гурван зүйл:* Өөрийн биеэ бурханы байдлаар бодох, араг яс тэргүүтэн гуа бусаар бодох, хадамга барьсан зэрэг онцгой шинжүүдийг бодно. *Биенээ шүтснээ бодоход таван зүйл:* Амьсгалаа бодох, нарийн шинжүүдийг бодох, дуслыг бодох, гэрлийн үе гишүүнийг бодох, баясгалан болоод жаргаланг бодох болой. *Амаа гадагш чиглүүлэн бодоход хоёр зүйл:* Ялгамжаатай болон эгэлээр бодох буй. *Ялгамжаатай түүнээ хоёр зүйл:* Лагшинг бодох ба зарлигийг бодох бий гэжээ.

Мөн *"Мөрийн зулын тайлбар"*-т ч ийм зүйл бий гэж эшлэж татсан байна. Тийнхүү бурханы лагшин дээр сэтгэлээ тогтоож бодох нь бурханыг даган дурдах мөн бөгөөд цаглашгүй их буян төрөх ба лагшингийн дүр төрх тодрон бат болвоос мөргөх, тахих, ерөөл тавих зэрэг буян хураахын орон болгох, наминчлах, боомтлох зэрэг нүглээ арилгахын орон болгож үйлдэхэд маш илүү онцлогтой юм.

Дээр *"Бясалгалын хаан судар"*-т татсан мэтээр "Үхэхийн цаг болоход бурханыг даган дурдах, үл мартах зэргийн эрдэм тустай болно. Нууц тарнийн мөрийг бясалгаваас машид ялгамжаатай бурханы егүзэрийг олох зэрэг хэрэг ихтэй хэмээжээ. Түүний тус эрдэм болоод бурханыг сэтгэлдээ үйлдэх ёсыг *"Эдүгээгийн бурхадыг илт болгоох бясалгалын судар"*-т ихэд дэлгэрэнгүй тодорхой өгүүлжээ. *"Бясалгалын суулийн зэрэг"*-ээс айлдсан мэтээр эдгээрийг тэндээс магадлан мэдээрэй. Үг ихдэнэ гэж бодоод энд бичсэнгүй. Иймд хэрэгтэй ялгамжаатай бясалгалыг бүтээх хэрэгтэйн дээр дашрамд эрдэм тустай бодол зоригдлыг эрэлцэх нь ухаантны ёс билээ. *Хэрхэн бурханы лагшинг бодож бясалгах вэ? "Бясалгалын суулийн зэрэг"-ээс:*

Бясалгалч эхлээд бурханы лагшин дүрийг хэрхэн үзсэн, хэрхэн сонссон дагуу сэтгэлдээ агуулж бүтээнэ. Бурханы лагшин дүр гэхэд тунгаамал алт адил шар өнгөт, үзэсгэлэнт лагшин найргаар чимсэн, нөхдийн дунд заларсан, элдэв аргаар амьтны тусыг бүтээж байгаагаар сэтгэлдээ үргэлжид бодно. Түүний эрдэмд баясах ба, живэх, дошигрох бодлуудыг амарлиулах, хэзээд түүнийг өмнөө байгаа юм шиг тодорхой үзэх тэр хүртэл сэтгэлдээ тогтоон үйлдээрэй хэмээсэн байна.

"Бясалгалын хаан судар"-аас ч

Алтан өнгөт адил лагшин биеэр
Ертөнцийн итгэл та бүхнээс үзэсгэлэнт хэмээх
Тэр л бодолд алив сэтгэлээ тогтоон
Түүнд л сэтгэлээ агуулж үйлд, бодисадва нар аа!

хэмээн айлдсан мэт бодлын суурь болгож бясалгаарай. Мөн шинээр ухаандаа бодох ба мөн чанараар (өвсөөн) оршихуйг нь тодруулан санах хоёр зүйл байдгаас суулчийнх нь сүсэг төрөхөд илүү ялгамжаатай ба нийт хөлгөнтэй зохилдох тул мөн чанараар байгааг нь тунгалаг тодорхой байдлаар бодно. Эхлээд сэтгэлээ тогтоох бодлын суурь шүтээнийг эрэхдээ зурмал, цутгамал зэрэг Бурхан багшийн сайн бүтээсэн дүрийг олоод түүнийгээ дахин дахин сайн

харж, шинж тэмдгийг нь тогтоож, сэтгэлийн орноо ургуулан бодож дадаж сур.

Цаашлаад багшаас ёс журмыг сонсож, утгыг санаж, сэтгэлийн нигуурт урган ургатал бодлын суурийг бясалгаарай. Бодлын сууринаа зурмал, цутгамал зэргийн намба төрхөөр бус жинхэнэ бурханы намба байдлаар ургуулан бодоход суралц. Заримууд лагшин дүр хөргийг өмнөө тавиад нүдээрээ харж бясалгал хийдэг бий. Үүнийг Ишдэ мэргэн бээр хориглосон нь машид сайн билээ. Бясалгал гэдэг эрхтний мэдрэхүйд бүтдэг зүйл биш. Дотоод сэтгэлийн мэдрэхүйд бүтдэг зүйл юм. Бясалгалын жинхэнэ бодол зоригдол нь жинхэнэ дотоод сэтгэлийн орон болдог тул түүнээ л сэтгэлээ тогтоох хэрэгтэй. Дээр номлосон мэтээр тухайн бодлын орны ерөнхий донж байдал юм уу, дүрс хөргийн байдлаар ургуулан бодох хэрэгтэйг айлджээ.

Лагшингийн бүдүүн ба нарийн хоёр байдлаас эхлээд ерөнхий бүдүүн байдлыг бодож баттай болгоод сүүлд нь нарийвчлан бодох хэрэгтэйг бусад номонд ч айлдсан байна. Амсах, мэдрэхэд ерөнхий энгийн байдал нь ургахдаа хялбар учир лагшингийн ерөнхий намба төрхийг бодлын шүтээнд авах шаардлагатай. Чухам чингэх учир нь номнож буй адил бясалгал хийхийн хүсэл юу нэгэн үл гарах хүртэл харилцан адилгүй язгуурт олон бодолд шилжвээс хэзээ ч бясалгал болж чадахгүйд хүрдэг. Ижил буруу олон бодлыг ээлжлэн бясалгаваас сэтгэлийн амарлингуй төрөхийн их тотгор болдог учиртай. Тиймд бясалгалыг бүтээхийг номносон төгөлдөр шалгадаг шастарууд болох "*Газрын аймгууд*" болон "*Бясалгалын зэрэг*" хэмээх гурван гол шастар тэргүүтнээ дияаныг бүтээхийн үест зөвхөн нэг л бодолд эрхэмлэн бүтээхийг заажээ. Түүнээс бус олон бодолд шилжиж болохгүй гэж зарлиглажээ. Энэ талаар *Хутагт Бавуу (Арьяашура) бээр тодорхойлон:*

Нэг л бодлыг батад болгох ёсыг
Сэтгэлдээ санаж батадган үйлд
Олон бодолд дамжваас
Сэтгэл нисваанисаар хямрах хэмээн бясалгалыг бүтээхийн үест айлджээ.

"Мөрийн зул"-д ч:

Аливаа бодлоос зөвхөн нэгийг
Сэтгэлдээ буян болгож агуулж үйлд

хэмээн магадтай барих учрыг айлдсан байна. Тиймээс эхлээд нэг л бодлыг барих ба харин сэтгэлийн амарлингуйг олсны дараа олон зүйлийг тухайлан

барьж болно. *"Бясалгалын анхдугаар зэрэг"-ээс:*

Хэн боловч сэтгэлдээ тогтоон бодож сурсан тэр цагт цогцос, язгуур тэргүүтний өвөрмөц ялгааг дэлгэрүүлэн бодож болно хэмээжээ. Энэ талаар *"Тааллын магадтай тайлбар" зэргүүдээс ч:* Егүзэрүүд бээр арван найман хоосон чанарыг бясалгах зэрэг өвөрмөц онцлогийг олон байдлаар бясалгахыг зарлиг болжээ хэмээн айлдсан буй.

Тийнхүү эхлээд сэтгэлээ юун дээр тогтоон барих бодлын шүтээнийг олох хэмжээ хэрцэдийн хувьд, тэргүүн, хоёр мутар, цээжин биеийн хэсэг, хоёр бойв зэргийг дараалан хэдэнтээ хослуулан тод санах хэрэгтэй. Дараа нь лагшинг ерөнхийд нь сэтгэлдээ тогтоон санаж, сэтгэлийн нигуурт бүдүүн хэсгийн ерөнхий байдлыг хагас хугас төдийг ч ургуулж чадваас гэрэл гэгээг тунгалаг тод ургуулаагүй ч тэр төдийд ханаж түүнээ л сэтгэлээ тогтоон барих хэрэгтэй. Энэ мэт тэр төдийд эс ханаваас түүнээс тод тунгалаг болгох хүсэл төрснөөр дахин дахин тодруулахад бодлын орон маань жаахан тодрох авч сэтгэл тогтохын хувьт бясалгалд хүрч чадахгүйд хүрч, бүр тотгор болдог учиртай. Бодол их тод бус ч гэсэн хагас хувь төдийд ч тэрхүү бодолдоо сэтгэлээ тогтоон бариваас бясалгал түргэнээ төрнө.

Цаашлаад тодорхой болоход дорвижлого гарч тодорхой хувийг маш хялбар олно. Эдгээр нь Ишдэ багшийн увдисаас гарсан бөгөөд машид чухал хэрэгтэй увдис болой. Бодлын шүтээнийг ургуулах ёсноо хоёр хэсэг, дөрвөн зүйл номлосон ч үзэгдэнэ. Гэвч тухайн бодгалийн язгуураас шалтгаалан намба байдал ургахад хялбар ба бэрх, тодорхой ба тодорхой бус, энэ хоёр ч бат ба бат бус зэргээр үзэгдэх тул заавал тийм байх шаардлагагүй. Нууц тарнийн бурхадын егүзэр бясалгал бүтээхийн үест бол бурханы намба дүрийг тодорхой бүтээх хэрэгтэй тул түүний намба ургах хүртэл олон аргаар түүнийг бүтээх хэрэгтэй болдог. Энэ үест бурханы намба дүр ургахад бэрхтэй болвоос дээр үзүүлсэн бодлоос аль нэгийг сонгож сэтгэлдээ тогтоон барьж болно. Энэ нь амарлингуй сэтгэлийн бясалгал төдийг ч гэсэн бүтээх шаардлагатайг эрхэмлэн үзүүлж байгаа хэрэг. Энэ үест бурханы лагшинг бодож бүтээхэд түүний намба байдлыг үл ургуулан сэтгэлдээ бариваас хүссэн хэрэг үл бүтэх учир намба байдлыг ургуулсны дээр сэтгэлээ тогтоох шаардлагатай.

Чингээд аль ургах хэмжээгээр ерөнхийд нь лагшингаа барих бөгөөд тэрхүү лагшингийн зарим нэг хэсэг нь их тод үзэгдвэл түүнийгээ барих буюу тэр нь сайн тодорхойгүй бол ерөнхийд нь бариарай. Тэр цагт шар өнгийг бясалгахыг бодтол улаан өнгө ургах мэтээр өнгөө үл магадлах, суугаа

байдалд бясалгахаар хүссэн ч босоо байдлаар ургах мэтээр хэлбэрээ үл магадлах, нэгийг бясалгана гэж бодсон хирнээ хоёрыг бодох зэргээр тоогоо үл мэдэх, их томоор бодох байснаа маш жижиг болгон ургуулах зэрэг зэрэг их, багыг үл мэдэх байдал гарвал тэдгээрийг дагаж үл болно. Зөвхөн язгуурын бодол юу байсан зөвхөн түүнийгээ л бодлын суурь болгож үйлдэх хэрэгтэй.

3

СЭТГЭЛЭЭ ТӨВЛӨРҮҮЛЭХ

2/ Хэрхэн сэтгэлдээ түүнийг тушаах ёсон
а/ Буруугүй ёсыг байгуулах
б/ Буруутай ёсыг арилгах
в/ Бясалгалын таасалгаа хэмжээг үзүүлэх

2/ Хэрхэн сэтгэлдээ түүнийг тушаах ёсноо гурав:
а/ Буруугүй ёсыг байгуулах
б/ Буруутай ёсыг арилгах
в/ Бясалгалын таасалгаа хэмжээг үзүүлэх

---оОо---

а/ Буруугүй ёсыг байгуулах

Энэ үесийн бүтээгдэхүүн болох бясалгал дияанд хоёр янзын ялгамжаа төгөлдөр байх хэрэгтэй. Үүнд сэтгэл машид тунгалаг орших буюу тунгалаг иртэй байх, хувь төгөлдөр байх, нөгөө нь бодол зорилгодоо нэгэн үзүүрт сэтгэлээр орших буюу үл атгаглах хувь төгөлдөр байх эдгээр болно.

Заримууд үүн дээр амгаланг нэмээд гурав болгосон бий. Мөн заримууд илхэн байхыг нэмээд дөрөв гэж тооцсон ч байна. Гэвч илхэн гэдэг эхний ялгамжаанд багтах тул тусад нь хэлэхийн шаардлагагүй.

Сэрүүхэн амсуургын (сэрэхүй) байдалт баясгалант амгалан тэр нь энэ үест бүтээх бясалгалын үрд гарах боловч, дияаны анхдугаар орны бэлтгэлд (нэрдог) багтах бясалгалтай хамт төрдөггүй. Гурван хөлгөний эрдмийг бүтээхийн дээд шүтээн хэмээн тооцогддог дияаны дөтгөөр орны бие амгалант, сэтгэл амгалант бясалгалын алинтай ч хамт төрдөггүй тул энд тооцохгүй. Тунгалаг ир ихтэй байх ч, дүрсгүй ертөнцийн газарт хураагдах зарим дияанд ч төрөхгүй бий. *"Судрын аймгийн чимэг"*-ээс "Дүрсгүй орныг тэвчсэн дияан болоод" хэмээсэн мэт зарим нэг эрхийг олсон бодисадвагаас бусад бодисадва нар дияаны газарт хураагдах бясалгалд шүтэн байж эрдэм бүтээлийг бүтээнэ" гэж зарлигласан учир тунгалаг байхын ялгамжааг номноход гэм байхгүй.

Тийнхүү тунгалаг тодохрой болж иртэй болоход "живэлт" тотгор болдог. Нэгэн үзүүрт үл атгаглах сэтгэл төрөхөд "дошгирол" тотгорлоно. Иймийн учир живэлт, дошигрол хоёр нь зөв сайн бясалгал бүтээхийн гол тотгор болдог учир энэ. Тиймээс живэл, дошигрол хоёрын нарийн, бүдүүн ялгааг сайтар таниад, таньсан хойноо тэдгээрийг хорих бясалгалыг хэрхэн үйлдэх ёсыг нарийн танин эс мэдвээс, үлэмж үзэхүй байтугай, амарлингуй ч үл төрөх тул, дияаныг чухалчлагч ухаантан нар эл учрыг ухаараарай.

Иймд живэл, дошигрол хоёр амарлингуйг бүтээхийн харшлах шалтгаан мөн бөгөөд харшлах шалтгааныг танин мэдэх болон хорих бодит ёсыг дараа номлох тул энэ үест амарлангуй сэтгэлийг бүтээхэд зохилдох шалтгаан болох бясалгал дияаныг төрүүлэх ёсыг өгүүлсүгэй.

Бясалгал дияан гэдэг сэтгэл нь бодол зоригдохуун дээрээ нэгэн үзүүрт болж орших хувь юм. Энэ нь бодол зоригдохуундаа үргэлжид тогтох нэгэн хэрэгтэй гэсэн утга буюу. Чингэхдээ 1/ сэтгэл маань аливаа үндсэн бодлоосоо алгасрахгүй байх нэгэн арга болоод 2/ алгасарсан, эс алгасарсан, алгасарч болох, алгасрахгүй байх алин болохоо мэдэж байх хоёр сэтгэл хэрэгтэй. Эхнийх нь дурдан санах бөгөөд удаах нь ухамсарлах (ухамсар) болно.*"Судрын аймгийн чимэг"-ээс:*

Санах, ухамсарлах хоёрт ойртуулан тушаах буюу. Эхнийх нь сэтгэлийг бодлоос нь сарниахгүйн тухайд хэрэгтэй бол удаах нь сэтгэл сарниж байгаагаа мэдэх мэдрэмж болой хэмээн айлджээ.

Дурдан санах сэтгэл доройтвоос бодох юмаа мартаж алгасраад тэр даруйд бодол санаа алдагдах тул бодол зорилгоо үл мартах, дурдан санах нь язгуур болно. Дурдан санах сэтгэл нь зоригдохуун орноо ойртуулахдаа дээр номносон мэт бодлын шүтээнээ тодруулах буюу наанадаж ургуулах төдий төсөөлөн мэдэх, аажмаар барих орноо хүчтэйгээр мэдрүүлж өгнө. Харин сэтгэлийг нөрдөн урамшуулах юм уу, шинээр олон зүйлийг шинжлэхгүй зөвхөн тогтоох болой. Дурдан санахуйн талаар *"Хотол хураангуй"-гаас:*

Дурдан санахуй гэж юу вэ? Мэдсэн зүйлээ санах, сэтгэлдээ мартахгүй байх болон алгасарахгүй байх үйлт болой" хэмээн гурван ялгамжаа төгөлдөр болохыг айлджээ.

Түүний бодлын орны ялгамжаа нь (1) Урьд нь мэдээгүй зүйлийг санах гэж байхгүй. Тиймээс мэдсэн зүйл гэж айлдсан хэрэг. Энэ үест өмнө нь мэдэж байсан бодлын орны дүр төрх ургах ёстой. (2) Намба төрх буюу барих орны

мэдэгдэхүүн ялгаа гэдэг нь сэтгэлээр мартахгүй хэмээн сэтгэлээр тэр орноо сэтгэлдээ мартахгүй байх хувь юм. Энэ үест бодлын сууриа үл мартах болой.

Үл мартах ёс гэдэг бусдаас асуусан болон өөрөө олж мэдсэнээ хэлэх тул тэдний бодлын суурь нь адил болно. "Тэр нь энэ адил болой" гэх зэргээр багшийн заасныг санаж чадах төдийг хэлээд зогсохгүй, сэтгэлдээ тогтоосон бодлоо үргэлжид санаж, өчүүхэн төдий ч үл алгасрах мөн. Алгасрах буюу тэр цухуйх төдийд л дурдан санах хаягдах болно. (3)Тиймээс бодлын орондоо сэтгэлээ урьдын адил агуулах буюу энэ мэтээр сэтгэлээ хадгална хэмээх нэгэн санааг төрүүлж, цаашдаа шинээр шинжлэлгүй, тэр ухааныхаа хүчийг сулруулалгүй үлгэлжид суралцах нь санахуйг шүтэх ёсны эрхэм увдис бөлгөө. Чадлын ялгамжаа нь сэтгэл бодлын орноосоо тийн алгасрах явдал билээ. Тийнхүү сэтгэлээ бодолдоо тушаах буюу номхотгох ёсыг их заасныг номхотгохын үлгэрээр айлдсан байдаг.

Үлгэрлэвээс, Их догшин зааныг маш бөх бат модонд юмуу, багананд маш бөх, хатуу сураар аргамжин байж, заан сургагч нэгэн түүнийг номхруулж сургах адилаар үйлдвээс сайн. Бүр эс болвол хурц гохоор дахин дахин цохиж, зодсоор номхруулдаг мэт. Эмнэг догшин их заантай адил сэтгэл түүнийг дээр номносон мэт "бодол зоригдлын бат багананд санахуйн сураар хүлээд, түүнээ үл тогтон сууваас ухамсарын дэгээгээр урхидан авчраад ягуу ягуухнаар эрхшээн үйлдэх хэмээсэн ба, *"Төв узлийн зурхэн"-ээс*

Бурууд одох сэтгэлийн зааныг
Бодлын бат бэх багананд
Санахуйн сураар сайтар хүлээд
Ухааны дэгээгээр зэрэгчлэн эрхшээ хэмээн айлдсан бөгөөд,

"Бясалгалын дунд зэрэг"-ээс ч: Сэтгэлийн их заанаа санах болоод ухамсарлахын сураар бодол зоригдлын модонд хүлж үйлдэх хэмээн айлдсан буй.

Эхний эш номонд ухамсарыг дэгээтэй адилтган айлдсан байна. Харин удаах эш номонд дээстэй (аргамж) адилтган айлдсан нь харшлахгүй. Сэтгэлээ бодож байгаа зүйлдээ үргэлж уяж байх нь дурдан санах болдог. Ухамсар ч гэсэн сэтгэлийг дамжуулж бодол руу нь оруулж байгаа хэрэг. Учир нь живэл, дошигрол бодитойгоор юм уу, эсвэл гарч ирэх нь гэдгийг ухамсарлан мэдэж, тэдний эрхэнд оруулалгүй үндсэн бодолд эргүүлж оруулж чаддаг.

Дээр дурдсан мэт Егнин (Васубанду) гэгээн бээр: "Санах, ухамсарлах

хоёулаа бодолд ойртуулан тушаагч болно" хэмээгээд "дурдан санахуйг шүтэж бясалгал бүтээнэ" хэмээн айлдсан бий. Санахуйг дээс аргамжтай адилаар сэтгэлийг жинхэнэ бодол дээр байнга уягч гэх зэргээр айлдсан тул бясалгалыг бүтээхийн эрхэм гол ёсноо суралцана гэдэг санахуйн ёсноо суралцах явдал билээ.

Дурдан санах ч гэсэн магадлах дүрт, барих оронт мөн тул дияанд суралцахад магадлан мэдэх дээд мэдэгдэхүүн байхгүйгээр гэнэт тогтоон бодлоо гэхэд сэтгэлд тунгалаг тодорхой хувь төрөх боловч, магадлах ухааны нигуурт өндөр иртэй тодорхой хувь гарахгүй учраас хүчтэй дурдан санахуй төрөхгүй. Тэр нь нарийн живлийг хорьж чадахгүй учраас зөвхөн алдаатай бясалгал болно.

"Бурханы лагшин тэргүүтнийг санах зэрэг бусад бодлын орноо сэтгэлээ тушаалгүй зөвхөн үл атгаглах сэтгэл төдийд суралцахдаа ч, ямар ч орноо үл атгаглах, эс сэжиглэх байдлаар агуулж үйлдээрэй" хэмээсэн увдисыг санаж сэтгэлээ саринуулалгүй, алгасруулалгүй үйлдэх хэрэгтэй.

"Үл алгасрах" гэдэг бодлын орноо үл мартаж дурдан санахтай нэгэн утгат тул санахуйд суралцах ёсноос хэтрэхгүй мөн. Тэр мэтээр бясалгахдаа ч магадлахын өндөр чадалт дурдан санахуйг ч шүтэх хэрэгтэй болно.

б/ Буруу ёсыг арилгах

Буруу ёсыг арилгахад арилгагдахуун болсон буруу ухаарсан атгагууд энэ мэт байна.

Буруу бодох нь: Урьд номносон мэт сэтгэлээ урамшуулж нөрдөн сайшаах ба нарийвчлан хянаад үл атгаглан барьснаар живэхийн гэм өчүүхэн төдий ч гарахгүй байж болох биз. Гэтэл дошигрох улам нэмэгдэж, сэтгэл тогтох хувь үргэлжлэн залгагдахаа болино. Үүнийг мэдээд ирэхээр ухаанаа урамшуулж байснаа муушаах бий. Бас сайн хянаад байхаар сулрах явдал ч тохионо. Тогтох байдал түргэн буй болохыг үзээд энэ арга нь их увдис мөн билээ.

Хариулт: Иймэрхүү магадлал олоод "сайн суларваас сайн бясалгал болно" гэж яруу өндөр дуугаар өгүүлэгч үзэгдэнэ. Гэхдээ энэ нь живэл төрөх ба бясалгал төрөх хоёрыг ялгаж чадаагүй хүний үг буюу. Энэ адилаар гэмгүй бясалгал мөн эсэхийг мэдьеэ гэхүл, дээр өгүүлсэн хоёр ялгамжаа төгөлдөр байх шаардлагатай. Зөвхөн үл атгаглах сэтгэлийн тогтох хувь баттай байгаагаар хязгаарлахгүй.

Хэдий тэр адилын сэтгэлийг харанхуйлж бүрхэх нэгэн гарч живэл

төрөх ч бий. Харин тиймгүй үед сэтгэл тунгалагшиж тодорхой хувьт болох тул бясалгал гэмгүй болно гэвэл мөн л тэр нь мунхрах болон живэл хоёрыг ялгахгүйн яриа болох вий. Тэдгээрийн талаар дараа дэлгэрэнгүй заана.

Буруу бодох нь: Хэдий хатуу хяналттай, ухааны иртэй байж, тодорхой хувь ихтэй байвч дошигрол ихдэх учраас тогтох хувь төрөхөд бэрхтэй болно биз дээ.

*Хариулт:*Түүнийгээ хэтэрхий султгаад байхаар тогтох хувь байвч живэлтийн хувь ихсээд иртэй хурц тод байх нь нь үгүй болно. Хянахдаа чанга, сулын алинд ч тавилгүй чанга, сул нь таарсан завсарыг олох амаргүй хэрэг. Живэл, дошигролоос хагацсан бясалгал төрөхөд бэрхтэй болох талаар, *Зандрагоми(Чандрагомин) багш бээр (Наминчлах магтаалдаа):*

Хичээж туурвихаар дошгирол гарах
Түүнээ орхивоос шантрал төрөх
Түүнийг тааруу тэнцүү олоход бэрхтэй тул
Хямарсан сэтгэлээр юу хийх вэ би хэмээжээ.

"Хичээж туурвих" гэдэг хатуу хянахыг хэлжээ. Түүнийг үйлдсэнээр дошгирол гардаг аж. Хяналтаа огоорох буюу сулруулаваас сэтгэл дотогш сууж мятрал төрдөг тул живэл, дошигролоос салж хувь тэгш орших сэтгэлийг мэдэж тэнцүүхэн хадгална гэдэг олоход бэрхтэй хэмээсэн утга ажээ. Энэ талаар *Санжай шивагийн(Буддхашанти) зохиосон тайлбарт:*

Хичээх гэдэг энэ үес буяны зүйлд илт эрмэлзэх байх тул хянамгайлан орж үйлдэх буюу хэмээгээд дошигрохын гэмийг мэдээд хичээхээ орхиж мэрийлтээ боливоос сэтгэл дотроо мятрахад хүрдэг хэмээн айлджээ.

Мөн "Наминчлах магтаал"-аас:

Шамдан орвоос дошигрол төрөх
Түүнийг сулруулваас мятрал төрөх
Эдгээрийн төвийг олж бүтээх бэрхтэй тул
Миний хямарсан сэтгэлээр юу хийх вэ хэмээжээ.

Түүний тайлбарт ч:

Машид шамдан хянамгайлан орж хичээвээс сэтгэл дошигрон алгасран даргадах тул хичээж мэрийснээс тогтвортой сэтгэл олдохгүй. Тиймээс тэрээр гэмтэй боллоо гээд түүнийг хариулахын тухайд хичээж шамдах сэтгэлээ султгаж,

мэрийлтээ орхивоос, мөн л бодлын орноо мартах зэргийн гэм ургаж сэтгэл мятрах ба живэл гарах болно гэж тодорхой айлджээ.

Тиймээс живэл, дошигрол хоёрын хязгаараас хагацсан төвийг олсон буюу тэгш орших бясалгал дияаныг олоход бэрхтэй ажгуу хэмээн айлдсан нь султгахаа зөв тааруулбал бэрхтэй зүйл байхгүй ч гэсэн түүнээс болж живэл төрнө хэмээсэн учир тэр дагуу бясалгалыг бүтээх зохисгүй болох нь тодорхой байна. Машид сулхан, тунгалаг төдий сэтгэлд тодорхой хувь хэрэгтэйгээр зогсохгүй барих орноо хянах шаардлагатай талаар *Асанга хутагт* бээр:

Тийнхүү агуулан үйлдэхэд ба үнэхээр агуулан үйлдэхэд хянан орох сэтгэлийг үйлдэх хэмээн сэтгэл тогтоох есөн аргын эхний болон хоёрдугаарх үесийг тийн айлджээ.

"Бясалгалын анхдугаар зэрэг"-ээс:

Живлийг арилгахдаа тэрхүү бодлоо чангатган барина хэмээжээ.

"Бясалгалын дунд зэрэг"-ээс айлдахдаа:

Чингэж живлийг амарлиулж яав ч сэтгэлээр бодлоо маш тодорхой үзэх тэр адилыг үйлд хэмээсэн буй. "Сэтгэлээр тодорхой үзэх" хэмээх нь (гадаад) орон вишай нь тодорхой байх төдийгүй ухааны (дотоод) барих орон нь тодорхой бат байхыг хэлжээ.

Дурдан санахыг шүтэх энэ ёс нь маш их чухал аа. Үүнийг мэдэхгүйгээр суралцсаны шинж гэвэл хичнээн олонтаа бясалгал хийвч тэр төдийгөөр мартах нь улам ихсэх ба ном үзэгдлийг тус тус ялгагч ухаан талхлагдахад хүрэх зэрэг маш буруутай зүйл олон гарна. Гэтэл баттай бясалгалыг оллоо гэж хөөрцөглөх ч үзэгдэнэ.

Асуулт: Дээр номносон мэтээр дурдан санах сэтгэлээ бодолдоо хадахын цагт бодлоо сайтар барьсан уу, үгүй юу гэдгээ манах сэтгэлийг төрүүлэх хэрэгтэй юу?

Хариулт : Үүнийг төрүүлэх хэрэгтэй. *"Бясалгалын дунд зэрэг"-ээс*:

Алин зорисон бодолдоо сэтгэлээ тогтоож түүнийгээ хойшид ургэлжид агуулах болой. Түүндээ шадар ойр байж, энэ мэтээр сэтгэл маань одоо юу

бодож байна, бодлоо сайн барина уу, живэл байна уу, гадны орон ургаж гараад алгасарч байна уу гэх зэргээр ажиглана хэмээжээ.

Энэ нь бясалгалаа орхичихоод ийн үзэхийн нэр бус. Бясалгалаа хийхийн сацуу үндсэн бодолдоо түрүүчийн адилаар оршиж байна уу, үгүй юу гэдгийг, хэрвээ эс оршсон бол живэл, дошигролын аль нь гарч ирсэн зэргийг үзэх төдий юм. Бясалгал хийхдээ хэтэрхий ахархан бус, хэтэрхий урт удаан байлгалгүй завсар завсарт нь манах бий. Түрүүчийн ухааны ир хүч мохоогүй үед үүнийг үйлдэж тэр ухааны нигуурт төрүүлвээс иртэй, хүчтэй удаан хугацаанд орших ба живэл, дошигрол гарахыг түргэн оножмэддэг учиртай. Тэр мэтээр завсар завсарт нь түрүүчийн бодлоо дурдан санаж байвал санах улам хүчтэй, бас үргэлж төгөлдөр болохын үндэс болох учир санахыг шүтэх ёсон үүнд буй болой. *"Сонсогчийн газар"-аас:*

Чингэвээс нэгэн үзүүрт сэтгэл гэж юу вэ? Өгүүлрүүн: Дахин дахин даган санах ба хувь зохилдонгуйг тухайлах, байнга үргэлжиж байх, гэмгүй буруугүй байх, баясал төгс сэтгэлийн үндэс энэ бүгд бий. Үүнийг бясалгал хэмээсэн ч бий. Нэгэн үзүүрт буяны сэтгэл ч гэдэг. Дахин дахин даган дурдах гэж юу вэ? өгүүлрүүн: Алив үзсэн, сонссон, багш нараас увдисласан, дагуулан заасан, олсон тэдгээр номын эрхнээ орж, бясалгал хийх ёсны шинж тэмдгийг илт үйлдэн тэдгээр бодлоо үргэлжид эргэцүүлэн санах ба их ойр шадарлан бодохыг хэлнэ хэмээжээ.

"Дундад хязгаарын тайлбар"-аас:

Дурдан санах гэдэг бодлоо үл мартах болой хэмээсэн нь сэтгэлээ тогтоох увдисыг сэтгэлээр өгүүлсэн хэмээх энгийн үг болой хэмээсэн буй.

Иймээс санахуйг шүтнэ гэдэг чинь бодлоос алгасруулагч мартамхайг арилгахын тухайд тул түүнийг хориглож юмаа мартахгүй байна гэдэг чинь сэтгэлээр бодлоо өгүүлэх буюу дахин дахин сэтгэлдээ бодлоо эргэцүүлэх болой. Үлгэрлэвээс, Зарим нэг мэдсэн юмаа мартахвий гэж сэжиг төрөхөд дахин дахин сэтгэлдээ эргэцүүлж санаад байхаар мартахгүй болдоггой адил. Тиймээс бодох юмаа үе үе санаж байваас санах ой хүчтэй болж сэтгэл бодох юмнаасаа өөр тийш салалгүй нэг чигт цэгцрэх учиртай.

Чингэж дурандан байж харуулдан манах нь живэл, дошигролыг таних ухамсар хүчтэй төрөх арга болдог. Гэтэл түүнийг атгаг сэжиг мэтээр ойлгоод орхивоос хүчтэй санах, ухамсарлах сэтгэл төрөхөд бэрхтэй болохыг

мэдээрэй.

в/ Бясалгалын тасалгаа хэмжээг үзүүлэх

Асуулт: Чингэвэл санах ойгоор сэтгэл маань өөрийн бодолдоо хэр зэргийн хугацаанд тогтож байгаа хэмжээг мэдэрч болох уу үгүй юу?

Хариулт: Тарнийн олон урсгалын төвд багш дээдэс нар айлдахдаа олон дахин богино хугацаатай бясалгах хэрэгтэй гэсэн буй.

Үүний учир утгын талаар, зарим нэгэн бээр: "Богино хугацаанд сайтар бясалгаад дараа нь нөгөө хэсгийг бясалгахаар орох мөн. Хугацаагаа уртасгавал залхах явдал гарч болзошгүй", бас заримууд бээр: "Хугацаагаа уртасгаваас живэл, дошигролын эрхэнд орохдоо хялбар болох тул зөв бясалгал төрөхөд бэрхтэй" хэмээн болгоожээ. *"Сонсогчийн газар"* зэрэг их ном шастараас тасалгааны хэмжээг тодорхой айлдаагүй ч, *"Бясалгалын сүүлийн зэрэг"-ээс:*

Энэ мэт буюу нэгэн цаг юмуу, тунгийн хагас хугацаанд манах юм уу, эсвээс нэг бүтэн тунгийн хугацаанд хэдий чадах тэр хүртлээ суугаарай хэмээн айлдсан байна.

Энэ бол амарлингүй сэтгэлийг бүтээчихээд үлэмж үзэхүйг бясалгах үеийн хэмжээг айлдсан мэт үзэгдэвч анхлан амарлингүйг бүтээх үетэй адилхан болох нь ил тул тэр дагуу үйлдээрэй. Энэ талаар дээр номносон мэт дурдан санах ба ухамсарлах ёсноо суралцан бодол зоригдохуун юугаа санах, манаж харуулдах зэргээр завсар завсарт нь шинжлээд байхад хугацааны урт, богиний гэм гарахгүй байж болох биз. Гэсэн хэдий ч ихэнх үйлийг анхдагч нарын хувьд хугацааг уртасгавал дахин умартаж алгасралд учирч болзошгүй. Тэр цагт сэтгэлийн живэл, дошигролын аль нэг гарч ирэхэд нь удаан хугацаанд нүүр төдийг танихаас цаашгүй түргэн таньж чадахгүйд хүрнэ. Хэдий санаж эс мартавч живэл, дошигролын эрхэнд орохдоо хялбар болж, гарч ирсэн живэл, дошигролоо түргэн хугацаанд танихгүй тохиолдол үзэгдэнэ.

Тэр хоёрын түрүүчийнх нь хүчтэй санамж төрөхөд саад болдог. Дараачийнх нь хүчтэй ухамсар төрөхөд саад болдог тул живэл, дошигролыг таслахад бэрхтэй болдог. Ялангуяа бодлоо мартаж алгасраад живэл, дошигрол хоёрыг таньж чадахгүй байна гэдэг бодлоо мартаагүй хирнээ живэл, дошигролыг түргэн таньж мэдэхгүй байгаагаас ч машид доорд муу зүйл болно. Тиймээс алгасралд автсаар амьтны санах сэтгэл доройтох

явдлыг няцаах ерөндөгийн талаар дээр номносон дагуу санах нь тун чухал шаардлагатай байна.

Алгасралд автваас мартах нь улам ихсэж живэл, дошигролыг түргэнээ мэдэхээ байж ухамсарын хүч улам хомсдоно. Харин мартах явдал багасч живэл, дошигролыг түргэн оножчадах үед хугацаагаа багахан уртасгавч нэг хором зэргээс илүү уртасгах шаардлагагүйг айлдсан буй.

Товчилвоос, "өөрийн ухааны хэр чадалд тохируулах хэрэгтэй тул хэдий чадал байна тэр хүртэл үйлд" хэмээн айлдсан байна. Мөн бие, сэтгэлд гэнэтийн хорлол тохиогоогүй үед бясалгал хийж болох ба хэрвээ тохиовоос чадах чинээгээр хийлгүйгээр тэр даруйд бясалгалаа түр завсарлаж, биеийн саад тотгорыг арилгасны дараа бясалгал хийхийг мэргэд болгоожээ. Чингэж үйлдэхдээ ч хэдий хүртэл хийх бясалгалын хугацаагаа бясалгалынхаа гишүүн гэж мэдэх хэрэгтэй.

4

ЖИВЭЛ, ДОШИГРОЛЫГ АМАРЛИУЛАХ НЬ

(в) Бодолдоо сэтгэлээ тушаасны дараа хэрхэн үйлдэх
1/ Живэл, дошигрол гарахын үест хэрхэн үйлдэх
а/ Живэл, дошигролыг үл танихын ерөндөгийг шүтэх
/1/ Живэл, дошигролын бэлэг чанарыг нотлон буулгах
/2/ Бясалгах үест живэл, дошигролыг таних ухамсарыг төрүүлэх арга
б/ Танин мэдсэн ч живэл, дошигролыг тэвчихийн тухайд үл хичээх ерөндөгийг шүтэх
/1/ Сэтгэлээ танин барьж живэл, дошигролыг хорих
/2/ Юуг шүтэж живэл, дошигрол төрөх үндсийг хорих
2/ Живэл, дошигролоос ангижрах үест хэрхэн үйлдэх

- - - o O o - - -

(в) Бодолдоо сэтгэлээ тушаасны дараа хэрхэн үйлдэхэд хоёр:
1/ Живэл, дошигрол гарахын үест хэрхэн үйлдэх
2/ Живэл, дошигролоос ангижрах үест хэрхэн үйлдэх

1/ Живэл, дошигрол гарахын үест хэрхэн үйлдэхэд хоёр:
а/ Живэл, дошигролыг үл танихын ерөндөгийг шүтэх
б/ Танин мэдсэн ч живэл, дошигролыг тэвчихийн тухайд үл хичээх ерөндөгийг шүтэх

а/ Живэл, дошигролыг үл танихын ерөндөгийг шүтэхэд хоёр:
/1/ Живэл, дошигролын бэлэг чанарыг нотлон буулгах
/2/ Бясалгах үест живэл, дошигролыг таних ухамсарыг төрүүлэх арга

/1/ Живэл, дошигролын бэлэг чанарыг нотлон буулгах

Дошигролын тухай *"Хотол хургаангуй"-гаас*:

Дошигрол гэж юу вэ? Гуа сайхан бэлгэ шинжийн дагалдан явах хүсэл шуналын аймагт багтаж сэтгэлийг үл амарлиулах ба амарлингуй сэтгэлийг тогторлох үйлт хэмээн тодорхойлжээ.

Түүнээ гурван зүйл буйгаас (1) Сэтгэлд таатай, гуа сайхан вишайнууд,

(2)Намба төрхийн хувьд сэтгэл огт тогтворгүй буюу гадагш сарнисан хүсэл шуналын аймгийн нэгэн хувьт болох тул шунах байдлаар зоригдолдоо хандах байдлууд, (3) Чадлын хувьд сэтгэл санаа бодож буй зүйл рүүгээ чиглэж тогтоход саад хийдэг. Сэтгэл бодлын орон руугаа хандах гэтэл дүрс, дуу зэрэгт шунах догшигрол төрснөөр өөрийн эрхгүй тэдэнд сэтгэл татагдан, алгасарч одно. *"Наминчлах магтаал"-аас:*

Хэрхэн чингэж амарлингүй сэтгэлийг зорьж
Тэр болоод түүнээ дахин дахин чиглэхүй ез
Тэр болоод түүнээс нисваанисын цалам болсон
Зоригдолд шунах болсоор өөрийн эрхгүй татагдах хэмээсэн мэт.

Асуулт: Чингэвэл өөр нисваанисын хүчээр сэтгэлээ өөр бусдад алгасруулах ба өөр бусад буяны бодолд шилжүүлбэл дошигрол болох уу?

Хариулт: "Дошигрол" бол хүсэл шуналын хувьт тул, түүнээс өөр бусад нисваанисын үүднээс алгасрах нь дошигрол биш. Харин шадар нисваанист багтах нөхөр сэтгэл л алгасрах сэтгэл болдог. Буяны бодол руу шилжвэл буянт сэтгэл болоод түүний нөхөр сэтгэлд багтах тул бүгдээрээ дошигролд тооцогдохгүй.

Олон зүйлийн орчуулгаас үзэхэд "живэх" гэдэг үгийг "мятрах шантрах" гэж хөрвүүлсэн байдаг ч "мууэкирч унах зэргийн шантрал" биш. Түүний бэлэг чанарын талаар Цастын орны ихэнх дияанч нар үзэхдээ: "Өөр бусад юм руу сарнилгүй оршиж, тунгалаг тодорхойгүй, бүрхэгдүү харанхуйлах балартах (мунхрах) маягтай сэтгэлийг живэх буюу живэл" хэмээсэн үзэгдэнэ. Гэхдээ энэ нь оновчтой бус шиг. "Харанхуйлах гэдэг живэлтийн үндэс гэж" айлдсан байх тул энэ хоёр тус тусдаа ойлголт болох нь. *"Бясалгалын дунд зэрэг"-ээс:*

Хэрэв харанхуйлж балартах болон нойроор дарагдаад ирэхийг сэтгэл живэх буюу живэл гэж үзвээс гэжээ.

"Таалльн тайлбар"-аас:

Хэрвээ балартах болон нойроор живэх буюу тэгш агуулах үеийн шадар нисваанисын алин нэгэн байгаа тохиолдолд түүний дотор байгаа сэтгэл алгасрал болох учиртай хэмээн балартах болон нойрсохын хүчээр сэтгэл живж унахыг дотоод алгасрал гэж айлджээ.

"Хотол хураангуй"-аас:

Живэлтийг шадар нисваанисын дотор багтах алгасрал гэж номносон боловч, тэр үест номносон алгасралд бас буянт сэтгэл төрөх тул нисваанис байх ч албагүй.

Тиймээс "харанхуйлах балартах" гэх утгын талаар *"Хотол хураангуй"-гаас:*

Харанхуйлах алин хэмээвээс, Мунхагийн аймагт багтах бөгөөд эдлэхүүн үйлт болоогүй (номхроогүй) сэтгэл буюу. Нисваанис болоод, шадар нисваанис бүгдтэй нөхөрлөх үйлт хэмээн айлдсан буй.

Тиймээс мунхагийн хувьт бөгөөд бие, сэтгэл хүндрэх буюу номхроогүй үйлт болохыг *"Абхидхармын тайлбарт*:

Харанхуйлах, алин бие хүндрэх, сэтгэл хүндрэх ба бие эдлэхүүн бус байх, сэтгэл эдлэхүүн бус байх алин тэр болой хэмээн айлджээ.

"Живэл" гэдэг сэтгэл бодлын орноо барих нь сулран, бодож буй зүйлээ маш тодорхой буюу баттай мэдэхээ больж, улмаар хэдий сэтгэлийн тунгалаг хувь байвч бодол зоригдохуун нь ямар ч тодорхойгүй болсноор живэл төрдөг байна. *"Бясалгалын дунд зэрэг"-ээс ч:*

Хэзээ нэгтээ харалган сохор байх юм уу, харанхуйд орсон хүн шиг байх юм уу, эсвээс нүдээ аних зэрэг тохиолдолд сэтгэлд бодлын орон тодорхойгүй болж үзэгдэж харагдахгүй болох тэр цагт живэл болно гэж ухаараарай хэмээжээ.

Бусад их номуудаас ч живлийн талаар тодорхой гаргаагүй үзэгдэнэ. "Живэл"-д "буянт болоод эш үл үзүүлсэн" гээд хоёр зүйл буй. "Харанхуйлан балартах" нь "нүгэлт болоод түйтгэрт эш үл үзүүлсэн" хоёрын аль нэгэн болж мунхагийн аймагт багтдаг болой.

Их гол номуудаас ч: Живлийг арилгахаар бурханы лагшин дүр зэрэг бясалгант орны сэтгэлдээ үйлдэх ба гэгээн гэрлийг бясалгаж сэтгэлээ нөрдөн магтах хэрэгтэй хэмээсэн буй. Тиймээс бодлын орноо харанхуй буусан мэт бүрхэг тодорхойгүй байлгах, бодол зоригдохуунаа орхих зэргээс ангижирч, харин ч бодлоо тунгалаг тодорхой болгох, бодлын орноо хянах хувь хоёуланг үйлдэх шаардлагатай. Орон тодорхой байх хувь болон орон тунгалаг байх хувь төдийгөөр хязгаарлаж болохгүй. Дошгирч буйгаа түргэн мэдэхэд хэргэтэй. Харин их номнуудаас живэлт гарч ирэхэд дарах талаар тодорхой зүйл айлдаагүй тул танин барихад бэрхтэй, бас маш харшилдах зүйл ч үзэгдэнэ. Энэ нь зөв дияан гэж тодорхойлоход эндүүрэх газар болмоор ч үзэгдэх. Ийм учраас нарийн нягт ухаанаар анхааран авч "*Бясалгалын зэрэг*"-т заасан дагуу сайтар шинжлэн мэдэж аваарай.

/2/ Бясалгах үест живэл, дошигролыг таних ухамсарыг төрүүлэх арга

Живэл, дошигролын ухаарал байгаа төдийгээр зогсохгүй, бясалгахын үест живэл, дошигрол гарсан, гараагүй эсэхийг ёсчлон мэдэх ухамсарыг төрүүлж чадах хэрэгтэй. Тэрхүү ухамсарыг хүчтэй зэрэгчлэн төрүүлснээр живэл, дошигрол төрсөн тэр даруйд танин барих ухамсар төрөхийг хэлээд яах вэ. Хараахан төрөөгүй байлаа ч төрүүлэхээр завдаж зохих ухамсарыг бий болгох шаардлагатай. *"Бясалгалын сүүлийн хоёр зэрэг"-ээс айлдахдаа:*

Сэтгэл живж байна буюу живэх гэж байна уу гэж сэжиглээд хэмээсэн ба
Сэтгэл дошигорч байна, дошигрох гэж байна уу гэж мэдээд хэмээжээ.

Тэр мэтийн нэгэн ухамсар төрөөгүй байх зуур эндээс энэ хүртэл живэл, дошигролгүй зөв бясалгал төржээ гэж лавлавч жинхэнээр төрөөгүй болохоор живэл, дошигрол төрчихөөд байхад огт таньж мэдэхгүй байдаг.

Энэ талаар *"Дундад хязгаар"-аас:* Живэл, дошигролыг ухах буюу хэмээн живэл, дошигролыг онохын тулд ухамсар хэрэгтэйг айлджээ. Тиймээс живэл, дошигролыг мэдэх үүрэгтэй ухамсар байхгүй бол хичнээн удаа бясалгал хийвч живэл, дошигрол төрсөөр байхад тэдгээрийг мэдэлгүйгээр нарийн живэл, дошигролоор цагийг өнгөрөөхөд хүрдэг.

Асуулт: Чингэвээс хэрхэн ухамсарлахуйг төрүүлэх вэ?

Хариулт: Дээр өгүүлсэн дурдан санахуйд суралцах ёс тун чухал шаардлагатай үндэс болно. Ийнхүү байнга дурдан санаж чадваас бодлоо умартаж алгасарах явдал хаагдаж живэл, дошигрол төрснийг удаан хугацаагаар мэдэхгүй өнгөрөх явдал буцаж, харин хялбархан мэддэг болно. Дурдан санахуйг доройтсон үед живэл, дошигролыг мэдэх ба доройтоогүй үед тэдгээрийг мэдэх цаг хугацааны урт, богино хувьд хоёр өөр зүйл мэдрэгдэх байдлаас тэдгээрийг илүү тодорхой харж болно. Үүнийг болгоон, *"Бодичарияаватара"-д айлдахдаа:*

Алин хэзээд санахуй сэтгэлийн үүднээс
Сахисан утганаа тогтон байх буюу
Тэр цагт л ухамсар (га) ирэх буюу хэмээсэн ба,

"Дундад хязгаарын тайлбар"-аас:

Дурдан санахаа үл умартан живэл, дошигролыг онож мэдэхийг ухамсар хэмээнэ хэмээсэн нь ухамсар нь дурдан санахуйтай шадар нөхөрлөн байж төгөлдөр болдог аж. Тиймээс санахуйг үл умартан хэмээн тайлбарлажээ.

Бас нэг үндэс гэхүл, ухамсарт суралцах нийт бусын нэг ёс буй. Сэтгэлдээ бурханы лагшин намба дүрийг бодох юм уу, мэдрэгдэх, амсагдах, тунгалаг

гэрэл төдий зэргээр баригдах намба байдал зэргийг бодож байхдаа, дээр өгүүлсэнчлэн дурдан санахын агаараас өөр зүйл рүү сэтгэлээ сарниалгүй, манаж харуулдан сэтгэлдээ барих явдал эдгээрийг ухамсарт суралцах гол аньс гэж бариарай. Энэ талаар, *"Бодичарияаватара"-д:*

Бие болон сэтгэлийн орон үеийг
Байн байн шинжлэн үйлдэх ба
Тэр тэр ямагтыг товчилвоос
Ухамсарт суралцах бэлэг чанар хэмээмой хэмээжээ.

Эндээс үзвэл живэл, дошигрол төрөх бэлтгэлийг мэдэхээс эхлэн ухамсар төрөх бөгөөд санахуйн ёсыг шүтсэнэр алгасарч одох, умартах явдлыг хорих тул сайтар ялгаж ойлгох хэрэгтэй. Чингэлгүй тэдгээр сэтгэлийг нэгэн гэж хольж хутгаад бодлоо ялгаж мэдэх ухааралгүйгээр одоогийн хийж байгаа шигээ сурчихвал барагтайхан үндэснээс төрсөн бясалгал түүн шигээ үр төрүүлнэ гэдгийг санаарай.

Тиймээс гарвал сайтай гол номнуудтай тааруулж сайтар нягтлах ухаанаар шинжлэн, бясалгах гарын авлага болгож нотлон буулгаваас чухал билээ л. Чин зориг төдийгөөр бүү хязгаарал. *"Барамидын хураангуй"-гаас:*

Гагц хичээнгүйг туурвиваас алжаалын туйл тул ухаантай ижилсүүлж суралцваас их хэргийг бүтээх хэмээн айлдсан нь учиртай буюу.

б/ Танин мэдсэн ч живэл, дошигролыг тэвчихийн тухайд үл хичээх ерөндөгийг шүтэх

Дээр номносон мэт санахуй ба ухамсарт суралцах ёсыг сайтар мэдснээр санах, ухамсарлах хоёр маш баттай төрнө. Живэл, дошигрол хэдий нарийхан байвч ухамсараар таньж чадах тул төрсөн живэл, дошигролыг танин бариагүйн гэм гарахгүй. Гэвч тэр хоёрыг төрмөгц хорихыг хичээж эс үйлдэх болон зөнд тавихгүй хэмээн хичээнгүйлэн эс үйлдвээс бясалгал төрөхөд маш их саадтай болдог. Энэ мэтээр явбаас сэтгэл дураар дургих ба аливаа дошигрол зэргээс ангижран салсан тогтвортой сэтгэлийг олоход маш бэрхтэй болдог. Тиймээс живэл, дошигрол төрөхөд тэвчихээр хурж үл үйлдэхийн эсрэг "ерөндөгт хуран үйлдэхүй буюу хичээхүй" гэж нэрлэгдсэн сэтгэлийг дадуулж үйлдээрэй. Үүнээ хоёр:

/1/ Сэтгэлээ танин барьж живэл, дошигролыг хорих ба,

/2/ Юуг шүтэж живэл, дошигрол төрөх үндсийг хорих болой.

/1/ Сэтгэлээ танин барьж живэл, дошигролыг хорих

"Хотол хураангуй"-аас:

Сэтгэх (сэдэх) гэж юу вэ? Сэтгэл илт хуран үйлдэх дотоод сэтгэлийн үйл буюу буян, нүгэл болон эш эс үзүүлсэнд (алин ч бус) сэтгэл орсон үйлт хэмээн айлдсан дагуу мэдээрэй.

Үлгэрлэвээс, соронзон чулууны эрхээр төмөр өөрийн эрхгүй хөдлөх адилаар сэтгэлийг буян, нүгэл, эш эс үзүүлсэн гурвын алин нэгнээ өдөөн хөдөлгөгч нөхөр сэтгэлийг сэтгэсэн бодол гэдэг. Энэ үед живэл, дошигролын аль нэг нь гарахад түүнийг тэвчихээр сэтгэлийг илт хураан үйлдэх, сэтгэх бодол гэж бариарай.

Асуулт: Чингэж живэл, дошигролыг хорихын тулд сэтгэлээ илт өдөөснөөр хэрхэн тэр хоёрыг хорих вэ?

Хариулт: Сэтгэлийн живэх байдал хэтэрхий дотогшоо хураагдан лавширснаар бодлын орноо алдахад хүрдэг. Тийм нөхцөлд сэтгэлээ гадагш цацруулахын үндэс болсон (сэтгэл сэргээх) баясалгалант зүйлийг сэтгэлдээ бодох хэрэгтэй. Жишээ нь, бурханы үзэсгэлэнт лагшинг харах гэх мэтээр. Гэхдээ нисваанис төрөх зугаа цэнгэлийг бус болой. Мөн нарны гэрэл гэгээ зэргийг сэтгэлд ургуулан бодвоос живлээс сэргэж ирдэг. Тэр даруйд бодлын орноо бататган барьж аваад цааш судална. *"Бясалгалын эхний зэрэг"-ээс:*

Балартах, нойр хүрэх зэрэгт цохиулан бодож буй зүйл тодорхойгүй болж сэтгэл санаа хүндэрч ирэх алин тэр цагт гэгээн гэрлийн хур мэдлийг бясалгах буюу бодит дээд баясгалан болсон бурхан тэргүүтний эрдэм чадлыг сэтгэлдээ бодох зэргээр живлээс ангижирч бодлоо чангатган бариарай хэмээн айлдсан мэт.

Ингэхдээ уйтгарт бодлыг бодох хэрэггүй. Уйтгарлах нь сэтгэлийг бүр дотогш хураах үндэс болдог учиртай. Тус тус ажиглагч ухаанаа аливаа ажиглахаар зорьсон орноо хандуулж ажиглаж шинжээд ирэхээр живэл арилддаг. *"Барамидын хураангуй"-гаас:*

Үлэмж үзэхүйд хичээх хүч чадлаар
Шантрах, няцах төрвөөс нөрдөн магтах (сэтгэлээ хянах)

хэмээсэн мэт. Тийнхүү живэх буюу шантрах нь бодлын орныг маш их холдуулж цаашлуулах бөгөөд хэтэрхий дотогшоо хураагдсан байдалтайг шантрах гэдэг. Өөрөөр хэлбэл, бодож буй зүйлдээ урамтай байх, бодлоо

дэлгэрэнгүй цацруулан бодох зэргээс буцсан мөн болохыг, *"Төв үзлийн зүрхэн"-ээс:*

Шантрах гэдэг бодлоо дэлгэр ихээр
Бясалгалаад алгасарч хоцрох буюу хэмээгээд

Шантрах гарлаа ч хичээнгүйлэн
Тус эрдмийг санаж нөрдөн магтаж үйлд хэмээжээ.

"Суртгаалийн хураангуй"-д ч: Түүнээ сэтгэл шантарвaас баясгаланг бясалган нөрдөн магтаж үйлд хэмээн их мэргэн бүтээлчид нэг дуугаар зарлигласан байна. Тиймд живлийг дарахад чухал eрөндөг гэвэл чухаг дээд гурав болон бодь сэтгэлийн тус эрдэм болон чөлөө учралыг олохын тус эрдэм зэргийг дурдан санаж, нойр хүрч зүүрмэглэвээс хүйтэн усаар шавшиж толгойгоо сэргээх зэргээр суралцах хэрэгтэй. Эдгээр нь тус эрдмийн зүгийг тус тус ажиглах, шинжлэх бясалгалын чадал олсонтой харгалзана.

Аливаа живэл төрөхийн уг болсон харанхуйлан балартах ба нойр хүрэх зэргээр энэ хоёрт татагдсан сэтгэл харанхуйлж бүдэгрээд ирэхэд тэдний ерөндөг болсон гэрэл гэгээ зэргийг бодож бясалгавал хэдийд ч тэдэнд дулдуйдсан живэл төрөхгүй бөгөөд төрсөн нь буцдаг.

Энэ үесийн явдал гэвэл тогтож суух, гэгээн шинж байдлыг дахин дахин сэтгэлдээ буулгах, дахин дахин дадуулах ба бурхан, ном, хувраг, шагшаавад, өглөг, бурханыг даган дурдан санах зэрэг зургаагийн аль нэгэн буюу үүнээс бусад сүсгийн орон болох бодлуудаар сэтгэлээ урамшуулан сэргээх зэрэг болно.

Балартах, унтах зэргийн гэм бурууг заасан ном судрыг амны уншлага болгох ба зүг зүг тийш харах, нар, сар, од эрхэсийг харах, нүүрээ усаар угаах зэргээр үйлдэхийг "*Сонсогчийн газар*"-аас айлджээ.

Живэл машид нимгэрч ганц нэг төдийгөөс илүү гарахгүй бол сэтгэлийн зоригдохуунаа хянамгайлан бариад бясалгалаа үйлд. Живэл хүндрэн зузаан болж дахин дахин ирвээс бясалгалынхаа тасалгааг хойшлуулах ба дээрх ерөндөгөөс алин таарахыг хэрэглэж живлээ арилгаад бясалгалаа үргэлжлүүлнэ.

Сэтгэлийн амыг гадагш, дотогш хандуулан барих үед аливаа бодох зүйлүүд тодорхойгүй болж, харанхуй нөмрөх мэтийн зузаан, нимгэн байдал алин нэгэн үзэгдэхэд тэдгээрийг арилгалгүйгээр бясалгалаа үргэлжлүүлбэл

живлээс ангжирахад бэрхтэй болдог. Түүний ерөндөг болон гэрэл гэгээг дахин дахин бясалгаж үйлдээрэй. *"Сонсогчийн газар"-аас:*

Гэгээ төгөлдөр, гэрэл төгөлдөр, тунгалаг гэрэлт харанхуй бус сэтгэлээр амарлингуй ба үлэмж үзэхүйг зөвөөр бясалгаарай. Та тэр адилаар амарлингуй болоод үлэмж үзэхүйн мөрд гэгээн хур мэдлийг бясалгахад эхэндээ бодолдоо сүслэх байдал тодорхойгүй байх, гэгээ өчүүхэн зэрэг гарах ч, бясалгал дадлагын шалтгаан нөхцөл түүгээр тэрхүү бодолдоо сүслэх явдал улам тодрон тодорсоор их гэгээн тунгалаг болох бий. Хэрвээ эхэндээ ихэд тунгалаг гэгээн байвал хойшдоо ч улам дэлгэрэн машид их гэгээн ямагт болох болой хэмээжээ.

Эхнээсээ бодлоо тодорхой болгон бясалгах хэрэгтэйн учир тодорхойгүй үед хэрхэхийг хэлэх юун. Гэгээн байдлыг хэрхэн яаж барих вэ? Дээрх "*Шастар*"-аас:

Зулын гэрэл, галын цогцосын гэрэл, нарны хот мандлын гэрэл зэргээс гэгээн шинжийг баригтун хэмээжээ.

Гэгээн шинжийг бясалгах гэдэг зөвхөн бясалгах цагт төдийгүй бусад үед ч хийж болдог. Дошигрох гэдэг хүсэл шуналаас үүдэж дүрс, дуу зэрэг орноо сэтгэл гүйх явдал тул сэтгэлээ дотогш татахын уг болсон сэтгэл гансрах зэргийг бодох нь зүйтэй. Чингэж дошигрол амарлингуут бодож байсан зүйл дээр сэтгэлээ тогтоож бясалгана. *"Бясалгалын анхдугаар зэрэг"-т:*

Хэзээ нэгэн цагт эхлээд сэтгэл дошигроод тоглоом наадам бодогдох зэргээр сэтгэл хөөрч гэгэлзээд байвал мөнх бус тэргүүтэн сэтгэл гансрах, сэмлэх бодлыг сэтгэлдээ тунгаавал дошигрол амарлина. Түүний дараа дахин сэтгэлээ бодолдоо илт хураалгүйгээр шамдаж үйлдэнэ хэмээжээ.

Мөн *"Төв үзлийн зүрхэн "-ээс ч:*

Дошигрох аваас мөнх бус тэргүүтнийг
Сэтгэлдээ бодож амарлиулах хэмээсэн ба,

Алгасран алгасрахын шинж гарваас
Гэм бурууг санан хурааж үйлдэх хэмээсэн ба,

"Суртгаалийн хураангуй"-гаас: Дошигрох болвоос мөнх бусыг сэтгэлдээ тунгааснаар машид амарлих хэмээсэн тул дошигрол хүчтэй буюу удаан хугацаагаар гарвал түр зуур бясалгалаа султгаад уйсал бясалгах их

аньстай. Гэхдээ сэтгэлийн цацралыг нэг нэгээр татаж агуулах бус. Харин дошигролыг ихэсгэлгүй тэр төдийд барьж цацарсан түүнийг татаж бодол дээрээ зүүх үйлдэл юм. "Барамидын хураангуй"- д:

Дошигрол гарах цагт урвасан сэтгэлийг
Амарлиулан тогтоох ёсоор хариулж үйлдэх хэмээжээ.

Судраас сэтгэлээ машид агуулах болой хэмээсэн нь дошигролын өрөндөгийг айлдсан хэмээн *"Газрын аймаг"-аас* тайлбарлажээ. Ерөнхий зүйлд сэтгэл дошгирвоос маш сайн бодол дээрээ сэтгэлээ тогтоох ба сэтгэл живбээс баясгалант орныг барих гэж хоёр зүйлийг айлджээ. *"Сонсогчийн газар"-аас:*

Тийнхүү сэтгэл дотогшоо илт хураагдаж шантрах буюу шантрах нь уу гэхээр сэжиг төрөх тэр цагт машид баригдах шинж болон завсарт урвах шинж байдлын аль нэг гарах тул машид таних ба машид баясан үйлдэх зэргээр тэдгээрийг сэтгэлдээ машид барьж үйлдэх мөн. Машид агуулах гэж юу вэ? Машид барихын үест болон сэтгэл дошигрох нь уу, үгүй юү гэдгийг сэжих тэр цагт ч сэтгэлийг дотогш илт хураах ба амарлиулан машид агуулж үйлдэх мөн хэмээн айлджээ.

Сэтгэл дошигроход дурлах болон баясалт орныг сэтгэлдээ бүү үйлдээрэй. Тэрээр гадагш алгасрахын үндэс болдог шүү.

/2/ Юуг шүтэж живэл дошигрол төрөх үндсийг хорих

"Газрын бодит суурь"-аас:

Живэл ямар шинжтэй вэ? Эрхтний үүдийг үл сахих, амны идээний хэмжээг үл барих, шөнийн эхний хувь болон сүүлийн хувьд унтахгүй байх ёсноо үл хичээх, ухамсаргүйгээр орших, мунхаглан явах, их унтах, арга үл мэдэх ба залхуу төгс дур хүсэл буюу хичээх, сэтгэх, ажиглах, амарлингуйд дадах зэрэгт залхуурал төгөлдөр байх болон амарлингуйг төгс төгөлдөр бус үйлдэх, өрөөсгөл талыг барих, сэтгэл будантай байх, бодлоо зүглүүлж чиглүүлэхдээ үл баясах хэмээн айлджээ.

Живэх шинж гэдгийг энэ үест живлийн шалтгаан гэж ухаараарай. Энд "залхуу төгөлдөр" гэснийг хичээх, сэтгэх, ажиглах гурав дээр нийлүүлэн ойлгоорой. *Мөн "Газрын бодит суурь"-аас:*

Дошигрол ямар шинжтэй вэ? Дээрхийн адил эрхтний үүдийг үл сахих тэргүүтэн дөрвөн зүйл: хүсэл шуналыг эдлэх, үл амарлих ёст байх, сэтгэл уйтгаргүй байх, аргаа үл мэдэх, дээрхийн адил хэтрүүлэн лавтай барих сэтгэл төгс дур хүсэл тэргүүтэн хичээнгүйд үл дадах, машид барихыг үл судлах, өрөөсгөл зүгийг бясалгах, эргэн тойрноо сэжих зэрэг дошигролын зохилдох алин нэг зүйлээр сэтгэл алгасрах явдал мөн хэмээсэн буй.

“Дошигрох шинж” гэдэг дошигролын үндэс болой. Хэтэрхий лав барих гэдэг сэтгэлээр баясгалант орныг чангатган барих явдал юм. “Түүнтэй төгөлдөр дур хүсэл” тэргүүтний дээр номносон болой. Тиймээс өмнө нь бясалгал завсарлах үест үзүүлсэн эрхтний үүдийг хаах дөрвөн зүйл нь живэл, дошигрол хоёуланг хаахад маш их хэрэгтэй байдаг. Ийнхүү эдгээр үндсийг мэдэж тэдгээрийг хорихоор хичээвэл живэл, дошигролыг таслахад машид тустай болох нь тодорхой.

Тиймээс живэл, дошигролын нарийн хувийг ч ухамсараар танин мэдэвч тэр хоёр ямар ч байдлаар байлаа зөнд нь үл орхиж бүгдийг хаах хэрэгтэй. Хэрвээ чингэж үл үйлдвээс “хуран үл үйлдэх” хэмээх бясалгалын гэм мөн болохыг “*Дундад хязгаар*”-аас айлдсан байна.

Гэтэл дошигрол, алгасрал зэргийн нарийн зүйлүүдийг эхнээс нь хааж чадаагүйгээс хойш таслаад яах вэ хэмээн ясал орхих ба тэдгээрт хүчтэй хатуу, өнө удаан үргэлжлэх “хонины холбоо хэлхээ” байхгүй тул хүч сул, үргэлжлэл богино байх учраас үйл үл хураах гээд таслах хэрэггүй хэмээх нь тэдгээрийг тэвчихээр “илт хуран эс үйлдэх” тэдгээрээр үнэн зөв бясалгал бүтээхийн ёсыг мэдэхгүй хирнээ мэдэж байгаа мэтээр засварлах нь бясалгалыг чухалчлагч нарыг хуурч байгаа явдал болно. Майдар гэгээн тэргүүтэн бясалгал дияныг бүтээх ёсыг нотлон буулгагчдын ёсноос гадуур зүйл болж байна.

Ийнхүү живэл, дошигролыг хаахдаа ихэнх тохиолдолд эхлээд дошигрол ба алгасралаар тотгорлогдсон зүйлийг таслахаар шамдах ёстой. Түүнийг буцааж сэтгэл тогтооход учрах тотгорыг арилгахаар шамдах шаардлагатай. Энэ мэтээр шамдахад дошигрол болон алгасралын бүдүүн хэсэг арилж тогтохын хувь өчүүхэн нэгийг олно. Тэр цагт живлийн авд шамдах хэрэгтэй. Ухаанд хүч сууж живлийг хөөгөөд ирэхээр дошигрол урьдынхаасаа нарийн болж сэтгэл тогтоход тотгорлох бий. Түүнийг таслахаар хичээж, улмаар түүнийг буцааснаар тогтох хувь их болж ирнэ. Тэр цагт ч живэл төрж болох тул живлийг таслахад шамдаарай.

Товчилвоос, цацрах дошигролоос сэтгэлээ татаж дотогш бодолдоо

наалдуулан тогтох хувийг эрэлцэх буюу. Тогтох хувь ганц нэгээр төрөх тутамд живлийн авыг ихэд хичээснээр улам тодорхой, хурц иртэй болно. Тэрхүү хоёр ээлжлэн ээлжилсээр гэмгүй зөв бясалгал дияаныг бүтээнэ.

Бодлын орон нь тодорхой сайн хувьт болоогүй ч иртэй хурц, тунгалаг нэгэн ургах төдийхнээр тогтох (орших) хувь оллоо гэж бүү горилоорой.

2/ Живэл, дошигролоос ангижрах үест хэрхэн үйлдэх

Дээр номносон мэт нарийн живэх, дошигрохыг таслахаар бясалгахад дахин живэл, дошигрол гарч ирэх зэрэг сэтгэл тэгшгүй байдал арилна. Чингэж тэгш орохын цагт хуран үйлдэх юм уу, хичээл шамдлыг эрэлцвэл бясалгалын гэм гарах тул түүний ерөндөг болгож тэгш агуулах сэтгэлийг бясалгаарай. Энэ талаар *"Бясалгалын дунд зэрэг"-ээс:*

Хэзээ нэг живэл, дошигрол хоёр үгүй болж, сэтгэл тэрхүү бодолдоо баттай суухыг үзэх тэр цагт хичээлээ сулруулж, тэгш агуулах бөгөөд тэр цагт хэдүй хүссэнээр сууж үйлдээрэй хэмээжээ.

Асуулт: Гэвч хуран үйлдэхэд болон хичээснээр ямар гэм үүдэх вэ?

Хариулт: Сэтгэл дошигроход дотогш татах ба живэхэд нөрдөн магтах зэргээр дадаж сураад ирэхээр бясалгал завсарлах үе бүхэнд живэл, дошигрол төрөхгүй байх бат нотыг олно. Тэр цагт анхны үеийнх шигээ живлийн ав болон дошигролын авыг ихээр үйлдэх бий.

Тийн үйлдэхийг *"Бясалгалын зэргийн" сүүлийн хоёроос айлдахдаа:* Сэтгэл тэгширчихээд байхад хичээл шамдлыг үйлдвээс тэр цагт сэтгэл алгасрах бий хэмээн айлдсан мэтээр алгасрал ирэх учир тэр цагт сулруулах учиртайг мэдээрэй.

Тэр нь хичээлээ сулруулахыг хэлж байгаа болохоос зоригдохуундаа иртэй байхаа болих бус болой. Тиймд тэгш агуулах энэхүү бясалгалыг живэл, дошигрол төрөөгүй байгаа тэр цаг үес болгонд үйлдэх бус живэл, дошигрол зах үзүүр цухуйгаад ирэхэд үйлдэнэ. Живэл, дошигрол үзүүр зах чуулсан үед тэгш агуулахуй байхгүй буюу.

Асуулт: Чингэвэл "тэгш агуулах" гэж юуг хэлнэ вэ?

Хариулт: Ер нь тэгш агуулах сэтгэлд амсуурга тэгш агуулах, дөрвөн цаглашгүйн нэг болох тэгш агуулах, хуран үйлдэхүйн тэгш агуулах гэж гурван зүйл буй. Энэ үед хуран үйлдэх тэгш агуулахын талаар ярьж байна. Түүний

мөн чанарын талаар *"Сонсогчийн газар"-аас:*

> Тэгш агуулах гэж юу вэ? Амарлингүй сэтгэл болоод үлэмж үзэхүйн зүгийн зоригдохуунаа хотол нисваанисгүй сэтгэлээр сэтгэл тэгширч тогтох, баттай буух, өөрийн зөнгөөр орших, сэтгэл амгалан тайван байх, сэтгэл эдлэхүүн болсны дараа хичээл чармайлтгүйгээр хандах зэрэг тэдгээр болой хэмээн айлдсан дагуу мэдээрэй.

Тэр адилын тэгш агуулах сэтгэлийг олсон цагт бясалгал үйлдэх буюу живэл, дошигрол гарахаа больсон цагт тэгш агуулах сэтгэлийг илт болгож хичээл чармайлтаа ихэд чангаруулалгүй агуулж үйлдээрэй. Түүний шинжийн талаар *Дээрхи ном"-оос айлдахдаа:*

> Тэгш агуулах нь ямар шинжтэй вэ? Аливаа бодол дээр сэтгэлээ тэгш агуулан үйлдэх ба тэрхүү бодол дээр хэтэрхий хичээл шамдлыг хэтрүүлэн туурвихгүй байх тэр мөн хэмээн айлдсан мэт. Тэгш агуулан бясалгах цагийн талаар, түүнд айлдахдаа: Тэгш агуулахын цаг юу вэ? Амарлингүй болоод үлэмж үзэхүйн зүгт сэтгэлд живэх ба дошигрох байхгүй болсон цаг бөгөөд хэмээсэн мэтээр болно.

Тийнхүү гэмгүй зөв бясалгалыг бүтээх ёсыг номносон эдгээр зүйлүүд нь *"Дундад хязгаарыг тийн ялгагч"* шастартаа Майдар гэгээн хэрхэн зарлигласан дагуу билээ.

Тэнд орших, үйлнээ эдлэгдэхүүн болох
Утга бүхнийг үчруулах буюу
Таван гэмийг тэвчих ба найман хур мэдлийг
Шүтэхийн үндэснээс гарсан болой

Залхуурах ба увдис номыг
Умартах, живэх, дошигрох
Хуран үл үйлдэхийг хуран үйлдэх
Эдгээрийг таван гэм хэмээдэг

Орших, түүнээ орших
Шалтгаан ба үр ямагт буюу
Бодлоо үл умартах ба
Живэл, дошигролыг онох ба

Тэдгээрийг тэвчлийг илт хуран үйлдэх
Амарлиулах цагт батад орох болой хэмээн айлджээ.

Энд өгүүлж буй "тэнд орших" гэдэг нь үл зохилдох зүгийг арилгахын тухайд хичээнгүйг туурвин түүнээ орших буюу сэтгэлээ эдэлж жолоодох бясалгал төрсөн болой. Мөн зөн мэдэл тэргүүтэн хэрэг бүхнийг бүтээх рид хувилгааны хөл буюу орон оршсон тул "утга бүхнийг учруулж" үйлдэнэ.

Хэрхэн тэр бясалгалыг төрүүлэх вэ? Таван гэмийг тэвчихийн үүднээс найман хуран үйлдэхүйг шүтэх үндэсээс төрөх болой. *Таван гэм нь:* Бэлтгэлийн үест залхуу гэмтэй буюу. Тэрээр бясалгалыг холбож нийлүүлдэггүй учраас. Бясалгалд хичээхийн үест увдисаа умартах нь гэмтэй буюу. Зоригдохуунаа умартваас сэтгэлээ бодолдоо тэгш агуулж чадахгүй. Тэгш агуулахад живэл, доширгол гэмтэй буюу. Тэр хоёр бээр сэтгэлийг (үйлнээ) эдлэхүүн болгохгүй учраас. Живэл доширгол гарсан үед үл хичээх нь гэмт мөн. Чингэснээр тэр хоёрыг амарлиулж үл чадна. Живэл, дошироолоос хагацсан цагт хуран үйлдэх сэтгэл гэмт буюу. Живэл, доширгол хоёрыг нэг гэж тоолвол тав болно. Тус тус тоолвол зургаан гэм ч болохыг *"Бясалгалын зэрэг"*-ээс айлджээ.

Тэдгээрийн өрөндөг болсон "хуран үйлдэх найман тэвчил" зэргээс залхуугийн өрөндөгт сүсэг, эрмэлзлэл, чармайлт, машид боловсорсон эдгээр дөрвөн зүйл бий. Цаашлаад умартах; живэл, доширгол, хуран үл үйлдэх; хуран үйлдэхийн өрөндөгт дурдан санах; живэл, доширголыг онох ухамсар, хуран үйлдэхийг бат агуулах; тэгш агуулах зэрэг тус тус бөгөөд эдгээрийг үүний өмнө дэлгэрэнгүй номносон бөлгөө.

Эдгээр нь бясалгалыг бүтээх увдисын дээд мөн тул их ловон Камалашилагийн "Бясалгалын гурван зэрэг" болон хутагтын орны бусад олон мэргэд нарын бясалгалыг бүтээх олон бүтээлд номножээ. *"Мөрийн зулын тайлбар"*-т ч, амарлингуй сэтгэлийг бүтээх үест номносон ба *"Бодь мөрийн зэрэг"*-ийн дээдэс багш нар ч хэсэг хэсгээр нь номносон бий. Гэхдээ бясалгал дияаныг бүтээхийг хүсэгч нар хэрхэн үйлдэхээ мэдэхгүй байх нь тохиолдох тул дэлгэрэнгүйгээр нотлон буулгасан нь энэ болой.

Ийнхүү нэгэн үзүүрт бясалгал дияаныг санах ба ухамсарлан байж живэл, доширголоос салгаж суралцах нь нийтийн орон болох тул зөвхөн судрын хөлгөний тухайлсан ном мөн гээд тарнийн ёсонд хэрэггүй гэж бүү үзээрэй. Үүнийг ханьцашгүй дандрын ёсонд ч мөн адил айлдсан учраас нийтийн орон болно. *"Цогт Самбуди дагву" хэмээх дандрын хоёрдугаар бүлэгт айлдахдаа:*

Хүслийн бясалгалыг тэвчсэн хуран үйлдэхүй төгөлдөр рид хувилгааны хөлөөр аглагт оршоод, хүсэл тачаалаас хагацан орших, хорихуйд орших, үнэхээр

тэвчил зэргээр огоот урвах буюу. Тэрээр хүсэлдээ хэтэрхий шантрахад болон ихэд магтуулахгүй зэрэгт дадах ба... хэмээн хичээхүй, ажиглах, сэтгэлийн бясалгал гурвуулан дээр тэр мэт байхыг айлджээ.

Дээр номносон бясалгалын эдлэхүүн болох тэдгээр нь рид хувилгаан тэргүүтэн эрдэм бүтээхийн суурь буюу хөл адил учир рид хувилгааны хөл хэмээжээ. Түүнийг бүтээхэд "дөрвөн үүд" буюу 1/ хүчтэй эрмэлзэн тэмүүлэх сэтгэлийг олох, 2/ өнө удаан хугацааны хичээнгүй туурвилтай байх, 3/ зоригдохуун бодлоо сайтар ялгаж чадах бясалгалыг олох зэргээр эрмэлзлэн тэмүүлэх бясалгалаас хичээнгүй болон 4/ шинжлэх бясалгал хүртэл бий гэж үздэг

Урьд байсан бясалгалын их хөрөнгөн дээр түшиглэж нэгэн үзүүрт сэтгэл олсныг сэтгэлийн бясалгал хэмээнэ гэж *"Дундад хязгаарын тайлбар"-т* номносноор номнов. "Машид мятрах" гэдэг нь хэтэрхий суларсан бодол юм. "Машид ихээр урамшуулах" гэдэг нь хэт хянах явдал бөгөөд энэ хоёроос ангижран судлах хэрэгтэй гэсэн утга болно.



5

АМАРЛИНГУЙ СЭТГЭЛИЙГ БЯСАЛГАХ НЬ

(2) Түүнээ шүтэж оршсон сэтгэл төрөхийн эрэмбэ зэрэг
(а) Оршсон сэтгэл төрөх бодит эрэмбэ зэрэг
(б) Түүнийг зургаан хүчээр бүтээх ёсон
(в) Түүнээ дөрвөн сэтгэлд үйлдэгч байхын ёсон

в. Бясалгаж амарлингуй сэтгэлийг бүтээх хэмжээ
1) Амарлингуй сэтгэл бүтсэн ба бүтээгүй газрын хэмжээг үзүүлэх
а) Бодит утгыг үзүүлэх
б) Сэтгэлд үйлдэхүй төгөлдөр болсон шинж ба сэжгийг таслах
2) Амарлингуй сэтгэлд шүтэж мөрд зорчих ерөнхий ёсыг үзүүлэх

(2) Түүнээ шүтэж оршсон сэтгэл төрөхийн эрэмбэ зэрэгт гурав:
(а) Оршсон сэтгэл төрөх бодит эрэмбэ зэрэг
(б) Түүнийг зургаан хүчээр бүтээх ёсон
(в) Түүнээ дөрвөн сэтгэлд үйлдэгч байхын ёсон

---оОо---

(а) Оршсон сэтгэл төрөх бодит эрэмбэ зэрэг. Үүнд есөн зүйл бий.

1.*"Тэр хийгээд түүнээ сэтгэлээ агуулах"* нь гадна талын орон бүхнээс сэтгэлээ үнэхээр хурааж дотоод бодолдоо чиглүүлэх (тушаах) явдал болно. *"Судрын аймгийн чимэг"-ээс:* Бодолдоо сэтгэлээ чиглүүлж тушаагаад хэмээжээ.

2..*"Үргэлжид агуулах"* нь сэтгэл анхлан чиглэсэн зүйлээсээ өөр зүйл рүү алгасрахгүй байх ба тэр бодол дээрээ үргэлжид тогтох буюу. Түүний үргэлжлэлд алгасрахгүй байх хэмээжээ.

3..*"Барин авч агуулах" нь* умартаж алгасрах ба гадагш алгасарч байгааг мэдээд жич дахин бодолдоо хадах явдал мөн."Алгасарч буйгаа түргэн ухаараад Түүнийг жич дахин барьж үйлдэх" хэмээжээ.

4..*"Ойр агуулах"* нь, *"Бясалгалын анхны зэрэг"-ээс:* Өмнөх сэтгэлийн алгасралыг мэдэж тэвчих ба сэтгэлээр алгасрахыг тэвчиж тэрхүү бодолдоо шамдан агуулах хэмээсэн буй. *"Барамидын үвдис"-аас:* Сэтгэлийн дэлгэр

их мөн чанарыг дахин дахин хураангуйлж, нарийн болгоод улам нарийсган тогтоохыг айлдсан буюу. [“*Судрын аймгийн чимэг*”-ээс] Ухаантан дээш дээш нь сэтгэлээ дотогш хураан үйлдэх хэмээсэнтэй таарч байна. *“Сонсогчийн газар”-аас:*“Эхлээд дурдан санаж сэтгэлээ гадагш хөдөлгөхгүй байхыг номносон байна. Дурдан санах хүчээр умартах зэргээр гадагш алгасрахыг болиулдаг байна.

5.*“Номхотгон үйлдэх”* нь бясалгал дияаны тус эрдмийг санаж түүнийг бясалгах явдал болно. [*“Судрын аймгийн чимэг*”-ээс] “Чингээд тус эрдэмтэйг ухаарснаар,Бясалгал дияанаар сэтгэлээ номхотгох хэмээжээ. *“Сонсогчийн газар”-аас:* Дүрс тэргүүтэн таван орон, гурван хор, эр, эмийн шинж алин нэгнээ сэтгэл алгасардаг. Эхнээс л тэдгээрийн гэм буруутайд бариад тэдгээр арван зүйлд сэтгэлээ сарниулахыг зөвшөөрөхгүй байхыг номножээ

6.*“Амарлиулан үйлдэх”* нь алгасрах буруутай зүйл гэж үзээд, бясалгалд үл баясах явдлыг амарлиулах явдал билээ. [*“Судрын аймгийн чимэг*”-ээс] Алгасрахуйг гэмтэйд үзэх учир, Түүнээ үл баясахыг амарлиулан үйлдэх хэмээжээ. *“Сонсогчийн газар”-аас:* Хүсэлт орны асар атгаг тэргүүтэн асар атгаг сэжиг, хүсэлд дурлагч түйтгэр зэрэг шадар нисваанисаар сэтгэл хямардаг. Эхнээсээ тэдгээрийг гэмтэй гэж таниад, атгаг сэжиг, шадар нисваанис тэдгээрт сэтгэлээ сарниулахыг зөвшөөрөхгүй явдал гэж номножээ.

7.*“Тийн амарлиулан үйлдэх”* нь шунах тачаах, амгалангүй сэтгэл төрөх, балартах, нойр хүрэх байдал зэрэг гарваас түргэн амарлиулан үйлдэх мөн.

“Судрын аймгийн чимэг”-ээс: Шунах, зовинох зэрэг сэтгэлүүд, Сэргэвээс тэр даруй амарлиулж үйлдэх буюу хэмээжээ. *“Сонсогчийн газар”-аас:* Умартах төрж өмнө номносон асар атгаг, шадар нисваанис гарваас төрсөн бүгдийг зөнд нь тавилгүй тэвчих хэмээн номножээ.

8.*“Нэгэн үзүүрт үйлдэх”* нь ямарваа шамдлагагүйгээр орохын тухайд шамдах явдал болно. *“Судрын аймгийн чимэг”*-ээс: Чингээд боомтлон хичээх бээр, Сэтгэлд илт хуран үйлдэх зэргээр,Өөрөө өөрийн аясаар гарсныг олох хэмээжээ. *Мөн “Сонсогчийн газар”-аас: Шл*т хуран үйлдэх зэргээр тотгоргүй болох ба үргэлжид агуулан үйлдэнэ. Тиймд нэгэн дамжлагаар үйлдэж болно хэмээснээр мэдэж аваарай. Наймдугаар сэтгэлийн нэрийг “Нэг дамжлагад үйлдэгч “ гэсэн буй. Нэрнээс нь утгыг ухаарахад хялбар байна.

9.*“Тэгш агуулах”* нь Сэтгэл тэгширч тэгш агуулан үйлдэх мөн гэж “*Бясалгалын зэрэг*”-ээс айлдсан билээ. “Нэг дамжлагад үйлдэхүйг” дадуулсаар ая зөндөө өөрийн эрхээр орох ба өөрийн эрхтэй болчихсон байдаг гэж “Барамидын увдис“-аас айлджээ. Тийн болохыг *“Судрын аймгийн*

чимэг"-ээс: Түүнээ дадсан тул хуран үл үйлдэх хэмээжээ. *"Сонсогчийн газар"-аас*:

Бясалгалыг хуран үйлдэх хэмээн айлдсан тэр талаар дээрх шастараас: Үргэлжид шүтэж олонтаа дадаж сурахын учраар аяндаа бүтэж орох ба өөрийн аяаар орох мөрийг олно. Илт хуран үйлдэхийн хэрэггүй аяндаа орох түүгээр тэрхүү сэтгэл алгасралгүй бясалгалын үргэлжлэл болдог. Тийнхүү бясалгал хуран үйлдэх мөн хэмээн тодорхой айлджээ.

Есөн сэтгэлд нэр өгсөн талаар *"Бясалгалын эхний зэрэг"-ээс айлдахдаа:* Амарлингуй сэтгэлийн энэхүү мөрийг билиг барамидын судар тэргүүтнээс номносон буюу хэмээн татсан адилаар үйлдээрэй.

(б) Түүнийг зургаан хүчээр бүтээх ёсон

"Зургаан хүч" болвоос 1* *Сонсохын хүч*, 2* *Санааны хүч*, 3* *Дурдан санах хүч*, *4* Ухамсарлах хүч*, 5* *Хичээнгүйн хүч*, 6* *Огоот ижилсэх хүч* болой. Тэдгээр нь ямар сэтгэлийг бүтээх ёсны хувьд гэвэл,

1 Сонсохын хүчнээс* "агуулах сэтгэл" төрдөг. Сэтгэлээ сэтгэхүүн дээрээ агуулах увдисыг бусдаас сонсох төдийд даган барих ба анхандаа сэтгэхүүн бодолдоо чиглэх төдий байдаг. Учир нь өөрөө дахин дахин санаж, дадаж сураагүй үе байдаг.

2 Санааны хүчнээс* "үргэлжид агуулах сэтгэл" төрдөг. Анхалж бодолдоо чиглэсэн байдлаа үргэлжлүүлэн дахин дахин санаж суралцсанаар, үргэлжлэл өчүүхэн төдийд золгож чадах чадлыг эхлэн олж байгаа үе болой.

3 Дурдан санахын хүчээр* "барин агуулах сэтгэл" болоод "шадар агуулах хоёр сэтгэл" төрнө. Сэтгэхүүн бодолдоо алгасран алгасраваас өмнөх бодлоо санаж дотогш хураана. Эхнээсээ л санах хүчийг гаргаваас бодлоосоо алгасарах явдал гарахгүй болой.

4* *Ухамсарлах хүчээр* "номхотгох" болон "амарлиулан үйлдэх хоёр сэтгэл" төрнө. Атгаг сэжиг, шадар нисваанисын бэлгэст сарних явдлын гэмийг ухамсарлаж гэм бурууг үзэх тул тэр хоёрт сарних явдлыг гаргахгүй болно.

5 Хичээнгүйн хүчээр* "асар атгаг амарлих" ба "нэг үзүүрт үйлдэх хоёр сэтгэл" үүсдэг. Атгаг ажиг сэжиг болоод шадар нисваанис нарийн гарахад ч хичээнгүйлэн тэвчиж зөнд нь үл тавина. Тэр мэтээр үйлдсэнээр живэл, дошигрол зэрэг нь бясалгалд тотгорлож чадахаа больж, үргэлжид бясалгал дияан төрөх болдог.

6* *Огоот ижилсэх хүчээр* "тэгш агуулах сэтгэл" бүтдэг. Өмнөх явдалд ихэд дадаж ирсний хүчээр шамдлагагүй ая зөндөө бясалгал төрнө. Тэдгээр нь "Сонсогчийн газрын"-ын таалал дагуу мөн. Үүнээс өөрөөр номносон үзэгдэвч сэтгэл итгэж бүү үйлд.

Чингээд есөн сэтгэлийг олсон бол үлгэрлэвээс, гол ном судрыг уншиж ихэд дадаад ирэхээр анхны уншиюу гэх хотол өдөөлгө гарангуут л унших ба завсар зуурт сэтгэл алгасрах тохиовч амны уншлагаа таслалгүй шамдлага шаардлагагүйгээр унших адилаар, анхнаасаа сэтгэлээ бодолдоо хадах дурдан санах сэтгэлийг тэгш агуулж чадвал, санах, ухамсарлах нь үргэлж гарахгүй ч, тэрхүү бясалгалын үргэлжлэл тасрахгүй, өнө удаанаар оршиж чадах нэгэн төрнө.

Санах, ухамсарлахын үргэлжлэл төгс аваас ганц нэг шамдлага шүтэх шаардлагагүй тул илт хуран үйлдэх буюу хичээл шамдал шаардлагагүй хэмээн өгүүлсэн буй.

Түүнийг төрүүлэхэд эхлээд санах, ухамсарлах сэтгэлд хичээж нэгийг шүтэж живэл, дошигрол зэрэг үл зохилдох зүгүүдээс тотгорлож чадахгүй, урт хугацаа тасалгааг ээлсэн нэгэн бясалгалыг төрүүлэх хэрэгтэй. Тэр наймдугаар сэтгэл мөн. Энэ болоод есдүгээр сэтгэл хоёр нь живэл, дошигрол зэрэг бясалгал дияны үл зохилдох зүгүүдээр тотгорлогдож чадахгүй нь адилхан. Гэвч үүнд санах ухамсарлахыг завсаргүйгээр шүтэх хэрэгтэй тул хуран үйлдэх буюу шамдах хичээл сэлтэст хэмээн өгүүлжээ.

Түүнийг төрөхөд нарийн живэл, дошигрол тэргүүтнийг төрсөн даруйгаас ая зөнд нь тавилгүй хорих хэрэгтэй тул долдугаар сэтгэл шаардлагатай. Түүнийг төрөхөд атгаг, шадар нисваанисаар үл алгасрах, гэмтэйд мэдэж тэдгээрийг үргэлжлүүлэлгүй харуулдан манах, ухамсарын хүчийг төгсгөх хэрэгтэй тул тав, зургадугаар сэтгэл хэрэгтэй болно. Энэ хоёр сэтгэлийг ухамсарын хүч их болсноор бүтээдэг. Тэр адил нэг төрөвч, бодолдоо алгасраад байвал түргэн бодлоо санах, эхнээсээ сэтгэлээ бодлоосоо алгасруулахгүй үйлдэхийг санах хэрэгтэй тул гутгаар болон дөтгөөр хэрэгтэй болно. Энэ хоёрыг хоёр санахуйгаар бүтээдэг болно. Түүнийг төрөхөд эхлээд сэтгэлээ бодолдоо чиглүүлнэ. Чиглүүлсэн түүнийгээ үргэлжлүүлэх ба үл алгасруулах явдал хэрэгтэй тул эхний хоёр сэтгэл эхлээд төрөх болой.

Тэр мэтээр товчлон хураавaас, анхлан увдисыг сонсож даган барих ба сэтгэлээ тэгш агуулах ёсыг сайтар үйлд. Чингээд агуулсан түүнийгээ дахин дахин санан үргэлжлэлийг өчүүхэн төдийд ч залгуулан чадахын үүднээс үргэлжлүүлэн суралц. Цаашид дурдан санах доройтон алгасарвaас түргэн хурааж мартсан бодлоо түргэн санах ба цаашид санах сэтгэлээ улам

хүчтэй болгож, эхнээсээ бодлоосоо өөр зүйлд алгасрахгүй байх учиртайгаа санахын хүчийг үүсгэ.

Хүчтэй санахуйг бүтээх ба бодлоосоо өөр зүйлд алгасрах живэл, дошигрол зэргийн гэмийг мэдэх үүднээс харуулдан манах ухамсарыг хүчтэй үүсгэ. Мөн нарийн умартах сэтгэлээр алгасаравч тэр даруйд танин бариад үргэлжлэлийг таслах ба үл зохилдох зүгээр үл тогтворлогдох үргэлжлэлийг устгахаар хичээх хүчийг үүсгэ. Түүнийг төрүүлэхэд шамдан сурснаар бясалгал гүнзгийрч, шамдлагагүйгээр бясалгалд хүрэх есөн сэтгэл бүтэх мөн. Тиймд есдүгээр сэтгэлийг олохоос өмнө бүтээлчин бээр сэтгэлээ бясалгалд агуулах хичээлийг цаашид үйлдэх хэрэгтэй байдаг.

Есдүгээр сэтгэлийг олсны дараа тухайлан шамдах шаардлагагүйгээр сэтгэл бясалгалд хуйлран ордог болно. Энэ мэтээр эдгээр есөн сэтгэлийг оловч машид боловсролыг олоогүй бол дараа номнох мэт эдүгээ амарлингуйг олсон гэж үзэхгүй тул үлэмж үзэхүйг олсон гэж үзэхгүйг хэлээд яах вэ. Гэвч энэ адилын тодорхой амгалант, үл атгаглах зэргээр чимсэн бясалгал нэгийг олвоос тэгш агуулах болон даган олохтой ижилсэх, тийн үл атгаглах билиг билгүүн төрнө гэж үздэг.

Ялангуяа, "Сонсоод, сонсогчийн газар"-аас номносон мэт "Есдүгээр үүнээ ханьцашгүй егүзэрийн төгсгөлийн зэрэг огоот төгссөн гарна" хэмээн олонтаа номносон үзэгдэх тул үүнийг хожим номноно.

(в) Түүнээ дөрвөн сэтгэлд үйлдэгч байхын ёсон.

"Сонсогчийн газар"-аас:

Тэрхүү есөн оршсон сэтгэлд дөрвөн сэтгэлдээ үйлдэхүй (анхаарал) байдаг гэж мэдээрэй. (1) Хянан орох, (2) Завсарт тотгорлож орох, (3)Тухайн үест тотгоргүй орох, (4) Ая зөнд бүтээн (шамдалгүйгээр) орох эдгээр болой. Тэрхүү агуулан орох ба үнэхээр агуулан үйлдэх хоёрт "хянан орох сэтгэлд үйлдэхүй" байна. Хураангуйлан агуулан үйлдэх, ойр агуулан үйлдэх, номхотгон үйлдэх, амарлиулан үйлдэх, ойр амарлиулан үйлдэхэд зэрэгт (тавд) "завсарт тотгорлон орох сэтгэлдээ үйлдэхүй" байна. Нэгэн дамжлагаар үйлдэхүйд "үест тотгоргүй орох сэтгэлд үйлдэхүй" байна. Бясалгалд хуран үйлдэхүйд "шамдалгүйгээр орох сэтгэлд үйлдэхүй байна хэмээжээ.

Эхний хоёр сэтгэлийн үед шамдаж хянах хэрэгтэй тул "хянан орох" ба түүнээс тавдугаар сэтгэл хүртэлх үест живэл, дошигролоор тотгорлогдож тунгаа удаан барьж чадахгүй тул "завсарт тотгорлон орох" болох ба түүнээс наймдугаар сэтгэл хүртэл живэл, дошигролоор үл тотгорлогдох болсноор

удаан хугацаанд тунгаа барьж чадах үе тул “тотгоргүй орох” болдог байна.

Цаашид есдүгээр сэтгэл дээр саад тотгор арилж бас үргэлжид шамдахын шаардлагагүй болж “шамдлагагүй орох сэтгэлд үйлдэхүй” төрдөг болно. Гэвч нэг, хоёрдугаар сэтгэлийн үед саад тотгортой орох бий.

Асуулт: Завсарын таван сэтгэлийн үест ч хянах шаардлагатай байдаг тул анхдугаар, хоёрдугаар хоёрт “тотгортой орох сэтгэлд үйлдэхүй байна” гэж номноогүй болон завсрын тавд “хянан орох сэтгэлд үйлдэхүй” байхыг үл номносон нь юун бэ?

Хариулт: Эхний хоёр сэтгэлд сэтгэл бясалгалд одсон, эс одсон гэж хоёр буй. Хойдхи нь ихэд удаан буюу завсарын тав дээр бясалгалд орших их удаан тул хойдхид нь бясалгалын тотгорт гэдэг томъёог хэрэглээд өмнөхөд нь эс зохиосон болой.

Тиймд тэр хоёуланд нь хянан орох, гарах нь адил боловч завсарт тотгорлож орох, орохгүйн хувьд адилгүй тул хянан орох сэтгэлдээ үйлдэхүйг тавдугаар сэтгэлд тооцоогүй байна. Тийнхүү дээр номносон чуулганаа оршиж бясалгалыг бүтээхээр үргэлжид хичээнгүйг шүтвээс амарлингүй сэтгэл төрөх болно. Ганц хоёр төдийг оролдоод дахин ажлаа орхивол бүтэхгүй хэмээн айлджээ. *“Барамидын хураангуй”-аас*:

Үргэлжлэл үл тасрах егүзэр бээр
Дияаны бүтээхээр хичээсүгэй
Дахин дахин амраад байвал
Зуруулаас гал гарахгүй буюу

Бясалгалыг бүтээх ёсон дээр ч
Ахиц олох хүртэл орхиж бүү үйлд хэмээн айлджээ.

в. Амарлингуй сэтгэлийг бясалгаж бүтээх хэмжээнд гурав:

1) Амарлингүй сэтгэл бүтсэн ба бүтээгүй газрын хэмжээг үзүүлэх
2) Амарлингүй сэтгэлд шүтэж мөрд зорчих ерөнхий ёсыг үзүүлэх
3) Ялангуяа ертөнцийн мөрд зорчих ёсыг үзүүлэх

1) Амарлингүй сэтгэл бүтсэн ба бүтээгүйн газрын хэмжээг үзүүлэхэд хоёр:

а) Бодит утгыг үзүүлэх
б) Сэтгэлд үйлдэхүй төгөлдөр болсон шинж ба сэжгийг таслах

а) Бодит утгыг үзүүлэх.

Эргэлзээ: Өмнө номносон тэр мэтээр бясалгалыг судлах ёсыг сайтар мэдэж суралцсанаар есөн сэтгэл зэрэгчлэн төрөх бөгөөд есдүгээр сэтгэлийн үед нарийн живэл, доширголоос салж удаан хугацаанд тунгаа барьж чаддаг болно. Санах, ухамсарлах хоёрыг үргэлжид шүтэн, шамдлагад харгалзалгүй ая зөнд бүтээхийн бясалгалыг олсноор амарлингуй сэтгэлийг олсон болох уу, үгүй юу?

Хариулт: Номносу. Энэхүү бясалгалыг олоход "машид боловсрол"-ыг олсон ба олоогүй гэж хоёр янз бий. Хэрвээ машид боловсролыг эс олсон аваас амарлингуйтай зохилдонгүй нэгэн болохоос бус жинхэнэ амарлингуй болохгүй. Тиймээс даган зохилдсон сэтгэлд үйлдэхүй хэмээдэг. *"Тааллын тайлбар"-аас:*

Ялж төгөлдөр нөгчигсөн бодисадва хэзээ сэтгэлдээ бодсон бодлоо дотоод сэтгэлдээ үйлдсэнээр машид боловсрох ба машид боловсрол эс олохыг хүртэлх сэтгэлдээ үйлдсэн түүнийг юу гэх вэ? Майдар аа, Амарлингуй сэтгэл бус, харин амарлингуй сэтгэлтэй даган зохилдсон сүсэг төгөлдөр мөн хэмээн өгүүлж үйлдсүгэй хэмээн тодорхой айлджээ.

"Судрын аймгийн чимэг"-ээс:

Түүнийг дадуулж бясалгасаар
Улмаар түүний бие болон сэтгэлийн
Машид боловсрол агуу их нэгнийг олсноор
Сэтгэлд үйлдэхүй зэрэг болох хэмээн айлдсан буй.

"Сэтгэлд үйлдэхүй" нь энэ үест амарлингуй сэтгэлийг заасан ба "Сонсогчийн газар"-аас айлдсан зүйлийг сүүлд номноно.*"Бясалгалын дунд зэрэг"-ээс ч:*

Тийнхүү амарлингуйг бясалгах түүний бие, сэтгэл аль ч үед машид боловсрох бөгөөд хэрхэн хүссэнээр бодолдоо сэтгэлээ эрхшээж чадах тэр үест амарлингуй сэтгэл бүтнэ хэмээн мэдээрэй хэмээн сэтгэлээ сэтгэхүүн дээрээ тогтоох өөрийн эрхийг олох ба машид боловсрох хоёул хэрэгтэй гэж айлджээ.

Тиймд *"Бясалгалын анхдугаар зэрэг"-ээс:*

Алин тэрхүү бодолд илт хуран үйлдэхүй байхгүй ч, хэзээ хүссэн цагт сэтгэл орших болсон тэр цагт амарлингуй сэтгэл төгс болохыг мэдээрэй хэмээн айлджээ.

Гэсэн ч "машид боловсрол" байх ёстойг тооцсон хэрэг гэж "*Бясалгалын дунд зэрэг*"-ээс тодорхой айлдсан буй. Мөн "*Дундад хязгаар*"-аас тэвчих

ёстой найман хуран үйлдэхүйг номносноос тэгш агуулахуй нь тэрхүү есдүгээр сэтгэлтэй нэг үндэстэй учир тэр төдийгээр зогсохгүй түүнээс дээш машид боловсорсон байхыг зарлиглажээ. *"Барамидын үвдис"-аас ч:*

Ийнхүү бодисадва ганцаар аглагт суугаад хэрхэн санах ёстой утгаа сэтгэлдээ үйлдэнэ. Сэтгэлдээ өгүүлэхийг тэвчиж сэтгэлдээ үзэх ёстой тэр зүйлээ олонтаа сэтгэлдээ бодно. Хэдий бие, сэтгэлийн машид боловсрол төрөөгүй байх хүртэл амарлингуй сэтгэлтэй зохилдуу сэтгэлд үйлдэхүй төрдөг. Хэзээ (машид боловсрол) төрсөн тэр цагт амарлингуй сэтгэл ирэх болой" хэмээн маш тодорхой айлдсан байна.

Тэд бүгдээр *"Судрын аймгийн таалллын тайлбар"*-ын утгыг нотлон буулгажээ.

Асуулт: Чингэвээс "машид боловсрол" төрөхөөс өмнөх үеийн тэрхүү бясалгалууд алинд хураагдах вэ?"

Хариулт: "Тэрхүү бясалгалууд хүсэлт орны газарт хураагдах буюу гурван орны есөн газрын аль нэгнээ хураагдах бий. Харин анхдугаар дияаны орны "бэлтгэл"-ээс дээшихэд хураагдахгүй. "Бэлтгэл" олчихсон бол амарлингуй сэтгэлийг олох ёстой. Хүсэлт ертөнцөд тэр адилын бясалгал байвч тэгш агуулахгүй газар юм. Тэгш агуулахгүй гэдгийн учир нь гэмшил байхгүй, дээд баясгалант амгалан болон машид боловсрол зэргүүд төрөөгүй байдаг. Тэр талаар *"Газрын бодит суурь"-аас:*

Юуны тул зөвхөн түүнийг тэгш агуулах газар хэмээв, яагаад алин хүсэлт орны нэгэн үзүүрт нь бус болов хэмээсэнд, Энэ мэт бясалгал тэрээр гэмшилгүй, дээд бясалгалт, машид боловсорсон, амгалангаар илт бүтсэн байх хэрэгтэй. Хүсэлт ертөнцөд эдлэх тэрээр тийм бус. Гэхдээ хүсэлт ертөнцөд үнэмлэхүй номыг чухалчлан санах, бодох байхгүй гэсэн биш юм ээ хэмээн айлджээ.

Тиймээс машид боловсролыг олоогүй л бол, эндүүрэлгүй дурдан санахуйг шүтээгүй ч өөрийн хүчээр үл атгаглах сэтгэл рүү очдог. Одох, ирэх, хэвтэх, суухын явдал мөр бүгдээ "хэтрүүлсэн (чөтгөрийг дийлсэн) адилд үзэгдэх" бясалгалыг хүслийн нэгэн үзүүрт сэтгэл гэхээс, жинхэнэ амарлингуй сэтгэл гэж үзэж болохгүйг мэдээрэй.

Асуулт: "Чингэхэд хэрхэн "машид боловсрол"-ыг олох вэ? Түүнийг олсноор амарлингуй сэтгэлд одох ёс гэж юу вэ?

Хариулт: "Машид боловсрол" гэж юу болох талаар *"Хотол хураангуй-гаас:*

“Машид боловсрол юу вэ? Бие, сэтгэлийн муу авир ёсны үргэлжлэлийг таслахын тухайд бие, сэтгэлээ эдлэхүй дор болгон эзэмших явдал бөгөөд хамаг түйтгэрийг арилгах үйлт болой” хэмээн зарлигласан мэтээр ухаарай.

“Бие болоод сэтгэлийн муу авир” гэдэг нь бие, сэтгэлээр сайн үйлийг бүтээхээр хүссэн ёсоор (бие сэтгэлээ) эдэлж эзэмшиж чадахгүй байгаа ахуй байдал юм. Түүний ерөндөг болгож “бие, сэтгэлээ машид боловсруулах, судлах” гэдэг нь бие, сэтгэлийн хоёр муу авир заншлаас ангижирч, бие болоод сэтгэлээ буянт сайн үйл хэргийн төлөө зориулж эдлэгдэхүүн болгож сайтар эзэмших явдал болой.

Чингэхдээ нисваанисаа тэвчих баяр баясгаланд саад тотгор болох ба нисваанисын зүг болсон биеийн муу авирт нисваанисыг тэвчихээр шамдах үед бие хүндрэх зэрэг үл эдлэгдэх авир байдлаас ангижирч бие хөнгөрөөд ирэхээр “бие үйл дор эдлэхүүн” болно. Түүнчлэн нисваанисаа тэвчих баяр баясгаланд саад тотгор болох ба нисваанисын зүг болсон сэтгэлийн муу авир, нисваанисыг арилгахын тухайд хичээн чармайх үед буяны зоригдолд чиглэхэд баясал, хөөрөл төрдөггүй байдлаас ангижирч, саадгүйгээр сэтгэл зорьсон орондоо оршихыг “сэтгэлээ үйл дор эдлэхүүн болно” хэмээсэн буй. Энэ талаар *Лодон (Штирамати) багш бээр “Гучин шүлэгтийн тайлбар”-таа:*

Тийнхүү бие (эдлэгдэх) эдлэхүүн болоод ирэхээр биеийн өөрийн үйл дээрээ хөнгөн, түргэн алин нэгэн болно. Сэтгэл эдлэхүүн болно гэдэг үнэхээр сэтгэлдээ үйлдэхээр орших сэтгэлийн хөнгөн сэмбэгэр болохын уг үндэс болсон “сэтгэлээс гарсан номууд өөр болж өөрчлөгдөх” буюу. Тийнхүү төгөлдөр болоод ирэхээр сэтгэл зорисон орондоо торолтгүйгээр орох тул түүнийг “сэтгэл эдлэхүүн” болсон хэмээдэг болой гэж айлджээ.

Товчилвоос, машид боловсрол төрөөд ирэхээр нисваанисыг тэвчихээр хичээх хүсэл төрөх хэдий ч муу үйлнээ өөрийн зөнгөөр орох, ороход бэрхтэй хавчигдмал үзэгдэлд орох, бие, сэтгэлээ эдэлж үл чадах зэргээс буцаж, бие болоод сэтгэлээ машид сайтар эдэлж чадах амгалан төгөлдөр болдог. Тийнхүү бие болоод сэтгэлээ огоот төгс эдлэхүүн болгож чадсан бясалгал анх олдохдоо маш өчүүхэн нарийн хувьтай төрдөг ч түүнийгээ дээш дээш нэмж ахиулсаар байвал сүүлдээ машид боловсрон нэгэн үзүүрт амарлингуй сэтгэл төрж гарна. Анхандаа нарийн учраас мэдэхэд бэрхтэй байх ч хожмоо мэдэхэд улам хялбар болдог.*“Сонсогчийн газар”-аас:*

Зөвхөн эхний үед үнэмлэхүйн найрлагын мөрд хичээх цагт машид боловсорсон

сэтгэл, машид боловсорсон бие, бие сэтгэл эдлэхүүн болсон зэргүүд төрөхдөө маш нарийн бөгөөд шинжлэхэд бэрхтэй байдаг хэмээгээд, мөн Тийнхүү сэтгэл нэгэн үзүүрт болох ба машид боловсорсон бие, сэтгэл тэдгээр нь үнэхээр аривжих гэдэг энэ мэт буюу. Нэг үндэснээс нэг рүү дамжиж явсаар бүдүүн агаад шинжихэд хялбар нэгэн үзүүрт сэтгэлүүд болоод машид боловсорсон бие, сэтгэлүүд татагдан гарна хэмээн айлджээ..

Бэлэг чанар төгс төгөлдөр, шинжлэхэд хялбар, тэрхүү машид боловсорсон сэтгэл төрөх урьдчилсан шинж гэвэл бясалгал сурахаар хичээгч тэрхүү бодгалийн толгой хүндрэх мэтийн үзэгдэл тохиох бий. Гэхдээ энэ нь зовлонт хүндрэл биш ээ. Тэр төрсөн даруйд нисваанисыг тэвчихээр баясах сэтгэлийг тотгорлох сэтгэлийн муу орноос хагацах болно. Түүний өрөндөг болсон машид боловсрон сэтгэл өмнө нь төрөх бий. *"Сонсогчийн газар"-аас:*

Хэдий тэрхүү бүдүүн буюу шинжлэхэд хялбар нэгэн үзүүрт сэтгэл болоод машид боловсорсон сэтгэл, бие өнө удалгүй төрөхийн шинж болж толгой тархи хүндрэх үзэгдэл гардаг. Энэ нь хортой шинж чанар бишээ. Тэр төрсөн даруйд тэвчилд баясахуйг тотгорлох нисваанисын зүгт багтдаг сэтгэлийн аливаа муу авир тэдгээрүүд тэвчигдэнэ. Түүний өрөндөг болсон сэтгэлээ эдлэхүүн болгосон машид боловсорсон сэтгэл ч төрнө хэмээн айлджээ.

Цаашид сэтгэлээ эдлэхүүн болгосон машид боловсрол төрнө. Түүний хүчнээ шүтэж машид боловсорсон бие төрөхийн үндэс болсон хий биенээ гүйх болно. Тэрхүү хий нь биеийн хувь бүхэнд түгэж гүйснээр бие муу орноосоо хагацах бөгөөд биеийн муу орны өрөндөг машид боловсорсон бие төрнө. Чингэхдээ бүх биенээ дэлгэрч эдлэгдэхүүн болсон хийн хүчээр дүүрсэн мэт үзэгдэнэ.

"Сонсогчийн газар"-аас:

Тийнхүү төрснөөр машид боловсорсон бие төрөхтэй зохилдон хийн махбодь биенээ гүйнэ. Тэд гүйхийн үест тэвчилд баясахуйг таслах нисваанисын зүгт багтах биеийн муу авир алин бүгдээс хагацана. Түүний өрөндөг машид боловсорсон бие нь бүх биенээ дэлгэрэн дүүрсэн мэт үзэгдэх болой хэмээн зарлиглажээ.

Энэхүү машид боловсорсон бие гэдэг нь биеийн доторхи маш их таалалмжтай хүрэлцэхүй юм. Гэхдээ сэтгэлээс гарсан бус аа. *Лодон багш бээр:*

Бией хүрэлцэхүйн гайхамшигт таалалмжит баясалаар эзлэгдсэн машид боловсорсон хүрэлцэхүй буюу. Сэтгэлд баясалтай машид боловсорч бие болой

хэмээн судраас гарсан болой хэмээжээ.

Тийнхүү машид боловсорсон бие эхлэн төрөх цагт хийний хүчээр биенээ амгалант их амсуурга төрдөг. Түүний дараа анх төрсөн машид боловсролын хүч чадал зэрэгчлэн багасгах болно. Гэхдээ машид боловсрол барагдана гэсэн үг биш. Будүүхэн түүгээр сэтгэл хэтэрхий хөдөлдөг. Тэр байдлаас гарч сүүдэр адил нимгэрэх машид боловсрол, үл хөдлөх диянтай зохилдон төрдөг. Сэтгэлийн бясалгал замхран замхарах тэр байдлаас гарна. Цаашдаа сэтгэл бодолдоо баттай сууж их бясалгалд гэгэлзэх буюу үл амарлихаас хагацсан амарлингуйг олно. *"Сонсогчийн газар"-аас:*

Эхлээд төрөх тэр цагт сэтгэл баясах, сэтгэлд амгалан мэдрэгдэх, сэтгэл дээд баясгалан төгс байх зэргийг тухайлах, илт баясгалант болох зэргээр үзэгдэх ч бий. Түүний дараа машид боловсролын анх төрсөн хүч чадал тэр аажмаар машид нарийсч, машид боловсорсон биед сүүдэр мэт төгөлдөр дагах болно. Алин сэтгэлийн баясал тэр ч тэвчигдэх бөгөөд сэтгэл амарлингуйд бүр ойртон батжиж, машид амарлингуйн байдлаар бодолдоо орох болно хэмээн айлджээ.

Тэр мэтээр гарваас амарлингуйг олох буюу сэтгэлд үйлдэхүй сэлт хэмээнэ" гэж айлдсан мэт сэтгэлд үйлдэхүйг оллоо хэмээхийн тоонд багтана. Анхдугаар дияаны орны бэлтгэлд багтах амарлингуйг олсноор тэгш агуулахуйн газрын сэтгэлд үйлдэхүйгээс бага зэргийг олно. Энэ талаар *"Сонсогчийн газар"-аас:*

Түүний сүүлд үйлийг анхдагч егүзэр тэрээр сэтгэл үйлдэхүй сэлт болно. Сэтгэлд үйлдэхүйтийн тоонд багтана гэсэн үг. Юунд тийн хэмээвээс, тэрбээр анхлан Дүрст ертөнцөд эдлэх тэгш агуулах газрын сэтгэлд үйлдэхүйг бага зэрэг олдог учиртай. Тиймээс сэтгэлд үйлдэхүйт сэлтэст хэмээжээ гэжээ.

"Тэгш агуулах газар" гэдэг нь дээд хоёр орны нэр бөлгөө.

б) Сэтгэлд үйлдэхүйнүүд төгөлдөр болох шинж

"Алин лугаа төгөлдөр болвоос сэтгэл үйлдэхүйг олно" хэмээн өөр болоод бусдын мэдэж үйлдэх шинж тэмдэг юу нэгнийг олсон тэрбээр 1. Дүрст ертөнцөд хамаарах сэтгэлийг олох, бие машид боловсорох, сэтгэл машид боловсрох, сэтгэл нэгэн үзүүрт болох дөрвийн аль нэгийг олох 2. Будүүвтэр байдалт амарлингуй болон үнэн байдалт мөрийн зэргээр нисваанисыг сайтар арилгах хүч чадал төгс болох ба, 3. Сэтгэлээ дотроо тэгш агуулах бясалгаж маш түргэн хугацаанд бие сэтгэлийн боловсрол олох, 4. Хүсэлт

орноо шунах зэрэг таван түйтгэрээр эзлэгдэх, 5. Бясалгалаас босох цагт ч бие, сэтгэлийн машид боловсрол зарим нэгэн төгөлдөр байх зэрэг болой. Эдгээрийн талаар *"Сонсогчийн газар"-аас:*

Үйлийг анхдагч сэтгэлд үйлдэхүй сэлтийн шинж эдгээр буюу. Тэрбээр дүрстэд эдлэх сэтгэл бага зэргийг олох, бие машид боловсрох, сэтгэл машид боловсрох, нэгэн үзүүрт сэтгэл өчүүхнийг олох, нисваанисыг сайтар арилгах орныг олох хувь чадал байх, түүний сэтгэлийн үндэс зөөлрөх, амарлингуй лугаа ойртон татагдах хэмээжээ.

Мөн: Түүнийг дотроо үнэхээр агуулан суух, сэтгэлээ тушаан чиглүүлсэнээр түргэн түргэн бие сэтгэл машид боловсрох ба биеийн муу авираар машид үл хорлогдох болоод түйтгэрүүд ихдэж, гүйхээ болих" хэмээгээд "Босож гүйвч бие болоод сэтгэлийн машид боловсрол зарим нэгтэй төгс болох, тэр мэтээр зохилдох сэтгэлд үйлдэхүйт сэлтийн шинж тэмдэг огоот ариухан байхыг мэдээрэй хэмээжээ.

Тэр мэт тэдгээр шинж төгөлдөр сэтгэн үйлдэхүйг олвоос амарлингуй сэтгэлийн мөр огоот ариусахад илүү хялбар болдог. Энэ мэтээр нэгэн үзүүрт амарлингуйд тэгш агуулсны сүүлд түргэнээ бие, сэтгэлийг машид боловсрол татагдан гардаг тул машид боловсрол арвижин ирдэг. Хэдий чинээ машид боловсрол арвижих төдийгөөр нэгэн үзүүрт амарлингуй сэтгэл арвижих тул инагш чинагш нэг нэгнийгээ нэмэгдүүлдэг учиртай. Ийм болохыг *"Сонсогчийн газар"-аас:*

Хэрхэн бие болоод сэтгэлийн машид боловсрол нэмэгдэх тэр адилаар бодолдоо нэгэн үзүүрт шулуудах ямагт тийн нэмэгддэг. Хэрхэн нэгэн үзүүрт ямагт нэмэгдэх тэр адилаар бие болоод сэтгэлийг машид боловсрол ч тийн аривжина.Энэхүү хоёр зүйл адилаар нэгэн үзүүрт сэтгэл ба машид боловсрол тэдгээрүүд нэг нь нөгөөдөө шүтэх ба нэг нь нөгөөгөөс харгалзах мөн хэмээжээ.

Товчилвоос, сэтгэл үйлнээ эдлэгдэхүүн болоод ирэхэд хий нь сэтгэлд орших нэгэн болж хий эдлэгдэхэд хүрдэг. Тэр цагт биеийн машид боловсрол илүү ялгамжаат бясалгал дияан төрж, улмаар ялгамжаат эдлэгдэх хий бүгдээр машид боловсорсон бие, сэтгэлд татагдан ирнэ гэж дээр номносонтой адил болно.

*Сэжгийг арилгах нь: Эргэлзээ:*Тэр мэт санах, ухамсарлахаар үргэлжид хичээл шамдлыг эс үйлдэвч, сэтгэл бясалгал дияанд одох үл

атгаглах есөн сэтгэлийн үест номносон мэтээр нарийн дошигрол зэргийг хорисон тодорхой ир төгс байх дияан ба дээр машид боловсорсон бие, сэтгэлийн үед номносон мэтээр хийгээд эдлэхүүн болгосон хүчээр бие, сэтгэлийн гайхамшигт амгаланг төрүүлэх бясалгал дияанууд, мөн өмнө нь шинж тэмдгийн үест номносон мэтээр Хүслийн орноо дурлах зэрэг ойрын нисваанисууд ихэнхдээ гүйхээ болих ба тэгш агуулахаас босох цагт ч машид боловсролоос хагацалгүй байх төгөлдөр эрдэм зэргүүд төрөх бий. Тэдгээрүүд таван мөрийн алинд нь багтах вэ?

Хариулт: Энэ адилаар төрсөн бясалгал дияанууд нь ерөнхийдөө их хөлгөний мөрд багтана. Ялангуяа машид боловсрол төрөх, түүн лугээ даган зохилдох хийгээр хамаг бие амгалангаар дүүрэх мэт үзэгдэх, түүнээс улбаалан бие, сэтгэлд их амгалангийн мэдрэмж төрөх, үл атгаглаглагч, маш тодорхой, төгс ялгамжаа зэргийг үзвээс хагацашгүй егүзэрийн ёсны бэлэг чанар төгөлдөр төгсгөлийн зэргийн егүзэрт багтааж өмнө болоод эдүгээ ч авч үзсээр байгаа нь олонтаа үзэгдэнэ.

Гэвч Майдар, Асанга хутагт тэргүүтний их гол номнууд болон бясалгалын эрэмбэ зэргийг тодорхой номносон *"Төв үзлийн бясалгалын зэрэг"* тэргүүтэн дээдэс мэргэдийн ном шастарыг түшиж ажиглавал энэ адилын бясалгал дияаныг их хөлгөнд багтаах байтугай бага хөлгөнд ч багтааж болохгүй байна. Энэ талаар *"Сонсогчийн газар"-аас айлдахдаа:* "Анхдугаар дияаны орны "бодит суурийг" бүтээх бүдүүвтэр амарлингуйн байдалтай ертөнцийн зам мөрүүд ч энэхүү дияанд дулдуйдан бүтдэг" гэж үзжээ.

Тиймээс ертөнцийн мөрөөр явагч гадаадын (бурханы номын бус) арш нар болон ертөнцийн зам мөрөөр орж "Юу ч үгүй" хэмээх орноос доошхи доод ертөнцөд шунах шуналаас хагацан үйлдэгч нар ч түүнээ шүтэж дээшхи зам мөрөөр зорчих хэрэгтэй тул гадаад болон дотоод хоёулангийн нийтийн бясалгал дияан болдог. Чингэхдээ энэ үед "би-үгүй чанарыг зөв ухаарсан үзэл онол, хамаг орчлонгийн гэмийг сайтар мэдэж орчлонгоос сэтгэл гансарч нирвааныг чухалчлах магад гарах сэтгэлээр эзлэгдвээс их хөлгөний мөрд тооцогдоно. Их эрдэнийн бодь сэтгэлээр эзлэгдвээс их хөлгөний мөрд ч урваж болно. Үлгэрлэвээс, Адгуусанаа ганц атга гурил өгсөн өглөг болон ганц нэгхэн сахил зэргийг сүрэгнэх санаа бодлоор эзлэгдэх төдийгээр ч тонилохуй болоод хамгийг болгоогчийн мөрийн буян болдогтой адил буюу. Гэвч энэ үест ямар мөрөөр эзлэгдвээс нирваан болоод хамгийг болгоогчийн мөрд одох, эс одохыг шинжиж байгаа бус, тэрхүү бясалгал өөрийн мөн чанарын үүднээс аль мөрд багтах эсэхийг шинжилж байгаа билээ.

Төв үзэлтэн болоод сэтгэлийн төдийтэн нарын хувьд ч үлэмж үзэхүй ухааны үзэл онолын орныг хэрхэн авч үзэх тал дээр зөрөөтэй ч ерөнхий амарлингүй болон үлэмж үзэхүй хоёрын талаарх ойлголт, тэдгээрийн онол сэтгэлд төрөх ёсон дээр ерөнхийдээ таарахгүй зүйл байхгүй.

Тиймээс Асанга хутагт бээр *"Бодийн газар", "Нотлон буулгасан хураангуй", "Хотол хураангуй", "Сонсогчийн газар"* зэрэг бүтээлдээ амарлингүй, үлэмж үзэхүй хоёрыг тус тус бүтээнэ гэж авч үзсэний дотроос амарлангуйг бүтээхдээ есөн сэтгэлийн үүднээс бүтээнэ гэжээ. Тэр талаар "*Сонсогчийн газар*"-таа дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд тэдгээр бясалгалуудыг үлэмж үзэхүйг бүтээх ёс гэж үзээгүй бөгөөд тэдгээр ном шастаруудаа үлэмж үзэхүйг есөн сэтгэлээс ангид тусгайлан номножээ.

Түүнийг бүтээх ёсыг "*Сонсогчийн газар*"-таа ч тусгайд нь авч үзжээ. Мөн төв үзлийн "Бясалгалын зэрэг" болон "*Барамидын увдис*" зэрэгт ч есөн сэтгэлийг амарлингүйн мөр гээд үлэмж үзэхүйг тусгай мөр болгон айлдсан бий. Майдарын ном шастарт ч Асанга гэгээний тайлбараас ангид зүйлгүй учир "их тэрэгчин" бүгдээр энэ тал дээр нэгэн таалалтай болох нь харагдана.

Асуулт: "*Сонсогчийн газар*"-аас номносон түүнээ Амгалан болоод тодорхой байдал ирнэ" гэж болох ч, үл атгаглагч дээр гүн гүнзгий байхгүй тул амарлингүй төдий зүйл болно. Үл атгаглагч байх аваас хоосон чанарын бясалгал дияан болох уу?", "Гүн гүнзгий үл атгаглагч" гэдгийн гүн утга юу болохыг тус тус онох ухаанаар үзлийн "мухрыг тасалж шийдээд", цаашид түүний дээр үл атгаглан агуулах уу, эсвээс юуг ч үл атгаглах, үл шинжих төдийг үйлдэх үү?

Хариулт: Эхнийхээр гэж үзвэл, тэр адил түүнийг хоосон чанарын бясалгал гэж бид ч үзнэ. Та нар тийн үзвээс, мөн ёсны (хоосон чанарын) үзэл онолын ухаарал буй, үгүй хоёроо тус тус ялгана. Үзэл онолтой бодгаль байтугай үл атгаглахуйг судлагч нар ч гүн гүнзгий хоосон чанарыг бясалгах бий. Үзэл онолыг ухаараагүй бодгальс буюу юу ч бодоод хэрэггүй гэх бясалгагч нарын бясалгал нь гүн гүнзгий хоосон чанарын бясалгал биш хэмээн тус тус ялгаж хэлэх нь зохилтой.

Юуг ч бодохгүй санахгүй байх бясалгал бүхнийг зоригдолгүй, бэлгэсгүй, хоосон чанарын бясалгал болой хэмээн өгүүлж болохгүй. Хэдийгээр хоосон чанарыг оносон үзэл онол мөн, бишийг танихад хялбар ч сэтгэлдээ юу ч бодохгүй, юу ч сэжихгүй байх бясалгал бүхнийг хоосон чанарын бясалгал гэж үзвэл, өмнө "*Сонсогчийн газар*"-аас номносон тэдгээр амарлингүйн зүгийн

бясалгал бүхнийг бясалгалд тооцоогүй хирнээ хоосон чанарын бясалгалд тооцох хэрэгтэй болно.

Асуулт: Тэдгээрийг ч бясалгал гэж тооцох үест санах, ухамсарлахын хүч өчүүхэн байвч харуулдан манах зэргийн зарим нэг үестэй адилгүйгээр энэ нь энэ болой, энэ нь энэ бус болой гэх зэргээр өчүүхэн төдийд ч үл атгаглаж бясаогаж болох нь ээ.

Хариулт: Энэ тохиолдолд амарлингуйг бүтээх бясалгалууд үл атгаглах дүрс хөрөг зэргийг зоригдохуун болгож болно" гэж *"Тааллын тайлбар"-аас* айлджээ. *"Сонсогчийн газар"-аас ч:*

Тэрээр тэр цагт асар атгагүй тул дүрс хөргийг тухайлан бодож болно. Тэрээр тэр зоригдолдоо зөвхөн нэг талаас дурдан санах ба нэгэн үзүүрт сэтгэлээр агуулна. Тийн үзэж үл үйлдэх ба тийн ялгаж үл үйлдэх, машид сайн ялгаж үл үйлдэх, огоот оножм үл үйлдэх, огоот шинжиж үл үйлдэх болой хэмээн амарлингуй ба үлэмж хоёроос амарлингуй энэ мэтээр байхыг номножээ.

Мөн үүнээс: Тэр мэт амарлингуйн сэтгэлийг оловч, умартах, үл дадуулсны гэмээр бэлэг шинжийг асар атгаглах, ойрын нисваанис зэргээр үзэгдэх, үүдийг заах, зоригдлын орон болгох гэвэл тэр бүгд бидэнд энэ мэт байна. Тэдгээрийн гэм бурууг өмнө мэдсэн ч түүний эрхэнд орж дурдан санахгүй, сэтгэлдээ үйлдэх ч үгүй байна. Тэр мэтээр санахгүй, сэтгэлдээ үйлдэхгүй болсноор тэрхүү бодол эвдрэх бөгөөд намба байдал нь арилж, үзэгдэхгүй болж ойр шадар агуулагдах болно хэмээн айлджээ.

Амарлингуйг бүтээх үест ажиглаж судлалгүй зөвхөн агуулах (тогтоох) бясалгал байна гэж шалгадаг гол ном шастараас айлдсан тул юу ч үл онох бясалгал бүхнийг хоосон чанарын бясалгалд тооцвол мэргэдийн инээдэм наадмын орон болно шүү. Ялангуяа санах зүйлгүй, сэтгэлдээ бодох юмгүй байхыг л хоосон чанарын бясалгал хэмээн үзэгчдийг тэрхүү "*Сонсогчийн газар*" шастарт сайтар хориглосон болно. Мөн *"Бясалгалын эхний зэрэг"-ээс:*

Амарлингуйн мөн чанар нь нэг үзүүрт сэтгэлд багтах учиртай. Хамаг амарлингуй бүгдийн ерөнхий бэлэг чанар энэ бөлгөө хэмээжээ.

"Барамидын үвдис"-аас ч: "Элдвийн зүйлийг сэтгэлдээ зориулах болон сэтгэлээр өгүүлэхийг тэвчиж амарлингуй сэтгэлийг бясалгаж үйлд" хэмээсэн ба, "Сэтгэлээр өгүүлэх гэдэг нь энэ нь энэ болой хэмээн тийн атгаглах болой" хэмээжээ. Мөн дээр *"Чухаг дээдийн үүлэн судар"-аас:* "Амарлингуй

гэдэг нэгэн үзүүрт ямагт" болохыг номносон бөгөөд Их тэрэгчин нарын олон номноос эш татаж, "амарлингүй сэтгэл гэдэг юу ч үл атгаглах (онох) сэтгэл" хэмээн олонтаа номножээ.

Тиймээс хоосон чанарыг бясалгаж үл атгаглах нэгэн болон хоосон чанарыг өчүүхэн төдийд ч үл онож үл атгаглах гэж хоёр зүйл буй тул амгалант, тодорхой, үл атгаглан гарсан бүгдийг хоосон чанарын бясалгал гэж бүү бариарай. Тиймээс тэдгээр нь нэг талыг гаргаж үзүүлсэн болно. Сайтар хичээж Майдар, Асанга тэргүүтний тайлбарласан амарлингүй болоод үлэмж үзэхүйг бүтээх ёсыг ухаарч мэдээрэй.

Эс чингэвээс амарлингүй бясалгалд ч хэрэггүй, үл атгаглан агуулах зарим нэгэн бясалгалыг орчлонгийн язгуурыг таслах үлэмж үзэхүй мөн хэмээн эндүүрч түүнийгээ ч ухааралгүй, хөөрч догдлон цагаа нөгчөөснөөр өвөр, бусдыг хуурах нь дамжигтүй. Мэргэн бүтээлчин нарын гол ном шастарт заахдаа, шинээр амарлингүй сэтгэлийг бүтээхдээ зөвхөн үл атгаглаж агуулан бясалгахыг болон анхлан үлэмж үзэхүйг бүтээхдээ тус тус атгаглах билгээр тус тус ялган шинжилж бясалгахыг зарлигласан байна.

Хамаг атгагийг "үнэнд баригч" гэж үзээд тэр бүгдийг орхивоос шалгадаг гол номноос чанх буруудаж "би-үгүйн" эндүүрэггүй үзлийг эс олох буюу. Юу ч үл атгаглах явдлыг үлэмж үзэхүйн гүн үзэл бясалгал гэж үздэг хятадын хамба Хуушааны ёс гэгч бусадтай таарахгүй нэгэн үзэгдэнэ. *"Бясалгалын гурван зэрэг"*-ээс нягтлан үзэж мэдэж аваарай.

2) Амарлингүй сэтгэлд шүтэж мөрд зорчих ерөнхий ёсыг үзүүлэх

Асуулт: Дээр номносон мэтээр үл атгаглах бясалгал болон сэтгэлдээ үйлдэхүйг олсноор тодорхой, үл атгаглах зэргийн ялгамжаат үл атгаглах бясалгалаар тэр төдийг арилгах уу?

Хариулт: Энэ адилын бясалгалыг үндсэнд төрүүлэх нь нисваанисыг дарах үлэмж үзэхүйг төрүүлэхийн тухайд билээ. Түүнээ шүтэж үлэмж үзэхүй эс төрвөөс, бясалгалд түүнээ хичнээн шамдавч Хүсэлт орны нисваанисыг ч тэвчиж чадахгүй тул нисваанис бүгдийг тэвчиж чадахгүйг хэлээд яах. Тиймээс үлэмж үзэхүйг бясалгах хэрэгтэй.

Ил нисваанисыг тэвчиж ертөнцийн мөрд зорчих үлэмж үзэхүй болон нисваанисын хөрөнгө язгуурыг тэвчиж ертөнцөөс нөгчигсөн мөрд зорчих үлэмж үзэхүй хоёроос өөр дээд мөрд зорчих арга байхгүй билээ. *"Сонсогчийн газар"-аас:*

Сэтгэлдээ үйлдэхүйг олсон егүзэр бээр тэвчихээр өчүүхэн баясалтай орших ба урьд нь өөрөөр зорчих зам байхгүй буюу. Зөвхөн хоёр зүйлд багтана. Хоёр зүйл алин хэмээвээс, энэ адил буюу. Ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөн болой хэмээжээ.

Тийнхүү амарлингуй болон сэтгэлд үйлдэхүйг олсон тэрбээр ертөнцийн мөрийн үлэмж үзэхүй болон ертөнцөөс нөгчигсөн мөрөөр одох үлэмж үзэхүй хоёрын аль нэгнийг бясалгах буюу. Түүнийг бясалгахыг хүсэгч бээр өмнө нь олсон амарлингуй сэтгэлээ олонтаа бясалган үйлдэнэ. Чингэж бясалгаснаар машид боловсрол болон нэг үзүүрт сэтгэл тэдгээр машид нэмэгдэж амарлингуй сэтгэл ч маш баттай болдог. Мөн амарлингуй ба үлэмжийн шинж тэмдэгт ч мэргэжих хэрэгтэй. Түүний дараагаар хоёр мөрийн алин нэгнээ зорчихоор зорьж хичээх талаар *"Сонсогчийн газар"-аас айлдахдаа:*

Сэтгэлдээ үйлдэхүйг олсон үйлийг анхдагч егүзэр тэрээр, би ертөнц болон ертөнцөөс гэтлэх мөрөөр зорчисугай хэмээн олонтаа сэтгэлдээ үйлдээрэй. Хэрхэн яаж олонтаа үйлдэж, тэр мэтээр өдөр, шөнөд болоод түүнээс цаашлан одуулваас машид боловсрол болоод нэгэн үзүүрт сэтгэл тэр бүгд арвижин дэлгэрч агуу уужим болно. Алин ч үед түүнийг сэтгэлдээ үйлдэх буюу чангатган чийрэг бат болгож огоот ариуссан бодолд сүсэглэн ороод амарлингуй болсон үлэмж үзэхүйн зүгийн шинж тэмдгийг ч гүйцэд барих тэр цагт түүнд ертөнцийн мөр эсвэл ертөнцөөс нөгчигсөний мөрийн алин нэгээр зорчихын хүсэл төрж, түүндээ бэлтгэн хичээх болой хэмээн айлджээ.

Түүнээс ертөнцийн үлэмж үзэхүй нь доод газарт бүдүүн бөгөөд дээд газарт нарийнд тооцогдох бүдүүвтэр амарлингуйн бясалгал болой. Ертөнцөөс нөгчигсөн үлэмж үзэхүйн талаар "*Сонсгчийн газар*"-аас айлдсан дөрвөн үнэний ялгамжаа болох мөнх бус тэргүүтэн арван зургаан зүйлийг бодох бясалгал мөн. Гол нь "бодгалийн би-үгүй"-г онох үзэл болой.

Асуулт: Чингэвээс дээр номносон амарлингуйг сэтгэлдээ үйлдэхүйг олох цагт ертөнцөөс нөгчигсөн мөрөөр үл одож, ертөнцийн мөрөөр одох бодгаль ямар байх вэ?

Хариулт: Энэ талаар *"Сонсогчийн газар"-аас:*

Алин энэ насандаа зөвхөн ертөнцийн замаар одох буюу ертөнцөөс нөгчигсөн замаар явахгүй бодгаль хэд байна гэхэд өгүүлрүүн: Дөрөв энэ мэт буюу. Үүнд

гадаадын тэрсүүд бүгд орох ба, энэ номын ёсных мөн боловч урьд амарлингуй явдлыг эдлэгч байгаагүй мохоо ухаант нар, тэрчлэн хурц ухаантай ч буяны үндэс огоот боловсроогүй нар, энэ насандаа бус хойд насандаа бодь хутаг олно гэх бодисадва нар хэмээн айлдсан мэт болой.

Тэрсүүдийн егүзэр буюу дээр номносон амарлингуйг ологч бүгдээр бодгалийн "би-үгүй"-г тус тус онох ухаанаар шинжилж судлаагүй билээ. Учир нь тэд нар "би-үгүй" чанарт үл сүслэгч билээ. Тиймээс амарлингуй, үл атгаглах тэр төдийхнийг үйлдсэн ба бүдүүхэн байдалт үлэмж үзэхүйг бясалгах төдийг үйлдэх тул зөвхөн ертөнцийн мөрөөр зорчих болой. Энэ номт нар нь бурханы номт мөн боловч өмнө нь амарлингуйн агуулах бясалгал төдийхэнд ихэд дадсандаа дулдуйдаж мохоо ухаантан голдуу байдаг. Тиймээс тус тус онох ухаанаар хоосон чанарын утгыг шинжлэх бясалгалд үл баясах ба, баясавч "би-үгүй"-н утгыг ухаарч үл чадах тул энэ насна зөвхөн ертөнцийн мөрөөр одох мөн. Мөн орших хувь тэр төдийг бясалгаж үйлдэнэ. Мөн бүдүүхэн байдалтай үлэмж үзэхүй төдийхнийг бясалгана.

Дотоод бурхан шашинтан буюу хурц ухаантан нар "би-үгүй" чанарын утгыг ухаарах, үнэнийг илт онох буяны ёзоор боловсроогүй болохоор энэ насна ертөнцөөс нөгчигсөн цувиралтгүй хутагтын мөрд түргэн орж чадахгүй тул зөвхөн ертөнцийн мөрөөр одох хэмээснээс бус, "би-үгүй" буюу хоосон чанарыг тухайлах үлэмж үзэхүйн ухааныг бясалгаж чадахгүй гэсэн үг бус болой.

Нэг төрлийн дараа бурхан болох бодисадва нар ч сүүлчийн төрөл буюу хойд төрөлдөө найруулгын мөрөөс аваад дөрвөн мөрийг үндсэндээ төрүүлнэ. Нэг төрөл дээрээ хутагтын мөрийг төрүүлж чадахгүй учир тэр төрөлдөө ертөнцийн мөрөөр одно хэмээснээс бус, "би-үгүйн" утгыг онохгүй гэсэн бус аа. Энэ талаар *"Абхидхарма"-гаас:*

Бурхад болоод өөрөө ялгуухийн хутгийн
Дияаны эцсийн шүтээн нэг тул
Бүгдийн өмнө тонилохуйн хувь зохилдох

хэмээсэнтэй зохилдох бага хөлгөний бурхан болох ёс болохоос Асанга гэгээний өөрийн таалал бус болой.

Тиймээс тэрсүүд нар бүдүүн амарлингуйн байдалт мөрийг бясалгаж ил нисваанисыг тэвчих ба дотоод бурханы номт нар "би-үгүй"-н утгыг бясалгаж нисваанисыг язгуураас нь тэвчих алин боловч эхлээд өмнө нь номносон

амарлингуй дияаныг заавал олох хэрэгтэй. Дээр номносон амарлингуй тэр нь гадаад, дотоод хоёр егүзэр нарын нисваанисаа тэвчихийн суурь болох учиртай.

Түүгээр барахгүй их, бага хөлгөний егүзэр алин ч байсан энэхүү бясалгалыг бүтээх хэрэгтэй. Их хөлгөнийхэн буюу судар тарнийн бүтээлчин нар ч амарлингуй сэтгэлийг бүтээх хэрэгтэй тул амарлингуй сэтгэл нь бүтээлчин бүгдийн мөрд зорчих маш чухал үндэс болой. Тарнийн гол номноос номносон амарлингуй сэтгэлээр ч бурханы лагшинг тухайлан бодох юм уу, мутрын тэмдэг, үсэг зэргийг бодож бясалгах зэргээр бодлын орны ялгамжаа болон зарим аргын хувьд ялгаатайгаас бусдаар дияан бясалгалыг гэм болсон залхуу тэргүүтэн таван зүйлийг тэвчих, тэдгээрийн өрөндөг болсон санах, ухамсарлах зэргийг шүтэх ёс, цаашлаад есөн сэтгэлийг олох, тэдгээрээс машид боловсрол тэргүүтэн бүгдээр нийтийн мөр мөн тул энэхүү бясалгал машид агуу их болой.

Үүнийг болгоон *"Судрын аймгийн тааллын тайлбар"-т:* "Их, бага хөлгөний бясалгал дияан бүгд амарлингуй болоод үлэмж үзэхүй хоёрт хураагдана" хэмээн айлдсан тул бясалгалд мэргэн болохыг хүсвээс амарлингуй болон үлэмж үзэхүй хоёрт мэргэн болоорой.

Энэ адилын бясалгалд амарлингуй сэтгэл, сэтгэлд үйлдэхүйг төрүүлэх зэрэг олон хэрэгтэй ч гол хэрэг нь үлэмж үзэхүйг онохын тухайд болой. Үлэмж үзэхүйн хувьд ч ил нисваанис төдийг тэвчсэн бүдүүн байдалт гадаадын болон нийтийн дотоод гэж бий. Дотоодын дотор их, бага хөлгөн нийтийн үлэмж үзэхүй болон нисваанисын хөрөнгийг дахин гарахгүй болтол ашид тэвчсэн, "би-үгүй" хоосон чанарын байдалт, зөвхөн дотоод бурханы номны онцлогт үлэмж үзэхүй гэж хоёр буй.

Тэр хоёроос эхнийх нь хотол чуулсан гишүүн болж арай чадаагүй байдаг харин удаах нь бүрэн бүрдсэн гишүүн болдог. Тийм учраас нирваныг чухалчлагч бээр "би-үгүй" хоосон чанарыг онох үлэмж үзэхүйг төрүүлж үйлдээрэй.

Энэ талаар өмнө нь номносон мэт анхдугаар дияаны орны бэлтгэлд багтах амарлингуйг олсон бол түүнээс дээшхи дияан буюу Дүрсгүй орны амарлингуйг олж чадаагүй ч түүнээ түшиж үлэмж үзэхүйг бясалгаснаар орчлонгийн хамаг хүлээснээс гэтэлсэн нирваанд хүрч чадна.

"Би-үгүй" хоосон чанарыг үл оножс, үл бясалгаваас, хэдийгээр дээр номносон амарлингуй сэтгэлд түшиж ертөнцийн үлэмж үзэхүйгээр "Юу ч үгүй" хэмээх орноос доошхи илт болсон нисваанисыг тэвчих ба "Сансрын үзүүр"

хэмээх орны бясалгалыг олох боловч зовлонгоос гэтэлж чадахгүйд хүрдэг. Энэ талаар *"Магтваас зохист магтаал буюу хариуг үл гуйгч""- аас:*

Таны номд үл зүглэгч
Мунхагаар хөвхөлзөх төрөлхтөн бээр
Сансрын үзүүрт хүрсэн ч
Дахин зовлон үүдэж орчлонд төрөх

Таны номыг даган одогсод
Бясалгал ба бодит суурийг эс оловч
Шумнасын нүдийг бүлтийлгэж
Орчлон бүхнийг буцааж чадна хэмээн айлджээ.

Тиймээс "үргэлжид орогч", "жич ирэгч" бүгдийн хутагтын мөрийг олох үлэмж үзэхүйн шүтээн бологч амарлингүй сэтгэл гэдэг өмнө нь номносон амарлингүй нь анхдугаар дияаны орны бэлтгэлд багтах тэр мөн болно. Мөн нэг зэрэг Дайснаа дарагч нар бүгдээр дээр номносон амарлангүйг түшин байж зөвхөн үлэмж үзэхүйг бясалгаснаар дайснаа дарсны үрийг олох жамтайг мэдээрэй.

Дээр номносон амарлингүй сэтгэлийн бясалгалыг сэтгэлдээ өмнө нь эс олвоос янагуух болоод үнэмлэхүйг тухайлсан бодит үлэмж үзэхүй төрөх боломжгүйг дараа номнох болно. Тиймд ханьцашгүй ёсны егүзэр нар ч янагуухид тухайлсан бүдүүн байдалт үлэмж үзэхүй болон түүнийг бүтээх амарлингүйг эс бүтээвч заавал ямар нэг амарлангүй сэтгэлийг бүтээсэн байх шаардлагатай.

Иймээс эхлээд төрөх хэмжээний хувьд энэ нь эгүүсгэхийн зэрэг болон төгсөхийн зэрэг хоёрын эхний үе шатанд төрдөг. Товчлон хураангуйлваас, өмнө нь ямар нэг амарлингүй сэтгэлийг төрүүлж түүнээ шүтэж бүдүүн байдалт үлэмж үзэхүйгээр "Сансрын үзүүр" хүртэлх мөрд зэрэгчлэн зорчино. "Би-үгүй" хоосон чанарын байдалт үлэмж үзэхүйг бясалган нирваан хутаг болоод хамгийг айлдагчийн таван мөрд зорчих хэрэгтэй гэдэг бурханы номны нийтийн тамга болсон тул бүтээлчин хэн ч үүнийг зөрчиж болохгүй биз ээ хэмээн амарлингүй сэтгэлд шүтэн байж дээш дээш мөрд зорчих ерөнхий ёсыг үзүүлсэн болой.

6

АМАРЛИНГУЙ НЬ БОДЬ МӨРИЙН ГИШҮҮН БОЛОХ НЬ

3) Ялангуяа ертөнцийн мөрд зорчих ёсыг үзүүлэх

а) Бүдүүн, нарийн байдалт мөрд зорчихын өмнө амарлангуй сэтгэлийг олсон байх ёстойг үзүүлэх

б) Амарлингуй сэтгэлд шүтэж хүсэл шуналаас ангижрах ёсон

3) Ялангуяа ертөнцийн мөрд зорчих ёсыг үзүүлэхэд хоёр зүйл:

а) Бүдүүн, нарийн байдалт мөрд зорчихын өмнө амарлангуй сэтгэлийг олсон байх ёстойг үзүүлэх

б) Амарлингуй сэтгэлд шүтэж хүсэл шуналаас ангижрах ёсон

---оОо---

а) Бүдүүн, нарийн байдалт мөрд зорчихын өмнө амарлангуй сэтгэлийг олсон байх ёстойг үзүүлэх. Бэлэг чанарыг тус тус мэдэх үүднээс бүдүүн байдалт мөрийг бясалгахад өмнө заавал дээр номносон амарлангуй сэтгэл түүнийг олсон байх шаардлагатай. "*Судрын аймгийн чимэг"-ээс:*

Түүгээр түүнийг барилдуулан үйлдээд
Өнөд аривжуулан одуулснаар
Бодит суурийн орныг магад олюу

хэмээн урьд номносон есөн сэтгэл, машид боловсрол зэргийг олсноор, тэрхүү бясалгалаа аривжуулах зэргээс шалтгаалан бодит суурь бүтээхийг зарлигласан буй. Есөн сэтгэлээс эхлээд сэтгэлдээ үйлдэхүйг эс олох хүртэлхийг сэтгэлдээ үйлдэхүйн үйлийн анхдагч болдог. Сэтгэлдээ үйлдэхүйг олоод нисванисаа арилгахаар бэлэг чанарыг тус тус онох сэтгэлдээ үйлдэхүйг бясалгахуйг нисванисаа тийн арилгагч үйлийн анхдагч гэж зарлиглажээ. Иймд бэлэг чанарыг тус тус мэдэхээр бясалгахад өмнө нь сэтгэлдээ үйлдэхүйг олох мөн. *"Сонсогчийн газар"-аас:*

Тэрхүү сэтгэлдээ үйлдэгчийн үйлдийг анхдагч нь нэгэн үзүүрт үйлдэвч хэзээд сэтгэлдээ үйлдэхүйг олоогүй байдаг. Нэгэн үзүүрт болоогүй цагт үйлийг анхдагч байна. Тэрхүү нисваанисыг тийн арилгах үйлийн анхдагч нь сэтгэлд үйлдээгүй

ч олчихсон, нисваанисаас сэтгэлдээ ариусгахаар хүссэн, бэлэг чанарыг тус тус мэдэх, сэтгэлдээ үйлдэх тэдгээрийг туурвиж, авч бясалгасан тэдгээр мөн бөгөөд хэмээн айлджээ.

Мөн егүзэрийн дөтгөөр орны газар ч сэтгэлдээ үйлдэхүйг олоод ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөн мөрийг бясалгана гэж айлджээ. Өмнө өгүүлсэн амарлангуй сэтгэлийг өмнө нь бүтээнэ. Чингээд ертөнц болоод ертөнцөөс нөгчигсөн үлэмж үзэхүйг бүтээх нисванисын тэвчих ёсыг маш дэлгэрэнгүй энэхүү номносон Абхидарма судласан мэргэд дээдэс нар ч нэгэн үзүүрт амарлангуй сэтгэл өмнө бүтэх, дараа түүнээ шүтэн нисваанисыг тэвчих ёстойг тодорхой ялгаж гаргаагүй үзэгдэнэ.

Тиймд "*Сонсогчийн газар*"-аас номносон түүнийг сайтар эс магадлаваас 1/ Дияаны болоод Дүрсгүй орчны мөрийн доод хэсгийг анхдугаар дияаны бэлтгэл мөн гэх, 2/ түүний сэтгэлд үйлдэхүй зургаа гэж номносон эхнийхийг нь бэлэг чанарыг тус тус мэдэгч гэх, 3/ бэлтгэл хураагдсан сэтгэл эхлэн төрөхийг бэлэг чанарын тус тус мэдэгч болой хэмээх эндүүрэлүүд төрдөг. Ингэж бодвол ерөөс таарахгүй. Учир нь амарлингуй сэтгэл олоогүй байхад дияаны анхдугаар орны бэлтгэл төрдөггүй. Тэр бэлгэдэлийг олоогүй бол амарлангуй сэтгэл төрөхгүй. Бэлэг чанарыг тус тус мэдэх гэдэг нь шинжлэх бясалгал байдаг учир түүнийг бясалгаснаар өмнө нь олоогүй амарлангуй сэтгэлийг шинээр бүтээж чадахгүй болно.

Дээр *"Газрын бодит суурь"-т эш татсанаар* Хүсэлт ертөнцийн нэгэн үзүүртэд машид боловсрол байхгүй ч, машид боловсрол олоогүй байхад амарлангуй сэтгэл төрөхгүй гэж "*Тааллын тайлбар*" тэргүүтнээс айлдсан бий. Тиймд анхдугаар бэлтгэлийг үл олвоос амарлангуй сэтгэлийг олохгүй гэсэн үг. Чингэхээр анхдугаар бэлтгэлд хураагдах үлэмж үзэхүйг бясалгах үүд болно. Анхдугаар бэлтгэл төдий нь эхлэл бус. Түүний өмнө бэлтгэлд хураагдсан амарлингуй сэтгэл төрсөн байх хэрэгтэй. Анхдугаар бэлтгэлд хураагдах дияаныг олохоос өмнөх дияан бүгдээр зөвхөн хүсэлт орны нэгэн үзүүрт сэтгэл болдог. Тиймд их үндсэн номноос айлдсан дагуу үзвээс үлэмж үзээгүй байтугай амарлангуй сэтгэл олох нь маш цөөн үзэгдэнэ.

б) Амарлингуй сэтгэлд шүтэж хүсэл шуналаас ангижрах ёсон

Дээр номносон тунгалаг тодорхой, үл атгаглах зэрэг олон ялгамжаатай амарлингуйн сэтгэл нэгнийг бясалгахдаа хоёр үлэмж үзэхүйг алиныг ч үл бясалгаваас хүсэлт орны ил нисваанис ганц нэг төдийг ч арилгаж чадахгүй тул нисваанисын хөрөнгө болон мэдэгдэхүүний түйтгэрийг тэвчиж үл

чадахыг хэлэх хэрэг юун.Тиймд хүсэл шуналыг тэвчих анхдугаар дияаны орныг олохыг хүсвээс л амарлингуй түүнээ шүтсэн үлэмж үзэхүй ухааныг бясалгаарай.

Эргэлзээ: Гэвч "Дээр амарлингуй төдийг бясалгаж сурснаар ил нисваанисын толгойг дарна гэж номлосонтой харшлахгүй юу?

Хариулт: "Харшлахгүй. Дээрх нь ертөнцийн үлэмж үзэхүйг амарлингуй сэтгэлийн дотор багтааж өгүүлсэн хэрэг. Энэ үест хоёр үлэмж үзэхүйн өмнө одох учиртай анхдугаар орны бэлтгэлд багтах амарлингуй сэтгэлийн эрхээр хураав.

Шуналаас хагацахуйг бүтээх үлэмж үзэхүйд үнэний байдлыг болон бүдүүн байдалт гэж хоёр янзаар шуналаас хагацах ёсон буй. Энэ үест сүүлийн байдлаар шуналаас хагацах ёсыг заана.

Ертөнцөд "би-үгүй" үзэл өчүүхэн ч байхгүй гадаад номтон (тэрсүүд) болоод "би-үгүй" үзэл төгөлдөр энэ номынхон гэж хоёр буй. Чухам ямар мөрийг бясалгаснаар нисваанисыг тэвчих талаар *"Сонсогчийн газар"-аас:*

Хүсэлт орны шуналаас хагацахын тухайд машид хичээгч диянч бээр долоон зүйлийг сэтгэлдээ үйлдэхгүйгээр шуналаас хагацахуйд даган олох болой. Тэдгээр долоо юу вэ? Өгүүлрүүн, (1) бэлэг чанарыг тус тус мэдэх, (2) сүслэн гарах, (3) аглагт сайтар орших, (4) баясгаланг хураах, (5) шинжлэлийг сэтгэлдээ үйлдэх, (6) барилдлагыг эцэст нь хүргэх, (7) түүний үрийг сэтгэлдээ үйлдэх болой хэмээсэн мэт болой.

Түүний сүүлчийнх нь хүсэлд шуналаас хагацаж бодит суурьнаа орших үеийн сэтгэлд үйлдэх мөн бүтээгдэхүүн орон болдог. Түрүүчийн зургаа нь бүтээгчид болно.

Асуулт: "Би-үгүйн"- утгыг бясалгаад нисваанисыг тэвчиж эс чадваас юуг нотлон буулгаж утгыг бясалгаснаар нисваанисыг тэвчих вэ?

Хариулт: Ийм мөрөөр хүсэлт орны ил нисваанис бас бусыг тэвчиж болом за. Гэхдээ "хүсэл шуналаас хагацах" хэмээсэн тул гол нь хүсэл шуналын ерөндөг болгох үүднээс тэвчих шаардлагатай. Хүсэл шунал гэдэг энэ үест хүслийн таван эрдэмд шунаж тачаах мөн тул түүний ерөндөг болгож олон талаас нь хүслийн эрдмийг гэмтэй гэж үзээд тэрхүү шунал тачаалын баригдахуун орныг няцаахын үүднээс бясалгаж үйлдсээр хүсэл шуналаас ангижирна. Хэдийгээр хүслийн гэм болоод анхдугаар дияаны эрдмийг эндүүрэлгүй тус тус онох буюу бэлэг чанарыг тус тус онох магадлал баттай байвч өмнө нь амарлингуй сэтгэл төрөөгүй байвал гэм, эрдэм тэр хоёрыг шинжилж хичнээн бясалгасан ч нисваанисыг тэвчиж үл чадна. Мөн

амарлингуйг бүтээсэн ч тус тус шинжлэн эс үйлдвээс хичнээн бясалгавч нисваанисыг тэвчин үл чадах тул амарлингуй болон үлэмж хоёуланг бясалгахын үүднээс тэвчих хэрэгтэй. Энэ бүгд бол нисваанисыг тэвчих ерөнхий агуулга болой. *Долоон зүйлийн сэтгэлдээ үйлдэхүйн талаар:*

(1)Тийнхүү дээр доор газрын гэм, эрдмийг тус тус ялгаж бэлэг чанарыг зөв мэдрэнэ гэдэг заримдаа сонсох, заримдаа санах сэтгэлээс гарах тул сонсох, санах хоёрын холимог болно.

(2)Тийнхүү дадсаар явтал сонсох санахаас хэтрэн бясалгалын байдалд хүрч зөвхөн бүдүүн амарлингуйн утганаа сүслэж ирэхийг сүсгээс төрсөн сэтгэлд үйлдэх гэдэг. Энэ талаар *"Сонсогчийн газар"-аас:* Тэрхүү шинжийг тухайлан бодсоор амарлингуй ба үлэмж үзэхүйг бясалгаж үйлдэнэ хэмээсэн ба зургаан сэтгэлд үйлдэхүйн үед ч амарлингуй, үлэмж үзэхүйг бясалгах учиртай аж.

Эхний сэтгэлд үйлдэхийн үест утга тэргүүтэн зургаан суурь дээр тухайлан бодохыг айлдсан буй. Бусад үед ч үлэмж үзэхүй байхыг олонтаа айлдсан тул хэдийгээр эдгээрүүд "би-үгүй" үзлийн бясалгал бус ч, үлэмж үзэхүйтэй үл харшилна. Тиймээс сэтгэлд үйлдэх тэдгээрийн үед амарлингуй, үлэмж хоёрын ёсоор бясалгаж нисваанисаа тэвчих буюу.

Түүнийг бясалгах ёсны хувьд бүдүүн амарлингуйг тус тус ялгах утгыг дахин дахин шинжлэх нь үлэмж үзэхүйн бясалгал болох ба дахин шинжилсний эцэст бүдүүн амарлингуйн утгыг нэгэн үзүүрт болгон агуулах нь амарлингуйн бясалгал болно.

(3) Тэрхүү хоёрдугаар болон анхдугаар бясалгалыг сэтгэлдээ үйлдэх нь сөхөөлгийн ерөндөг болно. Тийнхүү амарлих, үлэмж хоёрыг ээлжлэн бясалгаж дадаж сурснаар Хүсэлт орны нисваанисыг дарах ерөндөг төрөх учраас машид аглаг сэтгэлдээ үйлдэх хэмээжээ.

(4) Мөн амарлих, үлэмж хоёрыг ээлжлэн бясалгаснаар дунд нисваанисыг тэвчиж чадсанаар "бясалгалд хураах" хэмээх сэтгэн үйлдэхүй төрнө.

(5) Чингээд буяны ажилд тотгорлогч Хүсэлт орны нисваанис нь дияанд орших атал, түүнээс босох үед ч гүйхгүй байна гээд, "би чинь одоо нисваанисаа тэвчив үү" гэж атгаглан нарийвчлан хянахгүй цаашлан шинжих явдал гардаг. Чингэж би хүсэл шуналаасаа салаагүй байхад гүйхээ больсон хэрэг үү? Гэвч шуналаас салсан бол гүйхгүй байх учиртай гээд түүнийг өдөөхийн тухайд нэгэн үзэсгэлэнтэй сайхан хүслийн орныг бодтол шунал

төрөөд ирэх бий. Үүнийг мэдээд тэвчихээр бясалгалдаа баясч үйлдэхийг "шинжлэх сэтгэн үйлдэх" гэдэг. Үүгээр тэвчээгүйгээ тэвчлээ хэмээн үзэх омгийг дардаг.

(6) Чингээд урьдын адил бүдүүн амирлангуйн утгыг тус тус шинжлэх ба шинжилгээний эцэст үргэлжид нэгэн үзүүрт сэтгэлд агуулах тэр хоёуланг дадуулснаар, Хүсэлт ертөнцийн бага нисваанисын ерөндөг төрөх цагт "ажлын эцсийн сэтгэн үйлдэх" хэмээжээ. Гурав, дөрөв, зургадугаар сэтгэн үйлдэхүйнүүд нь нисваанисыг тэвчих ерөндөг болдог.

(7)Тэр мэтээр хамгийн бага нисваанисыг тэвчээд ирэхээр хүслийн ил нисваанис бүгд дарагдаж түр хугацаанд өчүүхэн төдийд ч гүйхгүй болно. Гэхдээ хамаг хөрөнгө бүгдийг дарсан бус аа.

Энэ үед "Юу ч үгүй" хэмээх орноос доошхи орны шуналаас салсан болохоос "Сансрын үзүүр" орны ил нисваанисыг ч хорьж чадаагүй учир орчлонгоос гэтэлж чадаагүй байдаг. Гэхдээ бясалгал дияанд шүтсэнээр таван илт (зөн) мэдэл зэргийг олох бий. Энэ талаар үг олон болох гэж эмээгээд бичсэнгүй. "Сонсогчийн газар"-т дэлгэрэнгүй байгаа тул тэндээс үзээрэй.

Дияаны бясалгалын бодит суурийг бүтээх энэ мэтийн ёс нь өдгөө үгүй тул тэдгээртэй эсэргэлдэн хөтлөх газар үгүй биз ээ. Эдгээрийг ерөнхий үг төдий одуулалгүй, ухаарч мэдвээс дияан бясалгалын талаарх бусдын эсэргүүцлийг няцаахад тун тустай үзэгдэнэ.

Тэр мэтийн Дияаны дөрвөн орны болон дүрсгүй дөрвөн орны дияан бясалгалууд болон таван зөн мэдэл зэрэг нь гадаад, дотоод нийтийнх мөн тул хэдий тэр адилын онцлог ялгаатай дияан бясалгалыг олсон ч тэр төдийгээр орчлонгоос гэтлэхгүй. Түүгээр барахгүй тэдгээр нь зовлонд хүлэгч мөн тул зөвхөн амарлих сэтгэл төдийгээ ханан мэдэж хязгаарлалгүй, тус тус онох үлэмж үзэхүй буюу "би-үгүй" үзлийг эрэлцээрэй.

Анхдугаар дияаны анхдугаар орон тэргүүтний "бодит суурь"-ийг бүтээх ёсыг дэлгэрэнгүй мэдэхгүй ч гэсэн дээр номносон амарлингуй сэтгэл буюу сэтгэлдээ үйлдэхүй хэмээгдэх эдгээрийг бүтээх ёсны талаар машид гүн гүнзгий *"Билиг барамидын судар"* тэргүүтнээс сэтгэлээ тогтоох есөн зүйлээр үзүүлсэн үүнийг *"Төв үзлийн бясалгалын зэрэг"-ээс* эш болгосныг дээр номнов. Түүний утгыг *"Судрын аймгийн чимэг"*-т тайлбарласан ба Асанга хутагт бээр *"Бодийн газар" болон "Дээд абхидхарма","Нотлон буулгах хураангуй"* зэрэг шастаруудаа хураангуйлан айлджээ.

Амарлингуй ба үлэмж хоёрын талаар *"Хураангуй"*-гаас илүү *"Сонсогчийн газар"*-т нэмж тайлбарласан учир, *"Сонсогчийн газар"* нь

дэлгэрэнгүй тайлбарлажээ. Тэдгээрийн утгыг төв үзлийн *"Бясалгалын зэрэг"* болон *"Барамидын увдис"* тэргүүтэнд ч айлдсан буй. Мөн *"Дундад хязгаар"*-т айлдсан "хуран үйлдэх найман тэвчил", "таван гэмийг тэвчих ёс" зэргээс амарлингуй сэтгэлийг бүтээх ёсны дээрх шимийг сайтар судлан, өөрөө урласан зохиомол зүйл бус гэдгийг ч магадлан мэдэх хэрэгтэй.

Эдгээр нь зарим дияанч, бясалгалч нарт нэрийн төдий ч байдаггүй. Зарим нэгэнд гол номонд суралцах цагт үг төдий байвч сайтар ухаарч чадаагүйн эрхээр хожим анхааран авахын цагт хэрэггүй гээд тоохгүй орхих явдал гардаг. Иймээс сайтар ухааралгүйгээр амарлингуй сэтгэлийн зүгт баггах ганц нэг бясалгал олчихоод түүнийгээ хоосон чанарын бясалгалд тооцох ч үзэгдэнэ.

Гадаад, дотоодын нийтийн бясалгал болсон есөн сэтгэл төдий нэгийг олчихоод ханьцашгүй егүзэрийн ёсны бэлэг чанар төгөлдөр төгсгөлийн зэргийг олчихсонд тооцох ба "тэгш агуулах" болон "дараа олох" хэмээх бясалгалын хоёр сэтгэл ижилсээд ирэхээр "үргэлжид үл тасрах, үл атгаглах билиг билгүүн" төрлөө гэж үзэгч олонтаа тааралдана.

Дээр номносон зүйлүүдийг сайтар шинжлэн магадлах гэдэг "зоригдол үгүй", "бэлэг үгүй", "магад утгыг бясалгах" зэрэг яруу сайхан нэр, нэрийтгэл төдийхнээр эндүүрэлгүй, тэрхүү бясалгалын утга учир чухам юунд оршин байна гэдгийг ухаарах үүднээс зам мөрийн харшлал ба зохилдлыг таньж барин шалгарсан ном шастараас зарлигласан бясалгал дияаныг бүтээх эрэмбэ зэрэгт мэргэжин суралцах явдал билээ. Энд өгүүлрүүн:

Судар болоод тааллын тайлбар, их шастар
Номуудаас сайтар зарлигласан бясалгал бүтээх эрэмбийг
Гүн нарийн өгүүлсэн учир өчүүхэн ухаант нар
Ёсчлон үл ухаарах нь өөрийн ухааны гэм буй за

Сайн номлол тэдгээр бусдыг тухайлсан тул
Үл атгаглахуйг судлах увдис алга хэмээгээд
Байгаа номыг судлалгүй, огт байхгүй газраас
Олонтаа сураглан эрж олно хэмээн санах тэд

Энэ мэтээр гадаад болоод дотоод өөрийн
Бясалгал дияаны ялгааг үл мэдэх тул
Их хөлгөн болоод бага хөлгөн
Очирт болоод судрын хөлгөний
Бясалгал дияаны ялгааг алин болохыг

Ёсчлон ялгаж чадахгүйг хэлэх юун
Энэ байдлыг үзээд их гол номын
Бясалгалыг судлах ёсныг ухаарахад хялбар болгон өгүүлэв

Их гол номонд олон жил суралцагч нөхөд та нар
Өөрийн зэндмэнь их эрдэнээ орхиж
Өрөөл бусдын овоохойг авалгүй
Өөрт байгаа эрдэнээ болгоон зохио

Та нарын судалсан номын увдис утганаас
Ангид зүйл үгүйг болгоон бурхан бээр
Олныг сонсогч ойд оршвоос амгалантай хэмээн
Зарлиг болгосны утгыг шинжвээс зохилтой

Юуг ч үл атгаглан тогтох, амарлингуйн мөрийг
Юун түрүүнд бүтээх ёс, бүтээх хэрцэд хэмжээг
Бодолдоо ялгагч сайн ухааралыг эс олсон ч
Чин сэтгэл ямагтад зоригч диянч

Та нар ч эдүүгээ мэргэдийг шүтэж
Судлах журмыг ёсчлон мэдэж зохиогоорой
Тэр мэт бус бөгөөс бурханы шашинд
Түр нэг алжаас болохоос хорлол өчүүхэн бизээ

Тийнхүү Майдар, Асанга нарын номын дагуу
Амарлингуй (амарлих) сэтгэл бүтээх ёсыг
Номносон энэ бүгд нь
Бурханы ном өнөд оршихын тулд болой

("Их төрөлхтний мөр-"өөс, Бодисадвын явдалд суралцагчийн бясалгал дияаныг бүтээх ёс буюу амарлингуй сэтгэлийг бясалгах ёсыг номновой)

ҮЛЭМЖ ҮЗЭХҮЙН УХААНД СУРАЛЦАХ ЁСОН

7

ҮЛЭМЖ ҮЗЭХҮЙН УХААНД СУРАЛЦАХ ШААРДЛАГА

2. Үлэмж үзэхүйн ухааныг бясалгах

Тийнхүү дээр номносон мэтээр сэтгэлээ нэгэн бодол дээр хэрхэн хүссэнээр тогтоож, хаана ч агуулж үл атгаглах ба живэл зэргээс хагацсан тунгалаг тодорхой байдалт, үлэмж илүү баясгалан, амгалан төгөлдөр болсон амарлингуй сэтгэл (амарлин орших) төдийг олсондоо ханалгүй хоосон чанарын утгыг эндүүрэггүй онох билгийг төрүүлэхийн тулд үлэмж үзэхүй ухааныг бясалгах хэрэгтэй. Эс чингэвээс энэ төдийн дияан бясалгалууд нь тэрсүүд нарт ч байх нийтлэг зүйл билээ. Зөвхөн тэр төдийд дадавч тэдгээрүүд зам мөрийн адилаар нисваанисын хөрөнгийг тэвчиж чадахгүй тул зовлонгоос (самсара/сансар) тонилохгүй буюу. Энэ талаар *“Бясалгалын анхдугаар зэрэг”-ээс:*

Тэр мэт бодолдоо сэтгэлээ баттай тогтоож билгээр сайтар шинжлэх мөн. Чингэснээр билгийн гэгээ ургаж, хотол мунхагийн хөрөнгийг сайтар арилгах болно. Эс чингэвээс тэрсүүд нарын бясалгал төдийхнөөр нисваанисыг тэвчиж үл чадна хэмээжээ.

Мөн *“Судрын аймаг”-аас:*

Ийн хэмээн, Ертөнц дахинаа бясалгал дияан үйлдэвч
Тэр нь “би”-д баригч сэтгэлийг үл эвдлэх буюу
Тэр нь нисваанист учир машид хямруулах хэмээн айлджээ.

Энд “бясалгал дияан үйлдэвч” гэдэг нь өмнө номносон үл атгаглах, тунгалаг тодорхой зэргийн ялгамжаа төгөлдөр бясалгалыг хэлж байна. Түүнийг бясалгавч “би”-д баригчийг үл тэвчиж чадахыг “тэр нь “би”-д баригч сэтгэлийг үл эвдлэх” хэмээжээ. “Би“-д баригчийг эс тэвчсэн тул эдүгээ ч нисваанис төрж байгааг “Тэр нь нисваанис учир машид хямруулах” хэмээжээ.

Чингэвээс чухам юуг бясалгаваас нирваанд хүрэх вэ? Дээр татсан *“Эш”*-ээс үргэлжлүүлэн “Хэрвээ номын “би-үгүй”-г тус тус онох” хэмээх тэргүүтнээр “би-үгүй”-н номын утгыг тус тус шинжих замаар “би-үгүй”-н утгыг оносон

ухааныг төрүүлэх учиртай. Мөн “Тус тус түүнийг шинжлэн бясалгах” хэмээсэн мэтээр “би-үгүй”-н үзлийг олохоор тэрхүү үзлийг судалж бясалгана. “Тэр нь нирваааныг олох үрийн үндэс” хэмээснээр тэрээр гаслангаас нөгчигсөн буюу нирвааныг олох үрийн үндэс мөн” хэмээжээ.

Түүнийг бясалгаснаар нирваан олно гэсэн тул түүнээс өөр бусад юу нэгийг бясалгавч нирвааныг олох гээд, “Бусад ямар ч үндэс байлаа нирваанд хүргэхгүй” хэмээн түүнээс бусад ямар ч мөрийг бясалгавч тэр л байхгүй бол зовлон нисваанисыг амарлиулж чадахгүй болой хэмээж, зөвхөн “би-үгүй”-н билгээр зовлонгийн язгуурыг тасалж чадна гэдгийг маш тодорхой үзүүлжээ. Энэ талаар “*Бясалгалын зэрэг*”-ийн доторх Хуушааныг буруушааж няцаасан хэсгээс үзэх хэрэгтэй.

Тэрсүүдийн арш, дияанч нарт бясалгал дияан, илт зөн мэдэл зэрэг олон эрдэм байвч “би-үгүй”-н үзэл онолгүй учир зовлонгоос өчүүхэн төдий ч гэтэлж чадаагүй байдаг. Мөн дээр эш авсан *“Бодисадвын аймаг сав”-аас айлдахдаа:*

Эрхэм зарлигаас номносон хоосон чанарыг оноогүй бясалгал төдийд ханан мэдэж, түүнийгээ гүн гүнзгий утгыг бясалгах мөр хэмээн илт омгорхон үйлдвээс орчлонгоос гэтэлнэ гэж байхгүй. Би түүнийг болгоон бусдаас сонсож байж л өтлөх, үхэхээс гэтэлнэ хэмээн зарлиг болов хэмээжээ.

Ийнхүү (Донбава) багш өөрийнхөө тааллыг барин тодорхой зарлиглажээ. “Бусдаас сонсох” гэдэг нь “би-үгүй”-г номнох бусдын номлолыг сонсохыг айлджээ. Тиймд гаднаас эрхэм буяны садан нараас “би-үгүй”-н утгыг сонсон санаж бодолгүйгээр дотроосоо төрнө хэмээх үзэгдлийг хорихын тухайд “бусдаас сонсох” хэмээн айлдсан нь омтоггүй үнэн болой.

Ер нь *Ялгуугсадын эрхэм зарлиг* бүгдээр хоосон чанарыг зарим үед илт заасан ба илт номлоогүй ч дамжуулан (далд утгаар) заах зэргээр зөвхөн түүнийг л зааж сургасан байдаг. Хоосон чанарыг ухаарах гэгээ эс төрөх хүртэл мунхагийн харанхуй үл буцна. Гэгээ гарваас буцах тул нэг үзүүрт амарлингүй сэтгэл төдийгөөр билиг оюун үл гэгээрэх учир мунхагийн харанхуй ч арилахгүй. Иймд хоосон чанар буюу “би-үгүй”-н утгыг онох ухааныг олно хэмээн билиг оюуныг эргэлзэлгүй эрэх шаардлагатай. *“Бясалгалын дунд зэрэг”-ээс:*

Чингээд амарлингуй сэтгэлийг бүтээгээд улэмж үзэхүйг бясалган үйлдсү хэмээн санаарай. Ялж төгөлдөр нөгчигсөн бурханы хамаг зарлигаас сайтар тодорхой айлдсан бөгөөд илт буюу дамжуулах зэргээр хоосон чанарыг тодорхой үйлдсэн

зөвхөн тэр ямагтад хичээгээрэй. Тэр ямагтыг ухаараад ирэхээр гэгээ гарахад харанхуй арилах шиг буруу үзлийн тор бүхнээс салах болно. Зөвхөн амарлингуй орших төдийгөөр билгэ билиг үл ариусах ба түйтгэрийн харанхуйг арилгахгүй. Хоосон чанарыг сайтар бясалгах билгээр бэлгэ билиг ариусан гэгээрнэ. Тэр ямагтыг ч онох болно. Зөвхөн билиг ухаанаар түйтгэрийг жинхэнэ ёсоор тэвчиж чадна. Тиймд би бээр амарлингуй сэтгэлийг бясалгаж, ухаан билгээр тэр ямагтыг олж үйлдмү. Зөвхөн амарлингуй сэтгэл төдийд ханаж бүү барь. "Тэр ямагт чанар" гэж юу вэ? Хамаг юм бүхэн үнэхээр "бодгалийн би" болон "номын би" хоёроос хоосон чанарт болой хэмээжээ.

"Тэр ямагт чанар" түүнийг барамидуудын дотроос чинад хүрсэн билиг буюу билиг барамидаар (prajna pramitta) онох мөн. Бясалгал зэргүүд оножүл чадах учир бясалгал дияан төдийхнийг билиг барамидтай эндүүрэлгүйгээр билиг ухааныг төрүүлэх хэрэгтэй. *"Тааллын тайлбар"-аас айлдахдаа:*

Ялж төгөлдөр нөгчигсөн өө! Ямар барамидаар бодисадва нар "мөн чанар үгүй-чанар"-ыг барих вэ? Хонсим бодисадва Арьяабал аа! Билиг барамидаар барих болой хэмээжээ.

Түүнийг болгоон өмнө эш авсан *"Их хөлгөнөө сүсэг бясалгах судар"-аас ч*:

Билиг ухаан байхгүй бол бодисадва нар хичнээн их хөлгөнөө сүслэж, их хөлгөнөө юу нэгийг үйлдэвч магадтай нирваанд хүрнэ гэж би өгүүлж чадашгүй" хэмээн айлджээ.

8

ЗӨВ ЭШ СУРВАЛЖИД ШҮТЭХ

2. Үлэмж үзэхүйд суралцах ёсон

а.Үлэмж үзэхүйн чуулганыг шүтэх

1) Гулзгай(удирдахуй) утгат болон магад утгат эрхэм зарлигийг ялгаж мэдэх

2) Нагаржуна(й) гэгээний тааллын тайлбар хэрхэн гарсан тухай

Түүнээ дөрвөн зүйл

а.Үлэмж үзэхүйн чуулганыг шүтэх

б.Үлэмж үзэхүйн машид ялгал

в.Үлэмж үзэхүйг бясалгах ёсон

г. Үлэмж үзэхүйг бясалган бүтээх хэмжээ

---оОо---

а. Үлэмж үзэхүйн чуулганыг шүтэх

Эрхэм зарлиг бүхний аньсыг эндүүрэлгүй болгоосон мэргэдийг шүтэж хиргүй гол ном судрыг сонсоно. Сонсох, санахын ухаанаар хоосон чанарыг онох үзэл онолтой болох явдал нь заавал байх шаардлагатай үлэмж үзэхүйн үндсэн нөхцөл шалтгаан бөлгөө. “Ахуй ёс”-ны утгыг “эцсийг нь хүртэл мухарлах үзэл онол байхгүй бол” үнэмлэхүй утгыг онох үлэмж үзэхүйн ухаан төрнө гэж байхгүй. Энэ адилын үзэл онолыг гулзгай утганд үл итгэх, магад утганаа итгэх итгэлээр эрэх хэрэгтэй. Тиймд гулзгай ба магад утгын ялгааг ухаж магад утгат эрхэм зарлигийн утгыг онож мэдэх хэрэгтэй.

Гэвч шалгадаг төрөлхтөн болсон “Их тэрэгчний ёсыг нээгч” дээдэс нарын зарлиг тааллыг тайлсан шастар ном, эш сурвалжийг үл шүтвээс хөтөчгүй харалган хүн аюул осолтой газар руу дөтлөх адил болно. Иймд эндүүрэлгүй тааллын тайлбарыг судалж үзээрэй. Чухам ямар тааллын тайлбар номыг шүтэх вэ? Ялж төгөлдөр нөгчигсөн бурханы шашин номын зүрхэн болсон “буй үгүй”-н туйлшрал бүхнээс хагацсан гүн гүнзгий утгыг тайлбарлав хэмээн олон судар, тантраас сайтар тодорхойлж эш бошиг үзүүлсэн гурван газраа Нагаржуна гэгээн (түв: Лүдүв, монг: Лусын бүтээлчин) хэмээн төгс алдаршсан түүний шастаруудыг шүтэх бөлгөө. Түүний гол эш номонд шүтэж хоосон чанарыг онох үзэл онолыг судлах хэрэгтэй.

Түүнээ гурав:

1) Гулзгай (удирдахуй) утгат болон магад утгат эрхэм зарлигийг ялгаж мэдэх

2) Нагаржуна(й) гэгээний тааллын тайлбар хэрхэн гарсан тухай

3) Хоосон чанарын үзлийг нотлон буулгах ёсон

1) Гулзгай утгат болон магад утгат эрхэм зарлигийг ялгаж мэдэх

Хоосон чанарыг мэдэхийг хүсэгчид Ялгуугсаны эрхэм зарлигийг шүтэх хэрэгтэй. Элдэв шавь нарын санааны эрхээр эрхэм зарлиг ч олон янз байдаг тул ямар зарлигийг шүтэж гүн гүнзгий утгыг судлах вэ? Магад утгат эрхэм зарлигийг шүтэж хоосон чанарыг онох учиртай.

Чингэвэл магад утгат гэж юуг хэлэх, бас гулзгай утгат гэж алиныг хэлэх вэ? Өгүүлж буй утгын үүднээс эдгээрийг ялгана. "Үнэмлэхүй утгыг заасанаар магад утгат гэх ба янагуухуй утгыг заасан бол гулзгай утгаж зарлиг" гэж үзээрэй. Ийм болохыг *"Лодоймэсадвын үзүүлсэн судар"-т айлдахдаа:*

Магад утгат судрын аймаг гэж алин бэ? Гулзгай утгат судрын аймаг гэж алин бэ? Алин янагуухуй утгыг заан үзүүлсэн судар тэдгээр нь гулзгай утгат хэмээмой. Алин үнэмлэхүйг зааж үзүүлсэн тэдгээр нь магад утгат хэмээмой. Алин үг, үсэг элдэв зүйлийг заасан тэдгээр судрууд гулзгай утгат болой. Алин гүнзгий тул ухахад бэрхийг үзүүлсэн тэдгээр нь магад утгат хэмээмой хэмээжээ.

Тэгвэл янагуухуйг зааснаар гулзгай утгат болсон тэрээр хэрхэн янагуух(и) утгыг заасан болон үнэмлэхүйг зааснаар үнэмлэхүй утганаа одогч тэрбээр хэрхэн үнэмлэхүйг заасан бэ? Энэ талаар дээрх судартмашид тодорхой үзүүлжээ. "*Түүнээс*":

Алин судрын аймгаас өөрийгөө болон бусад амьтны тухай амь насны, тэжээхүй ухааны, ард олны, бодгальсын, шумнасаас төрсөний, шумнасын хөвүүний, үйлдэгчийн, эдлэгчийн, элдэв хэлний талаар, "би-үгүй" байтал "би буй" мэтээр номлох зэргээр тэдгээрийн тухай заасан бол гулзгай утгат хэмээмой. Алин судрын аймгаас хоосон чанарын тухай, бэлгэс үгүй чанарын тухай, илт хуран үйлдэх үгүй талаар, төрөх үгүйн тухай, үл төрөхийн тухай, амьтан үгүй, амь үгүй, бодгаль үгүй, тийн тонилохуйн үүдийг заасан тэдгээр нь магадтай утга хэмээгдэнэ" хэмээжээ.

"Би-үгүй" болон "төрөх үгүй" зэргийн цацралыг тийн таслах ёсыг заасан бол магад утгат гэх ба "би" тэргүүтнийг заасныг гулзгай утгат хэмээжээ. Тиймд

"би-үгүй" болоод "төрөх үгүй" зэргийг үнэмлэхүй гэнэ. Төрөх тэргүүтнийг заасан бол янагуух утгат гэж мэдээрэй. *"Бясалгалын хаан судар"-аас:*

Түүнчлэн залрагсад бээр хоосон чанарыг үзүүлсэн түүгээр
Магад утгат судрын аймгийн өвөрмөц ялгааг мэдэх
Алин амьтан, бодгаль, ардын заасан тэр ном бүхнийг
Гулзгай утгат гэж мэдээрэй хэмээн айлджээ.

"Төв үзлийн гэгээ"-нээс:

Тиймд зөвхөн үнэмлэхүй утгыг өгүүлсэн нь магад утгат гэж мэдээрэй.
(Түүнээс) Буцсан нь гулзгай утгат хэмээн ухаараарай хэмээжээ.

"Хутаг бурхад бүгдийн орноо орох бэлгэ билгийн гэгээн чимэг"-т ч: "Алин магад утга тэр нь үнэмлэхүй утга мөн болой" хэмээжээ. Төрөх үгүй тэргүүтний талаар, *"Хутагт Лодоймэсадвын судар"-аас:*

"Магад утгат хэмээн үзүүлсэн буй. Тиймд зөвхөн "төрөх үгүй" тэргүүтнийг үнэмлэхүй утгат гэж магадлах болой" хэмээн айлджээ.

Тиймд *"Төв үзлийн ухааны чуулган", "Тааллын тайлбар"* зэргээс магад утгын талаар хэрхэн заасан дагуу баримтлах нь зүйтэй байна. Учир нь төрөх, төрдөх зэрэг цацралын чуулган бүгдээс салсанаар үнэмлэхүйн утга болохыг дэлгэрэнгүй номножээ. Ямар учраас тийнхүү хоёр янзаар буюу гулзгай утгат ба магад утгат гэж заасан юм бэ? Тухайн утгыг бусад байдлаар (өөр тийш татах) гулзгайлгаж чадахгүй учир магад утга буюу утгыг магадлагч хэмээжээ. Тийм утга нь хоосон чанар мөн болох тул нотлогдохууны эцэс туйл аж. Түүнээс цаашид татаж, гулзгайлгаж болохгүй, түүнээс өөрөөр, бусад бодгаль татаж чадахгүй болох нь шалгадаг ухаанаар нотлогдсон аж. Энэ талаар *"Төв үзлийн гэгээ"-нд:*

Магад утга алин бэ? Шалгадаг ухааны болон үнэмлэхүйн эрхнээ зохиож номносон алин буюу. Түүнийг түүнээс өөр бусдад алинд ч татан чадахгүй болой хэмээжээ.

Тийн айлдсаны хүчээр гулзгай утгыг мэдэж болно. Үүний утга нь хэрхэн заасан дагуу барих албагүй гэсэн санааг өгүүлэх буюу өгүүлэх үг дагуу барьж болох авч тэр төдийд туйлын утга "тэр ямагт чанарт" (хоосон чанарт) биш байна. Түүнээс өөрөөр, түүний хоосон чанарыг эрэх хэрэгтэй тул гулзгай утгат буюу утгаа тайлбарлах хэрэгтэй болдог.

Эргэлзээ : "Магад утгат судрын аймгууд нь өгүүлэх дуу дагуу мөн бол тэдгээр судраас төрөх үгүй, бодгаль үгүй гэх зэргээр айлдахад нь ерөөсөө төрөлхтөн, бодгаль огт байхгүй гэж барих болох нь ээ. Эс чингэвээс үг дагуу бус болох учир гулзгай утгат болж хэтийднэ биз дээ"

Хариулт: "Ингэж хэлдэг ч таарахгүй. Тийн айлдагч бурхан бээр төрөх тэргүүтнийг хорихдоо (үгүйсгэх) "үнэхээр"-ийн ялгааг найруулж, магад утгаа заасан нь судрын аймагт олонтаа үзэгдэнэ. Ялгааг найруулсан, найруулаагүй аль ч үед нийтийн ном мөн бол найруулах хэрэгтэй. Энэ нь тэр номын хоосон чанар мөн тул тэр мэтийг заасанаар магад утгат болохгүй гэж хаанаас байх вэ. Чингэхгүй бол ерөнхий төрөх хэмээх утга үгүйсгэгдэж, ялгасан үг ч эвдрэхэд хүрч түүнийг заасан судар ном магад утгаа илэрхийлж чадахгүй болно.

Тиймээс судар шастар аль нь ч бай ялгаагүй ерөнхийдөө тэдгээрийн эхэнд болон эцэст юу өгүүлсэнийг найруулалгүй (бодолгүй)-гээр өчүүхэн нижгээд "үгийн хацар" дээр үзэгдсэн төдийг дагаж барихгүй байвал магад утгат эрхэм зарлигийг эвдэхгүй. Тухайн үгийн үзүүлэх утгын дагуу дууг барьж болмоор байсан ч гулзгай утгат болохгүй гэж үзэж болохгүйг мэдээрэй.

2) Нагаржуна гэгээний тааллын тайлбар хэрхэн гарсан тухай

Тэр мэт хамаг ном (юмс үзэгдэл) өөрийн мөн чанараас (өвөсбээн бүтэх) төрөх болон төрдөх (мөхөх) зэрэг ерөөс үгүй болохыг заасан билиг барамидын судар тэргүүтэн эрхэм зарлигуудыг үнэн зөв тайлбарласан Нагаржуна гэгээний тааллын тайлбар зэргүүд хэрхэн үүдсэн түүхтэй вэ?

Буддхапалита (Санжайжан), Бхававивека (Лэгданжэд), Чандракирти (Даваадагва), Шантаракшида (Шиванцо) зэрэг төв үзлийн их сэтгэгч мэргэд нараас Пагвалха (Арьяадэвэ) гэгээнийг багштайгаа (Нагаржуна) адил гэж нотолсон бий. Тиймээс урьдын дээдэс бээр "эцэг, хөвгүүн" тэр хоёрыг бусад төв үзэлтэн (Мадхьямикка) нарынхаа "Анхдагч" буюу "Эх гол номын төв үзэлтэн" хэмээж бусдыг нь "Зүгийг баригч төв үзэлтэн" хэмээжээ.

Энэ талаар урьдын дээдэс зарим нэг багш нараас: "Нэр томъёог агуулах ёсны үүднээс нэрийдэх төв үзэлтэнд хоёр буй. Нэр төдийд гадны утга байна хэмээх "Судрын явдалт төв үзэлтэн" ба нэр төдийд ч гадна утга байхгүй хэмээх "Егүзэрийн явдалт төв үзэлтэн" нар болой. Үнэмлэхүйг агуулах ёсны үүднээс нэрийдсэн хоёр буй. Үзэгдэл хоосон хоёр чуулганыг үнэмлэхүй үнэн хэмээх "Илбийн язгуурыг бүтээгч" ба үзэгдлийн цацралыг тийн таслах төдийгөөр үнэмлэхүй үнэн болно гэж үзэх "Машид үл оршихыг

өгүүлэгч" нар болой. Энэ хоёрын эхний төлөөлөгчид нь Ловон Шивацо, Камалашила (Бадма Анцүл) тэргүүтнийг тооцдог. Илбэ мэт болон машид үл оршигч хэмээх нэрийг Энэтхэгийн зарим мэргэд нар ч хүлээсэн үзэгдэнэ. Ер нь Төв үзэлтэн гэж хөөрөмших Энэтхэг, Түвдийн зарим нэгнийг ингэж үзэж болох биз ээ. Гэвч Нагаржуна багшийг дагасан их төв үзэлтний ёс ямар болохыг нотлон буулгаж үйлдсү. Нарийн зүйлийг хэн номнож яаж чадах вэ.

Мөн үнэмлэхүйг үзэх ёсыг хоёр зүйлээр үзэх нь мунхагаа гайхуулсан ёс хэмээн их дуун хөрвүүлэгч Лодоншарав айлдсан нь машид зөв болой. "Тэд нар учир шалтгааны жиших ухаанаар үлэгдэх (баригдах) утга төдийхнийг үнэмлэхүй үнэн гэж үзээд учир шалтгааны ухааны үлэгдэхүүн орныг үнэмлэхүй үнэнтэй таарна гээд үнэмлэхүй гэж нэрийдсэн болно" хэмээн "*Төв үзлийн чимэг*" болон "*Төв үзлийн гэгээ*" хоёроос айлджээ. Бусад их төв үзэлтэн нар ч учир шалтгааны ухаанаар цацралыг тасалсан утга төдийг үнэмлэхүй үнэн гэж үзээгүй учир буруу аж.

Энэ талаар Эшдэ багш бээр: "Эцэг хөвгүүн, багш, хутагт нарын зохиосон төв үзлийн шастаруудаас үзвэл, гадна утгын буй үгүйг тодорхой (гол болгож) айлдаагүй байна. Түүний дараагаар Лэгданжэд гэгээн бээр Сэтгэл төдийтний ёсыг баалж нэр төдийд гадна утга байх ёсыг номножээ. Чингээд Шивацо гэгээн бээр Егүзэрийн явдалтны гол номонд шүтэж нэр төдийд гадна утга байхгүй ба үнэмлэхүй сэтгэл гэдэг өөрийн мөн чанаргүй байна гэх зэргээр харилцан адилгүй төв үзлийг номносноос хоёр зүйлийн ёс гарчээ.

Эхнийх нь "Судрын аймгийг явдалт төв үзэлтэн" (Сутрантика Мадхьямика) хэмээгдэж, удаах нь "Егүзэрийн явдалт төв үзэлтэн" (Ёгочара Мадхьямика) хэмээгдсэн болой" гэж номносноос үзвэл гарвал үүслийн хувьд тэр дагуу болох нь тодорхой байна. Гэвч Чандракирти гэгээн үзэхдээ, "Нэр төдийд гадна утга байна хэмээн үзэвч бусад тогтсон тааллыг өгүүлэгч нарын ёстой таарахгүй зүйл байх тул "Судрын аймгийн явдалт" гэж болохгүй. Түүнчлэн "Өвөрмөц өгүүлэгч (Вайбхашика)" ч гэж хэлэхэд таарахгүй нэгэн байна"

Цастын орны хожуу үеийн мэргэд ч Төв үзэлтэн нарыг *"Хэтрүүлэгч" (түв: Талжүрва, самг: Прасангика*) болон *"Өөрийн үндэст" (түв: Ранжүдва, самг: Свантантрика)* гэсэн хоёр нэрээр илэрхийлж ирсэн нь "*Тодорхой үг (Pasana-pada)*"-тэй таарах учир өөрсдөө зохиосон гэж үзэхгүй байна. Тиймээс нэрийдэл төдий гадна утга буй, үгүй гэж үзэх хоёр байх нь магадтайн дээр үнэмлэхүй үнэн болсон хоосон чанарыг оносон үзэл онол сэтгэлд төрөх үүднээс нэр зүүсэн байсан ч "Талжүрва, Ранжүдба" хоёрт багтах нь тодорхой байна.

Чингэвэл эдгээр багш нар хэнийг дагаж эцэг, хөвгүүн, хутагт нарын таалдыг тайлбарлав? Их богд Чандракиртигийн эрхэмлэн туурвисан тэдгээр ёсыг дагаж энэхүү увдисын дээдэс мэргэд нарын тэр ёсыг л эрхэмлэн барьжээ. Чандракирти гэгээн бээр "*Үндсэн билиг (Mula-madhyamaka-karika)*"-ийг тайлсан мэргэд дотроос Буддхапалита багшийг хутагтын таалдыг төгс төгөлдөр тайлсан хэмээн болгоож тэрхүү ёсноо суурилж, Бхававивека багшийн олон сайн номоос зарим нэг үл таарах хэсгийг хянан залруулж хутагтын таалдыг тайлбарлан зохиожээ.

Энэхүү хоёр багшийн тайлбарууд нь эцэг, хөвгүүн, хутагт нарын гол номыг үлэмж гайхамшигтайгаар номносон болно. Иймд энэ үес Буддхапалита болон Чандракирти багш нарыг дагаж хутагтын таалдыг нотлон буулгаж үйлдсүгэй.

9

ҮНЭНИЙГ УХААРАХ ШАТУУД

3) Хоосон чанарын үзлийг нотлон буулгах ёсон

а) Хоосон чанарт орохын зэрэг

3) Хоосон чанарын үзлийг нотлон буулгах ёсноо хоёр:
а) Хоосон чанарт орохын зэрэг
б) Хоосон чанарыг бодитой нотлон буулгах

- - - о О о - - -

а) Хоосон чанарт орохын зэрэг

Асуулт: Энэ үесийн оногдохуун болох хоосон чанар буюу нирваан гэж юу вэ? Түүнийг олох арга буюу хоосон чанарт орохдоо чухам яаж орох вэ?

Хариулт: Гадна, дотны элдэв юмс, үзэгдэл өөрийн мөн чанарт бус хирнээ өөрийн мөн чанарт юм шиг үзэгдэх тэр бодол авьяас бүгдээр лавтайяа амарлиж, би болоод минийх хэмээх бүх үзэл барагдаж дуусахаар сая энэ үест онох ёстой хоосон чанар буюу номын лагшинг олох болой.

Хоосон чанарыг онохын тулд эхлээд орчлонгийн гэм эргүүг санаж сэтгэл гансрах ба улмаар түүнийг орхих бодол төрсөн байх чухал. Чингэхдээ зовлонгийн (самсара) үндсийг буцаахгүй бол түүнийг огоорч чадахгүй нь ойлгомжтой тул сансрын үндэс гэж юу болохыг тунгааж мэднэ. Ийнхүү эвдрэх үзэл буюу мунхаг сэтгэл нь зовлонгийн үндэс болохыг сайтар ухаж мэдээд түүнийг бүр ёзоороос гаргаж хаях, тэвчих бодлыг баттай төрүүлэх учиртай.

Тэрхүү эвдрэх үзлийг буцаана гэхэд, түүнийг барих "би"-г байхгүй болохыг онох ухаан төрөх эсэхээс хамаарна гэж ойлгож ирвэл нөгөөх "би"-гээ хаах хэрэгтэй гэж үзэх болно. "Би"-г буй гэхэд эсэргүүцэгч ба үгүйсгэж нотлох эш үндэслэл, учир шалтгаан зэрэгт түшиглэн байж магадлал нэгнийг олно гэдэг нирвааныг хүсэгчдэд зайлшгүй байх ёстой арга билээ. Тийнхүү би болоод минийх хэмээх мөн чанар огт байхгүйг таньсан үзлийг олж, тэрхүү утгыг дадуулж бясалгаснаар номын лагшинг олно. Энэ талаар *"Тодорхой үгт"-ээс:*

Асуулт: Ерөөс нисваанист, үйлт, биет, үйлдэгч, үр дагавар эдгээр өөрийн

чанарт бус гандирсын хот балгад зэрэг мэт өөрийн чанаргүй хирнээ нялхас нарт өөрийн чанартай мэт үзэгдэнэ. Энэ үест тэр ямагт чанар гэж юу вэ? Хоосон чанарт хэрхэн орох вэ?

Хариулт: Өгүүлсүг: Гадаад, дотоодын бодас (юмс) үл тухайлагдах буюу гадаад, дотоодыг "би"-д барих, минийх хэмээн барих бодол бүгд барагдах энэ л тэр ямагт чанар болой. Тэр ямагт чанарт орох талаар:

Хамаг нисваанис гэмүүд бүгд
Эвдрэх үзлээс үүдэхийг ухаарч
"Би" гэдэг түүний орон мөнийг оносноор
Егүзэрүүд "би"-гээ хорьж үйлдэх хэмээсэн тэргүүтнийг *"Төв үзэлд орохуй"* зэргээс ухаж мэдээрэй. хэмээгээд,

Мөн түүнээс:

Хоосон чанарыг мэдэхийг хүсэх, нисваанис болон хамаг гэмийг тэвчихийг хүсэх егүзэр нарт энэхүү орчлон юунаас үндэстэй юм бол гэх ухаарах бодол төрж, улмаар түүнийг эвдрэхүй чуулганы үзлийн үндэст болохыг лавтай ойлгож ирнэ. "Би"-гэдэг зөвхөн эвдрэх үзлийн тухайлагдах (зоригдол) орон гэж үзэх болно. "Би"-гээ үл тухайлах болоод ирэхээр эвдрэх үзлийг тэвчих ба тэдгээрийг тэвчвээс хамаг нисваанис гэмүүд арилна гэж үзнэ. Тиймээс "би"-д баригч бодлын орон болсон "би" гэж чухам юу вэ? хэмээн хамгийн түрүүнд зөвхөн "би"-гээ лавтай ухаж мэдээрэй хэмээн айлджээ.

Хэмжээлшгүй олон ном (юмс) тус тусын өөрийн мөн чанарыг няцаасан олон зүйлийн учир шалтгааныг айлдсан бий. Хэдий тийм ч егүзэр нар бясалгахын үүднээс товчлон хураaж, "би" болоод "минийх" хэмээхийн өөрийн мөн чанар үгүйг нотлон буулгах бясалгалд багтаажээ. Энэхүү бясалгалыг *"Үндсэн билгийн арван наймдугаар бүлэг"*-ийн утга мөн хэмээж Санжайжан багш айлдсанаа түшиж, Чандракирти багш ч мөн ийн зохиосон бөгөөд бодгалийн "би-үгүй" чанарын талаар *"Төв үзэлд орохуй"*-гаас айлдсан зэрэг нь *"Арван наймдугаар бүлэг"*-ийг дэлгэрэнгүй номносон нь тэр ажээ.

Эргэлзээ: "Хэрэв энэ үед их хөлгөний хоосон чанарт орох ёсыг заагаагүй гэх буюу "би хийгээд минийх гэж барихуй"-г барах төдий олох ёстой хоосон чанар болж чадахгүй гэх ба "би хийгээд минийх" дээр өөрийн мөн чанар байхгүйг нотлон буулгах төдийгөөр "номын би-үгүй"-г нотолж чадахгүй учраас хоосон чанарт орох (ухаарах) мөр гэх нь зохисгүй болов уу?"

Хариулт: Гэм гарахгүй ээ."Би хийгээд би-д барихуй" үзлийг үндсээр нь

няцаахад хоёр зүйл буй. Түүнээс нисваанис дахин төрөхгүйн үүднээс ашид тэвчих мөр бага хөлгөнд ч байж болно. Гэвч гадаад, дотоод ном бүгдийн цацрал бэлгэс бүгд үл тухайлагдаж ашид тэвчигдэж ирэхэд номын лагшин болж буй хэрэг. Тиймээс "би"-г өөрийн мөн чанараар байхгүй гэдгийг оножавсанаар түүний гишүүн болох цогцос тэргүүтнийг өөрийн мөн чанараар бүтсэнд үзэх үзлийг буцааж болно. Модон тэрэг шатахад хүрд дугуй зэрэг түүний эд ангиуд нь шатахтай адил буюу. Энэ талаар *"Тодорхой үгт"-ээс:*

Шүтэн гарсаныг үл ухааран буруу үзэгч нар "би"-д илт шунах үзлийн суурь болсон эдгээр таван цогцосыг чухал авагч мэтээр үзэгдэх алин түүнээ цогцосын бэлэг чанар байна уу, эсвээс байхгүй юу хэмээн тонилохуйг хүсэгч нар шинжилнэ. Тонилохуйг хүсэгч нар намба байдал бүгдийн талаас шинжиж хайгаад тэдгээрүүд үл тухайлагдах (үл олдох) учраас, "Эзэн (би) нь буй бус тул минийх хэмээхийн чанар хаана буй" хэмээсэн буй. "Би" гэдэг үл тухайлагдахын учир "би"-гээс үүдэх "минийх" хэмээх суурь огтоос үл тухайлагдах болой. Хэрхэн модон тэрэг шатахад түүний эд анги ч шатаж үгүй болдоггой адилаар егүзэр, бясалгагч нар хэзээд "би-үгүй"-г (хоосон чанар) онох цагт цогцосын зүйлийг минийх хэмээх үзлийг ч "би-үгүй" чанарт гэж онох болой" хэмээн "би-гээ өөрийн мөн чанараар байхгүй" болохыг онохын цагт минийх хэмээх цогцос юугаа ч "би-үгүй" буюу өөрийн мөн чанар үгүй гэж ононо хэмээн айлджээ.

"Орохуйн тайлбар"-аас

Дүрс тэргүүтнийг өөрийн мөн чанартай гэж үзвээс чанх буруудаж "бодгалийн би-үгүй"-г онож чадахгүйд хүрнэ. "Би" гэж нэрийдэхийн суурь болох цогцост тухайлсанаас (үнэнд барьснаар) болой. Ийн өгүүлрүүн:

Хэдий цогцосоо (үнэхээр) барих буй
Тэр хүртэл минийх (минийхмхийлэх) гэж барих буй

хэмээн цогцосууд өөрийн мөн чанараар бүтээгүйг онохгүй бол "бодгалийн би-үгүй" чанарыг онож чадахгүйг ийн айлджээ.

Эргэлзээ: (1) "Хэрвээ бодгалийн өөрийн мөн чанар үгүйг оносон тэр ухаанаар цогцосын өөрийн мөн чанар үгүйг онох болвоос хоёр "би-үгүй"-г оносон хоёр ухаан нэгэн болохын гэм гарна. Яагаад гэвэл ном болоод бодгаль хоёр тус тусдаа учраас тэр хоёрын өөрийн мөн чанарыг оносон хоёр ухаан тус тус байх ёстой. Үлгэрлэвээс, хумх болоод багана хоёрын мөнх бусыг онох ухаантай адил бус уу?

(2) Бодгалийн өөрийн мөн чанар үгүйг оносон тэр ухаанаар цогцосын мөн чанар үгүйг хэрхэн онох вэ?

Хариулт: Эхний асуултыг хүлээн зөвшөөрөхгүй (адил гэхгүй). Дараагийн асуултанд хариулья. Бодгалийн өөрийн чанаргүйг онох тэр ухаанаар цогцосын өөрийн чанараар бүтээгүй гэж онохгүй ч тэр ухаанаар бусдаас харгалзалгүйгээр цогцос өөрийн чанараар биш гэж магадлах сэтгэлийг татаж чадах тул цогцосыг өөрийн мөн чанараар бүтсэн гэж хөөрөх (өд зүүх) хэтийдлийг тасалж чаддаг байна. Тиймээс "бодгалийн би-үгүй"-г онохын цагт цогцосын өөрийн чанараар бүтээгүй болохыг онож болохыг айлджээ. Энэ талаар *"Буддхапалида"-аас:*

Энэ мэт "би" хэмээх алин тэдгээрийг минийх хэмээвээс "би" гэдэг тэр ч буй бус. Тэр үгүй болохоор түүний энэ тэр хэмээх хэрхэн таарах" хэмээн айлдсан дагуу мэдээрэй.

Үлгэрлэвээс, хүүсэр эмийн хөвгүүнийг байхгүйг мэдэхдээ тэрхүү ухаанаар түүний чих тэргүүтнийг байхгүй гэж барих хэрэггүй ч түүний чих байна гэх хөөрөмшил хэтийдлийг дарж чадахтай адилаар "би" гэхэд өөрийн чанар байхгүйг мэдээд ирэхээр түүний нүд хараа тэргүүтэнд тийм чанар байна гэх бодлыг буцаана.

Эсэргүүцэх нь: Чингэвээс нэрийтгэлийн бодгаль байна гэж үзэх манай аймгийн "бодит өгүүлэгч" нараас үнэхээр бүтсэн бодгаль байхгүй гэж үзэх тул тэдгээр ч бас нүд тэргүүтнийг өөрийн мөн чанаргүй гэж ухаарах уу?

Хариулт: Чингэхэд хүрвэл тэд нар ч мөн нүд болоод зүлэг ногоо тэргүүтэн бүдүүн бараг зүйлийн нэрийтгэл мөн хэмээн үзэх учраас өөрийн чанар үгүйг оночих болох нь ээ. Ийм байж таарах уу?Ингэж үзвээс өөрийн тангарагтай ч харшлах ба зүлэг ногоо тэргүүтнийг үнэхээр бүтээгүй гэж нотлох хэрэггүй болно. "Нүгэл буяны үйлийн мөрийг огоот төгсгөн гүйцээхэд үргэлжлэл байх хэрэгтэй. Үргэлжлэл нь өөрийн мөн чанаргүй гэж үзэхэд Харибадраагийн *"Утгыг тодруулагч тайлбар" –аас:*

Зүүдтэй адил шүү гэхээр арван хар нүгэл ба өглөг тэргүүтнийг үгүйсгэх бий. Нойр хүрээгүй сэрүүн үе чинь нойрсох үетэй адилгүй биз дээ,

хэмээн тэдгээрийн үнэхээр бүтээгүй чанарыг зүүдтэй адилтгаж Төв үзэлтний өгүүлэхэд эсэргэлдэх нь утгагүй. Тиймээс "бодит өгүүлэгч" нарын ёсны үнэмлэхүй, янагуух утгууд бүтэх, эс бүтэх хийгээд, "төв үзэлтний" ёсны үнэмлэхүй, янагуух утгууд бүтэх, эс бүтэх зэрэг ойлголтууд хоорондоо

таарахгүй байх нь элбэг үзэгдэнэ. Тэдний янагуух гэж тооцох зүйлс нь Төв үзэлтэнтэй харьцуулахад үнэмлэхүй болох юмуу, эсвэл тэдгээрийн үнэмлэхүй гэх зүйлс нь Төв үзэлтнээ янагуух болоход харшлахгүй тул тэдгээрийг ялгаж мэдэж аваарай.

Мөн тэдний үзэх нэрийтгэлийн бодгаль ба энэхүү багшийн (Нагаржуна) нэрийтгэлийн бодгаль хоёрын нэр нь адил ч утга нь адилгүй байна. Багш бээр тэдэнд "бодгалийн би-үгүйг оносон үзэл" байхгүй гэж үзжээ. "Номын би-үгүй чанарыг эс оновоос бодгалийн би-үгүйг эс онох" хэмээн болгоосон учраас тийн ажээ. Иймээс "Цогцосыг эдэд буй" хэмээх тогтсон тааллыг орхиогүй тэр хүртэл "бодгалийн эдэд буй" хэмээн барина" гэж энэхүү багш бээр болгоох тул тэд нар нь бодгалийг үнэхээр бүтээгүй хэмээн оножчадаагүй ажээ.

10

ХОРИГДОХУУН УТГАА БУРУУ ТОДОРХОЙЛСОН НЬ

б) Хоосон чанарыг бодитой нотлон буулгах

(1) Учир шалтгааны хоригдохууныг (хаагдахуун) танин барих
(а) Хоригдохуунаа сайтар мэдэхийн учир шалтгаан
(б) Хоригдохуунаа ухааралгүйгээр хорино гэх бусдын ёсыг хорих
1/ Хоригдохуунаа хэтэрхий хэтрүүлэн тайлбарласныг хорих
а/ Үзэл баримтлалыг өгүүлэх
/а/ Төв үзэлтний ялгамжааг танин барих

---oOo---

б) Хоосон чанарыг бодитой нотлон буулгахад гурав:

(1) Учир шалтгааны хоригдохууныг (хаагдахуун) танин барих

(2)Тэрхүү хоригдохууныг Өөрийн үндэст (Сватантрика) болон Хэтрүүлэгч (Прасангика) төв үзэлт нарын ёсноо хэрхэн үзэх

(3) Түүнээ түшиж үзэл онол үндсэнд төрөх ёсон

(1) Учир шалтгааны хоригдохуун (хаагдахуун)-ыг танин барихад гурав:
(а) Хоригдохуунаа сайтар мэдэхийн учир шалтгаан
(б) Хоригдохуунаа ухааралгүйгээр хорино гэх бусдын ёсыг хорих
(в) Өөрийн ёсны хоригдохууныг танин барих ёсон

(а) Хоригдохуунаа сайтар мэдэхийн учир шалтгаан

Үлгэрлэвээс "энэхүү бодгаль буй бус" гэдгийг мэдэхийн тулд үгүйсгэгдэх үндэс болсон тэрхүү бодгаль чухам яагаад буй болох" болсныг мэдэх хэрэгтэйн адилаар, "би-үгүй" болоод "өөрийн мөн чанар үгүй" хэмээх утгыг онохын тулд ч үгүйсгэгдэх үндэс болсон "би" болоод "өөрийн мөн чанар" хэмээх тэдгээр учрыг сайтар тунгааж ойлгох хэрэгтэй. Ер нь хоригдохуун утгаа сайн ухаарахгүй бол хэдий үгүйсгэвч утгаа зөвөөр магадалж чадахгүйд хүрдэг учиртай. *"Бодисадвын явдалд орохуй"*-гаас:

Нэрийдсэн утгаа эс ухаарваас
Түүний бодит бус утгыг барих бус

хэмээн айлдсан мэт болой. Харилцан адилгүй хоригдохууны ялгал тоолшгүй

олон боловч товч хураангуйлан язгуураас нь хорьж чадвал хоригдохуун бүхнийг няцааж болно. Харин хоригдохууны хамгийн нарийн язгуураас нь няцааж чадалгүй үлдээчихвэл "буйн хязгаар"-т унах ба "буй-д барих" шунал төрснөөр сансраас гэтэлж чадахгүйд хүрнэ. Бас дэндүү хэтрүүлж хоригдохууны хэр хэмжээг мэдэлгүй, үгүйсгэж хорих аваас үйлийн үр болон шүтэн барилдахуйн утга хүртэл байхгүй гэх зэрэг "тасархайн хязгаар"-т унах ба энэ үзлээр явсаар муу заяанд хөтлөгдөх болдог.

Чингэхлээр хоригдохуунаа сайтар ойлгож авах нь маш хэрэгтэй. Түүнийг эс мэдвээс л нэг бол мөнхийн үзэл, нөгөө бол тасархайн үзэл лавтайяа төрдөг байна.

(б) Хоригдохуунаа ухааралгүйгээр хорино гэх бусдын ёсыг хориход хоёр:

1/ Хоригдохуунаа хэтэрхий хэтрүүлэн тайлбарласныг хорих

2/ Хоригдохуунаа хэтэрхий явцуу тайлбарласныг хорих

1/ Хоригдохуунаа хэтэрхий хэтрүүлэн тайбарласныг хориход хоёр:

а/ Үзэл баримтлалыг өгүүлэх

б/ Тэдгээр нь үл таарах ёсыг үзүүлэх

а/ Үзэл баримтлалыг өгүүлэх

Эдүгээ төв үзлийн утгыг өгүүлэх ихэнх хүмүүс бээр төрөх зэргийн мөн чанараар бүтэх ба эс бүтэхийг ажиж шинжлээд ирэхэд дүрсээс эхлээд хамгийг болгоогчийн таалал хүртэлх хамаг ном бүгд эвдрэнэ гэнэ. Алин ам авсан зүйлээ ухаанаар шинжиж ажиглаад ирэхэд шинжлэлд тэсэж үлдэх зүйл тоосон төдий ч байхгүй.

Буй, буй бус зэргийн дөрвөн талаас нь шинжихэд бүгд хоригдох бөгөөд түүнд багтаагүй ном гэж үгүй болой. Мөн хоосон чанарыг болгоогч хутагтынн бэлгэ билгээр төрөх, түрдэх ба хүлэгдэх, тонилох (сансар нирваан) гэж юу ч үгүй хэмээн болгоодог тул үүгээр жишиж үзэхэд "төрөх тэргүүтэн байхгүй" болно. "Хэрвээ төрөх тэргүүтнийг буй" хэмээвээс, түүний мөн чанарыг шинжих ухаанаар шинжлэхэд тэсэх үү, эс тэсэх үү? хэмээсэнд тэснэ гэвэл ухааны шинжлэлд тэсэж үлдсэн бодит зүйл байх хэрэгтэй болж үнэнээр бүтсэн болоход хүрнэ.

Шинжлэлд эс тэснэ гэвэл ухаанаар эвдрэх гэсэн утгатай таарах буюу. Тэрчлэн төрөх тэргүүтнийг буй гэж үзвээс шалгадаг ухаанаар бүтсэн үү, эс бүтсэн үү? Эхний дагуу үзвээс хоосон чанарыг болгоох билгэ билгээр төрөх

үгүй болохыг болгоосон тул магад бүтсэн гэж болохгүй. (Эсвэл) нэрийдлийн харах мэдрэхүй зэргээр бүтсэн гэж үзвээс тэдгээрийг шалгадаг ухаан болохыг хорисон учир тэдгээрийг бүтээгч (нотлогч) шалгадаг ухаан" гэж үзэж таарахгүй байна. *"Бясалгалын хаан судар"*-аас:

Нүд, хамар, чих ч шалгадаг ухаан бус
Хэл, бие, сэтгэл ч шалгадаг ухаан бус
Хэрвээ эрхтэн тэдгээр шалгадаг ухаан болвоос
Хутагтын мөр хэнд, юунд хэрэгтэй вэ? хэмээжээ.

"Орохуй"-д ч: "Намба төрх бүгдийг ертөнцийн шалгадагаар бус" хэмээн айлдсан учиртай. Шалгадагаар эс бүтсэн бол буй хэмээн үзэхийг өөрөө ч үл баримтлах бөгөөд ухаанд ч зохисгүй тул үл таарна. Хэрвээ төрөхүйг буй гэчихээд үнэхээр гэж үзэлгүй харин янагуухи гэх хэрэгтэй гэвэл энэ ч бас таарахгүй. *"Орохуй"*-гаас:

Тэр ямагтын үест аливаа нэг ухаанаар
Өөрөөс болоод бусдаас төрөх нь зохисгүй буюу
Тэрхүү ухаанаар янагуух болох ч зохисгүй тул
Таны баримтлах төрөхүй гэдэг алин мөн вэ?

хэмээн "үнэхээр төрөх"-ийг хорих ухаанаар янагуухийг хорьсон болохыг айлджээ.

Мөн "өөрөөс, бусдаас" зэрэг дөрвөн зүйлийн алин нэгнээс төрөхгүй боловч "төрөх" гэж үзэх нь үнэхээр төрөхийг хориход дөрвөн талаас шинжлэн хорьсноор ч үл няцаагдах буюу тэдгээрийн алин ч болохгүй "төрөх" бий. Дөрвөн талын алин нэгнээс төрөх болвол бусад гуравт үл тооцогдох учраас "бусдаас төрөх" гэх тэр ч таарахгүй гээд *"Орохуй"*-гаас: "Бусдаас төрөх гэдэг ертөнцөд ч байхгүй" хэмээн айлджээ. Тиймээс төрөхүйг хориход "үнэхээр" хэмээх ялгалыг найруулах шаардлагагүй аж. *"Тодорхой үгт"-ээс:*

"Үнэхээр" хэмээх ялгал хийхийг хориглосон болой. Энэ талаар зарим нэгэн бээр төрөх тэргүүтнийг нэр томъёо төдийд ч байхгүй гэдэг. Нөгөө нэг нь нэр томъёо төдийд байна гэж үзнэ. Бүгдээр ийн хэмээн ухааны үүднээс ном, юмст өөрийн мөн чанараар бүтсэн араншинг хорино гэдэг эл багшийн ёсноо осолгүй бөгөөд хоёр үнэн хоёулаа өөрийн мөн чанараар бүтсэнийг хорьсон учраас буюу. Тэр мэтээр өөрийн мөн чанар үгүй учраас түүнээс цааш юу байх билээ. Ийм

болохоор хоригдохуунд үнэхээр ялгалыг найруулах нь зөвхөн “Өөрийн үндэст” хэмээх төв үзэлтний ёс болно” хэмээн хоолойгоо засаж номножээ.

б/ Тэдгээр нь ул таарах ёсыг үзүүлэхэд хоёр:

/1/ Тэр ёсныхон төв үзлийн нийт бусын ялгамжааг хорихыг үзүүлэх

/2/ Эсэргэлдэн өгүүлэгч нараас сөхөөж эс чадахыг үзүүлэх

/1/ Тэр ёсныхон төв үзлийн нийт бусын ялгамжааг хорихыг үзүүлэхэд гурав:

/а/ Төв үзэлтний ялгамжааг танин барих

/б/ Тэдгээр ёсоор түүнийг хэрхэн хорьсон нь

/в/ Түүнээ Төв үзэлтэн хэрхэн хариу тавьсан нь

/а/ Төв үзэлтний ялгамжааг танин барих

“Ухааны жаран шүлэгт”-ээс:

Төрөлхтөн бүхэн энэхүү буянаар
Бинавад болоод билгэ билгийн буяныг хурааж
Бинавад болоод билгэ билгээс төрөх
Хоёр дээд лагшинг олох болтугай

хэмээн айлдсан мэт их хөлгөнөө зорчих шавь нар бээр үрийг олохын үест (бурханы хутагт хүрэхэд) номын дээд лагшинг ба дүрст дээд лагшинг олох бөгөөд энэ нь мөрийн үест заасан дагуу арга, билиг хоёр хосолсон бинавадын болон бэлгэ билгийн хэмжээлшгүй их буяны чуулганыг хэрхэн хураахаас хамаарна.

Чингэхдээ янагуухийн шалтгаан нөхцөлөөс үүдэж тустай, гэмтэй үр дагавар энэ хийгээд энэ төрнө хэмээх үйлийн үрийн барилдлагыг язгуураас нь сайтар ухаарах буюу янагуухийн тухай магадлал нэгийг олох ба ном бүгд өөрийн мөн чанараар бүтсэн гэж тоосон төдийд ч байхгүйг сайтар ухаарах зэрэг үнэмлэхүйг ойлгох ухаан олсон зэргээс ч хамаарна. Энэ хоёулаа байхгүй аваас арга, билиг хоёулангийн зам мөр ул бүрдэхэд хүрч жинхэнэ ёсоор суралцсанд тооцогдохгүй.

Чингээд энэхүү явдал мөр нь үр болж гарах хоёр лагшинг олохын үндэс болж, мөрийн аньсыг эндүүрэлгүй оносон суурь үзэл онолоо хэрхэн нотлон буулгахад харгалзана. Иймийн учир үзэл онолыг нотлон буулгах ёс болвоос энд үзүүлэх хоёр үнэнийг магадлан ухаарах явдал билээ. Үүнийг

төв үзэлтнээс бусад бодгаль хэн бүхэн харшуулж үзэх бөгөөд үл харшлах ёсыг олж чадаагүй байна.

Нарийн ухаарал, саруул оюун төгөлдөр мэргэн ухаант Төв үзэлт хэмээх тэрбээр хоёр үнэнийг онох аргад мэргэн тул огт харшлахын хиргүйгээр нотлон буулгаж ялгуугсаны таалльн оройд хүрсэн бөлгөө. Түүнээ шүтэн байж өөрийн багш болон номонд машид гайхамшигт бишрэл хүндэтгэл төрсөн учраас гулзгай хуудам гэмээс ангижирсан болно. Иймээс "Ухаантан нар аа" Өөрийн мөн чанараар хоосон байх гэдэг чинь шүтэн барилдаж гарсан утга мөн буюу. Тус хэрэг үйлдэх чадлаас хоосорсон бодас байхгүй гэсэн утга бус болой" хэмээн яруу тод дуугаар дахин дахин дуурсган зохиодог.

Ухааны олон оронд сайтар мэргэжсэн манай аймгийн бодит өгүүлэгч нар Төв үзлийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд тэд "хамаг ном өөрийн мөн чанараар ерөөс бүтэхгүй хоосон болчихвол хүлээс тонилохуй зэрэг сансар, нирваны ухагдахуун бүгдийг томъёолж болохгүйд хүрнэ" гээд зөвхөн энэ тал дээр Төв үзэлтэнтэй тэмцэлддэг. Энэ тухай *"Үндсэн билиг"*-ээс:

Хэрвээ эдгээр бүгд хоосон болчихвол
Төрөх ч үгүй, түрдэх ч үгүй болюу
Хутагтын дөрвөн үнэн тэдгээр ч
Таны ёсноо үгүйсгэгдэн хэтийдэх

хэмээн өөрийн мөн чанараар хоосон байх аваас төрөх, түрдэх хийгээд дөрвөн үнэн үгүйсгэгдэнэ гэх ба *"Тэмцлийг няцаагч"*-аас:

Хэрвээ хамаг бодит зүйлсийн
Өөрийн мөн чанар огтоос үгүй болвоос
Таны үг ч гэсэн мөн чанаргүй болох тул
Мөн чанарыг няцааж үл чадах

хэмээн үг нь мөн чанаргүй болчих тул мөн чанарыг хорих буюу мөн чанар үгүйг баталжчадахгүй гэжээ.

Тиймээс өөрийн мөн чанар үгүй болчихвол үйлдэгдэхүүн үйлдэгч болоод хорих бүтээх зэргийн үйл үйлдвэр таарахгүй болно гэж үзэж тэмцэлддэг бөлгөө. Үүнээс болоод мөн чанарыг хорих учир шалтгаан нь үйл үйлдвэр бүхнийг үгүйсгэж байна гэж ухаарч эсэргэлцэх ажгуу. Ийнхүү Бодит өгүүлэгч болоод Төв үзэлтэн хоёр нийт бусын тогтсон тааллын ёсны онолын хувьд тэмцэлдэх буюу. Мөн чанараар хоосон болоход (үүнд) сансар нирваны ухагдахуун бүгд агуулагдаж болох уу? үгүй юу гэдэг зөвхөн энэ асуудал дээр л тэмцэж иржээ.

Өөрийн мөн чанараар бүтэх гэдэг тоосон төдий байхгүй хэдий ч төрөгдөхүүн ба төрүүлэгч, хаах ба бүтээх зэрэг сансар, нирвааны агуулга бүгд оршин байж болохыг хүлээн зөвшөөрөх нь Төв үзлийн гол онцлог ялгамжаа юм. Үүнийг *"Үндсэн билгийн хорин дөрөвдүгээр бүлэг"*-т:

Гэмтэй хэтийднэ гэж үзэхдээ
Хоосон учраас байж болохгүй гэх тул
Та хоосон чанарыг огоорогч болно
Таны тэр чинь надад буй бус аа

Алин хоосон чанарт мөн аваас
Түүнээ бүгд оршин байх мөн
Хэрвээ хоосон чанарт бус бөгөөс л
Түүнээ хамаг зүйлс үл орших бүгд

хэмээн "Хэрвээ тэр бүхэн хоосон аваас" хэмээх тэргүүтний "гэм буруу" нь ч өвөрчлөн чанараар бүтээгүй гэж өгүүлэгч нарт ч үл гарахаар зогсохгүй өвөрчлөн чанараар хоосны зүгт л төрөх, түрдэх тэргүүтэн оршин байх аж. Харин өөрийн мөн чанараар хоосроогүй зүгт байж болохгүй аж. Энэ талаар *"Тодорхой үгт"*-ээс:

"Бидний ёсноо тийн өгүүлсэн гэм хэтийдэл үл гарахаар барахгүй, харин ч үнэн тэргүүтний ухагдахуун бүгдээр машид таарах болно" хэмээн айлдаад "Алин хоосон чанарт болвоос" тэргүүтний эш зарлигийг үзүүлэн номложээ.

Үүнийг Төв үзлийн *"Үндсэн билгийн хорин зургаадугаар бүлэг"-ээс*: "Арван хоёр шүтэн баридахуйн "ёсоор гарах" буюу төрөхүйн зэрэг болон "ёсноос буцах" буюу түрдэхүйн зэргээр үзүүлжээ. *"Хорин тавдугаар бүлэг"-ээс:* "Мөн чанарыг голлон хорих ёсыг" үзүүлжээ. *"Хорин дөрөвдүгээр бүлэг"-т:* "Хутагтын дөрвөн үнэнийг шинжлэх үүднээс буюу мөн чанараар хоосон биш бол сансар, нирвааны ухагдахуун бүгд оршиж болохгүйн ёс болоод мөн чанараар хоосон байгаа учраас л тэдгээр бүгд оршиж байгаа ёсыг дэлгэрэнгүй нотлон үзүүлжээ. Энэ бүлэг нь бусад бүх бүлгээ ойлгуулж ухааруулах хөтлөгч болжээ.

Эдүгээ Төв үзлийн утгыг өгүүлэхийг хүсэгч нар аа! Өөрийн мөн чанар байхгүй болвол төрөгдөхүүн, төрүүлэгч зэрэг нөхцөл шалтгаан, үр дагавар байхгүй байх албатай мэтээр өгүүлэх нь бодит өгүүлэгч нарын ёс болно. Тиймээс Нагаржунай багшийн болгоол болох энэхүү үндэс шалтгаан зэрэгт шүтэн байж, энэхүү үр дагавар төрөх ба түрдэх жамт ба энэхүү шалтгаан

үрийн агуулгад шүтэх учраас л өөрийн мөн чанараар хоосон байна хэмээх төв үзлийн замыг эрэлцэх хэрэгтэй. *"Хорин дөрөвдүгээр бүлэг"-ээс:*

Алин шүтэн барилдаж гарсан түүнийг
Хоосон чанарт хэмээн номложээ
Тэр нь шүтэж оршихыг нэрлэсэн агаад
Тэр нь Төв мөр мөн болой

Алин шүтэж эс гараагүй
Ном хаана ч үгүй
Тиймээс хоосон чанаргүй
Ном хаана ч үгүй буюу

хэмээн шүтэн барилдаж гарсан л бол өөрийн мөн чанараар хоосон болох жам ёстойг айлджээ. Энэ айлдварт шалтгаан нөхцөлд шүтэн байж төрсөн болохоор өөрийн мөн чанараар бүтэх ёстой гэдгийг няцааж чингэж өгүүлэх ёсгүй болохыг *"Тэмцлийн няцаагч"-аас:*

Алин энд хоосон чанар байгаа цагт
Түүнээ учир шалтгаан бүхэн буй
Алин хоосон чанар буй бус болвоос
Түүнээ юу ч үгүй болох

Алин хоосон болоод шүтэн гарсан лугаа
Төв үзлийн мөр нэгэн утгат болохыг
Эрхэмлэн зарлигласан ханьцашгүй бурхан
Танаа мөргөмү хэмээсэн ба,

"Хоосон чанарын далан шүлэгт" –ээс:

Хамаг бодит зүйлс (бодас) өөрийн мөн чанараар
Хоосон мөн болох нь бодит зүйлс
Шүтэн барилдаж гарснаас хэмээн
Ханьцашгүй бурхад чухалчлан үзүүлэв хэмээсэн ба,

"Ухааны жаран шүлэгт" –ээс:

Алин хэн бээр үл шүтэлцэх
Би болоод ертөнц хэмээн илт шунаваас
Аяа, тэдгээр л мөнх, мөнх бус тэргүүтний
(Туйлшрах) үзэл баримтлалаар булаагдах буюу
Алин бодит юмс шүтэн байж

Тэр л чанарт бүтнэ гэж үзэгчид ба
Тэдгээр бүхэнд мөнх гэх зэргийн алжаас гэм
Алин тэр бүхэн яахин төрөх

Алив шүтэлдэх бодит зүйлсүүд
Усан доторх саран адилд
Үнэн бус болохын эндүүрэлгүй
Үзэгч нар тэдгээр үзлээр үл булаагдах хэмээсэн ба,

"Ертөнцөөс нөгчигсөн магтаал"-аас:

Зовлонг өөрөө бүтсэн болоод
Өрөөлөөс бүтсэн, бас хоёулангаас бүтээсэн ба
Учир шалтгаангүйгээр ч буй хэмээн "Хашрууд" үздэг
Та бээр шүтэн барилдаж төрсөн хэмээжээ

Шүтэн барилдаж гарсан түүнийг
Та хоосон чанарт хэмээн болгоожээ
Бодит зүйлс өөрийн эрхгүй хэмээх
Ханьцашгүй таны арслангийн дуу

хэмээн шүтэн барилдсан мөн учраас л зөвхөн өөрийн мөн чанараас хоосон болохыг зарлиглажээ. Ийнхүү шүтэн барилдахуйн утга болвоос өөрийн мөн чанаргүй хоосон чанарын утга мөн хэмээх номнол нь Хутагт Нагаржунай багшийн нийт (ер) бусын ёс болой.

Тиймээс өөрийн мөн чанаргүй буюу хоосон чанарт болохыг Төв үзэлтний талаас авч үзсэн гэх буюу шүтэн барилдахуй болоод учир шалтгаан зэргийн ухагдахууныг өөрийн ёсноо найруулж амар хялбар болгоод бусдад (тулгаж) хүргэхийг шүтэн барилдахуйн утга гэсэн бус. Харин "алин хоосон болсон түүнд л" хэмээсэн мэтээр алин өөрийн мөн чанар байхгүй хэмээх тэр л ёсноо сансар, нирваны шүтэн барилдлагад багтана гэж айлдсан хэрэг ээ.

11

ШҮТЭН БАРИЛДАХУЙ БА ХООСОН ЧАНАР

/б/ Тэдгээр ёсоор түүнийг хэрхэн хорьсон нь
/в/ Түүнээ Төв үзэлтэн хэрхэн хариу тавьсан нь

Чингэвээс хоосон чанарыг баримтлах ёсноо сансар, нирваан бүгдээр хэрхэн таарах вэ? Хамаг бодасыг өөрийн мөн чанараар хоосон гэж өгүүлэх нь шүтэн барилдаж гарсан тул ийн өгүүлж тийн номносон болой. Тиймээс шүтэн барилдах тэр утганд л таарах хэрэг. Тийн таарах учраас зовлон ч оршиж таарна. Зовлон гэдэг шалтгаан нөхцөлд шүтэн байж л үүддэг учиртай. Шүтэн барилдаж гараагүй бол зовлон гэж орших учиргүй. "Зовлонгийн үнэн" орших болохоор түүний үүдэх үндэс-"хотол гарахуй" (үйл нисванис) болон тэрхүү зовлонг хорих–"хорихуй үнэн" (амирлангуй) болон түүнд хүргэх-"мөр" ч орших болж "дөрвөн үнэн" буй болох буюу.

"Дөрвөн үнэн" орших болсноор тэдгээрийг мэдэх, тэвчих, илт үйлдэх, мөр бясалгах явдлууд ч мөн орших болно. Тэдгээр орших болохоор чухаг дээд гурав тэргүүтэн ч бүгдээр орших болно. Энэ талаар *"Тодорхой үгт"-ээс:*

Алин хамаг зүйлс өөрийн мөн чанараар хоосон ямагт болсон үед л алин өгүүлэн буй бүгд орших болой. Хэрхэн хэмээвээс, учир нь бид нар шүтэн барилдаж гарсныг хоосон чанарт хэмээн өгүүлдэг. Алин илт хоосон чанар болсон тэр л шүтэн барилдсан болно. Алин шүтэн барилдаж гарсан түүнд л хутагтын дөрвөн үнэн буй гэж мэдээрэй. Хэрхэн хэмээвээс, шүтэн барилдаж гарсан учраас зовлонт буюу эс шүтэн барилдаж гарваас тийн бус болой. Тэр нь өөрийн мөн чанар үгүй учраас хоосон болой. Зовлон буй болохоор зовлонгийн (шалтгаан) "хотол гарахуй" ба зовлонг "хорихуй" болон "хорихуй"-д одох "мөр" ч оршино. Тийм учир зовлонг огоот мэдэх, хотол гарахуйг тэвчих, хорихуйг илт үйлдэх бөгөөд мөрийн бясалгал ч орших болно. Зовлон тэргүүтэн үнэнийг огоот мэдэх зэрэг орших аваас л үр дагаварууд орших болно. Үр буй аваас "Үрд оршихуй" ч буй болно. "Үрд оршихуй"-нууд буй аваас "Орогч нар" ч буй болно. "Үрд оршигч" болоод "Орогч" нар буй аваас "Буянд дурлагч" хувраг тойн орших болой. Хутагтын дөрвөн үнэн байх аваас дээдийн ном орших болно. Дээдийн ном болоод хувраг тойн буй аваас бурхан ч орших болно. Иймээс чухаг дээд гурав ч орших болно. Ертөнц хийгээд ертөнцөөс нөгчигсөн хамаг ном бүгд хийгээд ялангуяа онохуй ухаан бүгд ч орших болно. Буян, нүгэл тэдгээрийн

үр дагавар болоод ертөнцийн томъёо агуулга бүгд орших болно. Тийм учраас тийнхүү алин хоосон чанарт болсон түүнд л хамаг бүгд орших буюу. Алин хоосон чанаргүй болвоос л түүнээ шүтэн барилдаж гарах зүйлгүй болох учраас хамаг бүгд оршихгүй болюу хэмээн айлджээ.

Орших ба эс орших гэдэг тэдгээрийг буй хийгээд буй бусыг өгүүлж буй гэж ухаараарай. Дээр өгүүлсэн "Тэмцлийг няцаагч"-ийн тэмцлийн хариуд ч өөрийн мөн чанаргүй байвал л үйл үйлдвэр оршино хэмээх хариуг (Нагаржунай) багш тодорхой айлдсан байна. *"Тэмцлийг няцаагч"-аас:*

Алин шүтэн барилдаж гарсан бодас
Тэдгээр л хоосон чанарт хэмээгдэх ба
Алин шүтэн барилдаж гарсан түүнийг
Өөрийн мөн чанаргүй (үгүй) хэмээн өгүүлэх хэмээжээ.

Түүнийг /Нагаржуна багшийн "Тэмцлийг няцаагч"-д хийсэн/ *"Өөрийн тайлбар"-аас ч:*

Та нар бодит юмсийн хоосон чанарын утгыг ухааралгүйгээр "Таны үг өөрийн мөн чанаргүй тул бодит юмсийн мөн чанарыг хорьж таарахгүй хэмээн гэм алдааг хайж өгүүлдэг билээ" гээд "Энэ үест бодит зүйлсийн шүтэн барилдаж гарсан алин тэр л хоосон чанар мөн бөлгөө. Яагаад гэвэл, өөрийн мөн чанар үгүйн учраас буюу. Алин шүтэн барилдаж гарсан бодит зүйлс өөрийн мөн чанартай бус буюу. Мөн чанараас бүтэх гэж огт байхгүй л дээ. Яагаад гэвэл, шалтгаан болоод нөхцөлд харгалзах учраас болой. Хэрвээ бодас юмст өөрийн мөн чанар буй аваас шалтгаан нөхцөл байхгүй байсан ч оршиход хүрнэ. Тийм байдал огтоос байхгүй учраас өөрийн мөн чанар үгүй буюу хоосон чанарт хэмээн номнов.

Түүнчлэн миний үг ч шүтэн барилдаж гарсан агаад тийм учраас өөрийн мөн чанар үгүй болой. Өөрийн мөн чанар үгүйн тул хоосон чанарт хэмээх нь таарна. Хэрхэн хумх болоод цэмбэ тэргүүтэн шүтэн барилдаж гарсан тул мөн чанар хоосон боловч зөгийн бал, ус, сүү зэргийг хөөрүүлж буцалгахад халуун, хүйтэн болон агаар салхи, нар зэргээр тэтгэж туслахтай адилаар миний үг ч гэсэн шүтэн барилдаж гарснаар өөрийн мөн чанар үгүй хэдий мөн ч бодас юмс өөрийн мөн чанар үгүй болохыг машид бүтээж чадах бөлгөө. Тиймээс "таны үг өөрийн мөн чанаргүй учраас хамаг бодас юмсын өөрийн мөн чанарыг хорьж таарахгүй гэж хэлэх чинь зохисгүй болно" хэмээн мөн чанараар бүтвээс

шалтгаан нөхцөлд харгалзахгүйд хүрэх ба шалтгаан нөхцөлд харгалзах учраас өөрийн мөн чанаргүй байх жамыг дагаж, "өөрийн мөн чанаргүйн үгээр" л бүтээх хорихын үйлийг үйлдэж чадах учиртай" гэж машид тодорхой зарлиглажээ.

Шалтгаан нөхцөлд шүтэн байж л хотол нисваанисын болоод асар арилсан ном юмс төрөх, түрдэхийн шүтэн барилдлагаар орших ба өөрийн мөн чанар үгүй болох хоёр нь сууръ зохилдож хурах нэгэн бэлгээ. Үгээр зогсохгүй, тэр адилын шүтэн барилдах мөн чанар бол өөрийн мөн чанаргүй мөн гэж онох энэхүү хосгүй учир шалтгаанд одох нь зөвхөн Төв үзэлтний ялгамжаат ном гэдгийг мэдээрэй. Шүтэн байж төрөх, шүтэн байж түрдэх ёсыг өөрийн мөн чанараар бүтэх "ёст" мэт барьж, мөн чанарыг хорьсон ухаанаар төрөх, түрдэхийн шүтэн барилдахуйг няцаана гэвэл "Бурхан нь буг чөтгөр болж буух" гэсний үлгэр болж Төв үзлийн утгыг зүй ёсоор онохын их тотгор болмуй за.

Тиймээс хамаг юмст өөрийн мөн чанараар бүтсэн (өвсбээн бүтсэн) мөн чанар гэж тоосон төдийд ч байхгүй гэх ойлголт төрөхөд шалтгаан нөхцлийн барилдлагатай гэх ойлголт төрөх учрыг өөрийн ёсноо үгүйсгэвээс бусдын нигуурыг харах хэрэгтэй болно. Өөрийн ёсны шалтгаан нөхцлийн тухай сайн ойлгосон боловч өөрийн мөн чанар байхгүй талаар өөрийн ёсны ойлголт олоогүй байтлаа хоосон чанарын утгыг мэдчихлээ гэж яривал төв үзлийг эдүгээ болтол олоогүйн шинж гэж ойлгоорой. Үзэл онолыг олох үндэс бол ам авсан шагшаавадаа ариунаар сахихын үүднээс буян хураах, нүглээ арилгахын үйлд олон зүйлээр шамдах ба мэргэд дээдсийг шүтэж сонсох, санах зэргээр хичээх явдал буюу. Тийнхүү үзэгдэл ба хоосон чанарыг таньж мэдэж тэр хослуулан барих нь "өдрийн од шиг" хааяа нэг тул төв үзлийг олно гэдэг маш их бэрхтэй буюу. Энэ талаар *"Үндсэн билгийн хорин дөрөвдүгээр бүлэг"*-т:

Тийн сулруулваас энэхүү номын ёзоорыг
Оноход бэрхтэйг болгоон таалж
Чадагчийн таалал, үзүүлсэн номоос
Машид буруугаар урвах бий хэмээсэн ба,

"Их эрдэнийн эрхи"-ээс ч:

Ариун бус, мөнх бусын жамт энэхүү бие
Энгийн илт мэдлийн орон (боловч)
Мөнх хэмээн үзэх тэр цагт ч,
Сэтгэлд орших орон бус

Тэр цагт дээдийн ном орших бус
Нарийн илт мэдлийн орон бус
Гүн гүнзгий энэ бүгдийг хэрхэн
Сэтгэлд амар буух билээ

Энэхүү ном гүн учир
Ардууд мэдэхэд бэрхтэй бөгөөд
Тиймээс Чадагч бурхадын
Үзүүлсэн номыг буруу ойлгох

хэмээн эрхэм зарлиг судар шастараас онож ухаарахад амаргүй болохыг айлджээ.

Чингэлгүй гол ном сударт ухаарсан гэх заримууд бээр хумх тэргүүтэн өөрийн гишүүнтэй нэг, эсвэл тусдаа утгат болохыг ажиглаж шинжсэнээр өөрийн мөн чанаргүйн утгыг нотлон буулгана гэж айлдсан утгыг эндүүрч, хумх тэргүүтнийг цорго, хүзүү тэргүүтнээс өөрийн үе гишүүдээс хайж шинжээд тэдгээрийн алинд ч олдохгүй болохоор "хумх байхгүй" гэж ойлгох бий. Цаашлаад шинжээчийг ч гэсэн тийм байдлаар шинжихэд "шинжээч байхгүй" гэж ойлгох ч бий. Ингээд шинжээч олдохгүй болох цагт "хумх тэргүүтнийг байхгүй" гэдгийг хэн мэдэх юм гээд байгаа ч биш, байхгүй ч биш гэж өгүүлэх зэргийн гулзгай эндүү ташаа ойлголт авчихаад үзэл онол оллоо гэвэл, энэ л хуудам нэгэн болж үзэгдэнэ.

Тиймд ухаантан мэргэд нар аа! Үнэн утгат эрхэм зарлиг болоод түүний утгыг тайлсан тайлбар шастарууд болон төв үзлийн зөв гол номлол суртгаалуудаас "хоосон чанарын утга бол шүтэн барилдахуйн утга" хэмээн айлдсан нь ухаант Төв үзэлтний гол ялгамжаа болой. Ялангуяа Буддхапалида, Чандракирти багш нар бээр хутагт эцэг, хөвгүүдийн таалал бүгдийг үлдээлгүй тайлсан хамгийн нарийн орон болсон шүтэн барилдахуйд суурилж өөрийн чанар байхгүй гэж ойлгож мэдэх ёс ба өөрийн мөн чанараар хоосон болох нь шалтгаан үр дагавар болж ургах ёсноос өөр бусдаар хөтлөгдөх учиргүй гэдэг магадлалыг ухаараарай.

/б/ Тэдгээр ёсоор түүнийг хэрхэн хорьсон нь

Тэр адил Нагаржуна багшийн ёсноо ном, юмс өвөрчлөн (өөрийн мөн чанараар) чанараар бүтэх гэж тоосон төдийд ч байхгүй гэнэ. Хэрэв өвөрчлөн чанараар бүтэх болвоос сансар, нирваны агуулга оршихгүйд хүрнэ. Тэрхүү агуулгыг хүлээн зөвшөөрөхгүй байх аргагүй бөгөөд хүлэгдэх, гэтлэх зэрэг агуулга бүхэн түүнд магадтай багтах учраас өвөрчлөн чанар байхгүй гэж

хүлээн зөвшөөрөх шаардлагатай. "Та нар бодит зүйлст өвөрчлөн чанар байхгүй болохоор өөр юу ч байхгүй болно гээд хүлэгдэх, гэтлэх болоод төрөх, түрдэх тэргүүтнийг хаахад "үнэхээр" гэх зэргийн ялгааг найруулах шаардлагагүй, зөвхөн өвөрчлөн чанарыг үгүйсгэх ухаан зэргээр үгүйсгэнэ гэвэл, өвөрчлөн чанар байхгүй түүнээ л хүлэгдэх, гэтлэх, төрөх, эвдрэх тэргүүтний агуулга таарах учраас үгүйсгэхгүй гэж яаж санана вэ.

Эсэргүүцэл: Хэрвээ багшийн тааллаар хүлэгдэх, гэтлэх тэргүүтэн сансар, нирваны агуулга бүгдээр нэр төдий учир бид ч мөн нэр төдий болох нь гэмгүй бус уу?"

Хариулт: Чингэж таарахгүй байна. Энэ талаар Чандракирти багш бээр "Нэр төдийд ч ном, юмс өөрийн мөн чанараар бүтээгүй гэж та ч үздэг. Чингэхдээ өвөрчлөн чанарыг хорих ухаанаар нэрийн төдийд ч байх өвөрчлөн чанарыг хаах хэрэгтэй. Өвөрчлөн чанарыг хорих ухаанаар хүлэгдэх, гэтлэх зэргийг ч хорино гэж үздэг болохоор нэр төдийд ч хүлэгдэх, тонилох тэргүүтнийг хорих нь маш тодорхой болой" хэмээжээ.

Товчилбоос, өвөрчлөн чанар үгүй болон хүлэгдэх, гэтлэх, төрөх, түрдэх тэргүүтэн харшилна гэж үзвээс, өвөрчлөн чанаргүй хоосон чанарт сансар, нирваны хамаг агуулга багтах гэдэг хоёр үнэний алин ч болохгүйд хүрэх тул төв үзлийн нэгэн онцлог түүнийг та хорих болох нь ээ. Тэдгээрийг харшлахгүй гэж үзвээс, мөн чанарыг хорьсон ухаанаар хоригдохуунаа ямар нэг "ялгамж" найруулах шаардлагагүйгээр төрөх, түрдэх, хүлэгдэх, гэтлэх тэргүүтнийг хориход үнэн учир шалтгааны шаардлагагүй. Тиймээс өвөрчлөн чанарыг хорьсон ухаанаар шалтгаан үрийг хорино гэдэг өвөрчлөн чанаргүй болвоос төрөх, түрдэх гэдэг байхгүй гэсэнтэй адил буюу. Иймээс *"Хориндөрөвдүгээр бүлэг"*-ээс:

Хэрвээ тэр бүгд хоосон аваас
Төрөх үгүй ба түрдэх үгүй буюу
Хутагтын дөрвөн үнэн тэдгээрийг
Та үгүйсгэж хэтийдсэн болно

хэмээх тэргүүтнээр бодит өгүүлэгч нарын эсэргүүцлийг тавьсан буюу.

Хэрвээ алив юмсийн бодит
Өвөрчлөн чанар хаана ч үгүй болвоос
Таны үг ч өвөрчлөн чанаргүй байх тул
Өвөрчлөн чанарыг буцааж чадахгүй болой

хэмээн *"Тэмцлийг няцаагч"*-аас бодит өгүүлэгч нарын тэмцлийг үзүүлсэнтэй ямар ч ялгаа байхгүй нь машид тодорхой байна.

Эсэргүүц рдэх байхгүй болвоос бид нарын өвөрчлөн чанараар хоосон, эс хоосны алиныг ч хүлээн зөвшөөрөхгүй байгаа маань зөв юм биш үү?

Хариулт: Таны тэр чинь гол номын утганд огтоос таарахгүй буюу. *"Тодорхой үгт тайлбар"*-аас:

"Бидний ёсноо төрөх, түрдэх тэргүүтэн таарахгүйн гэм огт гарахгүйгээр барахгүй дөрвөн үнэн тэргүүтэн ч таарах мөн" хэмээн номлосон буй.

"*Үндсэн билиг*"-ээс ч, өөрийн мөн чанараар хоосны зүгт ч таарах бөгөөд харин эс хоосон аваас үл таарна гэдгийг сайтар ялган айлдсан нь учиртай. *"Төв үзэлд орохуй"-гаас ч:*

Бодитой хоосон хөрөг, дүрс, тусгал тэргүүтэн (адил)
Чуулганд харгалзах юмс эс алдаршсан ч бус
Хэрхэн тэдгээр хөрөг, дүрс зэргүүд шиг хоосноос
Тэдгээрийг мэдэх сэтгэлийн намба дүр төрөх мэт

Түүний адил бодит бүхэн хоосон хэдий ч
Хоосон чанараас л машид төрөх болюу хэмээн айлджээ.

Мөн хүлэгдэх, гэтлэх тэргүүтнийг ухаанаар хориход үнэмлэхүйн хориг үйлдэлгүйгээр янагуухид хорих хэрэгтэй гээд тэр цагт янагуухид ч сансар, нирваан агуулга бүгдийг хорино гэх тэр адилын төв үзэлтэн урьд ч гараагүй нэгэн билээ.

/в/ Түүнээ Төв үзэлтэн хэрхэн хариу тавьсан нь

Бодас юмс өвөрчлөн чанараар (өөрийн мөн чанаргүй) хоосон болохоор сансар, нирвааны шалтгаан үрийг агуулж болохгүй хэмээх эл тэмцлийн талаар Нагаржунай багш бээр, Төв үзэлтэн нараас гадагш хаях учиртай гэмийг дотогш нь хаялаа гээд няцааж гэмийг гарган тавьжээ. *"Үндсэн билгийн хорин дөрөвдүгээр бүлэг"*-т:

Та өөрийн гэмүүдийг
Миний гэм болгон хөрвүүлжээ
Морио үнэхээр унасан хирнээ
Морио мартах адил болжээ

Хэрвээ бодит зүйлс өвөрчлөн чанараас
Буй хэмээн даган үзвээс

Тэр адилаар бодит зүйлс
Шалтгаан нөхцөлгүй болно гэж Та үзэх хэмээсэн ба,

Хэрвээ энэ бүхэн хоосон бус болвоос
Төрөх үгүй, түрдэх үгүй болюу
Хутагтын дөрвөн үнэн тэргүүтнийг
Та үгүйсгэж хэтийдэх болно хэмээн айлджээ.

Тиймээс өвөрчлөн бүтсэн мөн чанар буй бус (байхгүй) гэхээр, тэгвэл өөр юу байх вэ гэж өгүүлэх энэ чинь ямар ч эргэлзээгүйгээр өөрийн мөн чанар буй бус (байхгүй) болоод ногоо буй бус (байхгүй) гэх хоёрын ялгааг ялгаж мэдээгүйтэй холбоотой нь тодорхой байна. Ногоо буй гэх ба ногоо өвөрчлөн чанараар бүтэх хоёрыг ч ялгаж чадаагүй учраас л буй аваас л өвөрчлөн чанараар буй (байх) ёстой. Эсвэл өвөрчлөн чанараар буй бус (үгүй) болвоос, (ерөөс) буй бус (үгүй) болно гэж үзсэн нь тодорхой байна. Эс чингэвээс өвөрчлөн чанараас бүтсэнийг хорих ухаанаар буй төдий болоод төрөх, түрдэх тэргүүтнийг хэрхэн хорих вэ гэх үү? Тиймээс хэзээ ногоо тэргүүтнийг буй (байна) гэж үзэх тэр хүртэл өвөрчлөн чанараар бүтсэн л гэж өгүүлэх ба өвөрчлөн чанараар бүтэх ерөөс байхгүй гэхээр огт байхгүй юм шиг өгүүлэх нь хоёр хязгаарт (туйл) эргэлзээгүй унах мөн тул бодит өгүүлэгчийн ухааралтай ялгалгүй нэгэн болно. Чандракирти гэгээний *"Дөрвөн зуутын тайлбар"*-т:

Бодит өгүүлэгчийн ёсоор хэзээ бодит зүйлс орших (буй) тэр хүртэл өөрийн мөн чанартай байна. Алин хэзээ өөрийн мөн чанараас хагацах болвол тэр цагт бодит зүйлс "илжигний эвэр" мэт бүгдээрээ үгүй болдог учиртай хэмээн хоёр болгож ярихаас хэтэрдэггүй. Иймээс эдний илт баримтлал бүгдийг жигдлэхэд бэрхтэй хэмээн тодорхой айлджээ.

Цогт Чандракирти бээр өвөрчлөн чанар буй болоод буй бус эсэхийг дөрвөн талаас шинжлэн гаргаж үзүүлсэн бөгөөд үүнийг ухаараагүй учраас хоёр хязгаарт эргэлзээгүй унаж, хязгаараас ангижирсан төв үзлийн утгыг онохгүйд хүрнэ. Энэ нь өвөрчлөн чанар ерөөс байхгүй гэхээр тухайн юмс, үзэгдлийг ерөөс байхгүй гэж үздэг байна. Иймээс өвөрчлөн чанараар хоосон буюу хоосон чанар дор шалтгаан үрийг ерөөс агуулж болохгүй гэж үзээд "тасархайн хязгаар"-т унана. Мөн тухайн юмс, үзэгдлийг буй (байна) гээд үзэхээрээ чинагш өөрийн мөн чанараар бүтсэнд тооцож үзэх хэрэгтэй гэнэ. Чингэхээр шалтгаан үрүүд ч өөрийн мөн чанаргүй буюу тийн үзэгдэх илбэ адил үзэх ухаан төрөхгүйд хүрэх учир "мөнхийн хязгаар"-т унах мөн.

Тиймээс хамаг ном, юмст өөрийн мөн чанараар бүтсэн чанар нь хоосон төдий ч байхгүй, ерөөсөө байхгүй болохыг оносноор буйгийн (мөнхийн) хязгаарт үл унах болно.

Гэсэн хэдий ч ногоо тэргүүтэн бодас, юмс хэрэг тус үйлдэх чадлаасаа хоосорсон огт оргүй зүйл болж одолгүй, басхүү өөр өөрийн үйлдвэр үйлийг үйлдэх хүч чадалтай хэвээр оршино гэж ухаарч магадлаваас үгүйсгэх (тасархайн) хязгаарыг тэвчих болно. "Өвөрчлөн чанар байхгүй" болон "байхгүй" хоёрыг тодорхой ялгаж мэдэх учиртайг *"Тодорхой үгт"*-ээс:

Эсэргүүцэл: Ийн хэмээн Хэрэв та энэ мэтээр бодит юмс өвөрчлөн чанаргүй гэж агуулваас алин ялж төгс нөгчигсөн бээр өөрийн үйлдсэн үйлийн тийн боловсролыг (үр) өөрөө амсах болно хэмээн айлдсан бүхнээ эл ёсоор үгүйсгэж, үйлийн үрийг басамжлах учир та үгүйсгэгчийн эрхэм болох буюу.

Хариулт: Өгүүлсүгэй. Би үгүйсгэгч бус аа. Би болвоос буй болоод буй бус хоёрт өгүүлэгчийг хориглож хоёр үгүй мөр болсон нирвааны хот балгадад одохыг тодорхой үйлдэгч мөн. Би болвоос үйл, үйлдэгч, үр жимс тэргүүтэн буй бус аа гэж өгүүлсэн бус аа. Тэгвэл юу хэмээвээс, Эдгээрийг өөрийн мөн чанар үгүй болой хэмээн агуулсан болой.

Эсэргүүцэл : Яавч өвөрчлөн чанаргүй болвоос үйл, үйлдэгч болж таарахгүй учир гэм нь илхэн байгаа бус уу.

Хариулт: Тэр тийм бус аа. (Харин) Зөвхөн өвөрчлөн чанартай л болчихвол үйл үйлдвэр үзэгдэхгүй болох учиртай. Зөвхөн өвөрчлөн чанаргүй учраас л үйл, үйлдвэр үзэгдэх мөн" хэмээн айлджээ.

Энэ үест "өөрийн мөн чанаргүй болохоор мөн чанарыг хориход хүрнэ. Иймээс үйлээс үүдэж тийн боловсрол төрнө гэдэг үгүйсгэгдэнэ" гэж бодит өгүүлэгч нар өгүүлдэг. Ийн өгүүлэх нь мөн чанарыг хорьсон ухаан өөр учир шалтгаан үрийг хорино гэсэн баримталтай ялгалгүй баримтлал байна. Шалтгаан үрийг хоривоос тасархай үзлийн "эрхэм" болно гэж төв үзэлтэн болоод бодит өгүүлэгч хоёулаа адилд үзнэ. Гэвч бодит өгүүлэгч нараас төв үзэлтэн шалтгаан үрийг хориогүй байхад өөрийн мөн чанарыг хорьсон учраас шалтгаан үрийг ч хорьсон болно гэж үзээд төв үзэлтнийг үгүйсгэгч буюу тасархай үзэлтэн хэмээдэг ажээ. Түвдэд өөрийгөө төв үзэлтэн хэмээгч их зонхиуд нь мөн чанарыг хорьсон болохоор шалтгаан үрийг ч хорьсон болох хэрэгтэй гэх нь бодит өгүүлэгч нартай адилхан үзэгдэнэ.

Бүр шалтгаан үрийг язгуураас хорих нь төв үзлийн ёс гэж хэлэх ч

байна. Энэхүү тэмцлийн хариуг "Би болвоос үгүйсгэгч бус аа. Буй, буй бус хэмээн хоёрт өгүүлэгчийг арилгаж нирвааны мөрийг тодруулагч болой" хэмээн айлдаж буй, буй бус хэмээн өгүүлэхийг арилгах ёсыг үлдсэн бусад хэсэгт үзүүлжээ. Түүнээ "Бид нар болвоос үйлийн үр тэргүүтнийг үгүй гэж үл өгүүлвэй" хэмээсээр, "үгүйсгэн өгүүлэгч" гэхийг арилгах буюу. Үйлийн үр тэргүүтнийг үгүйсгэвээс үгүйсгэгч болох тул "Бид тийн үзэхгүй" хэмээжээ.

"Тэгвэл юу өгүүлэх" хэмээн асуухад, "Үйлийн үр тэргүүтэн эдгээр нь өөрийн мөн чанаргүй болой гэж агуулах буюу үзэх болой" хэмээн өгүүлснээр "буй гэж өгүүлэгч"-ийг арилгасан мөн. "Өвөрчлөн чанаргүй болвол үйл, үйлдвэр байх нь таарахгүй учир гэмтэй болох биш үү" гэвэл, "Та бээр үгүйсгэн бүү өгүүл. Өвөрчлөн чанараар үгүй хэмээн өгүүлэх хэдий ч дээр хэлсэн гэм буюу өвөрчлөн чанаргүй болвол үйлийн үрд таарахгүй, эдүгээ тэвчих шаардлагагүй гэх зэргээр бодит өгүүлэгч нар тэмцэх бий. Энэ нь тэдний ёсноо өвөрчлөн чанар байхгүй болоод буй бус хоёрыг ялгаж үзээгүйгээс болоод тийм тэмцэл үүдсэн буюу.

Түүний хариуд шалтгаан үрийг төрүүлэх тэргүүтний үйл, үйлдвэр зэрэг нь өвөрчлөн чанарт буй аваас үл орших бөгөөд зөвхөн өвөрчлөн мөн чанаргүй байхад л таарах болохыг айлджээ. *"Дөрвөн зуутын тайлбар"*-аас:

Би болвоос бодитыг үгүйсгэн өгүүлэгч бус аа. Шүтэн барилдаж гарахуйг өгүүлэгч учраас тэгвэл та бодит өгүүлэгч үү хэмээвээс тэр бус аа. Шүтэн барилдаж гарахуйг өгүүлэгч мөн учраас буюу. Та чухам юуг өгүүлэх вэ? хэмээвээс, Шүтэн барилдахуйг өгүүлэгч болой" хэмээжээ.

Мөн "Шүтэн барилдаж гарахын утга юу вэ?" "Өвөрчлөн чанар байхгүй гэсэн утга, өөрийн мөн чанараар төрөхгүй гэсэн утга, илбэ, зэрэглээ тусгал дүрс, гандирсын балгад, хувилал, зүүд зэрэгтэй адил чанартай үрээ гаргах утгат хоосон чанар ба "би-үгүй"-н утгат болой хэмээжээ.

Ийнхүү шүтэн барилдана гэж үзсэнээр бодас, юмсын буй болон буй бусын хоёр хязгаарт өгүүлэх ёсноос арилахыг үзүүлжээ. Тийнхүү шүтэн барилдахуйн утгыг өвөрчлөн чанараар эс төрөхийн утгаар айлдсанаар "бодит буй" гэж өгүүлэхийг арилгаж, илбэ зэргүүдтэй адилаар шүтэн барилдаж гарах гэснээр "бодит үгүй" гэж өгүүлэхийг арилгажээ. Тиймд "бодит"-ын хувьд өвөрчлөн чанарын болон ач тус үйлдэхийн хоёр талаас томъёолдог. Үүнд "бодит буй" хэмээн өгүүлэхийн "бодит" нь зөвхөн өвөрчлөн чанараас бүтсэн гэсэн талаас нь авч үзсэн байхад "бодит буй бус" хэмээн өгүүлэхийн "бодит" нь тусыг үйлдэх талаас нь үзжээ. Энэ хоёрыг ялгаж өвөрчлөн чанарыг

хорьж илбэ мэтийн шалтгаан үр оршихыг үзүүлсэн болой. Мөн *"Дөрвөн зуутын тайлбар"*-аас:

Асуулт: Бас дахин юунд өнгөрсөн орон вишайг дурдан санах байхгүй буюу байхгүй болой хэмээн өгүүлнэ вэ?

Хариулт: Би болвоос шүтэн барилдахыг арилгаагүй билээ. Хэрхэн байсан тэр дагуу магадлах болохоор дурдан санахдаа буруу утгыг буруу л гэж зөвхөн санах" хэмээн тэр багш тийн томъёолжээ. Тийм учраас санах сэтгэлийн орон нь өнгөрсөн бодас, юмс байдаг буюу.

Хэрвээ өөрийн мөн чанараас буй аваас
Түүнийг санах сэтгэл түүнийг
Тэрхүү буй утгаар нь бодох учиртай

Өөрийн мөн чанараар бүтсэн болвоос алин цагт ч тэрхүү өнгөрсөн бодит зүйлс өөрийн мөн чанаргүй болж тэр цагт түүнийг дурдан санах сэтгэл ч өөрийн мөн чанаргүй болно. Тиймээс буруу хэмээн үзжээ. "Буруу" гэхэд ч өөрийн мөн чанаргүй болоод шүтэн барилдаж гарахаас өөр утгаас гарахгүй. "Бодит бус" хэмээх утга нь буруу утга биш ээ. "Өнгөрсөн юм бүхэн байхгүй байх ёсгүй. Түүнийг чинь эгээрэн санах болохоор түүний үр дагаврыг үзэж буй хэрэг. Өөрийн мөн чанараар байж болохгүй. Мөнх болж хэтийднэ. "Бодитойд барихад ч хүрч хэтийдэх" учраас хэмээн өнгөрсөн зүйл гэдэг ерөөс байхгүй зүйл бус, өөрийн мөн чанараар ч бүтсэн бус. Буруу буюу хуурамч утга гэдэг шүтэн барилдахуйн утга буюу. Бодитыг үгүйсгэсэн утга бус хэмээн айлджээ.

Тиймээс эдгээр номын өөрийн мөн чанараар бүтсэн гэж үзвээс бодит өгүүлэгч буюу "буй-гийн хязгаарт унагч" болно. Тэдгээрийг буй төдий гэж өгүүлснээр бодит өгүүлэгч буюу "буй" гэж өгүүлэгч үл болно. Түүнчлэн гадаад, дотоодын бодит юмсууд тус үйлдэх чадлаар хоосорсон бодит бус гэж үзвээс "бодит бус өгүүлэгч" буюу "үгүйсгэлийн тасархай хязгаарт унагч" болой.

Тэдгээрийг өөрийн мөн чанаргүй гэж өгүүлснээр тасархайн хязгаарт үл унана. Тийнхүү огт байхгүй болоод өвөрчлөн чанаргүй байхын ялгааг ойлгоогүйгээс буй ба үгүйн хязгаарт унах бий. Эл явдлыг хорихдоо бид "Огт байхгүй гэж өгүүлээгүй ч буй бус аа гэж хэлсэн буюу. Буй гэж эс өгүүлсэн ч байхгүй биш ээ гэж өгүүлсэн мөн" Ийн өгүүлэх төдийд горилсон ч (шунаваас) зөвхөн харшилсан болох тул Төв үзлийн утга өчүүхэн төдийг ч үл баттаана. Бусдыг хорихын цагт өөрийн мөн чанар буй, буй бус хоёрын талаас нь авч үзэж хорих юм бол тэр хоёр бие биенээ үгүйсгэх ёстой гэж өөрсдөө үздэг

шиг тэр хоёрын аль нь ч болохгүй гэсэн тийм утгаар илэрхийлдэг билээ.

Ийнхүү аль нэгэн суурь дээр үндэслэж өөрийн мөн чанар байна уу үгүй юу гэдгийг шинжилж (эрж хайж) байгаа, байхгүй тэр хоёр бие биенээ үгүйсгэх хэрэгтэй. Тэнд (тэр хоёрт) багтаагүй гуравдагч этгээд байвал мөн чанараар байна уу эсвэл байхгүй юу гэдгийг шинжлэх нь зохисгүй болно. Үлгэрлэвээс, "өнгө мөн байна гэхэд хөх байна уу эсвэл шар байна уу "гэж асуухтай адил.

Буй, буй бус хоёр чанар бие биенээ үгүйсгэх гэдэг ер нь мэдэгдэхүүн болдог буй, буй бус хоёрын үгүйсгэлээс хамаардаг билээ. Үлгэрлэвээс, үнэн дотор үнэний нэг болон үнэний олон хоёр үгүйсгэгдэхтэй ер нь нэг ба олон хоёрын үгүйсгэлээс хамаардагтай адил буюу. Тийнхүү бие биенээ үгүйсгэхэд гуравдагч этгээд буцах ёстой. Тэр хоёрын аль нь ч болдоггүй зүйлийг эгээрэх нь хэрэггүй дэмий мөн. Эл талаар *"Тэмцлийг няцаагч"*-аас:

Өөрийн мөн чанараар бүтэхээс буцваас
Өөрийн мөн чанарт болон бүтэх хэмээжээ.

Гэвч тийн үзэх болохоор хаана ч гуравдагчыг няцаасан тооцоо гаргаагүй учраас зөвхөн доноголзох (эргэлзэх) төдийд болно. Буй бус тэргүүтний нэгий нь тийн мэдсэнээр нөгөөг нь төгс мэдэх албагүй. Мөн, бишийн зарим зүйлүүд гуравдагч байхгүй гэж үзэж байгаа бол буй, буй бус дээр бүгд адил шүү дээ. Тэр адилаар тийн үзэх нь Төв үзлийн гол номоос "буй ч бус, буй бус ч бус" хэмээсэн үг төдийг эндүүрсэн мөн тул түүнийг үзэхдээ байна, байхгүй гэж хэлдэггүйтэй адил, "буй бус ба буй бус бус" гэж ч хэлэх хэрэггүй гэж дөрвөн талаас тийн айлджээ. Иймээс *"Үндсэн билиг"*-ээс:

Буй хэмээн мөнхөд барих
Буй бус хэмээн тасархайд барих
Тиймээс мэргэд буй, үгүй хоёуланд
Оршиж үл үйлдэх буюу

хэмээсэн нь байх, байхгүй төдийхнийг хэлээгүй хэрэг ээ. Бодит юмсыг өөрийн мөн чанар бүтсэн гэж үзвээс мөнх болоод тасархайн үзэл болохыг тодорхой айлджээ. *"Тодорхой үгт"*-ээс:

"Дээрх "буй, буй бус" гэж барихыг бодит юмсын буй, буй бус гэх үзэл болохыг айлдсаны дараагаар "Жич юуны учир бодит болоод бодит бус хэмээх үзэл байснаар мөнхөд болоод тасархай үзэл болж хэтийдэв хэмээхэд, Ийн хэмээн:

Алин мөн чанараар буй аваас
Тэрээр буй бус ч буй болсноор мөнх болох
Урьд ч гараад одоо үгүй хэмээх
Тэрээр тасархай болж хэтийдэх

Алин өөрийн чанараар буй гэж өгүүлэх тэрээр мөн чанараас буцахгүй тул хэзээ ч буй бус, бус мөн. Тийм болохоор өөрийн мөн чанар буй гэж үзээд мөнх гэж баримтлах үзэл болж хэтийднэ. Урьд оршиж байсан бодит юмсын мөн чанарыг хүлээн зөвшөөрвөөс эдүгээ буюу хойшдоо эвдэрч байхгүй болно гэж үзэхэд хүрч тасархайн үзэл болж хэтийднэ" хэмээн өөр мөн чанараар байна гэж үзвээс мөнхийн үзэл болж урьдын мөн чанар хойшдоо эвдэрнэ гэж үзвээс (тасархай) үгүйсгэх үзэл болохыг айлджээ. Буй төдий болоод эвдрэх төдийг эс айлджээ. *"Буддхапалида"*-гаас:

"Буй хэмээх ба буй бус хэмээхийг мөнх, тасархайн үзэлд эдгээр алин (бүгдээр) өөрийн мөн чанараар буй гэж үзэх мөнх, тасархайн үзэл болохыг тодорхой үзүүлснийг" номножээ.

Товчилбоос, өөрийн мөн чанаргүй хоосон чанар гэдэг жинхэнэ хоосон чанар биш ээ гэж өгүүлэн түүнийг үгүйсгэвээс билиг барамидыг тэвчсэн буюу номыг огоорсон үйл болж муу заяанд одох бөгөөд өөрийн мөн чанаргүй гэж хэлэх хэдий ч "өөрийн мөн чанаргүй болвоос юу байх юм бэ?" хэмээгээд хамаг ном бүгдийг ерөөс байхгүй гэж үзэхэд л тасархай үзлийн халилд унах болно. Тийн болохыг "Хоосон чанарын үзлийг гэмтээвээс, Дорд ухаантан нар гутамшигт болгох" хэмээснийг *"Тодорхой үгт"*-ээс: "Хэрвээ заримууд бүгд хоосон бөгөөд бүгд буй бус (байхгүй) болой хэмээн атгаглаваас тэр цагт буруу үзэл болюу. *Ийн хэмээн:*

Энэхүү номыг буруу бариваас
Эс мэргэшсэн нар шамшаагдах (доройтох)
Энэ адилаар үгүйсгэх үзлийн
Идээ буртагт түүнээ живэх хэмээн айлджээ.

Хэдийгээр бүгдийг басамжилж үзэхийг хүсээгүй ч тэр цагт эдгээр бодит зүйлсийг бодолдоо бодовч хоосон ямагт болгож, чингээд өөрийн мөн чанар байхгүй утгыг хоосон чанарын утга биш ээ хэмээн үгээр хоосон чанарыг тэвчсэн болдог. Тийнхүү тэвчсэнээр номоор хоосрох үйл болж муу заяанд одох буюу. Ийн хэмээн *"Их эрдэнийн эрхи"-ээс*

Бас дахин үүнийг буруу барьсан
Мэргэд хэмээх омогт тэнэгүүд
Огоорсон тул мунхагийн мөн чанарт болоод
Аюус тамд тонгорцоглон одох хэмээн номнов хэмээн айлдсан буй.

Эсэргүүцэл: Хэрвээ бид бодит юмсыг урьд нь буй гэж үзчихээд хойно нь байхгүй гэвэл үгүйсгэх үзэл болно биз. Гэвч бид анхнаасаа (язгуураасаа) тэдгээрийг буй хэмээн үл үзсэн учраас яалаа гэж тасархайн үзэлтэн болох билээ.

Урьд гарсан (ч) эдүгээ байхгүй хэмээх
Тиймээс ч тасархай болж хэтийдэх хэмээх энэ мэтийг тасархай үзэл хэмээжээ.

"Тодорхой үгт"-ээс ч:

Егүзэр бээр янагуух байхгүйг ухаарч түүний хоосон чанарын үнэмлэхүйн бэлэг чанартайг оносноор хоёр хязгаарт үл унана. "Алин цагт одоо байхгүй болохоор тэр цагт юу байх билээ" хэмээх нь тийнхүү урьд нь үзэж мөн чанар нь баригдахгүй болохоор хойноо ч байхгүй гэж үзэж байгаа биш хэмээсэн байна шүү дээ гэвэл,

Хариулт: Энэ таарахгүй. Тасархай үзэл гэхээр үгүйсгэхийн үндэс болж буй зүйлээ өмнө нь (буй гэж) хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм бол ертөнцийн Жанпэнба (Локояата, тасархай үзэлтэн) нар ч хойд, урьд төрөл болоод үйлийн үр тэргүүтнийг урьд байхыг зөвшөөрч, хойно байхгүй гэж үл өгүүлнэ вэ. Тэд анхнаасаа буй гэж үздэггүй байсан бол тасархай үзэлтэн биш болж хэтийднэ биз дээ. Тиймээс "урьд гарсан ч эдүгээ үгүй хэмээх, Тиймээс тасархай болж хэтийднэ" хэмээн айлдсан нь, Бодас юмсын өөрийн мөн чанараар бүтсэн мөн чанар байдаг аа гэж үздэг бодит өгүүлэгч нарт эргэлзээгүйгээр мөнх болоод тасархай үзэл төрдөг гэсэн утга мөн. Тэрхүү мөн чанар нь цаг үргэлжид хувирахгүй байдаг гэж үзсэнээр мөнх болно.

Урьд цагт байсан зүйлс хойд цагт эвдрэх (байхгүй болно) гэснээр тасархай үзэл болдог учиртай. Тийм учраас урьд цагт байх мөн чанар хойд цагт эвдэрнэ гэдэг тасархай үзлийг үгүйсгэн заах нь үнэхээр мөн чанараар бүтсэн мөн чанар тоосон төдийд ч байхгүй гэх үзлийн шалтгаан нөхцөл болж өгдөг. Харин тэрээр хамаг тасархай үзлийг тэвчсэн биш л дээ.

Үйлийн үрийг үгүйсгэдэг тасархай үзэлтэй адилгүй бусад ёсны талаар *"Тодорхой үгт"*-ээс тодорхой айлдсан бий. "Ийнхүү тасархай үзэлтнүүд үйлийн үр болоод чинад ертөнцийг үгүйсгэж үздэг" байхад Төв үзэлтэн нар тэдгээрийн мөн чанарыг үгүйсгэж үздэг тул (тангараг) үзэл баримтлалын хувьд ялгаатай билээ. Төв үзэлтэн нараас үйлийн үр тэргүүтэн тэдгээрийг шүтэн барилдахуй

болохын үүднээс өөрийн мөн чанаргүй хэмээн өгүүлдэг билээ. Үгүйсгэгч нар үйлийн үр тэргүүтний шүтэн барилдахуй бус гэж үздэг тул түүний үүднээс үл барина.Тиймээс их ялгаатай буюу *"Тодорхой үгт"*-ээс:

Энэ үест заримууд Төв үзэлтэн нь үгүйсгэгчээс ялгаагүй. Яагаад гэвэл нүгэл, буяны үйл үйлдээчин үр дагавар болоод ертөнц дахиныг мөн чанараар хоосон гэж өгүүлдэг. Тасархай өгүүлэгч нар ч тэдгээрийг (байхгүй) үгүй гэж өгүүлэх учраас төв үзэлтнүүд нь тасархай өгүүлэгч нартай ялгал байхгүй хэмээн мэтгэлцэнэ. Тийм биш ээ. Төв үзэлтэн нар шүтэн барилдахуйг өгүүлдэг мөн. Шүтэн барилдаж гарсан учраас л эл ертөнц төрөл болоод бусад ертөнц (хойд төрөл) бүгдээр өөрийн мөн чанаргүй болно гэж өгүүлдэг буюу. Тасархай үзэлтэн нар бээр тэр адилын шүтэн барилдаж гарсан учраас өөрийн мөн чанаргүй гэх хоосон чанарын үүднээс бусад ертөнц тэргүүтэн бодит бус чанарт болохыг оноож чаддаггүй байна. Тэгвэл юу гэж үздэг вэ? хэмээвээс, Эл ертөнцийн бодит зүйлсийн байдлыг өөрийн мөн чанартай гэж үзээд бусад ертөнцөөс энд ирэх ба эл ертөнцөөс нөгөө ертөнцөд одох зэргийг үл харна гээд зөвхөн энэ ертөнцөд л үзэгдэх, харагдах төдий бодит зүйлстэй адилтган бусад бодит зүйлсийг басамжлан доорд үздэг мөн хэмээн айлджээ.

Эсэргүүцэх нь: "Хэдийгээр Төв үзэлт болоод Тасархай үзэлт хоёрын учир шалтгаан харилцан адилгүй байлаа ч үйлийн үр болоод урьд, хойд төрлүүд өөрийн мөн чанараас бүтсэн өөрийн мөн чанаргүй гэж ухаарахтай адилхан. Иймээс эл өөрийн мөн чанаргүй үзлээрээ хоорондоо ижилхэн шүү"

Хариулт: Энэ ч адилгүй. Тэдний (тасархай) өөрийн мөн чанаргүй гэж хэлдэг нь огт байхгүй зүйл гэж үгүйсгэнэ. Бүр хоёр үнэний алинд ч болохгүй гэдэг. Төв үзэлтнүүд үзэхдээ үйлийн үр тэргүүтэн, тэдгээр янагуухид байна гэдэг. "*Тодорхой үгт*"-ээс:

Эсэргүүцэх нь: "Хэрвээ тийн боловч тэдгээр бээр бодит зүйлсийн өөрийн мөн чанар байхгүй гэхээр огт байхгүй мэтээр онодог. Эл үзлийнхээ үүднээс л адилхан бус уу?"

Хариулт: Тиймгүй буюу. Төв үзэлтэн нар янагуухид буй гэж үзэх, нөгөөх нь тийн үл зөвшөөрөх учраас адил бус буюу" хэмээжээ.

Тийнхүү Төв үзэлтэн нарыг янагуухид ч үйлийн үр тэргүүтнийг ч хүлээн зөвшөөрдөггүй мэтээр үзвэл тэрсүүд Жанпэнбатай (Холд хаягдагч/ Ньяаяаки) адил үзэгдэхийг үзүүлсэн буй.

Энэ үест багш бээр тасархай үзэлтэнтэй адилгүйн учир шалтгааныг өгүүлсэн бөгөөд "түүнд байхгүй" гэдгийг эс айлджээ. "Тэдгээрийн үгүйсгэлийг

бид биш ээ гэж эс өгүүлэв. Буй бус аа гэж үздэг" хэмээн эс өгүүлэв. Харин өөрийн мөн чанаргүй гэж өгүүлсэн бөгөөд түүний шалтгаан нь шүтэн барилдахуй буюу. Тэдгээр асуулга ухагдахуун бүгд янагуух утгат хэмээн болгоохыг айлджээ.

Эсэргүүцэх нь: Хэрвээ үйлийн үр тэргүүтнээ өөрийн мөн чанараар бүтсэн мөн чанар байхгүй гэдэгт таардаг гэвэл Тасархай үзэлтэн ч гэсэн тэдгээрийг үгүйсгэж үзсэнээр өөрийн мөн чанаргүй гэж тооцдог тул өөрийн мөн чанаргүй гэх талаасаа Төв үзэлтэй адил болой.

Хариулт Чингэвэл бүр ч адилгүй. Үлгэрлэвээс, "Эд хулгайлсан хүнийг түүний хулгайлсан эсэхийг үл мэдэх хирнээ нэг хүн бээр энэ хулгайлсан шүү гэж худал хэлнэ. Эд хулгайлж байсан тэр этгээдийг харсан нөгөө хүн бээр энэ хулгайлсан шүү гэж хоёулаа "Энэ хүн эд хулгайлав" гэж хэлэх нь адилхан ч хулгайч ч тийн хулгай үйлдсэн байж болох ч нэг нь худал өгүүлсэн, нөгөө нь үнэн өгүүлсэн хоёрын хувьд адилгүй байдагтай адил буюу". Тэр талаар *"Тодорхой үгт"*-ээс:

Эсэргүүцэх нь: Хэрвээ бодитой гэхийн хувьд тэр хоёр адилхан л даа?

Хариулт: Хэдийгээр бодитой эс бүтсэн нь тийм мэт боловч тус тус атгаглах тул адилгүй болой. Үлгэрлэвээс, нэг хүн хулгай хийсэн хүнийг мэдээгүй хирнээ садан эс болохын учраар энэ хулгайлсан гэж өгүүлэх нөгөө нэг нь харсан учраар сөхөөж айлгаж чаддаг. Тус, тус бус бодит зүйлс дээр ингэж болох авч ухаарсан мөн чанар нь тусдаа учраас нэг нь худлаа хэлсэн болоход нөгөө нь үнэн хэлсэн болно. Нэг дэх хүнийг шинжээд ирэхээр хэлсэн нь худлаа болж нүгэл болно. Нөгөөд тийм явдал байхгүйтэй адилаар энэ үест ч бодит зүйлс өөрийн мөн чанараар байдаг гэж ухаарчихаад хэлэхтэй үгүйсгэгч нар, бодитууд өөрийн мөн чанаргүй гэж ухаарагч нартай адилгүй болой хэмээн айлджээ.

Иймээс л заримууд өөрийн мөн чанаргүйг ухаарахдаа үйлийн үр тэргүүтнийг учир шалтгааны үүднээс хорих мэтээр ухаарч улмаар шалтгаан үрсийг өөрийн ёсноо үгүйсгэн үзэгдэх зүгт янагуухийг ч буруугаар ухаарах бий. Бүр хоосон чанарын үзлийг эндүүрэлгүй оллоо гэж өгүүлдэг. Гэвч сайтар түүнийг харах хэрэгтэй тийм хоосон чанар болвоос тусыг үйлдэх чадлаас хоосорсон хоосон биш бөгөөд өөрийн мөн чанаргүй боловч шүтэн барилдахуйд агуулагдсан нэгэн байх хэрэгтэй.

"Дөрвөн зуутын тайлбар"-аас:

Тийн адил хэдий ч утгат нэгэн бөгөөд
Төрөхүйеэ эрэх хийгээд
Тэрчлэн түрдэхүйеэ одохгүй
Түүнээ үнэхээр мөн чанар үгүй бөлгөө

Хэрвээ түүнд мөн чанар байхгүй юм бол юунд буй?" хэмээвээс, Өгүүлсүгэй. Алин хамаг нисваанис болоод хамаг арилсан бүгдийн үндэс болдог мөн чанар-шүтэн барилдаж гарсан тэр буй хэмээн айлджээ.

Үүгээр олон чанар үгүй аваас түүний тод байх хэмээхийн хариуг тодорхой зохиожээ. Буддхабаллида багш ч буй хийгээд өөрийн мөн чанар хоёрын ялгааг тодорхой ялган хариулсан аж. Тэрээр *"Хорьдугаар бүлгийн тайлбар"*-таа:

Эсэргүүцэх нь: Өгүүлэх нь хэрвээ цаг хугацаа үгүй болж үр дагавар, чуулган сэлт ч үгүй болвоос өөр юу буй. Тиймээс тэр нь үгүйсгэн өгүүлэгч болно.

Хариулт: Ном тийм биш л дээ. Та хэрхэн цаг хугацаа тэргүүтнийг мөн чанартай байна гэж төгс ойлговоос тэр адил таарахгүйгээр зогсохгүй тэдгээрийн шүтэн нэрийдэж бүтсэн хэмээн Бодит өгүүлэгч нарын баримтлал мөн ч өөрийн мөн чанараар бүтэх учраас таарахгүй" гэж хорьсон мөн.

"Шүтэн нэрийдэж бүтсэн" гэдэг нь шүтэн барилдахад байна гэсэн утга хэмээжээ. Тиймээс мөн чанар буй, буй бус болоод буй, буй бус хоёулаа, хоёулаа бус гэсэн дөрвөөр түүнийг ялгаваас таашгүй олон буруу атгагийг буцаах бөгөөд мөн чанарыг хорьсон ухааны буй төдийг хорьсон гэх эндүүрэл гарахгүйд хүрнэ. Төв үзэлтэн нараас Бодит өгүүлэгч нарт хариулт өгөхдөө энэ дөрвийг гол болгон барьсан учраас өчүүхэн төдий өгүүлэв.

12

УХААНААР ШИНЖИХ НЬ

/2/ Эсэргэлдэн өгүүлэгч нараас сөхөөж эс чадахыг үзүүлэх
/а/ Ухааны шинжлэлд тэсэх, эс тэсэхийг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх

---oOo---

/2/ Эсэргэлдэн өгүүлэгч нараас сөхөөж эс чадахыг үзүүлэхэд дөрөв:
/а/ Ухааны шинжлэлд тэсэх, эс тэсэхийг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх
/б/ Шалгадаг ухаанаар бүтэх, эс бүтэхийг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх
/в/ Дөрвөн хязгаараас төрөх мөн, бусыг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх
/г/ Бодасын буй, буй бус зэрэг дөрвөн талыг хориход эсэргүүцэл гарахгүйг үзүүлэх

/а/ Ухааны шинжлэлд тэсэх, эс тэсэхийг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх

Буй, буй бус болон төрөх, эс төрөх зэргийн үүднээс дүрс тэргүүтэн эдгээр ном юмсын утгыг ёсчлон шинжих нь хоосон чанарыг шинжих ухаан буюу эцэс туйлыг хүртэл ажиглаж буй ухаан болой. Дүрс тэргүүтний төрөх ёсыг тэр ухаанаар шинжээд үзэхээр тэсэх (үлдэх) зүйл байна гэж бид үздэггүй учраас үнэхээр бүтсэн гэж барих хэтийдэх гэм гарахгүй.

Асуулт: Хэдий ухаанаар тэднийг шинжихгүй байсан ч, ухаанд эвдрэх утга байна гэдэг чинь хэрхэн таарах билээ?

Хариулт: Энэ чинь ухаанаар шинжихэд үл тэсэх болон ухаанаар хорих хоёрыг нэг зүйл гэж эндүүрдэгтэй адил буюу. Хэдий хоосон чанарыг шинжих ухаанаар хориглох боловч төрөх буй хэмээн өгүүлэх чинь утгагүй дэмий үг болно гэж өгүүлэгч олон ч бид тэднийг үл дагана. Ухаанаар ажиглахад тэсэх, эс тэсэх гэдэг чинь хоосон чанарыг шинжих тэр ухаанаар олдох, олдохгүй гэх тэр утга билээ. Тэр талаар *"Дөрвөн зуутын тайлбар"*-аас:

Бидний тийн шинжлэл нь өвөрчлөн (өөрийн) мөн чанар байгаа эсэхийг

чухалчлан хайж буй үйл билээ

хэмээн айлдсан мэтээр дүрс тэргүүтнээ төрөх, түрдэх зэргийн өвөрчлөн мөн чанар буй, үгүй эсэхийг л эрж хайж буй шинжлэл ажгуу.

Тэр ухаанаар дүрс зэрэг юмст өөрийн мөн чанараар бүтсэн төрөх, түрдэх нь байна уу, үгүй юү гэдгийг хайж буй явдал болохоос, зөвхөн төрөх, түрдэх төдийхнийг эрж хайсан бус аа. Тиймээс тэрхүү ухааныг "тэр ямагт чанар"-ыг шинжигч гэсэн нь тэр ямагт чанарт төрөх, түрдэх зэргүүд бүтсэн, эс бүтсэн эсэхийг шинжих үүднээс болой. Төрөх зэрэг юмсыг тэр ухаанаар шинжих буюу эрээд ирэхээр өчүүхэн төдий ч олдохгүй байвал "шинжлэлд үл тэсэх" хэмээдэг. Гэсэн ч тэрхүү ухаанд баригдахгүй байгаа төдийхнөөр нь үгүйсгэх учиргүй. Хэрэв буй аваас тэр ухаанаар бүтэх (нотлогдох) ёстой. Харин тэр ухаанаар эс бүтсэн болвол үгүйсгэгдэх хэрэг болно.

Дүрс зэрэг юмсын төрөх, түрдэхийг нэрийдэх (янагуух) сэтгэл ухаанаар мэднэ. Тэдгээр байх атал, (үнэмлэхүй) ухаанаар эс бүтэж, эс олдох тул тэдгээрийг хэрхэн үгүйсгэх вэ? Үлгэрлэвээс, нүдний мэдрэхүйгээр дууг үл барих боловч тэрээр түүнийг үл үгүйсгэх адил. Хэрвээ төрөх, түрдэх тэргүүтэн өөрийн мөн чанараар бүтсэн бол тэр ухаанд баригдах хэрэгтэй. Учир нь тэр ухаанаар дүрс тэргүүтэн өөрийн мөн чанараар бүтсэн төрөх, түрдэх буй, үгүй эсэхийг ёсчлон шинжилж байгаа хэрэг. Гэтэл түүнд төрөх тэргүүтэн эс баригдана. Хэрэв өөрийн мөн чанараар бүтсэн аваас түүнд баригдах, олдох ёстой байтал олдохгүй байна. Үлгэрлэвээс, Зүүн зүгт хумх (бумба) байвал олдоно гэж бодсон эрэлчин бээр зүүн зүгт хумх эрэхийн цагт олдохгүй бол тэрээр зүүн зүгт хумх байна гэхээ үгүйсгэнэ. Хумх байна гэдгийг юунд үгүйсгэх билээ. Түүнтэй адил "өөрийн мөн чанараар бүтсэн төрөх буй аваас олдоно" гэж үзээд Төв үзлийн ухаанаар хайгаад "тийн төрөхийг олж чадаагүй тэр ухаанаар л" "өвөрчлөн буюу өөрийн мөн чанараар бүтсэн төрөх"-ийг үгүйсгэхээс бус, "төрөх төдий нэгэн"-ийг юунд үгүйсгэх вэ?.
Энэ талаар *"Дөрвөн зуутын тайлбар"*-аас:

Ийнхүү ухаанаар тийн шинжлэхэд эрхтэн, орон, тийн мэдэл зэргийн байдаг мөн чанар байхгүй учраас өөрийн мөн чанараас бүтсэн ч байхгүй болой. Хэрэв тэдгээр өөрийн мөн чанараар бүтсэн болвоос тэр үест тааруулан тийн шинжихэд маш тов тодорхой орших өөрийн мөн чанар байгаа гэдэг нь баригдах ёстой. Гэтэл тийн баригдахгүй болохоор өөрийн мөн чанараар хоосон болвой гэж тодорхой айлдсан байна.

Дүрс, дуу зэргийн янагуух эдгээр байх боловч өөрийн мөн чанар буй,

үгүйг болоод тэр ямагт чанарыг шинжих ухаанаар хайхад ерөөс байхгүй тул тэдгээр нь ухааны шинжлэлд үл баригдана хэмээн эл багш ч олон дахин айлджээ. Мөн ухаанаар ажиглагаа явуулаад тэр ухаанд олдохгүй байгаа учраас янагуух тэдгээрийг эвдлээд (үгүйсгээд) янагуух гэж агуулж (бодож) бүү сур гэж олонтаа айлджээ. Хэрвээ мөн чанараар буй, мөн чанараар буй, үгүй эсэхийг шинжих ухаанаар эдгээрийг үгүйсгээд дүрс, амсуурга тэргүүтэн эдгээр янагуухид ухааны шинжлэл лавтай оруулах хэрэг гэвээс энэ багшийн номноос энэ мэтийн зүйлийг хэзээ үргэлж хорьсон учраас өөрийн мөн чанар буй, үгүй эсэхийг шинжих ухаанд олдоогүй утгыг ухаанаар үгүйсгэгдэх утгат гэж үзвээс Төв үзлийн ёсонд маш их төөрөлдсөн хэрэг болно шүү. Мөн чингэвээс хутагтын тэгш агуулах бясалгалаар ч дүрс тэргүүтний төрөх, түрдэхийг эс болгооно. Тиймээс тэрээр төрөх, түрдэх зэргийг буй (үгүй) гэж хаанаас болгоох мөн. Өөрийн мөн чанар буй, үгүйг шинжих ухаанаар ч төрөх, түрдэх тэргүүтнийг үл эрэлцэх, төрөх, түрдэх тэргүүтнийг үгүй гэж барих бус аа.

Ийм учраас ухаанаар шинжихэд үл тэсэх болон ухаанаар хорлогдох хоёр, бас хутагтын тэгш агуулах билгэ билгээр төрөх, түрдэхийг болгоох болон тэдгээрийг үгүй гэж болгоох хоёр, бас мөн чанар буй, үгүйг шинжих ухаанаар төрөх, түрдэх эс олдох ба төрөх, түрдэхгүй нь олдох хоёрын ялгааг мэдэлгүйгээр нэгэн зүйл мэтээр барих нь одоо ч байгааг хэлэх юун. Мөн урьдын мэргэдэд ч хаая эндүүрэх байсан нь үзэгдэх тул ухаантан мэргэд та нар нягтлан шинжлээд ялгаж тунгаагтун! Тиймээс бид тэр янагуух ухаан нь үнэмлэхүйн оронг шалгадаг их ухаанаас их хүчтэй гэх юмуу, янагуух ухаанаар үнэмлэхүй оронг шалгадаг ухааныг хорлоно (харшлах) гэж үзээгүй болно.

Гэвч хоосон чанарыг шинжих ухаанаар янагуух дүрс, амсуурга зэргийг шинжээд тэдгээр эс олдох учраас тэдгээр нь ухаанаар эвдэрч (үгүйсгэх) байна гэвэл тэрээр гадагшаа эвдрэхгүйгээр зогсохгүй тэр адилаар ертөнцөд алдаршсан шалгадаг ухаан нь хориглогчийг хорлох болдог.

"Төв үзэлд орохуй"-гаас:

Хэрэв таныг ертөнц эс хорловоос
Ертөнцөд харгалзах энэ бээр хориму за
Та болоод ертөнц эл талаар тэмцэгтүн
Хожим аль хүч төгөлдөр болсныг шүтдэг би

хэмээн айлдсаныг Чандракиртийн *"Тайлбар"*-т ч:

Бид ертөнцийн янагуух утгыг буцаахын тулд маш их бэрхшээлтэй

тулгарч байна. "Та ертөнцийн янагуухийг арилгагтун! Хэрвээ танд ертөнцийн хорлол байхгүй бол би ч хоосон (чанар)-ыг зааж өгсүгэй. Ертөнц бээр хорлох ч мөн хэмээн айлджээ.

Энд "бид нар ертөнцийн янагуухийг буцаахын тухайд маш их бэрхшээлтэй тулгарч байна" гэсэн нь харааны мэдрэхүй зэрэг эндүүрэлт оронтууд (мэдрэхүй) болоод дүрс тэргүүтэн эндүүрэгт орон зэрэг (үзэгдлүүд) эдгээрийг арилгах мөрд хичээхийг хэлж байгаа хэрэг. Эдгээр нь ухааны хоригдохуун бус, харин мөрийн зэргийн хоригдохуун болно. "Та ертөнцийн янагуухийг арилгагтун!" гэсэн нь Төв үзэлтэн нар "бусдын эрхэт"-ийг "эдэд буй" болохыг хориглох тул би ч таны янагуух ухаанаар хорино гэдэгт толгой сэгсрээд "бусдын эрхэт"-ийн мөн чанарыг хорьж чадсан адилаар та янагуух ухаанаар хорьж чадсан учраас би ч тантай энэ тал дээр нөхөрлөе хэмээжээ.

Иймээс ухаанаар хоривоос үүнийг буцаахын тулд мөрийг бясалгахын хатуужил, бэрхшээл хэрэггүй гэж би үзэх хэрэгтэй болов хэмээн заасан тул янангуухийг ухаанаар үл эвдэнэ гэдгийг үзүүлжээ. "Үл эвдэхээр зогсохгүй, хоривоос" ертөнцөд алдаршсаныг хорлосон болох тул тэдгээрээс хүч ихтэй гэж үзэх болно. *Эсэргүүцэх:* Ийнхүү Бодит өгүүлэгч нараас ухааны шинжлэл хийгээд гадаад утга тэргүүтэн янагуух юмсыг хориход (үгүйсгэх) тэрхүү ухаанаар олдохгүй болохоос эвдэрч байгаа бус болно. Заримууд дүрс тэргүүтэн томъёонд байхыг үл хоригдох утгыг Нагзэ тэргүүтэн ертөнцийн ухаантнууд өөрийн дураар хорьж чадахгүй бус уу.

Хариулт: Тэр ямагт чанарыг шинжих ухаанаар хорино гэж хэлэх нь машид таарахгүй ээ. Ямар ч шинжих хүнд тэр ямагтыг шинжих ухаанаар хорих, эс хорих эсэх дээр эргэлзэх байна. Тогтсон таалал мэдэхгүй хүнд хориогүй байсан ч сэжих ухаан төрөхгүй. Тэр ямагтын чанарыг шинжих ухаанаар хориглоход хоригдохуунаа нэр томъёо гэж үзэх хэрэгтэй. Тэр ямагтыг шинжих ухаанаар хамаг төрөхийг үл хориглосон талаар Чандракирти багш ч тодорхой айлдаж *"Дөрвөн зуутын тайлбар"*-таа:

Буруу ойлголт: Хэрвээ энэхүү шинжлэлээр хэзээ үргэлж төрөхүйг үгүйсгэх (хорих) болбол хуран үйлдсэн төрөхүй ч байхгүй гэж номносон болно.

Хариулт: Чингэвэл "илбэ" адилын чанаргүй болж, "хүүсэр эмийн хөвүүн" зэрэгтэй тун ойрхон төсөөлөгдөх болно. Улмаар шүтэн барилдаж гарах ч үгүйсгэгдэж хэтийдэхийн аюул гарах учраас тэдэнтэй адил үзэж болохгүй. Тэдэнтэй харшлахгүй "илбэ" зэрэгтэй адилд үйлдээрэй хэмээн" тун тодорхой айлджээ.

"Энэхүү шинжлэлээр" гэсэн нь тэр ямагт чанарыг шинжих ухааныг өгүүлжээ. "Хүүсэр эмийн хөвгүүн зэрэг" гэсэн нь төрөхүй бүгдийг үгүйсгэвээс хүүсэр эмийн хөвгүүн болоод "туулайн эвэр" адил тусыг үйлдэгч бүгдээр хов хоосон, бодит бус зүйл болж явсаар шүтэн барилдахуй ч үгүйсгэгдэхийг андуу гэм болох аюултай.

Иймээс тус болох хамаг чадлаасаа хагацсан "хүүсэр эмийн хөвгүүн" зэргийн үл төрөхүйтэй адилгүй. Харин илбэ тэргүүтэй адил болох учраас үнэн буюу өөрийн мөн чанараар "төрөхүй" явдлыг үгүйсгэсэн (хорьсон) болой. Мөн *"Дөрвөн зуутын тайлбар"*-аас:

Хэрвээ нүд тэргүүтэн үгүй болчихвол хэрхэн эдгээр нүд тэргүүтэн эрхтнээс үүдэх үйлийн боловсролын (үр) мөн чанарыг томъёолох вэ? хэмээвээс, Тэгвэл бид нараас эдгээрийн тийн боловсролын мөн чанарыг хорьсон юм уу. Нүд тэргүүтнийг хорин бүтээсэн болохоор түүнийг эс хорив гэх нь үү. Бидний тийн шинжлэл бол мөн чанарыг эрж хайж байгаа явдал. Бид нар энд бодит юмс нь өөрийн (өөрөө бүтсэн) мөн чанараар бүтээгүй гэдгийг үгүйсгэн хорьсон болно. (Түүнээс бус) Нүд тэргүүтэн бий болох шүтэн барилдаж гарах зэрэг үйлийн боловсролыг үгүйсгээгүй билээ. Тийм учраас тэр буй мөн. Тийн боловсрол хэмээгдэх нүд тэргүүтэн ч буй болой хэмээжээ.

Ухаанаар энэ төдийг хорьсон, энэ төдийг хориогүй гэдгийг тун тодорхой айлдсан тул энэ мэтээр үйлдэх талаар эл хэсэгт айлджээ. Айлдаагүй бүгд дээр ч энэ адил тул ямар ч байсан ийн үйлдэх хэрэгтэй. Өөрийн талаас эрхдээ, орон вишай (мэдэгдэхүүн) оршихдоо, "өөрийн чанараар орших (буй)" гэдгийг л ухаанаар хорьсон хэрэг болохоос, "орших (буй) төдий"-г хориогүй юм аа. Ухаанаар "мөн чанар"-ыг л эрж хайсан болно" гэж айлджээ.

Иймд "ухаан" гэдэг мөн чанар буй, үгүй (байна уу, үгүй юу) эсэхийг эрж хайж байгаа явдал болохоор түүгээр хорино гэдэг тийм мөн чанарыг хорьсон гэсэн утга болно. Энэ хоёрыг ялгаж ойлгох хэрэгтэй. Энэ адилаар үйлийн үрийг үл хорихоор барахгүй, Төв үзэлтэн (өөрөө) тэднийг баримтлах учиртай бөлгөө. Энэ талаар дээрх номонд үргэлжлүүлэн "Тийм учраас мэргэдүүд ертөнцийн утгыг дээр номносон тийн шинжлэл болох хоосон чанарыг үзэх явдалтай нийлүүлж оруулалгүйгээр үйлийн үрийн тийн боловсрол санаанд багташгүй гэдгийг баримталдаг бөгөөд хувилгаанаас хувилгаан төрөх ёсыг ертөнц бүгдээр хүлээн зөвшөөрдөг болой" хэмээжээ. Тиймээс хоёр үнэний агуулгад багтдаг үнэмлэхүй үнэнийг нотлон үзүүлэх ухаанаар янагуухийн агуулгыг хорловоос (үгүйсгэвээс) хоёр үнэний агуулга томъёолол хоорондоо

харшихад хүрнэ. Чингэвэл хоёр үнэний агуулгад онцгойрох мэргэн яаж болох вэ? Тэрхүү хоёр агуулгад ямар ч харшлах зүйл байхгүй үнэмлэхүй үнэнийг нотлон үзүүлэх ухаанаар янагуух үнэний агуулгыг сөхөөнө гэдэг бол харш зүйл болно. *"Тодорхой үгт"*-ээс:

"Та болвоос үнэмлэхүй болоод янагуух үнэнд мэргэн болоогүй учраас заримдаа үл тааруулж, зохисгүй ухаанаар тэдгээрийн агуулгыг эвдэлнэ. Бид болвоос янагуухийн үнэний агуулгыг мэдэх учир ертөнцийн талыг баримтлах буюу. Ганцхан янагуухийн зүгийг арилгахын тулд байгуулсан "таарамж нь бусадтай таарна" гэдгийг бусад ч няцаадаг Ертөнцийн өтгөс дээдэс адилаар ертөнцийн ном ёсноос доройтсон зөвхөн таныг няцаасан мөн. "Янагуух бус аа" хэмээх янагуухиас доройтсон тогтсон таалал өгүүлэгчийг хорьсон болохоос янагуухийг хориогүй болно" хэмээн айлджээ.

Хоосон чанарыг шинжих ухаанаар (янагуухийг шинжвэл) янагуух эвдрэх тул хоёр үнэний агуулгад мэргэн бус болно" хэмээжээ. Иймээс янагуух, дүрс тэргүүтнийг ухаанаар хорино гэдэг энэ багшийн таалал ерөөс биш ээ. Товчилбоос, хоёр үнэний талаарх Төв үзэлтний үзэл баримтлал төдийгүй, Хутагтын орны (Энэтхэгийн) тогтсон тааллыг өгүүлэгч нарын болон манай аймгийн мэргэдийн баримтлах ёсыг хоёр үнэний агуулгатай таарахгүй харшилна гэж бусдын зүгээс өгүүлсэн ч бий. Гэсэн ч тэд өөрсдийн томъёолж байгаа хоёр үнэний баримтлалдаа "үнэмлэхүйн зүгийн ухаанаар янагуух утгыг сөхөөнө гэж огт үздэггүй" хэмээн өгүүлсү бид.

13

ШАЛГАДАГ УХААНААР ШИНЖИХ НЬ

/б/ Шалгадаг ухаанаар бүтэх, эс бүтэхийг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх

---oOo---

/б/ Шалгадаг ухаанаар бүтэх, эс бүтэхийг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх. Дүрс тэргүүтнийг авч үзэхдээ шалгадаг ухаанд баригдаагүй бол зөвшөөрдөггүй, шалгадаг ухаанд баригдсан бол зөвшөөрдөг билээ.

Асуулт: Чингэвэл "хамаг зүйлс ертөнцийн шалгадагаар болохгүй" хэмээсэн нь хэрхэн тохирох вэ?

Хариулт: Үүний утга нь ертөнцийн харах мэдрэхүй зэрэг мэдрэхүй сэтгэлүүд нь хоосон чанарыг (оносон) шалгадаг ухаан болж чадахгүйг үзүүлснээс бус хамаг мэдэгдэхүүн бүхэн шалгадаг ухаанаар мэдрэгдэхийг үгүйсгэээгүй болно. Тийм учрыг *"Орохуйн тайлбар"-т:*

Чингэхлээр хоосон чанарыг мэдэхэд зөвхөн хутагт нарын шалгадаг ухаан хэрэгтэй. Хутагт бусууд нь үл болмой. Хэдий ертөнцийнхэн эсэргүүцэл гаргана гэж үзээд, хоосон чанарыг шинжихэд ертөнцийн ухаанаар буюу шалгадагаар болно гэж үзвэл л тийм байж болох ч

Хэрвээ ертөнцийн шалгадагаар мэдэх болвол
Ертөнц хоосон чанарыг үзэх учир, тусгай хутагтын
Хэрэг юун хутагтын мөрөөр ч юу хийх
Тэнэгүүд шалгадагаар мэдэх нь зохисгүй болъюу хэмээжээ.

Түүнийг *"Гадаад тайлбар"-т:*

Зөвхөн харах зэргээр хоосон чанарыг магадлах болчихвол хутагтын мөрийг ухаарч мэдэхээр шагшаавад сүрэгнэх, сонсох, санах, бясалгах зэргийг нягтлан судлахын үр жимс хэрэггүй болох нь ээ гэвэл тэр тийм бус бөлгөө. Тийм учраас л "хамаг зүйл ертөнцийн шалгадагаар бус учраас хоосон чанарын үест зөрчил гарахгүй хэмээн айлджээ.

"Ухааны жаран шүлэгтийн тайлбар"-т өгүүлэхдээ: "Тэдгээрийн "буй" гэж үзэж байгаа нь ч хоосон чанарыг үзэж байгаа бус. Тэр учрыг Ялж төгөлдөр нөгчигсөн бээр, "Нүд, чих, хамар ч шалгадаг ухаан бус" хэмээх зэргээр шууд бус утгаар айлдаж, ялгамжаат орон болох хоосон чанарын хувьд шалгадаг ухаан болж чадахгүй гэж хорьсноос бус бусад мэдэгдэхүүн дээр тийн бус болох нь маш тодорхой харагдана. Чингэхгүй аваас ямар ч барилдлагагүй болоход ч хүрнэ.

"Харах мэдрэхүй эдгээр нь нэрийдлийн утгат дүрс, дуу зэрэгт шалгадаг ухаан мөн болохоор л хоосон чанарыг мэдэхийн тухайд хутагтын мөрийг эрэлцэх хэрэггүй болно доо" гэж хэлбэл "харах мэдрэхүйгээр дүрсийг мэдэрчихээр л дууг сонсоход чих хэрэггүй болно" гэсэнтэй адил болно. Дүрс, дуу тэргүүтнийг мэдэхийн тулд хутагтын мөрийг эрэлцэх хэрэггүй гэж хэлбэл зөвшөөрч болох агаад зөвшөөрөхгүй гээд ч юу болох вэ? *Асуулт: "Дөрвөн зуутын тайлбар"-т ч:*

Энэхүү эрхтний тийн мэдэл (мэдрэхүй) үүнийг илт мэдэл гэж өд зүүх (хөөргөх) ба бусдыг нь шалгадаг ухаан гэж атгаглан үзэх тэдгээр нь машид учир холбогдолгүй болно. Хуурмаггүй сэтгэл нь ертөнцийн шалгадаг ухаан гэж тооцогдох ба тийн мэдэл түүнийг хурж үйлдсэн учир хуурмаг бас илбэтэй адил хэмээн Ялж төгөлдөр нөгчигсөн бээр айлдсан бий. Нэгэнт хуурмаг жамт илбэтэй адил учраас тэрээр үнэн болж таарахгүй. Өөр байдалтай орших зүйлсийг өөр байдлаар нь мэдэх учиртай. Тийм болохоор шалгадаг зөв зүйл гэж болохгүй. Чингэвээс тийн мэдэл бүгдээр шалгадаг болж хэтийдэхэд хүрнэ.

хэмээн харах мэдрэхүй тэдгээр бүгдээр шалгадаг болно гэдгийг ерөнхийд нь хорьжээ. Гэвч үүнийг хэрхэн тайлбарлах вэ?

Хариулт: "Нүд, чих, хамар ч шалгадаг бус" хэмээн харилцан адилгүй сэжих орон олон тул нягтлан номлосугай.

Тийнхүү харах мэдрэхүй тэргүүтнийг "илт мэдэл" болон "шалгадаг ухаан" мөн болохыг хориглож байгаа нь урьдийн мэргэдийн тааллыг хааж буй хэрэг учраас эхлээд тэдний үзэл баримтлалаас өгүүлсү. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:*

Эдгээр мэргэд нь ертөнцийн утгыг гүйцэд судлаагүй учир нь нялх, идэр залуугийн адил зөвхөн анхдагчийн үүднээс л судалсан аж. Орших хур мэдэл нь шулуун нэгнээс хагацсан байна. Таван эрхтний тийн мэдэл нь өөрийн орон вишайн өгүүлж болшгүй бэлэг чанар төдий нэгнээ орох учир илт мэдэл хэмээн

өгүүлнэ" хэмээсэн мэт атгагаас хагацсан эндүүрэггүй ухааныг илт мэдэл гэж үзнэ.

Өөрийн бэлэг чанараар орон вишайн орших дагуу барих ба таван эрхтний илт мэдэл тавуул өөрийн бэлэг чанарыг мэдрэх ба дуу, дүрс зэргүүдийн бэлэг чанар нь тэрхүү таван илт мэдлүүдийн мэдэгдэхүүн орон болох ба тэдгээр шалгадаг болохдоо тэдгээр таван орныг өөрийн бэлэг чанартай гэж үздэг учраас "эндүүрэггүй" болдог байна.

Гэтэл энэ багш маань саяын үздэг шиг өөрийн мөн чанараар бүтэх буюу өөрийн бэлэг чанараар бүтсэн гэж нэрийн төдийд ч үзэхгүй тул эрхтний тэдгээр мэдлүүд өөрийн бэлэг чанараа мэдэх шалгадаг ухаан болно гэж хаанаас үзэх вэ. Тиймээс энэ үест тэдгээрийг шалгадаг болохыг хориҳдоо тэдгээрүүд таван орны өөрийн бэлэг чанарыг онох шалгадаг ухаан болно гэдгийг хаасан хэрэг ээ. Хорих ёсны хувьд Ялж төгөлдөр нөгчигсөн бээр тийн мэдэл нь "хуурмаг, худал" гэж айлдсан түүгээр няцаах буюу.

Тийнхүү хуурмаг болохыг айлдсан нь хуурмаггүй болохыг хориглож, дээр нь шалгадаг мөнийг ч хорьсон хэрэг. Шалгадаг байхын мөн чанар нь хуурмаггүй байх учиртай. Ер нь хуурмаг гэж юуг хэлэх вэ хэмээвэл, "Өөр өөр байдалтай орших зүйлийг өөр бусад байдлаар үзэх" хэмээн айлдсан эл утга билээ. Дүрс, дуу тэргүүтэн таван орон тэдгээр нь эрхтний мэдрэхүйд тусахдаа өөр өөрийн бэлэг чанараар бүтээгүй хэдий ч өөрийн бэлэг чанартай мэтээр үзэгддэг учраас л тэдгээрийг өөрийнхөө бэлэг чанарт шалгадаг мөн гэж үздэг.

Товчлон хэлбэл, тэдгээр эрхтний мэдрэхүй нь таван мэдэгдэхүүний бэлэг чанарыг оносон шалгадаг болж чадахгүй. Учир нь таван мэдэгдэхүүний өөрийн бэлэг чанарыг үзэхтэй харгалзуулбаас хуурмаг бөгөөд таван орон өөрийн бэлэг чанараар хоосон байтал бэлэг чанартай мэтээр үздэг билээ. Үлгэрлэвээс, нэг сарыг хоёр болгож харах сэтгэлтэй адил хэмээн болгоожээ.

Энэ үест *"Бодит өгүүлэгч" нараас:* "Дүрс, дуу тэргүүтэнд өөрийн бэлэг чанараас бүтсэн мөн чанар байхгүй болчихвол тэд бүгдээр "тусыг үйлдэгч" хамаг чадлаасаа хоосорч "бодит зүйл" биш болно. Таван мэдэгдэхүүний өөрийн бэлэг чанарыг онох илт мэдэл болж чадахгүй бол таван мэдэгдэхүүнд ч шалгадаг болохын газаргүй. Таван мэдэгдэхүүнд шалгадаг болбол тэдгээрийн өөрийн бэлэг чанарт ч шалгадаг болно" гэх зэргээр үздэг. Энэ багш болбоос өөрийн бэлэг чанар буюу мөн чанараас бүтсэн л бол үнэхээр бүтсэн болно гэх ба тийм нөхцөлд мэдэгдэхүүнээ үнэнээр бүтсэн гэж оносон шалгадаг ухаан нь

өөрийн бэлэг чанараа онох шалгадаг болох учиртай. Гэвч мэдэгдэхүүн хуурмаг учраас л түүнийг сайтар онох шалгадаг нь өөрийн бэлэг чанараа шалгадаг болж чадахгүйд хүрч байна. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас*:

Ертөнцийн ухаанаар хоосон чанарыг үзэж тодорхой мэдэж чадахгүй ээ. Тэр ухаан нь зөвхөн ертөнцийг л шалгадаг буюу. Түүний тухайлсан (барьсан) утга нь хуурмаг худлын жамт болж бүтсэн тул, хэмээжээ.

Тиймээс өөрийн бэлэг чанар дээр шалгадаг болохыг хорьсноор шалгадаг ухаан төдийг үгүйсгэсэн хэрэг бус. Тиймээс нэрийтгэлийн сэтгэлүүдийг нь нийтэд нь шалгадаг болохыг үгүйсгээгүй болой. Чингэлгүйгээр ертөнцөд хуурмаггүй гэх сэтгэл болгоныг шалгадаг гээд байвал бас зохисгүй. Нэрийдлийн сэтгэл бүгдийг шалгадаг болохыг няцаасан буй. *"Тодорхой үгт"-ээс ч:*

Тиймээс тэдгээр дөрвөн шалгадгаас өөр ертөнцийн утгыг онох бий гэж үзвэл илт мэдэл, жишин мэдэх, эшийн болон үлгэрт шадарлан мэдэх шалгадгуудын агуулга тодорхойлттой харшлахад хүрнэ. Шалгадаг болоод мэдэгдэхүүн нь мөн чанараас бүтсэн гэхийг хорьсон болохоос шалгадаг болон мэдэгдэхүүнүүд нь хоорондоо харилцан хамааралтай байдаг шүтэн барилдлагыг хориогүй шүү дээ.

"Түүнээс" ч: "Тэдгээрүүд ч инагш чанагш харгалзан бүтсэн буюу. Шалгадаг зөв аваас мэдэгдэхүүн утга нь зөв байдаг. Мэдэгдэхүүн утга нь зөв аваас шалгадаг ухаан нь зөв байдаг. Түүнээс бус шалгадаг болон мэдэгдэхүүн хоёр нь мөн чанараас бүтсэн нь үгүй билээ" хэмээжээ.

Тиймээс хөлхөлгөө зэрэг гадна, дотны эндүүрлийн шалтагаар уршигдах хорлол ч гарахгүй бол мунхагаар уршигдсан эрхтний мэдрэхүй сэтгэлүүд нь өөрийн мөн чанаргүй атал тийм мөн чанартай гэж уг орноо барих үзэгдлийг эндүүрэхээс бус үнэн нэрийдлийн утгаа онохдоо эндүүрээгүй болно. *"Орохуй"-гаас:*

Үзэгдэл хуурамч хэдий ч хоёр зүйл буюу
Эрхтэн тунгалаг тодорхой болон гэм хавсарсан ч буй
Гэм хавсарсан эрхтний мэдрэхүйг
Зөв сэтгэлтэй харгалзуулан буруу гэж үзэх
Эрүүл зургаан эрхтэнд баригдах
Аливаа нэгнийг ертөнцийнхөн онох ба
Ертөнц ямагтаас зөв "үнэн"-д үзэх буюу
Үлдсэнийг ертөнцийнхөн "буруу"-д тооцох

хэмээн нэрийдлийн сэтгэл болон мэдэгдэхүүн орныг нэрийдлийн сэтгэл ямагтад харгалзуулан чанх зөв, чанх буруу гэж хоёр хоёроор ялгажээ. Дотор талаас эрхтэнг хорлох шалтгаан байдаг талаар Чандракиртийн "*Орохуйн тайлбар"-аас:*

Нүд бүрэлзэх (хөлхөлгөө), нүд шарлах болон додүра өвс идсэн зэргээр дотор талаас эрхтэнг хорлох шалтгаан буй хэмээн айлджээ.

Гадна талд байх шалтгааны талаар мөн "Дээрх"-*ээс:*

Улаан дэл будаа, ус мөрөн, толь болоод хад агуйнаас гарах дуу цуурайнууд бас нарны гэрэл цаг хугацааны ялгаанаас болон юмс үзэгдэлд ойж тусах зэрэг нь гадна талаас эрхтэнд хорлол учруулах нөхцөл болдог. Тэдгээр нь эрхтэнг дотроос хорлох нөхцөл болох ба би (эзэн) байхгүй хөрөг дүрсийг (би гэж) барих, хадны цуурай, зэрэглээ зэргийг ус гэж бодох зэргийн үндэс болж өгдөг. Мөн илбэчин хүний сайтар бэлдсэн тарни, эм тан зэргийг ч мөн тийн ойлгоорой. Мөн дотоод сэтгэлд хорлол гарахад дээрхүүд болоод буруу тогтсон таалал үзэл онолууд болон мөн тэднийг дагалдан гарсан бодлууд багтана" хэмээн буруу тогтсон таалал, буруу учир шалтгаан зэргүүд нь дотоод сэтгэлийг булингартуулах үндэс болохыг ч айлджээ.

Басхүү зүүдлэх үед сэтгэлийг уршигдуулах шалтгаанд нойр зэргийг ч багтаажээ. Чингэхлээр дараа үзүүлэх мунхаг сэтгэлийн барих орон хэдийгээр нэрийн төдий ч байхгүй боловч энэ үест мунхагаар уршигдах хорлолыг хорлолын шалтгаан болгож аваагүй байна.

Асуулт: Хэдий таван эрхтний мэдрэхүй сэтгэлүүд нь бусад ямар нэг хорлол гарахгүй нөхцөлд нэрийн төдий ч эндүүрэлгүй гэж тооцогдвол тэдний үзэх "өөрийн бэлэг чанар" нь мөн л нэр төдийд орших хэрэгтэй болно. Үүнийг энэ багш зөвшөөрдөггүй билээ.

"Тиймээс л эндүүрэлтэй байдалд зайлшгүй тулж байна. Чингэвэл тэдгээр сэтгэлүүд нь дүрс, дуу тэргүүтний нэрийдэл гэж тийн агуулах (мэдэх) шалгадаг болж таарахгүй буюу нэрийдлийн дүрс зэрэгт ч эндүүрсэн байна шүү дээ? Энэ талаар хэлэлцсүгэй.

Хариулт: Энэ тухай *Бхававивека /Лэгданжэд/ багш бээр:* "Дүрс тэргүүтэн нь нэрийдлийн төдий өөрийн бэлэг чанараас бүтсэн мөн чанартай" гэж үздэг. Сэтгэлийн төдийтөн нар үзэхдээ "хотол нэрийдэл" бүхнээ өөрийн бэлэг чанараас бүтсэн мөн чанар байхгүй учраас бэлэг чанар нь мөн чанар үгүй гэж үзэхийг хориглодог."Хотол нэрийдэл"-ийг сэжиглэгч ба нэрийдэгч

хоёроор шинжлэн мөн чанарт буюу ялгамжаат гэж сэжих дуу буюу нэрийдсэн өөрийн бэлэг чанарт мөн чанар сэтгэлд байхгүй гэж үзвэл "бусдын эрхэт бодит зүйл"-ийг басамжилсан болно гээд хориглох тул "бусдын эрхэт нь нэрийдлийн төдий өөрийн бэлэг чанараас бүтсэн мөн чанарт" гэж үздэг нь тодорхой. Энэ талаар Бхававивэка багш *"Билгийн зулын хорин тавдугаар дугаар бүлэгтээ:*

Хэрвээ энэ үед дүрс хэмээн сэтгэлдээ өгүүлэх, үгээр хэлэхийн хотол нэрийдэх мөн чанар тэдгээр хаана ч байхгүй гэвэл бодит бүхнийг дорд үзсэн буюу сэтгэл болон хэлэх үгээр өгүүлэгдэх бүхнийг басамжилсан болно хэмээн айлджээ.

Мөн *Авалогтиврата (Жанрайсэг дүлшүг) бээр "Билгийн зулын тайлбар"-таа:*

Энэ үед егүзэрийн явдалтан нарын хотол нэрийдлийн мөн чанарыг "бэлэг чанарын мөн чанар үгүй учраас мөн чанар үгүй" гэж хэлвэл дүрс хэмээгдэх түүний мөн чанар болоод ялгамжаа зэргийг сэтгэлдээ хэлэх, тийн атгаглах болон үгээр өгүүлэх, нэрийдэн сэжих зэргүүд нь ямар нэг бэлэг чанар буюу ямарваа бэлэг чанарын чанаргүй учраас мөн чанаргүй болой" гэж үзвэл янагуух болсон *"бусдын эрхэт"* бодит бүхнийг басамжилсан явдал болох тул тун зохисгүй мөнийг заав" хэмээн (өгүүлэх) дуу болон сэтгэлд баггах бусдын эрхэт бүхнийг нэрийдлийн бэлэг чанар байхгүй болой гэж үзвээс басамжлал болно ийн айлджээ.

Тэрхүү *"бэлэг чанарын мөн чанар байхгүй"* хэмээсний "бэлэг чанар" гэдэг бол "өөрийн бэлэг чанар" буюу "өөрийн мөн чанар" болно. Сэтгэлийн төдийтөн нар тэр чанар байхгүй байтал түүнийг "хотол нэрийдэл" гэж үздэг. *"Бусдын эрхэт"* эд юмст тэрхүү чанар байдаг учраас өөрийн мөн чанар байна гэнэ. Гэхдээ бусдаас төрдөг болохоор өөрөөс төрөхийн мөн чанар байхгүй гэж бас үзнэ. *"Судрын тааллын тайлбар"-т* мөн ийнхүү айлдаж "хамаг ном (юмсын) мөн чанар байхгүй хэмээн болгоосон" гэж айлджээ.

Камалашила багш бээр /"Төв үзлийн гэгээ"-дээ/: "Дээрх судраас мөн чанаргүй гурвын учир утгыг зааж хоёр хязгаараас хагацсан төв үзлийг сайтар ялган үзүүлсэн тул ямагт магад утгат гол номыг үзүүлжээ" хэмээжээ. "Бусдын эрхэт"-ийг үнэмлэхүй мөн чанарт гэвэл "өд зүүж" бүгдийг гүтгэсэн болно. Чингэлгүй нэрийдэх бусдын эрхэт нь өөрийн бэлэг чанаргүй байна гэх тэрхүү басамжлах үзлийг няцааж төв үзлийн утгыг заасан гэж үздэг. Энэ багш ч

нэрийдэх өөрийн бэлэг чанар буй гэж болгоодог. *"Орохуйн тайлбар"-т ч:*

Үлгэрлэвээс, могой нь хуйлсан эрээн дээсний үест "хотол нэрийдэл" болох ба харин жинхэнэ могой үестээ *"огоот бүтсэн"* болдог. Үүнтэй адилаар өөрийн мөн чанарт хэдий ч шүтэн барилдаж бий болсон "бусдын эрхэт" учраас "хотол нэрийдэл" болно. Бурханы мэдэгдэхүүн болох "огоот бүтсэн хэмээх гурван мөн чанарыг мэдэж ухааран судрын таалал утгыг номнох болой" хэмээжээ. Мөн тэрээр:

Алин судард тэр ямагт бус гэсэн утгыг
Гулзгай утгат гэж номносон ч ухаарч тайлбарлах

хэмээн тайлбарлан айлдсан байна. Тиймээс *"Судрын тааллын тайлбар"*-аас гурван мөн чанарын агуулгыг янагуух утгат гэж тайлбарлах хэмээн болгоосон нь тодорхой.

Өөрийн ёсны (Төв үзэлтний) хотол нэрийдэл гэхэд бусдын эрхэтийг өөрийн мөн чанартай гээд бусдын эрхэт нь нэрийдэх төдийд өөрийн бэлэг чанараар бүтсэн мөн чанар байхгүй гэж үздэг. Сэтгэлийн төдийтөн нар үзэхдээ "хотол нэрийдэл"-д багтахгүй "бусдын эрхэт" болон "огоот бүтсэн" хоёр нь бэлэг чанарт мөн чанаргүй гэхгүй харин тэр хоёуланд өөрийн бэлэг чанараас бүтсэн бэлэг чанар буюу мөн чанар бий гэж үздэг болохыг *"Судрын тааллын тайлбар"*-т голчлон тулгуурлаж үзүүлжээ. Тиймээс тэр хоёрыг үнэхээр бүтсэн гэж үздэг. Харин Буддхабалида болон Чандракирти багш нар "өөрийн бэлэг чанараас бүтэх тийм мөн чанар байх аваас л үнэхээр бүтсэнд тооцно" гэж үздэг. Бхававивека багш тэргүүтэн нар: "Тэр төдийгээр үнэхээр бүтсэн гэж болохгүй" хэмээн үздэг.

Мөн сэтгэлийн төдийтөн нараас: "Нарийн тоосны ширхэг бүхэн эрхтний мэдрэх орон болохгүй, харагдахгүй учраас" гэх ба "Олон зүйл хурж нэгдэх явдал нь ч түүний орон болохгүй. Эдэт (материаллаг) зүйл тэнд байхгүй учраас хоёр сар үзэгдэхтэй адил" хэмээсний хариуд Бхававивека багш *"Учир шалтгааны бадрал"-даа:*

Зөвхөн хуриж нийлээгүй нарийн тоос бол эрхтний мэдэх орон биш" гэж нотлохдоо нотлогдохуунаа нотлов" гэжээ.

Сүүлийн нотлолын тухай тэрээр:

Нэг язгуурын нарийн тоос нэг зүгт хурснаар жишээлээд тэрээр шалтгаан үндэс болж болохгүй л дээ, эдлэг зүйл болохгүй учраас" гэсэн учир шалтгааныг өгүүлбэл энэ шалтгаан нь "бусдыг үл бүтээх" ямагт болно. Энэ нь нэг язгууртай хирнээ өөр мөн чанартай нарийн тоос болох буюу өөр бусдууд түүнд туслах

нөхцөл байдал бүрдэх тул түүнийг өөрийн мэдэгдэхүүний мөн чанартай нэгэн гишүүн болгоод нарийн тоосон дотор хураагдсан зүйл гэж үзэх дуртэй эрхтний мэдрэхүй төрөх нь ээ.

Нэг язгуурын нарийн тоос хураагдаж байж гарч ирсэн хумх (бумба) зэргийг ч эдлэг зүйл гэж бид үзэх агаад нарийн тоостой адилаар буюу хэдий нарийн байлаа ч найман эдэд хурсан мөн чанарт тул түүнийг эдлэг материаллаг гэж лавтай үзнэ. Түүнтэй адил хуурмаг мөн чанарт хумх тэргүүтэн тийм эдлэг ямагт болно."Зөвхөн тэр нь үл бүтэх болой хэмээн хуралдаж буй нарийн тоос нижгээд нижгээд бүхэн эрхтэний мэдрэхүйн (төрөх ч) шалтгаан болох төдийгүй тэдгээр нь эдлэг болохыг болгоосон хийгээд нарийн тоосны хамгийн эцсийн тоос хүртэл тийн болно гэжээ.

Улмаар хуваагдашгүй нарийн тоосыг хүртэл "бодлын шалтгаан" гээд дээр номносон мэт эрхтний мэдрэхүй нь гадна, дотнын эндүүрлийн шалтгаанаар үл уршигдаж үл эндүүрэгдэх болохыг баримталж судрын аймгийнхантай адил "зоригдол шалтгаан болно" гэжээ. *"Орохуйн тайлбар"-аас:*

Судрын аймагтны ёсны үнэмлэхүй гэж өгүүлж буй тэр зүйлүүд төв үзэлтний янагуух болно" гэж зарим нэгэн үзэх нь төв үзлийн шастараас үзүүлсэн хоосон чанарыг огт мэдээгүй өгүүлэгч байна гэж мэдээрэй" хэмээжээ. Мөн "Өвөрмөц өгүүлэгч нарын янагуух мөн гэж үзэх алив зүйлс төв үзэлтэн нарын үнэмлэхүй болой хэмээн сэтгэгч тэдгээр нь ч шастарын мөн чанарыг огт ухаараагүйг харуулна. Иймээс ертөнцөөс нөгчигсөн номыг ертөнцийн номтой жиших нь зохисгүй буюу. Эл ёс нь бусдаас ангид, нийт бусын ёс хэмээн мэргэд таньж аваарай,

хэмээн зарлигласан учраас энэхүү нийт бусын тааллын аймгаа харуулах нэг жишээ нь орон, оронт зэргүүд нь "хувь үгүй" (хуваагдашгүй) зүйл гэж ерөөс таалдаггүй болно. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас*:

Манайхан Өвөрмөцтөн (Vaisesika) нар шиг эдэт нарийн тоосыг авч үзэж болохгүй" хэмээн "тоосыг хувьгүй" гэж үзэж хэрхэвч болохгүй хэмээжээ.

Эдгээр хоёр аймгийнхны үнэмлэхүй гэж үздэг зүйлийг Төв үзэлтэн нар янагуух ч гэж үзэхгүй байгаа нь зөвхөн хувьгүй "хэмээгдэх" бодит (бодас) зүйл дээр л илэрхийлэгдэнэ. Түүнээс бус тэр хоёрын үнэн гэж үзэж байгаа алив бүхнийг Төв үзэлтэн нар янагуух гэж авч үзэхгүй гэж заагаагүй билээ. Тэд нар дүрс, дуу зэргийг үнэн гэж үздэг хэдий ч Төв үзэлтэн нар түүнийг нь янагуух гэж үздэгтэй адил.

"Дөрвөн зуутын тайлбар"-таа: "Эрхтний нарийн тоос цуглархын үесийн нижгээд нижгээдээс эхлэн эрхтний мэдрэхүйн үндэс гэж үзэхийг хориглох, эрхтнүүд нарийн тоос болвол өөрөө болох уу эсвэл өөр зүйл болох зэргийн алин болохгүй, тэдгээрт шүтэн нэрийдсэн тийн мэдрэхүйн суурь болох ба улмаар орон мэдэгдэхүүнүүд нь ч шүтэж нэрийдсэн нэрийтгэл болоод эрхтний мэдрэхүйн орон болно" гэжээ.

Сэтгэл мэдэгдэхүүнүүдийг илт нэрийдсэн илт мэдэл гэх ба мэдэгдэхүүнүүдийг илт мэдлийн бэлэг чанартууд болно" гэж энэ багш болон Бхававивека багш хоёул гадаад утга дээр таалал адил хэдий ч эрхтэн болоод мэдэгдэхүүний тодорхойлолт дээр зөрөөтэй нь харагдана. Дээрх тайлбарт "эрхтний мэдрэхүйд өөрийн бэлэг чанартай шалгадаг байхыг хориглох үест "өөр байдалд байгаа бодит зүйлийг өөр байдалтай үзэх болой" гэж айлдсан тул эрхтний мэдрэхүйд дүрс, дуу тэргүүтэн өөрийн бэлэг чанараар бүтсэнээр үзэгдэх (санагдах) хэдий ч үзэгдэж байгаа шигээ өөрийн бэлэг чанараар нэрийн төдийд ч байдаггүй учир энэхүү багш бээр тэдгээрийг нэрийн төдийд ч эндүүрэлтэй гэж үздэг аж. Гэсэн хэдий ч эрхтний мэдрэхүйнүүдийг дүрс, дуу тэргүүтнийг нэр томъёоллын хувьд таньж барьдаг шалгадаг ухаан гэдгийг үгүйсгэсэн хэрэг биш. Тэдгээрийг эндүүрэлтэй гэж үзэх шалтгаан болсон "*өөрийн бэлэг чанараас бүтсэн*" хэмээхийн утга "үгүй" болохыг нь өөр мөн чанарын буй, буй бусыг шинжлэгч язгуурын ухаанаар олж мэдэх учиртай.

Нэрийдэх шалгадаг ухаанаар ерөөс оножн чадахгүй тул нэрийдлийн сэтгэлтэй харгалзуулахад эндүүрэлтэй зүйл биш л дээ. Сарыг хоёр гэж үзэх, толины доторхи дүрс тусгал зэргийг харах мэдрэхүйнүүдэд үзэгдэх хоёр сар, нүүр царай зэрэг нь байхгүй нөхцөлд язгуурын ухаан зэрэгт харгалзалгүйгээр зөвхөн нэрийдлийн шалгадаг ухаанаар бий болбол тэдгээрүүд болон дээрх бүгдэд үнэмлэхүй болон янагуухийн тийн ялгалууд нь таарах билээ. Хэдий язгуурын ухаан болон нэр томъёоны шалгадаг ухаанд харгалзуулан эндүүрэлтэй ухааны ялгааг гаргаж болох ч толины доторх дүрс зэрэг үзэгдлүүд мөн чанаргүйн адилаар өөрийн бэлэг чанартай гэж үзэх нь утгагүй нэгэн болно.

Асуулт: Гэсэн ч "*өөрийн бэлэг чанараас хоосорсон дүрс*" тэргүүтэн байдагтай адил толин доторх дүрс зэргээс "хоосорсон" дүрс зураг тэргүүтэн ч байж болно. Чингэвэл тэдгээрт өөрт буй нэр томъёоны ухаанд ч харгалзах зөв, буруугийн ялгавар гарахгүй юу?

Хариулт: Гэвч өөрийн бэлэг чанараар бүтэх мөн чанар болоод толинд харагдах дүрс хоёр нь утгын хувьд нэрийн төдий ч байхгүйгээрээ адилхан

ч дүрс болон түүний тусгал болох дүрс зураг хоёулаа нэр төдийд оршихын хувьд бас адил буюу. *“Орохуйн тайлбар”-аас:*

Шүтэж харгалзан гарсан дүрс зураг, хадны цуурай алин ч байсан хуурмаг хэдий ч төгс мунхагууд тийн үзнэ. Хөх өнгө зэргийг дүрс, сэтгэл, амсуурга тэргүүтнүүд өчүүхэн төдий ч “үнэнд” үзнэ. Төгс мунхагууд жинхэнэ мөн чанарыг хэзээ ч үзэхгүй болой. Тиймээс тэдний алин нэг нь янагуух болж худал боллоо ч янагуух үнэн болохгүй” хэмээж, “хөх өнгө тэргүүтнийг янагуух үнэнд үзэх ба дүрс, тусгал зэргийг янагуух үнэнд үл үзэхийн ялгаа байхгүй гэж хэлбэл юу гэж хариулах вэ? гэж тэрээр ялгааг асуужээ.

“Тэр хоёул янагуух нэрийдэх жирийн сэтгэл мэдрэхүйд адилхан тусаж мэдрэгдэвч дүрс, зураг зэргийг ертөнцийн ухаанаар худал гэж онох тул ертөнцийнхөн янагуух үнэнд тооцдоггүй. Хэдийгээр хөх өнгө зэрэг худал хэдий ч түүний худал болохыг ертөнцийн ухаанаар мэдэж болохгүй учраас л ертөнцийнхөн янагуух үнэнд багтаасан болов уу?” “Тэрхүү хоёр орныг янагуух нэрийдэх сэтгэлд харгалзуулан үнэн, худал гэж тогтоодогтой адилаар хоёр мэдрэхүй ухааныг ч мөн л нэр томъёоны ухаанд харгалзуулан зөв, бурууг тогтоодог болой”

Асуулт: Хэрвээ “янагуух нэрийдэх сэтгэл”-д харгалзуулан зөв боллоо ч ертөнцийн нэр дээрээ эндүүрэгтэй болж харшлах юм биш үү?

Хариулт: Нэрийдлийн гэж эндүүрэх эндүүргийн гэзрын янагуух томъёо болон аль ухаанд харгалзуулснаас зөв гэж тооцогдох янагуух ухаан хоёрын нэгэн зүйл гэвэл хоорондоо харшлах буюу. Гэвч тэрхүү янагуух гэх хоёр нэрийдэл тус тусдаа болбол харин юу харшлах билээ.Хэрхэн тэд ялгагдах вэ?

Ингэхлээр дүрс тэргүүтний өөрийн мөн чанараас бүтсэн мөн чанарыг учир шалтгааны үүднээс үгүйсгэнэ гэдэг үнэхээр үл болох бөгөөд харин нэр томъёогоор л үйлдэх хэрэгтэй. Тийм нэр томъёоллыг ухааны тэр нигуурт (тайлбарт) эрхтний сэтгэлүүд нь эндүүрэлтэй байна.Түүнээс бусад өөрийн дураар байх нэрийдэх ухааны нигуурт эндүүрэггүй байхад харшлах зүйлгүй ээ.

Үлгэрлэвээс, Ертөнцийн нэр томъёонд “заримууд буй”, “заримууд буй бус” хэмээхтэй адилаар зарим хэмээх үг нь нэг боловч буй заримууд, буй бус заримууд хоёрыг нэг утгатай гэж үзэж болдоггүйтэй адил болой. Тэр эндүүрэггүй байхын хувьд өөрийн дураар буй ертөнцийн сэтгэлд харгалзуулсан болохоос, төв үзэлтэн нараас эндүүрэггүй гэж үзэхгүй буюу “ертөнц ямагтдаа л үнэн мөн” хэмээх зэргээр айлдсантай адил буюу. Тиймээс Төв үзэлтэн нар тэдгээрийг эндүүрэгтэй гэж үздэг. Гэхдээ мэдэгдэхүүнийг

хуурмаг гэж үзэхтэй харшлахгүй болой.

Хамаг ном юмс илбэ мэт нэр төдий гэж үзэх учраас хэдийгээр нэр томъёо төдий хуурмаг боловч янагуух үнэн болоход харшлахгүй буюу. "Мунхагийн мөн чанараар халхлагдсан тул хотол хуурмаг" хэмээсний янагуух нь мунхаг түүний нигуурт "үнэн" болох ба хамаг номыг өөрийн мөн чанараар бүтэхийг хоригч (хорихуйн үнэн) алины нигуурт агуулагдах янагуух нь түүний (хоригчийн) нигуурт "худал" байх хоёр үл харшлах болой.

"Хотол янагуух болох хэдий ч худал болдог тэр нь янагуух үнэн болохгүй" гэж айлдсан нь нэр томъёоны шалгадгаар худал гэж оносноор нь агуулсан хэрэг. Нэр төдий худал бүхнийг тийн тодорхойлж болохгүй.

(Янагуух оршихуй) Тийнхүү төв үзэлтэн нар өөрийн ёсондоо сансар, нирваны хамаг ном юмс нэр төдий оршино гэж үзнэ. Бодит өгүүлэгч нарын өөрсдийн үзэл буюу нийт бусын гэж алдаршсан эдгээр утгыг нэр төдийд байна гэдгийг ч ийнхүү үгүйсгэн хорих нь машид бэрх билээ. Тиймээс хоёр үнэний мөн чанарыг жинхэнэ зөвөөр таньж мэдэх явдал "өдрийн од" шиг үзэгдэнэ.

Ийнхүү бодит өгүүлэгч нарын үздэг янагуух байдалд оршихуйг хориглоход учир шалтгааны шинжлэлийг хийж хорих хэрэгтэй. Өөрсдөө (төв үзэлтэн нар) янагуух ёсоор төрөх, түрдэх зэргийг буй гэж үзэхдээ ч ухаалаг зөв эш баримтлал гаргахгүй бол нотолгоо нь үгүйсгэгдэж болно.

Басхүү ухааныг даган бараадагч нарт дулдуйдсан болой гээд ухаанаар шинжлэхдээ өөрсдийн баримтлах "янагуух" болон "бодит өгүүлэгч "нарын үзэх" хотол нэрийдэл" хоёр нь учир шалтгааны үүднээс харшилдах аваас зөрчлийг тэнцүүлэх ба эс харшилваас зөрчилдөхгүй байна гэж үзээд (ертөнцийн тэнгэр) Вишнү болон Зову тэргүүтний нэр төдий байхгүй гэх ба харин дүрс тэргүүтнийг байхгүй гэж үзэх хэрэгтэй болно. Тэдгээрийг нь нэрийдэлд буй гэх аваас Вишнү тэргүүтэн ч байна" гэж үзэх хоёр адилхан болж ирнэ.

Алив номыг өөр өөрийн ёсондоо энэ мөн, энэ бус хэмээн танин мэдэх, авч үзэх алиныг ч үйлдэлгүй байвал төв үзлийн мөн чанарыг (хоосон чанар) олсон болно гэж хий хөөрөмшин тэр мэтийн ухаарлыг даган дуурайж юу ч бодохгүй, санахгүй байхыг нь асар арилсан утгыг бясалгаж байгаа хэрэг гэж үзэгч нар маш олон байна. Иймэрхүү хүмүүс нь мэргэд баясах ярианд үл багтана.

Дээр номносон дагуу ухааны хоригдохууныг танин барихгүй бол мөн чанарыг үгүйсгэх ухаанаар янагуухийн агуулга бүхнийг эвдэж болох бөгөөд үнэмлэхүй үзэл болон буруу үзлүүдийг эндүүрвээс эндүүрлээ хэмээгээд эс эндүүрвээс эндүүрсэнгүй гээд явах их буруу үзэлтэй болно шүү. Чингээд

энэ мэтийн зүйлдээ удаан хугацаанд сурч дадсаар үнэмлэхүй үзэлд өчүүхэн төдий ч ойртох байтугай улам холдож, улмаар сансар, нирваны шүтэн барилдах утга учир болон эл ёсны шүтэн барилдаж гарсан мөртэй машид харшлах болно. Тийм учрыг *"Төв үзэлд орохуй"-гаас:*

Үл мэдэхийн нойронд сайтар бүжих тэртэгүүд
"Би" хэмээн хэрхэн нэрийдэн дуудах болон
Илбэ, зэрэглээ зэргээр алин нэрийдэвч
Тэр бүгд ертөнцөд ч буй бус бөлгөө

хэмээн тэртэгүүд (тэрсүүд буюу бурханы номын бус үзэлтэн) нарын нийт бусын үзэл болон дээр үзүүлсэн манай бодит өгүүлэгч нарын нийт бусын үзэл баримтлал гэгддэг нэрийдлүүд нь энэхүү "ёсны" янагуух утгад ч "байхгүй" хэмээсэн утгыг номножээ.

Энэ үест нэр томъёо төдийд буй, буй бус гэх хоёрыг хэрхэн юуны үүднээс ялгах вэ? Нэрийдлийн ухаанаар алдаршсан /1/ бол, бусад нэрийдлийн шалгадаг ухаанууд тэрхүү алдаршсан утгыг үл үгүйсгэх /2 /ба, хоосон чанар болоод мөн чанарт буй, үгүйг шинжигч ухаанаар үл үгүйсгэгдэх нэгэн /3/ болвоос түүнийг нэрийдэлд орших байна гэж үздэг. Тэдгээрээс буцсан бол үгүйсгэж үзнэ. Зөвхөн харсан, үзсэн дагуугаа даган орсон төдий буюу түүний ухаанд хэрхэн үзэгдэх тэрхүү утга төдийгөөр орох юм уу, эсвэл утга, мөн чанар хэрхэн бүтсэн зэргийн огт шинжлэлгүй орох сэтгэлүүд зэргүүд багтана.

"Хоосон чанарыг үл шинжигч ухаан хэмээсэн ч огт юу ч шинжихгүй гэсэн бус" Энэ сэтгэл нь ертөнцийн буюу нэрийдлийн сэтгэлүүд бөгөөд зөвхөн хэрхэн харсан, үзсэн дагуу орно хэмээн алдаршсан. Чухам мөн чанар юу болохыг ажиглахаар ороогүй болно.

"Ертөнцөд алдаршсанаар" (ердийн ойлголтоор) хэмээдэг нь ч ийн буюу. Тогтсон таалалд ухаан урвасан, урваагүй хэн бүхэнд ийм ухаан байх бөгөөд хэний ч үндсэнд байсан ялгалгүй "ертөнцөд алдаршсан буюу үл шинжигч ухаан" хэмээжээ. Зөвхөн тогтсон таалалд ухаан урваагүй ертөнцийнхний үндсэнд байна гэж үзэж болохгүй.

Тогтсон таалалд ухаан урвасан хэн нэгэнд ч хэрхэн нэрийдэл, томъёоллын ёсоор оносон ухаан эсвээс хоосон чанар бол ийн болой гэх зэргээр ажиглах, шинжлэх зэрэг олон ухаан байж болно. Гэхдээ түүний хамаг сэтгэл нь жинхэнэ мөн чанарыг оносон байх гэж хаанаас байх вэ. Ертөнцөд алдаршсан дагуу мөн боловч өвгөн ертөнцийн үзэл баримтлалаас зөвхөн салсан болон ижилсэх ч хэрэггүй. Эсэргэлдэгч нарын үндсэнд буй үл шинжлэх, ажиглах ухааны хэрхэн хаашаа халдаж байна гэдгээр л

тодорхойлно. Тэрхүү сэтгэлд ухаанд алдарших гэдэг нь үзэж харах буюу амсах мэдрэхийн томъёоллын суурь болсон тэдгээр болой.

Үйлийн үр, зам мөр зэргүүд эгэл жирийн ардад үл алдаршсан (үл онох) ба сонсоод санаж бодоод ирэхийн цагт мөн чанарыг юу болохыг үл шинжигч ердийн ухаанд ч санагдах мэдрэгдэг болох тул (тэр үед) ертөнцөд алдаршсан бус болоход гэмгүй.

Нэрийдлийн шалгадаг ухааныг бусдууд үгүйсгэхдээ: Үлгэрлэвээс, эрээн дээсийг могой гэж үзэх, зэрэглээг ус гэх зэргээр барих үест мөн чанар гэж юу болохыг шинжих ухаан хэрэггүй, жирийн ухаанаар барьж болно гэвч тэдгээрийн барьсан утгуудыг нэрийдлийн шалгадаг ухаанаар ч үгүйсгэдэх тул тэдгээр нь нэрийдлийн төдий ч буй бус болой.

Өөрийн мөн чанар буй, буй бусын ёсчлон шинжих ухаан нь гэмгүй зөв тул нэрийдэлд багтах утгууд нэрийдсэн мөнийг шалгадгаар нотлогдсон байна. Мөн буй, үгүйг ёсчлон шинжигч ухаанд хэзээ ч үгүйсгэл гарахгүй байх нь магад хэрэгтэй. Тэрхүү ухаанаар буй гэж нотлогдвоос өөрийн мөн чанараар буй гэж нотлогдох учир нэрийдлийн утгатай харшлахад хүрнэ. Иймээс язгуурын ухаан нь гэмгүй зөв байх, түүгээр нотлогдох хоёрыг нэг гэж үзээд нэрийдэл томъёололд нүгэл буяны үйлээс жаргал зовлон гарах болон Ванчүг, Зову зэргээс зовлон жаргал төрнө гэдэг хоёрыг мөн гэвээс мөн гэх, биш гэвээс биш гэж барих буруу атгагийн орон байх ёсгүй. Ванчүг, Зову тэргүүтэн жаргал зовлон төрүүлэх ба нүгэл буянаас жаргал зовлон төрүүлнэ гэх хоёрын мөн чанар буй, үгүйг шинжих ухаанаар үзвэл (мөн чанараар) бүтээгүйн хувьд адил байна. Гэвч ухаанаар үгүйсгэгдэх, үл үгүйсгэхдэхийн хувьд адилгүй байна.

Тэдгээрийн тухайд бодит өгүүлэгч өвөр бусдын аймгийн нийт бусын үзэл баримтлал гэж хотол нэрийдэх хувьгүй орон, оронт болон "би", Ванчүг, Зову зэргийг тэдгээрээр (шалгадаг) тийн агуулахдаа тэр мэт өөрийн мөн бүтсэн, эс бүтсэн эсэхийг ухаанаар шинжлэн, улмаар тийнхүү ажиглах ухаанаар тэдгээрийн утгыг олж мэдэн тодорхойлдог билээ. Тиймээс бусдын мөн чанар буй, буй бус эсэхийг шинжин бусдын гаргаж тавьсан дүгнэлтийг анхаарч үзэх хэрэгтэй. Ухаанаар шинжиж шалгарч гарч ирсэн утгуудыг баримтлах учир бий. Тийнхүү шинжлээд иртэл харгүй ухаанаар шинжих үүрэг ачааг даахгүй зүйл ч гарч, тэдгээр нь ухаанд үл олдож эвдрэхэд ч хүрдэг. Хэрвээ тэдгээр нь буй аваас тэдгээр ухаанд олдох (мэдрэхдэх) ёстой. Дүрс, дуу тэргүүтний хувьд гадаад, дотоодын эндүүрлийн шалтгааныг хорлолгүй, нэрийдлийн ухаанд хэрхэн алдаршсан ёсоороо агуулагдсан төдий зүйл билээ.

Тэдгээрийн хувьд эдгээр нь лавтай нэрийдэл төдий гэчихээд утгын мөн чанар тэр адилаар бүтсэн юм болов уу гэж шинжих тэрхүү шинжилгээгээр өөрийн мөн чанараар бүтсэн мөн чанарыг олсон ёс гэж үзэж болохгүй ээ. Тиймээс тэдгээрт өөрийн мөн чанарыг буй, буй бусыг шинжлэх оюуны шинжлэлийг хийж болохгүй. Учир нь тэдгээр утгуудыг ухаанаар шинжихэд тэсэх зүйл (олдох) гарахгүй билээ. Үлгэрлэвээс, "энэ хонь мөн гэж нэгэнт хэлчихээд за байз морь бил үү, үхэр бил үү гэж шинжихийн хэрэг байдаггүйтэй" адил болой.

Ертөнцөд тэргүүлшгүй цагаас алдаршсан утга мөн боловч ухаанаар шинжлэгдэн үгүйсгэгдээд нэрийдлийн төдий ч байхгүй зүйлүүдийг мунхагийн эрхээр өөрийн мөн чанарт гэж үзэх хэтрүүлэх үзлүүд, эвдрэх үзлийн эрхээр өөрийн чанараар бүтсэн "би" болоод "минийх хэмээн барих" үзлүүд, маргаашийн уулыг өнөөдрийн уул мэтээр үзэх орнууд багтана. Гэхдээ төв үзэлтэн нар ертөнцөд алин алдаршсан бүхнийг янагуух гэж үздэггүй.

Заримууд дүрс, дуу тэргүүтэн болон тэрсүүд нарын нэрийдсэн зүйлсийг нэрийдсэн ёсоор буй, буй бус нь адилгүйгээс шалтгаалж, эхнийх нь хамаг ертөнцөд алдаршсан бөгөөд удаах нь зөвхөн тогтсон таалалтанд алдаршсан учраас гэж хэлдэг нь сайн ялгаагүйн шинж. Өөрөөр хэлбэл, нэрийдлийн ёсоор дүрс тэргүүтэнд илбэ мэт байж болохгүй. Өөрийн мөн чанараар бүтэх хэрэгтэй гэх мэтээр олон янзаар үзэх бий. *"Жаран шулэгтийн тайлбар"-аас:*

Чингээд чанх буруугаар үзэхдээ жаргалтай мэтээр барих буюу янагуух боллоо ч өөрийн мөн чанараар бодит зүйлсүүд үл орших учиртай. Чанх зөвөөр гэвэл зовлонтой гэж үзэх буюу тэдгээр бодит зүйлүүд янагуух нэрийдлийн мөн чанарт оршино хэмээжээ. Мөнх дөрөв гэж нийт ертөнцөд алдаршсан хэдий ч тийн барихыг чанх буруу янагуух гэж номножээ. Мөнх бус тэргүүтэн дөрөв нь нийт ертөнцөд алдаршаагүй ч тийн барихыг чанх зөв гэж номножээ.

Тэр мэт цогцосоо мөнх бус хэмээн барих атгаг нь үзэх орноо (вишай) эндүүрэх хэдий ч, барих орноо шалгадгийн хорлол байхгүйн учраас чанх буруу бус буюу эндүүрэлгүй хэмээгддэг. Эрхтний мэдрэхүйн хувьд үзэх орноо эндүүрэх, эндүүрэхгүйн хувьд ялгаа байхгүй гээд эндүүрэлгүй гэж бүү бодоорой. Эрхтний мэдрэхүйнүүд үзэхдээ эндүүрэх явдал нь ижил боловч ертөнцийн нигуурт үзэгдэх үзэгдэл, даган зохиолдсон утга буй, буй бусаас шалтгаалж дүрс зураг харж буй эрхтний мэдрэхүйнүүд нь буруу янагуухид багтана. Түүнээс бусад хорлол саадгүй эрхтний мэдрэхүйнүүд зөв янагуух

болно.

Цогцосоо мөнх мэтээр барих атгагийн орнууд нэрийдэлд буй тул ухаанаар хорьж болохгүй. Үнэхээр өөрийн мөн чанараар бүтсэн мөнх тэргүүтэн дөрвөн зүйл байхгүйтэй адил дээрх хоёроор бүтсэн мөнх бус тэргүүтэн дөрвөн зүйл ч байх учиргүй. Тиймээс зөвхөн түүнд харгалзуулан тэрхүү найман зүйлийг байна гэж барихад л зөв буруугийн ялгал байхгүйг болгоож дүрсийн мөнх, мөнх бус, зовлон жаргал, би буй, үгүй зэргийн аль ч талаас нь үзлээ гэсэн шинж байдлыг л үздэг болохыг айлджээ.

Асуулт: Бодит зүйлсийг мөн чанартай гэж хэтийдүүлэн үзэгч (хөөрөмшил) мунхагийн барих орныг учир шалтгаанаар (нотлол) сөхөөх ба янагуухийн утгуудыг үл хориглох хоёр хоорондоо харшилна. *"Орохуй"-гаас:*

Мунхаг нь араншинг түйтэрлэх учир янагуух буюу
Түүгээр засварлагдсан, үнэн мэтээр үзэгдэх түүнийг
Янагуух үнэн хэмээнэ гэж
Чадагч тэр бээр зарлиглав

хэмээн дүрс, дуу тэргүүтнийг мунхагийн эрхээр баригдсаны учир янагуух үнэн гэж айлдсан бус уу хэмээвээс энд гэм гарахгүй.

Хариулт: Дүрс, дуу тэргүүтнийг янагуух үнэнд агуулж буй "үнэн" гэдэг нь санаа бодлын эрхээр үнэн гэж буй хэрэг. Тэрхүү санаа бодол нь "үнэнд баригч" бодлыг л зааж байгаа учраас мөн чанартай хэмээн хэтийдүүлэн үзэх мунхагийн нигуурт "үнэн" болой. Тиймээс "нисваанис мунхагийг тэвчсэн хоёр дайснаа дарагч" (архад) нар болон наймдугаар газраас дээшхи бодисадва нарт тэдгээр үзэгдлүүд засдаг (хуурамч) мөн чанартай гэж үзэгдэх тул үнэн бус буюу. Тэр үнэнд барьж илт хөөрөмших бодолгүй болой" хэмээн "үнэнд баригч" бодолгүй болсон тэдэнд янагуух төдий байна гэсний учир энэ болой.

Дүрс, дуу тэргүүтний үнэн гэдэг мунхагийн нигуурт л тийн болохоос тэрхүү мунхагаар дүрс, дуу тэргүүтнийг агуулах хэрэг биш л дээ. Үлгэрлэвээс, "Эрээн дээсийг могой гэж барих буруу сэтгэлийн нигуурт л тэрхүү дээс чинь могой болж харагдах хэдий ч тэрхүү буруу бодол нь дээсээ таньж мэдсэн ухаан байхгүйтэй адил болой" Дүрс, дуу тэргүүтнийг мэдэрдэг ухаанд ямарваа хорлолгүй хараа тэргүүтэн зургаан мэдрэхүйнүүд орох бөгөөд тэдгээрээр мэдрэгдсэн утгууд нь нэрийдэлд томъёолол болж байх тул ухаанаар үгүйсгэх учиргүй. Харин мунхагаар барих тэр бүхэн нэрийдэлд ч буй бус билээ. Үүнд бодит зүйлсийг мөн чанараар бүтсэн гэж үзэх хэтийдэл хөөрөмшилгүй байх

бөгөөд тиймэрхүү мөн чанар нэрийн төдий ч байхгүй бөлгөө. Тиймээс л учир шалтгааны үүднээс нэрийн төдий хүртэл няцаана. Хэрэв няцаахгүй бол янагуух орших бодит зүйлс илбэ мэт оршихгүйд хүрнэ.

Энэхүү мунхагаар хөөрөгдөн гарсан "мөн чанар"-т сайхан муухай зэргийн ялгавруудыг нэмж хөөргөөд ирэхээр шунал хүсэл, уур хилэн зэргийн муу сэтгэлүүд төрж бий болно. Тиймээс эдгээрийн барих орныг ч (учир шалтгаан) ухаанаар сөхөөж чадах хэрэгтэй. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:*

Шунал хүсэл тэргүүтэн л мунхаг сэтгэлд буй хэмээн бодогдож, зөвхөн бодит зүйлсийн өөрийн мөн чанарт мэтээр үзэж сайхан муухай зэргийн ялгаврыг хэтийдүүлэн орох буюу. Мунхагтай хамт оршиж мунхагийг шүтэж гарах тул мунхаг гол нь болой хэмээжээ.

Хэдийгээр тэдгээр нисваанисууд нь тэргүүлшгүй цагаас хамт орших боловч тэдний барих орныг ухаанаар сөхөөж чадах учраас тэдний барих орон нэрийн төдий ч оргүй болой. Тиймээс хамт төрсөн сэтгэлийн орныг ухаанаар сөхөөж болох, болохгүй хоёр байж болно. Дүрс, дуу тэргүүтнийг танин баригч янагуух шалгадаг болсон, хамт төрсөн эдгээрийн орон нь нэрийдэлд буй учир ухаанаар хорих ёсгүй. Чингэж үзэн Санжайжан болон Чандракирти багш нарын ёсноо нэрийн төдий ч өөрийн мөн чанар бүтсэн мөн чанар байхыг хориглосон бөгөөд нэрийдэл янагуухийн утга гэдэг чухам юу болохыг мэдэхэд машид бэрхтэй нь харагдана.

Тэдгээрийг зөвөөр, сайтар таньж мэдэхгүй бол явдлын зүгт сайн магадлалд төрөхгүйд хүрнэ. Ихэнхдээ басамжлах, дорд үзэх үзэл болчих тул ухаантан мэргэд бүхэн энэхүү ёсны "янагуухийн талаарх агуулга, тодохойлолт"-ыг мэргэн ухаанаар тунгаагаарай. Үүнээс үг олшрох вий гээд энэ төдийгөөс цааш хэтэрсэнгүй.

14

ХУРАН ҮЙЛДЭХҮЙГ ШИНЖИХ НЬ

в/ Дөрвөн хязгаараас төрөх мөн, бусыг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх
/г/ Бодасын буй, буй бус зэрэг дөрвөн талыг хориход эсэргүүцэл гарахгүйг үзүүлэх

---oOo---

/в/ Дөрвөн хязгаараас төрөх мөн, бусыг шинжлэн хорьсон тул сөхөөж эс чадахыг үзүүлэх

Асуулт: "Өөрөөс, бусдаас, тэр хоёулангаас, үндэс шалтгаангүйгээр төрөх" явдлыг хорьсноор төрөхийг үгүйсгэнэ. Энэхүү ёсноо дөрвөн зүйлээр төрөх нь нэрийн төдий ч үгүй болох тул төрөхүйг хориход ялгамжааг найруулах (үнэхээр төрөхүйг гэх мэт) хэрэггүй юу?

Хариулт: Харин тийнхүү эвдэлж чадахгүй бол дөрвөн зүйлийн төрөхүй хорьж үнэхээр төрөхүйг.ч үл эвдлэх болой" хэмээн өгүүлэхийн эхнийхийг үл зөвшөөрөх тул удаахийн хариуг номлосугай.

Үнэхээр төрөхүйг зөвшөөрвөөс хоосон чанарыг шинжих ухаанаар шинжлэгдэн тэсэж үлдсэн байх хэрэгтэй. Тэр цагт өөрөөс, бусдаас зэргийн дөрвөн зүйлээр төрөхөөс чухам алинаас төрсөн болохыг шинжлэх шаардлагатай. Үнэхээр төрсөн гэж үзэж байгаа бол дөрвөн зүйлийн аль нэг шинжилгээг лавтай хийсэн байна. Энэхүү үндэс, шалтаг, шалтгаанд шүтэн байж энэ төрөв хэмээх төрөх төдийг зөвшөөрвөл зөвхөн "тэр ямагтын" төрөхүйг баримтлах хэрэггүй.

Түүнийг баримтлахгүй учраас хоосон чанарыг шинжих ухаанаар өвөр, бусад зэргийн алинаас төрвөө хэмээн ёсчлон ажиглах, ухаанаар шинжиж тогтоохын хэрэггүй болно. Басхүү шүтэж төрсөн гэхээр дөрвөн зүйлийн төрөхүйг хорьж байгаа хэрэг. *"Орохуй"-гаас:*

Алин бодит зүйлс (бодас) шүтэж машид гарсан тул
Эдгээр атгагуудаар шинжиж үл чадах
Иймээс шүтэн гарсан энэхүү ухаанаар л
Элдэв муу үзэл бүгдийг таслах хэмээжээ.

Иймээс Чандракирти бээр шүтэн барилдаж төрнө хэмээгээд, тэдгээр дөрвөн хязгаараас төрөхийг хориглон болгоожээ. Та болвоос дөрвөн хязгаар алинаас ч төрөхгүй учраас төрөхийн төдий ч байхгүй гэж үзэх учир Чандракирти багшийн тааллаас буцаж өгүүлсэн харагдана. Мөн дээрх "*Шастар*"-*аас:*

Алин үндэс шалтгаангүйгээс болон
Вишну/Бүтээгч/ тэнгэрийн шалтгаан зэргээс өвөр, бусад хоёулангаас
Бодит зүйлс төрнө гэж байхгүй ээ
Тиймээс л шүтэлцэн байж машид төрөх

хэмээн айлдсан нь ч таны өгүүлдэгтэй харшлах болох нь ээ. Шүтэж төрсөн шүтэн барилдахуй нь дөрвөн хязгаараас хагацсан мөн тул хязгаар туйлаас хагацсан дөрвөн хязгаар алин бэ гэж бүү асуухтун.

Асуулт: Эдгээрээс үзэхүл, өөрчлөн үл төрөх ба үл төрөх хоёрын ялгааг ялгаж чадахгүйгээс болж уршигджээ. Чингэвээс:

Тэр цагт ямар нотлол ухаанаар
Өөрөөс болон бусдаас төрөх зохисгүй гэв ээ
Тэрхүү нотлол ухаанаар бодвоос
Нэрийн төдий ч зохисгүй бус уу хэмээснийг юу гэх вэ вэ?

Хариулт: Энэ нь эдээс бүтсэн буюу өөрийн бэлэг чанараар бүтэн төрөхүйг зөвшөөрөх аваас нэрийн төдийд ч (байхгүй хэмээн) дээрх нотлол ухаанаар хорихыг заасан болохоос бус төрөх төдийг ерөөс хориглоогүй буюу.Тэр номын үргэлжлэлд:

Асуулт: Алин хотол нисваанист болоод арилсан номын үндэст болж *"эдэт мөн чанарт"* байх хэрэгтэй гэж өгүүлсэн билээ? хэмээвээс,

Хариулт: Хэдий тийн боловч тийн өгүүлэхдээ нэрийн төдий нэгэн байж бусад нь хэвээрээ байна. Учир нь тэр үест хэмээх зэргээр эш татаж,түүний "*Тайлбар*"-аас ч: Тиймээс өөрийн бэлэг чанараар төрнө гэдэг хоёр үнэнд хоёуланд байхгүй хэмээн үл таалан байж тангараглах болой" хэмээн айлсан байна

"Өөрийн мөн чанараар бүтэж төрөх" гэдэг нь үнэмлэхүйгээр төрөх мөн тул түүнийг зөвшөөрөхдөө зөвхөн нэрийдлийн хувьд зөвшөөрч болох талтай. Үнэмлэхүйгээр төрөх гэгчийг хорьсон шиг хорих шаардлагатай гэдэг бол энэхүү багшийн таалын эрхэм дээд нь мөн тул өөрийн мөн чанараар бүтсэн төрөхүй гэдэг нэрийн төдий ч байж болохгүй гэж үзэх хэрэгтэй. *"Орохуй"-гаас:*

Хүүсэр эмийн "хөвгүүн"-д өөрийн чанараар
Төрөх гэх чанар түүнд огт үгүй, ертөнцөд ч огт үгүй
Түүнтэй адил хамаг бодит бүхнээ
Мөн чанараар ертөнцөд үл төрөх хэмээн айлджээ.

Мөн өөрчлөнгөөр өөрийн чанараар үл төрсөн буюу төрөхийн мөн чанар байхгүй гэхээр (ерөөс) төрөх гэж байхгүй нь албатай гэж барьснаар "шүтэн барилдаж төрөх" болон "өөрчлөнгөөр үл төрөх" хоёрыг харшуулан тэмцэлдээд "чих байхгүй", "зүрх байхгүй" гэж айлдсан байна гэдэг. "Өөрчлөнгөөр үл төрөх" хэмээхийн "өөрчлөн" хэмээх үгийг сонсолгүйгээр "үл төрөх" хэмээснийг барьж бодох вий гээд "чих байхгүй" гэж "өөрчлөн" хэмээх тэрхүү үгийн утгыг ухаарахгүйд хүрэх вий гээд "зүрх байхгүй" хэмээн айлджээ. Тэр талаар, *"Ухааны жаран шүлэгт"-д:*

Шүтэн барилдаж төрөх тул (өөрчлөн) эс төрөх учиртайг
Түүнийг болгоогч дээдэс бээр айлдав

хэмээснийг *"Түүний тайлбар"-аас:*

Шүтэн барилдаж гарсан гэж үзээд бодит зүйлсийг "өөрчлөн чанарт" гэж тухайлж болохгүй. Алин шүтэж гарсан тэрээр дүрс хөрөгтэй адил өөрийн мөн чанараар үл төрсний тул болой. Чингэвэл шүтэн гарсан алин бүхэн тэдгээр төрсөн бус болох уу. Юунд эс төрсөн хэмээх үгийг өгүүлэв. Хэрвээ үл төрсөн хэмээн өгүүлэх бол шүтэж төрвэй гэж хэлэх хэрэггүй билээ. Инагш чинагш харшлах учраас ингэх нь зохисгүй бус уу гэх зэргээр асуухад, "Аяа хө, чих байхгүй, зүрх байхгүй" гэснээр маргалдах, тэмцэлдэх энэ нь бид нарт л бэрхтэй нэгэн аж. Алин хэзээ бид нар "алин шүтэж төрсөн тэр бүгдээр дүрс хөрөг адил өөрийн мөн чанараар үл төрөх бил үү гэж ярилцах тэр цагт л үгүйсгэлээ ухаарахын үе ирнэ гэж айлдсан тул тэрхүү ялгааг мэдэхийг л эрхэмлээрэй.

Мөн *"Лусын хаан Мадойва айлтгасан судар"-аас:*

Алин шалтгаанаас төрөх тэр л үл төрөх
Түүнээ төрөхийн өөрчлөн чанар үгүй буюу
Шалтгаанд шүтсэн алин түүнийг хоосон (чанарт) гэж номнов
Алин хоосон чанартайг ийн мэдэж жиших мөн

хэмээсний *эхний мөрөөр бурхан бээр:* "Шалтгаанаас төрсөн тэр л үл төрөх" хэмээн айлдаж үл төрөхийн ёсыг заажээ. *Хоёрдугаар мөрөөр:* "Түүнээ төрөхийн өөрчлөн чанар үгүй" хэмээн хоригдохуундаа ялгааг нь гаргаж "өөрчлөн чанар үгүй болой" гэжээ.

Энэ мэтийг үл ухаж зөвхөн тэдгээр үгийг сонсож "гагц төрсөн бол (хэрхэн) эс төрөх", "гагц шүтсэн бол (хэрхэн) эс шүтэх" хэмээх ёсоор зөвхөн харшлах мэтээр өгүүлэгч их үгтэд энэ үзэл их хол харагдана. "*Тодорхой үгт*"-ээс татсан, *"Ланкаад заларсан судар"-аас ч:* "Их мэргэд ээ! Өвөрчлөн чанараар эс төрөхүйг болгоож, тэр бээр хамаг ном үл төрөх болой хэмээн зарлиглав" хэмээн маш тодорхой айлджээ.

Төрөхүй тэргүүтнийг хорихдоо үнэхээрийн ялгааг найруулсан, эс найруулсны хариуг утгаар нь ойлгож болох ч зоригдлоор нь ялгасан хариуг хожим үзүүлнэ. "Өвөрчлөн чанар байхгүй гэдгийг шалтгаан, үр хэрхэн бий болох ёсны эдгээрийн энэ бүх сөхөөлөг бүгдээр сөхөөж чадахгүйг харуулж байна. Ер нь тааруухан сөхөөлгийн эцэс туйл нь хүртэл бусдыг үгүйсгэхээр өөрийнх нь гаргаж тавьж байгаа шинжлэл эсэргүүцэл тэднийг сөхөөхдөө ямар ч эргэлт буцалтгүй болгож үйлдсэн байдаг.

Та бүхний гаргаж тавьж байгаа энэ зүйл тааруухан сөхөөлгийн туйл болжээ. Ухаанаар хорлох, эс хорлох зэргийн шинжлэл хийгээд бусдын зүгийг ёсчлон хорьж, жич буцаагаад тэр мэт хэрхэн сөхөөх ухаанаа ч хориглож үйлджээ.

Асуулт: Та дүрс тэргүүтнийг "буй" гэж ам авч тэдгээрт дүгнэлт хийсэн хэдий ч та нарын өөрийн ёсны чиглэл баримтлал байхгүй учраас тэдгээр дүгнэлт хэрэггүй бус уу?

Хариулт: Үгээр эдгээр гэмүүдийг үл няцаах тул "Хэтрүүлэгч" болон "Өөрийн үндэст" нарыг нотлон буулгах үед заана.

/г/ Бодасын буй, буй бус зэрэг дөрвөн талыг хориход эсэргүүцэл гарахгүйг үзүүлэх

Асуулт: Төв үзлийн гол номоос бодас юмсын өвөрчлөн чанарт болохыг /1/ буйгаас, /2/ буй бусаас, /3/ хоёулангаас, /4/ хоёул бус зүйлээс байхгүй гэж дөрвөн хязгаараас үгүйсгэнэ. Ер энэ дөрөвт багтахгүй үзэгдэл юмс байхгүй тул эл учир шалтгаанаар бүгдийг үгүйсгэх болох нь ээ?.

Хариулт: Дээр өгүүлсэн мэт ер бодит зүйл байхаас өөрийн мөн чанараар бүтсэн бодит зүйл нь хоёр үнэний хаана ч багтахгүй гэж хориглоно. Харин тусыг үйлдэх бодит зүйлсийг нэрийн төдийд байхыг үгүйсгээгүй болой. Бодит зүйлс үгүй боловч хуран эс үйлдсэн юмс өөрийн мөн чанараар бүтсэн "бодит бус юмс" гэж үзвээс мөн тэр адилын "бодит бус юмс"-ыг ч үгүйсгэнэ.

Улмаар тэр мэтийн бодит зүйлсийн буй, буй бус хоёуланг няцааж, хоёуланг бусын өөрийн мөн чанараар бүтсэн байхыг ч үгүйсгэх тул дөрвөн

хязгаараас хорих ёсыг энэ мэтээр мэдэж аваарай. Тэр адилын ялгааг найруулалгүйгээр дөрвөн зүйлээс хоривоос бодит зүйл буй болон буй бус хоёрыг хорихын цагт хоёуланг биш гэж хориглоод жич бас хоёулаа биш нь биш болгож хориход хүрвэл авч үзэж байгаа зүйлтэй харшлах билээ. Гэвч тийм л байдаг юм гэмгүй ээ гээд суух бид мэтийн галзуутай хамт бүү тэмцээрэй.

Басхүү цогцоснуудын өөрийн мөн чанараар бүтсэн чанар буюу "би"-г хориод мөн чанар буюу "би" нь байхгүй болой хэмээх ухаан төрөх тэрхүү ухааны орон болон мөн чанар буй бусыг ч үгүйсгэж хоривол төв үзлийг сөхөөн гаргаж байгаа нь тэр мөн. Ном юмсын өвөрчлөн чанаргүйг оносон ухааны орныг сөхөөж буй нь тэр ээ. Мөн чанар буй, буй бус хоёуланг сөхөөхийн хүсэлтнээс үүнийг асуух хэрэгтэй. Цогцост өвөрчлөн чанар үгүй болой хэмээн магадлагч ухааны орон нь өвөрчлөн чанаргүй гэдэг тэр юу болохыг мэдэж сөхөөлөө гэж өгүүлэхтүн. *Асуулт: "Үндсэн билиг"-ээс:*

Хэрвээ хоосон бус нь өчүүхэн буй аваас
Хоосон нь ч өчүүхэн байж болох
Хоосон бус өчүүхэн буй бус аваас
Хоосон ч байх нь хаанаас буй

хэмээсэн нь "хоосон бус зүйл огт үгүй тул өвөрчлөн чанаргүй хоосон нь ч байхгүй гэсэн үг биш үү?"

Хариулт: Энэ үест: "хоосон, хоосон бус" гэдгийг өвөрчлөн чанараар хоосон ба хоосон бус гэж номны эх, адаг бүхэнд зохиожээ. Тиймээс "өвөрчлөн чанараар хоосон бус" гэвэл мөн чанараар бүтсэн мөн болно. Гэтэл "өвөрчлөн чанараар бүтсэн нь өчүүхэн ч үгүй тул өвөрчлөн чанараар бүтээгүй хоосон чанар байхгүй ээ" гэж өгүүлэх их инээдэм наадам үүнээс өөр хаана байх вэ?

Мөн жишээ нь: (Зүлэг) ногоо нь "өөрийн мөн чанараар бүтсэн мөн чанар байхгүй юм аа" гэж магадалсан бодол нь "ногоонд мөн чанар байхгүй" гэж барина. Харин "тэрхүү өөрийн чанар байхгүй" нь байдаг юм уу, байхгүй юм уу гэх хоёрын алиныг ч барихгүй байгааг нүдээ аньж, амаа наашлуулаад оножмэдэгтүн, ухаарахад хялбар шүү.

Чингэхлээр "өөрийн мөн чанар байхгүй" ч бас "байна" гэж барьж болохгүй. Тиймээс "өөрийн мөн чанараар байна" гэж барих бодлыг буцаахын тулд учир шалтгааны "хоосон чанар байна" гэдгийг хорих хэрэгтэй боловч, өөр нэгэн ухаанаар өөрийн мөн чанараар "байхгүй" ч "байна" гэж барьдаг ухааны орныг хорих хэрэгтэй гэж үзэж болно. Гэхдээ өөрийн мөн чанараар байхгүйг оносон ухааны орныг хорино гэвэл ерөөсөө таарахгүй.

Бид нар ногооны "өөрийн мөн чанараас бүтсэн мөн чанарыг хорихоор "мөн чанаргүй байна" гэж ухаарчихаад байна. Улмаар бас өөр нэг ухаанаар "өөрийн мөн чанар байхгүй тэр нь байгаа (буй) болой" гэж үзэхдээ ч түүний орныг ухаанаар хорихгүй, харин тэр хоосон чанар өөрийн мөн чанараар бүтчихнэ гэж үзээд хорьдог билээ.

Асуулт: Тэгвэл өөрийн мөн чанаргүй түүнийг мөн чанартай гэж барих бодол ямар байх вэ?

Хариулт: "Ногооны өөрийн мөн чанар байхгүй" гэдгийг тухайлан бодоод хэдийгээр ногоо нь өөрийн мөн чанараар бүтээгүй ч "ногооны мөн чанар байхгүй байгаа нь тэрний мөн чанар болж байна" гэх бодол төрдөг. Үлгэрлэвээс, "Хумх байхгүй ээ" гэхэд "хумх байсан нь үнэн" гэх бодол төрөхгүй ч "хумх байхгүй нь үнэн" гэх бодол төрдөгтэй адил. Тэр мэтээр үзвэл өөрийн мөн чанараар үл хоосон байх нь өчүүхэн ч үгүй тул ногооны өөрийн мөн чанараар хоосон гэдэг нь "өөрийн мөн чанараар бүтсэн нь байхгүй" гэж хэлбэл зөв учир шалтгаан болно. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас ч:*

Хоосон чанар гэж өөрийн мөн чанараар бүтсэнийг хорьсон мөн гээд, ийн өгүүлрүүн, хэрвээ хоосон хэмээгдэх зарим нэгүүд өөрийн мөн чанараар бүтсэн нэгэн байх аваас бодас өөрийн мөн чанартай болох тул" хэмээгээд, чингэж болохгүйг үзүүлж *"Дөрвөн зуут"*-аас.

Хоосон бус нь үгүй бол
Хоосон нь хаанаас гарах
Энэ мэтээр нэг хэсэг нь үгүй бол
Ерөндөг хаанаас гарах вэ хэмээжээ.

Чингэлгүйгээр өөрийн мөн чанар (өвөрчлөн) хоосон байхыг хоривоос өөрийн мөн чанаргүй нь үгүйсгэгдэхэд хүрнэ. Ингэвэл өөрийн мөн чанараар бүтсэн мөн чанар бүтэхэд хүрч улмаар "өөр мөн чанар"-ыг хэзээ ч хорьж чадахгүй болно. Тэр талаар *"Тэмцлийн няцаагч"-аас:*

Хэзээ өөрийн чанар үгүй чанар түүгээр
Хэрхэж өөрийн чанар үгүйг хариулах вэ
Өөрийн чанар үгүй нь няцваас л
Өөрийн чанартай болж нотлогдох хэмээжээ.

Мөн Чандракирти багш *"Өөрийн тайлбар"-таа:*

Эсэргүүцэл: "Бүү дуугар" гэж хэлэх үгээр дууг хорих гэдэгтэй адил бус уу?

Хариулт: Өөрийн мөн чанар үгүй ямагтаар бодасын мөн чанар үгүйг буцааж болно гэвэл энэхүү жишээ таарч болмоор. Энд өөрийн мөн чанар үгүй үг ямагтаар бодит юмсын өөрийн мөн чанартайг хорьж байгаа хэрэг. Хэрэв үг өөрийн мөн чанаргүй гэдгээр бодит юмсын мөн чанар үгүйг хорих болвол өөрийн мөн чанаргүй түүнийг ч хорих болно. Ингэснээр бодит зүйлс өөрийн мөн чанартай болох ба "өөрийн араншинтай болвол хоосон чанарт болохгүй ээ" хэмээн маш тодорхой айлджээ.

Тиймээс дээр "*Үндсэн билиг*"-ийн эшээс "Хоосон байх гэж хаанаас буй" хэмээсэн даруйд:

Ялгуугсад бээр хоосон чанараас
Хамаг үзэл магад гарах гэж айлджээ
Алин хоосон чанарт үзэх үзлүүд
Тэрээр бүгдээр бүтээгүйг айлдав

хэмээсний доторх "хоосон чанарт үзэх үзлүүд" хэмээхдээ "араншингаар хоосон" гэсэн үзлийг хэлээгүй, "араншингаар хоосон хоосон чанарыг үзэхдээ үнэнээр буюу бодитой гэж үзэх" үзлийг айлджээ. *"Буддхабалида"-аас:*

Аливаа бодит юмс өөрийн мөн чанараар байна гэх тэдгээр сэжгийг буцаахын тулд хоосон чанартай гэж өгүүлдэг нь шүтэн барилдаж гарснаар буюу шалтгаан нөхцлийн эрхээр бодит гэж нэрийдсэн хэрэг. Тэрхүү бодит юмсын өөрийн мөн чанар нь байдаггүй буюу тэдгээр нь мөн чанараар хоосон байдаг. Тэр л чанарыг сайтар гаргаж тавьснаар буцааж чадна. Аливаа хоосон чанарыг бодитой бүтсэн мэтээр үзэгч тэдгээр шуналыг өөр бусад ямар ч шуналаар буцааж чадахгүй. Үлгэрлэвээс, "Юу ч байхгүй ээ гэж хэлэхэд юу байхгүй тэрнийгээ гаргаад ир гэж хэлэх хэн нэгэн ч байхгүй юмыг л барихаар орж чаддагтай адил хэмээх жишээгээр тодорхой айлджээ.

Чингэхгүй бол жишээ нь ч үл таарна. Зарим нэгэн нөгөөгөөрөө "Эд юмс уршигдлаа" гэж хэлэх гээд "эд юмгүй болчихлоо" гэж хэлэх тэр цагт "Эд юмс байхгүй болжээ" гэж барихад гэм болохгүй. Эдгүй болсон түүнийг эдтэй болжээ гэж барих үед эдгүй гэсэн ойлголт төрдөггүйтэй адилаар бодит юмст мөн чанар байгаа, үгүйг асуухад өөрийн чанар байхгүй ээ гэж хэлэхэд өөрийн мөн чанар байхгүй байна гэж барих өгүүлэгч ийн гарах тул тэнд гэм байхгүй билээ. Харин бодит юмс мөн чанаргүй байтал мөн чанартай гэж бариваас гэм болно. Таны бодлоор бол эд байхгүй гэж хэлэх цагт эд байхгүй гэж барих боловч бүр үгүйсгэн барих хэрэг гарах тул та өөрийн хэлсэн үгэндээ л үзэсгэлэнтэй болой.

"Тодорхой үгт"-ээс: "Хоосон чанарыг бодит гэж шунах сэтгэлийг айлдсан болохоос хоосон чанарыг хорьсон бус. Хоосон чанарт гэж үзсэн төдийгээр гэм байх албагүй" Ингээд *"Судрын хураангуй"-аас:*

Энэхүү цогцосыг хоосон хэмээн ухахнаа ч бодисадва нар
Бэлгэс гэж үзэн төрөх үгүй орноо ч үл сүслэх буюу хэмээсэн ба,

"Их эрдэнийн эрхи"-ээс ч:

"Би" болоод "би үгүй"-г үзэгч нь
"Би" тул их Чадагч бээр буцаав

хэмээн айлдсан тул бас бус эрхэм зарлиг, шастараас "хов хоосон" гэх болон "би үгүй" үзлүүд таарахгүй хэмээн дээр номносон мэтээр мэдэх хэрэгтэй.

Хэрвээ чингэхгүй бол "Шаарийн хөвгүүн бээр, гүн билиг барамидын ухааныг суралцахыг хүсэн Арьяабал бурханаас асуусны хариуд, тэдгээр таван цогцосууд өөрийн мөн чанараар үнэхээр хоосон гэдгийг даган бариарай" хэмээсэн ба *"Судрын хураангуй"г-аас:*

Ном бүгд өөрийн мөн чанаргүйг мэдэх болсоноор
Энэ л билиг барамидын дээд чинадыг эдлэх хэмээсэн ба,

"Орохуй"- гаас:

Тиймд би болон минийх гэдэг хоосон гэж үзсэнээр
Егүзэр тэдгээр нь тийн гэтлэх

хэмээсэн зэрэг тэдгээр олонтой харшлах болно. Тиймээс унал, гутамшиг бүгдийн үндэс нь "өөрийн мөн чанарт" хэмээн гүтгэх мунхаг мөн. Түүнтэй бодитой харшлах ухааны үүднээс түүнийг ёзоороос нь үлдэн хөөнө гэдэг өөрийн мөн чанар үгүй буюу "би үгүй" чанарыг оносон гагц ухаан л түүний барих орныг сөхөөн гаргаж, хоосон чанарын үзлийг нээж харуулж чадна гэж үзэх хэрэгтэй. "Нирваань хоёргүй үүд" хэмээх талаар, *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:*

Хүсэл шуналыг төгс барснаар нирваанын олох үндэс төрнө. Өөрийн мөн чанаргүйг оножь мэдэхээс ангид, юмст шунах шуналыг төгс барах үндэс байхгүй билээ. Тиймээс өөрийн мөн чанаргүй бэлэг шинжит "би үгүй" энэ чанар хоёргүй нирвааны үүд болно. Нирвааны хот балгадад орох ханьцашгүй гагц үүд мөн болой.

Хэдийгээр хоосон чанар, бэлгэс үгүй чанар, ерөөл үгүй чанар хэмээх

гурван тийн тонилохуйн үүд байдаг ч зөвхөн “би үгүй”-г үзэгч үзэл эрхэм гол болно. Хамаг номыг “би үгүй” хэмээн мэдэж, бүхий л бодит юмст шунах хамаг шуналыг барахдаа өөр ямарваа нэгийг чухалчлах, тэдгээрийг бэлгэст барих гэж хаанаас байх билээ. Тиймээс л “би үгүй”-н энэхүү үзэл нь нирваанд орох хоёргүй гагц үүд болой. *“Бодийн чуулган”-аас:*

Өөрийн мөн чанараас хоосорсон хоосон үүнийг
Мөн хэмээх бэлэг чанараар юунд үйлдэх вэ
Бэлэг бүгдээр буруу учраас
Мэргэд юунд ерөөл талбих вэ хэмээн номножээ

хэмээн тонилохуйн гурван үүдийг номносон ба өөрийн мөн чанараар хоосон хэмээх ганц үзлийг нирваны үүд хэмээх харшлалыг огоорон эш, онолоор түүнийг нирваны үүд хэмээн нотолжээ.

Өөрийн мөн чанарын намба төрхийг таслах төдийгөөр тэрхүү орноо лавтай сөхөөх хэрэгтэй бөгөөд тэрхүү ёсоор онох явдал нь хоёр “би”-г бэлгэдэн барих алжаасын ерөндөг болдог.

Тэрхүү ухаанд бэлгэст барих үнэр төдий ч зүйл байхгүй. Тэрхүү ухааны гэмтэй мэт үзэж, муу сайн ямар ч атгаг бүхнийг хорих хэрэгтэй гэж үзвэл Жанаг Хуушааны ёсыг барьсантай адил болно.

15

ХОРИГДОХУУН УТГАА БУРУУ ТАЙЛБАРЛАСАН НЬ

2/ Хоригдохуунаа (хаагдахуун) хэтэрхий явцуу тайлбарласныг хорих

---oOo---

2/ Хоригдохуунаа (хаагдахуун) хэтэрхий явцуу тайлбарласныг хорих

Шүүмжлэх нь: "Хоригдохуун бол өөрийн мөн чанар мөн" гэхдээ гурван онцлог ялгаатай байна. Үүнд: /1/ "Мөн чанарын хувьд үндэс шалтгаанаар үл эгүүсгэгдэх, орон үест үл урвах, агуулга төрх нь бусдаас үл хамаарах болой. Тэр талаар *"Төв үзлийн үндэс"/"Үндсэн билиг"/-ээс:*

Өөрийн мөн чанар үндэс шалтгаанаас
Үүдэх нь зохисгүй буюу
Үндэс шалтгаанаас үүдвээс л
Мөн чанар үйлдэгдсэн болно

Мөн чанарт болсон хэмээх нь
Хэдийд ч үйлдэгдсэн болох
Мөн чанарт болвоос засваргүй ба
Бусдад үл харгалзах буюу хэмээн айлдсан болой.

Хариулт: Ер нь ногоо зэргийн гадаад, дотоодын бодит юмс нь иймэрхүү мөн чанартай гэх юм бол Төв үзэлтэн нар заавал үгүйсгэж хорихын хэрэггүй л дээ. Гэхдээ энэ үест хоригдохууныг танин барих гэдэг нь хамаг номын өөрийн мөн чанаргүйг онох төв үзлийн үндсэнд төрөхийн хориг саадын үндсийг хорьж, түүнийг таньж мэдэх явдал болой. Тиймээс хуран үйлдсэн юмс шалтгаан нөхцлөөр хүргэгдэн бас өөр болж хувирах зэргийг өөрийн аймгийнхан бүтээсэн тул тэдгээрийг өөрийн мөн чанаргүй гэж бүтээх хэрэггүй бөгөөд тэр ч гэсэн бодит юмсын өөрийн мөн чанаргүй гэж онох тэргүүтний гэм байх тул тэдгээр нь нийт бусын хоригдохуун хаанаас болох.

Өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн чанарт болвол, бүх юмс үндэс шалтгаанд үл харгалзах, өөр зүйл болж хувирч өөрчлөгдөхгүй байх хэрэгтэй гэж Төв үзлийн гол ном шастаруудад олонтоо гаргасан байдаг. Гэвч тэдгээр нь "түгэн үйлдэгч"-ийн (ерөнхий) талаас алдааг нь өгүүлсэн болохоос хоригдохууны өөрийн талаас нь бодитой хандаагүй байдаг. Өөрөөр хэлбэл, үнэмлэхүй

үнэнээр бүтсэн буюу үнэнээр бүтсэн ч бай шалтгаан нөхцлөөс үүдэхгүй байх хэрэгтэй. Хэдий ч тэд чинь үнэмлэхгүйээр бүтсэн утгатай байх ёсгүй.

Жишээлбэл, Хумх мөнх бус байх хэдий ч мөнх бус нь хумхын утга байх албагүй, харин хумхын ходоод, цорго нь түүний утгыг агуулсан байх шаардлагатай гэхийн адил болой.

Мөн үнэмлэхгүйгээр бүтсэн мөн болбол хувьгүй хуваагдашгүй бодит зүйлс байх ёстой. Гэвч хувьгүй бодит зүйлсийг язгуурын хоригдохуунд авч үздэггүй. Түүнийг тогтсон тааллыг өгүүлэгч нараас: “Нийт бусаар авч үздэг нэрийдэл төдий баримтлал” ч гэдэг. Тэд амьтан бүхнийг сансарт хүлдэг үндэс биш учраас бас тэдгээрийг “өөрийн мөн чанараар үгүй”-г нотлон буулгаж бясалгалаа ч тэргүүлшгүйгээс мунхагаар баригдсан баримтлалд ямар ч хорлол болж чадахгүй учраас тэдний утгыг эцэслэн илт оножболох хэдий ч хамт төрсөн нисваанисыг буцааж чадахгүй билээ.

Тиймээс үзэл онолоо баттай сайн мэдэхийн цагт хамт төрсөн мунхагийн баримтлах утгыг нь байхгүй болохыг баттай мэдэх явдлыг гол орноо болгож авах, түүний дашрамд хамаг нэрийдэл томъёог баримтлах сэтгэлийн орнуудыг хашраан сөхөөх учиртай зэргийг таньж мэдэлгүйгээр хамт төрсөн мунхагийн баримтлах орныг сөхөөх явдлыг орхигдуулаад “бодгалийн би үгүй”-г хорих гээд “мөнх, гагц, өөрийн эрхэт би болон, “номын би үгүй”-г хорино гээд хувьгүй нарийн тоос хэмээх баригдахуун”, хувьгүй агшин хэмээх баригч, гурван ялгамжаа төгөлдөр мөн чанар зэрэг зөвхөн тогтсон тааллыг өгүүлэгч нарын нэрийдэн томъёолсон зүйлсийг хорино гэж үзвэл тэр болгон таарахгүй. Чингэлгүйгээр үзэл онолоо баттай танин мэдэхийн үест тэр төдийгөөс эхлэн таньж мэдээгүй бол бясалгахын цагт ч тэдгээр төдий ч нэгийг баттай мэдээгүй гээд тэр цагт тэр төдийг л бясалгах хэрэг гарна.

Үзэл онолоо баттай мэднэ гэдэг бясалгаж мэднэ гэсэн утга билээ. Тиймээс бясалгаад илт болгох ба бясалгаж дадуулсаар эцэст хүргэнэ гэдэг ч тэр төдий хэмжээнд хүрэх ёстой. Тэр мэтээр хотол нэрийдлийг мэдсэн тэр л нэрийдлийн төдий хоёр “би-үгүй”-г оносноор хамт төрсөн нисваанисыг буцаана гэж үзвэл хэтэрсэн болно. *“Орохуй”-гаас:*

“Би үгүй”-г онохын цагт мөнхийн “би”-г тэвчих бөгөөд
Энд л “би”-д барихын шүтээн гэж үл үзэх
Тиймээс “би-үгүй”-н ухаанаар “би”-г үзэхийг
Ёзоороос нь үлдэн хөөх хэмээх машид гайхамшигтай хэмээснийг

“Тайлбар”-аас ч: Өвөр хоорондоо барилдлага холбоогүй энэ утгыг үлгэрээр тодорхой болгож номносон буюу.

Өөрийн гэрийн туурганаа могой асахыг хараад
Энд их заан алга байна гэх бодлоос салж
Могойн аюулаас гэтэлж байна гэх нь
Аяа, хоохой! Бусдын инээд болохоос өөр газаргүй хэмээжээ.

Энд "бодгалийн би үгүй"-г айлдсан ч "номын би үгүй" дээр ч мөн адил буюу.

"Би үгүй"-г онох цагт хотол нэрийдэгч "би"-г тэвчих бөгөөд
Үүнийг мунхагийн сууринд ч үл үзэх буюу
Тиймээс "би үгүй"-г оносон ухаанаар мунхагийг
Ёзоороос нь үлдэн хөөнө гэж өгүүлэх машид сонин гайхамшигт хэмээн найруулах болой.

Асуулт: Гэвч багш бээр үл засах болон бусдаас үл харгалзах нь мөн чанар, бэлэг чанар байна гэж дээр айлдсан тэр чинь, ерөнхий шинжиж тодорхойлсон хэрэг үү? Эсвээс өвөрчлөн чанар гэдэг тийм байна гэсэн хэрэг үү?

Хариулт: Ном юмсын жам ёс түүнийг л "өвөрчлөн чанар" (араншин) хэмээн агуулсан бөгөөд засвартай бус, бусдаас үл харгалзах болой. Тийм зүйлүүд бий. *"Орохуйн тайлбар"-аас:*

Тийм ялгамжаатай, намба төрхтэй өвөрчлөн чанарын талаар багш айлдсан уу? хэмээсэнд, Ялж төгөлдөр нөгчигсөн бурхан бээр "Түүнчлэн залрагсад ирсэн ч бай, ирээгүй ч бай ном юмсын энэхүү жам ёс оршиж байдаг" хэмээн дэлгэрэнгүй айлдсан буй. Энэхүү номын ёс болвоос энэ үест эдгээр нүд тэргүүтний "өвөрчлөн чанар" болой. Тэрхүү өвөрчлөн чанар гэж юу вэ? Тэдгээрийн засвартай бус, бусдаас үл харгалзах буюу мунхагийн хөлхөлгөөнөөс хагацсан ухаанаар оногдох өөрийн мөн чанар болой. Тэр чинь байдаг юм уу, байдаггүй юм уу хэмээн өгүүлэв. Хэрвээ байдаггүй юм бол юунд бодисадва нар чинад хүрэхүйн мөр гэж бясалгав. Юуны учир ном чанарыг мэдэхээр бодисадва нар тийм олон мянган бэрхшээлийг туурвив" хэмээн судрын эшлэл зэргээр үзүүлжээ.

Асуулт: Чингэвэл дээр ном юмс бүхэнд өвөрчлөн чанар байхгүй гэж хорьсон бус уу?

Хариулт: Дотоод сэтгэл оюунаар баригдаагүй (нэрийдээгүй) ном юмст өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн чанар тоосон төдий ч байхгүй гэж та нар олонтаа өгүүлсэн бус уу. Тиймээс бусад номууд тэр адил өвөрчлөн

чанартай байхыг хэлэх юун. Үнэмлэхүй үнэн болсон номын чанар бүтсэн зүйл огтоос үгүй билээ. *"Тодорхой үгт"-ээс:*

Гурван цагт хэдий ч галыг үл эндүүрэх "язгуурын мөн чанар" гэх засваргүй нэгэн байж, урьд гараагүй үйлээр хойшдоо гарахгүй байж, ус халах, дээш доош, урт богино болох зэргээр нөхцөл шалтгаан зэргээс үл харгалзан байх алин түүнийг өвөрчлөн чанар болно гэжээ. Галын өөрийн мөн чанар тэр мэтээр хувирах уу хэмээвэл, Тэрээр өөрийн мөн чанараар байгаа ч бус, байхгүй л бус болой. Тийн байх боловч сонсогч нарын айдас цочирдлыг арилгахын тулд гүтгэж нэрийдэл ямагтын ёсоор байна гэж хэлээрэй" хэмээн тэрхүү өвөрчлөн чанар өөрийн мөн чанараар бүтэхийг хориглож, харин нэрийдэл төдий байхыг айлджээ.

Асуулт: Хэрвээ сонсогчийн цочирдлыг арилгахын тулд гүтгэж үзүүлсэн гэсэн айлдвар байхгүй гэвэл тэр нь таарахгүй юу? */Хариулт/* Тийнхүү нэрийдэн айлдсан хэрэг нь бусад ном юмсын тухайд учраас бусад зүйлс үгүйсгэгдэх болно. Дээр эш татсан мэтээр тэр утга үгүйсгэгдвэл зөв явдлууд ч хэрэггүй болж хэтийдэх тул бурууг тайлбарлан нотолсон билээ. *Мөн "Орохуйн тайлбар"-аас ч:*

Энэхүү өвөрчлөн чанарын талаар Багш таалан болгоосон төдийгүй бусдууд ч энэхүү утгыг хүлээн зөвшөөрч орж чадсан тул энэхүү өвөрчлөн чанарыг хоёр ёс хоёулаа баталж, томъёолох болой хэмээн айлджээ.

Эс чингэвээс, төв үзлийн ёсноо нирваныг олж болохгүй нь гэж үзэхэд хүрэх буюу. Нирваныг олно гэдэг бол нирваныг илтээр үйлдэх, бүтээх явдал билээ. Нирваан бол хорихуйн үнэн гэж номносон буй. Бас түүнийг үнэмлэхүй үнэн ч гэж айлдсан. Үнэмлэхүй үнэн "үгүй" зүйл, "Нирваан олохын цагт үнэмлэхүйг хорьсон үнэнийг илт үйлдэх мөн" хэмээн "*Язгуурын жаран шүлэгтийн тайлбар*"-т олонтаа чухалчлан айлджээ.

Нүд тэргүүтэн хуран үйлдсэн эдгээр нь өөрийн мөн чанараас бүтсэн өвөрчлөн чанараар ч үнэхээр үл бүтнэ. Номын чанарыг өвөрчлөн чанар гэж агуулсан ч тийн байж чадахгүй. Тиймээс аль нь ч өвөрчлөн чанартай байлаа үл бүтсэн байна. Үнэмлэхүй үнэний хувьд номын чанарыг өвөрчилнө гэж агуулаад тийн бүтсэн байж болно. Гэвч тэрхүү өвөрчлөн чанарын агуулагч "засваргүй" болоод "бусдаас үл харгалзагч" зэргүүд нь "*өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн гэдэг тэдэнд өчүүхэн байхгүй учраас нэрийдэл төдийд бүтсэн байна*. "Засваргүй" гэдэг нь урьд байгаагүй шинээр бүтээгдсэн бүтээгдэхүүн. "Бусдаас үл харгалзах нь" шалтгаан нөхцөлд харгалздаг болой.

Дүрс тэргүүтнүүд дээрх хоёр мөн чанарын аль нь ч болж бүтээгүй учраас номын чанарыг өвөрчлөн гэж үзэх тэрхүү араншинг мэдэхийн тулд мөрийг бясалгаж зөв явдлыг туурвих нь бас чиг хэрэггүй зүйл болохгүй гэж айлджээ.

Ном юмст өөрийн мөн чанараар бүтсэн араншин гэж огтоос байхгүй гэж үзэх болон түр зуурын араншинтай гэж үзэх хоёр хоорондоо харшлахгүй гэж номносон буюу. *"Орохуйн тайлбар"-аас:*

Эсэргүүцэх нь: Аяа, зарим өчүүхэн төдий бодит зүйлсийг үл зөвшөөрөх хирнээ түр зуурын "засвартай бус" болон "бусдаас үл харгалзах" хоёрын "өвөрчлөн чанар" байна гэж үзэх та болвоос нааш, цааш харшлах утгыг өгүүлэгч нэгэн аж.

Хариулт: Өгүүлсүгэй. Та болвоос шастрын утгыг болгоосонгүй. Үүний утга нь нялхасууд нүд тэргүүтний өөрийн мөн чанар нь шүтэн барилдаж гарах мөн гэж үзээд түүнийг тэдгээрийн өвөрчлөн чанар мөн гэж үздэг. Тэрхүү өвөрчлөн чанар нь огт биш ч гэсэн онодог учиртай. Тиймээс зөв явдал тусгүй болоход хүрдэг. Ямар ч байлаа ийнхүү үзэх тэр зүйл нь өвөрчлөн чанар биш юм. Тиймээс түүнийг тийн үзвээс л зөв явдалтай, утга төгөлдөр болюу. Тиймээс би бээр, янагуух үнэнд харгалзуулан "засвартай бус" бас "бусдаас харгалзах" чанарт гэж өгүүлэв. Алин нялхас төрөлхтнийг үзэж байгаа шиг биш тэр чанарыг өвөрчлөн мөн гэж үзнэ. Тэр төдийгөөр үнэмлэхүй үнэн нь бодит бус болох бас бодит бус бус ч болохгүй. Учир нь тэрээр өвөрчлөн чанараар амарлисан мөн чанарт бөлгөө хэмээн айлджээ.

Энд дээр хоёр өгүүлэгчийн үест номносон мэт бодит зүйлсийн буй, буй бус гэдэг өөрийн мөн чанараар байх, эсвээс огт байхгүйн утгаар мөн. Эдүгээ ном юмст өөрийн мөн чанараас бүтсэн өвөрчлөн чанар тоосны төдий ч байхгүй гэдгийг номлон буулгаж өвөрчлөнгөөр хоосон хоосон чанар нь дүрс тэргүүтэн ном юмсын ялгарах суурь дээр ялгагдсан ном болж, нэгэн ухааны вишайд тэр хоёул харшлахгүй бөгөөд хоёрт үзэгдэх буцаагүй нөхцөлд үнэмлэхгүй үнэн хэмээн нэрийдэх тэр чанар бөлгөө.

Өвөрчлөн үгүйг онох үзэл онолыг бясалгаснаар тэрхүү утгыг илт болгоох ухааны нигуурт өвөрчлөн байхгүйтай адилаар өвөрчлөн гэж баригч эндүүрлийн үзэгдэл бүгд буцна.

Тийнхүү номын чанарын илт оногч ухаанаар ном вишай болох дүрс тэргүүтэн тэдгээрүүд үл тухайлагдана. Тиймээс тэр мэтийн номын чанар болон номт хоёулаа тэрхүү ухааны нигуурт үгүй болох учраас тэр хоёрыг номын чанар болон номт хоёр гэж агуулахдаа өөр бусад нэрийдлийн ухаанаар л агуулах хэрэгтэй болно. Чингэхлээр үнэмлэхүй үнэн бол өөрийн мөн чанараар бүтсэн цацрал бүгдийг амарлиулахын дээр өвөрчлөн чанар

байхгүй, тийн үзэгдэгч эндүүрэлт үзэгдлийн цацрал бүгдийг баттай няцаах зэргийн үүднээс тодорхойлогдоно. Түүнийг зөвшөөрвөл өөрийн мөн чанараас бүтсэн өвөрчлөн чанарыг хаанаас юунд зөвшөөрөх билээ. *"Тодорхой үгт"-ээс:*

Мунхагийн хөлхөлгөөний эрхээр бодас юмсын намба төрхийг үл болгоохын чанарт буюу мунхагийн хөлхөлгөөнөөс хагацсан хутагт нарын орон болдог тэр л чанарыг түүний мөн чанар гэж үзнэ" хэмээгээд бодит зүйлсийн мөн чанар болсон "үл төрөх" тэр нь ч огтоос байхгүй гэдгээр "бодит үгүй төдий" болдог учир мөн чанар байхгүй учраас л бодит зүйлсийн мөн чанар буй бус болно" хэмээн айлджээ.

Мөн: "Аливаа үнэмлэхүй үнэн гэдэг "хоёр би" зэрэг хоригдохуун цацралын бүхнээс ангижирсан төдийгөөр тодорхойлогдоод зогсохгүй, энэ нь хөх, энэ нь шар өнгө үзэх зэрэг "ахуй ёс"-ыг ямар ч эндүүрэлгүй онох ухааны орон болж өөрийн эрхээр бүтсэн юм шиг ургагч тэр мэтээр байна гэж ухаарагдаж буй нь гүн утгыг оносон үзэл" гэж үзнэ.

Амьтан бүхнээс "хоёр би–г байна" гэж үзэж шунахын суурь болон гадаад, дотоод эдгээр ном бүгдийн өвөрчлөн чанар байхгүй гэж онох үнэн үзэл онол хоёрыг буйд газар (сөргөлдүүлж) үзвээс л их, бага хөлгөний эрхэм зарлиг бүгдтэй огт таарахгүй болно.

Хамаг амьтныг орчлонд хүлэгч үндэс болсон "би"-д барихуй бодлыг буцаах хэрэгтэй гэж үзсэн хэрнээ, "би"-д баригдсан суурь түүний өвөрчлөн чанар байхгүйг ухаарсан төдийгөөр түүнийг буцаахгүй гээд харин хоорондоо холбоогүй бусад ном юмсыг үнэн байна гэж оносноор "би-д барихуйг буцаана" гэж үзэх байна.

Үүнийг үлгэрлэвээс, "Зүүн талд могой байхгүй атал байна гэж цочих зовлонг буцаахын тулд, зүүн талд ерөөсөө могой байхгүй ээ гэж бодсоноор могой байна гэж бодсон бодлыг буцааж чадахгүй. Харин баруун талд ийм мод байна. Түүнийг баригтун гэх мэтийн бодол төрснөөр л могой байна гэх бодол болон тэрхүү айдсыг буцааж болно" гэсэнтэй ямар ч ялгаагүй үзэгдэнэ. Тиймээс өөрийгөө сайн болгоё гэж бодсон хэн бүхэн тэр адилын бодлыг өнө хол хаяж зовлонд хүлэгч гутамшиг бүгдийн үндэс мунхагийн орныг няцаах арга болсон магад утгат эрхэм зарлиг болоод тэдгээрийн утгыг өөр тийш хазайлгалгүй лавтай ухааруулах баттай суурийг сүндлэгч учир шалтгааны агуу их чуулганыг тодруулан айлдагч хутагт Нагаржуна эцэг, хөвгүүн сэлтийн эрхэм ном шастаруудад шүтэж орчлонгийн далайн чинадад хүрэгтүн. Төв үзлийг онохын тулд хоригдохуун болсон буруу атгаг сэжиг эдгээр эндүүрэгтэй газруудыг арилгах нь маш их чухал тул ийнхүү дэлгэрэнгүй номносон болой.

16

ХОРИГДОХУУНЫ ЖИНХЭНЭ УТГА

(в) Өөрийн ёсны хоригдохуунаа танин барих ёсон
1/ Хоригдохууны жинхэнэ утгыг танин барих
2/ Түүнийг бусад хоригдохуунтай найруулах, эс найруулах ёсон
3/ Хоригдохуунд үнэмлэхүйн ялгааг найруулах, эс найруулах ёсон

- - - o O o - - -

(в) Өөрийн ёсны хоригдохуунаа танин барих ёсноо гурав:

1/ Хоригдохууны жинхэнэ утгыг танин барих
3/ Хоригдохуунд үнэмлэхүйн ялгааг найруулах, эс найруулах ёсон

1/ Хоригдохууны жинхэнэ утгыг танин барих

*Ер нь хоригдохуунд:*а) Мөрийн хоригдохуун ба б)Учир шалтгааны хоригдохуун гэж хоёр буй.

а) *Мөрийн хоригдохуун. "Төвийн хязгаар"-аас:*

Нисваанисын түйтгэр болон
Мэдэгдэхүүний түйтгэр гэж үзүүлэв
Тэр бүхэнд хамаг түйтгэрүүд багтах ба
Тэдгээрийг дарвaас гэтлэх (нирваан) мөн

хэмээн айлдсан мэт нисваанисын болон мэдэгдэхүүний түйтгэр хоёр буй. Эдгээр нь мэдэгдэхүүнд багтдаг хоригдохуун бөгөөд эдгээрийг байхгүй болгосноор амьтан бүхэн гэтэлж нирваанд хүрнэ.

б) Учир шалтгааны хоригдохуун. "Тэмцлийг няцаагч"-аас:

Жич заримууд хувилгасан бүсгүйг
Бүсгүй хэмээн
Бурууд барих ба хувилгаан бээр
Хорьж үйлдсэн энэ нь тэр мэт буюу

хэмээснийг *"Түүний өөрийн тайлбар"-аас:* "Бас зарим эрчүүд хувилгасан бүсгүйг өвөрчлөн чанараар хоосон байтал үнэхээр бүсгүй хэмээн буруугаар

ухдаг бий. Чингэж буруугаар барьж, бас түүнээ шунах, тачаах сэтгэл төрдөг. Түүнчлэн залрагсад, түүнчлэн залрагсадын шавь нар, Сонсоод сонсогч нараас ямар нэг хувилгаан дүрд хувилан үзүүлэхдээ тэдгээрийн буруу бодлыг буцаадаг билээ. Ийнхүү хувилгаан дүр адилын миний үгээр бусад бүх бодит юмс нь хувилгасан бүсгүй мэт өвөрчлөн чанартай гэх аливаа үзлийг буцаана" хэмээн айлджээ.

Иймээс чанх буруугаар үзэх санаа бодол болоод түүний баригдахуун болон өвөрчлөн чанар буй хоёрыг хоёуланг хоригдохуун гэж номножээ. Гэхдээ гол хоригдохуун нь хоёр дахь нь болно. Учир нь чанх буруугаар баригч бодлыг хорихын тулд түүний барьж байгаа орныг эхлээд хорих хэрэгтэй л дээ. Энэ нь шүтэн барилдахуйн учир шалтгаанаар (нотлол) бодгалийн болоод ном юмст өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн чанар байна гэдгийг хорьдоггой адил буюу. Энэ нь угтаа байхгүй билээ. Хэрвээ байх аваас хорьж чадахгүйд хүрнэ.

Хэдий тийм ч байна гэж гүтгэх хөөрөмшлөөс "буй" болсон хэрэг. Тиймээс хорих шаардлагатай. Хорино, буцаана гэдэг алхаар хумхыг цохиж эвдлэхтэй адил бус. Байхгүй юмыг байхгүй байна уу гэдэг нь нүүр, царайг нь таньж мэдсэн магадлал төрөх буюу байхгүй байна гэдэг магад бодол буцах болой.

Мөн нотлохуйн ухаанаар бүтэхдээ хөрөнгөнөөс ногоо ургадаг шиг урьд нь байгаагүй зүйл шинээр бий болохтой адилаар ухаарах бус тэрхүү оршиж буй ном юмс нь тийм л чанартай юм байна гэдгийг таньж мэдсэн магадлалыг төрүүлж өгнө. *"Тэмцлийг няцаагч"-аас:*

Үг байхгүй гэдгийн "байхгүй"-г
Үгүйсгэж бүтээх болно хэмээв
Түүний үг нь "байхгүй" хэмээн
Ухаарч болно, арилгаж болохгүй

Түүнийг *"Өөрийн тайлбар"-аас:*

"Та нар үгс байхгүй гэдгийг ухаарахдаа үгсээс бусад нь ч байхгүй гэж үгүйсгэн нотлоно. Бодит бүхэнд мөн чанар байхгүй гэж өгүүлэгч таны тэр үгээр юу хийх вэ гэж өгүүлэгч хэн бүхнээ үүнийг номнов. "Бодит бүхэнд өвөрчлөн байхгүй болой" хэмээх энэ үг нь "бодит юмсууд "өвөрчлөн байхгүй ямагт" гэж үйлдсэн бус. Гэвч "өвөрчлөн чанар байхгүй" гэдгийг нь "бодит юмсын өвөрчлөн чанар байхгүй болой" гэдгээр ухааруулж буй. Үлгэрлэвээс, зарим нь Лхайжинг гэртээ алга байхад нь байгаа гэж хэлэх. Зарим нь түүнийг гэртээ алга байхад "байхгүй ээ" гэж хэлэх. Ингэж хэлснээр Лхайжинг "байхгүй" болгож байгаа биш. Лхайжинг зөвхөн гэртээ алга байгааг л хэлж байгаа хэрэг. Түүнтэй адил "бодит юмс өвөрчлөн байхгүй"

хэмээх үг нь бодит юмсыг “өөрчлөн чанар байхгүй ямагт” гэж үгүйсгээгүй хэрэг. Гэсэн хэдий ч үнэхээр хүний мөн чанараас хагацсан илбийн хүн мэт өөрчлөн чанар байхгүй ээ хэмээснийг ухаарахгүй моншиpсон хэрэг. Мунхагаар эргүүтсэн нялхас төрөлхтөн нар өөрчлөн чанарыг гүтгэн хэтрүүлж “өөрчлөн огт байхгүй” мэтээр ухаардаг. Тиймээс “өөрчлөн” байхгүй болохоор “үг байхгүй” болж “үгнээс бусад ч өөрчлөн байхгүй” болж үнэхээр бүтэх учраас л “өөрчлөн байхгүй ээ” гэж хэлэхийн хэрэг юун гэж өгүүлэгч хэн бүхэнд “тэр чинь зохисгүй ээ” хэмээн тодорхой айлдсанаас мэдэгтүн.

Чингэхэд “буй аваас” хорьж болдоггүй, харин “буй бус” бол хорьж хэрэггүй гэвэл бүтээх буюу хорих хоёроос хагацаах болчихно. Тиймээс л хорих, бүтээх олон нотолгооны үүднээс шинжих нь нэрийн томъёо, үг төдий ч “ууҗим боллоо” гэж үзэх нь мөрийн болон ухааны хоригдохуун, бүтээгдэхүүн алинд ч ерөнхий төсөөлөл ургуулалгүйгээр хоорондхаршуулсан дэмий яриа болжээ. Өөрөө байна гэвээс хорьж үл болох, байхгүй гэвээс хорих хэрэггүй гэх шалтгааныг баримтлан бусдаас хийх, хорих, бүтээхийн шинжилгээг хориглож хорих, бүтээхийн үйлдлийг сонсохыг ч хориглосон байна шүү. Тиймэрхүү зүйлээр шалтаглан бусдын хорих, бүтээх шаардлагатай гэснийг хориглох нь зохисгүй билээ. Буй аваас хорьж болохгүй, буй бус аваас хориглох хэрэггүй болой.

Чанх буруу эндүүрэгт атгаг сэжгийг буцаахын тулд зөв сайн ухаанаар хорих хэрэгтэй. Жинхэнэ зөв ойлголт төрүүлэх явдал билээ. Тиймээс чанх буруу ухаарлыг буцаах болоод жинхэнэ зөв ухаарлыг олж авья гэвэл Нагаржуна багш тэргүүтний *“Ухааны чуулган”* зэрэг ном шастаруудыг даган үзэж эндүүрэггүй зөв оносон хорих, бүтээхийн ухааныг олж аваарай.

Асуулт: Тийнхүү ухаанаар хорих гэдэг нь жинхэнэ зөв магадлалыг олж авахын тулд чанх буруугаар баригч ухааны орныг (вишайг) сөхөөн няцаах замыг хэлнэ гэвэл, ямархуу ухааны орныг ухаанаар сөхөөх вэ?

Хариулт: Ер нь хоригдохуун баригч атгаг бодол тоолшгүй олон байна. Гэхдээ гэм буруу бүгдийн үндэс язгуур болдог тэр л чанх буруу атгаг бодлыг л сайтар танин мэдэж түүний “шунах орныг” сөхөөн няцаах явдал мөн. Түүнийг буцааж чадвал хамаг гэм буруу буцдаг учиртай. (Ерөндөгийн хувьд) шунал тачаал зэрэг муу сэтгэлүүдийн бусад ерөндөгүүдийн талаар номносон байдаг ч тэдгээр нь ганц нэг талын ерөндөг болдог. Харин мунхагийн ерөндөг нь бусад бүгдийн ерөндөг болж чаддаг. Мунхаг болвоос хамаг гэм буруу бүгдийн суурь болдог. *“Тодорхой үгт”-ээс:*

Бурхадын судрын аймаг зэргээс хоёр үнэнд шүтсэн есөн зүйлийг
Ертөнцийнхний явдлын нигуурт машид үнэхээр ихээр буй хэмээжээ.

Түүнд шунал тачаалыг арилгахаар айлдсан нь уур хилэнг үл дарах
Уур хилэнг арилгахаар айлдсан нь ч шунал тачаалыг үл дарах
Алив омог дээрэнгүйг арилгахаар айлдсан нь бусад хирийг үл дарах
Чингэхээр тэдгээр нь ихэд түгээмэл бус хэмээж тэд тэдэнтэй тусдаа бус

Харин мунхагийг арилгахын тулд айлдсан түүгээр хамаг нисваанисыг дарах
Хамаг нисваанис бүгдээр мунхагт үнэхээр суурилна гэж Ялгуугсад айлджээ хэмээжээ.

Асуулт: Чингэвэл юуг мунхаг гэх вэ?

Хариулт: Энэ үест "гадаад, дотоод ном юмс бүхэн өөрийн бэлэг чанараар бүтсэн гэж баригч, өвөрчлөн чанарт гэж гүтгэн хэтийдэгч ухааны мунхаг" гэх буюу. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:* "Бодит юмст өвөрчлөн чанар буй гэж үлэмж ихээр гүтгэн хөөрөмшигч тийн мэдэхүй болж, үл мэдэгч нисваанисын эрхээр бодит юмст баттай шунан тачаагч, зовлон (самсара) үүдэгч хөрөнгө болсон тэр бүгдийг хорьж буцааснаар зовлонгоос гэтэллээ гэж тооцно" гэж номносон."Дөрвөн зуут"-аас:

Зовлонгийн хөрөнгө бологч тийн үл мэдэх (мунхаг)
Түүний эдлэх орнууд буюу вишай болой
Вишайн "би үгүй"-г мэдсэнээр л
Зовлонгийн үндсийг хорих мөн

хэмээн номносон ёсоор вишайг өвөрчлөн чанаргүй болохыг мэдсэнээр л шунахын үндэс болсон тийн мэдэхүй зовлонгийн хөрөнгө болсон тэдгээр бүгдийг буцаана. Ийнхүү "үл төрөх"–ийн номонд тэсвэрийг олсон, сонсоод сонсогч, өөрөө ялгуугсад, бодисадва нар нь ч зовлонг буцаасанд тооцогдоно" хэмээжээ. Түүнийг (мунхаг) мөн "үнэнд баригч" ч гэх талаар:

Бие эрхтэн биеийг эрхшээх адил
Мунхаг хамаг бүхнээ түгэн орших буюу
Тиймээс мунхагийг дарснаар л
Хамаг нисваанис буцах буюу

хэмээснийг *"Дөрвөн зуут тайлбар"-аас:* "Мунхаг болвоос тэдгээрийг "үнэхээр" гэж үзэх атгаг бодлоор мунхарсны тул бодит юмс өөрийн мөн чанараар үнэн гэж үлэмж гүтгэн баттай оршсон болой" хэмээжээ.

Асуулт: Тийнхүү мунхаг зовлонгийн үндэс юм бол, *"Орохуй", "Тодорхой*

үгст" зэрэг шастаруудаас "эвдрэх үзэл"-ийг зовлонгийн үндэс гэж номносонтой нь зөрчилдөж байгаа биш шүү. Хоёр үндэс байж таарахгүй биз дээ.

Хариулт: Мунхаг болон эвдрэхүй үзлийн талаар бусад багш нарын баримтлалыг *"Дунд төрөлхтний аймаг"*-т номносон билээ.

Тиймээс энэ үест Чандракирти багшийн тааллыг номносугай. Төв үзлийн буюу тэлөөлөгчдөөс "Мунхаг бол бодит юмсыг үнэнд баригч бөгөөд мэдэгдэхүүний түйтгэр" гэж үздэг. Бас "нисваанисын мунхаг" ч гэдэг. Дээр татсан *"Дөрвөн зуутын тайлбар"*-т "нисваанист" гэж номносон. *"Орохуйн тайлбар"-аас ч:*

Энэ нь амьтан хүнийг оршин буй ямарваа бодит юмсыг таньж мэдэхэд моншруулан үйлдэгч учраас мунхрах буюу үл мэдэх байдалт сэтгэл болдог. Бодит юмст өөрийн чанар байхгүй атал гүтгэн хөөрөмшин үйлдэх бөгөөд жинхэнэ мөн чанарыг мэдэхэд "түйтгэрлэх" (хаах) авирт учир янагуух буюу хэмээжээ. Мөн: Тиймээс орчлонгийн гишүүнд лавтайяа багтах нисваанист мунхагийн эрхээр янагуух үнэний агуулгыг тодорхойлдог шүтэн барилдахуйн арван хоёр гишүүний анхдугаарт номносон учраас энэ нь нисваанист тооцогдож, мэдэгдэхүүний түйтгэр биш болой.

Асуулт: Чингэвээс "мэдэгдэхүүний түйтгэр" биш юм уу?

Хариулт: Түүнийг хойно номносугай. Арван хоёр гишүүний анхных болж буй "энэхүү мунхаг нь зовлонгийн үндэс мөн" бас "эвдрэх үзэл ч зовлонгийн үндэс мөн" гэж номнохоор мунхаг нь ерөнхий (үндэс) болох, эвдрэх үзэл нь түүний өвөрмөц (салбар) болно гэж үзсэн учраас зөрчилдөх зүйл гарахгүй. Бас мунхаг бол оюун ухааны сөрөг тал болдог. Хэдийгээр янз янзын ухаан мэдлэг байх боловч энэ үед "би-үгүй" буюу хоосон чанарыг оносон билиг ухааныг тухайлсан болой.

Түүний сөрөг тал нь тийн ухааныг байхгүй гэх буюу түүнээс ангид төдий ч байхгүй гэх зэргээр түүний харшлах талыг барина. Өөрөөр хэлбэл "би байна" гэж гүтгэх бодол болой". Чингэхдээ "номын би-г барих", "бодгалийн би-г барих" зэргээр гүтгэх тул "номын би-г баригч" болон "бодгалийн би-г баригч атгаг" хоёулаа мунхаг болно. Тиймээс эвдрэх үзлийг бусад нисваанис бүхий суурь гэж заачихаад мунхагийг заагаагүй гэж болохгүй.

Хэзээ "цогцос" гэж барих бодол буй. Тэр хүртэл түүнийг "би-д барих буй" гэж "ном юмсын би"-д барих мунхаг нь "бодгалийн би"-д барих мунхагийн үндэс болно гэж заасныг үзвэл энэ хоёр мунхагийн нэг нь нөгөөнийнхөө үндэс, үр дагавар болно гэдгийг үзүүлжээ. Тиймээс эвдрэх үзэл нь мунхагаас буюу бүх нисваанисуудын үндэс болно гэхэд харшлах зүйлгүй болох нь ээ.

Багшийн энэхүү номлол тааллыг ухаараагүйгээс болж зовлонгийн

үндэсийг хоёр гэж номносон гэж үзэх зөрчлийг арилгах маш бэрхтэй. Чингэж мунхагийг танин мэдэх ёс нь Нагаржунай багшийн таалал билээ. *"Хоосон чанарын далан шүлэгт"-ээс:*

Шалтгаан, нөхцлөөс бодитой төрөгсөдийг
Үнэхээр хэмээн атгаглах алин тэдгээрийг
Мунхаг хэмээн бурхад зарлиглав
Түүнээс арван хоёр гишүүд үүдэх

Үнэнийг мэдэхийн тул бодасууд хоосон болох л
Сайтар ухаарваас мунхаг үл гарах
Тэр л мунхагийг хорих буюу
Тийнхүү арван хоёр гишүүд ч түрдэх буюу хэмээн айлджээ.

"Үндсэн билгийн хорин зургадугаар бүлэг"-ээс ч:

Мунхагийг хорих болсноор л
Хуран үйлдэхүй, бүхэн гарахуй үл төрөх
Мунхагийг хорих болсноор л
Хоосон чанарыг ухаарч бясалгах

Тэр болоод тэдгээрийг хорих болсноор
Тэр болоод тэдгээр нь илт үл болох
Зовлонгийн цогцос зөвхөн түүнийг
Тэр болоод тэдгээрийг үнэхээр хорьсоноор л

хэмээсэнтэй бас таарна. "Хэзээ цогцос гэж барих буй" хэмээн цогцост баригч атгагийг зовлонгийн үндэс болно гэж айлдсантай машид таарах болой.

Арьядэва хутагтын болгоолыг: "Биеийн эрхтэн биеийг эрхшээхтэй адил" хэмээх ба "зовлонгийн үндэс болсон тийн мэдэхүй" хэмээх зэргээр дээр дурдсан эшүүдээр тодорхой заажээ. Нагаржунай багш бээр төв үзлийн шастаруудаа айлдсан хоригдохууныг хорих ухаан бүгдээрээ ном юмсыг өөрийн мөн чанараар бүтсэн гэж гүтгэн үзэх мунхагаар өдөөгдсөн тэрхүү "өвөрчлөн чанар" гэгчийг хорьж буцаан алив ном юмс өөрийн (өөрөөс бүтсэн) мөн чанар байхгүй орныг л сөхөөн гаргах утга зорилготой элдэв янзын нотлох ухаануудыг айлдсан байдаг. Энэ талаар "*Буддхабалида"*-аас ийн номнов:

Их нигүүлсэхүйн эзэн, багш бээр хамаг амьтан зовлонд нэрвэгдэж энэлэхийг болгоон тэднийг лавтайяа гэтэлгэхийн тухайд бодит юмсын үнэн (үнэмлэхүй) чанарыг зөв зүйтэй заах учиртай хэмээн таалж шүтэн барилдахуйн

жамыг зааж туурвижээ. Үнэн бусыг үзвээс хүлэгдэх, үнэнийг үзвээс лавтай гэтлэх хэмээн айлджээ.

Чингээд бодит юмсын үнэнхүү чанар гэж юу болохыг номносу. "Мөн чанар байхгүй гэдгийг ухаараагүйгээс буюу оюун ухааны нүд минь мунхагийн харанхуй түйтгэрээр халхлагдсан болохоор бодит юмст (өөрийн) мөн чанар байдаг юм шиг атгаг бодол төрж улмаар шунал тачаал, уур хилэн (урт) зэргүүдийг үүсгэнэ.

Харин шүтэн барилдахуйн жамыг ухаарсан гэгээн бодол ургаснаар мунхагийн харанхуй арилж, ухаан билгийн нүдээр бодит юмст (өөрийн) мөн чанар байхгүй юм байна гэдгийг мэдэрч ухаарна. Тэр цагт "байхгүйн орон зайд" нөгөөх шунах тачаах, уурлах хилэгнэх сэтгэлүүд төрөхгүй" хэмээжээ.

"Хорин зургадугаар бүлгийн завсарын найрлага"-аас:

Ийн өгүүлсү. Та их хөлгөний гол номуудаар үнэмлэхүй утгыг хэрхэн ухаарахыг номнов. Эдүгээ Та сонсоод сонсогчийн гол номуудаар үнэмлэхүй утгыг хэрхэн ухаарахыг заагтун. Үүнийг өгүүлсү. Мунхагийн түйтгэрээс дахин төрөх..." хэмээх тэргүүтэн ба *"Хорин долдугаар бүлгийн завсарын найрлага"-аас ч:* "Энд өгүүлсү. Эдүгээ та сонсоод сонсогчийн хөлгөнтэй зохилдох судрын аймаг нийтээр шүтэх үзэл онолыг хэзээ ч буу заагтун. Энд номносу. Өнгөрсөн цагт гарч байлаа" хэмээх зэргээр айлджээ.

Буддхабалида багш бээр ч *"Тайлбар"*-таа :

Арван хоёр гишүүний эхнийх нь болох мунхаг нь бодас юмст мөн чанар байна *гэж гутгэх* бөгөөд Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад нар ч "номын би үгүй" чанарыг (хоосон чанар) ононо гэж тодорхойлжээ. Тиймээс Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад нар нь өвөрчлөн чанар байхгүйг ононо гэдгийн их баталгаа нь "номын би-г баригч атгаг нь арван хоёр гишүүний доторх мунхаг энэ болой гэж үздэгт байгааг ухаарахтун.

"Дөрвөн зуут"-аас"

Атгаглан үзэх нь хүлээс буюу
Түүнийг энд хорьж үйлдэх

хэмээсний "атгаг"-ийг атгаг бүхэнтэй адилтган үзэж болохгүй биз. Харин ном юмсыг өөрийн мөн чанараас бүтсэн гэж гутгэн хэтийдүүлэн бодогч атгагийг л хэлж байна" хэмээжээ. Түүнийг бас нисваанист мунхаг ч гэдэг. "Энэ чинь ийм болой" гэх зэргээр аливаа юмсыг мэдрэх хүртэлх атгаг бодол бүхнийг хорих

хэрэгтэй гэвэл огт юу ч ухаараагүйн шинж ээ" хэмээжээ.

Чингэлгүй хоосон чанарын утга нь эгэл төрөлхтөнд далд мэдэгдэхүүн учраас хоосон чанарын утгыг атгаглах гэж үгүй. Тиймээс мэдэхийн ч арга огт байхгүй гээд ямар ч атгагаар юм мэдэж болохгүй гэвэл, мэдэх ёстой орноо эндүүрэгч буруу мэдрэхүй буюу мөн чанар буй хэмээн гүтгэгч бодолтой адил болно шүү. Тэр адил болбол гаслангаас нөгчихүй газарт хөтлөх үнэн үзэлгүй болох тул төв үзлийн гол ном шастаруудыг дуулж, сонсож, бодож санасны ч тус гарахгүйд хүрэх буюу. *"Дөрвөн зуут"-аас:*

Би гаслангаас нөгчих хэмээн
Хоосон бусыг хоосон мэт үзэх бус аа
Буруу үзлээр гаслангаас үл нөгчих хэмээн
Түүнчлэн залрагсад бээр айлдав хэмээжээ.

Дээр өгүүлсэн мунхаг сэтгэлээр шунан барих орон түүнээ суурилж гадаад, дотоодын аймгийн бодит өгүүлэгч нарын тогтсон тааллын үүднээс элдэв олон гүтгэлэг, хэтийдлүүд гаргаж ирсэн бүгдийн үндсийг тасарсан мод адилаар мунхаг барих тэрхүү орныг хөөж гаргаснаар тэр бүгдийг буцаана.

Тиймд ухаантан мэргэд бээр хамт төрсөн мунхагийн шунах орныг л гол хоригдохуун гэж таниарай. Харин зөвхөн тогтсон тааллыг өгүүлэгч нарын гаргаж томъёолсон "хамаг нэрийдэл" бүхнийг гол зүйл болгож бүү баригтун.

Хоригдохууныг хорино гэдэг үйл ажлыг үгүйсгэж, хоосруулж буй хэрэг биш. Хоригдохуун болох тухайн буруу атгаг буруу сэтгэл бодлоор л амьтан зовлонд хүлэгдэж байгааг ухаж мэдээд тэрхүү бодлын орныг хөөж гаргах нь гол зүйл мөн. Учир нь хамт төрсөн мунхагаас болж амьтан зовлонд хүлэгддэг байна. Харин "хотол нэрийдсэн мунхаг" нь зөвхөн тогтсон тааллыг өгүүлэгч нарт байдаг учраас зовлонгийн үндэс болж таардаггүй. Эдгээрийг сайтар ялгаж мэдэх нь маш их чухал аа.

Чингэхээр хоригдохуун болох хамгийн гол буруу атгаг бол арван хоёр гишүүний анхдугаарт орох хамт төрсөн мунхаг болой. Хотол нэрийдлийн хоригдохуунуудын хувьд дээрх мунхагт суурилсан хэтийдүүлэн гүтгэлэг болох учраас эрхтний мэдрэхүй зэрэг атгаггүй сэтгэл ухааны орон бүхнийг хэзээ ч нотлох ухаанаар сөхөөж няцаадаггүй болой.

Тиймээс нотлох ухаанаар барих орноо сөхөөн няцааж буй сэтгэл ухаанд зөвхөн дотоод сэтгэл мэдрэхүйнүүд, "би"-д барих хоёр мунхаг, мөн тэдгээрийн барих вишай орнууд, ялангуяа гүтгэх, хэтийдэн барих атгаг зэргүүд багтана. Атгаг бүхнийг ингэж бүү бодоорой.

Асуулт: Чингэвээс мунхаг сэтгэл тэрээр хэрхэн өвөрчлөн чанарыг гүтгэж хэтийдүүлэн боддог вэ?

Хариулт: Эл багшийн номоос үзвэл ерөнхийдөө янагуух нэрийдэл төдийд бүтсэн утгуудыг "өвөрчлөн", "өөрийн мөн чанарт" гэх зэргээр нэрлэсэн, томъёолсон зүйл олонтаа үзэгдэнэ. Гэвч энэ үед бодгаль болон ном юмс болж байгаа ямар ч орон вишайг зөвхөн ухаан, сэтгэлд мэдрэгдэх, агуулагдахаар нь төдийгөөр бус, тэдгээр юмс үзэгдэлд нь "өөр, өөрийнхөө талаас оршин тогтох буюу байж суух жамтай гэж үзэх энэ бодолд агуулагдана.

Тийнхүү бодох бодлын шунах (барих) орон болсон ном юмсын "өөрөө байх жам ёс" гэж ойлгоорой. Томъёоны үүднээс "би" буюу "өвөрчлөн чанар" гэж ойлгоорой.

Энэ бүхэн өөрийн эрхгүй бөгөөд
Тиймээс л "би" хэмээх буй бус хэмээснийг,

"Дөрвөн зуутын тайлбар"-аас:

Энэ нь өөрийн мөн чанартай, өвөрчлөн чанартай, өөрийн эрхтэй, бусдаас үл хамаарах чанарт болно. Түүнийг хэмээн тэдгээр тоо зүйлийн талаар айлджээ. Түүний доторхи "бусдаас үл харгалзах" гэдэг шалтгаан нөхцөлд харгалзалгүйгээр зогсохгүй "бусад" хэмээн онох янагуух сэтгэл болоод түүний эрхээр агуулагдахгүй учраас "бусдаас үл харгалзах" болжээ. "Өөрийн эрхт" гэдэг нь тэдгээр орнууд нь "өөр өөрийн оршихуй ёс буюу байж суух нийт бусын чанартайд" оршино. Тэр л чанарыг "өөрийн мөн чанар болон өөрийн өвөрчлөн чанарт хэмээжээ.

Түүнийг үлгэрлэвээс, "Хуйлсан дээсийг могой гэж нэрийдэх явдал нь могой мэт харсан сэтгэлийн талаас хэрхэн үзсэн, харсан тэр л байдлаар нь агуулсан хэрэг. Тэрхүү могой үнэхээр өөрийнхөө талаас тийнхүү нэрийдсэн, агуулагдсан шигээ өөрийн мөн чанараар хэрхэн мөн эсэхийг шинжилвээс тэрхүү эрээн дээсэнд могойн чанар юу ч байхгүй, түүний ялгамжаа онцлогийг ажиглахад огт байдаггүй. Түүнтэй адил янагуух ухааны орон болж байгаа эдгээр ном юмсын хэрхэн үзэгдэх, үзэх ёсыг ажиглахаа орхиод тэдгээр ном юмсын жинхэнэ "өөрийнх нь жам ёс" гэж юу байна гэж тухайн ном юмс дээр ажиглаад ирэхээр "юу ч бүтээгүй" болж ирнэ. Чингэж барихгүй буюу нэрийдлийн байхгүй мэдрэхүйн эрхээр ч агуулалгүйгээр тэдгээр ном юмст өөр өөрийн талаас хэмжигдэх жам ёс тус тус байна" гэж барих явдал" (үзэх) билээ. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:*

Буй гэх атгаг байгаагаар "буй" хэмээх, "Би буй бус" хэмээх атгагаар "буй бус" гэх тэдгээр энд таарахгүй. Хуйлсан дээсийг хараад могой гэж нэрийдэхдээ өөрийн мөн чанараас бүтээгүй гэдгийг мэдэж болно" хэмээн өөрийн чанараар эс бүтэх ёсыг тийн айлджээ. Тиймээс дотоод сэтгэл оюуны эрхээр агуулагдах бус өөрийн мөн чанарын үүднээс тухайн ном юмст бүтэж бий болсон түүнийг л "би" буюу "өвөрчлөн чанар" хэмээнэ гэжээ.

Тэр чанарын нь суурь ялгааны хувьд бодгальд байхгүй байгаа нь "бодгалийн би үгүй" чанар болж, нүд, чих зэрэг ном юмст байхгүй болохоор "номын би-үгүй" чанар болно гэж айлджээ. Тиймээс тэрхүү "өвөрчлөн чанар"-ыг "бодгальд болоод ном юмст буй" гэж үзэх нь "би-д баригч" хоёроор үзэж болохыг далдуур ухаарч болно. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:*

"Би гэдэг аливаа бодит юмсын бусдаас харгалзахгүй байна гэвэл тэрээр өвөрчлөн мөн чанарт болно. Тэр чанар байхгүй байгаа нь "би-үгүй" болой. Тэдгээрийг номын болоод бодгалийн гэж хоёр зүйлээр ойлгох буюу "номын би-үгүй" болон "бодгалийн би-үгүй хэмээх болой" хэмээн айлджээ.

Гэвч бодгалийн өөрийн бэлэг чанараар бүтсэнд барих бодол түүнийг "бодгалийн би"-д баригч гэж үзэж болохгүй. Ингэхгүй бол бусад бодгалийг бодоод өөрийн бэлэг чанараар бүтжээ гэж барихыг ч "бодгалийн би"-д баригч гэж үзэхэд хүрнэ. Түүнийг зөвшөөрвөл "эвдрэхүй чуулганы үзэл" болох учиртай. Гэтэл нөгөө бодол чинь "би болой" гэж боддоггүй учраас "эвдрэх үзэл" болж таарахгүй биз дээ? хэмээв. Бодгальд мөн чанар байна гэж үзэх буюу дээр номносон мөн чанартай бодгалийг "бодгалийн би" гэж айлдсан тул "бодгалийн би"-д баригч л гэж үзэх ёстой. Гэхдээ "бодгалийн би"-д баригч атгаг болоход заавал эвдрэх үзэл байх албагүй болой.

Асуулт: Чингэвээс эвдрэх үзэл болдог "би"-д баригч нь ямаршуу байх вэ?

Хариулт: Эвдрэх үзлийн хотол нэрийдсэн "би"-д баригчийн хувьд "Олноо өргөгдсөн аймгийн зарим нэгнүүд бие цогцосоо бодож "би-д барих" ёстой гэж үзсэн нь лавтай үзэгдэхгүй ч хамт төрсөн эвдрэх үзлийн талаар *"Орохуйд"*-д үзэхдээ "цогцосоо бодно" гэдгийг үгүйсгэсэн" байдаг. *"Тайлбар"*-т үзэхдээ "Шүтэлцэж нэрийдсэн би-г бодно" гэж айлджээ. Ингэхээр цогцосоо бодох албагүй, бодгаль төдий нэгнээ тухайлах ажээ. Мөн "би болой" хэмээн барих бодол төрөхийн суурь болсон бодгаль нь нэг л зүйл байх тул бусад язгуурын бодгалийг бодох ёсгүй билээ.

Тэрхүү бодлын орноо ямархуу намба төрхтэйгээр барих талаар

"Орохуйн тайлбар"-аас:

Би болон минийх болой хэмээх нь тэр л байдлаар эвдрэх чуулганы үзэл болой" хэмээсэн мэт өөрийн бэлэг чанараар бүтсэн мөн чанар байна гэж барих бус, "би болой хэмээн барих нэгэн хэрэгтэй.

Мөн *"Орохуйн тайлбар"-аас:*

Зөвхөн эвдрэх чуулганы үзлийг л тэвчих хэрэгтэй. Миний "би" нь байхгүй гэдгийг ухаарч мэдэх нь тэвчиж байгаа хэрэг" хэмээн тухайлах бодлын вишай орон болсон "би" түүний "би-үгүй буюу өөрийн мөн чанар байхгүйг нь ухаарч оносноор барих орнууд харшлахын үүднээс тэвчиж болой хэмээн айлджээ.

Тиймээс билиг ухааны няцаах зүг гэж ойлгох хэрэгтэй. Бодгаль өөрийн бэлэг чанараар бүтсэн гэж үзэж буй учраас өөрийн бэлэг чанараар бүтсэн "би болой" гэж барьдаг. "Минийх" гэж барих эвдрэх үзлийг ч үүгээр жишиж мэдээрэй. "Би болоод минийх болой" гэж үзэлгүйгээр "бодгаль нь эдлэг зүйлт" гэж барих бодол нь "бодгалийн би-үгүй" чанарыг ойлгоогүй мунхаг учраас нисваанист болно.

Чингэхдээ өөрийн мөн чанараар бүтсэн мөн чанар төдийг "би" гэж үзэх болон "би болой" хэмээх төдийд барих бодлын орны "би" гэж үзэх хоёр янз бий. Эхнийх нь ухааны хоригдохуун болно. Удаахыг нэрийдэл төдий байх учраас заавал хорих албагүй. Тэдгээрээр хамт төрсөн эвдрэх үзлийн бодол тухайллыг хориогүй, харин түүний барих орон болсон өөрийн мөн чанараар бүтсэн "би"-г хорихгүй байж болохгүй. Үлгэрлэвээс, "Дуу авиаг мөнх" гэж үзэх үзлийн бодлын орон болсон "дуу авиа"-г хорьж үгүйсгэхгүй ч түүний шунах орон "дуу авиа мөнх" гэдгийг хориход харшлахгүйтэй адил. Тийнхүү хутагт эцэг, хөвгүүд болон хоёр багшийн гол зохиолуудаас айлдсан *"өвөрчлөн буй аваас", "өөрийн мөн чанарар буй аваас", "өөрийн бэлэг чанараар буй аваас", "эдлэг чанар буй аваас"* хэмээн хориглож айлдсан "өвөрчлөн" тэдгээрийг дээр үзүүлсэн тэр ёсоор ухаарч аваарай. Тэдгээрийг үгүйсгэн заасан үгийн утгууд нь ч мунхагаар шунан дурдсан тийм утга байхгүй болохыг л заасан тул тэр дагуу ойлгоорой.

2/ Түүнийг бусад хоригдохуунтой найруулах, эс найруулах ёсон

"Туулайн эвэр", "хүүсэр эмийн хөвгүүн" зэрэг огт байхгүй зүйлсийг байхгүй ээ гэж ярихад заавал тэрхүү *ялгамжааг хийх* шаардлагагүй. Түүнтэй адилаар мэдэгдэхүүн мөн ч зарим орон, цаг үед гарч ирээд зарим орон цаг үед үгүй болдог зүйлүүд дээр ч тэр орон цаг үед байна, байхгүй гэх зэргээр

өгүүлдэг ч тэрхүү ялгаврыг хэрэглэх хэрэггүй.

Мөн Төв үзэлтэн нараас “нэрийн төдий ч бүтээгүй” гэж үзээд гадаад, дотоодын бодит өгүүлэгч нарын нийт бусын элдэв гүтгэлэг, хэтийдэл зэргийг буруутгаж хориxдоо ч сануулах зэргийн үүднээс зарим нэг газар хэрэглэхээс бус, утгандаа “өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн” гэж шинээр ялгавар гаргаж хэрэглэх шаардлагагүй. Тогтсон тааллыг өгүүлэгчид бээр тэдгээр утгыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Харин эдгээрээс өөр нөхцөлд Төв үзэлтэн нар янагуухийн агуулга, утга юу болох, мөн тэдгээрийг үгүйсгэх үестээ тэрхүү ялгаврыг гаргаж хэрэглэхгүй бол няцаагчийн нотлох ухаан тэр нь алдаатай юм шиг болж муухан няцаалга болж одох тул ялгаврыг хэрэглэх хэрэгтэй.

Мөн дээр өгүүлсэн мэт Төв үзэлтэн нар янагуух утгын агуулга дээр өвөрчлөн байх, байхгүйн нотлол ухаан болоод янагуухийн шалгадаг ухаан зэргээр хорлох (шалгах) хэрэггүй. Эс чингэвээс Вишну тэнгэр зэргийг нэрийн төдийд ч үл авч үзэх, харин дүр, дуу зэргийг авч үзэхийн ялгаа ерөөс гарахгүй болно. “Энэ адил нь мөр мөн. Энэ адил нь мөр биш. Иймд тогтсон таалалд таарна. Иймд тогтсон таалалд таарахгүй” гэх зэргээр ертөнц ба ертөнцөөс нөгчигсөн ямарваа утга агуулгыг ялгахын аргагүйд хүрэх тул өвөрчлөнгөөр хоосон чанарт сансар (самсара), нирваны хамаг утга агуулагдана гэдэг ялгаа ч үгүйсгэгдэнэ. Тэгээд ч шалгадаг ухаанаар шалгачихаад байхад түүнийг хорино, үгүйсгэнэ гэвэл мэргэдийн элэг доог болох биз ээ.

Тиймээс тэдгээрийг тийн хориглож айлдсан үед л эргэлзэлгүйгээр тэр ялгаврыг найруулаарай. Энэ талаар *“Дөрвөн зуутын тайлбар”*, *“Ухааны жаран шүлэгтийн тайлбар”* зэргүүдэд хоригдохууныг хорих үед тэрхүү ялгаврыг хэрэглэсэн нь олонтаа үзэгдэнэ. Мөн *"Үндсэн билиг"*, *“Буддхапалида”*, *“Тодорхой үгт”*, *“Орохуйн тайлбар”* зэрэгт ч хэрэглэсэн үгс олонтаа хэрэглэсэн нь тааралдана. Тиймээс үг олон болох вий гээд найруулаагүй байвч, хэрэглэвэл онох ухаарахад хялбар болохыг болгоож найруулаагүй үест ч найруулан хэрэглэж болно. Тэдгээр найруулах, эс найруулахын ялгаа огт гарахгүй. Мөн “тийн шинжилвээс буй бус болой” хэмээн “тийн шинжлэх” гэдэг ялгаврыг хэрэглэх нь ч олон үзэгдэнэ. Түүнийг дээр номносон мэтээр “өөрийн мөн чанараар бүтсэн” эсэхийг ахуй ёсыг шинжигч ухаанаар хайгаад үзэхээр эс олдсон учир “өөрийн мөн чанараар бүтэн утга байхгүй” юм байна гэдэг дүгнэлт хийсэн ухаан буюу. Тиймээс “өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн байхгүй” хэмээсэнтэй нэгэн утгат гэж ойлгоорой. *“Дөрвөн зуутын тайлбар”-аас:*

Галын хүрдэн, илбийн морь мэт эдгээр юмс хуурмаг хэдий ч, огт байхгүй

гэж үзэж болохгүй. Тэр цагт магад утгыг зөв шинжилж үзэх гэтэл, "тунгаамал алт" тэдэнд "өөрийн мөн чанар" гэгч байх ч юм шиг тодорхой бодогдоод ирвэл чанх буруугаар ухаарах шалтгаан болж одох вий. Тиймээс тэдгээрийг "үнэн зөв шинжлэлийн галд хайлуулбал" "өөрийн мөн чанар байхгүй болох нь мэдэгдэхгүй ч зүйл биш л дээ" хэмээн айлдсан мэт болой.

3/ Хоригдохуунд үнэмлэхүйн ялгааг найруулах, эс найруулах ёсон

Зөвхөн "Өөрийн үндэст" төв үзэлтний ёсонд л хоригдохуунд үнэмлэхүйн ялгаврыг найруулдаг гэвэл огт таарахгүй. *"Орохуйн тайлбар"-т "Ялгуугсадын эх судар"*-аас эшлэж:

Насан гавьяат Равжор (Субути) юуг ч олохгүй, бас юуг ч илт онохгүй юу? Равжор ийн хариулав. Насан гавьяат Шарийн хөвгүүн (Шарибудра) ээ! Онох ч буй. Илт онох ч буй билээ. Гэхдээ энэ хоёрын ёсоор бус аа. Насан гавьяат Шарийн хөвгүүн ээ! Онох ба илт онох нь ертөнцийн нэр томъёонд алдаршсан болой. Үргэлжид оргоч, Нэг удаа жич ирэгч, Жич үл ирэгч, Дайснаа дарагч архад, Бурхан, Бодисадва нар ч ертөнцийн нэр томъёо болой. (Харин) Үнэмлэхүй утгаараа бол онох үгүй, илт онох үгүй болой" хэмээн айлдсан дагуу өгүүлэх ёстой.

"Орохуйн тайлбар"-аас айлдсан түүнийг Өөрийн үндэстийн судар гэж өгүүлэх буюу тэрчлэн магад утгын (үнэмлэхүйн үнэнийг) судраас ч үнэмлэхүй ялгаврыг найруулсан нь олонтаа үзэгдэнэ. *"Хоосон чанартын далан шүлэгт"-ээс ч:*

Орших, төрөх, эвдрэх, буй, буй бус гэх болоод
Доор, дээр онцлог ялгаа гэх зэргийг
Ертөнцийн томъёоны эрхээр айлдсан болохоос
Үнэмлэхүйн эрхээр бус, Бурхад бээр" хэмээсэн ба,

"Их эрдэнийн эрхи"-ээс:

Би хийгээд минийх байна гэсэн ч
Үнэмлэхүйн утгаар бус үүнийг
Мөн алин хуурмаг хөрөнгө түүнээс
Үнэн төрөх гэж хаана байх хэмээсэн ба, мөн

Илбэ адилын ертөнцөд хэдий

Төрөх, түүрдэх зэрэг үзэгдэвч
Үнэмлэхүй утгаар төрөх болоод
Түрдэх гэдэг хаана байна

хэмээх зэрэгт "үнэмлэхүйгээр", "үнэнээр", "үнэхээр" гэх зэргээр хоригдохуунд найруулж айлдсан нь олон буй. Тийнхүү найруулаагүй ч "өөрийн мөн чанар, өвөрчлөн, өөрийн бэлэг чанараар бүтээгүй" гэх зэргийн ялгавар хэрэглэсэн нь маш олон үзэгдэнэ. *"Буддхабалида"-аас:*

Бурхадын үзүүлсэн номууд
Хоёр үнэнд үнэхээр шүтэх
Ертөнцөд янагуух үнэн болоод
Үнэмлэхүй үнэн буй болой хэмээсэн буй.

Тиймээс ертөнцийн алив янагуух үнэн болвоос "хумх байна", "өвсөн дэвсгэр буй" гэх зэргийг өгүүлэх, бас хумх хагарах, өвсөн дэвсгэр шатах гэх зэргээр тэдний мөнх бусыг ч өгүүлнэ.Хэзээ тэр ямагт чанарыг (хоосон чанар) санаж бодох цагт болвоос "хорих болоод өвсөн дэвсгэр" зэрэг нь шүтэн барилдсан нэрийдэл болж ертөнцөд үл таарах тул "хагарах", "шатах" тэдгээрүүд зохино гэж хаанаас байх вэ" Мөн ертөнцийн янагуухийн эрхээр түүнчлэн залрагсад (бурхад)-ыг "түүнчлэн залрагсад өөдөө оршсон болой", "түүнчлэн залрагсад гаслангаас нөгчигсөн болой" хэмээн мөнх бус болохыг өгүүлж болно. Хэзээ үнэмлэхүйг бодох тэр цагт "түүнчлэн залрагсад тэр чанар ч үл таарах учраас", өөдлөх "гаслангаас нөгчих" зэргүүд таарах гэж хаанаас байх вэ?" хэмээн айлдсан буй.

Чандракирти багш бээр: Үнэхээр төрөхийг хорьсон болохоос,Төрөх төдийг хорьсон бус хэмээн айлджээ. Тэрээр мөн *"Ухааны жаран шүлэгтийн тайлбар"-таа:*

Бид нар аливаа намба дүрийг "үл төрөх" (төрөх үгүй) гэж үзэхдээ, зөвхөн дүрс хөрөг шиг хуурмагаар тусдаг талаас нь өгүүлээгүй хэрэг. Гагцхүү (тэдгээрийн) "өвөрчлөн чанар" гэгдэх нь хаана ч олдохгүй (байхгүй) байгаа тэр үүднээс нь тэдгээрийг "үл төрөх" гэж өгүүлсэн хэрэг. Чингэхэд хаанаас ч олдохгүй байгаа "өвөрчлөн чанар" гэгч чинь ямаршуу зүйл төсөөлөгдөх бол? Хуурмагаар бус, үнэхээр байна гэж шүнах тэрхүү сэтгэлийн араншинг тухайлах болов уу даа. Тиймээс л тэдгээр юмсыг тэр цагт шүтэн барилдахуйн агаарт төрсөн гэж үзэх хэрэгтэй болно шүү дээ" хэмээж хуурмаг, илбэ адилд төрөхийг хааж хориглолгүй, харин "үнэнээр төрөх" гэгчийг хорьсон аж.

Тиймээс шүтэн барилдаж төрөх болон өвөрчлөнгөөр эс төрөх хоёр

харшлахгүй болохыг үзүүлжээ. Мөн дээрх *"Шастар"-аас:*

Тиймийн учир төрөх ба эс төрөх энэ хоёр нь тус тусын вишайтай тул хоорондоо харшлах гэж хаана буй" хэмээсэн ба "алин хэзээд шүтэж төрсөн тэр нь дүрс хөрөг адилаар өөрийн мөн чанараар эс төрөх болой гэж та нар хэлэх, өгүүлэх цагт эсэргүүцэхийн орон зай хаанаас ирэх билээ" хэмээн шүтэж төрөх болон өөрийн мөн чанараар эс төрөх хоёрыг харш гэж тэмцэлдэхийн хариу болгож айлджээ.

Мөн "Орохуй"-даа ч:

Тиймээс тэр адилын зэргээр
Бодит юмс язгуураасаа
Тийн ямагт эс төрөв
Ертөнц төрсөн хэмээн мэдэх

хэмээн "эс төрөх" гэдгээр "тэр ямагт"-ын ялгаврыг найруулжээ.

Хумхын тэргүүтэн эдгээр тэр ямагтад үгүй буюу
Ертөнцөд машид алдарсанаар буй хэмээгдэхтэй адил
Түүнтэй адилаар бодит юмс урвах тул
Хүүсэр эмийн хөвгүүнтэй адилтгаж бүү хэтрүүл

хэмээн гадаад, дотоодын бодит юмс бүхэн тэр ямагт чанараар, үнэмлэхүй байхгүй нэр алдараар (янагуух) байна хэмээн айлдсан тул хоригдохуунд үнэмлэхүйн ялгаврыг найруулахгүй байж болохгүй.

Хураангуйлваас, хоригдохуунд үнэмлэхүйн ялгаврыг найруулах огт хэрэггүй гэвэл "энэ, энэ нь үнэмлэхүй болой" гэх ба "Энэ, энэ нь янагуух болой" гэх зэргээр хоёр үнэнийг ялгаж болохгүйд хүрнэ. Чингэж үзэх төв үзэлтнийг хаана ч номлоогүй тул зөвхөн буруу атгаг болно. *"Тодорхой үгт"-ээс:*

"Өөрөөс төрөх" гэдгийг хориход л хоригдохуунд үнэмлэхүйн ялгавар хэрэглэхийг хориглосон болохоос төрөх төдий дээр бус" хэмээн тэрхүү тайлбартаа тодорхойлжээ.

"Орохуйн тайлбар"-таа ч:

Багш бээр ялгавар хэрэглэлгүйгээр "өөрөөс бус" хэмээн ерөнхийд нь төрөхийг хориглосон болой. Аливаа бодит юмс үнэмлэхүй "би"-гээс төрсөн бус мөн орших учраас амьтантай адил" хэмээхэд "үнэмлэхүй" гэдэг ялгаврыг хэрэглэх хэрэггүйг санаарай" гэж айлдсаны дагуу болой"

Тиймээс "Өөрийн үндэст" болон "Хэтрүүлэгч" хэмээх хоёр төв үзэлт нар хоригдохуундаа үнэмлэхүйн ялгаврыг найруулах, эс найруулахын үүднээс ялгадаггүй ч өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн түүнийг нэрийдлээр хорих уу, эсвээс хорихгүй юу гэдгийг (нэрийдэл төдий бус, эсвээс буй бус гэж үзэх) ялгадаг. "Хэтрүүлэгч"-ийн ёсоор бол өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн гадаад, дотоодын юмсыг (байхгүй) хориход "үнэмлэхүй", "үнэхээр", "үнэн" гэх зэргийн ялгаврыг шинээр нэмэх хэрэггүй. Учир нь өөрийн мөн чанар өвөрчлөн буй аваас үнэмлэхүй утгаар бүтсэн байх хэрэгтэй болно" Өөрийн үндэст нар үзэхдээ тэдгээрт "үнэмлэхүй" зэргийн ялгаврыг эс найруулваас хорьж чадахгүйд хүрэх тул "үнэмлэхүй", "үнэхээр", "үнэн" зэргийн ялгаврыг найруулна хэмээдэг. Гэсэн ч энэ хоёр төв үзэлтнүүд төрөх, түрдэх, хүлэгдэх, гэтлэх тэргүүтэнд "үнэхээр" "өөрийн мөн чанараар бүтэх" зэргийн ялгавраар алиныг ч хэрэглэлгүйгээр хорьж чадна гэж үздэггүй байна.

Чингэвээс "Үнэхээр байхгүй" гэдэг ямар утгатай вэ? Ер нь дээд утга буюу үнэмлэхүй хэмээхийн утга бол мэдэгдэхүүний эрхэм дээд утга бөгөөд энэ хоёр ижил утгатай мөн "дээд" гэхэд үл атгаглах билгэ билиг мөн. Түүний вишай утга буюу орон болох учраас "үнэмлэхүй" хэмээдэг. Бас үнэмлэхүй дээдийг илт онох билгэ билиг болон түүнтэй ижилсэх билиг ухааныг "үнэмлэхүй" гэнэ.[Бхававивека гэгээн *"Төв үзлийн зүрхэн"* бүтээлдээ:]

Энд шороо тоос тэргүүтэн
Үнэхээр, дээдээр гарсан бус
хэмээснээ тайлбарлаж *"Ухааны бадрал"-даа:*

Дээд утга (үнэмлэхүй) хэмээхийн хувьд, "утга" нь мэдэгдэхүүн буюу шинжигдэхүүн, ухааргадахуун гэсэн үг болой. "Дээд" нь эрхэм, манлай хэмээх үг дохио болой. Дээд утга гэдгийг хураангуйлваас тэрээр утга ч болдог, бас эрхэм дээд нь ч болдог учраас дээд утгат болно. Мөн дээд утгат болдог нь сайтар үл атгаглах дээд билгэ билгийн орон учраас л дээд утгат болой. Мөн дээд утга лугаа зохилдож дээд үнэнийг онох ба даган зохилдсон билиг түүнээ дээд утга тэр орших учраас л үнэмлэхүйтэй зохилдоно хэмээн айлджээ.

"Дээд утгаар тэнд байх бус буюу байхгүй" хэмээн өгүүлэх дээд утга нь дараах байдлаар буюу дээрх *"Шастар"-аас:*

Асуулт: Чингэвэл ямарваа дээд утга бол ухаан сэтгэлээс хэтэрсэн зүйл билээ. Бодит юмсын мөн чанарыг хорих нь үсгийн орон учир хорихгүй байж болохгүй юу?

Хариулт: Дээд утганаа хоёр зүйл буй түүний нэг нь илт хуран үйлдсэн

байхгүй" гэж оносон, ертөнцөөс нөгчигсөн, цувиралтгүй, цацралгүй нэгэн болой. Удаах нь илт хуран үйлдэх зэрэгтэй хамт орох тул бинавад болоод билгэ билгийн буяны чуулган зэргийг даган зохилдсон, ертөнцийн билгэ билиг хэмээгдэн цацрал сэлттэй буюу. Энэ үест түүнийг хүлээн зөвшөөрч онцлог ялгаа зэргийг баримтлах тул гэмгүй болой хэмээжээ.

Тиймээс тэр ямагт чанарыг ёсчлон шинжлэх, сонсох, санахын билгээс дээшхийг багтаана. Зөвхөн хутагтын даган олох билиг төдийгөөр хязгаарлахгүй.

"Төв үзлийн гэгээ"-нээс ч:

Үнэхээр төрөх хаана ч үгүй хэмээн өгүүлэх түүний утга энэ болой. Үнэмлэхүй утгыг сонсох, санах, бясалгахаас үүдсэн билиг ухаан бүгдээр зөв ухаан болох учраас үнэмлэхүй хэмээжээ. Түүний утга нь ч дээд болой. Илтээр болоод дамжуулан үйлдэхийн ялгаа бий. Тэдгээрийг санаж, бодсоны ачаар тэрээр бодит юмс зөвхөн "үл төрөх" мөн гэдгийг мэдэж ухаарна. "Үнэхээр үл төрөх" болой хэмээн ийн өгүүлэх нь үнэмлэхүй билгэ билгээр л эдгээрийг ийнхүү эс төрөхийг мэднэ хэмээн номнов хэмээсэнтэй зохилдож харагдана.

Мөн "Төв үзлийн чимгийн бэрх газрын тайлбар"-аас:

Гэсэн ч хэрхэн өөрийн мөн чанаргүй болно гэдгийг "үнэхээр" гэж хэлнэ. "Үнэхээр" гэх үгээр бодит хүчээр даган жишиж онох ёстой тэр ямагтын мөн чанар илэрхийлэгдэнэ. Тэр ямагт чанарыг тийн шинжээд ирэхээр хоосон хэмээгдэх үг үлдэнэ. Үүгээр л тэр ямагт болж, бас үнэмлэхүй дээд утгат тэргүүтэн болно гэж номножээ.

Мөн зөвхөн үнэмлэхүй сэтгэл тэргүүтнийг үнэмлэхүй зэргээр өгүүлсэн буй. Түүний бодлын орон тийн учраас буюу. Үнэмлэхүй сэтгэл бодлын эрхээр л өвөрчлөн чанар үгүй болно. Харин янагуух сэтгэлийн эрхээр тийм бус хэмээн өгүүлдэг" хэмээжээ.

"Өвөрчлөн үгүй-г" заахдаа "үнэмлэхүй" зэргийн ялгааг найруулах явдал [Бхававивекагийн] *"Билгийн зул", "Ухааны бадрал"* хоёрт олонтаа үзэгдэнэ.

Ялангуяа "Билгийн зулын арван тавдугаар бүлгийн тайлбар" -таа:

Эсэргүүцэх нь: Хэрвээ энд мөн чанаргүй болвоос яаж бодит болох вэ? Хэдий бодит болвол яагаад ч мөн чанаргүй байж болохгүй гэж үзээд түүгээрээ дээрх утгыг басамжлах гэм бий" хэмээн бодит зүйлсийн мөн чанар ямагт байхгүй ээ гэж үзэх нь өөрийн үгтэйгээ харшлах гэм гарна гэсэн тэмцлийн хариуд дээрх*"Шастар"-аас:*

Бодит юмс үнэхээр бүтсэн мөн чанартай гэж үзвэл, мөн чанар огтоос байхгүй гэж тангараглаж болохгүй учиртай. Чингэвээс тангараглах утганаа басамжлал тавиагүй, нотлолын утгыг бүтээсэн учраас үүнд гэм байхгүй, хэмээн бодит зүйлсийг үнэхээр мөн чанараар байхгүй гэж үзсэнээр басамжлал тавиагүй тул нэрийн төдийд өөрийн мөн чанараар бүтсэн мөн чанар байхгүй" гэж басамжлал талбисан болно гэж болгоосон нь тодорхой. Мөн *"Туунэс"*:

Нэгэнт хуран үйлдсэн учраас үнэхээр дотоодын бодит зүйлс нь өөрийн мөн чанаргүй болно. Ялгамжаат өгүүлэгдэхүүнд шүтэж харгалзсан учир үлгэрлэвээс, илбэчний хувилгасан хүн тэргүүнтэй адил" хэмээн мөн чанартайг үнэмлэхүйн ялгаврыг лавтай найруулах хэрэгтэй.

Чингэвэл үнэхээр үгүй хэмээхийн утга чухамдаа юу вэ? Ёсчлон шинжлэх ухаанаар тийн шинжиж түүнийг буй бус гэж нотлохын тал дээр энэ багшийн таалал бусадтай таарна. Энэ багшийн гол номонд ч "хоосон чанарыг үзэх болон даган зохилдох шинжилгээ хийлгүйгээр" хэмээн янагуухийн агуулгыг айлдсан буй. Мөн чанарыг хорихын цагт ухаанаар тийн шинжвээс "байхгүй ээ" гэж олонтаа айлдсан тул тэдгээртэй дээрх зүйлүүд адил болно. Гэвч өөрийн мөн чанараар бүтсэн хирнээ мөн ёсыг шинжих ухаанаар нягтлаж үзэхэд тэсэж гарах зүйл буй гэж үзэх хэрэгтэй гэвэл ерөөс таарахгүй. Энэ хоёр багш бээр, "өөрийн мөн чанараар бүтсэн юм бол тэр ямагт чанарыг шинжих ухаанаар нягтлахад тэсэх албатай" болох ба, "үнэхээр бүтэх нь ч бүр албатай болно" гэж үзэхэд хүрэхийг дээр олонтаа номносонтой адил аа.

17

ӨӨРИЙН ҮНДЭСТ (СВАНТАТРИКА) БОЛОН ХЭТРҮҮЛЭГЧ (ПРАСАНГАКА) ХОЁРЫН ЯЛГААГ БУРУУ ТАЙЛБАРЛАСАН НЬ

2) Өөрийн үндэст болон Хэтрүүлэгч төв үзэлтэн нар хоригдохууныг хэрхэн хорих
(а) Өөрийн үндэст болон Хэтрүүлэгч нарын утгыг бодитой барих
1/ Бусдын ёсыг хорих
а/ Баримтлалыг өгүүлэх

- - - o O o - - -

(2) Өөрийн үндэст болон Хэтрүүлэгч төв үзэлтэн нар хоригдохууныг хэрхэн хориход хоёр:
(а) Өөрийн үндэст болон Хэтрүүлэгч нарын утгыг бодитой барих
(б) Тэр хоёрыг даган барьж үзэл онол үндсэнд төрөх

(а) Өөрийн үндэст болон Хэтрүүлэгч нарын утгыг бодитой барих

Буддхабалида багшийн тайлбарт "Хэтрүүлэгч, Өөрийн үндэст" гэж хоёр ялгаж Хэтрүүлэгчийг тусгайлан авч үзсэн нь тодорхойгүй байна. Гэсэн ч *"Үндсэн билиг"* -ээс:

Өөрөөс бус, бусдаас бус
Хоёроос бус, шалтгаангүйгээс бус
Бодас зүйл алин юу байлаа ч
Төрөх нь хэзээ ч буй бус

хэмээн айлдаж "бусдын ёсыг үгүйсгэхийн үүднээс дөрвөн төрөхүйг няцаан зохиожээ. Түүнийг Бхававивека багш бээр "өөрийн ёсыг бүтээх ба бусдын зүгийг няцаах аль ч чадал байхгүй гээд, гэм буруугг тоочин няцаасан" гэцгээдэг. Гэвч Чандракирти багш бээр тэр мэтийн гэмүүд Буддхабалида багшийн ёсноо үл таарах учир шалтгааныг дэлгэрэнгүй тайлбарлаж бусад төв үзэлтэн нарт төв үзлийн онол сэтгэлд зөв төрөхийн арга болгож Хэтрүүлэгчийн ёсыг судлах хэрэгтэй гээд мөнхүү Өөрийн үндэстийн ёс таарахгүй хэмээн хориглож Хэтрүүлэгчийн аймгийг тодруулан тайлбарлажээ.

Түүнээ хоёр:
1/ Бусдын ёсыг хорих
2/ Өөрийн ёсыг номнох

1/ Бусдын ёсыг хориход хоёр:
а/ Баримтлалыг өгүүлэх
б/ Тэдгээрийг хорих

а/ Баримтлалыг өгүүлэхэд дөрөв: ***/1/*** Хэтрүүлэгч болон өөрийн үндэстийн талаар олон томъёолол бий. Гэхдээ тэр бүгдийг хэн номнож чадах билээ. Түүнээс зарим нэгийг номносугай. Үүнд Заянанда бандида бээр *"Орохуйн тайлбар номлол"-доо:*

Асуулт: "Тэр талаар хэрвээ заримууд Хэтрүүллийг (танжүр/*reductio ad absurdum argument*), учир шалтгааны нотлол (данцэг/*syllogistic reasoning*) гэж үзвээс, тэрээр шалгадгаар бүтсэн зөв мөн үү. Гэхдээ тийн эс бүтсэн мөн. Энэ талаар эхнийхээр болно (бүтсэн) гэвэл тэр цагт хоёулаа бүтэх учраас бусдын ам авсан (тангараг) гэж юунд өгүүлэх. Удаахаар гэвэл бусдын ам авсан болж таарахгүй учраас бусдын ам авсан гэж хэрхэн өгүүлэх вэ?

Түүний хариуд: Шалгадгаар бүтсэн алин болвоос л хоёулаа бүтсэн мөн болой" хэмээн тэр ямагт үл мэдэх үед ийнхүү эсэргэлдэгч бээр бүтээгч нотлол өгүүлэх цагт тэрхүү нотлол нь шалгадгаар бүтсэн (нотлогдсон) байх боловч бусад шалгадгаар бүтээж, түүгээр мэдэж болно. Бусдын сэтгэлийн ялгамжаа нь илт болон жишиж мэдэх сэтгэлийн орон бус болой. Өөрийгөө ч гэсэн шалгадгаар бүтээж мэднэ. Эндүүргийн шалтгаанаас удаан хугацааны туршид барьсан учир хуурмаг болжээ. Тиймээс цаад наад эсэргэлдэгч нарын шалгадаг гэж үзсэний хүчээр бодит юмсын мөн чанарыг хүлээн зөвшөөрдөг болно. Тиймээс бусдууд хэрхэн ам авахын эрхээр бусдын зүгийг сөхөөнө" гэжээ.

Цаад сөргөлдөгчийн учир (нотлох) шалгадгаар бүтсэн, эс бүтсэн эсэхийг наад эсэргэлдэгч үл мэднэ. Учир түүний санаа бодол нь наад эсэргэлдэгчийн хоёр шалгадгаар бүтсэн эсэхийг мэдэхгүй, өөрийн шалгадгаар бүтсэн гэж лавтай боддог ч тэр нь хуурмаг байдаг аж. Тиймээс хоёул шалгадгаар бүтсэн учир байхгүй тул ам авах төдийд тулдаг. Тиймээс шалгадгаар нотлогдоогүй ч гэсэн ам авахын үүднээс сөхөөх нь няцаах явдалд тулгарна. Цаашид мөн "*Түүнээс*":

Өөрийн үндэстний нотлолын дагуу, хэрвээ нотлол, бүтээгдэхүүн зэрэгт шалгадгаар бүр албатай гэж бүтсэн бол тэр цагт өөрөө үндэст бүтээгч нотлогч болно. Гэхдээ албагүй. Ийнхүү албатай, ёстойг бүтээгч шалгадаг нь илт, эсвээс жишиг онох ухаан байдаг. Тэдгээрийн хувьд ганц нэг илт мэдэрхүйгээр ч тийн албатай бүтээхгүй. Галын гэрт харагдах, харагдахгүй зүйлүүдээр гал, утаа хоёрын энэ нь байвал энэ нь байна, энэ нь байхгүй бол энэ нь байхгүй"

хэмээн "байхгүй бол үл гарах" гэснээр онож болно. Хамаг юмсыг байгаагаар бус. Жиших мэдэл ухаанаар ч бус. Тэнд чинь орон вишайг магадалж мэдэх нь ч бий. Энд даган жишигдэх орон бүгдээрээ биш л дээ. Ямар зүйл дээр зөвхөн бүтээгдэхүүн (нотлогдохуун) нь зөв байх учир шалтгаан зэргүүд байхад л мөнх бус тэргүүтнийг мэдэж болдог.

Хамаг орон, цаг хугацаанд биш л дээ. Тиймээс ертөнцийн ам авсан түүний үүднээс албатай болохыг бүтээж болно. Шалгадгаар бус учир Хэтрүүлэгчийн нотлолоор бусдын зүгийг сөхөөх нь зохисгүй болой хэмээжээ.

Утаа байгаа учраас гал байна гэх, үйлдсэн болвоос л мөнх бус байх албатай гэж шалгадгаар бүтнэ гэдэг өөрийн үндэстэнд төрөвч тийн эс бүтээх буюу. Шалгадгаар бүтсэн бол орон зай, цаг хугацаа, бүгдэд утаа байх нь болж, үйлдсэн учир мөнх бус байх албатай болж, албатай болохыг бүтээсэн илт болоод жиших ухаанаар галын гэр, хумхын дотор ч бүтэх тул заримдаг бүрэн бус болно. Чингэвэл албатай гэж ам авах төдийгөөр бүтээх хэрэгтэй болно.

Иймээс л "*Гурван ёсыг шалгадгаар бүтсэн учраар, үйлдэх учраар Өөрийн үндэст*" хэмээсэн ба "*Гурван ёсыг хамгийн эцсийн ам авах төдийгөөр үйлдэх учраар Хэтрүүлэгч*" гэж үзсэн нь харагдана.

/2/ Энэ бандидагийн шавь Дуун хөрвүүлэгч заримууд ч ийн өгүүлэв. "Бусдын баримтлалыг хорихоос өөр бусад өөрийн гэх тангараг, төв үзэлтэн нарт байдаггүй. Мөн "номт" (хэлцээний суурь) зэрэг хоёуланд нийтийн алдаршил нь эс бүтэх учир өөрийн үндэст ч таарахгүй. Ухаанаар шинжсэний үр нь ч бусдын тогтсон тааллыг орхиулах, няцаах төдийгөөс бус өөрийн үндэстний нотлол учрыг хэзээ ч хэлж чаддаггүй болой.

Тиймээс зөвхөн хэтрүүлэгч л мөн байна. Түүний дэвшүүлж байгаа хэтрүүлэл нь өөрийн үндэстийн туйл болсон нэгнийг сөхөөн няцаадаг гагц хэтрүүлгүүд" байна. Энэ нь учир болон албатай хоёуланг ам авдаг буюу ам авсан туйлын эцсийн хэтрүүлэгч тул үнэмлэхүй шалгадаг болно. Үүнээ шүтэж бусдын ам авах, цацарлага бүхнийг таслахдаа дөрвөн зүйлийн үүднээс үйлдэнэ. Үүнд харшлах учрыг өгүүлэх хэтрүүлэл нь гадны этгээд төрөх явдлын утгат, бас хязгаартай гэж үзнэ. "Өөрөөс төрнө" гэж үзвэл хэрвээ өөрөөс төрөх байгаад түүнээс төрөөд ирвэл төрөх гэдэг утгагүй болж, хязгааргүй болох учраас утгатай юм уу эсвэл хязгаартай гэх нь таарахгүй.

Чингэвээс өөрөөс төрнө гэж үзэж болохгүй, зохисгүй болно хэмээн харшлах учрыг өгүлэхэд гадны этгээд түүнийг ойлгож тогтсон тааллыг

орхих төдий үр гарна. "Бусдад алдаршсан жишин мэдэхүй нь өөрөөс төрнө гэж үзэх" нөгөө нь "өөрөөс төрөх нь үгүй гээд учир өөрийн мөн чанартай орших" хэмээн бусдад алдаршсан номт болон учир тэргүүтнийг өгүүлж гадны этгээдийг хорино.

"Өөрөөс төрөх байхгүй" гэж өгүүлэвч бусдын өөрөөс төрөх төдийг л хорьж байгаа хэрэг. Өөрөө, өөрөөсөө төрөх байхгүй гэдгийг нотлоогүй учраас тангараг (бүтээгдэхүүн) байхгүй. Бүтээгч, бүтээгдэхүүн хоёр нь адил учраас гадны этгээд өөрийн зүгийг бүтээхийн тухайд үлгэр, учир зэрэг алин байгуулсан бүхэн түрүүчийнхтэй адил болой. "Учир шалтгаан адил, толгой тэнцүү" гэдэг нь ингэж ам авбал, ингэж ам авна гэж учир шалтгааны ялгааг гаргахгүй байхыг хэлнэ.

Эсэргүүцэл : Гэвч танд гадна этгээдийн ам авсаныг (баталгаа) хорих хүсэл байна уу, үгүй юу байх аваас түүнийг тангараглах хэрэгтэй тул түүнийг бүтээхэд өөрийн үндэстний учир байх хэрэгтэй, байхгүй бол бусдын ам авсаныг хорих учир шалтгааныг өгүүлэх зохисгүй биз дээ?

Тэдний хариулт: Үнэмлэхүйг шинжихийн үест өвөрчлөн үгүй буюу төрөх үгүй хэмээхийг бүтээхийг хүсвээс өөрийн үндэстний тангараг болон учрыг хэлэх хэрэгтэй ч түүнийг үл хүсэх тул гэмгүй. Хүсэл байх төдийгөөр тангараг байх аваас бүгдэд нь тангараг хэрэгтэй болно гэж номнožээ. Үүгээр л өөрийн зүгийг бүтээхийн шалтгаан байхгүй ч бусдын зүгийг бүтээх төдий хүсэл төрөх, тангараг байхгүй бас өөрийн зүг байхгүй хэдий үнэмлэхүйг шинжилж байгаа үед өвөрчлөнг үгүйсгэх зэрэгт тангаргийг агуулалгүй үйлдэнэ. Алин ам авсан бүгдийг үгүйсгэхийг хүсэхгүйгээр үнэмлэхүйг шинжихийн үест өвөрчлөн үгүйг бүтээхээр ам аваад түүнийгээ өөрийн ёсноо бүтээж байгаа нь "Өөрийн үндэст" болох тэр мэтээр ам авалгүйгээр бусдын баримтлалыг хорих төдийг үйлдэхийг "хэтрүүлэгч" гэх нь үзэгдэнэ.

/3/ Эдүгээ Хэтрүүлэгч төв үзэлтэн гэж тооцогдогч нарын үнэмлэхүй болон янагуух алиныг ам авлаа гэсэн өөрийн ёсноо нэрийн төдийд ч байхгүй гэж үздэг. Харин тэр мэтийн тангараг байх аваас түүнийг бүтээн үйлдэгч үлгэр, учрыг ч авч үзэх хэрэгтэй болно. Тийм бол өөрийн үндэст болно. Тиймээс "Хэтрүүлэгчид" өөрийн ёс гэж ор байхгүй. *"Тэмцлийг няцаагч"-аас:*

Чингээд ч надад тангараглах зүйл хаана ч үгүй
Түүгээр надад буруу хэрэг (байвал)
Надад тангараг байхгүй учир
Надад ганц гэм ч байхгүй мөн

Чингээд ч илт мэдэх тэргүүтнээр
Зарим нэгийг утгаар зорих ба
Бүтээх буюу буцааж үйлдэх зэрэг
Тэр байхгүй тул тэмцэл байхгүй хэмээсэн ба,

"Ухааны жаран шүлэгт"-ээс:

Дээдсийн чанарт тэдгээртэн
Зүглэсэн ч үгүй, тэмцэл ч үгүй
Алин юунд ч зүг үгүй
Түүнд зүг гэж хаанаас байх хэмээсэн ба,

"Дөрвөн зуут"-аас:

Буй, буй бус, буй бус бус гэж
Хаанаа ч зүглэх байхгүй тул
Түүнээ өнө удаан хэдий боллоо ч
Тэмцлийн зай завсрыг өгүүлж үл чадах

хэмээн Төв үзэлтэн нарт зүг болон тангараг байхгүйг айлджээ.

"Тодорхой үгт"-ээс:

Төв үзэлтэн болвоос өөрийн үндэстний жишин мэдэх язгуурт биш болой. Учир нь бусад зүгийг ам авдаггүй болой" хэмээсэн ба "Хэтрүүлэгчийг буцаах утга болон гадны этгээдтэй холбогддог. Бид нар тийм биш. Өөртөө тангараг байхгүй хэмээжээ.

"Орохуй"-гаас ч:

Сөхөөн гаргаснаар сөхөгдөхүүнтэй үл учрах, сөхөөж няцаасан буюу
Хэрвээ учраад гаргав гэж өгүүлбэл, энд гэм гарч
Магадтай зүглэх болж түүнээс урвах "би"-гийн энэ зүг нь
Байхгүй болох тул энэхүү хэтрүүлэл үгүй бөлгөө

хэмээн өөрийн зүг гарахгүй учраас гэм болохгүй гэдгийг айлджээ. Тиймээс эдгээр утга агуулга бүгдээр буюу төв үзэлтэн нарын нигуурт зориулсан агуулга төдий.

"Орохуй"-гаас:

Хэрхэн Та, бусдын эрхтийг бодит гэж үздэг шиг
Янагуух боловч өөрөө үл ам авах
Үрийн тухайд эдгээр байхгүй ч байна гэж

Ертөнцийн нигуурыг барин "би"-г (байна) гэж өгүүлэх хэмээсэн ба,

"Тэмцлийг няцаагч"-аас:

Хоригдохуун ер байхгүй тул
Би юуг ч хориогүй ээ
Тиймээ, Та хориглов хэмээн
Та түүнд басамжлал тавих

хэмээн бусдын зүгийг хориглосон нь ч байхгүй гэж айлдсан гэдэг.

/4/ Урьд цагийн төв үзэлтэн Чандракирти багшийг даган баримтлагч түвдийн зарим нэг мэргэдүүд үзэхдээ: "Тийнхүү төв үзэлтэн нарт өөрийн ёсны зүг болон тэдгээрийг бүтээгч шалгадаг байхгүй гэдэг ёсыг сайтар сөхөөгөөд өөрийн ёсноо ухаанаар тийн шинжлэх ба өөрийн бэлэг чанараар үлэгдэхүүн болох, үлэгч шалгадаг ухаан хоёрын агуулгыг зөвшөөрөх бодит хүчээр оршигч илт болон даган жишигч шалгадаг хоёуланг хорьж, нэр томьёог үл шинжлэх ертөнцөд алдаршсан шалгадаг болон мэдэгдэхүүнийг зөвшөөрнө. Төв үзэлтэн өөрөө гадаад эсэргэлдэгчид бүтээх (нотлох) үгийг байгуулах үүднээс зөв учир шалтгаанаар нотолж "үнэхээр байхгүй утгыг" нотлоно. Хэдий "өөрийн үндэст" болохгүй ч үл ажиглах ертөнцийн шалгадаг ухааны үүднээс баримтлана" хэмээн номножээ.

18

ӨӨРИЙН ҮНДЭСТ, ХЭТРҮҮЛЭГЧ ХОЁРЫН ЯЛГААГ БУРУУ ТАЙЛСНЫГ НЯЦААХ НЬ

б/ Тэдгээрийг хориглох
/1/ Анхдугаар ёсыг хориглох нь
/2/ Хоёрдугаар ёсыг хориглох нь
/3/ Гутгаар ёсыг хориглох нь
/4/ Дөтгөөр ёсыг хориглох нь

- - - o O o - - -

/1/ Анхдугаар ёсыг хориглох нь. Заянанд бандидагийн *"Орохуйн тайлбар номлол"*-ын ёсноо "учир шалтгаан албатай байхыг" (дагчав/*reason and pervasion*), шалгадагаар эс бүтэх учир шалгадагаар эс бүтсэн гэх шалтгаанаар нотлох нь зохисгүй ээ. Энэ адилын учир нь гадаад, дотоодын цаад наад хоёулаа шалгадагаар бүтсэн байх хэрэгтэй гэж үздэг ёсноо ч гадаад эсэргэлдэгчид бүтээсэн зүйлээ дотоод эсэргэлдэгч мэдэхгүй бол учир болж өгөхгүй учраас гадаад эсэргүүцэгчид заавал шалгадаг бүтсэн байх хэрэгтэй гэдэг нь эвдэрнэ. Гадаад бусдын сэтгэлийг эс мэдсэн тул бусдаар шалгадагаар бүтсэнийг ч мэдэхгүй гэж үзвэл бусад ч тэр утгаа ам авахаа мэдэхгүй болсноор гадны этгээдийн ам авсан ёсоор хорих зэрэг ч таарахгүй болой. Гадаад этгээд мөн ингэж үздэг" хэмээх үгээ илтээр мэдэвч хэрхэн өгүүлсэн дагуу тангарагаа мэдэхгүй хийгээд бусдын сэтгэлийг мэдэхгүйгээс болой.

"Албатай болох нь" шалгадгаар эс бүтсэн гэх учир шалтгаан нь ч таарахгүй байна. "Галын гэрийн дээр утаа гарч байвал гал байх албатай" гэж нотлоход мэдэх ёстой суурь нь "галын гэр" болно. Түүний дээр байгаа мэдэх ёстой зүйл "утаа байна" гэдгээр "гал байх ёстой гэдэг албатай төдий" хэрэг. Галын гэрийн дээрх утаагаар галын гэрийн гал байх албатай гэж үзэх баттай биш тул ганц цаг зүг чигээр албатай гэж үзэж яаж болох вэ. Чингэхгүй бол тэр мэтээр албатай гэж ухаарахын суурь нь галын гэр болохгүй тул энэхүү суурийн дээр магадлах хэрэгтэй суурийг үзүүлэх хэрэгтэй болно.Үлгэрлэвээс, "Дууны дээр магадлах бүтээгдэхүүн ном болох "мөнх бус" тэрээр дуу хумх хоёуланг даган орох хэрэгтэй. Дууны хувь гишүүн болох мөнх бусыг агуулахгүйтэй адил болно..

Энэхүү ухаанаар албатайг бүтээгч жишин мэдэхүйд шалгадаг байхгүй гэж үзэж болохгүйг мэдээрэй.Тийнхүү шалгадагаар бүтээгүй учраас наад цаад эсэргэлдэгч нарын ам авсан төдийхнөөр бүтнэ гэж өгүүлэх нь зохистой бус. Зөвхөн ам авсан төдийгөөр шалтгаалваас гадны этгээдийг буцааж чадахгүй. Түүний ам авсан утгыг шалгана гэдэг өвөр бусад хоёуланд байхгүй болой. Гэвч ам авсанд нь ялгаа гаргаж энэ мэтээр бол бүтнэ, энэ мэтээр бол бүтэхгүй хэмээн ялгах, ингэж ялгахдаа ам авсны шалтгаанаар ялгаваас бүтээгдэхүүн нотлогдохуунтай адил болно. Харин шалгадаг байх, байхгүйгээр ялгаваас шалгадаг байхгүй гэдэг баримтлал доройтно.

/2/ Хоёрдугаар ёсыг хориглох нь. Тэр ямагт чанарыг шинжлэх үесийн өвөрчлөн үгүй тангараг ам үл авах, "Өөрийн үндэстийн" тангарагийг үл агуулах утгыг баримтлагч тэрээр өвөрчлөн байх, байхгүйг учир шалтгааны ухаанаар тэрхүү тангарагийг үл бүтээх тул тэр тангарагийг ам авахгүй юм уу. Гэхдээ ч тэр ямагт чанарыг шинжлэх үе шүү дээ" хэмээн учрыг байгуулаад тангарагийг ам үл авна гэх баримтлагч мөн. Эхнийхээр бол, өвөрчлөнгөөр байхгүй гэж гол тангараглах тэр утгыг, учир шалтгааны ухаанаар эс бүтээвээс өвөрчлөнгөөр байна гэж тангараглах тэрхүү утгыг учир шалтгааны ухаанаар эвдэж чадахгүй ээ. Шалтгаан нь ижил байна шүү дээ гэсэн ч тэр ямагт тангараг шинжихийн үест өвөрчилж байна гэдэг тэр утга эвдрэхгүй гэж үзвэл огт таарахгүй л дээ. Дээр элдэв ухаанаар шинжлээд бусдын ёсыг хориглов гэж өгүүлсэн тул. Үл шинжлэх сэтгэлээр бусдын ёсыг хорьж чадахгүй тул. Мөн өөрийн ёсны тангарагийг баримтлахгүй гэж тусгайлахын хэрэг юун. Бусдын ёсыг хорьсон хэтрүүлэгийг ч үл баримтлах учраас болой.

Бусдын тогтсон тааллыг сөхөөж няцаах хэтрүүлэл үйлдэнэ гэдэг өвөрчлөн байна гэх үүнийг гагцхүү хорьж өвөрчлөн үгүй чанарыг л бүтээж буй хэрэг мөнийг дээр *"Тэмцлийг няцаагчийн тайлбар"*-т зарилгалсан тул түүнээ гуравдагч гарц байхгүй ээ. Чингэхгүй бол өвөрчлөн үгүйг бүтээсэн мөн болохоос өвөрчлөн байгааг хорьсон бусаа гэж буцааж өгүүлбэл ямар хариу байна вэ. Өвөрчлөн үгүйг огоот тасалваас (мэдвээс) ямарч эргэлзээгүй өвөрчлөн тийн таалагдах хэрэгтэй хэмээвэл, чингэж өвөрчлөн байгаа нь тийн таалагдваас, эргэлзээгүйгээр өвөрчлөн үгүй нь огоот таалагдах хэрэгтэй нь адил болно. Хэрвээ тэр ямагтын шинжлэх үе учраас л өвөрчлөн үгүй гэх зэргийн тангараг байх ёсгүй гэвэл түүнийхээ учрыг өгүүлэхтүн.

Гэхдээ тэр ямагтын шинжлэхийн үест бүтсэн бол үнэхээр бүтэх хэрэгтэй учир ам авч болохгүй хэмээвээс тэр нь таарахгүй ч биш ээ. Ийнхүү тэр ямагт чанарыг шинжлэх үе байсан ч үл баримтлаваас, Төв үзлийн ухаанаар

тийн шинжлэх цаг биш гэж үзэх хэрэгтэй. Иймд тийм үес байлаа гэхэд шинжигч, шинжих язгуур, шинжих суурь, хаана ч хамт шинжих эсэргэлдэгч зэргийг магадтай авч үзэх шаардлагатай тул тэр цагт бүтэх бүгдээр үнэхээр бүтэхээс өөрөөр яах билээ. Хэтрүүлэл төдий нь бусдын ам авсан болон ам авахын эцэс туйл мөнийн тул шалгадаг байхгүй ч хэтрүүлэл үйлдэх хэрэгтэй гэж өгүүлэвч сэтгэлийг цэнгүүлэгч бус тул дээр эхний ёсыг хориглосон шиг хорьж үйлдэх болой.

Мөн тэр ямагтыг шинжлэх үед ам авах байхгүй ч янагуух гэж ам авах нь байна хэмээн тийн агуулсан ч таарахгүй л дээ. Тэр ямагтыг шинжлэх үеийг үнэмлэхүй биш-янагуух болгох хэрэгтэй болохоор тэрээр харшлахад хүрнэ. Тэр ямагтын шинжихийн үест байхгүй байна гэдэг үнэмлэхүйд байхгүй байхын утга болох үнэмлэхүйгээр ам авах байна гэж үзэх ямар ч төв үзэлтэн байхгүй тул тэрээр хэтрүүлэгч ёсны ялгамжаат онцлог ном болж чадахгүй.

/3/ Гутгаар ёсыг хориглох нь. Төв үзэлтэнд нэрийн төдий ч ам авах зүйл байхгүй гэж өгүүлэх нь дээр номлосон ухааны хоригдохууныг сайн ойлгоогүйгээс өвөрчлөн хорих ухаанаар цаад талаа хориод, наад талаа хорихын цагт өөрийн ёсондоо ч тэр адилаар орно гэж үзээд, Өөрийн ёсоо тогтоохдоо алдаа гэмээ тэвчихээ юу ч мэдэхгүйгээр сансар, нирваны шүтэн барилдахуй бүхнийг Вишнү тэнгэр болоод буй, буй бустай адилтган оруулсан болно. Тиймээс төв үзэлд басамжлал талбисан машид адгийн зүйл болно. Тэдгээрийг хорьж дээр олонтаа номносон билээ.

Төв үзэлтэнд ам авах зүйл буй, үгүй эсэхийг шинжилвээс төв үзэл гэж юугаар нь юу гэж хэлдэгээр нь агуулав гэдгээс нь ам авах хэрэгтэй болно. Үнэхээр бүтсэн гэдэг тоосон төдий ч байхгүй хийгээд нэрийдсэн бүгд дээр илбэ адил шүтэн барилдсан утгыг онох хэрэгтэй учраас ам авч үйлдэх зүйл байгаа хэрэг. Түүнийг ч дээрх хоёрын няцаах зүг болсон үнэхээр байх болоод нэрийдэлд байхгүй гэж үзэх буруу өгүүллийг няцааж тодорхойлох хэрэгтэй. Тиймээс хорих, бүтээхийг ямагт шалгадаг байх ба өөрөөр ухаарч, бусдад чанх зөвөөр заах төв үзлийн хэл ярианд бодох, зорих ёстой. Тэдгээрийг тодорхойлоход эсэргэлдэгч нарын ном лугаа зохилдсон, тэмцлийг завсар чөлөө өчүүхэн ч гарахгүй тул энэ огоот ариуссан нэгэн болдог.

Тиймээс мэргэд бээр алдаа эндлээс ангижирсан, төв үзлийн ёсыг өөр мэдэхгүй ч гэсэн тэр байхгүй гэж басамжилж доорд үзэлгүй, шүтэн барилдаж гарахуйн ухааныг ам авсан тэр ямагтаар буруу үзлийн тор бүгдийг тасалж дотроо урлан сэтгэгч ухаантан нар төв үзлийн ёсыг ухааран байгуулаад элдэв харшлал бүгдээс хагацаж үйлдээрэй. Хүчирлэж ундууцаж бүү үйлдээрэй.

"Тодорхой үгт"-ээс:

Тэр мэт бид нарын зүг нь огоот сайн ариун агаад тийн агуулал бүгдээр үл харшлан сайтар арилсан мөн. Өөрийн зүг нь маш бүдүүн бараг алдаа гэм төгөлдөр, тэдгээртэй харшлах ихэд тэнэг тул гэм, эрдэм хэрхэн орших байгааг үл үзэх буюу. Та "өөрийн гэмээ" хэмээх зэргээр дээр татсан дагуу билээ"

Төв үзлийн ёс нь үнэмлэхүй номлол буулгасан шалгадаг ухаан болоод янагуух шалгадаг ухааны мөрөөр ирсэн агуулгууд нь гэм зүүхийн учиргүй тул машид арилсан бөгөөд сансар, нирваны агуулга бүгд багтах болно гэж магадалж ойлгоорой.

Чингэлгүй "Төв үзэлтэнд өөрийн ёс байхгүй" хэмээн өгүүлэгчнээ гэм бурууг хэлэхгүй бол үг хэлэгч алин тэд бүгдээр худал үгт болно" хэмээхэд ч өчүүхэн төдий сөхөөлөг болж чадахгүй. Учир шалтгаан бүгдээр адил байх хэрэгтэй. "Ам авсан зүйл байхгүй" гэж хэлэхэд "ам авсан байна" гэдгийг шинжлэх ажил гарахгүй тул элдэв харшлах байхгүй, тэгээд ч юу ч гэж ам аваагүй учир гэж ч хэлж чадахгүй л дээ. Тийн хэлсэн бүгд худал болно" хэмээн өгүүлэхэд ч "үг бүгд чинь худал буюу" хэмээн өгүүлэх тэр үг чинь үнэн үг болж шинжлэл хийхийн хэрэггүй болж өөрийн үг харшилж байгааг үзүүлж чадахгүйд хүрдэг. *"Орохуй"-гаас:*

Хэрэв "би" заримдаа бодитой бүтдэг бол
Сэтгэл мэт бодитой бүтэж өгүүлж болохгүй байж болохгүй

хэмээн "Наймабүва" (Vatsiputriyas) хэмээх тогтсон таалалтан бээр цогцостойгоо нэг буюу тусгаар алин ч гэж хэлж болохгүй "би" хэмээх эдэт зүйл байгаа гэж ам авдаг. Гэвч эдлэг зүйл болбол цогцостойгоо нэг байх, эсвээс тусгаар аль нэгээр хэлэх хэрэгтэй. Тэгэж хэлж болохгүй гэж сөхөөж болохгүй. Та нар тэр ямагт болон бусдаар хэлж болохгүй "би" байна гэж хэлэхдээ тэр ямагт юм уу, эсвээс бусад хоёрын аль нэгэн гэж хэлэх шаардлагатай хэмээн шинжлэл хийхгүй ээ гэсний хариуд ингэж хэлж болно. Нэгэнт "бодгалийг эдэт зүйл мөн" гэж хэлвээс цогцос болон тэр ямагт болоод бусдад байхгүй гэдэгтэй харшлах учраас тэдгээрийг хэлж болохгүй зүйл гэж таарахгүй. Тиймээс тийн шинжлэл орно гэнэ.

Гэхдээ юуг ч үл ам авах болвол, "ам авах зүйл байхгүй ээ хэмээн өгүүлж болохын хувьд бүгдээр адил буюу. /1/ "Түүнд эд таваар байхгүй ээ" гэж өгүүлэхэд "Эд байхгүй гэж байгаа тэр эдээ өгөхтүн" гэж хариулах ба, /2/ "Түүнд ам авах юм байхгүй" гэж өгүүлэхэд "Ам авах юмгүй гэх тэр чинь өөрөө ам авах болой" гэж хариулах хоёр адилхан болой гэнэ. Гэвч тийн

өгүүлэх нь бидний дээр өгүүлснийг ухаараагүйн шинж байна.

Ингэж бид нар "ам авсан нь байхгүй" тэр ямагтыг "ам авсан болой" гэж бүү өгүүлэгтүн. Тэгвэл юу гэж хэлэх вэ? "ам авсан нь байхгүй" хэмээн өгүүлэх түүнийг "ам авах зүйл байхгүй" гэж ам авах хэрэгтэй" хэмээн заасан тул өөрийн үгийг засаж залруулж чадахгүй, таны өгүүлэх тэр зүйлүүд нь төв үзлийн ёс биш болохоор Хутагт эцэг, хөвгүүдийн эшийг татаад ч харшлах бөгөөд Чандракирти багшийн ёсоор ч агуулж болохгүй, бусад бурхадын ёсонд үл таарах тул энэхүү номоос гадуур нэгэн ажээ. Төв үзэлтэн болоод түүний дотроос ч Чандракирти багшийн ёсоор өгүүлнэ гэвэл тэдгээрт өөрийн ёс байхгүй ээ гэдэг чинь харшлах билээ. Цаашилбал ам авснаар гэтэлнэ гэж горилоод агуулга, томъёо бүгдийг зөвхөн бусдын нигуурт агуулна гэж өгүүлбэл зохисгүй.

Шүүмжлэх нь: "Дүрс тэргүүтнийг бусдын нигуурын төдийд л амлах хэрэгтэй" хэмээдэг чинь дүрс тэргүүтний оршин байгааг ам авахгүй ч, бусдын нигуурт агуулж сайтар авах хэрэгтэй гэвэл ам авахаас цааш хэтрэхгүй зүйл биз дээ. Тэр цагт хэний ч нигуурт агуулсан бусад болон агуулагч эзэн зэргийг ч ам авах хэрэгтэй болох тул "бусдын нигуур төдий гэж ам авах болно" хэмээн өгүүлэх нь өөрийн ёсыг үгүйсгэхэд үл туслахаар барахгүй харин ч хорлол болдог. Хэрвээ өөрийн ёс байхгүй болоод бусдын нигуур төдийд ам авна аа" хэмээж та нар тийн бүү өгүүлэгтүн.

Хариулт: Бид нарын нигуурт үзэгдэнэ ээ хэмээвэл, ертөнц тасархай үзэлт Жанпэнба (lokayattas) нар ч хүчирхэж үл чадах илт мэдлийг хүчирхэж нь та нар өөрсдөө ч хэлж чадахгүй хирнээ бидний сонсох тэргүүтнийг та нар мэднэ гэдэг гайхалтай яа.

Эсэргүүцэл: Тиймээс "ам авах байхгүй" зэргийн хэтрүүлэл зэргээ сайтар магадлах хэрэгтэй буюу. Юу ч гэж хэлж болох, бас эцэстээ түүнийг сайтар мэлзэж болох тул гэмгүй байх учиртай биш үү?

Хариулт: Хэдий хэтрүүлэл мөн болов ч бусдын нигуур төдийд л агуулна, өөрийн ёс гэж байхгүй ээ" хэмээн өгүүлээд өөрийн үндэстний ёсыг хориод, хэтрүүлэгчийн гол номыг байгуулсан Чандракиртийн ёсноо сүсэглээд яах билээ?

"Өөрийн үндэстийн" өөрийн ёс байхгүйтэй адилаар хэтрүүлэгч нар ч бусдын нигуурт агуулагдаж болох адил. Өөрийн үндэст хэрэгтэйн эрхээр бусдын нигуурт ч үйлдэж болох нээ. Сэтгэлийн төдийт нар бусдын нигуурт баримталж, өөрийн ёсноо авч үзэхгүй бол сэтгэлийн төдийтөн болохгүйтэй адилаар, төв үзлийн утгыг хэтрүүллээр нотлон буулгах нь Хэтрүүлэгч

өөрийн ёсноо үгүйсгэгдэхэд хүрнэ. Бусдын нигуурт агуулах болсноор тэрхүү Хэтрүүлэгч ёс болон Өөрийн үндэст ч үгүйсгэгдэх тул та нар төв үзэлтэн бус хэмээн тодорхой үзүүлжээ.

Тэдгээр байхгүй ч үр нь байх тул буй болой
Ертөнцийн нигуурт үйлдэж "би"-г өгүүлэх"

хэмээсний утга нь юм болгоныг бусдын нигуурт хамааралтай гэж үзэж болохгүйг өгүүлжээ. Мөн бодас юмст өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн чанар байхгүй ээ гэдгийг өвөрчлөн чанар байна уу, үгүй юу гэдгийг шинжих ухааны үүднээс тогтоохоос биш, жирийн ертөнцийн ухаанаар тогтоох бус аа.

Дээрх "*Ном*"-оос ч: "Буй болой" хэмээгээд "ертөнцийн нигуурт үйлдэх" гэж айлдсан нь дүрс тэргүүтнийг ертөнцийнхэн юу гэж үздэг түүн шиг үзнэ хэмээсэн болой. "Янагуухийг бүү ам ав" хэмээсэн нь "Сэтгэлийн төдийтөн" нараас "бусдын эрхэт"-ийг авч үздэг шигээр "бүү ав" хэмээсэн утга болохоос, өөрийн ёсноо янагуух тэдгээрийг "бүү авч үз" гэсэн үг бишээ. "Хэрхэн та бээр бусдын эрхэтийг бодит гэж үздэгтэй адилаар"хэмээн айлдсан шүү дээ.

Тэрхүү номын завсар үест ч: "Та нар зохих ёсны ухаанаар "бусдын эрхэт"-ийг үгүйсгэвэл би ч гэсэн та нарын ухаанаар та нарт тэр янагуухийг чинь үгүйсгэнэ" хэмээх тэмцлийн хариу мөн учир "бусдын эрхэт" нь ухаанаар шинжихэд тэсч үлдэх бодит гэж таны үздэг мэт янагуухиуд тэр адил биш гэж бид үздэг учраас л ухаанаар хорьж чадах, чадахгүй нь адил болой гэсэн утга билээ.

"Ертөнцийн нигуурт үйлдэх" гэдэг нь өөрийн ёсны бус бусдын нигуурт гэсэн үг бус аа. Элдэв хорлолгүй янагуух сэтгэл ухааныг зааж буй хэрэг. Учир нь янагуухийн утгууд бүгдээр байна гэдэг нь түүний нигуурт агуулагдах хэрэгтэй болохоор тэр. Төв үзэлтэн түүний үндсэнд ч янагуухийг мэдсэн шалгадаг ухаанууд байгаа учраас.

"Тиймээс байхгүй ч" гэснийг "өөрийн бэлэг чанараар байхгүй" гэдгээр үйлдээрэй."Өөрийн бэлэг чанар байхгүй ч, тэнд байна" гэдэг нь "байхгүй ч" "байна аа" гэсэн үг бишээ. Энд өөрийн янагуух утгуудыг илэрхийлж байгаа мөн. "Өөрийн бэлэг чанараар бүтэх" гэдэг нэрийн төдийд ч үгүй билээ. Тэр тухай "*Төв үзлийн тайлбар*"-аас түүнийг мэдүүлэхийн тулд,

Ертөнцөд буй болоод буй бус гэж үзэх түүнийг
Би ч гэсэн тэр дагуу авч үзнэ

хэмээсэн тул үгүйсгэж болохгүй ээ. Чингээд "үнэхээр байхгүй боловч нэрийдэлд буй " хэмээн олонтаа гарсны учир "байхгүй ч байх болой " хэмээх

утга тус тусдаа тухайлагдах учраас л ч ямар ч буруу юм алга аа.

Шүүмжлэх нь: Гэвч *"Тэмцлийг няцаагч"-аас:* "Зүгийн ном болоод тангараг байхгүй" гэж номносон утга алин байлаа ч номнох хэрэгтэй", "Зүлэг ногоо нь өөрийн мөн чанараар бүтсэн өөрчлөн байхгүй ээ" хэмээн ам аваад, шүтэж барилдсан мөний тул хэмээн учирлаж нотлох бий. Үлгэрлэвээс, хөрөг дүрстэй адил хэмээн үлгэрлэхэд ч "тиймээ" гэх хэрэгтэй болно. Тийнхүү "зүгийн ном" болон "албатай байх" хоёр ёсны нотлол, түүгээр бүтээгдэх "бүтээгдэхүүн", "түүнийг оногч жиших шалгадаг ухаан" болон "найруулга хэл яриан д" шүтэн байж гадаад эсэргэлдэгчдэд ухаан төрүүлэхийг хүсвээс, тэр цагт "Өөрийн үндэст"-ийн нэр болох "учир шалтгааны нотлолыг" (autnomous syllogism) уурлах төдийхнөөр барж болох тул "Өөрийн үндэст"-ийг хорьж зовохын хэрэг юун?

Хариулт: Түүний хувьд тангараг болон зүгийн номгүйгээр болно гэж номносон ч та нарын эш татсан шиг байж болох ч ам авахыг орхих хэрэгтэй гэж олонтаа айлдсан байгаа тул тэр төдий нэгийг татаад зүгийн номгүйгээр нотлоно гэж хаанаас байх вэ. Гэхдээ "өөрчлөн байхгүй" гэдэг нотлол байвал "Өөрийн үндэст" болно гэхэд сэжиг төрнө гэдэг чинь үнэн шүү. Энэ бол маш их нарийн бэрхтэй орон гэж тооцогддог. Түүний хариуг (өөрийн) ёсыг байгуулахын үест номнох болно. *"Тэмцлийг няцаагч"-аас:*

Тангараг байхгүй гэж айлдсан нь
Бодит юмсын өөрчлөн байхгүйг болой

хэмээн Төв үзэлтний өгүүлсэнд Бодит өгүүлэгч нараас тийнхүү тангараглах тэр үгэнд "өөрчлөн буй аваас бодит бүх зүйлд өөрчлөн байхгүй гэдэг нь таарахгүй, өөрчлөн буй бус аваас өөрчлөн буй гэдгийг хорьж чадахгүй" хэмээх зэргийн тэмцэл маргаанаас цацарч гарсан зүйл.

Өөрчлөн байхгүй ч гэсэн хорих бүтээхийн үйл үйлдвэр байж болно гэж дээр *"Тэмцлийг няцаагчийн тайлбар"*-аас эш татсантай адил болой. Тиймээс тангараг байна, байхгүй гэдэг нь ердийн байх, байхгүйн утга дээр маргаж байгаа бус. Хамаг бодит юмс дээр өөрчлөн байхгүй болой хэмээн тангараглах (андгайлах) үг дээр өөрчлөн байна уу, үгүй юу гэж тэмцэж байгаа билээ.

Тэр адилын тангарагийн үг түүнээ өөрчлөн байна гэж ам авах болвоос, бодит бүх юмсын өөрчлөн байхгүй гэх тангарагтай харшлах гэм бидэнд бий болох хэдий ч бид нар тийн үздэггүй болохоор бидэнд гэм байхгүй хэмээсний утга билээ. Тиймээс тангараг байхгүй бол бүтээж үйлдэхийн хэрэггүй бөгөөд "өөрчлөн байхгүй" гэх ба "огт байхгүй" гэх хоёрын хооронд

маш ялгаа байна шүү.

"Хэрвээ илт мэдрэхүй тэргүүтэн" хэмээх зэргээр илт мэдрэхүй тэргүүтнийг хэзээ ч зорьж тухайлж болохгүй мэт номносон байдаг ч дээр *"Тодорхой үгт"*-ээс эш татсан мэт шалгадаг ухаан болон мэдэгдэхүүний хувьд өөрийн мөн чанараар бүтсэн зоригдохуун орон болоод зорин үйлдэгч ухаан хоёр байхгүй болохыг заасан болохоос "шүтэн барилдаж гарсан шалгадаг ухаан болон мэдэгдэхүүн байхгүй" гэж заагаагүй болно. Бидний санаанд бодит юмсын бэлэг чанар нь илт мэдрэхүйгээр бүтсэн (мэдрэгдэх) учраас хорих зохистой гэж үздэг ч Төв үзэлтэн нар "бодит бүгдээр өөрчлөнгөөр хоосон болой" хэмээн өгүүлээд хэдий илт мэдэл болон тэрээр орон юмсыг мэдэх хэдий ч, тэд бодас юмсын дотор хурах тул өөрчлөнгөөр хоосон байна. Чингэж тэд үгүйсгэгдэх учир үл хоригдох хэмээн санах буюу. Тэр тухай *" Тэмцлийг няцаагч"-аас :*

Түр нэг бодас юмсыг илт мэдрэхүйгээр
Болгоож буцааж үйлдэх болвоос
Алив бодит юмсыг тухайлж зорьсон
Илт мэдрэхүй тэрээр үйлдэгдэх больюу

хэмээсэн түүний хариу билээ. Түүний *"Тайлбар"-т ч:*

Хэрэв та, бодит бүхнийг илт мэдрэхүйгээр тухайлж болгоогоод бодит бүхэн хоосон болой хэмээснийг буцааж үйлдэнэ гэвэл тэр ч таарахгүй. Яагаад гэвэл бодит бүхний дотор нь илт мэдрэхүй шалгадаг нь багтах учраас хоосон болно. Бодит юмсыг бодсон, тухайлсан алин болгон тийн хоосон болой. Тиймээс шалгадгаар тухайлан зорих гэдэг үгүй болой. Үл зоригдох, тухайлагдах учраас хорих нь зохисгүй тул бодит бүгдээр хоосон болой" хэмээн өгүүлсэн тэр бүхэн заавал таарахгүй болой хэмээн айлджээ.

"Дөрвөн зуут"-аас ч: "Буй ба буй бус, буй нь буй бус хэмээх" зэргээр айлдсаныг түүнийг *"Тайлбар"*-т авч үзэхдээ: "Хоосон чанартай гэж өгүүлэхдээ өнө удаан сөхөөж няцааж чадахгүй үзүүлжээ. Хоосон чанартай байлаа ч авч үзэхгүй гэж та өгүүлэх тул ямар ч үзэл байхгүй гэхийн гарвал яаж болох вэ?". *"Орохуйн тайлбар"-аас*:

Алин нэрийдсэн бүхнийг байна гэж өгүүлэгч нарт хоёр өгүүлэгч энэ нь зохисгүй учир хоёр зүйлд шүтэж сөхөөх болоод хариуг өгүүлэгч Төв үзэлтэн нарт хэзээ ч бүгдэд чөлөө завсар олдохгүй билээ".

Ийн хэмээн Арьяадэва гэгээн бээр: "Буй хийгээд буй бус" хэмээх тэргүүтэн дөрвөн мөртийг эшлэжээ.

Тэр мэт өөрийн мөн чанараар бүтсэн эдэт зүйлийг эвдлэх нэрийдэл байна гэж үзэгч бүхэнд бодит өгүүлэгч нар буюу өөрийн мөн чанараар бүтсэн гэгчид ба бодит байхгүй хэмээн өгүүлэгч буюу дүрс тэргүүтний бодит юмсын тусыг үйлдэгч бүхнийг үгүй гэж үзэгч хоёр бээр сөхөөж үйлдээгүй ч мэдүүлэхээр эш татсан тул өөрийн ёсыг байхгүй хээхийн гарвал болохгүй ээ. Буй, бусын зүгийг ч хоёрт өгүүлэхийн зүг болохыг маш тодорхойлсон тул дээр дөрвөн талаас хориглох болон буй, буй бус гэж өгүүлэхийг арилгахын үест номносонтой адил болой. *"Ухааны жаран шулэгт"*-ээс айлдахдаа энэхүү эшийг тайлбарлаж:

Алин цагт тийнхүү бодит үгүй учраас өвөр болоод бусдын тал байхгүй буюу.
Тэрээр тэр мэтээр бодит үзэгч нарын нисваанисыг магадтай хорих болой

хэмээн зүгийн ном байхгүй шалтгаан болгож "бодит байхгүй" гэж айлджээ. Өөрийн бэлэг чанар буюу өвөрчлөн чанарыг бодит гэж үздэг. Тус үйлдэх гэчихээд түүнийгээ үгүйсгэж үзвэл нисваанисыг хорино гэсэн айлдвартай харшлах болно. Тиймээс өвөрчлөнтэй бодит юмсыг ам авах нь зүг байхгүй гэдэг дээр л зүг байхгүй гэж айлдсан болно.

Дээрхи эшийн эхэнд, *"Ухааны жаран шулэгтийн тайлбар"-аас:* "Алин шүтэн барилдаж гарсан номын чанар үүний язгуурыг ухааралгүй бодит юмсын өөрийн бэлэг чанарыг огоот мэдлээ гэж үзэгч нарт л бодит гэж ам авах нь магадтай байдаг тул

Хүсэл шунал уур хилэнгээс ургах
Үзлээр барахгүй,буруугаар баригч
Түүнээс л үүдэж тэмцэл болох

хэмээн бодит юмсын өөрийн бэлэг чанар байна гэж гүтгэгч нар л бодит гэж ам авдаг болохыг айлджээ.

Тиймээс эдгээр эшүүд нь Төв үзэлтнийг өөрийн ёс байхгүй гэж заагаагүй билээ. Тиймээс *"Тэмцлийг няцаагч"* болон *"Дөрвөн зуут"*-ыг татаад бусад зүгийг ам авна гэж байхгүй билээ" хэмээн *"Тодорхой үгт"*-ээс айлдсаны утгыг тэр адилаар мэдээрэй.

Хоригдохуун огт байхгүй тул
Би юуг ч хориогүй ээ

хэмээн айлдсан хоригдохуунд хоёр зүйл буйгаас өвөрчлөнг байна гэж гүтгэх бодлын оронг хориход, түүнийг байхгүй гэдгийг учир шалтгаанд авчихаад хориогүй гэж айлддаг чинь зохисгүй гэж айлддаг нь зохисгүй тул оронтын

хоригдохууныг хөөргөх бодлоор үйлдэх буюу.

Түүнийг *“Тайлбар”*-т хориглохын дээр “буй бус болно” гэж айлдсан тул “тэр хоёр байхгүй” нь өөрийн бэлэг чанараар бүтэхийн хоригдохуун гээд хааж үйлдээгүй ч, тэр адилаар буй гэж барин үгээр үүнийг хорив хэмээн та бээр басамжлал талбив хэмээн айлдсан буй. Тэр хоёрыг илбэ мэт гэж таалаагүй ч биш л дээ. *“Тэмцлийг няцаагч”-аас:*

Хувилгаан бээр хувилгаснаа,
Илбэ үзүүлэгч төрөлхтөн бээр
Илбээр илбээ хорихтой адил
Энэхүү хоригдохуун түүнтэй адил

Хэрвээ өөрчлөн байна гэж баривал
Шүтэн барилдаж гарахгүй болно
Барьсан алин шүтэж гарсан
Тэр ямагт хоосон чанарт бус уу

Хэрэв бариваас өөрчлөн буй гэх
Тийнхүү бариваас хэн буцаах
Үлдсэн бүхэнд ч энэ ёсоор мөн
Тиймээс гэм хайх чөлөө түүнд байхгүй

хэмээн зэрэглээг ус гэж үзэхэд өөрчлөн байна гэвэл өөрийн шалтгаан нөхцөлд шүтэж төрөх нь үгүй болно. Тийн бариваас хэн ч буцааж чадахгүйд хүрэхийг айлджээ.

”Тодорхой үгт”-ээс: “Өөртөө тангараг байхгүй” учраас хэмээн айлдсан нь өөрийн ёс байхгүй гэсэн үндэслэл биш. Тэр өөрийн үндсэнд тангараг байхгүй” гэсэн утга мөн. *“Орохуй”-гаас:* ”Зүг байхгүй” гэж айлдсан нь өөрийн ёсноо сөхөөгдөхүүн болон сөхөөгч хоёуланг өөрчлөнгөөр бүтсэн гэж үзсэнээр үндэс, үр дагавар өөрчлөнгөөр бүтсэн гэж үзэхэд учрах буюу, эс учирваас үндэс шалтгааны үр дагавраа гаргаж үйлдэнэ гэх ухаанаар шинжиж үйлдэхийг үгүйсгэх сөхөөлгө та нарт байхгүй ухаанаар шинжихэд тэсч үлдэнэ гэж үзэх хэрэггүй хэмээсэн утгууд билээ. Ерөөс өөрийн ёс байхгүй гэсэн бус. “*Түүний тайлбар”-т*:

Бидний зүгтэй ч адил биш л дээ. Юу боловч бидний зүгийг сөхөөснөөр хөөгдөхүүнтэй тулж учирах биз. Гэвч сөхөөж болохгүй зүйлийг сөхөөж няцааснаар сөхөөгдөхүүнтэйгээ учрахгүйгээр сөхөөж үйлдэж болохгүй. Сөхөөгч,

сөхөөгдөхүүн хоёулаа өвөрчлөнгөөр бүтээгүй шүү дээ. Тиймээс ч учрах, эс учрахыг санаагүй байна

хэмээн бодит өгүүлэгчийн гаргаж тавьсан ухааны шинжлэл үл зохих учир шалтгаан болгож өвөрчлөнгөөр эс бүтэхийг тавьжээ.

Ам аваагүй гэж хэлээгүй учраас түүнийг ухуулж "*Эх судар*"-аас эшлэн: "Шаарийн хөвүүн бээр Равжораас, төрөх болон эс төрөхийн алин номоос эс төрөхийг олсон уу, олдох уу гэж шинжлэн асуухад, тэр хоёуланг олохыг үгүйсгэв. Шаарийн хөвүүн бээр чингэвэл олох ба онох гэж байхгүй юу? хэмээн асуухад, "Дээр эш татсан мэт тэр хоёрын байх, байхгүй хоёр ёсоор бус аа. Тэр ч янагуухид тийн боловч үнэмлэхүйгээр үгүй болой" хэмээн айлдсаныг үлгэрт авч тэр адилаар ам авах хэрэгтэй гэж айлджээ. *"Орохуйн тайлбар"-аас:*

Үгээр үзвэл тийнхүү хоёр хэтийдэл гарах учраас төрөх буюу эс төрөх номоор олсон ба олохыг хорьсон. Хоёулаа бодит үгүй учраас таарахгүй билээ. Үл шинжлэн ертөнцийн нэр томъёонд олно гэж ам авч болдоггой адилаар сөхөөгдөхүүн болоод сөхөөгчүүд нь учирсан, эсвээс учраагүй ч байж болно. Гэхдээ нэрийдэл утгаар ч сөхөөгч, сөхөөгдөхүүнээ сөхөөлөө гэж болдогийг мэдээрэй" хэмээн учрах, эс учрах ухааны шинжлэлийг хийгээд тэр хоёрын алин ч сөхөөгдөх нь байхгүй ч тэрээр сөхөөгдөж болно гэдгийг эвдлэхгүйгээр, янагуух утганд бусдын зүгийг сөхөөж болно гэж ам авах хэрэгтэй" гэдгийг айлджээ.

Түүгээр зогсохгүй нотлолоор бүтээгдэхүүнийг бүтээж болохыг ч болгоосон буй. Саяхан эш татсан номонд:

Хэдий та бээр нарны хот мандалд байгаа ялгаануудын
Дүрс хөрөг дээр будгаар буулгасны цагт үзээд
Нэр болоод түүний зураг хоёрын намба таарах, таарахгүйг
Хэлэх зохисгүй боловч харин түүнд шүтэж нэрийдэл төдий нэгэн гарсан буюу

Худлаа байсан ч өөрийн нүүрээ үзэсгэлэнтэй болгохын тул
Түүнийг буй хэмээн хэрхэн ёсчлон энд ч билгийн хацрыг
Ариусгаж гоёх чадал нь үзэгдэх нотлол нь
Заавал зохистой бус ч гэсэн бүтээгдэхүүнээ онодог гэдгийг мэдээрэй.

Хэрхэн дүрс хөрөг хэмээх нь өчүүхэн төдий нэг буй бус боловч нарны хот мандалтай таарах, таарахгүй бол төрнө гэх атгаг хэзээ ч байхгүй байх болно. Гэхдээ шалтаг болсон дүрс ойртож дөтөлснөөр дүрс хөрөг болгох бодол төрж, мэдэх гэж хүсч байсан утгаа мэдэж авдагтай адил өвөрчлөнгөөр хоосон чанарын сөхөөлгөөр, сөхөөгдөхүүнийг сөхөөж няцаах ба өвөрчлөнгөөр хоосон бөгөөд таарч тохирохоос хагацсан нотлолоор бүтээгдэхүүнээ бүтээх мөн.

Хоёр болж хэтийдэж үл болох тул өөрийнхөө үгийг ч хэтийдэлтэй адилтгах нь зохисгүй гэдгийг мэдээрэй хэмээжээ.

Чингэж өөрийгөө цаашид хорих ухааны толгойг цогнойлгож үл оруулах хариултыг ийнхүү айлдаад "өөрийн ёс байхгүй ээ" гэж айлдаагүй болой. Мөн үндэс шалтгаан, үр дагавар өвөрчлөнгөөр бүтсэн гэж үзэхдээ шалтгаанаар учрах, эс учрах болсноор үр дагавраа гаргадаг гэж шинжээд хорихын гэмийг өөртөө авдаггүй. Гэвч өвөрчлөн байхгүй гэдгээр шалтаглан тэвчиж буй хэрэг. *"Орохуйн тайлбар"-аас:*

Та хэрхэн хуран үйлдэхүйг үзэх вэ? Алив тэдгээр хоёулаа илбэтэй адил учраас л. Надад гэм болохгүй ертөнцийн бодит юмс ч байна. Алин өөрийн бэлэг чанар эгүүсгэгдэхүүн, эгүүсгэгч тэдгээрийг шинжилж л болно. Ямар ч байлаа бодит зүйлсийг буруугаар хотол нэрийдэн эгүүсгэгч тэр бээр илбэ мэт үл төрөхийн мөн чанарт болон өвөрчлөн байхгүй ч хөлхөлгөөний эрхээр үс үзэгдэх зэргээр тийн атгалах орон болдог зэргийг ер санадаггүй билээ. Тиймээс надад тэр хэлж байгаа гэм буруугийн үес байхгүй бөгөөд ажиглал шинжлэлгүй бүтсэн ертөнцийн бодит юмсууд орших тул бүгд байх болно.

хэмээн бусдад гэм орох шалтгаан болгож өөрийн бэлэг чанарыг ам аван байгуулсан бөгөөд өөрт тэдгээр гэмүүд байхгүйн шалтгаанд илбэ зэргийг авсан гэж айлдсан тул тэдгээрийг мэдэж Төв үзлийн ёс бол гэмээс ангижирсан гэдгийг мэдэж авагтун.

Ер нь магад утгат эрхэм зарлиг болон Төв үзлийн шастаруудаас "энэ нь энэ мэт мөн", "энэ нь энэ мэт бус болой", "энэ хийгээд энэ үгүй болой", "энэ хийгээд энэ буй болой" хэмээн хэмжээлшгүй нэгнийг айлдсан байдаг. Тиймээс тухайн туурвигч нарын тухайн тааллууд байх учир тусгайд нь эш татаж батлахын хэрэг юун. Харин тиймгүй ингэж үзэж тангарагласан гэж айлдаагүй тэдгээр гол номуудыг тэр үест номнохдоо энэ бол туурвигч түүний ёс гэх буюу түүний болгоол болой, энэ нь тэр мэт бус гэх зэргээр нарийн ялгаж чадахгүйд хүрдэг. Гэсэн ч "хүсэх (авч үздэг) "ам авдаг, тангарагладаг" гэх зэргийн үгийн ялгааг гаргах шаардлагатайг олонтаа айлджээ. *"Тэмцлийг няцаагч"-аас:*

Нэрийдэх гэж амыг авалгүйгээр
Бид нар номнож үл үйлдэх хэмээсэн ба,

"Ухааны жаран шүлэгт"-ээс ч:

Бодит гарсан нэгэн эвдрэхэд

Хэдий үгүй боллоо гэж нэрийдэх шиг
Дээдэс тэрчлэн
Илбэд үйлдсэнийг үзээд үгүй хэмээн таалах

Алин шүтэж гарсан бодитууд
Усан доторхи саран мэт
Үнэхээр бус ч, буруу бус гэж
Үзэх тэд нар үзлээр үл булаагдах хэмээсэн ба,

"Ертөнцөөс нөгчсөн нирвааны магтаал"-аас ч:

Аливаа шалтгаанаас үүссэн бүгдээр
Огт үгүй бус, бас буй бус тул
Дүрс хөрөгтэй ижил гэдэг нь
Тодорхой атал юу үл хүсэх хэмээсэн

Амсагдахуун тэр үгүй тул
Амсаж мэдрэх "би"-нь үгүй болюу
Тэрхүү амсуурга өөрчлөнгөөр
Буй бус гэж та болгоожээ хэмээсэн ба,

Үйлдэгч болоод үйл түүнийг ч
Нэрийдэлт болохыг та үзүүлжээ
Инагш, чинагш хамаарах чанараар
Бүтсэн хэмээн та таалжээ

Түр нэг эвдрэх шалтгаанаас
Үр гарна гэдэг зохисгүй
Эс эвдрэх үйлээс бус
Төрөлхтөн зүүд мэт гэж та болгоожээ

Алив шүтэн барилдаж гарсан
Алин тэр ямагтын хоосон гэж таалав та хэмээн айлджээ.

"Орохуйн тайлбар"-аас ч:

Мэргэд ухаантны энэ зүг гэм буруугүй бөгөөд тус эрдэмт болой хэмээн санаж, эргэлзэж доноголзолгүй ам аваарай" хэмээгээд,

Түүнээс шүтэн барилдаж гарсан шалтгаан энэ төдийг ам авсан дагуу зүтгэж нэрийдэхийг ам авах тул бидний ёсноо нэрийдэл бүгдээр тасархайдахын хэтийдэл

болохгүй бөгөөд гадныхан ч гэсэн энэ ямагтыг ам авах нь зохистой" хэмээн лавтай яа ам авах хэрэгтэйг айлдсан бөгөөд энэ мэтийн зүйл олон байна.

Мөн *"Орохуйн тайлбар"-аас:* Дөрвөн тангараг даган өгүүлээд тэдгээрийн ухаанаар батлахын тулд номнов" тэр ямагт нь түүнээс төрөх бус, бусдаас төрөх гэж хаанаас, хоёулангаас бус, шалтгаангүйгээс хаанаас байх" хэмээн дөрвөн тангаргийг номнов. *"Тодорхой үгт"*-ээс ч тэр мэтээр номносон тул Нагаржуна багш болон Чандракирти багшийн ёсноо өөрийн хүсэл (үзэл), ам авах, тангараглах баримтлалууд бий.

/4/ Дөтгөөр ёсыг хорих нь. Ийнхүү нэрийдлийн өөрийн бэлэг чанар байж болох ч өөрийн бэлэг чанарыг ухаанаар ажихад тэсч үлддэг нэрийдлийг хорих нь сайн зүйл биш гэж дээр номносон билээ. Төв үзэлтэн болон гадаад эсэргэлдэгч, бодит өгүүлэгч хоёулангийн ёсноо орших бусдын тусад жиших шалгадгаар батлагдах "гурван ёст учир шалтгаан"-ыг Чандракирти багшийн ёс гэж үзвэл таарахгүй шүү. *"Тодорхой үгт"*-ээс тэр адилын зүйлүүд дээр тусгайлан ялгаж хориг тавьсан болой. Тэр адилаар түүнийг авч үзвэл, бодит хүчтэй орших учир шалтгааны нэрийдлийг найруулахгүй гэсэн, Өөрийн үндэстийн учир шалтгаан болох учраас буцааж болохгүйд хүрнэ. Эдгээр бүгдийг өнөөдөр ч номнож болох тул энд энэ төдий цөөн үг өгүүлэв.

19

ӨӨРИЙН ҮНДЭСТ (СВАТАТРИКА), ХЭТРҮҮЛЭГЧ (ПРАСАМТИКА) ХОЁРЫН ЯЛГААГ ТАЙЛБАРЛАХ НЬ

2/ Өөрийн ёсыг номнох нь
а/ Өөрийн үндэстийг бодитойгоор сөхөөх
/1/ Суурь номт эс бүтэх зүгийн гэмийг үзүүлэх
/а/ Бодол санааг өгүүлэх
/б/ Тэдгээрийг хорих
1' Утга нь үл таарах нь
2' Үлгэр авах нь адилгүй байгаа нь
/2/ Тэрхүү гэмээс нотлол ч эс бүтэхийг үзүүлэх

- - - o O o - - -

2/ Өөрийн ёсыг номнох нь

Хэтрүүлэгч нар өөрийн үндэстийн ёсыг сөхөөг гаргаад өөрийн ёсоо байгуулсан түүнийг хэлэхэд тэр хоёуланг нь ухаарч болох тул түүнийг өгүүлсүгэй. Энэ талаар *"Тодорхой үгт"*-ээс олонтаа айлдсан тул үг олон болох вий гэж эмээгээд энэ үест гол зүйлүүдийг номносу.

Түүнээ хоёр зүйл:
а/ Өөрийн үндэстийг бодитойгоор сөхөөх
б/ Тэд бидэнтэй адилгүйн ёсон

а/ Өөрийн үндэстийг бодитой сөхөөхөд хоёр:
/1/ Суурь номт эс бүтэх зүгийн гэмийг үзүүлэх
/2/ Тэр гэмээс нотлол ч эс бүтэхийг үзүүлэх

/1/ Суурь номт эс бүтэх зүгийн гэмийг үзүүлэхэд хоёр:
/а/ Бодол санааг өгүүлэх
/б/Тэдгээрийг хорих

/а/ Бодол санааг өгүүлэх

"Тодорхой үгт"-ийн айлдвар номууд дотроос энэ үесийн ном нь ухаарахад маш бэрхтэй үзэгдэх тул *"Тодорхой үгт"*-ийн үгийг эш татаж номносугай.

"Ийн өгүүлэв. Юутай ч "дууг мөнх бус аа" гэхэд "ном" болон "номт" хоёрыг ерөнхийгөөр барьсан мөн. Тусгай ялгааг нь бариагүй. Ялгааг нь барьсан бол жишин баригч болоод жишин баригдахуун хоёрын нэр томъёо байхгүй байх

хэрэгтэй. Хэрвээ ийнхүү "дууг дөрвөн махбодиос бүтсэн" гэж бариваас тэрээр гадна талд үл бүтнэ. "Огторгуйн эрдэм" гэж бариваас тэрээр бурхан өөрт нь үл бүтэх мөн. Мөн "өвөрмөц өгүүлэгч нар" дууг мөнх бус гэж үздэг ч, "үйлдсэн дуу" гэж бариваас тэрээр бусдад эс бүтнэ. Гэсэн ч "илт тодотгон үйлдэгч" гэвэл тэр нь өөрт эс бүтнэ.

Цаашлаад "эвдрэх буюу шалтгаан нөхцөлт" гэвэл тэрээр бурхан өөрт эс бүтнэ. Бүр "шалтгаангүй зүйл" гэвэл гадаад этгээдэд эс бүтнэ. Тийм учраас энд хэрхэн ном болоод номтыг ерөнхийлөн барьж байгаа түүгээр л, энд ч ялгааг орхисон номт нэгнийг барьсан болно шүү" хэмээжээ.

Түүний утга нь: "Бурхан бээр Өвөрмөц өгүүлэгч нарт "дуу бол мөнх бус шүү" хэмээн андгайлахад махбодиос гарсан дуу гэж номтод бариваас "Өвөрмөц өгүүлэгчид "үл бүтэх". Огторгуйн эрдмийн дуу хэмээн номтод бариваас өөрийн ёсноо эс бүтэх. Тэрчлэн Өвөрмөц өгүүлэгч бээр, тодруулан үйлдэгчийг дуу нь мөнх бус гэж андгайлаад, үйлдсэн дуун хэмээн номтод бариваас тодорхой үйлдэгч болохгүй. Урьд байсан нөхцлөөс тодорхой үйлдэгч дуун хэмээн номтод бариваас өөрт эс бүтнэ. Чингэхдээ өөр, өөрийн ёсны нийт бусын бодлыг номтод барьж болохгүй ээ. Номт гэдэг бол эсэргэлдэгч хоёр талаас тусгайлан шинжлэн үзэж байгаа зүйлийн суурь учраас хоёулангийн "зохилдох үзэгдэл" болж бүтсэн нэгэн байх хэрэгтэй.

Ингэж "номт" нь зохилдох үзэгдэл болох шаардлагатайн адилаар "ном" болох мөнх бус нь ч гэсэн тусгай ялгааг гаргаагүй ерөнхий нэгэн зүйл байх хоёулаа бүтсэн байх хэрэгтэй. Ямар ч жишээг татахдаа, зохилдох үзэгдэл нэгэн бүтээгдэхүүнийг бүтээхийн (нотлогдохууныг батлах) өмнө байх хэрэгтэй.

Тэр жишээний дагуу Төв үзэлтэн нар нүд тэргүүтнийг дотоодын төрөн түгэхүй буюу дүрс тэргүүтэн гадаадын төрөн түгэхүйнүүдийг "өөрөөсөө төрөх нь байхгүй" гэдгийг өөрийн аймгийн бодит өгүүлэгч нар бүтээхдээ "үнэн нүд тэргүүтэн " хэмээн номтод бариад өөрт үл бүтээх, "хуурмаг нүд тэргүүтэн "хэмээн номтод бариад гадаадынханд үл бүтээх тул энэ мэтийн ялгааг орхиж нүд, дүрс төдий нэгнийг номтод агуулваас төв үзэлт болон бодит өгүүлэгч хоёулаа "өөрөөсөө төрөх байхгүй" тэргүүтнийг тусгайлан шинжих суурь болж өгнө. Тиймээс хоёуланд "зохилдох үзэгдэл" болох шаардлагатай болно гэж санаарай. Зохилдох үзэгдэлд бүтэхийн утгын хувьд ч хэрхэн гадны эсэргэлдэгчдэд төрсөн шалгдаг ухаан нь төдий чинээгээр дотоод эсэргэлдэгчдэд ч тэр адилаар шалгадаг ухаан төрөх аж.

/б/ Тэдгээрийг хорихад хоёр:

1' Утга нь үл таарах нь

2' Үлгэр авах нь адилгүй байгаа нь

1' Утга үл таарах нь

"Тодорхой үгт"-ээс:

Тэр нь тийм бус аа. Энэ мэт алин хэзээд энэ үест төрөх хоригдохуун мөнийг бүтээх ёстой ном гэж үзэх тэр үест зөвхөн түүний шүтээн буюу чанх буруу номт төдийгөөр "миний бодит гэгчийг олвоос доройтох болно. Тиймээс өөрийнхөөр ам авах ямагт болой. Чанх буруу, чанх зөвүүд нь тус тусдаа байна. Тиймд хэзээд хөлхөлгөөгөөр үс хялгас эх үзэгдэх зэрэг чанх буруу бодлоор байхгүй зүйлийг байгаа гэж барих тэр цагийн байгаа гэх утгыг хувь төдий зорих гэж хаана байх. Хэзээд хөлхөлгөө бусаар үс хялгас гэж зөв бодлоор буюу үнэн бус зүйлийг үнэн гэж гүтгэхгүй тэр цагт хэн ч гэсэн янагуух болсон ч буй бус байгаа утгаас өчүүхэн төдийд ч зорих гэж хаанаас байх вэ. Тэр ямагтын учир Нагаржуна багшийн (*"Тэмцлийг няцаагч"-аас*) аман гэгээнээс,

Хэрэв илт мэдэл тэргүүн бээр
Зарим нэг утгыг зоривоос л
Бүтэх буюу буцааж үйлдэх
Тэр нь үгүй тул надад гэм хайх чөлөө байхгүй хэмээн айлджээ.

Алин хэзээд тэр мэтээр чанх буруу болон зөв хоёр тус тусдаа болох тэр цагт чанх зөв байх орон үест чанх буруу нь үгүй (буй бус) байх учраас номт болох янагуух нүд хаанаас байх вэ. Тиймээс сууринд эс бүтэх мэдэгдэхүүн бус зүйлийн гэм, сууринд эс бүтэх нотлолын гэм буцаагүй тул үүнийг хариулт гэхгүй хэмээжээ.

Үүнийг *"Дүрс төрөн түгэхүйг авья. Өөрөө өөрөөс төрөх үгүй л дээ, Тэрээр буй учраас. Үлгэрлэвээс өмнө тодрох хумхтай адил"* хэмээх учир шалтгааны гаргалгаан /syllogism/ дээр жишвээс ухахад хялбар учраас түүний үүднээс номносон болой.

Тэдгээр хариулт номоор номт нь зохилдох үзэгдэлд эс бүтэх ёсыг үзүүлжээ. Хэрхэн үзүүлсэн хэмээвээс энд аливаа гадны эсэргэлдэгчтэй зохилдох үзэгдлийг бүтээх номт эс бүтээхийн эс бүтээх ёсыг заагч гадны эсэргэлдэгчид нь *"Тодорхой үгт"*-ээс айлдсан энэ үест "өөрөөс төрөх"-ийг хорих эсэргэлдэгч мөн байж болох ч ер нь бодит юмст үнэмлэхүй мөн чанар байна гэж үзэгч "бодит өгүүлэгч" нар болоод нэрийдэлд тэдгээр бэлэг чанараас бүтсэн өвөрчлөн байна гэж үздэг "өөрийн үндэст" хоёулаа байна. "Өөрийн үндэст" төв үзэлтэн нарыг "мөн чанарыг үгүйсгэн өгүүлэгч" гэж

нэрлэдэг ч энэ үест үгийн чуулганыг судлахын тулд "өөрчлөн үгүйг өгүүлэгч" хэмээн Хэтрүүлэгчийн ёсноо ойлгож болно. "Өөрчлөн буй хэмээн өгүүлэгч" хэмээвэл "Бодит өгүүлэгч "болон "Өөрийн үндэст" хоёуланг гэж ойлгоорой.

Дүрс төрөн түгэхүйг номтод агуулсан түүнийг бүтээх ёс нь түүнийг баригч харах мэдрэхүй нь илт шалгадаг ухаан болсон байх хэрэгтэй. Мөн эндүүрэггүй гэж тэдгээрээр эс батлагдаваас утга бүтээсэн (оносон) илт мэдэл болохгүй учраас эндүүрэггүй байх ёстой. Атгаггүй, эндүүрэггүй байна гэдэг нь тэдгээрийн ёсонд эндүүрэггүй гэж байгаа алин газар түүнийгэ өөрийн бэлэг чанараар бүтжээ гэж үзэх бөгөөд үзсэн тэр дагуу байна аа гэж магадалж чадаж уу гэдгээс хамаарна. Тийм учраас гадны эсэргэлдэгчид хэрхэн номтыг бүтээсэн тэр адилын шалгадаг ухаан нь дотоодын эсэргэлдэгчид тэр адилаар байх хэрэггүй. Аливаа ном юмст өөрийн бэлэг чанараар бүтсэн мөн чанар нэрийн төдийд ч байхгүй тул түүнийг бүтээгч шалгадаг байхгүй билээ хэмээн энэ багш болгоож "өөрийн үндэст"-ийг хорьсон ажээ.

Чингээд бодит юмсын өөрчлөн байхгүй онох үзлийг шинээр төрүүлэх гишүүн болгож гадны этгээд нарт "Өөрийн үндэст"-ийг хорих шаардлагатай учрыг номножээ. Хэтрүүлэгч төв үзэлтнүүд өөр хоорондоо янагуухийн зарим утгыг онох жиших шалгадаг ухааныг төрүүлэхийн гишүүнд "Өөрийн үндэст" хэрэгтэй, хэрэггүй ажиглалтыг түр нэг үзүүлжээ. Түүнийг гол номтой найруулан номносу. "Алин цаг" хэмээхээс "ам авах ямагт болой " хэмээх утгын хувьд "бүтээгдэхүүн номын суурь номт болох дүрс тэргүүтэн хэмээвэл тэр ямагтад доройтох буюу эс бүтнэ гэж Лэгданжэд багш бээр өөрөө ам авсан мөн болой.

"Номт нь ямар байх вэ?" Мунхагаар уршигдсан чанх буруу төдийгөөр өөрийн бодитыг олсон буюу харах мэдрэхүй зэрэг нэрийдлийн ухаан төдийгөөр бүтсэн утгууд болно. "Ам авах ёс"-ны хувьд үнэхээр төрөхийг хорих тэрээр тэдгээр номтууд бүтээж үйлдэх номонд шүтэх тэр цаг тийн болно. Чингэвэл "тийн ам аваагүй" гэвэл хэрхэх вэ? "Тэр ямагтад эс бүтсэн бөгөөд тэр ямагтын утгат бус дүрс зэргүүдийг эндүүрэггүй ухаанаар олохын утгат болохгүйд хүрч хуурмагийг баригч янагуух сэтгэлийн олз (мэдэгдэхүүн) болно.

Тиймээс тэдгээр нь өөрсдөө мунхагаар уршигдсан эндүүрэл болно. Чингэвэл эндүүрэгт сэтгэл нь эндүүрэггүй сэтгэлээр олсон утгыг онож чадахгүй эндүүрэгт сэтгэлд ургах утга эндүүрэггүй сэтгэлээр олдохгүй. Чанх буруу эндүүрэгт сэтгэл болон чанх зөв эндүүрэггүй сэтгэл хоёр өөрийн орныг харилцан тэвчихийн (үгүйсгэх) үүднээс орноо мэдэхийн хувьд тус тусдаа болой" хэмээсэн нь чанх буруу бөгөөд зөв тэдгээр нь тус тусдаа хэмээсэн утгаа. Түүнийг номнохдоо "алин тэр цаг" хэмээхээс "зорих хаанаас байх вэ" хэмээх хүртэл болой. Түүнд чанх буруу хэмээсэн нь мунхагаар уршигдсан

харах мэдрэхүй зэрэг янагуух сэтгэлүүд болой.

Тэрхүү "буй бусын байна (буй) гэж барих" гэдэг нь "Дүрс, дуу тэргүүтэн өөрийн мөн чанараар бүтсэн бэлэг чанар байхгүйтэй адилаар эрхтний мэдрэхүй зэргээр байна гэж барьдаг. "Атгаггүй сэтгэлээр барина" гэдэг үзэх төдий нэгнийг хэлэх учир өөрийн бэлэг чанартай юм шиг дүрс тэргүүтэн үзэгдэнэ. "Тэр цагт буй байна гэх утгыг хувь өчүүхэн төдийд ч хаанаас зорих" хэмээсэн нь тийнхүү өөрийн бэлэг чанар байхгүй атал үзэгдэж харагддаг шиг тэдгээр сэтгэлээр өөрийн бэлэг чанараар оршихын утга өчүүхэн төдийд ч бүтэх гэж хаанаас байх хэмээсэн утга болой. Өөрийн бэлэг чанараар бүтсэн утга байхгүй ээ гэдгийг харуулах жишээг "Үс хялгас зэрэг мэт" хэмээжээ.

Тэдгээрээр дүрс, дуу тэргүүтнийг үзэх эрхтний мэдрэхүйнүүд эндүүрэгт учир өөрийн бэлэг чанараас бүтсэн гэх утгыг "бүтээгчид" биш (нотлогч) гэдгийг айлджээ. "Эндүүрэггүй сэтгэлээр дүрс,дуу тэргүүтнийг хэзээ ч барихгүй болой" хэмээсэн нь хэзээд хөлхөлгөөт бус сэтгэлийг илэрхийлжээ. "Түүнээ чанх зөв, үл эндүүрэх сэтгэлүүд болой. Тэр нь тэр ямагтыг илт болгоохоос өөр бусдад үгүй болой" "Түүгээр үнэн бусыг үл гүтгэх " гэдэг нь тэр ямагт болдоггүй дүрс, дуу зэргийг үл гүтгэх буюу буй гэж үл барихыг заажээ. Үлгэрлэвээс, хөлхөлгөөнөөс хагацсан харааны мэдрэхүйгээр үс хялгас эрвэлзэн торойхын үзэгдлийг үл үзэх мэт болой. "Янагуух болох нь" гэдгээр дүрс, дуу зэрэг хуурмаг утгууд болой. "Буй бус" гэдэг нь өөрийн бэлэг чанараар эс бүтсэн учраас болой. Тэр мэтийг эндүүрэггүй сэтгэлээр, тэр ямагтыг оронт түүгээр өчүүхэн хувь төдий ч эс бүтэх буюу. Тэдгээр нь түүгээр үл болгоогдох учраас" хэмээх утга болой.

Тэдгээр утгын талаар Нагаржунай багшийн гол номын эшлэлийг өгүүлсү. "Хэрвээ хэмээх тэргүүтэн" гэсэн үүгээр илт мэдэл тэргүүтэн дөрвөн шалгадгаар өөрийн бэлэг чанараар бүтсэн утга хаана ч бүтээгүйг айлдаж үүнийг энэ үест үндэс гарвал болгон зохиожээ.

"Алины тухайд ч тэр мэт" хэмээх зэрэг нь дээр номносон утгыг хураангуйлсан буюу. "Алин номт болсон нүд нь янагуух болох хаанаас байх" хэмээсэн нь янагуухийн нүд зэрэг нь номт болохгүйг заасан бус, дээр номносон мэт өөрийн бэлэг чанараар бүтсэн буюу илт эндүүрэггүйгээр бүтэх дүрс гэдэг номт болж нэрийн төдийд ч бүтэхгүй хэмээх утга болой. "Тиймийн тул" хэмээхийн утга нь "өөрийн мөн чанараар бүтэх араншин байхгүй гэж өгүүлэгч" болон "бодит өгүүлэгч" хоёуланд дүрст төрөн түгэхүйг номтод жишээлэхийн үест үл эндүүрэх илт мэдэл зохилдох үзэгдэл болохгүй тул хоёулангийн ёсноо зохилдох үзэгдэл болсон номтыг бүтээсэн шалгадаг

байхгүй тул өөрийн үндэстийн учир шалтгаанаар гадаадын эсэргэлдэгчдэд нотлох ёстой зүгийг гэмгүй гэж үзэж болохгүй гэсэн утга болой. Нэрийн төдийд ч өөрийн мөн чанараар бүтсэн араншин байхгүй гэж үзэх зүгт тэр мэт биз ээ. Гэсэн ч бид нар нэрийн төдийд ч тийн үл үзэх учир өөрийн үндэстийн номт зэргүүд буй тул гэмийн зүг байхгүй гэнэ хэмээвээс. Нэрийн төдийд ч тэр адилын араншин байх нь зохисгүй гэж дээр ч номносон эдүгээ ч номнож буй тул тэр хариулт чинь таарахгүй байна.

2' Үлгэр авах нь адилгүй байгаа нь

"Тодорхой үгт"-ээс:

Үлгэрийн хувьд ч адил бус болой. Энэ нь дууны ерөнхий болон мөнх бусын ерөнхий ялгааг өгүүлээгүй байгаа нь хоёулан дээр байна. Тэрчлэн нүдний ерөнхий утга нь хоосон чанар мөн болон хоосон чанар болохгүй гэж өгүүлэхийг нэрийн төдий ч ам аваагүй тул, үнэмлэхүйд ч аваагүй учир үлгэр жишээний хувьд адилгүй болой хэмээжээ.

Энэ нь махбодиос төрөгсөд болон огторгуйн эрдэм хоёр болон үйлдэгдсэн хийгээд урьд байсан шалтгаан нөхцлөөс тодорч гарах хоёрын аль нь ч бус дуу болон шалтгаанд дулдуйдах, дулдуйдахгүй хоёрын аль нь ч биш болох ерөнхий мөнх бусын байх бөгөөд харин үнэн худлын алин ч болдоггүй нүд зэргүүд байхгүй хэмээн заасан бус гэсэн утгатай аж. Тэдгээрийг эсэргэлдэгч нар үл зөвшөөрөх бөгөөд тиймээс үлгэр, утга хоёрыг таарахгүй гэж хэн ч баталж чадахгүй бүюу. Чингэвэл юу болох вэ ?

Махбодиос төрсөн дуу хэмээх огторгуйн эрдмийн дуу хэмээн ямар ч ялгаа гаргаагүй дуу байна гэж мэдэхдээ тэрхүү эсэргэлдэгч хоёр ёсноо байна гэж үзнэ. Өвөрчлөнгөөр хоосон гэж өгүүлэх ба хоосонгүй гэж өгүүлэх хоёр ёсноо үл эндүүрэх сэтгэлээр бүтсэн ч биш. Эндүүрэх сэтгэлээр бүтсэн ч биш.Тийм шалгадгаар бүтсэн нүдний буюу дүрсний ерөнхий байхгүй. Эндүүрэггүй сэтгэлээр бүтэхдээ гадны эсэргэлдэгчдэд бүтэхгүй. Эндүүрэггүй сэтгэлээр олно гэдэг эсэргэлдэгчийн шалгадгаар эс бүтэх тул үлгэртэй адил биш гэсэн утга болно.

Ер нь эс эндүүрэх сэтгэл бол үнэмлэхүй үнэнийг оносон тэгш агуулах бясалгалын сэтгэл байдаг. Гэвч энэ үест үзэгдэх орон болсон өөрийн бэлгэстээ үл эндүүрэх илт шалгадаг болон шунахуйн орон өөрийн бэлгэстээ үл эндүүрэн жиших, шалгадаг хоёрыг баггаaж болно. Нийт болоод учир шалтгааны гурван ёсыг бүтээх шалгадаг тэр адил ерөөс байхгүй тул эс

эндүүрэх сэтгэлээр олсон утга нь номт болохгүй. Энэ үест өөрийн бэлэг чанар хэмээх нь зөвхөн ертөнцийн хашир мэргэдийн үзэл баримтлалын дагуу утгыг үйлдэж болохгүй. Бодит буюу бодит үгүйн алинд ч өөр өөрийн өвөрчлөнг авч үзэх өвөрчлөнг дээр номносны дагуу үйлдэнэ. Өвөрчлөнг байна гэж өгүүлэгч нар нь бодит бусыг онох жиших шалгадгаар ч тэр мэтийн өвөрчлөгийн шунахуйн оронг эндүүрэггүй гэж үздэг.

Тэр мэтийн өвөрчлөн нь үл эндүүрэх сэтгэл тул үзэх орон болоод шунах орон алинд ч үл эндүүрэх мөн. Гэвч тэр ямагтын утганаа үл эндүүрэн одсоноор өөрийн ёсны шалгадаг түүгээр номт зэргүүд эс бүтнэ гэж үздэг ч хоёр эсэргэлдэгчийн үндсэнд нүд,дүрс тэргүүтнийг онох янагуух шалгадаг байхгүй гэж үздэг бус аа. Гадаад эсэргэлдэгчийн үндсэнд ч дээр номносон элдэв хорлолгүй эрхтний мэдрэхүйгээр татагдсан дүрс тэргүүтэн байх төдийг магадалсан магадлагч сэтгэлийн оронд ухааны хорлол ирэхгүй буюу.

Нарийвчлан номновоос, "ногоог буй гэж барих бодол" дээр гурван зүйл бий. Ногоонд өөрийн мөн чанараас бүтсэн өвөрчлө байна гэж барихыг "үнэхээр буй гэж барих бодол" гэнэ. Ногоог өөрийн мөн чанараар бүтсэн бус ч "илбэ адилаар байна гэж барих" буюу "худлаар буй гэж бодох" бодол. Мөн худал, үнэн алиныг нь ялгалгүйгээр "ер нь байдаг төдий л зүйл" гэж барих бий. Ногоог мөнх, мөнх бус, мөнх бусын ёст зэргээр барих ёс байдаг ч тэр гурван зүйлийн аль нэгээр л барихаас өөр барих ёсон байхгүй тэдгээрийг энд номнох хэрэггүй. Түүнээс бодит юмсын өвөрчлөн үгүйг оносон үзэл үндсэнд төрөөгүй амьтанд буй төдийд барих болон үнэхээр байна гэж барих хоёр нь байна. Өөрийн мөн чанараас байхгүй ч илбэ адилаар байна гэдэг бодол үл төрнө. Ном юмсыг илбэтэй адилд үзэх үзлийг олоогүй байгаа дээрхи амьтан бодгалийн атгагаар барьж байгаа орон бүхнийг үнэнд барьсан гэж бүгдийг хэлж болохгүй. Үүнийг дээр нэрийдлийн шалгадаг ухааны номнох үес болон өвөрчлөн буй, буй бус дөрвийн ялгааг гаргах үест олонтаа заасан билээ.

Чингэлгүйгээр өвөрчлөн үгүй үзлийг үл ухаарсан дээрхи атгагаар томъёолсон утга бүгдээр үнэнд баригч болвол, Төв үзэлтэн нараас дээр номносон эндүүргийн шалтгаар үл хөлхөгдөж, өөрийн байгаагаар тогтоогдсон ертөнцийн нэр, томъёо, агуулга утгуудыг нэрийдэлд буй гэж үзэх ёстой тэр бүгдэд ухааны хорлол буух учраас Вишнү тэнгэр болон буй, бусын ялгааг ч үгүйсгэхэд хүрэх учир чанх буруу үзэлтэй болж төв үзлийг олохын их тотгор болно шүү.

Энэ мэтээр хоосон чанарыг буруу ухаарахын шинж буюу урьд нь атгагаар олох хэрэгтэй буяны үйлийн олон зүгийг үйлдэгч нар хожмоо үзэл

оллоо гээд урьд хураасан бүгдийг “бэлгэст баригч”, “орчлонд хүлэгч” гэх мэтээр үзэх ба буяныг тэр адилаар үйлдэх нь магад утгыг олж чадаагүй нарт айлдсан билээ гэх зэргээр ухаарч “атгаг бүхнийг гэмтэй” гэж үзэх буруу сэжигээр олон номыг тэвчигч болсон Хятадын хуушаан хамба адил бологсод олонтаа үзэгдэнэ.

Өвөрчлөн үгүй үзлийг хараахан олоогүй байгаа бодгаль тэрбээр тэдгээрийн “буй төдий” болоод “өөрийн бэлэг чанараар бүтэж буй” хоёрыг тус тус ялгаж чаддагүй болой. Буй бүгдийг өөрийн мөн чанараар бүтэж байх албатай гэж үздэг болохыг дээр “*Дөрвөн зуутын тайлбар*”-аас эшилсэн билээ.

Тэр оньсоор бол өвөрчлөн үгүйг ч байхгүй байх албатай гэж бариад өвөрчлөнгөөр хоосон болвоос үндэс шалтгаан, үр дагавар гэж томъёолж болохгүй хэмээн олонтаа эсэргэлдсэн болой.

Өвөрчлөн үгүйг оносон үзэл сэтгэлд төрсөн бол буй гэж барих гурван ёс гурвуулаа гарна. Гэхдээ тэрхүү үзэл төрөөд хэдий түүний хуран үйлдэхүй үл доройтох тэр хүртэл ухаанаар сайтар шинжлээд өөрийн мөн чанараар бүтсэн, эс бүтсэнийг санахын цагт өөрийн мөн чанараар бүтсэнийг ам авах үнэнд баригч түр нэг эс төрөх боловч хамт төрсөн үнэнд баригч төрөхгүй ч биш л дээ. Тиймээс өөрийн мөн чанараас бүтсэн өвөрчлөн байхгүйг оносон үзэл төрж, тэр нь дордоогүй байгаа сэтгэлд “ногоог байна” гэж бодох санаа бүгдээр илбэ мэт байна гэх бодол биш ээ. Тэр мэт бус болохоор “тэдгээрийг үнэн байна” гэх илт мэдэл төрөхгүй гэсэн бодол гарна.

“Ном юмст өөрийн мөн чанараар бүтсэн өөрийн бэлэг чанар нэрийдлийн төдийд буй” гэж үздэг Бхававивека багш зэргийн “өөрийн үндэст”-ийн учир шалтгааныг өөрийн ёсноо нигуураар таалахын шалтгаан нь ч нэрийдсэн өөрийн бэлэг чанараар бүтсэн өөрийн бэлэг байна гэдэг энэ мөн учраас “өөрийн үндэст”-ийн учир шалтгааныг агуулах, эс агуулах гэдэг нь энэхүү маш нарийн хоригдохуунд тулдаг.

Тиймээс тэрхүү ёсноо өөрийн мөн чанараас бүтсэн өвөрчлөнг үзэх эрүүл эрхтний мэдрэхүйнүүд ч нэрийдэлд үзэх орноо эндүүрэхгүй буюу мөн тэр адилын өвөрчлөн ногоо тэргүүтнийг буй гэж барих атгаг хүртэл шунах орноо эндүүрэхгүй мөн. Чингэлгүй тэднийг эндүүрэгтэй гэж болгоовоос бодит өгүүлэгч нар хоёулангийн ёсноо зохилдох үзэгдэлд бүтсэн шалгадаг хаана байх вэ. Чандракирти багш болгоосон мэт өөрийн бэлэг чанарыг үзэх мэтийн өвөрчлөн үгүйг тийн үзэгч эрхтний мэдрэхүйнүүдээр бодит өгүүлэгчийг тодорхойлвоос хэзээ номт бүтвээс л өвөрчлөн үгүй бүтчихсэн байх учир өөрийн учир шалтгаанаар юу хийх?

Эсэргүүцэх нь: Гэхдээ цаад этгээд өөртөө бүтээсэн бол болох биз. Төв үзэлтэн, бодит өгүүлэгч хоёуланд зохилдох үзэгдэл болох хэрэггүй шүү дээ.Түүнийг өөрөө ч үл зөвшөөрөх ба ухаан нь ч бас биш үү?

Хариулт: Чингэвээс бүтээх учир шалтгаан, найруулга бүгдээрээ бусдад алдаршсан төдий болж одох тул хэтийдлийн араас орох болно. Шивацо багш тэргүүтэн гадаад утгыг нэрийдэл төдий ч байхгүй гэж болгоогч нараас ч "намбыг үнэнд баригчид" хөх өнгийг хэрхэн үзэхийн адилаар нэрийдэлд ч сэтгэл эдлэг зүйл болно гэж үздэг тул тэдгээрийг үзэх эрхтний мэдрэхүй нь түүнээ харгалзан өөрийн бэлэг чанараар бүтсэн утгыг барих мөн тул нигуур төдийд харгалзах эндүүрэл бишээ. Нүд тэргүүтнийг далд зүйлийн жишээ болгодог тэр ёсонд илт мэдлээр мэдрэгдэх тийм зүйл бодитой биш ч түүнийг бүтээх, нотлохын эцсийн үндэс нь ямар нэг илт мэдэлд л тулах ёстой гэж тогтсон тааллыг өгүүлэгч нар үздэг юм. Харалган хүний жиших мэдрэхүй дамждаг мэтээр түүний язгуурын бүтээгч ч гэсэн илт мэдэлд тулдаг гэж үздэг болой. Тэр цагт язгуурын илт мэдэл тэрээр нэг бол эндүүрэлгүй бусдыг мэдэх сэтгэл, нөгөө бол эндүүрэггүй өөрийгөө мэдэх сэтгэл болно гэж үзнэ.

Чингэхдээ дээр номносон мэт өөрийн бэлэг чанараар бүтсэн үзэгдэх утганаа үзэгдэх мэт вишайн дээр байх хэрэгтэй гэх тэдгээрийг үздэг. Тиймээс тэдгээр болон өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн үгүй гэж өгүүлэгч, төв үзэлтэн хоёуланд зохилдох үзэгдэл бүтэх илт мэдэл эндүүрэггүй байхгүй билээ. Тэр мэт илт мэдэлд үл тулах ч хариулт өгч чадна. Ийнхүү өвөрчлөн байна гэж өгүүлэхдээ хуран үйлдэх, хуран эс үйлдэх алин ч байлаа тэдгээрийн шалгадгаар бүтсэн утга нь тэдгээрийн өөр өөрсдийн ахуй ёсны мөн чанар вишайн дээр байх утгаар бүтэх хэрэгтэй гэхэд нь түүнийг ухаанаар хориглосон учир бүх зүйлийг нотолж үйлдэх шаардлагагүй.

/2/ Тэрхүү гэмээр нотлол ч үл бүтэхийг үзүүлэх

"Тодорхой үгт"-ээс:

Суурь үл бүтэх зүгийн гэмийг өгүүлэх алин ёс энэ ямагт бол буй учраас хэмээх энэ нотлол дээр эс бүтэхийн гэмийг өгүүлсэн дээр ч найруулаарай гэж айлдсан үүгээр үзүүлжээ.

Үүнд өмнө өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөнгөөр хоосон, эс хоосон гэж эсэргэлдэгч хоёрын ёсноо, "*зохилдох үзэгдэл*" болж бүтсэн

"номтыг бүтээгч шалгадаг ухаан" үгүй билээ. Тиймээс "өөрийн үндэстийн" ёсноо "номт болох дүрс төрөн түгэхүй болон өөрөөс эс төрөх үгүй" хэмээх "ном" хоёрыг нэгтгэсэн "зүг" буюу "бүтээгдэхүүн"-ийг байхгүй гэж номносон ухаан түүгээр буй болох учраас" хэмээх нотлол ч тэр хоёрын ёсноо зохилдох үзэгдэл гэж бүтээх бүтээгч шалгадаг байхгүй тул "учир" үл бүтэх болсныг дээр номносон дагуу мэдээрэй. Энэ үед *" Тодорхой үгт"-ээс:*

Тэр адилын тэр нь энэ мэт мөн. Алин боловч ийн өгүүлэх нэн утгыг эл хашир мэргэд өөрийнхөө ам авснаар авах мөн. Хэрхэн хэмээвээс, дотоод түрэн түгэхүйнүүдийг эгүүсгэн үйлдэгч шалтгаан зэрэг нь зөвхөн буй мөн буюу. Тийн болохыг тэрчлэн залрагсад (бурхад) бээр айлдсан тул болой. Алив тэрчлэн залрагсад бээр ийн айлдсан тэр нь тэрчлэн буюу. Үлгэрлэвээс, гаслангаас нөгчигсөн бол амарлингуй нирваан болой хэмээхтэй адил" хэмээн бусдын дэвшүүлсэн энэ бүтээгчийг, энэ үест таны нотлолын утга гэж хэрхэн үзэх билээ. Тэрчлэн залрагсад бээр янагуух гэж айлдсан тул гэх үү, эсвээс үнэмлэхүй гэж айлдсан уу. Хэрвээ янагуухиар гэвэл өөртөө нотлолын утга эс бүтэх ямагт болох" хэмээсэн ба "үнэмлэхүй гэж бүтээх бүтээгч болж эс бүтэх учир нотлол эс бүтэхийн утгатай харшлах утгат болно хэмээх үүгээр энэхүү гэмийг өгүүлжээ. Алин боловч үүгээр өөрийн энэ ёсоор нотлол эс бүтэхийг ам авсан тул бодит номын нотлол болгож байгуулсан жишин мэдэх бүгдэд нотлол зэргүүд өөртөө эс бүтэх учир бүтээн үйлдэгч бүгдээр эвдрэх буюу" хэмээн айлджээ.

Уг утгыг Чандракирти багшийг даган баригч заримууд бээр *"Шороог авья. Үнэхээр хатуу мөн чанартай бус аа. Махбодь учраас, Үлгэрлэвээс хий махбодьтой адил буюу"* хэмээн "*Ухааны бадрал"* зэрэгт байгуулсан зэргийг "үнэхээр гарсан мөн буюу" гэж өгүүлвээс өөрөө эс бүтэх болно. Янагуух болж гарсан мөн хэмээн байгуулваас гадаад бодит өгүүлэгчид эс бүтнэ. Тэрээр учрыг эс бүтэх гэж болохгүй учраас тэр хоёрын үүднээс "эс бүтнэ" гээд "учир эс бүтэх нь албатай" гэвэл өөрийн ам авсантай харшилна гэхэд заримууд "гарах төдий" нэгнийг байгуулваас язгуур ухаанаар эс бүтэх тул хорих мөн хэмээв.

Энэ мэтээр сөхөөх няцаах нь *"Тодорхой үгт"*-ийн таалал утга ерөөс биш багш тэрээр ч ингэж таалаагүй тул хоёр ёс хоёулаа чанх буруу өгүүлж байна. Тэгвэл ямар байх хэмээвээс "алин боловч ийн хэмээн өгүүлэх энэхүү утга үүнийг өөрөө ам авсан ёсоор мөн" хэмээн айлджээ. "Ийн өгүүлэх"гэж номносон нь дээр номносон номт эс бүтэхийн ёс болоод түүний нотлол дээр найруулахыг айлдсан тэр бөлгөө. Тийн айлдсан даруйд гол номоо айлджээ. Тиймээс "энэхүү" болжээ. Номт болон нотлолыг бүтээх илт мэдлийн хувьд

тэрээр эндүүрэлт ба эндүүрэлгүй хоёроос үл хэтрэнэ. Эндүүргээр олсон утгыг нотлол болговоос “бодит өгүүлэгч” нарт үл таарна. Эндүүрэлгүй олсон утгыг тэдгээрт агуулваас өөрийн шалгадгаар бүтээх тул Өөрийн үндэстийн учир болон номт тэргүүтэн эс бүтнэ гэж дээр өгүүлсэн нь “ийн хэмээн өгүүлэх” хэмээсний утга болой.

Тэр адилын үүднээс “бүтэхгүйн агуулга” түүнийг Бхававивека багш бээр хэрхэн ам авсныг үзүүлсүгэй. “Тэр мэт Тэрчлэн залрагсад бээр айлдсан тул” хэмээснийг хоёр үнэний үүднээс шинжлэн зохиосон гэдэг. Түүний утгыг өгүүлвээс, “Тэрчлэн залрагсад бээр янагуух гэж айлдсан тул хэмээн” учирт байгуулах буюу “Үнэмлэхүй гэж айлдсан тул” хэмээн учирт байгуулах хэмээн шинжлэн үйлдэнэ гэдэг ерөөс биш ээ. Урьдын зүгийг урьд нь ам авсан мэтээр номтыг худал үнэн алин болохын ялгаагүйгээр агуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, эсэргэлдэгч аль нэгэнд ч таарахгүй гэж үздэгтэй адил нотлол, үлгэр тэргүүтнийг тэр мэтээр үзэх тул тэр адилын бүдүүн буруу сонжоог энэхүү төгс төгөлдөр бандида юунд эндүүрэх билээ.

Тиймээс “Тэрчлэн залрагсад бээр айлдсан тул” хэмээх учир шалтгааны утга нь “Хоёр үнэний алин бэ?” гэж асуухад, “янагуух болвоос өөрөө тэр мэтийг үл хүсэх учраас өөртөө үл бүтэх”, “үнэмлэхүй мөн болвоос, бид нарын үнэмлэхүйд “үр байх”, “байхгүй”, “хоёулаа байх”, “шалтгаанаас төрөх” эсэх зэргүүд хаагдах тул үл бүтнэ. Хоёр үнэн алин ч болохгүйн утгыг үл хүсэх тул түүнийг тодорхой зохиохын хэрэггүй” Түүнийг гарсан мөн тул хэмээн байгуулахад учирт байгуулсан “гарсан” гэх тэр нь хоёр үнэний алин бэ? гэж асуухад дээрхтэй адил.

“Хоёр үнэн гарсан”-ыг аль учир дээр байгуулах хэмээн өгүүлвээс урьдын зүгийг ерөөс эс ухаарах болой. Тийнхүү хоёр үнэний аль нь мөн гэж асуухад үнэмлэхүй болвоос өөртөө эс бүтсэн мөн боловч янагуух болвоос бусдад үл бүтэх хэмээн өгүүлж болно. Чингэхгүй бол номт болгосон дотоод түрэн түгэхүй нь янагуухид буй учраас тэрээр эсэргэлдэгч нар баталж чадахгүй болно. Гэвч “ийн хэмээн өгүүлэх ”түүнийг Бхававивека багшийн учир шалтгаанд хоёр үнэний шинжилгээг үйлдэж, түүгээрээ ам авах ёс гэж юу вэ хэмээвээс номносугай. Энд тэр багш бээр эндүүрэггүй сэтгэлээр олдсон түүнийг үнэмлэхүй ба эндүүрэгт сэтгэлээр олдсон түүнийг янагуух гэж үзжээ.

Чингээд “Хоёр үнэн алин мөн” хэмээсэн тэр нь “хоёр үнэн юугаар хэрхэн олдсоноор нь мөн” хэмээгээд нэгэн аньст болох хэрэгтэй гэж боджээ. Энэ мэтээр учирт байгуулахын утга тэрээр янагуух, үнэмлэхүйн алин ч биш болвол тэр учир эс бүтэх хэрэгтэй болно. Учирт байгуулсан тэр утга тэрээр,

эндүүрэгт эс эндүүрэгт ухаан хоёрын аль нэгээр олдсон утга болохгүй бол учирт байгуулсан тэр утга үл бүтэхийн учир шалтгаан адил тул үүнийг өөрөө ам авсан хэмээн айлдсан болохоос жинхэнээр ам аваагүй болой. "Иймээс бодит ном юмсыг нотлолд байгуулсан зүйлүүд" хэмээн бодит номыг тусгайлан айлджээ.

Бхававивека багшийн өөрөө байгуулсан эдгээр учрыг заримууд эндүүрэггүй илт мэдлээс, заримууд нь туйлын дээд бүтээгч эндүүрэггүй илт мэдлээс болсон гэж үзэх байдаг ч эдгээрийг багш үгүйсгэсэн байна. Ингээд дээр эш авсан мэтээр "Төв үзэлтэн мөн болвоос бусдын зүгийг ам авдаггүй" хэмээн өөрийн бэлэг чанараар бүтсэн утгыг ам авах нь зохисгүй болохыг баталж "Хэрвээ илт мэдэл зэргүүд" хэмээснийг эшилж өөрийн бэлэг чанарыг мэдэх шалгадаг байхгүй гэх зэргээр Бхававивека багшийн "зүгийг барин" баталжээ.

20

ӨӨРИЙН ҮНДЭСТИЙГ (СВАТАТРИКА) ШҮҮМЖЛЭХ НЬ

б/ Тэр бидэнтэй адилгүй ёсон

(б) Тэр хоёрыг даган барьж үзэл онолыг үндэснээ төрүүлэх

---оОо---

б/ Тэр бидэнтэй адилгүй ёсон

"*Тодорхой үгт"-ээс* "Хэрвээ бусдын жишин мэдэх сэтгэлд номт учир эс бүтэх зэргийн гэмийг өгүүлэгч нарын өөрийн жиших үйл ч гэмтэй зүйл байхгүй юм уу. Тийм бол бусадтай маргалдах хэрэггүй шүү дээ?" хэмээвээс, "Бусдад тэдгээр гэм ирнэ гэдэг өөрийн үндэстийн жишихүй ам авсан бол гарна. Бид нар өөрийн үндэстийн жиших сэтгэлийг үл ам авсан тул тэдгээр гэм байхгүй"гэж айлджээ.

Энд жиших сэтгэлүүд нь найруулга нотлол болой. Өөрийн үндэстийг ам авбаас, "өөрийн бэлэг чанарыг шалгадаг ухааныг эсэргэлдэгч хоёулангийн "зохилдох үзэгдэл" гэж үзээд түүний нотлох гурван ёст хоёуланг бүтээхээр "бүтээгдэхүүн номоо" бүтээх хэрэгтэй. Тиймээс тэр шалгадаг нь үгүй тул номт тэргүүтэн үл бүтэх буюу. Өөрийн үндэстийг эс ам авбаас гадаадын бодит өгүүлэгч нар өөртөө шалгадаг тэр адилаар бүтэж болох ч өөртөө тэр шалгадаг бүтэх хэрэггүй болой. Тиймээс гол номоос гарах жишихүй сэтгэлүүд нь ч бусдын тангарагийг хорих төдийд хэрэгтэй бусдад алдаршсан жиших сэтгэл болохоос өөрийн үндэст бус аа. Үүнийг үлгэрлэвээс *"Үндсэн билгийн гутгаар бүлэг"*-ээс:

Тэрээр өөрийн чанараа
Өөрөө үзэх бус буюу,
Алимад өөрийгөө үл үзэх
Тэрээр бусдыг яаж үзэх билээ

хэмээн "өөрийгөө үл үзэх"-ийг учирт байгуулан "бусдыг үл үзэх"-ийг бүтээх мэт болой. Ингэж "учир"ыг өөрөө ч зөвшөөрч "тангарагийг бусдаас харах" өөрийн мөн чанар бахйгүй ч төв үзэлтний дэвшүүлдэг энэ мэтийн нотлолууд дээр "бусдад алдаршсан жиших сэтгэл" гэдэг. *"Тодорхой үгт"*-ээс:

Бид нар "өөрийн үндэст"-ийн даган жишихүйг үл хэрэглэх буюу. Жишихүйнүүд нь бусдын тангарагийг хорих төдий үрд гарсан мөн" хэмээн нотлол байгуулагч нар "Өөрийн үндэст" бус гэх ба бусдын тангарагийг хорих төдийд л хэрэгтэй гэж болгоосон тул нотлол байгуулаагүй нь бус аа. Нотлол байгуулаад тангарагийг үгүйсгэх ёсыг дээрх эшийн сүүлд: "Ийнхүү бусдыг нүдээр харах болой" хэмээх тэр бодол нь "нүд өөрийнхөө мөн чанарыг харахгүй номт" гэж үзнэ. Хэрэв "тэрээр бусдыг үзэхийн хувьгүй" аваас "ерөөс байхгүйн номт болно" гэж ам авсан мөн. Тиймээс алин юунд ч өөрийнхөө мөн чанарыг үзнэ гэж байхгүй, тэр болоод түүнд бусдыг үзэх ч буй бус. Үлгэрлэвээс, хумхтай адил. Нүд ч өөрийн мөн чанараар үл үзнэ. Тиймээс бусдыг үзэх ч түүнд үгүй болой. Тиймээс өөрийн мөн чанараа үл үзэхтэй харшлах "хөх өнгө тэргүүтэн бусдыг үзэх өөрт алдаршсан жишихүй сэтгэлтэй харшлах мөн" хэмээн түүнийг бүтээх жиших сэтгэлийг арилгаж үйлдэнэ хэмээн айлджээ.

Гадаадын эсэргэлдэгч өөртөө алдаршигч болон дотоод эсэргэлдэгч Төв үзэлтэнд харгалзуулваас "бусдад алдаршсан" хоёр нь нэг аньстай. Өөрөө бусдад алдаршсан нотлол үгийг байгуулан буруу атгагийг буцаах энэ ёс машид чухал тул нарийвчлан номносугай.

"Түүнийг бүтээх"-дээ, "номт" (subject) болох *"нүд"*, "үлгэр" (the example) болох *"хумх"*, учир шалтгаан (the reason) болох *"өөрийгөө үл үзэх"*, "бүтээгдэхүүн ном" (the predicated quality) болох *"хөх өнгө тэргүүтнийг үл харах"* зэргүүдийг өөрийн ёсноо ам үл авах буюу. Бусдын авах төдий мөн тул учир болоод албатай тэргүүтнийг зөвхөн гадаад эсэргэлдэгчид бүтнэ хэмээсэн утга бус аа. Тэгвэл юун хэмээвэл, тэдгээрийг өөрийн ёсонд ам авсан нь байхгүй ч, тэдгээрийг бүтээхийн шалгадаг өөрийн мөн чанараар бүтсэн мэдэгдэхүүнийг илт мэднэ гэдэг өөрийн ёсонд томъёо төдий ч үгүй билээ.

Өвөрчлөн буй гэж өгүүлэгч тэдгээрийн хувьд бүтсэн гэдэг нь тэрхүү шалгадгаар бүтсэнээ магадтай харгалзах тул хоёуланд зохилдох үзэгдэлд бүтсэн, өөрийн мөн чанараар бүтсэн гэдгийг оносон шалгадаг байхгүй учир хоёулаа үл бүтсэн болж бусдад алдаршсан буюу бусдад бүтсэн хэмээгджээ.

Асуулт: Чингэхэд тэр мэтийн шалгадаг нэрийдлийн төдийд ч үгүй тул түүнийг бүтсэнд үзэх чинь өвөрчлөнг гүтгэж үздэгтэй адил болж ухаанаар хорлогдох тул тэдгээр "бүтээгч" нарт дулдуйдаж хэрхэн төв үзлийг олох билээ. Шалгадагт хорлогдох үндэслэлд шүтсэн хирнээ эндүүрэггүй нэгнийг олно гэвэл чанх буруу бүхий л тогтсон таалаар ч гэсэн олно гэсэн үг үү?

Хариулт: Энэхүү гадаад эсэргэлдэгч бээр "номт"-*"нүд"*, "учир шалтгаан"-*"өөрийгөө үл үзэх"*, "үлгэр"-*"хумх"*,"ном"- *"хөх өнгө зэргийг үл үзэх"*

зэргүүдийг буй гэж барих орнууд өөрийн ёсондоо ч нэрийдэл төдийд ч буй гэж үзэх учраас тэдгээрийг ухаанаар хорлохгүй болой. Гэхдээ эсэргэлдэгч бээр тэдгээрийг өөрийн мөн чанараар буй болоод буй хоёрын ялгааг тус тус үл ялгах учир тэдгээрийг өөрийн мөн чанарар бүтсэн гэх нь шалгадаг мэдэгдэхүүнтэй харшлах ба шалгадгаар бүтсэн гэж хөөрөмших нь вишайг мэдэх ухаантай зөрчилдөнө.

Гэвч түүний үндсэнд буй эрүүл нэрийдлийн сэтгэлүүдээр бүтэхийг ухаанаар хаанаас хорих билээ. Тиймээс түүний ёс болон бидний ёс хоёуланд өөрийн мөн чанараар бүтсэн мэдэгдэхүүнийг оносон шалгадаг нь зохилдох үзэгдэлд бүтсэн гэж ам авах эс гарсан ч "Өөрийн үндэст" нар эс бүтсэн гэж тэд өөрсдөө ам авч харшлах ёс төдийг үйлджээ. Түүний ёс нь дээр байгуулсан "бусдад алдаршсан нотлол" түүгээр бэлгэдэж, "номт-нүд" түүнээ "өөрийгөө үл харах"-ын "учир шалтгаан нь нэрийдсэн байна" гээд "хөх өнгө тэргүүтнийг үзэх өөрийн мөн чанараар бүтсэн" гэх түүнээ "нэрийдэлд ч үгүй тул" түрүүчийнх нь хойдхоо хориглогч үл болно. Нүд түүнээ тэрхүү учир тэрхүү хорих ном хоёулаа байвал буй хэмээх ба байхгүй бол үгүй хэмээхэд хүрэх тул, тэр хоёр нь хорлогч хорлогдохуун хаанаас болох вэ. Тиймээс бусдад алдаршсан нотлолын "номт","ном", "учир шалтгаан" зэрэг нь нэрийдэл байх ёстой. "Тэрээр байна" гэж "ам авах" төдийгөөр зогсохгүй, "номт-нүд" тэргүүтэн "тэдгээрийг байна гэж ам авах" учраас Төв үзэлтэн нар тэдгээрийг бүтээнэ гэж хаанаас байх вэ? Хэрвээ түүнд хүчирлэж бид нарт бүтээгүй тул бүтээсүгэй гэж хэлээд хүчирлэгдэхгүй юм хаана ч байхгүй гэж болохгүй тул, тэдгээртэй тэмцээд үр гарахгүй тул, түүний хань болж хэн үйлдэх вэ.

Эсэргүүцэл: Энэ үед заримууд, гадныхан "өөрийгөө үл үзэх", "хөх өнгө тэргүүтнийг үзэх", "өөрийн мөн чанараар бүтэх", "өвөрчлөн байна" гэх зэргээр үзэх нь харшилна гэж заадаг ч харшилна гэж юугаар мэдэх вэ. Харшилна гэж шалгадгаар бүтээвэл хоёулаа бүтэх хэрэгтэй тул бусдад алдаршсан гэж бүү үйлд. Ам авах болоод харшилна гэж агуулваас л өөрийгөө үзэх, бусдыг үзэх хоёрыг гадныхан үл харшлах гэж үздэг тул түүний ам авснаар харшилна гэж үзэх нь таарахгүй. Бид өөрсдөө харшилна гэж үзвээс дэндүү хэтийдэх биз. "Эсэргэлдэгчид, та үүнийг харшилна гэж үзэх нь зохисгүй. Би үүнийг харшилна гэж үздэг учраас" гэж хэлж болох уу?"

Хариулт: Ингэхэд гэмгүй биздээ."Өөрийгөө үзэхгүй ээ" гэдэг нь "өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн байна" гэдэгтэй харшлахыг шалгадгаар

бүтсэн төдийгөөр агуулахгүй ээ.

Асуулт: Чингэвэл тэрхүү шалгадаг нь гадны этгээдэд үзүүлж байж харшлах гэдгээ магадтай мэдэж болох биз. "Түүний ам авснаа шүтээд юу хийх вэ?" */Хариулт/* Бодит өгүүлэгчийн нигуурт харш байна гэдгийг батлах шалгадаг бий гэж нотлохдоо өөрийн мөн чанараар бүтсэн мэдэгдэхүүнийг оножт мэдсэнд харгалзах буюу. Тэр нь ч үгүй учраас өөрөө түүнийг ам авах гэдэг хаана бүтэх. Мэдэгдэхүүнд өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн байхгүй ч шалгадагт баригдахад харшлахгүй гэж та үзсэн. Тэр адил шалгадгаар онож байж ном юмсын өвөрчлөн үгүйг оносон үзлийг олно. Тиймээс өөрийгөө үл харах болвол өөрийн мөн чанараар бүтэх үзэл болж харшлах болно гэдгийг бүтээхийн хэрэг юун. Тиймээс л Чандракирти гэгээний ёсыг мэдэхийг хүсвээс тэдгээрийг машид нягтлан ухаарч үйлдээрэй.

Асуулт: Чингэхэд өөрт алдаршнаа шүтэж, "өөрийгөө үл харж, бусдыг харах нь өөрийн мөн чанараар бүтээгүй байх албатайн ёс"-ыг яаж заах вэ?

Хариулт: Үүнийг *"Буддхабалида"*-д хэрхэн тайлбарласан дагуу номноорой.

Үлгэрлэвээс ус төгөлдөр учраас газар чийгтэй байх, галтай учраас ус халуун байх, намэ (сайхан үнэрт) цэцэг төгс учраас дээл хувцас анхилам үнэртэй байх зэргийг мэдэхдээ ус тэргүүтэн гурав болон түүн дээр чийг тэргүүтэн гурав байхыг харгалзуулж бодох хэрэгтэй гэж та ч гэсэн үздэг. Түүнтэй адилаар бодит юмст өөрийн мөн чанараар бүтэх зарим нэг өвөрчлөн байхад тэр өвөрчлөнг "өөрийгөө" (өөрийн) гэж бодоод цаашлаад түүнтэй төгөлдөр гэж бодсоор бусдыг ч мөн тийм гэж бодох хэрэгтэй болдог. Хэрвээ эхнээсээ өөрийгөө бодохгүй бол түүнтэй төгөлдөр байлаа ч бусдыг яаж бодох билээ. Үлгэрлэвээс, "намэ (jas-min) цэцгийг (өөрий нь)" гэж бодохгүй бол түүнтэй төгөлдөр хувцасыг анхилам үнэрт гэж бодохгүйд тулдагтай адил" хэмээжээ.

Эсэргэлдэгч өөрт алдаршсантай жишин орж, буцахын магадлалыг олдог. Чингээд энэ үеийн утгатай найруулваас нүдэнд ч харах өвөрчлөн байдаг бол эхлээд өөрийгөө харж бодоод түүнээсээ дүрс тэргүүтэн болон цуглаж нийлсэн дүрс түүнийг харж үзэх төдийхнөөр бодож болох уу гэвэл, өөрийгөө харж үзэж чадахгүйтэй адил бусдыг ч харж чадахгүй гэж заасан болой. *"Дөрвөн зуут"*-аас ч:

Бодас бүгдийн өвөрчлөн чанарыг
Эхлээд өөр дээрээ гэж бодох болвоос
Нүд зэргийг нүдээрээ

Яаж ч барих билээ ? хэмээн айлдсан мэт,

Эсэргүүцэх нь: Гал өөрийгөө түлдэггүй ч бусдыг түлдэгтэй адил нүд өөрийгөө харахгүй ч бусдыг харах нь харшлахгүй биз дээ?

Хариулт: Ер нь галд түлээ мод шатах ба нүдээр дүрсийг үзэх төдийг хориогүй юм. Нүдээр бусдыг үзэх нь өөрийн мөн чанартай байна гэдгийг хорьсон хэрэг болой. Тэр мэт бөгөөд галд түлээ мод шатахыг мөн чанараар бүтсэний жишээнд авах хэрэгтэй ч тэр цагт жишээ маань "бүтээгдэхүүн" болж таарахгүй л дээ. Ийнхүү гал, түлээ хоёулаа өөрийн ман чанараар бүтсэн юм бол өөрийн мөн чанарт нэг зүйл болвол мөн чанараар нэгэн зүйл эсвээс тус тусдаа байх хоёроос хэтрэхгүй байх учиртай. Тэгвэл тэр хоёрын аль нь вэ? Нэг мөн болвоос гал өөрийгөө шатаах болно.

Бас тэгээд гал нь шатаагч, түлээ нь шатаагдахуун хэрхэн болох. Хэрэв болно гэвэл та ч гэсэн гал нь шатаан үйлдэгч болох, түлээ нь шатагч болой гэж ярьдаг тул ямар хариу өгөх билээ. Хэрвээ мөн чанартаа тус тусдаа болвол түлээ байхгүй ч гал нь бодогдож мэдрэгдэхэд хүрнэ. Морь байхгүй ч үхэр бодох болдогтой адил болой. *"Дөрвөн зуут"*-аас:

Гал халуун чанарт тул шатах
Халуун биш бол хаанаас шатах
Тиймээс мод хэмээгдэх нь байхгүй бол
Түүнээс өөрөөр гал гэж үгүй хэмээн айлдсан мэт.

Тэр мэт шатаах түлэхэд өөрийн мөн чанараар бүтсэн араншинтай байна гэж үзвээс өөрийгөө шатаахгүйтэй адил бусдыг ч шатаахгүй болно. Үүнтэй адил нүдэнд харагдах өвөрчлөн байна гэж ам авбаас ч өөрийгөө харахгүй байж бусдыг ч харахгүй байх хэрэгтэй гэж урьдын гэмээс мултрахгүй.

Тийнхүү өвөрчлөн байна хэмээн андгайлахад ямар хорлол гарахыг заасныг үзээд өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөнг буй гэж үздэг тогтсон тааллыг орхих учиртай. Цаашлаад өвөрчлөн байхгүй байж л үйл үйлдвэр бүхэн таардаг гэдгийг ч ухаарч чадах тул өвөрчлөнгөөр үгүй болоод ердийн үгүй (буй бус) хоёрыг ялгаж мэднэ. Чингээд өвөрчлөнгөөр байх ба ердийн байх хоёрын ялгааг ухаарахад хүрэх тул өвөрчлөн үгүй мэдэгдэхүүнийг өвөрчлөн үгүй шалгадаг ухаанаар онох зэргийг ч ухаарах болно.

Асуулт: Чингэвэл гал, түлээ хоёрыг өвөрчлөн үгүйг оносон шалгадаг чинь илт байж таарахгүй учир жиших мэдэл гэж үзэх хэрэгтэй. "Тиймээс түүний суурь болсон нотлол нь ямар байх вэ?

Хариулт: "Өвөрчлөн байваас нэг болон тус тус байхаас өөр учиргүй" гэдгийг мэдэж, нэг бол тус тусдаа байх тул өвөрчлөн нь эвдэрсэн л бол өвөрчлөн үгүй болох нь магадтай. Энэ нь зүгийн номын ёс мөн тул гурван ёстын учир байна. Түүнээ шүтэж гал болоод түлээнд өвөрчлөн байхгүй гэдгийг магадалсан жишин онох ухаан төрдөг. Үгээр дээр гарсан бусдад алдаршсан нотлолд ч гурван ёст болон жиших ухаан төрөх ёсыг мэдээрэй.

Хэтрүүлэл (reductio) нь: "Гал нь түлээнд өвөрчлөнгөөр буй аваас өвөрчлөн чанар нь нэг болон тус тус хоёрын аль нэг болно. Хэрвээ "нэг болвоос гал өөрөө өөрийгөө шатаах болно" хэмээх тэргүүтэн бусдын ам авсныг учирт байгуулж гадны этгээдийн үл зөвшөөрөх зүйлийг хаях энэ мэт мөн тул үүгээр жишиж бусад хэтрүүллийг ч ухаараарай. Тиймээс гадны эсэргэлдэгч нар хэдий бодит өгүүлэх тогтсон тааллаа эс орхих тэр хүртэл өөрийн мөн чанараар бүтсэн мэдэгдэхүүнийг мэдэж бүтээнэ гэдэгтээ баригдаж утгын бүтээгч шалгадаг байна гэж үздэг. Хэзээ нэг цагт зарим бодит юмс өөрийн мөн чанараар бүтээгүй гэдгийг шалгадгаар мэдээд ирэхээр бодит өгүүлэх тогтсон тааллаа орхидог билээ. *"Тодорхой үгт"*-ээс:

Асуулт: "Ямар нэгнийг бүтээх жиших ухааны үүднээс ч жиших ухаанд хорлол гарах байх уу?

Хариулт: Тэр нь өөрийгөө бүтээх нотлол ямагт мөн. Бусдад бүтээхээр бус. Ертөнц ямагтад үзэх болой. Ертөнцөд заримдаа гэрч эсэргэлдэгч, гадаад эсэргэлдэгч хоёр бээр үгээр ялах, ялагдах ч байна. Заримдаа зөвхөн өөрийнхөө үгээр болохоос бусдын үгээр ялж, ялагдах гэж байхгүй. Ертөнцөд хэрхэн мөн байна түүн шигээ мэдэх бас байна. Зөвхөн ертөнцийн нэр томъёо төдийд зохистой гэж шастар номуудад тухайлан буулгасан бий" хэмээн бусдад алдаршсан учир болохыг үлгэр, ном зэргийн үүднээс айлдсан буюу. Хашир мэргэдээс гадаад эсэргэлдэгчдийн ямар ч шалгадгийг "гурван учирт" шалгуур зэргээр нотлох ба тэрхүү шалгадгийг гадаад, дотоод эсэргэлдэгч хоёуланд нотлон бүтээх хэрэгтэй гэх зэрэг үзлийг хорьж айлджээ.

Мөн "Түүнээс":

Алин хоёуланд магадлал өгүүлнэ гэдэг бүтээх буюу сөхөөх мөн. Алин нэгнээ бүтэх буюу доноголзон тээнэгэлзэнэ гэж өгүүлж болохгүй гэж санадаг ч ертөнцийн тийн агуулгад шүтэж, жишин мэдэхэд тийн өгүүлэх энэхүү ёсыг ам аваарай. Үүнийг эшээр няцаахад хоёуланг бүтээх тэр л эшийн үүднээс биш ээ. Тэгвэл юугаар гэвэл өөрийгөө бүтээхийн үүднээс болой. Өөрийн утгыг даган

барихдаа бүгд өөрт бүтнэ гэж хөөрч болохгүй. Хоёулаа бүтэх бус аа. Үүний тул мэргэд хашруудын бэлэг чанарыг өгүүлэх нь хэрэггүй зүйл билээ. Бурхадууд өөрт хэрхэн алдаршсанд дагуулж тэр ямагтыг үл мэдэх төрөлхтөн шавь нарт тусалдаг болой хэмээн айлджээ.

Тэр мэт дээр номносон мэт шалгадгаар эсэргэлдэгч хоёуланд бүтсэн учраар бүтээгдэхүүнийг бүтээхэд "Өөрийн үндэст"-ийн учир шалтгаан болон түүнийг үл ухаарах бусад эсэргэлдэгч нарт алдаршсан гурван ёстоор бүтээгдэхүүнийг бүтээхэд "хэтрүүллийг" ийнхүү агуулах нь энэ багшийн таалал болох нь тодорхой.

(б) Тэр хоёрыг даган барьж үзэл онолыг үндэснээ төрүүлэх

Тэр мэт хутагт эцэг, хөвгүүн тэдгээрийн даган барихдаа төв үзэлтэн "хэтрүүлэгч", "өөрийн үндэст" нарт харилцан адилгүй хоёр ёс буй. Тэр хоёрын алиныг дагах вэ? хэмээвээс, Энд хэтрүүлэгч ёсыг даган барина. Үүнийг дээр номносон мэтээр нэрийдэлд ч өдий мөн чанараар бүтсэн өвөрчлөнг хориглож түүнийг хориход сансар, нирваны агуулга бүгдийг сайтар барих чухал хэрэгтэй тул тэрхүү хоёр ёсыг сайтар ухаарах учиртай. Бодас мэт өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөнг ам авбаас ахуй ёсыг шинжлэх ухаан ба шинжилгээ шаардлагатай гэж энэ хоёр багшийн гол номоос олонтаа айлдсан тул хутагт эцэг, хөвгүүний гол номуудтай сайтар жигдрүүлж тэр ёсноо ам авах ба тэр тусмаа дээр номносон мэт магадтайгаар "Хэтрүүлэгч" ёсны зүг ам авах хэрэгтэй.

21

"МОДОН ТЭРЭГ"-ИЙГ ШИНЖИХ НЬ
(Бодгалийн хоосон чанарыг онох)

(3) Чадал түүнээ шүтэж үзэл онол үндсэнд төрөх
  (а) Бодгалийн "би-үгүй"-г нотлон буулгах
    1/ "Би" нь өвөрчлөн бодитойгоор үгүй гэдгийг нотлон буулгах
      а/ Үлгэрийг үзүүлэх
        /1/ Модон тэрэгнээ өвөрчлөн үгүй харин нэрийдсэн буйг үзүүлэх
        /2/ Тэр тухай тэмцлийг няцаах
        /3/ Нэрийн ялгааны үүднээс бүтээх ёсон
        /4 Түүнээ шүтэж түзэл онолыг түргэн олох тус эрдэм

- - - о О о - - -

(3) Чадал түүнээ шүтэж үзэл онол үндсэнд төрөхөд гурван зүйл:
  (а) Бодгалийн "би-үгүй"-г нотлон буулгах
  (б) Номын "би-үгүй"-г нотлон буулгах
  (в) Тэдгээр үзлийг дадуулснаар түйтгэрийг тэвчих ёс

(а) Бодгалийн "би-үгүй"-г нотлон буулгахад гурав:
  1/ "Би" нь өвөрчлөн үгүй гэдгийг нотлон буулгах
  2/ Түүнчлэн "минийх" гэдэг ч өвөрчлөн үгүй болохыг үзүүлэх
  3/ Тэрхүү ухаануудыг бусадтай найруулах ёсон

1/ "Би" нь нь өвөрчлөн үгүй гэдгийг нотлон буулгахад хоёр:
    а/ Үлгэрийг үзүүлэх
    б/ Утгыг найруулах

а/ Үлгэрийг үзүүлэх

"Орохуй тайлбар"-д судраас эшлэн:

"Би" хэмээх нь шумнасын сэтгэл гэж
Та түүнийг мэдэх буюу
Хурсан цогцос энэ хоосон бөгөөд
Үүнээ амьтан буй бус аа
Хэрхэн гишүүд цуглаж нийлснээ
Шүтэж модон тэрэг гэж өгүүлдэг шиг

Тэрчлэн цогцосуудад шүтэн байж
Янагуух амьтан хэмээх болой

хэмээн өөрийн гишүүн (бүрэлдэхүүн хэсэг) болох дугуй хүрд зэрэгтээ шүтэн байж модон тэрэг гэж нэрлэгдэх жишээг аваад цогцосуудад шүтэж л би буюу амьтан гэж нэрлэгддэг болохыг айлдсан тул эхлээд "модон тэрэг" дээр үлгэрлэн номлосугай.

Үүнээ дөрөв:

/1/ Модон тэрэгнээ өвөрчлөн үгүй харин нэрийдсэн буйг үзүүлэх
/2/ Тэр тухай тэмцлийг няцаах
/3/ Нэрийн ялгааны үүднээс бүтээх ёсон
/4 Түүнээ шүтэж түзэл онолыг түргэн олох тус эрдэм

/1/ Модон тэрэгнээ өвөрчлөн үгүй ч харин нэрийдэлд буйг үзүүлэх

"Орохуй"-гаас:

Модон тэрэг нь өөрийн гишүүнээс ангид бус /1/,
Ангид бус нь бус /2/, түүнтэй төгөлдөр ч бус /3/,
Гишүүн ч бус /4/, гишүүд нь ч тэр бус /5/,
Хурсан төдий ч бус /6/, хэлбэр дүрс нь ч тэр бус /7/ адил

хэмээн модон тэрэг нь өөрийн гишүүдтэй нэг болон эсвэл ангид байх зэрэг долоон зүйлээр "буй бус" тул зөвхөн нэрийдэл төдий зүйл мөн. Түүнтэй адилаар "би" болоод "цогцос" хоёр ч мөн тийм болохыг айлджээ.

Энд модон тэрэг өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөнтэй байх аваас нэгэн байх буюу эсвээс ангид тус тус байх долоон зүйлийн аль нэгээр буюу өвөрчлөн буй үгүйг шинжигч ухаанаар ямар ч эргэлзээгүй бүтсэн байх хэрэгтэй. Гэтэл тэр долоогийн аль нэг нь болж тийн бүтээгүй (мэдрэгдээгүй) байгаа тул түүнээ өвөрчлөн чанар байхгүй байна. Модон тэрэг нь гол мод, хүрд (дугуй), шаантаг (хадаас) зэрэг гишүүдээс бүрдэнэ. Модон тэрэг нь тэдгээр бүхэнтэй нэг мөн чанартай бус. Нэг гэвэл түүний гишүүд олон байгаатай адилаар модон тэрэг ч мөн олон болж таарна. Мөн нөгөө талаас модон тэрэг нэг байгаатай адилаар тэдгээр гишүүд ч нэг болж болно.

Ингэхээр үйлийг үйлдэгч (эзэн) болон үйл, ажил хоёр нэг зүйл болчих зэрэг гэм гарна. Өөрийн гишүүдтэйгээ өөрийн мөн чанараар бүтсэн ангид

тусдаа ч бус. Мөн болвоос хумх болон цэмбэ шиг ялгагдах тус тусдаа зүйл болж бодогдох учиртай ч тийн үл зоригдох болой. Тийм нэрийдэх үндэслэл байхгүй тул. Шүтээн (суурь), шүтэгдэхүүн /түүний бүрэлдэхүүн хэсэг/ хэмээх хоёр зүг нь "тараг тагшинд байхтай адил" өөрийн гишүүдийнхээ суурь дээр ч буй бус, "Лхайжэн /Дэвадатта/ гэртээ суух " гэхтэй адилаар гэрийн бүрэлдүүлэх хэсгүүддээ шүтэж байгаа нь үгүй. Тэр хоёр өөрийн мөн чанараар тус тусдаа бүтнэ гэвэл тийм зүйл огт байхгүй. Гэхдээ энэ үест инагш, чинагш байх гэдгийг үгүйсгэхгүй. Харин шүтээн, шүтэгдэхүүн нь өөрийн бэлэг чанараар бүтсэнийг л хорьж буй хэрэг. Хоёр жишээг айлддаг тэдгээр нь өөрийн бэлэг чанараар шүтээн, шүтэгдэхүүн болгож бүтээсэн бусдад алдаршсаныг гадны этгээдэд үзүүлсэн бөгөөд энэ адил бүгдэд үнэхээр адилаар мэдээрэй. Төгөлдөр байхын зүг ч таарахгүй. Ингэвээс Лхайжэн нь өөрөөсөө ангид утгатай үхэр болчих вий.

Тийнхүү модон тэргийг өөрийн гишүүдтэй төгөлдөр гэж үзвэл үхэр, Лхайжэн хоёрыг тус тус барихтай адилаар модон тэрэг болоод түүний гишүүдийг тус тус барих хэрэгтэй. Гэтэл тийнхүү барьж болохгүй учраас л тийн төгөлдөр бусаа."Лхайжэн чих төгөлдөр болой" гэхтэй адилаар "модон тэрэг гишүүдтэй төгөлдөр байх нь" зохисгүй л дээ. Өвөрчлөн ангид тусдаа байхыг хорьсон учир өөрийн мөн чанараар бүтсэн зүйлтэй төгөлдөр байна гэдэг өвөрчлөнтэйгээр нэг байна гэсэн утга болно. Түүнийг дээр хорьсон болой. Ингэхэд "Лхайжэн чихтэй төгөлдөр байх нь нэрийдэл төдий байх" гэдгийг үгүйсгээгүйтэй адилаар модон тэрэгнээ ч мөн тийм л байх тул "өөрийн бэлэг чанараар төгөлдөр бүтсэн бахыг л хорьсон хэрэг ээ. Үлдсэн хоёр зүгийн хувьд *"Орохуй"-гаас:*

Хэрвээ хурсан төдий нь модон тэрэг болвоос
Хэсэг бусаг байгаа нь модон тэрэг мөн болох
Алин гишүүнт бус болвоос тэдгээр гишүүд
Үгүй болох тул хэлбэр дүрс төдий нь модон тэрэг бус аа

хэмээсэн мэт "гишүүд цугласан төдий" болоод гишүүдийн ялгагдах "хэлбэр" хоёрын л модон тэрэг гэж үзэх бий. Гэтэл модон тэрэг нь өөрийн гишүүдийн цугларал, нийлэмж төдийд ч үл таарна. Энд хоёр зүйлээс:

Нэгд: *Учир шалтгаантай харшлах нь:* Гишүүн болох хүрд дугуй зэргүүд нь салаад хэсэг хэсгээрээ орших ба тэрээр нь бүгдээрээ бүрэн чуулсан нийлсэн байгааг модон тэрэг болох буюу гишүүд хурсан төдий нь л модон тэрэг мөн билээ.

Хоёрт: Ам авахтай /нотлол/ харшлах нь: Энд манай аймгийн бодит өгүүлэгчээр гишүүнт гэж байхгүй гишүүд хурсан төдий ч нэгийг үздэг.

Түүгээр бодвол гишүүн ч байхгүй болох. Гишүүнт байхгүй учраас чимээд хурсан чуулга болох модон тэрэг ч үгүй болно. Харин модон тэрэг нь өөрийн гишүүдийн цугласан, нийлсэн төдий нэгэн гэдгийг хориглохоор энэ багшийн болгоолоор ялгамжааг найруулах хэрэггүй. Чуулсан хурсан нь модон тэрэгний нэрийдлээр суурь мөн болой. Цогцос чуулсан нь "би"-гийн суурь мөн тул "би" гэж болохгүйг айлджээ.

Эсэргүүцэл: Хэдийгээр гишүүд цугласан, чуулсан тэр төдийг модон тэрэг гэж үзэхгүй ч гэсэн, тэдгээр гишүүдийн угсарч холбогдсон тэр үеийн ялгаамжаатай хэлбэрийг модон тэрэг хэмээнэ

Хариулт: Үүнийг чинь дээр номносон мэт гишүүнт өөрөө бий болоогүй үе гэж үзэх тул, гишүүдийн хэлбэр төдийг модон тэрэг гэж үзэх нь зохисгүй болж ам авсантай харшлах гэмүүд гарна. "Байхад ч" гэсэн үг нь чуулсан төдий нь ч модон тэрэг болохгүйгээр барахгүй гэсэн үг болой. Мөн тэр адилын хэлбэрийг модон тэрэг гэж үзвээс гишүүн тус тусын хэлбэрүүд ч болж болох, эсвээс гишүүд нийлж чуулсан хэлбэр нь модон тэрэг болж таарна. Эхний дагуу гэвэл угсрах үеийн хэлбэрээс ялгаагүй хэлбэр мөн үү, эсвэл урьдын хэлбэртэй адилгүй өөр нэгэн хэлбэр байх уу. Эхнийхээр гэвэл: *"Орохуй"-гаас:*

Түүний хэлбэр нижгээд нижгээд урьд байсан адил болох ба
Хэрхэн модон тэргийг оноход ч тэр адил болох тул
Салж тарсан тэдгээрийг юу гэж хэлэх
Тийм бөгөөс модон тэрэг буй бус аа хэмээн буруу болохыг үзүүлжээ.

Эхлээд жигдлээгүй байгаад хожим үеийн тэрэгний толгой зэргийн хэлбэрүүд нь хоорондоо адилгүй байх ялгаа гарахгүй болно. Иймээс салгах үед ч модон тэрэг байхгүй адилаар босгох үед ч модон тэрэг байхгүй байна. Хэрвээ урьд нь жигдлээгүй үеийн тэрэгний толгой тэргүүтнээс хожим жигдэлсэн гишүүд нь урьдах үеийн гишүүдийн хэлбэр дүрстэй харилцан адилгүй ангид нэгэн гарсныг модон тэрэг гэвэл *"Орохуй"-гаас:*

Хэрвээ эдүгээ модон тэрэг болох энэ цагт
Модон тэрэгний толгой тэргүүтэн ангид хэлбэртэй болвоос
Үүнийг бариваас тэрээр буй бус болох
Тиймээс хэлбэр төдий ч модон тэрэг бус хэмээн гэм гарна.

Тэрэгний урд, хойд дугуй болон тэрэгний гол зэргүүдийн хэлбэрүүд нь харилцан адилгүй ялгамжаатай нэгэн байх аваас тэдгээр нь тухайлж мэдрэгдэх хэрэгтэй. Гэтэл хичнээн үзсэн ч тэр адилууд үл мэдрэгдэх учраас

урьдын хэлбэртэйгээ адилгүй хойно гарсан хэлбэр нь модон тэрэг болох нь таарахгүй ээ. Мөн гишүүн тус тусын хэлбэрийг тус тус модон тэрэг гэж үзэхгүй. Харин гишүүд чуулсан ерөнхий хэлбэрийг л модон тэрэг хэмээс гэвэл: *"Орохуй"-гаас:*

Алин таныхаар чуулсан огт байхгүй тул
Тэрхүү хэлбэр гишүүдийн чуулган бус болохоор
Алин юу ч үл болох түүнээ шүтэж
Энэхүү дүрсийг харна гэж хаанаас байх хэмээн айлдсан гэм гарна.

Энэ мэтээр чуулснаа шүтсэн хэлбэрийг модон тэрэг гэх нь таарахгүй ээ. Чуулсан нь "эдэт" болж эс бүтэх тул чуулснаа шүтэж хэлбэрийг сэжих нь таарахгүй. Учир нь нэрийдэн буй бүгдийн сэжих суурийг эдэт гэж ам авсан болой. Гишүүд чуулахад өөрийн мөн чанараар бүтсэн "өвөрчлөн" бусад "эд үгүй" нь өвөрчлөнгөөр байх аваас чуулсан гишүүд нь өвөрчлөн нэг болон тус тус хоёрын амь нэгнээс хэтрэхгүй байх ёстой. Тэдгээрийн алинаар үзлээ ч дээр модон тэрэг дээр номносонтой адилаар хорьж чадах билээ. Нэрийдэл буйгийн нэрийдэх сууринд эдэт буйг зөвшөөрдөггүй өөрийн ёсонд ч гишүүд чуулсан хэлбэрийг модон тэрэг мөн гэж үздэггүй. Тиймээс чуулсан хэлбэрийг модон тэрэг мөнийг хорьсон хоригдохуун дээр ялгамжааг найруулах хэрэггүй болой.

Эсэргүүцэх нь: Хэрвээ үнэн бус чуулганыг шүтэж үнэн бус хэлбэр гэж сэжих нь зохисгүй зүйл биш л дээ.

Хариулт: Тэгвэл мунхаг, хөрөнгө зэрэг үнэн бусын шалтгаан нөхцөлд шүтэж хуран үйлдэхгүй ногоо зэрэг үнэн бус үр дагаврууд бүгдээр төрөх нь зохисгүй зүйл биш л дээ гэж үзэх хэрэгтэй. *"Орохуй"-гаас:*

Та үүнийг хэрхэн үздэг тэр мэтээр
Үнэн бусын шалтгаанд шүтэж үйлдээд
Үнэн бусын мөн чанар үр дагварууд бүгдээр
Төрөхийг мэдэж автугай хэмээн айлдсан мэт болой.

Модон тэрэгний энэхүү үлгэрээр дүрс тэргүүтэй найман тоос хурах төдийг хумх тэргүүтэй гэж агуулахыг ч арилгах мөн. Мөн найман тоос эдэт болж бүтсэн, хумх тэргүүтнийг сэжигдэх болоод хумх тэргүүтнийг эдэт болж бүтсэн дүрс тэргүүтэн ялгамжаат хэлбэр гэж үзэх явдлыг ч хорино. Дүрс тэргүүтнээ өвөрчлөн байхгүй учраас өвөрчлөнгөөр төрөх байхгүй тул эдэд бүтсэн гэх нь таарахгүй ээ. Тийм болохыг *"Орохуй"-гаас:*

Үгээр л дүрс тэргүүтэн тэдгээр вишай орнуудыг

Хумхыг барьсан ухаан хэмээвч, олох бус ямагт
Төрөх үгүй учир дүрс ч буй бус
Тиймээс тэдгээрийн хэлбэр ч зохисгүй хэмээжээ.

Шүүмж: Хэрвээ хумхыг модон тэрэг шиг өөрийн гишүүдээс бүрдсэн хэлбэртэй биш гэж үгүйсгэвэл, цүлхгэр ходоод зэрэг түүнийг илэрхийлэх шинж чанарууд нь үгүйсгэгдэх болно. Тэр хэлбэрүүд чинь түүнийг илэрхийлж байгаа биш үү?

Хариулт: Цүлхгэр ходоод, урт хүзүү зэргээр нь хумх мөн байна гэж таньж болно. Харин цүлхгэр ходоод зэргийн хэлбэр дүрсийг хумх гэж үзэхгүй л дээ. Хэрвээ тийн үзэх болвол, ходоод, хүзүү зэрэг нь хумх болох нь ээ дээ.

/2/ Тэр тухай тэмцлийг няцаах нь

Эсэргүүцэл: Энд "*бодит өгүүлэгч заримууд*": "Өвөрчлөн буй, үгүйг шинжих ухаанаар ийн номносон дагуу долоон зүйлийн үүднээс модон тэргийг эрэхэд түүнд олдохгүй болохоор модон тэрэг буй бус (байхгүй) болно шүү дээ. Тиймээс ертөнцөд модон тэрэг гэж нэрлэж томьёолох ч хэрэггүй болно доо" хэмээвэл, тэгж таарахгүй ээ. "Модон тэргийг авчирагтун, зарсугай, засагтун" гэх зэргийг үзэж харж л байна шүү дээ. Чингэвэл модон тэрэг зэргүүд чинь байгаа юм уу?

Хариулт: "*Орохуйн тайлбар*"-аас тэдгээр гэмүүдэд зөвхөн бодит өгүүлэгч нарт байх гэм хийгээд Өөрт байхгүй гэм гэсэн хоёр зүйлийг айлдсан бий. а/ *Зөвхөн бодит өгүүлэгч нарт байгаа гэмүүдийн талаар:* Таны ёсоор бол "модон тэргийг авчирахтун" гэх зэргээр үйлдэх ертөнцийн нэр томъёо хүртэл үгүйсгэгдэх хэрэгтэй болох нь ээ. Та бодит гэж тооцогдож буй юмсыг өвөрчилж буй, үгүйг шинжих ухаанаар лавтай ажиглаж тооцоод тэрхүү ухаанаар эрж хайх гээд ирэхээр тэд долоогийн алинд нь модон тэрэг олдоогүй бас бодит юмс орших бусад аргыг ч эс ам авсан болохоор "модон тэрэг" байхгүй болжээ. Өвөрчлөн буй, үгүйг эрэх ухаанаар эрэхийн цагт түүнд модон тэрэг олдоогүй болохоор нь модон тэрэг байхгүй юм байна гэх бодит өгүүлэгч нарын энэхүү тэмцлийг эдүгээ Төв үзлийг өгүүлэхийг хүсэгч нар ч төв үзэлтний ёс мэтээр үзэгдэнэ. Ингэж үзэгч нар нь нэрийдлийн хамаг ялгамжааг ухаараагүй гэмтэй болох нь эргэлзэлгүй байна. б/ *Өөрт байхгүй гэмийн талаар: "Орохуй"-гаас:*

Тэрээр тэр ямагт болж ертөнцөд
Долоон зүйлээр бүтээгүй боловч
Тийн шинжлэл бусаар эл ертөнцөд

Эдгээр нь өөрсдийн гишүүддээ шүтнэ гэж сэжигдэв хэмээсэн үгээр заажээ.

Түүний утга нь өвөрчлөнгөөр буй, буй бус эсэхийг ухаанаар эрэхэд долоон зүйлийн алинд ч модон тэрэг үл олдох тэр нь хоёр үнэн хоёуланд мөн билээ. Модон тэргийг долоон зүйлээр эрэхэд ухаанд олдохгүй гээд тэдгээрийг үгүйсгэж хаанаас болох билээ. Хэдий тийм байсан ч "модон тэрэг байна" гэж ам авах нь өвөрчлөнгөөр буй, үгүйг шинжих ухааны үүднээс агуулах бус аа. Тийнхүү нарийн ухаанаар шинжлэхээ орхиод жирийн ертөнцийн нэрийдэх, энгийн эрүүл саруул ухаан төдийгөөр онож болно. Тиймээс тэрээр модон тэргийг үзэхдээ өөрийн гишүүдэд шүтэж нэрийдэж буй болсон гэдгийг зөвшөөрнө шүү дээ.

Эсэргүүцэл: Егүзэр нарын тэрхүү нарийн ухаанаар шинжлэхэд "тэр ухаанд нь модон тэрэг олдохгүй учраас түүнийг "өөрийн мөн чанараас бүтсэн өвөрчлөн байхгүй" гэж үзэх хэдий ч түүний гишүүд нь өвөрчлөн чанартай байж болно шүү дээ.

Хариулт: Таны энэ бодол чинь "шатсан тээрэмний үнснээс ширхэг утас хайхтай" адил тул элэг доог болох вий.

Модон тэрэг буй бус болсон цагт
Гишүүнт нь үгүй, гишүүн ч үгүй

хэмээн айлдсан мэт гишүүнт нь үгүй болохоор гишүүн ч байхгүй болно шүү дээ. *Эсэргүүцэл:* Хэдий тийм ч тэр бол таарахгүй. Модон тэрэг эвдэрсэн байсан ч гишүүдээс чуулсан гэж бодогдох байдаг шүү дээ.

Хариулт: Тэр тийм биш л дээ. Урьд нь зөвхөн модон тэргийг харагч тэрээр тэрэгний толгой зэргийг хараад модон тэрэг гэж сэтгэдэг. Бусдаар бус модон тэрэг эвдрэх тэр цагт тэрэгний толгой зэргүүд чинь тэрэгтэй барилдахгүй болох учраас тэрэгний гишүүн ч бий болно. Тэр цагт гишүүнт болох модон тэрэг байхгүй тул модон тэрэгний гишүүн байхгүй болно. Тэр цагт модон тэрэгний гишүүн гишүүнт гэх хаана ч байхгүй. Гэвч толгой зэргүүд нь өөрийн хувь, хэсгүүдэд дулдуйлан гишүүнт болдог. Тэдгээр хувь хэсгүүд нь түүний гишүүн учраас гишүүд нь байхгүй үед гишүүд нь агуулагдаж чадахгүй билээ. *Мөн гишүүнт байхгүй үед гишүүн нь үгүйсгэгдэх эл утгыг: "Орохуй"-гаас:*

Модон тэрэг шатах цагт гишүүн үгүй болох үлгэр адил
Ухааны галаар гишүүд шатсан бол гишүүд үгүй болой

хэмээн айлдсан үлгэр тэр мэтээр мэдээрэй.

/3/ Нэрийн ялгааны үүднээс бүтээх ёсон

"*Орохуйн тайлбар*"-аас:

Энэ зүгээр ертөнцөд алдаршсан үүднээс модон тэрэг гэж нэрийдэхэд маш тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд болон түүний нэрийн ялгамжаа зэрэг ямар байх зэргийг нарийвчлан шинжлэлгүйгээр ертөнцөд алдаршсан үүднээс ам авч үйлдээрэй. Энэ буюу:

Тэрээр гишүүнт буюу хувь хэсэгт бөгөөд
Модон тэрэг түүнийг үйлдэгч хэмээн ардууд нэрлэх
Төрөлхтөн ард нь түүний хэрэглэгч болох буюу хэмээн айлдсан мэт буюу.

Чингээд модон тэрэг нь тэрэгний мөөр толгой зэрэг гишүүдэд буюу олон хэсгүүдэд харгалзаж "гишүүнт" буюу "хувь хэсэгт" хэмээн нэрийдэх утганаа агуулагдана. Тэрчлэн тэрэгний мөөр, толгой зэргийг чухал авах үйлд харгалзаж "үйлдэгч" болох ба "чухал авахуйд" нийт биедээ харгалзаж "чухал авагч" хэмээх нэрээр нэрийддэг. Манай аймгийн заримууд, гишүүн болоод хувь хэсэг хурсан төдий байна, түүнээс тусдаа үл тухайлагдах учир "гишүүнт" болон "хувь хэсэгт" болохгүй гэж өгүүлдэг бий. Мөн зөвхөн үйл л байна, үйлдэгч байхгүй гэх, чухал авахуйгаас (цогцос) тусдаа үл тухайлагдах учир чухал авахуй л байхаас чухал авагч байхгүй гэх зэргээр өгүүлэх тэдгээр нь ертөнцийн янагуухийг чанх буруугаар өгүүлэгч нар бөгөөд тийн мөн болвоос гишүүд зэргүүд ч үгүй болох учиртай.

Түүнийг болгоож *"Орохуй"-гаас*: "Ертөнцөд алдаршсан янагуухийг бүү эвдэхтүн" хэмээн айлджээ. Тиймээс "үнэхээр бүтсэн гишүүнт зэргүүд байхгүй учраар тийм гишүүн байхгүй байж болох ч", харин янагуух гишүүн байхын адилаар мөн тийм гишүүнт нь буй" гэж өгүүлэх нь хоёр үнэний ёсыг доройтуулаагүй ёсон болно.

/4/ Түүнээ шүтэж үзэл онолыг түргэн олох тус эрдэм

"Орохуйн тайлбар"-аас:

Ертөнцийн алив янагуух үүнийг тэр мэтээр нарийвчлан шинжилж байж "буй бус"ыг нь олж мэднэ. Харин шинжлэл хийхгүй бол жирийн алдаршснаараа л байх (ойлгогдох) учиртай. Ямар эрэмбэ зэргээр үүнийг нарийвчлан шинжилбээс бүтээлчин хүн маш түргэн тэр ямагт чанарын (хоосон чанар) гүн гүнзгий утгыг

мэдэх болох вэ?. Хэрхэн яаж ?

Алин буй бус болохыг долоон зүйлээр буюу
Хэдий буй хэмээсэн ч егүзэр бээр буйг үл олов
Түүгээр л тэр ямагтад амар хялбар орох тул
Энэ үест түүний бүтээсэн дагуу мэдэж аваарай

хэмээн энэхүү модон тэрэгний шинжлэл түүгээр тэр ямагт өвөрчлөн үгүйн гүн гүнзгий утгыг түргэн ухаарч болно гэж айлдсан нь маш их аньстай үзэгдэнэ.

Ийнхүү ахуй ёсыг тийн шинжигч егүзэр бээр "Хэрвээ модон тэрэг нь өвөрчлөнгөөр бүтсэн нэгэн болвол тийн бүтсэн нэг юм уу, эсвэл тус тусдаа байх учиртай" гэх зэргийн долоон зүйлийн үүднээс "өвөрчлөнгөөр байна уу, үгүй юу" гэдгийг ухаанаар эрж шинжих нь эргэлзээгүй. Хэдий тэр долоогийн аль нэгэнд олдох ёстой ч тэдгээрийн алинд ч олдсонгүй. Тэр мэтээр эс олдовч "модон тэрэг" гэх нэрийдэх утгыг хүчээр үгүйсгэж болохгүй гэж үзнэ. "Мунхагийн "нүдний цагаан" бууж, ухааны нүдийг харанхуйлсан зэргээс шалтгаалж л "модон тэрэг" гэж нэрийдэх төдий зүйл байгаа болохоос өвөрчлөнгөөр бүтсэн модон тэрэг гэж байхгүй" гэж ухаарсан егүзэр тэрбээр тэр ямагт чанарыг амар хялбар онох болно.

Энд "тэр ямагтыг" гэсэн үгээр янагуух утгыг ч үгүйсгэж болохгүй" гэснийг заажээ. Модон тэрэгнээ өвөрчлөн чанар байна гэдгийг хорих энэхүү долоон зүйлт эцсийн шинжлэлийн намба байдлын хувьд тодорхой, бас хорих ухаан нь бүр ч тодорхой тул үүнийг шүтвээс модон тэрэгний өвөрчлөн үгүй чанарыг хялбархан онох мөн. Товчилбоос, дээр номносон мэт модон тэрэг дээр жишээлж ийнхүү номноход гурван эрдэм буй:

1* Ном юмсыг өвөрчлөн буй гэж гүтгэж мөнхөд барих үзлийг хялбархан хорих эрдэм

2* Өвөрчлөнгөөр байхгүй гэхээр шүтэн барилдаж таарахгүй хэмээх тасархайд барих үзлийг хялбархан хорих эрдэм

3* Энэ хоёр эрдмээр хэрхэн ажиглах ёс дагуу үйлдэж бүтээлчин егүзэр бээр чухалчлан шинжих зэрэг болой.

1 Ном юмсыг өвөрчлөн буй гэж гүтгэж мөнхөд барих үзлийг хялбархан хорих эрдэм:* Нэг болон тус тусдаа төдийг хорисноор өвөрчлөнгөөр буйг хорих ёсыг маш их хураангуйлваас оноход бэрхтэй болно. Бас хэтэрхий

дэлгэрүүлбээс үг нь олон болох тул долоон зүйлээр шинжих маш таарсан нэгэн болой.

2 Өөрчлөнгөөр байхгүй гэхээр шүтэн барилдаж таарахгүй хэмээдэг тасархайд барих үзлийг хялбархан хорих эрдэм:* Анхлан хорихын үест хоригдохуунд ялгамжаа найруулж хорих тул түүний үүднээс өөрчлөнгөөр байхыг эвдэх хэдий ч нэрийдэх үйл үйлдвэр оршиход харшлах зүйлгүй болно.

3 Энэ хоёр эрдмээр хэрхэн ажиглах ёс дагуу үйлдэж бүтээлчийн егүзэр бээр чухалчлан шинжих эрдэм:* Түгээгдэхүүн өөрчлөн бүтвээс түгээгч нэг, тусгаар тэргүүтэн долоон зүйлээс үл хэтрэх магадлалыг олоод түүнээс цааш тэр нижгээд бүрт хорлол гараад ирсэн, тэр долоогийн чухам алинд нь хорлол буусныг шинж. Түгээгч эвдэрсэнээр түгээгдэхүүн ч эвдрэхийг эхэнд үйлдээд, өөрчлөн үгүй болохыг лавлан шийдэж олонтаа магадлаарай. Түүний дараагаар тэр мэтээр өөрчлөн үгүй ч модон тэрэгний нэрийдлийг мэлзэж болохгүйг үзээд "Аяа, үйл нисваанисын "Илбэчний үйлдсэн" модон тэрэг тэргүүтний энэ илбэ маш гайхамшигтай яа. Энэ адилууд нь өөр өөрийн үндэс шалтгаанаар өчүүхэн ч эрж хайлгалгүй төржээ. Өөр өөрийн мөн чанараас бүтсэн өөрчлөн өчүүхэн тэдий ч байхгүйн учир" хэмээн шүтэн барилдаж гарсан утга нь өөрчлөн үл төрөх юм шүү гэсэн магадлал олох болой. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас* ч:

Хумх тэргүүтнийг өөрийн шалтгаанаас энэ ямагт болон бүгдэд зэрэг таван зүйлээр тийн шинжихэд буй бус байдаг. Гэвч шүтэн нэрийдсэн зөгийн бал цуглуулах, ус уух, сүү барих, хураах зэргийн ижил үйл хийж болдог. Энэ нь сонин гайхамшигт биш гэж үү хэмээсэн ба Аливаа өөрчилж үгүйг тухайлагдах тэр нь эргэлдэх галын хүрд мэт өөрчлөн чанараар хоосон мөн болой хэмээн айлдсан мөн.

22

ӨӨРЧЛӨН ЧАНАР ҮГҮЙ БОДГАЛЬ

б/ Утгыг найруулах

/1/ Өөрчлөн үгүй ёсыг утганаа найруулах

/а/ "Би нь цогцостойгоо нэг" хэмээх згийг хорих

/б/ "Би нь цогцостойгоо тусдаа" хэмээх зүгийг хорих

/в/ Түүгээр үлдсэн зүгүүдийг ч эвдэх

/г/ Түүнээ шүтэж "бодгаль нь илбэ адил" гэж ухаарах

/2/ Нэрийн ялгамжааны үүднээс бүтэх ёсыг утганаа найруулах

2/ Түүнчлэн "минийх" гэдэг ч өөрчлөнгөөр байхгүй болохыг үзүүлэх

---оОо---

б/ Утгыг найруулахад хоёр:

/1/ Өөрчлөн үгүй ёсыг утганаа найруулах

/2/ Нэрийн ялгамжааны үүднээс бүтэх ёсыг утганаа найруулах

/1/ Өөрчлөн үгүй ёсыг утганаа найруулахад дөрөв:

/а/ "Би нь цогцостойгоо нэг" хэмээх зүгийг хорих

/б/ "Би нь цогцостойгоо тусдаа" хэмээх зүгийг хорих

/в/ Түүгээр үлдсэн зүгүүдийг ч эвдэх

/г/ Түүнээ шүтэж "бодгаль нь илбэ адил" гэж ухаарах

/а/ "Би нь цогцостойгоо нэг" хэмээх зүгийг хорих

Ер нь ямар нэг ном юмс нөхөр сэлттэй гэсэн бодол төгс таслагдаж ирэхээр "нөхөргүй юм байна" гэдэг бодол төрдөг. "Нөхөргүй юм байна гэдэг бодол төгс таслагдаад ирэхээр "нөхөр сэлттэй юм байна" гэдэг бодол төрдөг нь ертөнцөд ч байдаг. Энэ нь ерөнхийдөө нэг болон тус тусдаа, эсвээс нэг болон олон байхаас өөр гуравдагч этгээдийг үгүйсгэж байгааг харуулна. Нөхөр сэлттэй, нөхөргүй гэдэг бол нэг болоод олон мөн буюу. Ерөнхий нэг ба нэг бус хоёрыг лавлан шийдэхэд (оножи мэдэх) түүний өвөрмөц салаа болсон өөрийн мөн чанараар бүтсэн өөрчилж байх аваас нэг болон тус тусаас үл хэтэрнэ.

Тиймээс энэ "би" маань цогцостойгоо мөн чанараар бүтсэн нэг зүйл

үү. Эсвээс мөн чанараар бүтсэн тус тусдаа зүйл үү гэдгийг шинжих хэрэг. Эхлээд "би" болоод "цогцос" хоёр "өөрчлөнгөөр нэг болвол ямар хорлол гарах вэ? гээд бүтээлчин егүзэр бээр нэг болох зүгт чухам ямар хорлол гарахыг хайж олоорой. Энэ талаар Санжайжан багш бээр гурван зүйлийн хорлол гарна гэжээ. Үүнд:

1. "Би"- гээ байна гэж өгүүлэх нь утгагүй болох
2. "Би"-нь олон болох гэм гарах
3. Төрөх, түрдэх (эвдрэх) эдгээр буй.

1. "Би"- гээ байна гэж өгүүлэх утгагүй болох. "Би" болон цогцос хоёр нь нэг өөрчлөн чанартай гэвэл би гэж ам авах нь утгагүй. Цогцосын тоотой адил зүйл болж хувирна. Үлгэрлэвээс, "сар болон туулайт" хэмээхтэй адил. Үүнийг үндсэн билэгт ч айлдсан буй. */"Үндсэн билгийн"/ "Хориндолоодугаар бүлэг"-ээс:*

Чухал авагчаас (цогцосоос) ангид
Би байхгүй гэж үзэх цагт
Чухал авагч нь би мөн болох тул
Таны "би" чинь үгүй болох буюу хэмээжээ.

2. "Би"-нь олон болох гэм гарах. "Би" болоод цогцосууд нь өөрөвчлөн нэг болвол нэг бодгальд гэхэд олон цогцос байдаг шиг "би"-ч мөн олон болж болно. "Би" нэгээс цаашгүйтэй адилаар цогцос ч бас нэг болохын гэм гарна. *"Орохуй"-гаас ч*:

Хэрвээ цогцос нь "би" мөн болвоос
Тэрээр олон учир "би" ч олон болох хэмээжээ.

3. Төрөх, түрдэх (эвдрэх). "Хорин найм дугаар бүлэг"-ээс:

Хэрвээ цогцос "би" болвоос
Төрөх, түрдэх мөн болох хэмээсэн ба,

"Хорин долдугаар бүлэг"-ээс:

Чухал авагч нь "би" бус аа
Тэрээр төрөх, түрдэх мөн

хэмээн айлдсан бөгөөд чухал авагч гэдгийг бид цогцос гэж ухаараарай.

Асуулт: Ийнхүү "би"-гээ агшин агшинаа төрдөг, түрддэг гэхэд ямар гэм гарах вэ?

Хариулт: Энэ талаар *"Орохуйн тайлбар"*-аас гурван гэм гарахыг заажээ. Үүнд:

1. Төрөл дамжлагаа дурдан санах нь таарахгүй гэм
2. Үйлдсэн үйлийн шим барагдах гэж үзэх гэм
3. Үйлдээгүй үйлтэй учрах гэж үзэх гэмүүд гарна.

1. Төрлөө дурдан санах нь таарахгүй гэм. "Би" нь агшин агшинаар төрөх, түрдэх гэдэг өөрийн мөн чанараар бүтсэн төрөх, түрдэх болж таарна. Тиймээс урд, хойдын "би"-нүүд өөрийн бэлэг чанараар бүтсэн тус тусдаа зүйл болно. Тиймээс л тэр цаг "би бол Алайнү (Mandhatr) хэмээх хаан байв" хэмээн хэлж болохгүйд тулна. Учир нь Алайнү "би" болоод бурхан багшийн "би" хоёр өөр бэлэг чанараар бүтсэн тус тусдаа зүйл болно. Үлгэрлэвээс, "Лхайжэн (Devadatta) төрлөө санаж би Чоджэн (Yajnadatta) болон явжээ гэж өгүүлж болохгүйтэй адил буюу" Чингэлгүйгээр өөрийн бэлэг чанараар ангид тус тус бүтсэн ч урьд нь амсаагүй мэдэрхүй утгыг хойд төрөлдөө санах явдал харшлахгүй гээд Лхайжэнгийн амсахыг Чоджэн амсаж болохгүй зэрэг харилцан адилгүй учир шалтгааныг гаргах хэрэгтэй тул харин тийм зүйл олдохгүй байна.

Эд хөрөнгө, ногоо хоёрыг өөрийн бэлэг чанараар бүтсэн өөрчлөн гэж үзэх байна, үндэс шалтгаан, үр дагварыг ч ангид гэж үзэх тэр мэтийн үндэс шалтгаан, үр дагавар болно гэвэл галын цогоос харанхуй үүдэх зэргээр "бусдаас төрөх"-ийг хорьсон ухаантай адил болно. Харин тус тусдаа төдий нэгэн гэж үзвэл дээрхийн адилаар адилтгаж болохгүй. Тэгвэл тэр судраас: "Бурхан багш болоод Алайнү хоёрыг нэг гэж үзүүлсэн юм уу?" хэмээвэл, тэрхүү зарлигаар тус тус өөр үндэст болохыг хориглож бас нэг хүн гэж заагаагүй ажээ. Тиймээс тэр судраас: "Тэр цагт тэрээр өөр нэгэн байсан юм уу гэхэд, тийн бүү үзэхтүн" хэмээн айлдсан хэрэг гэж Чандракирти багш болгоожээ.

Тийн айлдаснаа эндүүрсэн нэгэн бээр: "Бурхан болоод тэдгээрийн урьд төрлийн бодгаль амьтнууд нэг болно доо. *"Судар"*-аас: "Урьд цагт би ийм байв" хэмээн нэг гэж айлдсан байна. Мөн хуран үйлдсэн болвоос агшин зуур эвдрэх учир нэг гэж болохгүй. Тэр хоёулаа мөнх болой хэмээн өгүүлэх нь урьд хязгаарт суурилсан дөрвөн буруу үзлийн эхнийх болно. Тэдгээрийг хориглож Нагаржуна багшийн *"Хориндолдугаар бүлэг"-ээс:*

"Би" өнгөрсөн цагт гарах хэмээн
Үйлдэх тэр нь үл таарах
Урьдын цагт алин гарсан

Тэр ямагт нь энэ төрөл бус болой

хэмээгээд тэр мэтээр болвол нэг төрөлдөө нэг амьтан зургаан зүйл амьтан болчихно.

Тэдгээрүүд зургаан зүйлийг зэрэгчлэн дамжин төрөл авна шүү дээ. Урьд, хойд бүгдээрээ мөнхийн нэг зүйл болоход хүрнэ. Тиймээс урьд, хойд тэдгээрийг өөрийн мөн чанараар бүтсэн тус тус зүйл гэж үзэхийг ч хорих учиртайг айлджээ. Үүнд "би"-д өвөрчлөн байх аваас тэрхүү урьд, хойд төрлүүд ч гэсэн өөрийн мөн чанараар бүтсэн нэг зүйл болж тэр цагт мөн болно. Бас өөрийн мөн чанараар тус тус болвол тэр цагт тасархай үзэлд хүрэх тул мэргэд бээр "би"-гийн өвөрчлөнг үл амлах болно.

2. *Үйлдсэн үйлийн шим барагдах гэж үзэх гэм.* "Би"-нь агшин нижгээд нижгээдэд өөрийн бэлэг чанараар бүтсэн төрөх, түрдэхийг үйлдэх болвоос урьдын "би"-гийн үйлдсэн үйлийн үрийг хойдын "би" нь эдэлнэ гэж үзэхийг дараа хорино. Энэ үед урьд хураасан үйлийн үрийг амсана гэж үгүй буюу үйлийг үйлдэгч эзэн үр амсахаасаа өмнө үхэх болохоор мөн "би" болоод "бусад" ч байхгүй болой. Урьд, хойдын бодит юмст өөрийн мөн чанараар бусдад ангид бүтэх гэж үгүй. Урьдах нь үрээ амсаагүй болохоор үрээ амсах гэж байхгүй байх хэрэгтэй. Үндэс нэг болохын хариуг ч сүүлд хорих тул үйлдсэн үйлийн шим барагдана гэдгийг хорьж чадахгүй.

3. *Үйлдээгүй үйлтэй учрах гэж үзэх гэм.* "Хэдий урьдын эзэн эвдэрч хойд эзэн үйлийн үрийг амсаж эдэлж болох тул үйлдсэн үйлийн шим барагдахад гэм гарахгүй" хэмээвээс, чингэвэл тэр үйлийн үрийг амсахын шалтгаан болсон үйлийг өчүүхэн ч хураагаагүй бодгаль бээр бусад бодгалийн хураасан үйлийн үрийг амсаж эдлэхэд хүрнэ. Өөрийн мөн чанараар бүтсэн бусад бодгалийн үрийг түүнтэй өөрийн мөн чанараар тусдаа бодгаль эдлэх учиртай болно. Тэр талаар *"Орохуй"-гаас:*

Гаслангаас нөгчөхийн өмнөх агшинд ч
Төрөх, түрдэхийн эзэн үгүй болсноор
Түүний үр үгүй болох биз
Бусдын хураасныг бусад нь идэх буюу хэмээжээ.

"*Орохуй*"-гаас бусад гурван гэмийг зарлигласан боловч зөвхөн өөрийн аймгийн үзлийг хорьсон бөгөөд энэ үест нийтэд нь хорьж байгаа тул гаргасангүй ээ. Тэрхүү хоёр ухааныг *"Хориндолдугаар бүлэг"-ээс:*

Хэрвээ энэ нь бусад болвоос
Тэр байхгүй ч гарах л мөн

Тэрчлэн түүнээ орших бөгөөд
Тэнд үл үхэх хүртэл төрөх буюу

Тасархай болж үйлүүд шим барагдах
Бусдын үйлдсэн үйлүүдийг
Бусдууд тус тус амсах
Эдлэх зэргээр хэтийдэх болюу

хэмээн үйлийн шил барагдах зэрэг хоёр гэмийн талаар Чандракирти багш айлджээ.

"Хэрвээ энэ нь бусад болвоос" хэмээсэн нь, "Урьд төрлийн үест "би" болоод одоо цагийн "би" хоёр нь өөрийн мөн чанараар бүтсэн тус тусдаа болвол" хэмээсэн ажээ. Тийм болвол урьдахтайгаа огт хамаарахгүй болж урьдын түүнтэйгээ шүтэлцэхгүй болно. Хумх урлахын цагт эвдэрэхгүйтэй адил хойд төрлийн "би" төрөхөд урьдын "би" нь эвдэрэхгүйгээр орших ба урьдах нь үхээгүй байхад хойдох нь төрж болно гэсэн утга гарч байна.

Эсэргүүцэх нь: Мөн урьд хойд төрлийн "би" нь өөрийн мөн чанараар бүтсэн тус тусдаа мөн боловч үйлийн шим барагдах, үйлдээгүй үйлтэй учрахын гэм гарахгүй л дээ. Нэг үндэстэй болно шүү дээ.

Хариулт: Өөрийн бэлэг чанараар тус тусдаа эс бүтсэн тул бүтээх хэрэгтэй гэсэнтэй адил сонсогдоно. Нэгэнт өөрийн мөн чанараар тус тусдаа болвол нэг байж ч таарахгүй. Үлгэрлэвээс, Жамба болон Нирвай гэсэнтэй адил болой. Энэ талаар *"Орохуй "-гаас:*

Тэр ямагтын үндэс буйгаар гэмгүй болчихвол
Урьд хэрхэн шинжих үест ч үндсэнд гэм болохыг номнов

хэмээсний урьд хэрхэн шинжих гэдгийг *"Түүнээс":*

Жамба нь Нирвайд шүтэх ёсууд нь
Бусдын болохын тул нэг үндсэнд багтааж болохгүй
Хэзээд өөрийн бэлэг чанараар тус тус болвоос
Тэдгээрийг нэг үндсэнд багтаах нь зохисгүй

хэмээн өөрийн бэлэг чанараар тус тусдаа бүтсэн бол хоёр тусдаа үндэс болох учраас нэг үндсэн нь гэж үзэж болохгүй билээ. *"Хорин долдугаар бүлэг"-ээс:*

Хэрвээ тэнгэр, хүмүүн ангид болвоос
Үндэс нь таарч болохгүй хэмээжээ.

Товчилвоос, өөрийн мөн чанараар бүтсэн тус тусдаа байгаа юм бол ахуй ёсыг шинжих ухаанаар шинжихэд тэсэж үлдэх ёстой. Тэрхүү ухаанаар нягтлан шинжихэд ч шинжилгээнд тэсэж үлдсэн бодит юмс тоосон төдий ч байхгүй байна. Тиймээс өөрийн мөн чанараар тус тусдаа байх урьд хураасан үйлийг хойноо амсана гэдэг нь тус тусдаа үндэстэй зүйл дээр ч гэсэн бүгдийг адилтгаж бас ялгаж салгаж чадахгүйд хүрэх тул энэ мэтийг хамаг үест мэдэж аваарай.

"Гэвч урьд цагийн амсан эдлэгч, хойд цагийн санагч хоёр нэг биш тул өөрийн ёсноо ч үндэс тус тус байгаатай адилаар урьд амссанаа санах, урьд хураасан үйлийн үрийг хойно эдлэх нь таарахгүй биз дээ" хэмээвэл гэмгүй ээ. Энэ үед нэг үндэст болоход харшлахгүй. Бусдын ёс нэг үндэст болохгүй учраас. Үлгэрвэлээс, тараг дүүргэсэн сүрлэн тагтай хувингийн таган дээр нэг тагтаа сууж байна. Тагтааны хөл тарагны саванд ороогүй байсан ч түүний хөлийн мөр гарсан байхыг харах (тагтаа орчихжээ гэх) адилаар, бодгальс бээр урьд төрлийнхөө тухайн цаг үед очдоггүй ч урьдын амссан зүйлээ өнөөдөр санахад ч харшлах юмгүй л дээ. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:*

Үндэс шалтгаан болон үр дагавруудыг энэ тэр гэх атгаглахыг огоорч шалтгааны ялгаагаар тодорхойлогдох хуран үйлдэхүйн үргэлжлэл нь зөвхөн мөнх бусад агуулагдах болохоор түүнийг "чухал авагч" нэрийдэлд орших "би"-гээр л төрлөө дурдан санана хэмээвээс зохист болой. Бодит юмс нь өөрийн мөн чанараар эс бүтсэн бөгөөд тэдгээрт тэр мэтийн намба байдалтай нөхцөл шалтгаан шадарлаж үлэмж их болно. Бусад нь болсноор таарахгүй зүйл байхгүй. Иймээс л өөрийн бэлэг чанараар бүтээгүй үндэс шалтгаан, үйл үйлдвэрийн ялгаа нь санаад багташгүй болохыг огоот сайн шинжилж үйлдээрэй. Энэ мэт тараг хадгалах гэрийн дээвэр дээр суух тагтааны хөл тарагтай хувинд ороогүй хэдий ч сүрлэн дээвэр дээрх тагтааны мөрийг хараад хэлэхтэй адил болой хэмээн айлджээ.

Дэлгэрэнгүйг "*Орохуй*"-аас олоорой. Эдүгээ утгыг шууд номносу. Тийнхүү "би" нь цогцостойгоо нэг гэж үзэхийг *"Хориндолдугаар бүлэг"-ээс:*

Хэрхэн чухал авах байгаа бол
Чухал авагч бий болох

хэмээн айлдсан үгээр их хорлолыг заажээ. Үнээ "эл бодгаль бээр энэ биеийг авсан болой хэмээх нэрийдэн үйлдсэнээр цогцоо чухалчлан авах мөн. "Би үүнийг авагч" болой гэх тэр хоёрыг нэг гэж үзвээс үйлдэх үйл болон үйлдэгч нар нэг болох учраас таслагч, таслагдахуун, хумх, шаварчин, гал,

түлээ, тэргүүтнүүд ч бүгд нэг зүйл болно. *"Хорьдугаар бүлэг "-ээс:*

Түлээ алин тэр нь гал болчихвол
Үйлдэгч болоод үйл нэгэн болох
Гал болоод модоор "би" болон
Чухал авагдах эрэмбэ бүхэн

Хумх, цэмбэ тэргүүтэнүүд хамтдаа
Бүгдээр нэгэн зүйл болно хэмээжээ.

"Орохуй"-гаас ч:

Авагч өөрөө авагдахуунтайгаа нэг байх зохисгүй
Чингэвээс л үйл болон үйлдэгч эзэн нэг болох хэмээжээ.

Энэ мэтээр "би"-нь цогцостойгоо нэгэн болвоос "би" гэж ам авах нь утгагүй болох, "би" нь олон болох, үйл үйлдвэр нэг болох, үйлдсэн үйлийн шим барагдах, үйл үйлдээгүйтэй учрах, төрлөө дурдан санах үгийг өгүүлэх зэрэг үл зохилдох зургаан зүйл гарах учир нэг гэж ам авч болохгүй нь ээ.

/б/ "Би нь цогцостойгоо тусдаа" хэмээх үгийг хорих

Асуулт: Ингээд "би" болоод цогцос хоёр өөрчлөн нэг биш гэж бодьё. Харин өөрчлөн тус тусдаа (ангид) болвол ямар гэм гарах вэ?

Хариулт: Энэ талаар *"Хориндолдугаар бүлэг"-ээс:*

Хэрвээ цогцоснуудаас ангид аваас
Цогцосны бэлэг чанар үгүй болно хэмээх гэмийг айлджээ.

Үүнд "би" нь цогцосноосоо мөн чанараар бүтсэн ангид зүйл болвол цогцосны бэлэг чанар нь төрөх, эвдрэх, орших гуравтай төгөлдөр болохгүй ээ. Үлгэрлэвээс, "Морь нь үхрээс тусдаа бүтсэн учраас үхрийн бэлэг чанартай төгөлдөр биш шүү дээ. Мөн байлаа ч тэрээр "би" гэж нэрийдэн сэжихийн суурь буюу "би"-д баригч атгагийн орон болохгүй нь ээ. Хуран үйлдсэн учраас. Үлгэрлэвээс, "Огторгуйн цэцэг буюу гаслангаас анлжирсантай адил"" хэмээн бусдад алдаршсан найруулгын *"Тодорхой үгт "*-ээс айлджээ. "Би нь төрөх, түрдэхийн бэлэг чанартай эс төгөлдөр болвол мөнх болно. Тэр цагт мөнх юм чинь урваж өөрчлөгдөхгүй, бас ямар ч үйл ажил үйлдэхгүй болно. Орох, буцахын аль нь ч болохгүй учраас"" хэмээн Санжайжан багш айлджээ. Мөн цогцосны бэлэг чанар нь дүрс болох зэргээр өөрчлөнөөр

тус тусдаа болвол тэр мэтээр бодогдох, зоригдох ёстой. Үлгэрлэвээс, "Бие нь сэтгэлээсээ тусдаа бодогддоггой адил. Тийн барих нь ч байхгүй учраас "би" ангид тусдаа утга алга" *"Хориндолдугаар бүлэг"-ээс:*

"Би" нь чухалчлан авагч (цогцосноос)
Ангид тусдаа зүйл бус аа
Хэрвээ ангид болвоос цогцос байхгүйд ч
Баригдах ёстой учир үл баригдах буюу хэмээжээ.

"Орохуй""-гаас:

Тэр мэт цогцосноос ангид "би" байхгүй
Цогцосноос ангид гэж түүнийг барьсан нь ч үгүй хэмээн айлджээ.

Тиймээс тэрсүүд нар цогцосноос ангид тусдаа утгат "би" байна гэж гүтгэдэг нь "би"-г нэрийн төрдийд ч үл ухааран цогцостой нэг байх нь зохисгүй гэж үздэг зэрэг нь тогтсон тааллын эрхээр гүтгэж байгаа хэрэг. Түүнээс бус тэдний үндсэнд буй нэрийдлийг мэдэх эгэл жирийн ухаанаар тийн үзэж байгаа биш л дээ.

Тэр мэтийн ухаанаар "би" нь цогцосноос өөрийн мөн чанараар нэрийдэлд байх цагт ч хорлол болохыг мэдэх баттай магадлал төрөн төртөл судлаарай. Нэг болоод тус тусын зүг хоёуланд хорлол гарах гэдэг сайтар магадлахыг эс олвоос бодгалиа өөрчлөн үгүйсгэж лавтай мэдэвч зөвхөн тангараг төдийд одох тул зөв үзэл онолыг олохгүй ээ. Тэр мэтээр бодгаль нь тэр ямагт чанараар бүтэх үү, эс бүтэх үү гэдгийг шинжлэхийг хүсээд бодгаль нь тэр ямагтад буй аваас нэг буюу тус тусдаа байхын шинжилгээг үйлдэнэ. Нэг гэж үзвэл, хамгийн дээд хорлол болох гол түлээ тэргүүтний үйлдэгч болоод үйл нэгэн зүйл болох энэ адилууд байна. Тэдгээрийг нэг гэж үзвээс ертөнцийн илт шалгадаг ухааныг хорих хэрэгтэй. Эсэргэлдэгч хоёрын нийт бусын тогтсон тааллууд хорлол болохгүй.

Ер нь тус тусдаа буй гээд тэр мэтээр байна гэвэл бие, сэтгэл хоёр шиг тус тусдаа үзэгдэх хэрэгтэй байтал "тэр мэт үзэгдэхгүй байгаа нь юун" хэмээн эгэл жирийн сэтгэлд баригдахгүй байгаа энэ нь хорлол болно. Нийт бусын тогтсон таалал нь хорлол болохгүй. Тиймээс тэр ямагтыг шинжихийн үест ч хамаг хорлол үйлдэгчийн туйлын ёзоор нь эсэргэлдэгч хоёрын эрүүл саруул, хорлогдоогүй нэрийдлийн сэтгэлд л тулдаг учир тэр цагт ертөнцийн хорлол байхгүй хэмээн айлдсан нь ч дээр номлосон мэт "тэр ямагт чанарт шалгадаг бус" хэмээсний болгоол мөн.

Тэр ямагт чанарыг шинжлэх үест хорлогдоогүй, нэрийдлийн сэтгэлүүдийг огт хорлолгүй гэж ч болгоосон биш л дээ. Хэрэв тийн бус бол тус тусын нийт бусын үзэл баримтлалууд нь хорлол болох нь гэж заах газаргүй болж, эшийг ам авсан, аваагүй гэх элдэв зүйлүүд гарна. Ам авсан байлаа ч магад гулзгай утгууд нь үл зохилдох учир тэдгээрийг ухаанаар бүтээх хэрэгтэй тул бусад ухаанаас аль нэгийг заана. Гадны этгээдийн ам авсан дээр үүнийг ам авсан бол үүнийг ч мөн ам авах хэрэгтэй хэмээсэн ба үүнийг ам аваагүй бол үүнийг ч мөн ам авах хэрэггүй зэргээр заана.

Тийн мөн болно гэхийн учир шалтгааны ухаан байхгүй бол хэрхэн магадлах билээ. Тиймээс хорлогч, бүтээгч бүгдийн язгуур эцэстээ тулна. Түүнтэй харш зүйлийг ам авахдаа өөрийн туршлагаас хорлолтой болохыг ухаарч түүнээс хэтрэхгүй байх нь Төв үзэлтэн бүгдийн ёс болой. Гэсэн хэдий ч нэрийдэх ухаанаар өөрчлөн байхгүй зэргийг нотлоход гэм гарахгүй ээ. "Дууг үйлдсэн мөн гэдгийг илт мэдлээр бүтээж болно. Гэвч мөнх бус болохыг нь илт мэдлээр бүтээх хэрэггүйтэй адил. Товчилвоос, бүтээн үйлдэгч болоод хорлон үйлдэгч хоёрын туйлын үндэс нь илт мэдэлд тулдаг ч язгуурын бүтээгдэхүүн нь илт мэдлээр бүтэх нь хаанаас заавал албатай байх вэ.

/в/ Түүгээр үлдсэн зүгүүдийг ч эвдэх

Өөрчлөн тус тусдаа байх аваас "хүрэл тэвшинд тараг байгаа мэт"-ээр цогцост "би", "би"-д цогцоснууд шүтэж байх бөгөөд шүтээн болоод шүтэгдэхүүн хоёр тал гарч ирнэ. Түүнээс өөрчлөн ангид байхгүй тул шүтээн, шүтэгдэхүүн хоёр байхгүй болохыг "модон тэрэг" дээр номносонтой адил болой. *"Орохуй"-гаас:*

Цогцос дор "би" буй бус, "би" дор ч
Цогцос тэдгээр буй бус тиймээс энд
Бусад ямагт байваас энэ гэж атгаглах уу
Бусад ямагт байхгүй учраас энэ гэж атгаглах хэмээнэ.

Би болоод цогцостой төгөлдөр байх зүгийг ч модон тэрэг дээр үлгэрлэн номносонтой адил түүний дагуу мэдэж аваарай. *"Түүнээс":*

"Би" болвоос дүрстэй төгөлдөр гэж үл үзэх
Учир нь "би" нь буй бус, тиймээс төгс утгыг найруулах
Бусдад зогдор төгөлдөр, бусад бус нь дүрс төгс болвоос

"Би" нь дүрсээс тэр ямагт бусад ямагт бус хэмээнэ.

"Зогдор төгс" гэвэл "Лхайжэн үхэр мал төгөлдөр" гэсэнтэй адил буюу. "Дүрс төгөлдөр" гэвэл "Лхайжэн дүрс лүгээ төгөлдөр" гэсэнтэй адил болой. Тэгвэл "Цогцосны хурах төдий" нь "би байна" гэвэл тэр ч бас таарахгүй л дээ. "Таван цогцосноо суурилж би гэж нэрийдэв" хэмээн айлдсан тул нэрийдэх суурь нь нэрийдсэн ном болж таарахгүй. *"Орохуй"-гаас:*

Цогцост шүтэх гэж судраас айлдсан
Тиймээс цогцосны хурах төдий нь би биш хэмээжээ.

Мөн цогцосны хураангуй төдий нь "би"–гийн чухал авагдахуун гэж үзвэл таван цогцос чухал авагдахуунд болох хэрэгтэй. Тэр мэт болвол цогцосны чуулган ч чухал авагдахуун болох хэрэгтэй шүү. Чуулган бол "би"-гийн нэрийдлийн суурь мөн. "Би" биш гэж ийн айлдахад ч цогцосны үргэлжлэлийг ч тэр мэт үзэх хэрэгтэй гэдэг нь тодорхой.

Эсэргүүцэх нь: Хэрэв тэдгээр нь "би" биш боловч, үлгэрлэвээс модон тэрэгний толгой, гол мод зэргийг угсрах үед онцлог ялгаатай нэг хэлбэр олоод л түүнийгээ модон тэрэг гэж нэрлэхтэй адил дүрс тэргүүтнийг нийлүүлээд онцлог ялгаатай хэлбэрийг "би" гэж үзэх үү?

Хариулт: Тэгвэл хэлбэр чинь зөвхөн дүрс болдог учраас сэтгэл зэргийг "би"гэж агуулахүйд хүрнэ. *"Орохуй"-гаас:*

Хэлбэр хэмээвээс, тэрээр дүрст байх учир
Тэдгээрийг та юунд би хэмээв
Сэтгэл тэргүүтний чуулган нь би ямагт үл болох
Учир нь тэдэнд сэтгэл буй бус билээ хэмээжээ.

Чингээд модон тэрэг маань өөрчлөн бүтсэн долоон намба зүйлийн алинд ч байхгүй билээ. Тийм боловч өөрийн гишүүддээ шүтэж л нэрийдсэн адилаар "би" нь ч гэсэн цогцостойгоо нэг болох буюу эсвээс тусдаа болох зэргийн долоон зүйлийн хаана ч байхгүй бөгөөд гагцхүү цогцост шүтэж нэрийдэхийн хувьд энэ хоёр адилхан байна. Тэр хоёрыг үлгэр утганаа найруулан сударт айлдсан дагуу үзүүлвэй.

/г/ Түүнээ шүтэж "бодгаль нь илбэ адил" гэж ухаарах

Илбэний утганаа хоёр зүйлийг айлджээ. Үнэмлэхүй үнэнийг илбэ адил гэж айлдсан дагуу "буй төдий" бүтсэн хэдий ч үнэн байхыг үгүйсгэх ба дүрс зэргийг илбэ адил гэж айлдсан дагуу өөрчлөнгөөр хоосон хирнээ дүрс зэргүүд үзэгдэх нь илбэ адил гэх хоёр зүйл буй. Эдгээрээс хоёрдах нь болно.

Хоёрдохоор эхний илбэ адилын утгат болно. Харин эхнийхэд удаах илбэ адилын утга байхын магадлал байхгүй. Хоёрдугаар утга бүтэхдээ үзэгдлээ барих болоод хоосноо ухаарсан хоёр ухаанд шүтэж илэрхийлэгдэнэ. Үлгэрлэвээс, илбийн морь, үхрийг үзэхдээ харааны мэдрэхүйгээр үзэж хараад үзэгдэж байгаа илбээ морь, үхэр чинь байхгүй гэдгийг дотоод мэдрэхүйгээрээ ухаарах зэрэгт шүтэн байж морь, үхэр гэж үзэж байгаа түүнээс илбэ буюу хуурамч үзэгдэл шүү гэх ойлголт төрдөгтэй адил. Түүнтэй адилаар бодгаль тэргүүтнийг нэрийдлийн сэтгэлээр эндүүрэлгүй үзэж харах ба түүнийгээ өөрийн мөн чанараас бүтэх өөрчлөнгөөс хоосорсон гэдгийг язгуурын ухаанаар магадлах хоёрт шүтэн байж л тэрхүү бодгалийг илбэ буюу хуурамч үзэгдэл гэдэг ойлголт төрнө.

Иймээс үүнд үзэгдэл байна гэдгийг язгуурын ухаанаар үл илэрхийлэгдэх, өөрчлөнгөөр хоосон чанар нь нэрийдлийн шалгадаг ухаанаар үл илэрхийлэгдэх тул өөрчлөн буй, буй бусыг эрэх язгуурын ухаан болоод дүрс тэргүүтнийг буй гэж барих нэрийдлийн ухаан гэж хоёр байх хэрэгтэйн учир энэ бөлгөө. Дүрс тэргүүтнийг илбэ адил гэж ургуулж бодохгүй байгаа нь тэдгээрийг барьж байгаа нэрийдлийн ухаан зөнгөөрөө орших бөгөөд түүнийг төрүүлэхийн арганд шамдах шаардлагагүй гэж үзэхтэй холбоотой.

Тиймээс тэдгээрт өөрчлөн байна уу, үгүй юу гэдгийг шинжих ухаанаар дахин дахин ажиглаж өөрчлөнг эвдлэх хатуу магадлалыг олж аваад тэндээсээ үзэгдэл ургахыг хараад илбэ адил юм байна гэж мэдрэнэ. Илбэ адил хоосон гэдгийг өөрөөр нотлох ёс байхгүй.

Язгуурын ухаанаар номт үзэгдэлд төрөх, түрдэхийн өөрчлөнг тийн таслах төдий хоосон чанарыг “огторгуй адилын хоосон чанар” ба өөрчлөнгөөр хоосон ч өөрчлөнт үзэгдэх дүрс тэргүүтний үзэгдэл ургахыг “илбэ адилын хоосон чанар” гэж урьдын мэргэд айлджээ.

Тэрчлэн эргэл мөргөл хийх, урин тоолох зэрэг явдал мөрийн зүгт орохдоо ч өмнө нь тэдгээрийн өөрчлөн байна уу, үгүй юу гэдгийг ухаанаар сайтар шинжлээд өөрчлөнг хорино. Тийн магдалсан ухааны үзүүрээр эзлэгдэж дээрх явдал мөрд орохдоо илбэ адилаар ургуулахад суралцах бөгөөд түүний агаараас тэдгээрийг үйлдэх болой.

Энэ учрыг мэдээд бясалгалд байхдаа “огторгуй адилын хоосон чанарыг” бясалгаж хожим бясалгалаас гарсан үедээ түүний хүчээр буюу илбэ адилын хоосон чанарыг ургуулах ёсыг сайтар мэдэж аваарай. Энд мөн дээр номносон мэтээр хоригдохууны хэмжээг сайтар барилгүй, нэг болон алив

тэргүүтнийг ухаанаар шинжлээд тэдгээрийн зөрчилтэй санагдаад ирэхээр бодгаль зэргийг ерөөс байхгүй гэх буюу бодгаль зэрэг бодит юмс "туулайн эвэр шиг" тус үзүүлэх хамаг бүгдээс хоосорсон гээд бодит юмсыг үгүйсгэх зэргийн бодол төрвөөс ихэд тасархай үзэлд хүргэдэг. Тиймээс түүнийг үнэн үзлийг эндүүрэх газар гэж ойлгоорой. *"Дөрвөн зуут"-аас:*

Хэдий тийн мөн боловч
Хэрхэн ертөнц илбэ адил бус хэмээснийг *"Дөрвөн зуутын тайлбар"-т:*

Шүтэн барилдаж гарсныг ёсчлон ухаарваас л илбэ мэт болсныг мэдэх болохоос "хүүсэр эмийн хөвгүүн" мэтээр ухаарахгүй.

Шүүмжлэх нь: Хэрвээ тийн шинжлэлгүйгээр төрөлхтөн бүгдийг үгүйсгээд, хуран үйлдсэн түүнээ төрөх байхгүй гэж үзүүлэхийг хүсэх үү?

*Хариулт: Т*эр цагт илбэ адил болж ч чадахгүй. Хүүсэр эмийн хөвгүүн" зэргээр шадарлаж хэмээвээс, шүтэн барилдаж гарсан нь үгүйсгэгдэж, хэтийдэх аюултай учраас түүнтэй тааруулж болохгүй ээ. Харин түүнтэй үл харшлах илбэ зэрэгтэй тааруулж үйлдээрэй хэмээн айлджээ.

Тиймээс өөрчлөн буй, үгүй эсэхийг эрэх язгуурын ухаанаар илбэ төдий утга байна гэж барихад ч гэмт болох уу. Тэр ухаанаар тийн шинжээд өөрчлөнг эвдсэний (үгүйсгэх) буйран дээр бодит юмсыг илбэ төдий утгатай орших гэж барих ойлголт төрөх тул гэм болохгүй. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:*

Тиймээс тэр мэтийг төгс сайтар шинжээд ирэхээр бодит юм өөрчлөн чанараар үл бүтсэн тул тус тусын бодит юмст илбэ адилын тэр ямагт тэр чанар ч үлдэж хоцрох болно хэмээн илбэ адил гэдэг утга л үлдэх учиртайг үзүүлжээ.

Мөн ногооны өөрийн мөн чанараар бүтсэн гэх өөрчлөнг үгүйсэх үед түүнийг онох ухааны хуран үйлдэхүй хэзээ үл доройтох тэр хүртэл таарах, эс таарах уу гэдгийг ухаанаар шинжихэд ногоонд өөрчлөн байна гэж барих бодол төрөхгүй. Гэсэн хэдий ч ногоонд өөрчлөн үгүй байгаа тэр нь үнэн гэх ба өөрчлөнгөөр хоосорсон үзэгдэл нь илбэ адил үнэн гээд ухаанаар хорих хэрэгтэй гэж үзвээс гэм гарна.

Тэдгээрийг үгүйсгэж илбэ адилын утга буй гэж барихдаа ч илбэ гэж барих илт шунал байх учир орхих хэрэгтэй гэж барих нь ерөөс уршиггүй. Хэрэв тийн бус болвоос шүтэн барилдахуйн магадлал бүгдээр ялгагдахгүйн их гэм гарахыг дээр номносон билээ. Энэ нь илбэ адилын утга орших болоод үнэнээр орших хоёрыг ялгахгүй байгааг эргэлзээгүй харуулдаг.

Мөн юмс үзэгдлийг шинжээд ухаанаар салгаад, ялгаад ирэхээр "байхгүй нь ээ" гэх санаа эхлээд гарч ирнэ. Цаашлаад шинжээчид ч тэр адилаар үзэж байхгүйг магадлагчид ч "байхгүй" болох тул алинд ч энэ нь мөн, тэр нь биш гэж магадалж үйлдэх газаргүйд хүрч эрээлжлэх мэтийн үзэгдэл ургана. Гэвч өөрчлөн буй, үгүй болоод (жирийн) буй, үгүй төдийг ялгалгүйгээр, бүгдийг ухаанаар хорьсоноо шүтэж гарсан мөн тул дээрх тэр адилын хоосон нь ч шүтэн барилдахуйг эвдэгч хоосон болно. Тиймээс тиймэрхүү атгагаас үүдсэн эрээлжлэх үзэгдэлд болж ургах нь ч илбэ адилын утга өрөөс бишээ.

Тийнхүү ухаанаар сайтар шинжих үед бодгаль тэргүүтэн өөрийн мөн чанараар бүтсэн орныхоо дээр өчүүхэн төдий ч сууж оршихгүй болой хэмээх ба түүнээ шүтэх эдгээр үзэгдэлүүд ч ээлжлэн ургах зэргүүд нь бэрхтэй бишээ. Төв үзлийн тогтсон таалалд сүслэн өөрчлөн үгүй ёсыг заасан номыг бага сага сонссон хэн бүхэнд тэр мэтийн зүйлүүд тохиолдолгүй яахав. Гэхдээ "хэцүү юм нь" өөрийн мөн чанараар бүтсэн өөрчлөнг үлдээлгүй эвдлэх ба өөрчлөн үгүй бодгаль тэдгээр нь үйлийг хураагч, үрийг эдлэгч тэргүүтэн болж агуулагдаж байгааг л ёзоор үндэснээс нь магадалж мэдэх хэрэгтэй юм. Тэдгээрийг агуулж байгаа "хоёр чуулган"-ыг хааяа нэг төдий (ховор) хураавал Төв үзлийг олоход маш бэрхтэй болно.

Тэр адил нэгийг эс олвоос, үзэл онолын ухаарал ихдэх болж явдлын зүгийн ухаарал хомсдоход хүрнэ. Мөн явдлын зүгийн улам ихсэх тусамд үзэл онолын чигийн ухаарал нь хомсдох нь эргэлзэгч тул хоёуланд нь хүчийг нь тэнцүүлэх их ухаарал төрөхийн аргагүй ээ. Тиймээс л ухаарахдаа ч өөрийн мөн чанараар бүтсэн гэж үзэн гүтгэх, мөнхөд барих, бодит юмсын буй гэж үзэх зэрэг үзлийн хязгаарт унадаг. Мөн бодит юмс тус үйлдэх бүхнээсээ хоосорсон гэж үзэх басамжлах, тасархайд үзэх, бодит юмсын буй бус (үгүйсгэх) гэж үзлийн хязгаарт унах бий. *"Бясалгалын хаан судар"-аас:*

Тэр цагт нүгэлгүй арван хүч төгөлдөр
Ялгуусан тэрээр бясалгалын дээд үүнийг номнов
Орчлонгийн амьтан зүүд мэт буюу
Үүнээ төрөх үгүй хэнд ч түрдэх үгүй

Амьтан хүмүүн амь насаа ч үл олох буюу
Энэ номууд нь хөөс, зэгс адил (хоосон)
Илбэ адил, бас огторгуйн цахилгаан адил
Усны саран мэт бас зэрэглээ адил буюу

Зарим хүмүүн энэ ертөнцөд үхэвч
Нөгөө ертөнцөд шилжих ба

Амьтан үгүй ч үйлдсэн үйл нь хэзээ ч үл барагдах
Ертөнцөд ч хар цагаан үйлийн үр боловсрох

Мөнх ч бус, тасархай ч бус буюу
Үйлийг хураах нь үгүй ба орших нь ч үгүй
Түүнийг үйлдээд мэдрэхгүй нь үгүй
Бусдын үйлдсэнийг эдлэх гэж ч үгүй

хэмээн үхэл егүүтгэсэн бодгалийг ухаанаар эрээд олохгүй ч илбэ адилын ном юмс дээр хар цагаан үйлийн үрүүд гарах бөгөөд үйлийг үйлдсэн бол үрийг нь хүртэж амсахгүй байхын учиргүй, бусдын үйлдсэн үйлийн үрийг бусад бодгалиуд амсаж, эдлэх зэргээр үйлдээгүйтэй учрахгүй байх зэргийг айлдсан тул ухаарч аваарай.

Тэрхүү ухаарлыг олж авахдаа дээр номносон дагуу ухааны хоригдохууны ерөнхий байдлыг ургуулж аваад өөрийн үйлдсэнд байгаа мунхагаар өвөрчлөнг хэрхэн гүтгэж байгаа зэргийг сайтар тунгааж таньж бариарай. Улмаар тэр мэтийн өвөрчлөн байх аваас нэг болоод ангидаас үл хэтрэх ёс болон тэр хоёуланг ам авбал хорлол (зөрчил) ирэх ёсыг ялгаж тухайлан санаад хорлолыг таньж мэдсэн ухаарлыг "татаж авчирна". Эцэст нь "бодгальд өвөрчлөн өчүүхэн төдий ч байхгүй болой" хэмээн баттай ухаарч, хоосон чанарын зүгийн энэ мэтээр олонтаа судална.

Чингээд бодгалийн нэрийдэл утгыг мэлзэлгүйгээр ухсаны оромд ургах бөгөөд тэрээр үйлийг хураагч, үрийг эдлэгч болж агуулагдах шүтэн барилдахуйн зүгүүдийг сэтгэж үйлдэнэ. Хэдий өвөрчлөн байхгүй ч шүтэн барилдаж таардаг ёсыг ч ухаарч ойлгоно. Тэр хоёрыг харш гэж үзэхийн цагт "Хөрөг дүрс" зэргээр үлгэрлэн үл харшлах учрыг "бүхнээс хоосорсон хэдий ч" нүүр царай, толь зэрэгт дулдуйдаж төрдөг. Зарим нэг нөхцөлүүд буцахын цагт хоёр эвдрэлд (хязгаар) үл чадагдан, суурь зохилдон хурахтай адилаар бодгальд өвөрчлөн тоосон төдий байхгүй ч үйлийг хураагч, үрийг эдлэгч, урьдын үйл нисваанис зэрэг шүтэн төрөх нь харшлахгүй хэмээн бодоорой. Энэ мэтийг энэ адил бүгдийн үест тийн мэдээрэй.

Асуулт: Чингэвэл хөрөг дүрс зэрэг эдгээрийг хаанаас ч харвaас хоосон гэх энэ ухаарлаар тэдгээрийн өвөрчлөн үгүйг ухаарчихдаг бол эгэл ардын илт мэдрэхгүйгээр ч өвөрчлөн үгүй болох нь ээ. Тэгвэл тэд хутагт болно шүү дээ. Ухаарахгүй гэвэл тэд чинь яаж өвөрчлөн үгүйг заасан үлгэр болох билээ. Тэдгээр үлгэрүүдийг ч өвөрчлөн үгүй учирт шүтэж ухаарах хэрэгтэй. Тэр үлгэрүүд юуг агуулж илэрхийлж байна гэдгийг шинжих учраас хязгааргүй

олноор дамжуулах хэрэгтэй бус уу?

Хариулт: Энэ талаар урьд нь заримууд бээр: "Хөрөг дүрс зэргийг өөрчлөн үгүйг илт мэдрэхүйгээр оножболох ч хутагт болохгүй л дээ. Учир нь ойр зуурын номтын хоосон чанар төдийг л оносон хэрэг. Хутагт болоход хамаг ном юмсын өөрчлөн үгүйг илт онох хэрэгтэй билүү" гэж өгүүлэх боловч энд таарахгүй буюу. *"Дөрвөн зуутын тайлбар"-аас:*

Нэгэн бодитын үзэл алин тэрээр
Бүгдийн үзэл гэж өгүүлэгдэх
Нэгийн хоосон чанар алин тэрээр
Бүгдийн хоосон чанар мөн

хэмээн нэг номын өөрчлөн үгүй хоосон чанарыг оносноор Ном бүгдийн хоосон чанарыг онож чадахыг айлдсан учиртай. Тиймээс хөрөг дүрс нь нүүр царайгаар хоосон гэдгийг ухаарснаар нүүр царай гэж үнэнд барихгүй ч дүрс хөрөг нь үнэнд буй гэж барихад харшлах юу байх вэ? Дохио мэдэхгүй балчир нялхас нүүрний хөрөг дүрсийг үзээд түүгээр тоглох наадах зэргээр үйлдэх нь нүүрээ үнэн (дотроо) байна гэж бодсоных. Харин дохиог судалсан өтгөс бээр тэнд нүүр байхгүй, нүүр царайгаар хоосон гэж ойлгоно. Нүүр царай гэж харагдаж буй тэрхүү дүрс хөргийг өөрийн чанараар бүтсэн буй гэж үзэж байгаа нь үнэнд барьж байгаа нь тэр.

Түүнийгээ өөрийн үндсэнд байна гэж мэдэрсэнээр бүтэх болой. Тийм боловч өөрчлөн үгүйн жишээ болсон нь алинд үзсэн ч тэрээр мөн чанараар хоосон байдаг. Хаана үзсэн ч өөрчлөн үгүй байдаг нь илтээр бүтсэн тул түүнийг үлгэрлэж авсан мөн. Алин харсан тэр өөрчлөнгөөр хоосон гэдгийг ногоо тэргүүтний дээр шалгадгаар бүтээхдээ ногооны өөрчлөн үгүйг оносон байх тул дүрс хөрөг зэргүүдтэй адилүй. *Иймээс:*

Хумх тэргүүтэн эдгээр тэр ямагтад үгүй ч
Ертөнцөд машид алдаршин буй мэтээр

хэмээн хумх тэргүүтнийг өөрчлөн үгүйн жишээ болгож бодит өгүүлэгчид байгуулсан ч хөрөг дүрсийн адил ойр зуурын хоосон чанар мөн болохоос тэдгээрийн өөрчлөн үгүй нь биш л дээ.

Модон тэрэг зэрэгт өөрчлөн чанар байхгүй болохыг дээр олонтаа айлдсан бий. Тэрчлэн илбэ үзэгч зарим хүмүүс илбийн морь, үхэрийг үнэн гэж үзэх боловч илбэчин хүн нь морь, үхэр нь худлаа гэж мэддэг нь ойр зуурын хоосныг мэдэж буй хэрэг. Зүүдэнд сав шимийн юмс зүүдлэгддэг ч сэрээд ирэхээр нөгөө харж үзсэн зүйл маань хоосон хуурмаг зүйл болохыг мэдэрдэг. Унтаж байх үест алин тэр барьж байгаа зүйл болох зүүдний эр,

эм тэдгээр нь түүнээс бусад эрэгтэй, эмэгтэйгээс хоосон гэж барих хэдий ч зүүдний аранши́н байхгүй гэдгийг мэдэрч байгаа бус аа. Үлгэрлэвээс, дүрс хөрөг зэрэгт нүүр царай байхгүй гэж магадлахтай адил. *Дээрхээс:*

Илбэ зэрэглээ зэрэг нэрийдсэн алин
Тэдгээр ертөнцөөс гэтэлсэн нь буй бус

хэмээн эш авсан мэт зэрэглээ, илбэ, зүүд, ус, үхэр, морь, эрэгтэй, эмэгтэй байна гэж барихад ердийн нэрийдлийн шалгадгаар хорлогдоно. Тиймээс тэдгээрийн шунан барих мэт утгагүй гэж мэдэж байгаа нь өөрчлөн үгүйг онож буй үзэл биш ээ. Тэр мэт дээр номносон илбийн утга тэдгээрийг судрын аймгийн гүн гүнзгий үгсэн тасалбарын эгшгээр хэлэндээ өгүүлэн санаарай. Үүнийг *"Бясалгалын хаан судар"*-аас айлдсан дагуу үйлдсүгэй. *Ийн өгүүлрүүн:*

Хэрхэн зэрэглээ, гандирсын балгад,
Илбэ, зүүд тэр мэтээр адилтгаж
Шинж байдлыг бясалгахад мөн чанараар хоосон тул
Хамаг ном юмс бүгдийг тэрчлэн мэдэхтүн

Хэдий тунгалаг огторгуйд ургасан саран
Түүний дүрс хөрөг тунгалаг далайд үзэгдэхэд
Саран усны дотор шилжсэн бус
Ном юмс бүхний бэлэг чанарыг тэр адилд мэдэхтүн

Хэрхэн ой шугуйд одох хүмүүсийн
Дуу дуулах, ярих хөөрөх, тоглох, уйлах зэргийн
Цуурай сонсогдовч үзэгдэх үгүйн адилаар
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн
Дуу хөгжим болоод уйлах цурхирах
Тэдгээрт шүтэж цуурай төрөх ч
Дуунд нь тэрхүү эгшиг хэзээ ч буй бус
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн

Хэрхэн зүүдэндээ хүслийг шүтэвч
Сэрээд ирэхэд хүмүүнд үл үзэгдэх буюу
Нялхас машид хүсч, дурлаж шунах
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн

Илбэ үзүүлэгч нар дүрсийг хувилгаж
Морь, үхэр, модон тэрэг элдвийг үйлдэх

Хэрхэн үзэгдэх тэр адилын юу ч үгүй буюу
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн

Хэрхэн залуу бүсгүй зүүдэндээ
Хүү төрлөө, бас өнгөрөв гэж зүүдлэхдээ
Төрлөө гэж баярлах, үхлээ гэж уйлах буюу
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн

Хэрхэн шөнө усанд туссан саран
Тунгалаг агаад булингаргүй усан дотор үзэгдэх
Усны саран хоосон агаад баригдах үгүй буюу
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн

Хэрхэн хаврын өдрийн хугаст
Ангаж цангаж энэлэх амьтан
Зэрэглээт усан мандал буй гэж үзэх буюу
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн

Хэзээд зэрэглээ учир ус үгүй байтал
Мунхарсан амьтан түүнээс уухыг хүсэх
Хуурмаг усыг ууж чадахгүй буюу
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн

Хэдий чийгтэй зэгс модыг
Шимийг хүссэн амьтан хөрөөдөвч
Гадна, дотно бүхнээ шимгүй буюу
Ном бүгдийг түүнчлэн мэдэхтүн хэмээжээ.

/2/ Нэрийн ялгамжааны үүднээс бүтэх ёсыг утганаа найруулах

Хэрхэн тэрэгний толгой зэрэгт дулдуйдан модон тэрэг гэж нэрлэх болохоор тэдгээр гишүүд нь чухал авагдахуунууд болж модон тэрэг өөрөө чухал авагч болохтой адилаар таван цогцос, зургаан язгуур, зургаан төрөн түгэхүйд дулдуйдаж "би" нь цогцос тэргүүтнийг авч үйлдэх үйлдвэрийг үйлдсэнээр үйлдэгч болж цогцос тэргүүтэн нь түүвэр авагдахуун үйл болно. *"Орохуй"-гаас :*

Тэрчлэн ертөнцөд алдаршснаар цогцос,
Язгуур, төрөн түгэхүй зургаад шүтэж
"Би" нь чухал авагч ямагтад тооцогдох
Чухал авах үйл энэ нь үйлдэгч мөн хэмээжээ.

Ингээд модон тэргээр үлгэрлэн тэр ямагт чанарыг шинжлэхэд долоон зүйлийн алинд ч "би" тэр нь үл олдох тул өөрчлөн өчүүхэн төдий байхгүй ч ажиглалтгүй (ердийн байдлаар) янагуух үнэн дээр орших болой.

2/ Түүнчлэн "минийх" гэдэг ч өөрчлөнгөөр байхгүй болохыг зүүлэх

Тийнхүү өөрчлөн буй, үгүйг хайх ухаанаар "би"-гээ эрэхэд долоон зүйлийн алинд ч үл олдох тул тийнхүү "би"-д өөрчлөн чанар эвдрэх (байхгүй болох) тэр цагт "энэ чинь нөгөө "би"-гийн нүд тэргүүтэн болно" гэж ухаанаар хаанаас олдох билээ. Тийм болохоор "минийх" гэдэг маань ч өөрчлөн үгүй болох нь ээ. Бүтээлчид бээр "би" болоод "минийх"-ийн өөрчлөнг хэзээ ч үл (зорих) тухайлах болсноор орчлонгоос тийн гэтлэх болохыг номнох болой. *"Арван наймдугаар бүлэг"-ээс:*

Би ямагт нь буй бус болохоор
Минийх гэдэг хаанаас байх хэмээсэн ба,

"Орохуй"-гаас:

Алин хэзээд үйлдэгч үгүй бол үйл үгүй
Тиймээс "би" нь үгүй учир минийх буй бус
Тийнхүү "би" болоод "минийх"–ийг хоосонд үзсэнээр
Тэдгээр егүүзэрүүд тийн гэтлэх буюу хэмээжээ.

"Би"-д өөрчлөн байхгүй гэдгийг олох хүчээр л "минийх" гэсэн өөрчлөн үгүй онох болно гэдгийн сэжиг бодлыг таслан дээр өгүүлснээс мэдэж аваарай.

23

ӨВӨРЧЛӨН ЧАНАРААС ХООСОН БОДАС ЮМС

(Номын хоосон чанарыг онох)

3/ Тэрхүү ухаануудыг бусадтай найруулах ёсон
(б) Номын "би-үгүй"-г нотлон буулгах ёсон
1/ Өөрөөс төрөхийг хорих
2/ Бусдаас төрөхийг хорих
3/ Хоёулангаас төрөхийг хорих
4/ Шалтгаан нөхцөлгүйгээр төрөхийг хорих
5/ Дөрвөн хязгаараас төрөхгүйг нотлох
(в) Тэдгээр үзлийг дадуулснаар түйтгэрийг тэвчих ёсон

---oOo---

3/ Тэрхүү ухаануудыг бусадтай найруулах ёсон

Тэр мэт модон тэрэгний шинжлэлээр би болоод цогцосыг шинжлэхтэй адилаар хумх, цэмбэ тэргүүтэн бусдыг ч мэдэж болно. Хумх тэргүүтнийг өөрийн дүрс, хэлбэр зэрэгтэй нэг байна уу, ангид тусдаа байна уу гэх зэргээр шинжиж өвөрчлөн буй, буй бус эсэхийг эрэлцэх долоон зүйлийн ухаанаар эрэлцэхэд тэрээр нь хоёр үнэн алинд ч үл олдох бөгөөд харин үл ажиглах нэрийдлийн ухааны нигуурт агуулагдах мөн буюу *"Хутагтын гурван санваарыг үзүүлэхүй"-гээс:*

Ертөнц надтай тэмцэх, "би" ертөнцтэй үл тэмцэв
Ертөнцөд алин буй ба буй бус гэж үзсэн түүнийг тэр дагуу үздэг "би"

хэмээн айлдсан учир ертөнцөд алдаршсан ухааныг хориглоогүй гэдгээ аман гэгээнээрээ айлдсан учиртай. Мөн *"Орохуй"-гаас:*

Хумх, цэмбэ, гөрмөл, цэрэг, ой мод, эрхи, найлзуур мод
Гэр, байшин, модон тэрэг, хавцал, орон балгад зэрэг алин бодит юмс
Тэрчлэн алин төрөх хэмээн нэрийдсэн тэр бүхнийг онох бөгөөд
Алин хэзээд Чадагч тэрээр ертөнц лүгээ тэмцэл үл зохиов

Гишүүн, эрдэм, шунал, бэлэг чанар болон түлээ мод зэргүүд
Эрдэмт, гишүүнт, шунал зэрэг бэлгийн суурь зэргийн утгууд
Тэдгээрийг модон тэрэгний шинжлэлээр үзэхэд долоон зүйлээр олдохгүй ч
Түүнээс бусад ертөнцөд алдаршсаны үүднээс үзвэл буй билээ хэмээн

айлджээ.

Үүнээс үзвэл юуны ч үүднээс бай ертөнцийн төрөлхтөн түүний олсон (нэрийдсэн) утгууд нь зөвхөн шинжлэхүйгээр байж болохыг ойлгож аваарай. Тэр нь юу вэ хэмээвээс, гишүүн болоод гишүүнт тэргүүтэн буюу. Эдгээрийг хумх дээр үлгэрлэвээс, хумх нь гишүүнт, эрдэмт гэх нэрийдлийн суурь болно. Хайрга чулуу зэрэг нь гишүүн болно. Хөх өнгө зэрэг нь эрдэм болно. Цүлдгэр гэдэс, сэлбэгэр цорго, урт хоолой зэрэг нь бэлэг чанар болно. Цэмбэ зэрэг дээр энэ адилаар жишээрэй. Шунан тачаах нь үлэмж шунахын нэр ба тачаал шунал түүний суурь болно гэж шуналт бодгалийн *"Тайлбар номлол"*-оос номлов. Гал бол шатаагч. Түлээ бол шатаагдахуун. Тиймээс гишүүнд дулдуйдаж гишүүнт гэж нэрийдэж болно. Мөн галд дулдуйдаж түлээ, түлээнд дулдуйдаж гал гэж нэрийдэх хүртэл гэж найруулаарай. *"Наймдугаар бүлэг"-ээс ч:*

Үйлдэгч нь үйлд шүтэх бөгөөд
Үйл нь ч үйлдэгчид ямагтад (зэргээр)
Шүтэн гарахаас өөр бусад
Бүтэх үндэс үл үзэгдэнэ хэмээгээд

Үйлдэгч болоод үйлүүдээр
Үйлдэх бодасыг мэдээрэй

хэмээн айлдсан тул үйлдэхдэхүүн үйлдэгч болоод одох, одогч, үзэгдэхүүн, үзэгч шалгадаг, шалгагдахуун (мэдэгдэхүүн) зэрэг бүгдээрээ мөн чанараас эс бүтсэн бөгөөд инагш, чинагш харгалзан бүтсэн төдий гэдгийг мэдээрэй.

Тийнхүү "би" мэтийн нэг зүйл дээр хэрхэн шинжилсэнээр л өөрчлөнгөөр хоосон болоод өөрчлөн үгүй хэдий ч үйл үйлдвэр бүхэн таардаг хоёр үнэнийг агуулах ёсыг мэдээд түүнийг ном бүгд дээр найруулан бүгдийн өөрчлөн үгүйг амар хялбар оножи чадах тул дээр номносон үлгэр, утга хоёрын мадлалыг олж аваарай. Тэр талаар *"Бясалгалын хаан судар" –аас:*

Тийнхүү миний хур мэдэл хэрхэхийг
Болгоосон та тэрчлэн бүхнийг ухаанаар жишээрэй
Ном бүгд түүний мөн чанар нь
Асар арлисан огторгуй мэт мөн

Нэгээр нь бусад бүгдийг ч мэдэх
Нэгээр нь бусад бүгдийг онох

(б) Номын "би-үгүй"-г нотлон буулгах ёсноо тав:

1/ Өөрөөс төрөхийг хорих
2/ Бусдаас төрөхийг хорих
3/ Хоёулангаас төрөхийг хорих
4/ Шалтгаан нөхцөлгүйгээр төрөхийг хорих
5/ Дөрвөн хязгаараас төрөхгүйг нотлох эдгээр болой.

Ном (юмс) бол бодгаль гэж нэрийдэх суурь болсон таван цогцос, шороо махбодь зэрэг зургаан язгуур, нүд тэргүүтэн зургаан төрөл түгэхүй тэргүүтэн бөлгөө. Ном тэдгээрийн "би-үгүй чанар" бол өөрсдийн мөн чанараас бүтсэн өвөрчлөнгөөс хоосон чанар болой. Түүнийг нотлон буулгах ёсон олон боловч *"Орохуй"*-гаас "дөрвөн зүйлээс төрөхийг" хааж, бодас юмсын өвөрчлөн байхгүйг нотлон буулгасан тэр ямагтыг *"Тайлбар"*-аас "номын би-үгүй" гэж айлдсан тул энэ үест түүнийг товч хураангуйлан өгүүлсүгэй. *"Нэгдүгээр бүлэг"-ээс:*

Өөрөөс бус, бусдаас бус
Хоёулангаас бус шалтгаангүйгээс бус
Бодас юмс алин хаана байлаа ч
Төрөх гэдэг хэзээ ч буй бус хэмээжээ.

Гадаад, дотоодын ямар ч бодас юмс "би"-гээс төрнө гэдэг хаана ч, хэзээ ч байхгүй хэмээгээд тэрчлэн бусад гурван тангараг дээр ч найруулаарай. Ийнхүү "би"-гээс төрөхийг хэтрүүлэл үгээр хаахдаа тэр мэтээр тангарлавч түүний бүтээх үлгэр шинж зэргийг хэлэхгүй байвал тэдгээр тангаргаас буцах хорлол гарахыг үзүүлжээ. Энэ үест өвөрчлөнгөөр төрвөл шалтгаанд харгалзах эс харгалзах хоёрыг лавлан шийдэх хэрэгтэй. Шалтгаанд харгалзлаа гэхэд ч үндэс үр хоёр өвөрчлөнгөөр нэг үү, тусдаа юу гэдгийг лавлан шийдэх болой. Түүнд үндэс үр нь нэг мөн чанартай төрнө гэвэл өөрөөс төрөх ба өвөрчлөнгөөр тус тусдаа төрөх буюу бусдаас төрөх тэдгээрт өвөр бусад нижгээд нижгээдээс болоод "өвөр бусдын чуулган"-аас төрөх хоёр зүйл магадтай гарна. Нижгээд нижгээд байлаа ч өөрөөс төрөх ба бусдаас төрөх хоёр гарах тул дөрвөн зүйлээс төрөх төдий ч хорих ба бусад хязгааруудыг ч хорих учир нь тэр мэт бөлгөө.

1/ Өөрөөс төрөхийг хорих

Ногоо нь өөрийн мөн чанараас төрөх болвол төрөх нь утгагүй болно.

Төрөх гэдэг хаана юу болж төрөх түүнийхээ мөн чанарыг олдог ёстой. Ногоо өөрийн мөн чанарыг олчихсон байдаг шүү дээ. Үлгэрлэвээс,

Илт тодрох ногоотой адил хэмээвээс
Төрөх нь хязгааргүй болох бөгөөд
Төрчихсөн хөрөнгө дахин төрвөөс л
Тэр хөрөнгө нь дахин дахин төрөх хэрэгтэй болно

Тиймээс хөрөнгө төдий нэгэн үргэлж төрөхөд хүрэх тул ногоо тэргүүтэн төрөхийн чөлөө олдохгүй гэм гарна. *"Хорьдугаар бүлэг"-ээс:*

Шалтгаан үр нь нэг болвоос
Үйлдэгдэхүүн үйлдэгч нэг болох хэмээсэн ба,

"Орохуй"- гаас:

Тэр нь түүнээс төрвөөс эрдэм хэзээ ч буй бус
Төрөх зүйлүүд дахин төрөх нь зохистой бус
Төрчихсөн нэгэн дахин үнэхээр төрөхөөр болвоос
Тиймээс дахин ногоо төрөхийг эндээс үл олох хэмээсэн ба,

Тиймээс бодит юмс өөрөөс гарлаа гэж машид нэрийдэх үүнийг
Энд ямагтад болоод ертөнцөд ч зохисгүй болой хэмээжээ.

2/ Бусдаас төрөхийг хорих

Асуулт: "Гэсэн ч бусад (ангид) болох дөрвөн шалтгаанаас үр төрж болно гэж айлдсан тул бусдаас төрж болно биз дээ?

Хариулт: Өвөрчлөн тус тусын шалтгаанаас үр төрдөг болвол галын оч гэрэл ч зузаан харанхуйгаас төрж болох нь ээ. Бусад учраас. Мөн үндэс шалтгаан болох, болохгүй элдэв зүйлээс үр болох, болохгүй элдэв зүйл төрөх нь ээ дээ. Бусад чинь адил мөний тул хэмээжээ.

Түүний утга нь "ногооны хөрөнгөнд өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн байна" гэж ам авбал "тутарга будаа нь өөрийг нь төрүүлж гаргах учиргүй гал зэргүүдээс өөрийн мөн чанарын үүднээс өвөрчлөнгөөр тус тусдаа одох ёс" ба "өөрийн үндэс болох тутарга будааны хөрөнгөөс өвөрчлөн тусдаа одох ёс" хоёуланд хэзээд адил үзэгдэнэ.

Тиймээс тэр мэт эгүүсгэгч бусдаас өвөрчлөнгөөр тус тусдаа байдал ургахтай адилаар тутрага будааны өөрийн хөрөнгөөс тусдаа үзэгдэхийн үест ч тус тусдаа байх хувь нь тэр мэт үзэгдэнэ. Тус тусдаа үзэгдэх ёс тэдгээрийг өөрийн мөн чанарын үүднээс бүтсэн өвөрчлөн мөн болвоос гал зэргээс үл

төрөх ба тутраганы хөрөнгөнөөс бүтэх ялгамжааг хэзээ ч гаргаж чадахгүй.

Асуулт: Хэрвээ төрөх, эс төрөхийн ялгааг үйлдвэл өөрчлөн тус тусдаа байх тус тусын ёсон түүнд ялгаа гаргахтун хэмээн харшлана гэж заасан юм уу?

Хариулт: Тэр талаар *"Орохуйн тайлбар"-т*:

Хэрхэн эгүүсгэн үйлдэгч тутарга будааны хөрөнгө нь өөрийн үр болсон тутарганаас ангид тусдаа болвол тэрчлэн эгүүсгэгч биш болох ба гал, овъёос, арвайны хөрөнгө зэргүүд шиг ангид бусад болно. Хэрхэн тутарганы хөрөнгө болохгүй бусад зүйлээс тутарга будаа ургах адилаар тэрчлэн гал, овъёос, арвайн хөрөнгө зэргээс ч төрж болох нь. Мөн хэрхэн тутарга будаа нь түүнээс ангид хөрөнгөнөөс гарах тэр адилаар хумх, цэмбэ тэргүүтнээс төрж болох ч түүнийг үзээгүй билээ. Тиймээс ийм байж болохгүй ээ хэмээн тодорхой айлджээ.

Нэг няцлагатай (агуулгатай) "галын өмөг хүчит түгээл" түүгээр нотолно гэдэг нь эл багшийн таалал биш. Түүнийг няцаахад ч "галын гэрээс утаа гарах төдийгөөр гал байх төдий нь албатай" гэхийг "албагүй ээ" гэж хорихын үест номносон билээ. *"Хорьдугаар бүлэг"-ээс:*

Шалтгаан болоод үр дагавар тус тус болвоос
Шалтгаан болоод шалтгаан бус хоёр ялгалгүй болох

"Орохуй"-гаас:

Хэрвээ бусдад шүтэж бусад нэгэн гарах болвоос
Галын очоос ч зузаан харанхуй үүдэж болох
Элдэв зүйлээс элдэв зүйл төрж болох учир
Эгүүсгэн үйлдэгч бусаас тул үлдэх зүйл дээр ч бусад адил хэмээн айлджээ.

Тэр адилын хэтрүүлэл түүнийг нэг үндсэнд багтах, багтахгүй зэргийн хариултыг тавилгүйгээр өөрчлөн тус тусдаа ангид болвоос нэг үндсэнд багтаж болохгүй гэж дээр номнсонтой адил болно. Төрөх болоод эс төрөхийг магадалж үзсэн ч хариулж болохгүй л дээ. Нэрийдэлд тус тусдаа гэж ташилгүйгээр "өөрийн мөн чанарын үүднээс мэдэгдэхүүний дээр бүтэх нь магадтай гэж үзэх чинь хэрхэн таарах вэ?" гэдгийг шинжилж байгаа үе билээ.

3/ Хоёулангаас төрөхийг хорих

"Хоёулангаас төрнө" гэж өгүүлэгч нар нь шавар хумх нь шавраас төрдөг нь өөрөөсөө төрж буй хэрэг. Шаварчин зэргээс төрж буй нь бусдаас төрж буй хэрэг гэж өгүүлэх бий. Дотроо ч гэсэн "Лхайжэн бусад төрөл

тутамдаа ч зөвхөн амь голтой нэгнээс төрөл авах учраас Лхайжэн болон амь хоёр нь нэг болно. Тиймийн учир өөрөөс төрсөн мөн. Эх, эцэг болоод нүгэл, буяны үйлийн үр зэргээс төрсний хувьд бусдаас төрсөн болоно" гэж өгүүлнэ. "Зөвхөн би-гээс ч төрөх" байхгүй. "Зөвхөн бусдаас ч төрөх" байхгүй. Харин "Хоёул чуулснаас төрөх" гэх эдгээрийг дээр номносон ухаанаар эвдлэх бөгөөд "өөрөөс төрөхийн талыг" өөрөөс төрөхийг хорьсон ухаанаар хаана. "Бусдаас төрсөн" гэхийг бусдаас төрөхийг хорьсон ёсоор хаах болой. *"Орохуй"-гаас*:

Хоёулангаас төрөх нь ч
Ухааны мөн чанар биш гэдгийг номносон
Тэдгээр гэмүүд дээрээс бууж ирэх учир
Энэ нь ертөнцөөс нөгчигсөн тэр ямагтад ч байхгүй
Тиймээс тус тусаас төрж бүтэх нь үгүй болой хэмээжээ.

4/ Шалтгаан нөхцөлгүйгээр төрөхийг хорих

"Мөн чанараас төрнө" гэж өгүүлэгч (Локояата) нараас "линхуа цэцгийн үндэс ёзоор ширүүн боловч навч дэвүүр нь зөөлөн байхыг хичээж бүтээгчийг үзсэнгүй" гэх бий. Мөн заримууд "тогос зэргийг хараад өнгө зүс, хэлбэр дүрсийг хэн урласныг үзсэнгүй гэх ба тиймээс бодас юмс төрөхдөө "зөвхөн мөн чанараас гарна" гэж өгүүлдэг. Эдгээр нь таарахгүй л дээ. "Үндэс шалтгаангүй төрвөөс" нэгэн орон зай, нэгэн цаг орших төрөл нь хамаг л орон зай, цаг үед ч орших хэрэгтэй болно. Эсвэл ерөөс байхгүй байх хэрэгтэй болно. Энэ орон цаг "төрөх" ба энэ орон цаг "төрөхгүй" гэх тийм учир шалтгааны үндсийг байна уу, байхгүй юу" гэж үзэх шаардлага огт байхгүй. Тогосны отог хэрээнд ч байх хэрэг тохиох вий. Товчилвоос, нэгээс төрсөн бол хамгаас төрөх буюу эсвээс хэзээ ч төрж болохгүйд хүрнэ. Үрийг олохын тухайд ертөнцийнхөн үндэс шалтгаанд олонтаа шамдах хэрэггүй болох нь ээ. *"Орохуй"-гаас*:

Хэрвээ зөвхөн шалтгаангүйгээр төрөх нэгэн болчихвол
Тэр цаг бүгдээрээ үргэлжид бүгдээс төрөх бөгөөд
Үр гарахын тухайд энэ ертөнцийнхөн хөрөнгө зэргийг
Зуун зуун тоогоор хураах хэрэггүй болох хэмээжээ.

5/ Дөрвөн хязгаараас төрөхгүйг нотлох

Тэр мэтээр дөрвөн зүйлээс төрнө гэхэд зөрчил гарахыг ухаарч дөрвөн зүйлээс төрөхгүй нь гэдгийг ойлгоно. "Өөрчлөнгөөр төрөх нь байхгүй

байх албатай" гэх үүнийг дээр бусад хязаарыг хорихын үест номносон дагуу ойлгоорой. Ийнхүү бодит юмст өвөрчлөн чанар байхгүй хэдий ч нэг нь нөгөөдөө шүтэх нь магадтай. Үүнийг хэтрүүлэл үгээр илэрхийлэх үест түүний чадалд шүтэн жишиж мэдэх ухаан төрдөг билээ. Шууд тангараг бүтээх найруулга үг байхгүй. *"Орохуй"–гаас:*

Алины учир "би" болоод бусад болон хоёулангаас төрөх ба

Шалтгаанд харгалзахгүйгээр төрөх үгүй тул бодас юмс өвөрчлөнгөөс хагацсан хэмээн төрөхийн дөрвөн хязгаарт хорлол ирэхийг өгүүлсэн утгыг хураангуйлан айлджээ.

Энэ нь хэтрүүлэгчид байгуулсан үрийг шинжлэхэд шүтэж жиших ухаан хэрхэн төрөх ёсыг үзүүлсэн болно. Анхнаасаа гадаад эсэргэлдэгчдэд бусдад алдаршсан тэр мэтээр байгуулаагүй болно. Тийнхүү өвөрчлөнгөөр төрөхийг хориход шүтэж бодас юмсын өвөрчлөн байхгүйг ойлгож мэдэж авна. Бодит бус зүйл дээр өвөрчлөн байхгүйг мэдэхэд хялбар учир ном бүгд өвөрчлөнгөөр хоосон болохыг олох төв үзлийг амар хялбар олох болой. *"Хорьдугаар бүлэг"-ээс:*

Шүтэж гарсан алин бүхэн
Тэрээр мөн чанараар амарлингуй хэмээсэн ба,

"Орохуй"–гаас

Алины учир бодит юмст шүтэж машид гарсан тул
Эдгээр атгагийг нэрийдэж үл чадах
Тиймээс шүтэж гарсан энэхүү ухаанаар
Муу үзлийн тор бүхнийг таслах

хэмээн айлдсан мэт шүтэн барилдахуйн учирт шүтэж ногоо тэргүүтэн өвөрчлөнгөөр хоосон болохыг ухаарч мэдэх ёсны харшлах зүгийг тасалж ухаарахад тодорхой болгох үүднээс өчүүхэн өгүүлсүгэй.

Энд "Ногоо нь өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн үгүй буюу. Өөрийн шалтгаан нөхцөлд шүтэж гарах учир. Үлгэрлэвээс, дүрс хөрөгтэй адил" хэмээн бусдаас алдаршсан жиших ухаан төрөх болой. Үлгэрлэвээс, нялх хүүхэд нүүрнийхээ дүрсийг хараад нүд, чих энэ байна гэж үзэх нь тухайн тэр ухааны нигуурт л тийм байгаа хэрэг. Хэрхэн харагдаж байгаа нь жинхэнэ өөрийнх нь ахуй байдал биш шүү гэж барилгүй тэр харагдах юмс өөрийн ахуйн ёсоороо буй байх ёстой жамаараа оршино гэж боддог. Чингэж амсах ба үзэгдэх ном юмсыг тэр адилаар үзэх амьтан хүний ухааны

эрхэнд агуулалгүйгээр тэдгээр утгыг хэрхэн үзэж байгаа шигээ "өөрийн мөн чанарын үүднээс өөрийнхөө орон вишай дээр оршин суух ёстой" гэж үзэх нь "өвөрчлөн чанар байна гэх хэтийдэн хөөрөмших ёс" болно. Тэрхүү орны мөн чанар тэр адил нь өөрийн мөн чанараар болон араншингаар өөрийн эрхэт байхын утга мөн тул тэр адилаар байх юм бол бусад шалтгаан нөхцөлд харгалзах гэдэгтэй харшилна. Харшлаагүй гэвэл "бүтчихсэн хумх дахин шалтгаан нөхцөлөөс төрөхийн хэрэггүй гэж ам авах хэрэггүй болно". Тэр талаар *"Дөрвөнзуут"-аас:*

Алин шүтэж гарсан болвоос л
Түүнд өөрийн эрх үгүй болой
Энэ бүгд өөрийн эрхгүй бөгөөд
Тиймээс л "би" буй бус аа хэмээн айлджээ.

Түүний *"Тайлбар"-аас:*

Тэрээр өөрийн мөн чанар, араншин, өөрийн эрх бусдаас үл хамаарах ямагт бөгөөд өөрөөс бүтсэн болвоос шүтэн барилдаж гарахгүй болой. Гэвч хурсан бүгд шүтэн барилдаж гарсан билээ. Тийнхүү бодас юмс алин нэгнээ шүтэж гарсан болохоор тэрээр өөрийн эрхгүй болж шалтгаан нөхцөлд харгалзаж төрөх буюу. Энэ бүгд өөрийн эрхгүй бөгөөд тиймээс л ямар ч бодит юмст "би" буюу өвөрчлөн байхгүй билээ хэмээн айлджээ.

"Өөрийн эрхтэй байна" гэж өөрийн мөн чанараар бүтсэн гэж үзэх цагт тэрээр сэтгэлүүд бусдаас харгалзахгүй мэтээр үзэгдэх бол үзэгдэж байгаа шигээ утга нь бүтсэн байх ёстой. Гэвч бусад шалтгаан нөхцөлд үл харгалзах хирнээ түүнийг хорих болохоор өөрийн аймагт бүтээх хэрэггүй гэх буюу тэдгээрийг эвдлэгч Төв үзлийг олж чадахгүй тул вишай дээрээ өөрийн мөн чанарын үүднээс өөрийн босгож чадах авир ёсоо л "өөрийн эрх" гэж болно.

Тиймээс "өвөрчлөнгөөр хоосон" гэдэг утга нь тэрхүү өөрийн эрхтэй мөн чанараас хагацсанаар хэлж буй хэрэг. Тусыг үйлдэгч бодит бус үйлийг хэлээгүй юм. Шүтэн барилдаж гарсан учраас өөрийн эрхээс хагацах болой. "*Дээрх тайлбар"-ы*н төгсгөлд:

Өөрийн эрхээс хагацсан утга нь хоосон чанарын утга мөн. Хамаг зүйлийг бодитой байхгүй гэсэн утга бус болой хэмээжээ.

Тиймээс тусыг үйлдэгч бодит юмс байхгүй гэдэг үзэл нь илбэ адилын арилсан, эс арилсан шүтэн барилдахуй басамжилсан чанх буруу мөн

болой. Тийм өөрчлөн хаана ч үгүй болой. Тийм талаар "*Дээрх тайлбар*"-*ы*н үргэлжлэлд:

Тиймээс үүнээ шүтэн барилдаж гарсанаар үйлдэх бөгөөд, илбэ адилын хотол нисваанисаас сайтар тонилохуйн үндсийг басамжлах тул түүнийг үгүйсгэж үзэх үзэл нь чанх буруу болно. Өөрчлөн байхгүй атал бодитой гэж үзэх нь ч чанх буруу болой. Тиймээс л бодит юмсын өөрчлөн байна гэж гэж өгүүлэгч нарт шүтэн барилдахуй байхгүй гэхийн болон мөнх, тасархайн үзлийн гэм гарах хэмээн айлджээ.

Тиймээс мөнх болоод тасархай үзлээс салахыг хүсвээс өөрчлөн үгүй болон илбэ адилын арилсан, эс арилсан шүтэн барилдахуйг андгайлах хэрэгтэй.

Эсэргүүцэл: Хэрвээ өөрийн эрхтэй мөн чанарт тусыг үйлдэгчийг шүтэн барилдахуйгаар хааж өөрийн эрхээс хагацсаны шүтэн барилдахуйн утга гэвэл та биднийг юугаар хорих билээ. Та ч гэсэн өөрөө тусыг үйлдэгч шүтэн барилдахуйг зөвшөөрдөг шүү дээ. Тиймээс танай, манай хоёрт ялгаа байхгүй биш үү?

Хариулт: Та нар шүтэн барилдахуйн учир шалтгааныг зөвшөөрч нялхас толин доторх нүүрний тусгал дүрсийг нүүр гэж үнэнээр боддогтой адилаар тэрхүү шүтэн барилдахуйгаа өөрийн мөн чанараар бүтсэн гэж гүтгэж, бодит юмсыг өөрийн мөн чанартай гэж өгүүлэх нь шүтэн барилдахуй ч ёсчлон ойлгоогүй ёс бусаар өгүүлж буй хэрэг. Бид нар өөрчлөнгөөр байхгүй гэж үздэг бөгөөд мөн тэр адилаар өгүүлдэг тул үгээрээ ялгаатай. Тэр талаар "*Дээрх тайлбар*"-*ы*н үргэлжлэлд:

Асуулт: Хэрвээ өөрийн эрхгүй байна гэдэг утга нь шүтэн барилдахуйн утга мөн бол гээд таны бидэнд хорлол болдог зүйлүүдээр танай, манайд ялгаа юу байна вэ? *Харулт:* Номносугай. Таны шүтэн барилдаж гарсан гээд байгаа амин утга чинь ёсчлон оонож өгүүлэхээ мэдэхгүйн ялгаа байна. Хэрхэн нялхас балчирууд (нэрийдлийг эс судалсан) дүрс хөргийг үнэнд барьж үлэмж гүтгэн хөөрөмшсөнөөр ёсчлон орших хоосон чанарыг үгүйсгэж, өөрчлөн чанартай гэж атгаглахаас болоод дүрс хөргийг оонож чадахгүйтэй адилаар, Та ч гэсэн шүтэн барилдахуйг ам ававч дүрс хөрөгтэйд адил шүтэн барилдаж төрсөн өөрчлөнгөөр хоосон чанарт боловч өөрийн мөн чанараар хэрхэн оршдог жамтайг ойлгож чаддаггүй. Өөрчлөнгөөр байхгүйг өөрчлөнгөөр байхгүй гэж барьж чаддаггүй билээ. Огт байдаггүй өөрийн мөн чанарыг өөрийн мөн

чанартай гэж үлэмж гүтгээд барьдаг билээ. Өчүүхэн ч үл мэдэх буюу Өвөрчлөн үгүй гэж үл өгүүлэх учир Бодит юмсын өөрийн мөн чанартай гэж өгүүлэх болой хэмээжээ.

Учир шалтгааны шүтэн барилдахуйг амлахдаа адилхан ч өвөрчлөнгөөр үгүй гэх, өвөрчлөнгөөр буй гэж өгүүлэхийн үүднээс шүтэн барилдахуйг ёсчлон онох, эс онох ба өчүүхнээ мэдэх, эс мэдэхийн ялгаагаар ийн үзүүлснээр тусыг үйлдэгч бодит юмсыг ам авбаас бодит өгүүлэгч нар нь түүнийг үнэнээр бүтсэн хэмээн өгүүлэгч гэнэ. Тиймээс үнэн буй ба буй бусаас тэмцэх нь нэр төдий төлөө тэмцэл гэх болон улмаар нэрийдлийн тусыг үйлдэгч бодит юмсыг зөвшөөрөх нэрийдэлд өөрийн бэлэг чанараар бүтсэн өвөрчлөн буй бус бус гэх зэргээр "Өөрийн үндэст"-тэй тэмцэлдэх нэрийн төдий гэх ба "Өөрийн үндэст" нар ч түүнийгээ өөрийн бэлэг чанараар бүтсэн болой гэж барих зэргийг тодорхой хорьжээ.

Тэр мэтийг үлгэрлэвээс, "Тоочин" (Samkhyas) нар сонсох мэдрэхүйн вишай орноо алдарших энэ утгыг мөнх гэж өгүүлснээр сонсох мэдрэхүйн орноо алдарших эл утгыг зөвшөөрч, дуу мөнх гэдгийг хорихдоо нэр төдийд уурлах болой хэмээн өгүүлэхтэй адил үзэгдэнэ. Бусад амьтан бодгаль ч шалтгаан нөхцөлд шүтэж төрөх гэж барих хирнээ түүнээ шүтэж өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн байна гэж барин хүлэгдэх байна. Мэргэд ухаантууд энэхүү учир шлатгаанд шүтэж өвөрчлөн буйг хорих бөгөөд өвөрчлөн үгүйг магадалж олдог. Хязгаарт баригч үзлийн хүлээсийг таслахаар л шүтэн барилдахуйн учраар өвөрчлөн үүнийг бүтээх энэ нь сонин гайхамшигт мэргэн арга болой. Эл эрхэм утгыг болгоож */"Лусын хаан Мадойвын айлтгасан судар"-аас/ "Ялж төгөлдөр нөгчигсөн" бээр:*

Алин шалтгаанаас төрөх болвол тэр үл төрөх буюу
Түүнээ төрөхийн мөн чанар буй бус
Шалтгаанд харгалзах алин тэр нь хоосон болохыг номнов
Алин хоосон чанартайг түүгээр жишиж мэдэх мөн

хэмээн эхний нэг, хоёрдугаар мөрөөр "шалтгаанаас төрөх учир өвөрчлөнгөөр үл төрөх албатай байх" учрыг айлджээ. Гуравдугаар мөрөөр "шалтгаанд харгалзах шүтэн барилдахуйн утга нь өвөрчлөнгөөр хоосон утгатай" хэмээн айлджээ. Дөтгөөр мөрөөр "хоосон чанарыг тэр мэт олохын тус эрдмийг" үзүүлжээ. Мөн:

Мэргэд шүтэн барилдахуйн номыг онох болсноор
Туйлшрах үзлийг шүтэж үл үйлдэх

хэмээн шүтэн барилдахуйг оносноор түйлшран барих үзлийг таслана гэж айлджээ. Мөн хэрвээ өөрийн мөн чанараар бүтсэн өвөрчлөн байх аваас Ялгуугсад, Сонсоод сонсогч нар түүнийг болгоосон байх атал эс болгоожээ. Тийм өвөрчлөн чанар байваас нөхцөл шалтгааны хэрэггүй тул бэлгэст барих цацралын торыг тасалж гэтлэх гэхийн учиргүй болно. *"Зааны ид хавт судар"-аас*:

Хэрвээ ном юмст өвөрчлөн буй аваас
Ялгуугсад, Сонсоод сонсогч нар түүнийг болгоох
Мөнхөд барих номоор гаслангаас үл гэтлэх ба
Хэзээ ч цацралаас үл хагацах буюу Мэргэд ээ

хэмээн айлдсан мэт "Номын би-үгүй"-г нотлох буулгахад "Үндсэн билиг"-ийн гурав, дөрөв, тав дугаар бүлгүүдээс үзүүлсэн төрөн түгэхүй, цогцос, язгуур зэргүүдэд өвөрчлөн байхыг үгүйсгэсэн ухааны үүднээс машид сайтар номносон олон боловч үг ихдэх вий гэж эмээж үүгээр хязгаарлав.

(в) Тэдгээр үзлийг дадуулснаар түйтгэрийг тэвчих ёсон

Тийнхүү "би" болоод "минийх" хэмээхийн өөрийн мөн чанараар бүтэх нь тоосон төдий ч байхгүйг ухаарч түүний утгыг бясалгаж дадуулснаар "би" болоод "минийх" хэмээн барих, эвдрэх үзлийг буцаана. Түүнийг буцаснаар чухал авагч хүсэл зэрэг "дөрвөн авахуй" буцна. Түүнийг буцаснаар авахуйн шалтгаанаас "хурьцахуй" төрөхгүй тул хурьцахуй шалтгаанаас цогцос хуралдаж төрөл авахгүй болсноор гэтлэх болно. *"Хорин наймдугаар бүлэг"-ээс:*

"Би" болоод "минийх" амарлих тул
Минимхийлэн барих, минийх гэж үзэх үгүй болох хэмээсэн ба,

Гадаад, дотоодын бодас юмст
"Би" болоод "минийх" хэмээх барагдаж
Чухал авахуй хоригдох бөгөөд
Тэр барагдваас төрөл барагдах хэмээн айлджээ.

Чингэхдээ чухал авахуй нь нисваанис ба хурьцахуй нь үйл мөн тул төрөхүйн үндэс болсон нисваанис, үйл хоёрыг барснаар нирваанд хүрч байгаа хэрэг. *"Дээрх"-ээс:*

Үйл болон нисваанисаа барснаар гэтлэх хэмээжээ.

Алив үйл нисваанис барагдсанаар барагдах болохыг *Түүнээс:*

Үйл нисваанисын асар атгагаас болон
Тэдгээрийн цацралаас цацрах зэргийг

Хоосон чанараар хорих мөн хэмээн айлджээ.

Төрөхөөс үхэх хүртэлх орчлонгийн дамжлага энэ нь үйлээс төрнө. Орчлонг бүтээх үйл нь зөвхөн нисваанист сэтгэл төгөлдөр гурван үүдний хуран үйлдэхүйгээс үүднэ. Үйл нь нисваанисаас төрнө. Вишай орны сайхан муухай зэргийн бэлэг шинжийг гүтгэх ёс бусын атгаг санаа гарахгүй бол эвдрэх үзлийн үндэст нисваанис үл төрнө. Шунах, уурлах зэргийн нисваанисууд буюу эвдрэх үзлийн үндэс тэдгээр ёс бусын атгагаас төрнө. Ертөнцийн найман ном болон эр, эм, хумх, тэрэм, дүрс амсуурга гэх мэт "эдгээрийг үнэн болой хэмээн илт шунах" зэргээс л ёс бусыг сэтгэлдээ бодох атгаг бий болж тэдгээрийг атгаглаж санана. Тэрхүү атгаг нь үнэнд барих цацралаас л төрдөг бөлгөө. *"Тодорхой үгт"-ээс*:

Ертөнцийн цацрал тэр бүгдээр хоосон чанартайг буюу бодас юмсын хоосон чанарыг мэдэх үзлээр л хорих болой. Хэрхэн яаж? хэмээвээс. Алив юмсыг бодас гэж тухайлах аваас тийн номносон цацрал байх болно. "Хүүсэр эмийн охин" үл тухайлагдах тул шунагчид болон түүнийг барих сэтгэлд цацрал төрдөггүй. Цацрал гарахгүй байна гэдэг вишай орноо ёс бусаар атгаглах явдал гарахгүй болой. Атгаг төрөхгүй бол "би болоод минийх болой" хэмээх илт шуналаас ангид нисваанис чуулсан эвдрэх үзлийн үндэс төрөх учиргүй. Нисваанис чуулсан эвдрэх үзлийн үндэс ёзоорыг хөөж гаргахгүйгээр үйл ариусахгүй. Үйлээ ариусгаж чадахгүй бол төрөх, өтлөх, үхэх хэмээх орчлонг ч бясалгаж чадахгүй хэмээжээ.

Хоосон чанарыг оносноор тэд бүгдийг буцаах учиртайг дээрх *"Шастар"-аас:*

Алины тухайд цацрал бүгдийг амарлиулах нирвааны мөн чанар болсон хоосон чанарт шүтэж цацралаас хагацана. Цацралаас хагацсанаар атгагаа буцаана. Атгагаа буцааснаар нисваанисаа буцаана. Үйл нисваансаа буцааснаар төрөхүйг буцаах тул зөвхөн хоосон чанар нь хамаг цацралыг буцаах мөн чанарт тул гаслангаас нөгчигсөн нирваан болой хэмээн маш тодорхой айлдсан бий.

Ийнхүү хоосон чанарын үзэл бол зовлонт орчлонгийн үндсийг таслагч бөгөөд тонилохуйн мөрийн амин сүнстэй адил гэдгийг үнэхээр баталж үзүүлсэн тул үүнээ баттай ухаарлыг олох хэрэгтэй. Тиймээс хутагт багшийн эдгээр номоор "Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад хүртэл өвөрчлөн үгүй чанарыг оножболно" гэж тодорхой айлдсан бөгөөд "зовлонгоос тонилохуйн хутаг ч энэ л хоосон чанарын үзлээр бүтнэ" гэж мөн тодолжээ. Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад нар ч өөрсдийн нисваанисаа барахын тулд энэ

үзлийг бясалгах учиртай. Нисваанис дарагдаад ирэхээр ингэсгээд болно гээд өнө удаан бясалгахаа боливол мэдэгдэхүүний түйтгэрээ тэвчиж чадахгүйд хүрнэ. Бодисадва нарын хувьд зөвхөн нисваанисаа барах төдий үүднээс буюу зөвхөн өөрөө зовлонгоос гэтлэх төдийхнөөр болно гэж үзэлгүйгээр хамаг амьтны тусын тулд бурханы хутгийг олохыг чухалчлан мэдэгдэхүүний түйтгэрээ барж дуустал бясалгадаг. Тиймээс маш их урт хугацаанд цаглашгүй их буянаар чимэн байж бясалгадаг билээ.

Тийнхүү хоёр түйтгэр хоёулангийн хөрөнгийг ёзоороос нь хөөж гаргах ерөндөг бол дээр дурдсан хоосон чанарын үзэл мөн. Гэвч урт хугацааны туршид бясалгах, эс бясалгахын үүднээс нисваанисын түйтгэр төдийг тэвчиж чадах ч мэдэгдэхүүний түйтгэрийг тэвчиж чадахгүй бий. Үлгэрлэвээс, “би-үгүй”-г оносон нэг ухаанаар “үзэх мөр” болон “бясалгах мөр” хоёрын тэвчигдэхүүнийг зэрэг тэвчиж чадахгүй тул “бясалгах мөр”-ийн тэвчигдэхүүнийг тэвчихэд урт хугацааны бясалгал шаардагдахтай адил болой. Зөвхөн мэдэгдэхүүний түйтгэрийг тэвчихэд өнө удаан хугацаанд бясалгаж тэвчихийн зэрэгцээ агуу их явдал мөрд болон бусад олон эрдэмд суралцах зэргээс хамааралтай. Сонсогч, Ялгуугсад нар мэдэгдэхүүний ерөндөгийг бясалгалгүй зөвхөн нисваанисын түйтгэрийг тэвчих арга төдийг бясалгахаас бус ”номын би-үгүй”-г бясалгах төгс төгөлдөр бясалгал хийдэггүй гэж айлдсан буй. *“Орохуйн тайлбар”-аас*:

Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад нар нь шүтэн барилдахуйн шалтгаан нөхцөл энэ төдийг л үзэх билээ. Гэвч тэдэнд “номын би-үгүй”-г төгс төгөлдөр бясалгах гэж байхгүй, гурван ертөнцийг эдлэх нисваанисаа тэвчих нэг л арга байдаг хэмээн айлджээ.

Тиймээс энэ багш бээр, бусад төв үзэлтэн нарын үзэх “номын би-д барих үзлийг нисваанист мунхаг” хэмээн болгоож, түүнийгээ тэвчиж дуустал “номын би-үгүй”-г бясалгах байвч “номын би-үгүй”-г төгс төгөлдөр бясалгах байхгүй” гэж дээр болоод энэ үест айлдсан дагуу мэдэж аваарай.

Чингэвэл энэ ёсонд мэдэгдэхүүний түйтгэр гэж юуг хэлэх вэ? Тэргүүлшгүй цагаас өөрчлөнгөөр буй гэж шунах буюу бодас юмст илт шунахын үүдийг үйлдсээр сэтгэлийн үндсэнд баттай авьяас тогтох ба авьясны эрхээр өөрчлөн үгүй байтал өөрчлөн байна гэж хоёрт үзэх эндүүрлийг мэдэгдэхүүний түйтгэр гэх буюу. *“Орохуйн тайлбар”-аас*:

Нисваанис мунхагийг тэвчсэн, хуран үйлдэхүйг дүрс тусгал адилд буй юм шиг болгоогч Сонсоод сонсогч, Өөрөө ялгуугсад болон Бодисадва нарт

бол "засвартай өөрчлөн" харагдана. Үнэхээр гэж үзэхгүй л дээ. Үнэхээр гэж хөөрөмших сэтгэлгүй учраас тэр. Харин нялхас нарыг хуурч үзэгдэх мөн. Түүнээс бусдуудад илбэ мэтээр шүтэн барилдаж гарах тул янагуух төдийд үзэгдэнэ. Тийнхүү мэдэгдэхүүний түйтгэрийн бэлэг чанарт мунхаг төдийхнөөр бүгд эдлэгдсэн учраас. Үзэгдэл сэлтийн явдал мөрт хутагт нар мэдрэхээс үзэгдэл сэлтгүй явдал мөрийг эрхшээгч нарт тийн бус болой хэмээн айлдсан мэт.

Нисваанист мунхагийг тэвчсэн бодисадвын талаар дээрх *"Дөрвөн зуутын тайлбар"-т:* "Үл төрөхийн номонд тэсвэрийг олсон бодисадва мөн" гэж эш татсан тул "наймдугаар газрыг олсон" бодисадвааг хэлжээ. Тиймээс бага хөлгөний "Дайснаа дарсан архад" болон наймдугаар газрын "бодисадва" нар хоёрт үзэх эндүүрлийн авьяас шинээр тогтохыг барсан гэх ч эрт урьдаас наалдсан хоёрт үзэх олон авьяасаа арилгах шаардлагаа гарах учраас л тэндээс эхлэн удаан хугацаанд бясалгах хэрэг гардаг. Тэдгээрийг арилгах буюу эндүүрлийн авьяас бүгдийг буцааснаар бурхан (ариусан дэлгэрэх хутаг) болох болой.

Хутагт эцэг, хөвгүүний болгоосноор их, бага хоёр хөлгөний магад утгат үзэл адил гэж үзүүлсэн үүнээ гайхамшигт хоёр зүйлийн үндэслэл бий буюу.

1. Бурхан болоход төдийгүй зовлонгоос гэтлэх төдий нэгэнд ч хамаг ном юмсын өөрчлөн үгүйг оносон үзэл онол байхгүй бол ямар ч аргагүй гэдгийг магадтай харуулж элдэв олон аргын үүднээс ихэд хичээн шамдаж хиргүй тунгалаг үзэл онолыг баттай олж авах ба,

2. Их, бага хөлгөний ер бусын ялгааг үзүүлэх онцлог гэвэл их эрдэнийн бодь сэтгэл болон бодисадвын агуу их явдал мөн гэж үзээд үндэс ёзоороос лавтай магадлан харуулж, явдал мөрийн зүгийг үлэмж увдисын түйлд барьж бодисадвын тангарагийг сахиж явдал мөрд суралцах эдгээр ажээ. Энд өгүүлрүүн:

Уулсын эрхэт "Тасын цогцост" хэмээн алдаршсан
Гайхамшигт дээд "Газрыг баригч" (уул) тэнд өөдлөн залархуй яа
Их газрыг зургаан зүйлээр хөдөлгөн зохиож
Зуун орны гэрлээр дүүргэх рид хувилгаанаар

Цог жавхлант харшнаас ном зарлигаа буулгасан Чадагчийн
Алин судар дандрын хоёр мөрийн амин гол болсон
Хутагт хөвгүүн сэлт мэндлэх "Их эх судар" (барамид судар) буюу
Ханьцашгүй сайн номлол "Билгийн чинад хүрэхүй"-г

Эш бошгыг ологч Нагаржунай гэгээн бээр
Ёсчлон тайлбарласан эрхэм дээд гол шастар
Түүний нь "Цогт үндсэн билиг" хэмээх буюу
Наран мэт алдаршсан ханьцашгүй ном болох

Буддхапалидагийн "гол ном"-оор "ялгуугсаны ногоог"
Сайтар номносон түүнийг нь сайн ном болгож
Сайтар ухааран дэлгэрүүлж тайлбарласан нь
"Саран" гэгээний (Чандракирти) "тодорхой үг, утгат сайн ном" болой

Тэдгээр бүгдийн хиргүй тунгалаг ёс болсон
Өөрчлөн чанар үгүй, илбэ адилын бодас юмст
Сансар нирваан, шүтэн барилдлага, үйл үйлдвэр бүхэн зохицох ёсыг
Ухаарахад хялбар үгээр өчүүхэн төдий номнов

Гүн гүзгий төв үзлийн гол номыг судлах нөхөд өө,
"Өөрчлөн буй бус хирнээ шалтгаан үрийн шүтэн барилдлага буй" гэх
Энэ л таны ухааны нигуурт багтахад бэрхтэй биз ээ
Гэсэн ч тэр адил нь Төв ёсон мөн болой хэмээн

Ийн өгүүлэх ёсыг шүтвээс л үзэсгэлэнтэй
Эс чингэвээс өөрөө ёсчлон тэвчиж чадаагүй хирнээ
Бусдад бурууг тохохын гэм гарах зэрэг
Ёс бус зүйлд горилсоор эдүгээ хүртэл сурч явах

Тэр мэт хутагт эцэг, хөвгүүдийн гол номоос
Үзэл онолоо олж сурахын учрыг
Сайтар номносон үгээр минь
Ялгуугсадын ном өнө удаан орших болтугай

24

ҮЛЭМЖ ҮЗЭХҮЙН ЯЛГАЛ

б.Үлэмж үзэхүйн машид ялгал
в. Үлэмж үзэхүйг бясалгах ёсноо хоёр:
1) Бусдын ёсыг хорих (бусдын шүүмжлэлд хариу өгөх)
а) Бусдыг хорих нэгдүгээр ёсон
б) Бусдыг хорих хоёдугаар ёсон
в) Бусдыг хорих гутгаар ёсон
г) Бусдыг хорих дөтгөөр ёсон
2) Өөрийн ёсыг байгуулах
а) Агуулах болон шинжлэх бясалгал хоёул хэрэгтэйн учир шалтгаан
б) Энэ талаарх тэмцлийг няцаах

---оОо---

б.Үлэмж үзэхүйн машид ялгал

Тийнхүү дээд төрөлхтнийг шүтэж олонтаа сонсох, төгс эрэлцэх, ёсчлон санах зэрэг үлэмж үзэхүй ухааны гурван чуулганы талаар "*Бясалгалын дунд зэрэг*"-ээс айлдсан тэдгээрийг шүтэж, хоёр "би-үгүй" чанарыг онох үзлийг олохоор үлэмж үзэхүй ухааныг бясалгана.

Чингэвээс бясалгах орон болсон үлэмж үзэхүй гэж юу вэ? Энэ үест дээд түвшингийн үлэмж үзэхүй ухаан зэргийг голлож үзүүлээгүй. Эгэл төрөлхтний үест бясалгах үлэмж үзэхүйг голлон үзүүлнэ. Энд үлэмж үзэхүйг төгс болгохоор дөрвөн зүйл, гурван зүйл, зургаан зүйлийн үлэмж үзэхүйг бясалгана.

Дөрвөн зүйл нь. "*Тааллын тайлбар*"-аас айлдсан "тийн ялгах тэргүүтэн дөрөв" болой. *Тийн ялгах нь* янагуухийг зорих (бодох) болой. *Машид тийн ялгах нь* үнэмлэхүйг зорих болой. Эхнийд төгс атгаглах (ажиглах) болон төгс шинжих хоёр буй. Удаахад нь атгаглах болоод шинжлэл хоёр буй. Бүдүүн нарийнийг тийн ялгах болой. Тэр талаар *"Сонсогчийн газар"-аас*:

Түүнээ үлэмж үзэхүйн дөрвөн байдал ямар байх вэ? Гэлэн нар аа! Үнээ энэ адил буюу Сэтгэлийн амарлингуйд шүтэж номыг тийн ялгах, машид ялгах, төгс атгаглах ба төгс шинжиж үйлдэх болой. Түүнийг хэрхэн тийн ялгах вэ? "Шинжлэлээ ариусгах зоригдол (орон)", "мэргэдийн зоригдол", "нисваанисаа

арилгах зоригдол" эдгээр нь янагуухид оршихоор тийн ялгагдах болой. Үнэмлэхүйд орших машид сайн ялгагдах бий. Ухаантай хамсарч сэтгэлдээ үйлдэх буюу тийн атгагаар бэлгэст барих үест төгс атгаглах болно. Зөв онохын цагт төгс шинжлэл болно хэмээжээ.

"Хотол хураангуй"-гаас ч: "Үлэмж үзэхүйн мөрд тэдгээр дөрөв" гэж айлдсан буй. "*Билиг барамидын үвдис*"-аас тэдгээрийн тодорхойлолтыг "*Сонсогчийн газар*"-ын дагуу айлджээ.

Гурван зүйл нь. *"Судрын аймгийн тааллын тайлбар"-аас*:

Ялж төгөлдөр нөгчигсөн өө, Хэдэн үлэмж үзэхүй байна вэ? хэмээсэнд Майдар аа! Гурван зүйл буй. Үүнд: "Бэлгэсээс гарсан", "Огоот эрэлцэхээс гарсан", "Тус тус онохоос гарсан" болой.

Бэлгэсээс гарсан гэж юу вэ? Бясалгалын орон болсон атгаглагдах төдий дүрс, хөрөг зэргийг сэтгэлдээ бодох зэргийн үлэмж үзэхүй болой.

Огоот эрэлцэхээс гарах гэдэг юу вэ? Ухаанаар сайтар онож чадаагүй тэдгээр номыг сайтар онохын тулд сэтгэлдээ бодож тунгааж буй үлэмж үзэхүй болой.

Тус тус онохоос гарах юу вэ? Ухаанаар машид сайтар оносон номоор тийн гэтлэхийн тулд машид сайтар амгаланг эдлэхийн тухайд сэтгэлдээ тунгаан бодох үлэмж үзэхүйн алин болой хэмээн айлджээ.

Энэ талаар "*Сонсогчийн газар*"-аас: "Сонсох болоод барих ном увдистаа сэтгэлээ тэгш агуулах газрын сэтгэлийн үйлдэл учраас санаж бодохгүй үе байна. "Атгагтай учрах буюу ойрхон ажихгүй байна" гэдэг бэлгэс шинж төдийхөнд даган орох буюу. Алин хэзээд бодож байн байн атгаглах тэр цагт "огоот эрэлцэх"-ээр даган орно. Тийн нотлон буулгахаар уг ёсоор тус тус онож мэдэхээр огоот эрэхийн дараагаар "тус тус атгаглаж" дагаж орно. Тэр гурвыг үлэмж үзэхүйн гурван үүд ч" хэмээсэн буй. Тэдгээр утгыг хураангуйлваас:

1. Би үгүйн утга зэргийг бодож түүний бэлэг шинж зэргийг сэтгэлдээ бодох буюу нотлон буулгаж олонтаа үйлдэнэ.
2. Урьд нь мэдээгүйгээ мэдэж авахын тулд нотлон буулгах болой.
3. Мэдчихсэн утгаа урьдын адил шинжилж үйлдэх болой.

Зургаан зүйл нь. "Зургаан суурийг бодох" буюу төгс эрж хайх буюу үлэмж үзэх ухаанаар эрэх болой. Энэ нь утга, бодас, бэлэг чанар,

зүг, цаг, язгуур зэргийг төгс хайж олоод тэдгээрийг тус тусад нь ажиглах болой. Тэдгээрээс "*Утгыг эрэхдээ*" энэ үгийн утга "юу вэ?" хэмээн эрэх болой. *"Бодасыг эрэхдээ"* "Энэ нь дотоодын бодас болой. Энэ нь гадаадын бодас болой" хэмээн эрэх болой. *"Бэлэг чанарыг эрэхэд"* хоёр буюу "энэ нь өөрийн бэлэг чанар болой. Энэ нь ерөнхий бэлэг чанар болой" хэмээж нийт болон нийт бусыг эрэлцэх болой. "*Зүгийг эрэхдээ*" "Хар зүг буюу гэм буруутай талаас хайх, цагаан зүг буюу эрдэм тустай талаас эрэлцэх" болой. *"Цагийг эрэхдээ"* "өнгөрсөн цаг тийм байжээ, ирээдүй цагт ийм болно, эдүгээ цагт ийм байна" гэх зэргээр эрнэ. *"Язгуур-ыг"* эрэхэд дөрвөн язгуур буй. "Харгалзах язгуур" нь үр дагавар гарахад шалтгаан нөхцөлд харгалзана. Ингэхдээ янагуух болон үнэмлэхүйн тэдгээрийн суурь тус тусын үүднээс эрнэ. "Үйл үйлдвэрийн язгуур" нь гал бол түлэх шатаах зэргийн үйл үйлдэх гэх зэргээр ном юмсын өөрийн үйлдэх үйлүүд багтана. "Энэ нь ном болой. Энэ нь үйлдэгч болой. Энэ номоор энэ үйлдлийг үйлдсэн болой" гэж эрнэ. "Тааруулж бүтээх язгуур" нь шалгадаг ухаантай харшуулалгүй утга бүтээх болой. Чингэхдээ үүнд илт мэдэх, жишиж мэдэх ба сэтгэл итгэмжлэх эшийн гурван шалгадаг байна уу, үгүй юу гэж эрэх болой.

"Номын жам ёсны язгуур"-ыг эрэхэд "гал халуун байх, ус чийгтэй байх зэрэг ертөнцөд алдаршсан ном жамт ёс болон санаанд багташгүй номын ёсон, оршихуйн номын ёсыг хүндэтгэж сүслэх зэргүүд бөгөөд тийн оршихын учир жүнцангаас өөрөөр бодолгүй, тэр ёсоор эрэх болой. Тийн агуулах зургаан зүйлийг егүзэр ухаарахдаа гуравт багтаан ойлгодог. Үүнээс: нэгдүгээрийн эрхэнд үзвэл "эхний эрэх ёс" багтана. Хоёрдугаарын эрхэнд үзвэл, "бодасыг эрэх" болон "өөрийн бэлэг чанарыг эрэх" багтана. Гуттаарын эрхэнд болвоос үлдсэн гурав болон "ерөнхий бэлэг чанарыг эрэх" багтана. *"Сонсогчийн газар"-аас:*

Тэдгээрт үлэмж үзэхүйн гурван үүд болон суурийг маш ялгасан зургаан зүйлийн зоригдохуун багтана. Товчилвоос, тэдгээрт үлэмж үзэхүйн бүгд үнэхээр хураагдсан болой хэмээн номносон тул тэдгээр нь хамаг үлэмж үзэхүйн хураангуй болно гэж айлджээ.

Энд эхлээд номносон дөрвөн үлэмж үзэхүйн үүд нь гурав мөн. Тэр гурвыг төгс эрэх болон даган орох зургаан эрэлцэх ёс гэж айлдсан тул гурван үүд, зургаан эрэлцэх ёс нь дээрх дөрөвт хураагдах болно. "Дээр номносон "хянаж орохоор сэтгэлдээ үйлдэх" зэрэг дөрөв нь ч үлэмж болон амарлингүй хоёуланд нийтийнх болно" гэж "*Сонсогчийн газар*"-аас айлдсан тул дөрвөн сэтгэлдээ үйлдэхүй байна. "*Билиг барамидын увдис*"-аас:

Тийнхүү дөрвөн үлэмж үзэхүйг төгс бясалгаснаар муу авир ёсны хүлээснээс гэтлэх бөгөөд есөн зүйлийн амарлингүй бясалгалыг төгс гүйцээснээр бэлгэсийн хүлээснээс гэтэлнэ хэмээсэн адилаар олон гол номуудаас айлдсан билээ.

Тиймээс үлэмж үзэхүйн бясалгал нь "*Судрын аймгийн тааллын тайлбар*"-аас айлдсан дагуу "Дөрвөн тийн ялгах"-ын үүднээс бөлгөө. Амарлингүй сэтгэлийн бясалгал нь "юуг ч үл атгаглан агуулах есөн сэтгэл"-ийн үүднээс болой.

***ө. Үлэмж үзэхүйг бясалгах ёсноо хоёр*:**

1) Бусдын ёсыг хорих (бусдын шүүмжлэлд хариу өгөх)
2) Өөрийн ёсыг байгуулах

1) Бусдын ёсыг хориход дөрвөн зүйл:

а) Бусдыг хорих нэгдүгээр ёсон
б) Бусдыг хорих хоёдугаар ёсон
в) Бусдыг хорих гутгаар ёсон
г) Бусдыг хорих дөтгөөр ёсон

а) Бусдыг хорих нэгдүгээр ёсон

Асуулт: Зарим-ууд: "Би-үгүй"-г онох ямар ч үзлийг олохгүй хирнээ сэтгэлээрээ юуг ч атгаглахгүй байвал ахуй ёсны хоосон чанарыг бясалгаж байгаа нь тэр мөн гэнэ. Ахуй ёс буюу хоосон чанар чинь энэ мөн, тэр биш гэх мэтээр бодитой барих бүхнээс ангижирсан тул чингэж бодож байгаа маань ахуй ёстойгоо зохилдон оршиж байна. Ерөөс ямарваа вишай орон (юмс) байхгүй бол ухаанд юу ч баригдахгүй шүү дээ хэмээв.

Хариулт: "Энэ талаар өгүүлсүгэй. Чингэвэл бясалгалч тэрээр,

а/ вишай орнууд ямараар ч бүтээгүй гэхийг огт бүтээгүй, байхгүй юм байна гэж ухаарах ба түүнийг даган зохилдох ухаан нь юуг ч барихгүй гэж үзэх хэрэгтэй юу?

б/ За яахав тийн мэдлээ гэхэд вишай орны ахуй ёс тэр нь хаана ч байхгүй хэрнээ ухаан чинь юу ч мэдэхгүй байснаар гэнэт тэрхүү ахуй ёсыг бясалгах болох нь ээ?

а/ Эхнийхээр гэвэл, тэрээр үзэл онол олоогүй болж харшилна. Та өөрөө түүнийгээ магад утгат гэж үзэж байгаа шүү дээ. Биднийхээр бол тэрхүү ухааны хоригдохууны хязгаарыг барилгүй юу ч гэж хэлж болох биз. Гэвч ухааны хорлол (зөрчил) гарах вий гээд бас бодитой барихаар орон юу ч

байхгүй гэвэл басамжилж үзсэн үзэлд хүрнэ. Түүний үүднээс үзсэн ч хоосон чанарын зөв бясалгал болохгүй гэдгийг дээр олонтаа номлосон билээ. Юутай ч эдгээрийн ахуй ёсыг шинжих ухаанаар ажиглаад үзэхэд бодит, бодит бус аливаа юмс тэдний ухаанд баригдахгүй, байхгүй болж улмаар тэр байдлаа үнэмлэхүйн цацрал бүгдээс хагацсан гэж үзэж байна.

Хэдий ингэж үзлээ ч бодгаль тэрээр түүнийг онохгүй байж болох ч тийн томьёолсон түүнтэй зохилдсон гээд хоосон чанарыг бясалгал мөн гэж үзвэл дэндүү хэтийдэх буюу. Эрхтний бүхий л мэдэрхүйгээр ч гэсэн "энэ нь энэ болой, тэр нь тийм бус болой" гэх зэргээр алив бүгдийг барьж чадахгүй ээ. Вишай орны ахуй ёстой зохилдох учраас тэр бүгдээр ахуй ёсыг бясалгах бясалгал болно гэх ба мөн дээр өгүүлсэнчлэн тэрсүүдийн ёсны юуг ч үл атгаглах нь хоосон чанарын бясалгал болно гэх зэргийн маш олон янзаар үзэх байна.

Мөн "Вишайн ахуй ёс болоод ухаанд агуулагдах ёс хоёр нь зохилдоно гэдгийг бусад хэн нэгний ухаанд мэдсэнээр болгочихно гэвэл тэрсүүд нарын үйлдсэн тэдгээрийг буцааж болохгүйд хүрэх тул яав ч түүнтэй адил бус биз ээ. Гэхдээ энэ үест тэр хоёрыг зохилдоно гэж ухаарсан тэр хүний бодсоноор агуулах хэрэгтэй болох уу?" "Тэр адилаар зохилдох ёсыг мэднэ гэвэл үзэл онол олох болно. Гэтэл үзэл онолоо ухаараагүй байж юу ч бодохгүй байх төдийхнөөр хоосон чанарыг бясалгана гэж үзэх чинь харштай байна. Хэдий ямар нэг зүйлийг ажиглавч тэр бүгдээр орчлонд хүлэгч болох учраас юу ч бодолгүй, ажиглалгүй байж байх нь гэтлэх мөр болчих биз дээ?" хэмээвэл, үүнийг дээр олонтаа хорьсон билээ. Чингэвэл Хуушааны ёсыг буруутгаж, гэм зүүх хэрэг өчүүхэн төдий ч байхгүй болно биз ээ. *"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс:*

Алив сэтгэлийн тийн атгагаас үүдсэн буян, нүглийн үйлийн эрхээр амьтан өндөр язгуур тэргүүтний үрийг эдэлж орчлонд эргэлдэнэ. Алин юу ч үл санах, юу ч үл үйлдэх тэдгээр нь орчлонгоос огоот гэтлэх бэлгээ. Тиймээс юу ч бүү санаарай. Өглөг өгөх зэргээр алив сайныг үйлдээрэй. Өглөг тэргүүтнийг үйлдэх нь зөвхөн тэнэг амьтны эрхээр зааж үзүүлсэн болой" гэх зэргээр өгүүлэгч тэр бүгдээр их хөлгөн бүгдийг тэвчсэн хэрэг болно шүү. Хөлгөн бүгдийн үндэс их хөлгөн мөн тул түүнийг тэвчвээс хөлгөн бүгдийг тэвчих болно. Ийнхүү "юу ч санах хэрэггүй" гэж өгүүлэх нь тус тус онох бэлэг чанарт зөв ухааныг тэвчсэн болой. Зөв бигэ билгийн үндэс нь тус тус зөв онох мөн тул түүнийг тэвчвээс язгуураа тэвчих буюу ертөнцөөс нөгчигсөн оюун ухаанаа тэвчих болно. Өглөг тэргүүтнийг өгч бүү үйлд гэж өгүүлэвч өглөг тэргүүтний машид гүн аргын хязгаарт

хүрэхийг тэвчсэн болно.

Товчилвоос, *"Хутагт гаяагори судар"*-аас:

Энэ адил буюу. Их хөлгөн бол арга болон билиг болой. Бодисадва нарын мөрийг хураангуйлваас хоёр буюу. Алин юун? хэмээвээс, Энэ адил буюу. Арга болоод билиг болой хэмээх зэргээр айлдсан буй.

Мөн *"Хутагт түүнчлэн залрагдасын нууц"*-аас ч:

Зарлиг болруун, Арга, билиг энэ хоёрт бодисадвын мөр бүгд хураагдах болой хэмээсэн буй. Тиймээс их хөлгөнийг огоорвоос үйлийн их түйтгэр болох талаар Тэр мэтээр их хөлгөнийг тэвчигч, өчүүхнийг сонсогч, "би"-гийн үзлийг дээдэд баригч, мэргэн төрөлхтөнг үл хүндлэгч, тэрчлэн залрагсан бурханы эрхэм зарлигийг үл оногч, өөрийг гутааж, бас өөрөөс бусдыг ч гутаагчийг болоод эш ухаантай харшлах хорт идэгдсэн үг нь мэргэдээс сайныг хүсэвч хор болох тул алс холоос тэвчээрэй хэмээжээ.

Хуушааны үзлийг гаргаж тавьсан нь хэрвээ тэрээр ингэж үзвэл их хөлгөн бүхнийг тэвчсэн болох учрыг тодотгон харуулжээ. Чингэснээр урьдын ёсыг мэдэхтүн. "Хэрвээ бидний өглөг өгөх зэргийн явдлууд тэдэнтэй адилгүй гэх зэргээр зөвхөн өглөг өгөх зэрэг явдал төдий үүднээс бид тэдний хоорондын ялгаа гаргах хэрэгтэй" гэвэл, "Бид болоод Хуушаан хоёрын магад утгат үзэл онол, бясалгал зэргүүд адилхан болно" гэсэн үг болно Тиймгүй учраас л юу ч үл атгаглах бясалгал дээр ч ялгаж салгаж ойлгох нь зохистой.

Асуулт: Алив атгаг бүхэн орчлонд хүлэгч юм бол танд зовлонгоос гэтлэх нирвааныг чухалчлах санаа байхгүй болох уу?

Хариулт: Түүнийг чухалчлах санаа ирвэл өглөг өгөх, ёс суртахуун сахих зэргээр атгаглах хэрэгтэй болно доо. Гэтэл тийн үйлдэх хэрэггүй гэж дээр олонтаа номносон шүү дээ. Аливаа атгаг бүхэн орчлонд хүлэгч гэж үзэх нь Хуушаандаа л сайн бодол биз ээ. Тэрээр харшлахын үүрэг ачаанд дарагдсан байна даа.

Мөн түүнийг дагасан заримууд: "Хоёр би" гэж бэлгэст баригч сэтгэлийн орныг олонтаа шинжээд улмаар сэтгэлээр барих орныг буцаахдаа "чулуу шидэж нохойг гадагш хөөх адилаар цацрал гадагшлахыг таслах хэрэгтэй мөн" гээд "анхнаасаа сэтгэлээ хааш нь ч цацруулалгүйгээр барих гэдэг нь чулуу шидэх гараа толгойдоо барих адилаар үйлдэх буюу бэлгэст барих тэдгээр орон руу цацруулалгүй байвал цацрал бүгдийг дотроос таслах болно.

Тиймээс үзэл онолыг нотлон буулгах эш ухааныг судлах гэдэг янагуухийн үг төдийг л судлах болой гэх зэргээр өгүүлэх бий.

Эдгээр нь бурханы эрхэм зарлиг болон "зургаан чимэг" тэргүүтэн мэргэдийн гол ном бүгдээс няцаасан адгийн буруу үзлүүд мөн бөгөөд уг ном шастаруудаас зөвхөн эш онолын утгаар нотлон үзүүлжээ.

Мөн "хоёр би"-г бэлгэст барих ухаанд ямар зүйл хэрхэн баригдаж байна вэ? гэдгийг сайтар шинжилж, зөв эш ухаанаар түүнийг барьж, байгаа юм шиг хирнээ байхгүй байна гэх магадлал олсны үндсэн дээр л эндүүрлийн хуурмаг нүхийг нураах хэрэгтэй. Тэр адилын магадлал юуг ч олоогүй хирнээ сэтгэлдээ юу ч бодохгүй төдийхнөөр үзвээс тэр цагт "хоёр би"- гийн вишай гэж сэтгэлд түгэх цацрал гарахгүй хэдий ч тэр төдийгөөр "би-үгүй"-н утгыг ононо гэвэл хэтийдэл болно шүү.

Эс чингэвээс бөх нойронд автах, ухаан алдаж унах зэргээр сэтгэлийн түгээл цацрал гарахгүй үед ч хоосон чанарыг онож болох хэтийдэлд хүрнэ. Үүнийг үлгэрлэвээс, "Шөнө дөлөөр агуйн мухарт мангас байна уу, үгүй юу гэх нэгэн айдас төрөхөд дэнлүү бариад л байна уу, үгүй юу гэдгийг лавлан шийдэж айдсаа арилгах байтал чингэлгүй зөвхөн мангас гэж атгаглах тэр бодлоо гадагш цацруулж хаялгүй барьж байхтун гэж хэлсэнтэй адил байна шүү.

"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс: "Тулаанд орохын үест нүдээ цавчилгүй байж хаана дайсан байгаа газрыг сайтар харж, мэсээ далайн байлдах баатарын адил тулалдалгүй, хүчит дайснаа харахаар нүдээ аниад суух аймхай нэгэнтэй адил" хэмээн айлджээ.

Мөн *"Хутагт Манзушириийн цэнгэлт судар"-аас ч ийн зарлиг болруун:*

Бүсгүй ээ! Хэрхэн бодисадва нар дайснаа ялж чадсан бэ? хэмээн айлтгахад Манзушири бээр, Сайтар шинжилж, хамаг ном юмсыг үл тухайлснаар мөн хэмээжээ.

Учир нь бясалгагч бээр билгэ билгийн нүдийг нээж билгийн мэсээр нисваанисын дайсныг ялан дийлэх буюу. Аюулгүй амар амгалан орших буюу. Эр зоригтон адилаар нүдээ үл цавчих болой" хэмээн айлджээ. Тиймээс (айсан хүний нүдэнд аргал хөдлөх гэгчээр-орч) "эрээн дээсийг могой гэж эндүүрч айх хэдий ч эвхэрч мушгиралдсан дээс л байгаа болохоос бус могой байхгүй нь ээ" гэдэг магадлал лавтай төрсөнөөр тэрхүү эндүүрч айсан зовлонг буцаах учиртай. Тэр адилаар буюу "хоёр би"-г байна гэж эндүүрэх

болоод энэ хоёр эндүүрлээс үүдсэн орчлонгийн зовлонг ч гэсэн "би-д баригч мунхаг"-ийн вишай орон байхгүй нь ээ" гэж эцэслэн тасалсан эш ухааны магадлалыг лавтай олсон үндсэн дээр л өнөөх "би-д баригч"-аа эндүүрэлт болохыг ухаарч улмаар түүний вишай орныг бясалгаж буцаадаг ёстой. Түүнийг буцааснаар түүнээс үүдсэн орчлонгийн зовлон бүгдийг буцаана. "Ухааны язгуур зэрэг төв үзлийн гол ном шастаруудаас вишай орнуудыг шинжилж байж буцаана гэж үзсэн учир шалтгаан ийн буюу. *Арьяадэва гэгээн бээр:*

Вишай орны "би-үгүй"-г ойлгосноор л
Зовлонгийн хөрөнгийг хаах буюу хэмээсэн ба,

"Орохуй "-гаас:

Атгаглаж бодитойд үзвээс урвах (төрөх) буюу
Бодас хэрхэн буй бус болохыг л төгс шинжлэх хэрэгтэй

хэмээн "туйлшран баригч атгагаар бодит юмсыг буй гэж барьсанаар л тэд төрөх буюу буй болоход хүрнэ. Тийн атгагийн вишай орон буй бус гэдгийг сайтар шинжлэх"-ийг айлдаад:

"Би" түүний орон болж оногдох тул
Бясалгалч бээр "би"-гээ хорьж үйлдэх хэмээжээ.

Ухааны эрх баялагт (Дхармакирти гэгээн) бээр:

Үүний вишай орныг эс сөхөөвөөс л
Түүнийг тэвчиж чадахгүйд хүрнэ
Эрдмийг гэмд барилдуулах
Шунал хүсэл, уур хилэнг тэвчихдээ

Тэдгээрийн вишай оронг үл үзэх тул
Ахуй ёсыг гадаад байдлаар ялгах бус хэмээн олонтаа айлджээ.

Аливаа атгаг бүгдээр орчлонд хүлэгч болох тул хоосон чанарыг бясалгах үед атгаг бүгдийг хорино гэж өгүүлэгч түүний энэ мэтээр дахин дахин ажиглаж шинжих буюу.

Асуулт: Хоосон чанарыг бясалгагч түүнээ хоосон чанар буюу "би-үгүй"-н утга нь ил байх уу, эсвэл далд болох уу?

Хариулт: Эхнийхээр гэвэл, тэр бодгаль чинь хутагт болох нь ээ. Хоосон чанарын утгыг илт оносон болохоор. Яахнаа ч хоосон чанар оносон л бол

эгэл төрөлхтөн байх харшлахгүй" гэж таны өгүүлэх чинь "бид ч гэсэн хоосон чанарын утгыг далд гэсэн хирнээ бид өөрсдийгөө хутагт гэхэд харшлахгүй" гэж хэлж болох нь ээ. Хаана хаанаа адилхан шүү дээ.

Бас Хоосон чанарыг илт оносон тэр хүн чинь өөрийн вишайгаа хоосон чанарын утгат гэж мэдэхгүй учраас түүнд бусад хүмүүс эш онолын үүднээс хоосон чанарыг ойлгуулж танилцуулна гэвэл мэргэдийн тоглоом шоглоомын орон болно оо. Шавь нь илт мэдлээр оноож байхад багш нар нь жишиж мэдэхийн үүднээс онoно гэж үзэж байна шүү дээ. Иймээс иймэрхүү яриаг мэргэдийн өмнө бүү өгүүлэхтүн. Хоосон чанарын утгыг илт мэдлээр бүтээсэн ч нэрийдэх нотлолоор бүтээнэ гэж хэлж ч болохгүй. *Ухааны эрх баялагт бээр:*

Тэр нь машид мунхарсан утга буюу
Үхэрчинд хүртэл алдаршсан болой

хэмээх утга бүтнэ гээд, нэрийдэх сэжих сэтгэлт үхэрчин хүртэлх алдаршсан утга дээр ч "мунхаг"-ийг нотлолд байгуулана гэж айлджээ.

Тиймээс тэр адилын мунхагаар ч хоосон чанарыг илт онoно гэж үзвэл хоосон чанарыг ухаараагүй мунхаг бээр юуг нь байна гэж хэлэх билээ. Хоосон чанар мөн гэж бодлоо ч үлгэрлэвээс, "цагаан тарлан үхэр мөн боловч, хамаг үхрийн бэлэг чанарт болохгүй" нь илт харагдах тэр төдийхнийг хоосон чанарыг тодорхойлох бэлэг чанар гэж үзэж болохгүй. Өөрийн чинь ам авсантай ч харшлах учраас нэрийдлэд бүтсэн гэж хэлэх үндэс байхгүй нь тодорхой биш үү.

"Хэрвээ хоосон чанарыг бясалгалч түүнд бясалгагдахуун вишай болсон хоосон чанар, "би-үгүй" чанар нь далд мөн" гэвэл далд утгыг атгагаас хагацсан мэдэрхүйгээр барина гэж үзэхэд хүрч элэг доог болох нь ээ. Товчилвоос, хоосон чанарыг бясалгагч эгэл төрөлхтний ухаан нь вишай болсон хоосон чанартаа ухааны ам нь зүглээгүй хирнээ хоосон чанарыг бясалгана гэвэл харшилна. Түүнээ ухааны ам зүглэсэн байлаа ч тэр вишай нь илт болвол хутагт байх хэрэгтэй учраас эгэл төрөлхтөнд хоосон чанар нь далд утгатай байх ёстой гэж үздэг. Тэр үест хоосон чанарын утгыг ерөнхий байдлын үүднээс онох учраас атгагаас салсан сэтгэлээр онoно гэдэг таарахгүй.

Мөн "найрлагын мөрийн" дээд шат болох "их дээд ном"-ын үед ч хоосон чанарыг ерөнхий байдлын үүднээс онoно гэж үздэг учраас эдүгээгийн үйлийг анхдагч нарын хоосон чанарыг оносон ухааныг атгагаас салсан гэж үзэх нь бүрч харшилна. Хоосон чанарын утганаа атгагаас салсан байна гэдэг

нь эндүүрэлгүй байхыг бүтээхээр барахгүй, бүр өгүүзэр бясалгалчийн илт мэдэл болсон байх хэрэгтэй. Хоосон чанарын утганаа атгагаас хагацсан, эндүүрэлгүй сэтгэл байх учиртай. Тиймээс "би"-д баригчийн орныг ухаанаар сөхөөх үнэмлэхүй үзлийг олохгүйгээр "хоёр би" тэргүүтнээ түүнд цацрах сэтгэлийг л цацруулалгүй барих төдийхнөөр хоосон чанарын утгыг бясалгана гэж үзэх ба эгэл төрөлхтнүүд хоосон чанарыг атгагаас салсан сэтгэлээр бясалгана гэх зэргээр үзэх нь эш онолын мөрөөс хэтэрхий их холдож төөрсний шинж болно.

б) Бусдыг хорих хоёрдугаар ёсон

Асуулт: Заримууд: "Би-үгүй"-н хоосон чанарын үзлийг олоогүй байж юу ч атгаглалгүй (ажиглалгүй) сэтгэлээ тогтоох төдийг хоосон чанарын бясалгал гэх нь зохисгүй гэж бид нар ч үзэх учраас дээрх зүйлс таарахгүй байж болох биз. Гэхдээ "би-үгүй чанар"-ын үзлийг нэгэнт олсноос хойш бол тэр бодгалийн юу ч үл атгаглах бясалгал бүгдээр хоосон чанарын бясалгал болой хэмээв.

Хариулт: Энэ таарахгүй. Тэр хүн маань магад утгат үзлийг олсон мөн ч түүний үл атгаглах бясалгал бүгд нь магад утгат үзлийг нотлон буулгах утгыг л бясалгах болчих нь ээ. Чингэвэл тэр хүн чинь хэрэв бодь сэтгэлийг бясалгах болвол магад утгыг бясалгаагүй байна гэхийн учир шалтгаан юу болохыг өгүүлэхтүн хэмээв.

Асуулт: Заримууд: Хэдий магад утгат үзлийг олсон тэрээр бодь сэтгэлийг бясалгах мөн боловч тэрхүү үзлээ яг тухайн цагт дурдан санах юм уу, яг тэр бясалгалтай хамтруулж бясалгахгүй хэмээвээс.

Хариулт: Яг үнэндээ тухайн хүн магад утгат үзлийг олчихоод бясалгахын цагт тэр үзлээ дурдан санаж, "үзэл онолоо дээрээс буулгаж" (тогтоох) бясалгаж болно л доо. Гэхдээ *"юу ч бодохгүй байх"-ыг* үзэл онол судалж байна гэж яаж таарах вэ? Тиймээс үзэл онолоо олчихсон хойноо бясалгахын үест түрүүний нотлон буулгасан үзэл онолын утгаа дурдан санан байж хоосон чанарыг бясалгах хэрэгтэй. Юу ч ажиглалгүй агуулан тогтоох төдийхнөөр хоосон чанарыг бясалгасан болохгүй ээ. "Өөрийн ёсны юу ч үл атгаглах ёс" хэмээн өмнө "Амарлингуй сэтгэл"-ийн үест олонтаа гарсан буюу "энэ нь ийн болой, тэр нь тийн бус болой" гэх зэргүүд нь олонтаа шинжлэлгүй, зөвхөн ямар нэг бодол дээр тогтоож барих талыг өгүүлсэн болохоос атгагаас хагацсан гэж үзсэн биш ээ.

в) Бусдыг хорих гутгаар ёсон

Асуулт: Заримууд: Үзэл онол олоогүй үед атгаглалгүй тогтоох явдлыг хоосон чанарын бясалгалын анхдугаар үе гэж үзэхгүй ба үзэл олчихсон ч атгаглалгүй тогтоохыг ч хоосон чанарын бясалгал гэж тооцохгүй. Гэхдээ юу ч атгаглалгүй бясалгах тутамд өмнө нь тус тус ажиглагч ухаанаар нэг удаа ажиглалт хийсний дараагаар алин тогтсон бүгд хоосон чанарын бясалгал болох нь ээ? гэв.

Хариулт: Энэ ч мөн таарахгүй. Чингэвээс нойрсох үед үзэл онолын ажиглалтыг нэг удаа хийчихээд түүний дараа гүн нойронд автаад юу ч бодогдохгүй болох үед хоосон чанарыг бясалгаж болох хэтийдэлд хүргэнэ. Учир нь үзэл онолын ажиглалтыг өмнө одуулахын хувьд хоёулаа адилхан ч бясалгах өөрийн үест үзэл онолоо бодох бясалгал болохгүй нь харагдаж байна. Үзэл онолоо судалж өвөрчлөн үгүйн утгыг нотлон буулгах утга дээр тогтох мөн боловч түүнээс өчүүхэн холдвол "үзлээ дээрээс буулгах" нь орхигдоно. Ухаандаа юу ч бодолгүйгээр жирийн байдал чинь хоосон чанарын бясалгал биш тул атгаг бодлоо судлах хэрэгтэй. Мөн үзэл онол маань дээрээс байна уу, үгүй юу гэж харуулдан манаж бясалгах хэрэгтэй.

г) Бусдыг хорих дөтгөөр ёсон

Асуулт: Заримууд: Тийнхүү дээрх гурвыг зөвшөөрөхгүй гэе. Хоосон чанарыг бясалгах цагт хоосон чанарт магадлалыг олох ба улмаар түүний утгыг сэтгэлдээ бодож түүнээс өөр зүйлийг шинжлэлгүйгээр тогтоож агуулах нь хоосон чанарын жинхэнэ зөв бясалгал болох нь ээ.

Хариулт: Нэгд, хоосон чанарын зүгт ухааны ам зүглээгүй байдлыг үгүй болох; *Хоёрт,* атгаглалгүй бясалгах үест хоосон чанарын үзэл онолыг дурдан санахгүй байж болохгүй; *Гуравт,* үзэл онолын ажиглалтыг өмнө нь одуулавч үзэл онолыг дээрээс буулгахгүй, үл атгаглах бодол байж болохгүй учраас хэмээв.

Энэ үед үзэл онолд ажиглалт хийв гэж хэлээд, үзэл онолоо дурдан санах төдийхнөөр зөвхөн үзлээ дээрээс буулгаж агуулах бясалгал хийхийг хоосон чанарын бясалгал гэх зохисгүй ээ. Хэрэв тийм бол агуулах бясалгал үйлдэх амарлингуй сэтгэл төдийгөөр л хоосон чанарыг бясалгаж болох нь. Чингэвэл шинжих бясалгал буюу үлэмж үзэхүйн ухааныг судлах явдал хэрэггүй болж амарлингуй, үлэмж үзэхүй хоёрыг барилдуулж бясалгана гэхгүй дан ганц зүгт болчихно шүү.

2) Өөрийн ёсыг байгуулах

"Би-үгүй"-н магад утгат үзэл онолыг олоогүй бол түүний үндсэнд байгаа бясалгал бүгдээр "би-үгүй"-д ухааны амаа зүглүүлээгүй болох тул "би-үгүй"-н үзэл онолыг олсон байх хэрэгтэй. Зөвхөн ухаарах төдийгөөр зогсохгүй, бясалгахын цагт үзэл онолоо дурдан санаж шинжих ба шинжсэн утга хоосон чанараа бясалгаж чадах хэрэгтэй. "Би-үгүй"-н утгыг шинжлэлгүйгээр агуулан (тогтоох) бясалгах ба тус тус ажиглагч ухаанаар шинжилж (ажиглах) бясалгах хоёр зүйлийн бясалгал хоёулаа хэрэгтэй. Өрөөсгөл дангаараа байж болохгүй.

Түүнээ гурван зүйл:

а) Агуулах болон шинжлэх бясалгал хоёул хэрэгтэйн учир шалтгаан

б) Энэ талаарх тэмцлийг няцаах

в) Бясалгах ёсны аньсийг өчүүхэн номнох

а) Агуулах болон шинжлэх бясалгал хоёул хэрэгтэйн учир шалтгаан

"Би-үгүй"-н утгыг эцэслэн шийдсэн ямар нэг үзэл онолын магадлал олж чадаагүй бол үлэмж үзэхүй ухаан төрөхгүй. Учир нь тэр магадлал түүний үндэс болно гэж айлдсан билээ. Тэрхүү үзлийг номносон үг яриаг ч сонсохгүй байх нь үлэмж үзэхүй ухаан төрөхийн тотгор болдог гэж айлдсан буй. *"Тааллын тайлбар "-аас:*

Ялж төгөлдөр нөгчигсөн! Амарлингүй сэтгэл болоод үлэмж үзэхүй нь ямар үндэснээс төрөх вэ? хэмээсэнд, Хутагтын үг айлдварыг дуртайяа үл сонсох зэрэг нь үлэмж үзэхүйн тотгор болой хэмээжээ.

Мөн *"Сэрдмэдийн хөвгүүний айлтгасан судар"-аас*:

Сонссоноор ухаан төрөх, ухаанаар нисваанисаа тэвчих" гэх зэргээр дээр олонтаа айлдсан буй.

Үзэл онолтой болсны дараа үлэмж үзэхүй төрөх ёсны хувьд эхлээд нотлон буулгах үест эш онолын үүднээс сайтар шинжлэн буулгана. Нотлон буулгахын үест тус тус ажиглах ухаанаар дахин дахин шинжилнэ. Судлалгүй зөвхөн тогтоон бясалгах төдийхнөөр үйлдвэл төрөхгүй тул амарлингүй сэтгэлийг бүтээж бясалгал үйлдэх цагт заавал ажиглан шинжилж бясалгах шаардлагатай.

Асуулт: Энэ үест *Заримууд:*"Анхнаасаа ажиглахгүй байна гэж үзээгүй. Гэсэн ч сонсох, санахдаа баттай буулгасны дараа бясалгах цагт шинжлэх бясалгал хийвэл атгагууд бэлгэст барина гэх буюу. Ингэж судлаагүй бол алив атгаг бүгдээр бэлгэст барьсан болно гэх ба эгэл төрөлхтнүүд атгагаас хагацсан ухаанаар "би-үгүй"-г бясалгаж болно гэх зэргийг олонтаа хорьсон тул таарахгүй байна. Мөн тэдгээр атгагууд бүгдээр үнэнд баригч мөн тул бясалгахын цагт хоригдоно. Нотлон буулгахын үест ч атгаглаж үйлдэх тул бас л хорих хэрэгтэй болно. Таны үздэгээр шавьдаа номнох, тэмцэх, туурвих, шинжилж судлах зэргийн бүх ажлууд атгагаар үйлдэх хэрэгтэй тул тэр цагт бас л хорих хэрэгтэй болох нь ээ. Үнэнд баригчид бясалгаж дадах цаг бүхнийг хорих хэрэгтэй. Бусад цагт хэрэггүй гэхийн ямар ч ялгаа гарахгүй шүү дээ. Яахав ингэж үзээгүй гэе. Гэхдээ олон талын эш онолын үүднээс шинжлэх гэдэг "би-үгүй"-н утгыг оноогүйгээ онохын тулд ингэж байгаа хэрэг. Үзэл онолоо олчихсон хойно бол бясалгахын хэрэггүй болох уу? хэмээв.

Хариулт: Чингэвэл "Үзэх мөр"-ийн үест "би-үгүй"-г илт оножмэдчих болохоор цаашдаа "би-үгүй"-г онож мэдсэнээ дахин бясалгах шаардлагагүй болох нь ээ? гэхэд, Тэгвэл бясалгах шаардлагатай. "Бясалгалын мөр"-ийн тэвчигдэхүүнүүдийг "Үзэх мөр" төдийгөөр тэвчиж чадахгүй гэсэнтэй адил байна.

Энэ үест ч өмнө нь сонсох, санах зэргээр нотлон буулгаж магадалж авсан хэдий ч түүнийгээ дадуулж бясалгах хэрэгтэй шүү дээ. Хэдий чинээ нотлон буулгах утгаа дадуулж бясалгах тусам төдий чинээ өнөөх магадлал нь хүчтэй, чадалтай, өнө удаан, бас намба байдал нь тодорхой, баттай болох зэргээр үзэгдэнэ. Тиймээс *"Тийн тайлбар "-аас:*

Магадлах болоод гүтгэх (хөөрөмших) сэтгэл нь
Хорлогч ба хорлогдохууны мөн чанарт

хэмээн айлдсэн мэтээр энэ хоёр нь хорлогч, хорлогдохуун мөн тул хэдий чинээ магадлах сэтгэл баттай, хүчтэй, чадалтай байх тусам л гүтгэх бодлуудыг хорлох болдог.

Энд ч өвөрчлөн үгүйг магадалсан сэтгэлийг л улам дээш баттай болгох хэрэгтэй. Үүнийг л хорлох ба бүтээхийн олон үүднээс санах шаардлагатай билээ. Хэрэв чингэхгүй бол мөнх бус, үйлийн үр, орчлонгийн гэм эргүү, бодь сэтгэл, асрах, нигүүлсэх сэтгэл тэргүүтнийг ухаарах төдий болоод ямар ч шинжлэл хийлгүйгээр "би чинь үхэх юм байна" гэх зэрэг ганц нэг зүйлийг л

барьж бясалгах хэрэгтэй болно. Бусад бүх шалтгаанууд адил болно.

Тиймээс жинхэнэ магадлал төрүүлэхийн тулд "би чинь үхнэ" гэх, "амьтныг тусад бурханы хутаг олсугай" гэх, "амьтан хөөрхий ээ" гэх зэргээр тангараглах төдийгөөр хязгаарлахгүй олон талаас нь учир шалтгааныг санаж тунгаах хэрэгтэйн адилаар, өвөрчлөн үгүй чанарыг баттай, сайнаар магадлаж мэдэхэд ч зөвхөн тангараглах төдий нэгнээр хязгаарлахгүйгээр хорлогч, бүтээгч зэргийн олон үүднээс тунгаах хэрэгтэй бөгөөд бага төрөлхтний үест ч олонтаа номносон билээ. Тэр талаар "*Бясалгалын гурван зэрэг*" гурвууланд амарлингуй сэтгэлийг бясалгахын цагт шинжлэлийг олонтаа хийж бясалгахыг айлджээ.

Мөн *"Орохуй"-гаас ч:* "Егүзэр бээр "би"-г хорьж үйлдэх зэргийг бясалгалын үест тийн үйлдэхийг айлдсан бий. Егүзэр нь амарлингуй, үлэмж хоёрын аль нэгийг олсон учраас, амарлингуй сэтгэл олохоос өмнө үзэл онолын ухаарал эрэлзээгүй нэгэн төрөхгүй ч бус. Бясалгалын дияанаас өмнө ухаарах үест үзэл онолын шинжлэл байна гэж айлдсан тул түүний эрэмбэ дараалын аньсаар бясалгал дияаныг бүтээж "хоёр би-үгүй"-г шинжлэх хэрэгтэй билээ. *"Төв үзлийн зүрхэн"-ээс:*

Оюун сэтгэлээ тэгш агуулсны дараагаар
Нэрийдэх үүдний баригдахуун болох
Ном бодас юмс тэдгээрийг
Ухаан билгээр энэ адилаар шинжих хэмээн айлджээ.

"*Тайлбар*"-т: "Бясалгал төрсний дараагаар үзэл онолын шинжилгээг үйлд" хэмээн айлдсан ба *"Бодисадвын явдалд орохуй"*-гаас ч, амарлингуй сэтгэлийн тухай бясалгал дияаны бүлгээс үзүүлсэн дагуу бүтээж, дараа нь ухаандаа бясалгахдаа ухаанаар шинжилж бясалгахыг айлджээ. Тиймээс сүүлийн хоёр барамидын эрэмбэ зэрэг болон сүүлийн хоёр суртгаалын эрэмбэ зэрэг бүгд нь бясалгал дияаныг өмнө нь одуулсны дараа ухаан билгийг бясалгах эрэмбэ бөлгөө. Тэрхүү ухааныг бясалгах ёс болгож үнэмлэхүй ба янагуухуйг шинжлэх үүднээс айлдсан бүгд бясалгалын эрэмбэ мөн тул буруугаар ажиглаж бүү үйлдээрэй. Түүгээр зогсохгүй их гол номуудаас ч тэр мэтээр айлдсан тул бясалгахын үест ажиглал, шинжлэл байна гэдэг эргэлзээгүй.

Чингээд амарлингуй сэтгэлийг бүтээсний дараа үлэмж үзэхүй ухааныг бясалгах цагт зөвхөн шинжлэл хийнэ гэвэл өмнөх амарлингуй эвдрэх болно. Шинээр ч төрөөгүй учраас амарлингуй сэтгэл байхгүй бол үлэмж үзэхүй үл

төрөх учиртайг дээр номносон мэт болой. Тиймээс өмнө нь тогтоож агуулах амарлингуй сэтгэлийг ч бясалгах хэрэгтэй. Бас шинжлэх бясалгалыг үйлдэх хэрэгтэй тул хоёулаа шаардлагатай болно. Улмаар үлэмж үзэх ухаанаар шинжлэх бясалгал хийсний эцэст тэр утгаа тогтоон бясалгаснаар "би-үгүй"-н хоосон чанарыг бясалгаж амарлингуй, үлэмж үзэхүй хоёрыг хослон барилдуулж бүтээх болно. *"Бясалгалын дунд зэрэг"-ээс:*

"Хутагт чухаг дээдийн үүлэн судар"-аас зарлиг болруун, ийнхүү гэм буруүд мэргэшигч тэрээр цацрал бүгдээс салахын тухайд хоосон чанарыг бясалгах егүзэр бясалгалыг үйлдэнэ. Тэрээр хоосон чанарыг бясалгах олон тул ямар ямар оронд сэтгэл цацарч байна, сэтгэл илт баясах тэр орон хийгээд тэдгээрийн мөн чанарыг сайтар эрэлцэн байж хоосон чанарыг онох болой. Тэр мэтийг оносноор бэлгэсгүй егүзэрт орох болой хэмээн айлджээ. Үгээр төгс онохын өмнө нь хоосон чанар, бэлгэсгүй чанарт орохыг өгүүлжээ. Сэтгэлдээ үйлдсэнийг огоот тэвчих төдий болон ухаанаар бодас юмсын мөн чанарыг шинжлэлгүйгээр асар атгаглан орж болохгүйг маш тодорхой үзүүлвэй хэмээжээ.

Энэ эшээр, сэтгэл цацрах орон болоод цацруулагч эзний сэтгэл зэргийг шинжилж хоосон болохыг онох ба хоосон болохыг онохдоо эрж хайж, ажиглаж, шинжилж байж хоосон болохыг мэднэ.

Чингэж байж бэлгэсгүйн бясалгалд орно гэж айлдсан тул төгс шинжлэлээр эрэлцэх ухааны шинжлэлийг өмнө нь одуулалгүйгээр, Хуушааны үздэг шиг сэтгэлийн цацралыг хураангуйлж сэтгэлдээ үйлдэх зэргийг тэвчсэн төдийгөөр бэлгэсгүй болох буюу үл атгаглах төдийгөөр "орж болохгүй" гэдгийг тодорхой үзүүлжээ.

Тиймээс өмнө нь номносон мэт ном юмст "хоёр би-гийн мөн чанар" нь тоосны төдий ч байхгүй болохыг ухааны илдээр нээж хоосон чанарыг магадлах болно. Тэр мэтээр "хоёр би нь бодитой байхгүй" учир түүнийг хорьсон "бодит үгүй нь ч үнэхээр бүтсэн" гэж хаанаас байх вэ. "Хүүсэр эмийн хөвгүүн байхгүй" хэмээхэд түүний "бодит бус" (байхгүй байгаа) нь байна" гэж барихдаа хүүсэр эм болоод хөвгүүн хоёуланд харгалзан байж буюу тэр хоёр хэзээ ч үл тухайлагдах учраас болой. "Хүүсэр эмийн хөвгүүн байхгүй" гэхэд хэзээ ч үнэхээр байна гэж нэрийн төдий ч сэжихгүйтэй адилаар "бодит юмс үнэн байх нь хаана ч, ямар ч суурь дээр тухайлагдахгүй байхад түүний бодит бусыг үнэнээр буй" гэж барих атгаг ч төрөх учиргүй юм.

Тиймээс л бэлгэст барих атгаг бүгд няцах буюу. Үнэнд баригч атгаг

мөн бол бодит юм уу, бодит бусаар үнэнд барих атгагийн аль нэгэн болох албатай учраас "түгээгч нь няцвал, түгээгдэхүүн нь няцна" гэж "*Бясалгалын дунд зэрэг*"-ээс айлдсан болой.

Тэр мэт бодит буй, буй бусын алинд ч үнэхээр бүтсэн зүйл тоосны төдий ч байхгүй гэж язгуураас хөөж гаргасан магадлалыг олж, тэрхүү мухарлаж олсон утгаа хоёр агуулгат бясалгалаар ээлжилж үйлдсэнээр тийн үл атгаглах билгэ билиг төрөх болно. Түүнээс бус орон вишайгаа огтхон ч үл шинжилж сэтгэлдээ үйлдэж хураах төдийгөөр бүтээж чадахгүй. Учир нь үнэнд барих сэтгэлийг тэвчиж чадахгүй л дээ. Тэрээр "үнэхээр байна" гэж үл атгаглах төдий л болохоос хоосон чанарыг онох бус аа. Тэрчлэн "би байна" гэж үл атгаглах төдий мөн. "Би-үгүй"-г онохгүй тул түүнийг бясалгаснаар "би-д баригч"-ийг яагаад ч хорлож чадахгүй. Тиймээс "үнэхээр байна" болон "хоёр би буй" гэж үл атгаглах хийгээд "үнэхээр үгүй" болон "хоёр би-үгүй чанарыг онох" зэргийг ялгаж салган ойлгох хэрэгтэй тул үүнийг л аньст утга гэж барихтун.

б) Энэ талаарх тэмцлийг няцаах

Эсэргүүцэх нь: "Би-үгүй"-н утгыг тус тус шинжлэх нь атгаг учраас түүнээс тийн үл атгаглах билгэ билиг төрөхөд харшлах болно. Үр дагавар болон үндэс шалтгаан хоёр дагалдах зохилдох хэрэгтэй билээ.

Хариулт: Энэ талаар Ялж төгөлдөр нөгчигсөн бээр үлгэр жишээ татаж "*Одсүрэнгийн айлтгасан бүлэг*"-ээс:

Одсүрэн! Энэ адил буюу. Үлгэрлэвээс салхинд үлээгдэж, хоёр мод хавиралдсанаас гал гардаг. Гал гарсанаар хоёр мод шатна. Одсүрэн! Түүнтэй адилаар үнэхээр тус тус атгаглагч байснаар хутагтын ухааны эрхтэй төрнө. Тэр төрснөөр тус тусын атгагаас хутагтын билиг ухаан төрөх учиртай" хэмээн зарлиглажээ.

Мөн "*Бясгалгалын дунд зэрэг*"-ээс:

Тэрхүү ухаанаар шинжлэх шинжлэл нь егүүзэр бээр аливаа үнэмлэхүй мөн чанарыг магадлан бариагүй тэр цагт хэзээд тийн үл атгаглах бясалгал болж оршдог. Аливаа билгээр бодит юмсын мөн чанарыг тэвчих төдий нэгнийг бясалгахад түүний намба байдал хэзээ ч үл буцах бөгөөд мөн чанаргүй ямагтыг хэзээ ч үл олно. Учир нь билгийн гэгээ байхгүй болой. Энэ мэт үнэхээр тус тусын атгагаас үнэхээр ёсчлон мэдсэн билгийн гал гарахад хэт цахиурын гал адил модыг шатаах болой хэмээн Ялж төгөлдөр нөгчсөн бээр зарлиг болжээ

хэмээжээ.

Эс чингэвээс цувиралт мөрөөс цувиралтгүй мөр гарахгүй болж, эгэл төрөлхтөн бээр бодь хутаг олж болохгүйд хүрнэ. Үндэс шалтгаан, үр дагавар адилгүй учраас. Мөн саарал хөрөнгөнөөс хөх ногоо төрөх, галаас утаа гарах, хүүсэр эмэгтэйгээс хүүхэд төрөх зэрэг хоорондоо намба төрх харилцан адилгүй элдэв үндэс шалтгаан, үр дагаврууд үзэгдэнэ.

Хутагтын тийн үл атгаглах билгэ билиг болвоос "хоёр би"-д барих сэтгэлийн орны хоосныг буюу "би-үгүй" утгыг илт оносон ухаан мөн. Түүнийг төрүүлэхийн тулд одоогоос эхлэн "би"-д барих орныг тус тус шинжилж, түүнийг байхгүй юм байна гэдгийг онохын үүднээс дадуулж бясалгах хэрэгтэй. Тэрээр атгаг мөн боловч үл атгаглах билгэ билигтэй машид даган зохилдох үндэс шалтгаан мөн билээ. *"Бясалгалын хаан судар"-аас ч:*

Гэсэн хэдий ч номын би-үгүйг тус тус атгаглах" хэмээн дээр үзүүлсэн мэтээр буюу.

Мөн *"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс ч:*

Тэр нь тийн атгагийн мөн чанарт боловч ёсчлон сэтгэлдээ үйлдэхийн мөн чанарт болой. Тийн үл атгаглах билгэ билиг болж урвах учир тэрхүү билгэ билгийг зөвшөөрч, түүнийг шүтээрэй хэмээсэн буй.

Эсэргүүцэх нь: Гэсэн ч *"Билгийн чанад хүрэхүй"-гээс:* Дүрс тэргүүтэн хоосон чанарт, "би-үгүй" болой хэмээн шинжвээс бэлгэст чанарыг эдэлсэн болно гэж айлдсан учраас хоосон чанарыг тус тус атгаглаж шинжсэн болж таарахуй биз дээ?

Хариулт: Ийн өгүүлсэн нь хоосон чанараа үнэхээр бүтсэн гэж үзэхийг заасан болохоос хоосон болой" хэмээн бодох төдийг биш гэдгийг дээр олонтаа номлосон билээ. Эс чингэвээс, дээрх судруудаас:

Бодисадва, их бодисадва нар билгийн чинад хүрэхүйг эдлэх бөгөөд билгийн чинад хүрэхүйг ч бясалгаад энэ адилд ойртон ажиглах мөн, билгийн чинад хүрэхүй энэ алиных вэ? Юу үгүй болж юу ч үл тухайлагдах түүнийг билгийн чинад хүрэхүй мөн буюу хэмээх зэргээр тэдгээрт ойртож шинжих, тэр мэтийн лавтай санах хэмээн билиг барамидыг бясалгахын цагт шинжилж байхыг айлджээ.

"Билгийн зүрхэн"-ээс: Гүн билиг барамидыг хэрхэн судлах талаар

асуусны хариуд: "Таван цогцос тэдгээр өөрчлөнгөөр хоосон болохыг үнэхээр дагуулан үзэх болой" хэмээсэн ба, *"Хураангуй"-гаас ч:*

> Алин цагт хурсан, эс хурсан болон буян, нүгэл зэрэг ном юмсын
> Ухаанаар тийн задлан үзэхэд тоосон төдий ч үл тухайлах тэр цагт
> Ертөнц дахинаа билгийн чинад хүрлээ гэж тооцон одох

хэмээн билгээр ном юмсыг шинжлэн үзээд тоосны төдий ч тухайлагдах зүйл байхгүйг мэдэхлээр л сая билгийн чинад хүрэхийг айлджээ.

Асуулт: Тиймээс тус тус шинжих ухаан хэрэгтэй болохыг олонтаа айлдсантай юунд харшлах билээ. Чингэж эс үзвээс ном юмсыг шинжилж бүү үйлд гэж айлдахын учир юунд оршино вэ?

Хариулт: Хуушаан шиг аливаа атгаглах бүгдийг орчлонд хүлэгч гэж үзвээс л үл атгаглах түүний увдисыг айлтгав, түүнийг бясалгав хэмээх зэрэг бүгдийг л хүлээс гэж үзэх хэрэгтэй болно. Тэд бүгдийг дээр олонтаа хорьсон болой.

Чингэж тэдгээрийг үнэнд үл барих нь эш номын утга болдог. Үнэнд баригч атгагийг хорих гэдгийг үлгэрлэвээс, дээсийг могой гэж эндүүрэн айдас зовлон төрөхөд тэрхүү сэтгэлд үзэгдэх адилын могой байхгүй гэдгийг магадалж мэдрээд ирэхээр нөгөө эндүүрэл тийн буцна. Өөр арга байхгүй тул үнэн гэж барих бодлын орон болох үнэнг мэдээд түүний утгыг асуух хэрэгтэй. Үнэнд барих сэтгэлийг нааш эргүүлэх төдийхнөөр хорьж чадахгүй билээ. Мөн үнэн гэж барих бодлоо эндүүрэл гэж үзэх хэрэгтэй. Эндүүрэл биш бол хорих хэрэггүй л дээ. Ямар нэг ухааныг эндүүрэлтэй гэж үзлээ ч түүний барих орон тэр нь байхгүй гэдгийг нь эс мэдвээс эндүүрэлтэй гэдгээ хэрхэн мэдэх билээ. Эндүүрсэн, эндүүрээгүй ухаан гэдэг нь зөвхөн баригдах орон нь буй, буй бус хоёрт л тулдаг учиртай.

Үнэхээр гэж барих сэтгэлийн (үнэнд баригч) вишай орон байхгүй болохыг зөвхөн тангараг төдийхнөөр нотлохгүй ээ. Түүнийг нотлох хиргүй эш ухааны цогц зэргээс хамаарна. Тэр мэтээр үйлдэж үнэн бусыг нотлон буулгах ба "үнэхээр гэж үл атгаглаж агуулана" гэж бид нар баримтална. Тиймээс урьд нь одуулсан тус тус онох ухаанаар шинжлэх "үл атгаглал" хэрэгтэй. Зөвхөн үл атгаглал байх төдийгөөр ч хязгаарлахгүй. *"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс ч:*

> Тийм учраас дээдийн номыг дурдан санахгүй байх, сэтгэлдээ бодохгүй зэргүүд алин гарлаа ч урьд нь үнэхээр тус тус онох ухаан байсан гэж үзээрэй. Учир нь үнэхээр тус тус атгаглаж байж л дурдан санаагүй байгаагаа, сэтгэлдээ

үйлдэхгүй байгаа зэргээ ялгаж чадна. Бусад нь чадахгүй хэмээжээ.

Мөн үлэмж үзэх ухаан нь үнэхээр тус тус онохын мөн чанарт болохыг "*Чухаг дээдийн үүл*" болон "*Таалал магадтай тайлбар*" зэргүүдээс ч зарлиг болгожээ. "*Хутагт чухаг дээдийн үүл*"-нээс зарлиг болруун, "Үлэмж үзэхгүйгээр шинжиж мөн чанар байхгүй хэмээн онох нь бэлгэсгүйд орох болой" хэмээн айлджээ. *"Хутагт Ланкаад заларсан судар"-аас:*

Их егүзэр нар аа, өөрийн болоод ерөнхий бэлэг чанарыг ухаанаар шинжихэд баригдах буюу. Тиймээс ном бүгд өөрийн мөн чанаргүй хэмээн зарлиг болвой. Хэрвээ үнэхээр тус тус ажиглал хийхгүй бол тийнхүү Ялж төгөлдөр нөгчигсөнөөс судрын аймаг тэдгээрээс үнэхээр тус тус ажиглах ёсыг олон зүйлээр буулгасантай харшилна.Тиймээс л миний ухаан өчүүхэн, хичээл шамдлага бага, олныг сонгож огоот эрэлцэж чадахгүй болой хэмээн ийн хэмээн өгүүлэх язгууртнаа олонтаа сонсохыг Ялж төгөлдөр нөгчигсөн бээр сайшаасан тул цаг үргэлжид бүхнийг тэвчих нь зохисгүй хэмээн айлдсан дагуу ухаараарай.

Тэрчлэн "дүрсээс хамгийн болгоогч хүртэлх алин юунд ч ухаан оршихгүй" гэж айлдсан нь ч тэдгээр орших орнуудыг үнэхээр гэж барьж болохгүйг заасан буюу. Эс чингэвээс зургаан барамид зэргийг ч тийн айлдсан тул гээд тэдгээр оршиж болохгүй юм байна гэж ойлгочих бий. Үнэхээр гэж бариваас л дээр номносон мэт болох тул тэдгээрийг үнэхээр бус гэж оносон ухаанаас хэрхэх нь хамаарна. Тиймээс тэр мэтээр үл орших болон үл баригдах гэж айлдсан, бүгдээр орон вишайнууд өвөрчлөн болон үнэхээр бүтэхийг хорьсон, үнэхээр тус тус шинжих ухааныг урьдаар одуулсан байх зөвхөн тэр нөхцлийг айлдсан гэж ойлгоорой. Тиймийн учир санаанд багташгүй буюу оюун ухаанаас хэтэрсэн гэх зэргээр судар зарлигаас айлдсан нь тэр бүхнийг зөвхөн гүн гүнзгий утгыг сонсох, санах төдийхнөөр оночихно гэдэг хөөрүү бодлуудыг хааж буй хэрэг. Тэд чинь хутагтын тус тус онох өөрийн ухааны мэдэгдэхүүн учир бусдын санаанд багташгүй гэж заасан буюу. Гүн гүнзгий утгыг үнэхээр гэж ёс бусаар бодох сэтгэлийг ч хаахын тухайд айлдсан буй. Тус тус оногч ухаанаар ёсчлон шинжихийг хориогүй гэж мэдээрэй. *"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс:*

Аливаа санаанд багташгүй гэх зэргийн үгийг сонсох цагт энэ тэрийг зөвхөн сонсох, санах төдийхнөөр тэр ямагт (хоосон) чанарыг мэдчихлээ гэх тэрхүү илт омог хөөрлийг дарахын тулд ном юмс нь зөвхөн тус тус онох өөрийн ухааны оногдохуун болохыг заасан болой. Ёс бусын бодлыг тийнхүү хорьсон

болохоос таньж мэдэх буюу үнэнээр тус тус онох ухааныг хорьсон хэрэг бус аа. Эс чингэвээс олон эш болоод ухаантай харшлах билээ хэмээн айлдсан мэт.

Олон эштэй харшлах нь: "Одсүрэнгийн бүлэг"-ээс:

Одсүрэн! Төв мөрийн номыг үнэхээр тус тус онох гэж юу бэ? Одсүрэн! Алин "би-үгүй"-г тус тус онох ба амьтан буй бус, амь нас буй бус, тэжээх буй бус, төрөлхтөн буй бус, бодгаль буй бус, чөтгөрөөс төрөх буй бус, чөтгөрөөс төрсөн хөвгүүн буй бус гэх зэргээр тус тус онох буюу. Одсүрэн! Төв мөрийн номуудыг үнэхээр онолоо хэмээх эдгээрүүд нь тэдгээрүүдтэй харшлах болой хэмээжээ.

"Бясалгалын эхний зэрэг", ""Тийн үл атгаглан орох тарни тогтоол" зэргүүдээс:

Сэтгэлдээ бодохгүй бол дүрс тэргүүтний шинж бэлгэсийг тэвчиж чадахгүй" хэмээсэн тэдгээр ч бай, ухаанаар шинжлэхэд сэтгэлд баригдахгүй байгаа алин түүнийг л сэтгэлд баригдахгүй гэсэн болохоос бус, сэтгэлдээ бодож тунгаах зэргийг үгүйсгээгүй билээ. Хур мэдэлгүй орны тэгш оршигч нар шиг тэргүүлшгүй цагаас дүрс тэргүүтнээ илт шунах зэргийг сэтгэлдээ санах төдийг ч тэвчих зэргээр бус болой хэмээсэн буюу.

Эл багшийн зохиосон дээрх "*Тарни тогтоолын тайлбар*"-т ч тодорхой буй. Товчилвоос, их хөлгөний ёсноо Нагаржунай, Асанга хутагт нарын гол номын ёсыг дэлгэрүүлэн тайлбарласан үзэл онолын хоёр ёсноос өөр үзэл онол байхгүй билээ. Энэтхэг, Түвдийн дээдэс мэргэд бүтээлчид ч энэ хоёрын тайлбар дагуу хоёр үзлийн аль нэгийг нь магадалж түшсэн үзэгдэх тул огтхон ч эргэлзэлгүй энэ хоёрын үзэл онолын аль нэгийг өөрсдийн ёсны дагуу суралцаарай. Мөн хутагт эцэг, хөвгүүний гол номонд шүтэж суралцах ёсыг дээр номносон билээ. Асанга хутагтыг дагахдаа ч тэр ямагт чанар нь баригдахуун ба баригч нь тус тус эдэт болохоос хэзээд хоосон байх ёстой ч нялхасууд тэдгээрийг тус тусдаа эдэт гэж үзэх ба үзсэн дагуу үнэхээр гэж барих орон болсон "хотол нэрийдсэн" бүхнийг, "өөрийн эрхэт"-ийн дээр оршихыг эш болоод ухаан бүгдийн үүднээс хорьж хоёр үгүй утгат "огоот бүтэх" үзлийг баттай магадалж олно гэнэ. Агуулах бясалгал болон тус тус шинжлэх бясалгал хоёрыг тэрхүү үзэл онол дээрээ тогтоож бясалгах хэрэгтэй гэнэ. Хэдий тийм ухаарал байвч бясалгах цагт тэрхүү үзэл онол дээрээ тогтохгүй, ажиглахгүй байх төдийхнөөр гэвэл хоосон чанарын бясалгал болохгүй.

"*Билиг барамидын үвдис*"-аас энэхүү ёсны үзэл онолын тухай тодорхой нотлолууд, нотлон буулгасан утгууд, амарлингуй, үлэмж үзэхүйн тус тусын бясалгах ёс, хослон барилдах учир холбогдол зэргийг маш тодорхой үзүүлсэн тул тэндээс үзээрэй. Энэ ёсыг сайтар мэдэж гол номоос гарсан дагуу бясалгаж үйлдвээс л маш гайхамшигтай болно. Их хөлгөний эрхэм зарлигуудаас гүн утгын хураангуйлан заасан нижгээд олон буй ч, тийн заагаагүй ч олон бий. Тиймээс заасан гол номоос авах хэрэгтэй бөгөөд хураангуй аваас дэлгэрэнгүйгээс нь авах хэрэгтэй. Улмаар агуу явдлын зүгээс ч мэдэж авах хэрэгтэй. Гүн болоод агуу их хоёрын аль алин нь байхгүй тийм зүгийг даган барьж болохгүй. Үүнийг болгоож мөрийг заагч багшийн бэлэг чанар төгс төгөлдөр байх хэрэгтэй гэж хамаг хөлгөний мэргэд олонтаа айлджээ.

25

АМАРЛИНГУЙ, ҮЛЭМЖ ХОЁР ХОСЛОН ОРОХ НЬ

в) Бясалгах ёсны аньсийг өчүүхэн номнох
г. Үлэмж үзэхүйг бясалган бүтээх хэмжээ
3. Амарлингуй сэтгэл, үлэмж үзэхүй ухаан хоёр хослон барилдах ёсон
4. Ерөнхий утгын хураангуй
Төгсгөлийн туурвил буюу ерөөлийн үг

- - - о О о - - -

в) Бясалгах ёсны аньсийг өчүүхэн номнох

Дээр номносон мэтээр магад утгат үзлийг олсон тэрээр "би болоод минийх болой" хэмээх бодол төрөх суурь "би болоод минийх" хэмээх нь "өөрчлөнгөөр байхгүй"-г нотлон буулгах цагт буюу тус тус ажиглах ухаанаар олонтаа шинжлэн судалсаны эцэст утгыг ухаарах хүч олно. Цацруулалгүй барих агуулах бясалгал болон тус тус онох ухаанаар шинжилгээг ээлжлэн хийнэ. Тэр цагт шинжлэх бясалгал ихэдвэл тогтох хувь нь багасах ба агуулах бясалгал нь ихэдвэл тогтох хувь нь мөн адил байна.

Агуулах бясалгал олонтаа үйлдэх хүчээр тогтох байдал ихэсч шинжилгээ хийх хүсэл төрөхгүйд хүрэх бий. Шинжлэл хийхгүй бол хоосон чанарыг зөв ухаарсан бат хүчит магадлал төрөхгүй. Тийм магадлал төрөхгүй болохоор өнөөх магадлалыг няцаах зүгүүд болон "хоёр би"-г байна гэж үзэх хэтийдэл мунхагаа арилгаж чадахгүйд хүрэх тул шинжлэх бясалгалыг олонтаа үйлдэхийн үүднээс амарлингуй, үлэмж үзэхүй хоёрыг хувь тэнцүү бясалгана. *"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс:*

Хэзээ үргэлж үлэмж үзэхүйг бясалгаваас ухаан билгийн хувь нэмэгдэж, харин амарлинуй сэтгэлийн хувь багасдаг. Салхинд тавьсан зул адил сэтгэл үелзэн хөдлөх үед хоосон чанарыг тодорхой үзэж чадахгүйд хүрнэ. Тэр цагт л амарлингуй сэтгэлийг бясалгаарай. Амарлингуйн хувь их болоход ч нойронд автсан хүн шиг хоосон чанарыг тодорхой үзэхгүйд ч хүрдэг. Тиймээс тэр цагт л билгийг бясалгаарай хэмээжээ.

Бясалгалын бэлтгэл, төгсгөл болон завсрын үест хэрхэх талаар "*Бага төрөлхтний үе*"-д номносон дагуу мэдээрэй. Тийнхүү хоосон чанарыг бясалгахын цагт живэл, дошигрол ирвээс танин барих, тэдгээрийг буцааж

дурдан санах ба ухамсарыг шүтэх ёс, живэлт, дошигрол зэргээр тэнцвэр алдахгүй байх, аяндаа оргоч тэгш агуулах бясалгал олох, хичээх шамдахаа султгах зэргүүдийг дээр амарлингуйн үест номносонтой адил болой. *"Билиг барамидын үвдис"-аас:*

Алин бясалгах орон түүнээ амарлингуй сэтгэлийн бясалгал үйлдэж машид судалсан сэтгэлийг олно. Мөн түүнээ үлэмж үзэхүйн бясалгалыг үйлдэж машид судалсан сэтгэлийг олно. Хэдий тэдгээрийг тус тус бүтээвч ч хослон барилдуулах хэрэгтэй хэмээн айлджээ.

Энэ мэтээр шинжлэх ба агуулах хоёрыг үргэжлүүлэн нэг болгосон нотолгоо харагдахгүй байгаа тул тус тусын тасалгаа хэмжээгээр үйлдсэн болохыг айлджээ. Энэ үест ойлгох хамгийн чухал зүйл гэвэл, миний мунхагаар гүтгэгдэж хөөрсөн баригдахуун орныг сөхөөж няцаах үүднээс л түүний няцагдахуун зүг болох өвөрчлөнгөөр хоосорсон-хоосон чанарын утгаа хүчтэй, баттай магадлах ухаан төрснөөр л сая хоосон чанарыг бясалгал болох учиртай. Харин "би"-д баригч мунхагийн орныг сөхөөн няцаахгүйгээр хоосон чанарын өнцөг төдий нэгийг барьж бясалгавч хоёр "би-үгүй" хэзээ ч хорлож чадахгүй болно.

"Чөтгөрийн хорлол зүүн зүгээс ирэхэд золиг балингаа баруун үүд рүү чулуудахтай адил" хэмээн дээдсүүд дахин дахин буруутгаж шүүмжилсэн үзэгдэнэ. Дээр номносон эдгээр нь бүдүүн нэгэн төдий билээ. Бясалгах үед тохиох нарийн ширийн гэмүүдийн тухай мэргэн багш нарыг шүтэж буюу өөрөө ч гэсэн бясалган байж онох хэрэгтэй тул бичсэнгүй. Эдгээр бясалгах ёсыг урьд гарсан бодь мөрийн зэргийн увдис номуудад түшиж дэлгэрүүлэн талбисан болно. Бодова гэгээний *"Өврийн дэвтэр"-ээс:*

Заримууд сонсох, санахын үест ухаарсанаар
Өвөрчлөн үгүйг нотлон буулгана гэх ба
Бясалгахын цагт ажиглал хийлгүй шууд бясалгана гэх
Тийм болвоос барилдагагүй болж хоосон чанарыг

Буруугаар бясалгах учир эрөндөг болохгүй
Тиймд бясалгахын цаг боловч
Нэг болон олноос хагацсан шүтэн барилдахуй тэргүүтэн
Алин юуг ч тус тус шинжилж бясалгах бөгөөд

Өчүүхэн ч бай ажиглах ямагтад орших
Тэр адилаар бясалгаваас нисваанисын эрөндөгийг

Хамтад нь даган барив гэж үзэх бөгөөд
Барамидын мөрөөр замнахыг хүсвээс л

Билгийг бясалгах ёс болсон энэхүү
Бодгалийн "би-үгүй"-г бясалгаж
Улмаар тэр адилаар даган орж үйлд хэмээсэн мэт,

Энэ талаар *Жову гэгээн бээр:*

Хоосон чанарыг хэрхэн онох вэ? хэмээвээс
Тэрчлэн залрагсадаас эш бошго үзүүлсэн
Номын чанар - үнэмлэхүй үнэнийг болгоогч
Наражунай гэгээний шавь Чандракирти зэрэг

Тэднээс дамжин увдисаар
Номын чанар-үнэмлэхүй үнэнийг онох болой хэмээсэн буй.

Түүнийг хөтлөх ёсны талаар *Жову гэгээн бээр:* Төв үзлийн увдист айлдсан мэтээр шинжлэх бясалгал болон тийнхүү шинжилсэн утганаа агуулах бясалгалыг ээлжлэн үйлдэхийг айлдсан нь энэ болой. Энэ нь Камалашила багшийн ёстой таарна. Дээр номносон "*Төв үзэлд орохуй*", "*Төв үзлийн зүрхэн*" зэрэг шастаруудын болон Шантидэва гэгээн нарын таалалтай ч мөн адил болой. "*Майдарын ном*" болон "*Хутагт Асангагийн гол шастарууд*"-аас ч олонтаа номносон бөгөөд түүний ёсыг эндүүрэлгүй баригч Шантидэва гэгээн бээр ч "*Билиг барамидын увдис*"-таа тодруулан тайлбарлажээ. Эдгээр нь үлэмж үзэхүйн бясалгах ёсыг номносон Нагаржунай, Асанга хоёроос дамжуулан гол ном увдисуудтай таардаг билээ.

г. Үлэмж үзэхүйг бясалган бүтээх хэмжээ

Тэр мэтээр тус тус онох ухаанаар шинжлэн бясалгахад дээр номносон машид судалсан сэтгэл төрөөгүй байх хугацаанд үлэмж үзэхүйтэй даган зохилдсон нэгэн оршино. Тэрхүү машид судалсан сэтгэл төрөхөөр жинхэнэ үлэмж үзэхүйн бэлэг чанар гүйцнэ. Машид судалсан сэтгэлийн мөн чанар болон төрөх ёс нь дээр номносонтой адил аа. Энд үед урд төрсөн амарлингуй хүч хараахан сулраагүй тул түүгээр татагдсан машид судалсан сэтгэл байх тул гагц машид судлах сэтгэл төдий ч бас биш ээ. Чингэвэл юу вэ? Шинжлэх бясалгал хийсний хүчээр машид судалсан сэтгэл хүчтэй татагдаж төрнө. Улмаар үлэмж үзэх ухаан болж хувирдаг. Энэ нь янагуух болон үнэмлэхүй үнэнд зорьсон хоёр үлэмж үзэхүй хоёулан дээр адил байдаг. Тэр талаар

"Судрын аймгийн тааллын тайлбар"-аас:

Ялж төгөлдөр нөгчигсөн! Бодисадва тэрээр хэзээ машид судалсан бие, сэтгэлийг олох хүртлээ хэрхэн сайтар тунгааж санах тэдгээр номоо самади бясалгалын орон болгож тусгал дүрс мэт сэтгэлдээ бодож байгаа тэр бодлыг юу гэх вэ? хэмээсэнд, Майдар аа! Үлэмж үзэхүй биш ээ. Үлэмж үзэхүйтэй даган зохилдсон буюу ижилдүү сүслэх сэтгэл мөн гэж өгүүлсүгэй хэмээжээ.

"Билиг барамидын үвдис"-аас ч:

Тэрээр машид судалсан бие болон сэтгэлийг олсон түүндээ л оршиж буй тэр. Хэрхэн бодох учиртай тэр ямагтын утгаа хөрөг дүр мэтээр бясалгах орон болгож үлэмж дурлан тус тус шинжлэх буюу. Хэдийд машид судалсан бие, сэтгэл эс төрөх тэр хүртэл үлэмж үзэхүйтэй даган зохилдсон бодол сэтгэлүүдээр үйлдэнэ. Хэдийд тэр төрсөнөөр үлэмж үзэхүй болох болой хэмээн айлджээ.

Янагуухийг бодсон амарлингуй, үлэмж үзэхүй хоёрын хослон барилдах ёс нь үнэмлэхүйг бодсон тэр хоёртой адил гэж айлджээ. Өөрийн хүчээр машид судалсан түүнийг татаж төрүүлж чадваас нэгэн үзүүрт сэтгэлээр ч түүнийг татаж төрүүлэх тул тус тус онох, шинжлэх бясалгалаар нэгэн үзүүрт сэтгэлийг татаж төрүүлэх нь амарлингуй сэтгэлийн эрдэм болно. Тэр мэт амарлингуйг сайтар бүтээгч нэгэн бээр шинжлэн бясалгахдаа амарлингуйг нөхөр болгох ч байх тул тус тус шинжлэн бясалгахад тогтох хувь нь багадана гэж бүү бодоорой.

Үнэмлэхүйд тухайлсан агуулах болон шинжлэх бясалгалыг үйлдэхдээ үлэмж үзэхүйн бясалгал мөн бишийн хэмжээг тодорхойлохдоо "хоёр би-үгүй" үзлийн аль нэгнээ эндүүрэлгүй, зөв ухаарлыг олж, түүнийг тухайлан бясалгах ба бясалгаагүйн үүднээс ялгах хэрэгтэйгээс бус өөр бусад юугаар ч ялгаж чадахгүй.

Тэр адилаар ялгаж чадахгүй юу? Бясалгаж сурснаар орон, оронт хоёр гэж хоёр үзэгч бүдүүхэн үзэгдлүүд хаагдаж тэнгэр цэлмэх мэт сэтгэл нь тунгалаг, тодорхой гэгээн ялгамжааг олж, салхинд үл бөхөх зул мэт өнөд удаан тогтуун болж гадаад, дотоодын орон үзэгдлүүд огторуйд солонго татах буюу нимгэн утаа хөшиглөх адилын байдалтайгаар сэтгэлд ургаж удаан оршино. Дотоод сэтгэлийн нигуурт ургах орон бүхэнд сэтгэлээ тушаах ба тушаасан ч өчүүхэн төдий ч тэсэлгүй, амарлингуй сэтгэл болж дээшлэн одно. Чингэхдээ эхлээд дүрс, дуу зэрэг гадаадын бүдүүхэн үзэгдлүүд дээр тэр адилаар ургана. Бясалгаж дадаад ирэхээр эцэстээ оронт болох

мэдрэхүй, сэрэхүй зэргүүд дээр урьдын намба байдлууд нь дэвэрч одох бөгөөд сэтгэлээ түүнд тушаав ч огтхон ч тогтож тэсэхгүй байдлууд гарна.

Гэвч тийм нөхцөлд хоёр үгүй тэр ямагт чанарыг оносон үзэл оллоо гэх буюу хэсэг бусаг тэр адилын үзэгдэл гарах үед төв үзлийн аймгаас номносон илбэ адилын утга зэргийг онохтой өчүүхэн төдийй ч адилтгаж болохгүй. Үзэл онолд ухаан зүглээгүй хирнээ сэтгэлээ тогтоох бясалгалыг урт хугацаанд судлах явцад иймэрхүү үзэгдэл олонтаа ургах бий. Иймээс дээр номносон дагуу илбэ адил утгат мөн байна гэдэг нь өөрийн мөн чанараар байхгүй гэж лавтай магадалсан ухаарал болон үзэгдэл нь мэлзэлтгүй болсон нэрийдэх шалгадгаар баригдсан байх хоёрт шүтэж байж ургах хэрэгтэй.

Сэтгэлийн нигуурт дүрс зэргүүд солонго адил нимгэн, маш тунгалаг байдлаар ургах нь торох, тулахын хүрэлцэхүйгээс хагацсан болохоор тэр биз. Торох, тулах зүйл байхгүй ч гэсэн үзэгдэл мөр хоёр чуулсан төдий буюу. Тийм магадлалд өвөрчлөнгөөр байхгүйг мэдсэн ухаарал ерөөс байхгүй билээ. Хоригдохуун-өвөрчлөн болоод торох хүрэлцэхүй хоёрыг нэг гэж үзээд л өвөрчлөн байхгүй гэдэг нэр зүүсэн хэрэг.

Чингэлгүйгээр тэдгээрийг төв үзлийн аймгаас номносон илбэ болон хуурмаг утгаар үзвэл солонго, нимгэн утаа зэргийн ялгах суурь дээр байна гэж үзэж тэдгээрт өвөрчлөн байна гэж барих атгаг төрөхгүй болоход хүрнэ. Ялгах сууриа байна гэж үзэх ухаарал тэр ямагтыг магадалсан, өвөрчлөн үгүйг оносон гэж үзэх болно. Мөн хүрэлцэх орноо ялгах суурь гэж барьчихаад түүнийг өвөрчлөн байхгүй гэж магадлах учиргүй. Ялгах суурийг ухаарах тэр нь өвөрчлөнгөөр байна гэж барьж буй хэрэг. Дүрс тэргүүтэн тэр мэт ургахын цагт нимгэн, тунгалаг байдлаар ургах тэр байдлууд нь тэдгээр вишай орнуудыг жам ёсоор буй гэж үзэх ухаанд вишайгаа өчүүхэн төдий ч сөхөөхгүйгээр ургаж буй тул илбэ адилын утгат биш ээ. Өмнө нь зөв үзэл онолыг олоод мартаагүй байх үед илбэ адилаар ургана гэж дээр номносон билээ.

Гэвш Гонбавагаас дамжсан "*Бодь мөрийн зэрэг*"-ээс хоосон чанарын бясалгал төрөх талаар үзэхдээ: Эхлээд бодгалийн "би-үгүй" чанарыг бясалгана. Дараа нь номын "би-үгүй"-н утгыг дурдан санаж ухамсар зэргээр сахиулж бясалгана. Бясалгалын тасалгааг хэтэрхий уртасгаваас дурдан санахуйд ба ухамсаргад баригдахгүй болох тул заримдаа живэх, заримдаа дошигрох зэргээр одох тул дорвижилгоо бага гарна. Тиймээс үдээс өмнө, үдээс хойно, үдэш, үүрээр зэрэг дөрвөн тасалгаа бүрт дөрөв, дөрвөөр болгож нэг өдөрт арван зургаан тунгаар бясалгана. Тодорхой болохын буюу бясалгахын чадал буураад ирвэл завсарлаарай. Тийн удаан хугацаанд

бясалгалгүй нүдээ нээж харах буюу өдрийн тунг бага бага хувааж бясалгавал сэтгэлд эзлэгдээд ирнэ. Удаан бясалгана гэвч харвaас юу ч харагдахгүй, үзвээс юу ч үзэгдэхгүй болох бий. Сэтгэл эзлэгдээд ирэхийн цагт үйлдвээс нисваанис багасч нойр ч хүрэхгүй байх бий. Цаашлаад ирэхээр үдээс өмнөх зэргийн тасалгаа уртасч дөрвөн бэлэг чанар төгөлдөр болно. Үүнд:

1. "Үл атгаглах" гэдэг нь бясалгаж суухад гадагш, дотогш гүйх амьсгалууд мэдэгдэхээ больж, амьсгал болон атгагууд маш нарийн байдалд одно.

2. "Тодорхой болох" гэдэг намар цагийн үд дундын наран болон мөн цагийн огторгуйн хотол мандалтай адил гэгээлэг болж гэрэлтэнэ.

3. "Тунгалаг" болохын хувьд цэвэрхэн ёроолтой саванд ус хийгээд наранд тавихад тув тунгалаг харагддаг шиг болно.

4. "Нарийн болох" нь дээрх гурван бэлэг чанарын агаараас харахад тасарсан ганц ширхэг үсийг хүртэл тодорхой хардаг болно. Тэр бүхэн үл атгаглах билгэ билиг төрөхийн даган зохилдсон зүгүүд бөгөөд үл атгаглах билгэ билигтэй харьцуулбал өөрийн мөн чанарыг атгаглах учраас чанх буруу болно" хэмээжээ.

"Төв үзлийн хязгаар"-аас: "Даган зохилдсон ч чанх буруу" хэмээн мөн болохыг айлджээ. "Төв үзлийн хязгаар"-аас айлдсан дагуу эгэл төрөлхтний хоосон чанарын сайн бясалгалууд нь даган зохилдсон учраас тул "чанх буруу" гэж тооцогдох аж. Бусад бэлэг чанарууд нь төрөөгүй байсан ч дээр номносон дагуу зөв үзлийн утгыг бясалгаваас "би-үгүй"-н утгыг бясалгасан болно. Зөв үзлийг нотлон буулгах утгыг эс бясалгаваас дээрх дөрвөн бэлэг чанар төрсөн байсан ч магад утгыг бясалгал болж чадахгүй. Тиймээс үнэмлэхүй утгыг бясалгасан болох уу, үгүй юү гэдгийг дээр номносон дагуу авна. Түүнийг бясалгасны дараагаар илбэ адилаар ургах ёсыг дээр номносон дагуу ухаарч аваарай.

3. Амарлингуй сэтгэл, улэмж үзэхүй ухаан хоёр хослон барилдах ёсон

Тэр хоёрын бүтэх хэмжээг заах үед номносон мэтээр амарлингуй, үлэмж үзэхүй хоёрыг олоогүй бол хослон барилдах үндэс ирэхгүй тул хослон барилдуулахад тэр хоёрыг заавал олсон байх хэрэгтэй. Энэ талаар "Хэзээ үлэмж үзэхүйн эхнээс л хослон барилдсан байх учиртай. Тэр талаар өмнө нь амарлингуйд шүтэж шинжлэх бясалгалыг үйлдэх ба хянамгайлан орох зэрэг дөрвөн сэтгэлдээ үйлдэх бясалгал зэргийг үйлдсэнээр төрөх учрыг дээр айлдсан тул дээр номносон мэт сэтгэлдээ үйлдэх дөрвөн бясалгал төрөх цагт хослон барилддаг байна. Чингэхдээ шинжлэх бясалгал бүтээсний

дараагаар агуулах бясалгал үйлдэх зэргээр буюу, тийнхүү судалсаар олсон амарлингуй энэ маань тэр адилаар агуулах бясалгал болон урваж байгаа хэрэг. Тэр талаар, *"Сонсогчийн газар"-аас:*

"Чухам хэрхэн амарлингуй сэтгэл болон үлэмж үзэхүй хоёр ижилсэж, тэгш барилдаж орох вэ?, Чухам юугаар нь хослон барилдсан мөр гэх вэ? хэмээвээс, Өгүүлрүүн: Сэтгэлийн есөн оршихуй зэргээс энэ мэт болой, Тэгш агуулах есөн зүйлийг олох бөгөөд бясалгал самадийг төгөлдөр бүтээх түүнээ шүтэж номыг тийн ялгагч-үлэмж билиг ухаанд хичээж үйлдэх буюу. Тэр цагт номын тийн ялгагч түүний мөр болох өөр өөрийн ая зөнгөөр орох, хичээл шамдалгүйгээр орох буюу. Амарлингуй мөртэй адил илт хуран мэдэл байхгүй тул үлэмж үзэхүй нь огоот ариусах, огоот гэгээрэх, амарлингуйг даган одох, амгалантай амсуургаар төгс эзлэгдэх буюу. Тиймээс түүний амарлингуй болон үлэмж үзэхүй хоёр ижилсэх, тэгш орох, амарлингуй үлэмж хоёр хослон барилдахын мөр хэмээсэн хэмээжээ.

"Бясалгалын төгсгөлийн зэрэг"-ээс:

Хэзээд живэх, дошигрохоос аглаг холдсон тул сэтгэл тэгш орших ба өөр өөрийн ая зөнгөөр орох буюу тэр ямагт чанарт сэтгэл машид тодорхой болж, тэр цагт шамдал суларч тэгш орших болдог. Тэр цагт л амарлингуй болон үлэмж үзэхүй хослон барилдсан мөр бүтэх мөн хэмээжээ.

Ямар болвол тэдгээрийг хослон барилдсан гэх вэ? Тэр адилыг олохоос өмнө тус тус атгалан агуулах бясалгал нь өөрийн хүчээр үл атгаглаж орших ганц хувийг ч татаж чадахгүй. Харин агуулах, шинжлэх хоёр бясалгалд тус тус шамдаж бясалгаж чадах хэрэгтэй байдаг. Тиймд тус тус онох шинжлэх бясалгал үйлдэж тэр хоёрыг олсноор л амарлингуйдаа татагдаж хослон барилдсан болно. Энэ үед шинжлэх гэдэг нь үлэмж үзэхүй болно. Эцэстээ хүрсэн шинжлэл нь хоосон чанарыг тухайлсан ялгамжаат амарлинуй сэтгэл болно. *"Билиг барамидын үвдис"-аас ч:*

Түүний дараагаар тийн атгаглах сэлтэст дүрс, хөрөг тэдгээрийг бодох буюу. Тэрхүү сэтгэлээ хэзээд ч үргэлжлүүлэх ба завсаргүйгээр сэтгэлдээ үйлдэх үргэлжлэл хоёуланг анхааран бясалгах тэр цагт амарлингуй болон үлэмж үзэхүй хоёр хослон барилдсан мөр хэмээх буюу. Амарлингуй болоод үлэмж үзэхүй хоёр нь хос буюу. Барилдах нь төгс төгөлдөр буюу. Инагш, чинагш хүлэгдэн (татагдаж) орох болой хэмээжээ.

"Завсаргүй" гэдэг нь шинжих бясалгалын залгааг орхиж үл атгаглах

агуулалгүй, тэрхүү шинжих бясалгалаар үл атгаглаж татах болой. "Хоёулаа анхааран бясалгах нь" үл атгаглаж дүрс хөргөнөө тухайлах, үлэмж үзэхүй хоёуланг анхааран бясалгах буюу. Гэхдээ нэг цагт бус. Сэтгэлдээ үйлдэн бясалгахдаа завсар гаргалгүй үргэлжид бясалгах болой.

Асуулт: Чингэвэл өмнө нь амарлингуйг бүтээчихээд тус тус онох, шинжих бясалгалаар тогтох хувийг бүтээх гэж номносонтой харшлах болох уу?

Хариулт: Тэр нь амарлингуйг бүтээхгүй байхад дахин дахин шинжсэний эцэст агуулахыг ээлжлэн үйлдээд ч амарлингуй бүтэхгүй. Харин амарлингуйг олчихоод тийн үйлдвэл бүр ялгамжаатай амарлингуй болохыг үзүүлсэн тул харшлахгүй болно. Мөн үлэмж үзэхүйг бүтээхийн өмнө тэр даруйдаа шинжих бясалгалаар нэгэн үзүүртийг татаж чадах нэг үе байх тул түүнийг мөн санана. Үлэмж үзэхүй төрөхөөс өмнө ч дахин дахин ажигласны эцэст ээлжлэн үйлдээд ч амарлингуй төрнө гэж байхгүй. Амарлингуйг олоод ч шинжлэх бясалгалаар үл атгаглахыг татаж үл чадах тул дээр номносон энэ нь тэрхүү ялгааг гаргахын өмнө буюу өмнө нь төрөөгүй байх үеийн эрхэнд авч үзвэй.

Товчилвоос, Амарлингуй төрөөгүй байхаас өмнө нь ганц нэг тогтоох төдийгөөр шинжсэний эцэст тогтоох бясалгал үйлдсэнээр амарлингуй сэтгэл төрөх бус аа. Амарлингуй сэтгэлийг бүтээчихээд үлэмж үзэхүй эс төрөхийн өмнө шинжих бясалгалаар ч нэгэн үзүүрт тогтоох хувь баттай гарах бөгөөд өөрийн хүчээр ажиглан шинжих тэр зэргээр тогтох хувь баттайг олох нь үлэмж үзэхүйг олсны дараа ирэх тул хослон барилдсан гэдгийг эндээс агуулах мөн. Тиймд "үл мяралзан тогтсон усны дээр жараахай цовхчих" адил баттай тогтсон үл атгаглах сэтгэлийн үзүүрийг ч олоогүйн агаараас, "би-үгүй"-н утганаа тус тус шинжилж болно хэмээх хоёрын нийлбэрийг амарлингуй, үлэмж үзэхүй хоёр хослон барилдлага гэж бүү эндүүрээрэй. Тиймээс амарлингуй, үлэмж үзэхүй хослон барилдах жам ёсны тухай гол номууд, үндэс тэдгээрээс үзүүлсэн дагуу мэдээрэй. Тийнхүү буюу гүтгэж, бас тасархай өгүүлсэнээ сэтгэл бататгаж бүү үйлд. Иймийн тул амарлингуй, үлэмж үзэхүйг бясалгах ёсны олон ялгамжаа байдгийг ялгах хэрэгтэй мэт үзэгдэвч үг олон болох вий хэмээн эмээж үл бичвэй.

4. ЕРӨНХИЙ УТГЫН ХУРААНГУЙ

Эдүгээ мөрийн утгыг ерөнхийлөн хурааж өчүүхэн өгүүлсүгэй. Эхлээд мөрийн язгуур нь буяны садныг шүтэх ёсноо тулах тул түүнийг лавлан мэд. Түүнээс чөлөө учралын шимийг авахыг хүсвэл завсаргүй нэгнийг төрүүлж, түүнийг үргэлжид бүтээхээр дотроосоо шаардаж, улмаар төрүүлэхийн тулд чөлөө учралын аймгийг бясалгана. Улмаар энэ насыг чухалчлах ухааныг эс буцаавaас хойд насаа чухалчлахгүй болно. Тийн бодол хүчтэй төрөхгүй учир бие олоод өнө удаан суулгүй мөнх бусыг үзүүлэх болон үхсэний дараа муу заянд тэнэх ёсыг бясалгаж хичээ. Тэр цагт аюулыг дурдан санах зөв ухаан төрснөөр гурван авралын эрдмийг зүрхний мухраас санаж магадлах сэтгэл төрнө. Нийт бусын авралыг одуулж түүнээ тангараглан түүний суртгаалд суралцаарай. Мөн цагаан зүгийн ном бүгдийн их суурь болсон үйлийн үрд сэтгэл итгэмжлэх сүсгийг олон үүднээс үүсгэн баттай болгоно. Арван цагаан буян, арван хар нүгэлд орох, буцахыг ухаарах оюунд шамдаж, дөрвөн хүчний мөрийг үргэлжид үйлдээрэй.

Тэр мэтийг бага төрөлхтний номын аймгийг дотор багтааж орчлон нийтийн болон тус тусын зовлон гэм бурууг олонтаа санана. Нийт орчлонд шунах ухааныг юу чадахаар буцаана. Цаашлаад зовлонт орчлон чухам юунаас үүдэх, түүний үндэс болсон үйл, нисваанисын мөн чанарыг танин мэдэж аваад түүнийг тэвчих засваргүй нэгэн эгээрлийг үүсгэнэ. Орчлонгоос гэтлэх мөр болон гурван суртгаалын талаар ерөнхий магадлал олно. Ялангуяа өөр өөрийн алин авсан тус тус гэтлэхүйн шагшаавадад шамдана.

Тэр мэт дунд төрөлхтний тийн номын аймгуудыг дотроо багтааж ухаарсны дараа "өөрөө орчлонгийн далайд унасан тэр адил"-аар эх болсон амьтан тэр адил болсоныг сэтгэлдээ тунгааж асрахуй болон нигүүлсэхүй сэтгэлээс үүдэх бодь сэтгэлийг судлахаар, түүнийг төрүүлэхээр шамдах хэрэгтэй. Тэр сэтгэл төрөхгүй бол "зургаан барамид" болон "хоёр зэрэг" тэргүүтэн нь "суурь тавилгүй байшин барих гэсэнтэй адил" болно. Түүнийг бага сагаар анхааран мэдэх болвоос зан үйлээр авах бөгөөд түүний суртгаалд шамдах баттай ерөөлийг тавиарай.

Цаашлаад бодисадвын агуу явдлыг сонсож орох, буцахын завсрыг сайтар мэдэж, суралцах хүслийг хүчтэй хатуу үүсгэнэ. Тэдгээр бодлууд төрвөөс орохуйн тангарагийг зан үйлээр барь. "Өөрийн үндсийг боловсруулагч зургаан барамид" хийгээд "бусдын үндсийг боловсруулагч дөрвөн хураангуй" зэрэгт суралцана.

Ялангуяа язгуурын унал зэрэг гарваас амь лугаа тэнцүүлэн баттай сэргийлэхээр шамд. Их бага цувирал, гэмт явдал зэргээр үл халдагдахын төлөө шамдаж халдсан болвоос жич засахын арганаа шамд. Цаашлаад сүүлийн ялгамжаат хоёр барамидад суралцах хэрэгтэй. Тиймээс бясалгал дияаныг судлах ёсноо мэргэжин бясалгал бүтээнэ. Хоёр "би-үгүй" үзэл буюу мөнхийн, тасархайн туйлаас хагацсан зөв үзэл нэгийг үндсэндээ төрүүлэх, олох, тэр үзлээ баримтлан бясалгах ёсыг зөвөөр ойлгон бясалгана. Тэр мэтийн бясалгал болон билиг хоёрт амарлингуй, үлэмж үзэхүй хоёрын нэр зүүсэн бөгөөд сүүлийн хоёр барамидаас өөр тусгай үйлдэх зүйл үгүй тул бодисадвын санваарыг аваад түүний суртгаалд суралцах ёсноо ирэх болно.

Иийхүү дээд, доод мөрийг бясалгаж чадсанаар л дээш дээшхи мөрийг олохын хүсэл их төрдөг тул дээш дээшхи бүтээхийн тулд доод доод мөрөө бүтээх хүсэл ч дээшлэн одох нэгэн гарваас аньстай болно. Урьд мөр нь юу ч байхгүй хирнээ ганц нэг сэтгэл тогтох төдий буюу үзэл онолыг ухаарах төдийгөөр хамаг хүчээрээ зүтгэвэл аньстай болох нь маш бэрхтэй тул төгс төгөлдөр нийтийн мөр нэгэнд тууштай магадлал олох хэрэгтэй. Тэдгээрийг бясалгах цагт ч атгагаа арилгаж, ухаанаа тэгш хуваарилж үйлдэх хэрэгтэй.

Чингээд мөрд хөтлөгч буяны саднаа багавтар биширвээс сайн буяны хамаг чуулганы үндэс тасрах тул шүтэх ёсноо шамд. Тэрчлэн бүтээх ухааны ир чадал мөхөсдвөөс чөлөө учралын аймгийг үз. Энэ насанаа шунах явдал ихэдвээс мөнх бус болоод муу заяаны гэм эргүүг голчлон бясалгах хэрэгтэй. Ам авсан тангарагаа алгасрах үзэгдвээс үйлийн үрийг өчүүхэн ухаарч дээ гэж санаад үйлийн үрийг голлон бясалгана. Орчлон даяарт бага уйсах аваас нирвааныг чухалчлах бодол бага байгаа хэрэг тул орчлонгийн зовлон зүдгүүрийг санана. Амьтны тусыг үйлдэх бодол хүчтэй нэгэн яагаад ч төрөхгүй үзэгдвэл их хөлгөний үндэс тасрах тул ерөөхүйн бодь сэтгэл, түүний үндэс язгуурт олонтаа суралцана.

Бодисадвын тангаргийг аваад явдалд суралцахдаа ч бэлгэс барих хүлээс хүчтэй үзэгдвээс язгуурын ухаанаар бэлгэст барих болон илбэ адилын хоосон чанарыг судлаарай. Сэтгэл нь буяны бодолд үл суух алгасралын боол болох нь үзэгдвээс нэгэн үзүүрт тогтоон барих явдлыг голлон бясалга хэмээн дээдэс мэргэд айлджээ. Үгээр жишиж номноогүй зүйлийг ч мэдэж аваарай. Товчилвоос, сэтгэлийн үндэс юугээ хаашаа ч хамаагүй зүгт зоргонд одуулалгүй, хамаг буяны зүгт жолоодож сурах хэрэгтэй билээ.

("Их төрөлхтний мөрийн зэрэг"-ээс бодисадвын явдалд суралцах ёсны билгийн мөн чанарт үлэмж үзэхүй ухаанаар хэрхэн бясалгах ёсыг номновой)

6. ЯЛАНГУЯА ОЧИРТ ХӨЛГӨНӨӨ СУРАЛЦАХ НЬ

Тийнхүү Судар (сутра), дандар (тантра) хоёрын "нийтийн мөр"-ийг судалсны дараагаар эргэлзэлгүйгээр "Нууц тарнийн хөлгөн"-өө (самг: tantrayana) ороорой. Энэхүү мөр нь буюу маш ховор чухаг ном бөгөөд хоёр буяны чуулганыг түргэнээ төгс төгөлдөр үйлдэх бөлгөө. Түүнээ орох талаар *"Мөрийн зул"*-аас айлдсан мэт эхлээд багшийг өргөн хүндлэх, зарлигийг бүтээх зэргээр баясгах зэргийг дээр номносноос ч үлэмж илүү нэгийг бүтээх хэрэгтэй. Тэр талаар түүнээс номносон бэлэг чанар наанадаж бүрэн нэгнээ тэр мэтийг үйлдэх хэрэгтэй. Цаашлаад эхлэн боловсруулагч дандрын аймаг, гарвалаас номносон нэгнээр үндсээ боловсруул. Түүнээс тэр цагт авсан тангараг, санваарыг сонсож мэдэж сахь. Язгуурын унал тэргүүтэн халдаж дахин авах байвч мөрийн эрхэм үндсэнд төрөх нь их удаашрах тул түүгээр халдаахгүйн төлөө баттай шамдан үйлд. Бүдүүхэн уналаар үл халдаахгүйн төлөө шамдах бөгөөд хааяа нэг халдваас жич засах арганаа шамд. Эдгээр нь мөрийг бясалгахын суурь мөн тул тэдгээр нь байхгүй бол суурь нь ялзарсан байшин адил болно. *"Манзуширын язгуурын үндэс"-нээс:*

Шагшаавад цалхайрснаа бурхан бээр
Тарнийн ном бүтнэ гэж айлдаагүй буюу

хэмээх зэргээр их, дунд, бага бүтээл аль нь ч төрөхгүйг айлджээ. Ханьцашгүй егүзэрийн үндэснээ ч тангаргийг үл сахих, авшгийг бага хүртсэн, хоосон чанарыг мэдэхгүй гуравт хураасан ч тангараг санваар байхгүй хирнээ мөр бясалгал хэмээн өгүүлдэг нь тарнийн ёсноос хол тэнэсэн хэрэг болно. Тэр мэт тангараг санваарыг сахисан тэрбээр тарнийн мөрийг бясалгаж үйлдэнэ.

Эхлээд дандрын аймгийн үндэснээс үүсэх зэргийн бурхадыг хүрдийг бүрэн гүйцэд номносон дагуу бясалгах хэрэгтэй. Дандрын мөрийн нийт бусын тэвчигдэхүүн нь цогцос, язгуур, төрөн түгэхүйд "өөрийн дураар шунах" буюу "эгэлд үзэх атгаг" билээ. Түүнийг тэвчихэд орон, бие, төгс эдлэлээ ялгамжаатай үзэгдэл болгон үйлдэх нь "Үүсгэлийн зэрэг" болно. Тэр мэт эгэлийн атгагийг арилгах, түүгээр бурхан бодисадва нар цаг үргэлжид адиститлэх бөгөөд хэмжээлшгүй буяны чуулганыг амар хялбар төгсгөж үйлдэх тул төгсгөлийн зэргийн сав болдог. Цаашлаад дандрын аймгийн үндэснээс гарсан дагуу "Төгсгөлийн зэрэг"-ийг бясалгах хэрэгтэй. Эхний зэргийг орхиод хойдхийг хураасан төдий мөрийн хувь нижгээд төдийг судлах нь дандрын аймаг болон тэдгээрийн таалдыг тайлбарласан мэргэдийн таалал биш болой.

Тиймээс ханьцашгүй егүзэрийн мөрийн бие төгс төгөлдөр болсон хоёр зэргийн увдисыг барьж үйлдээрэй. Энд эдгээрээр нэр төдий үүднээс дандрын ёсноо орох зүг төдий нэгийг үзүүлсэн болой. Дэлгэрэнгүйг *"Нууц тарнийн мөрийн зэрэг"*-ээс мэдэх хэрэгтэй. Тэр адилын ёсоор суралцвaас судар, дандрын аньс бүхнийг хураасан, мөрийн бие огоот төгс төгөлдөр ёсноо суралцаж чөлөө учрал олсоны хэргийг төгс үйлдэх бөгөөд Ялгуугсаны үзүүлсэн дээдийн ном их эрдэнийг өвөр, бусдын үндэснээ дэлгэрүүлэн үйлдэх чадалт болмой.

Төгсгөлийн туурвил буюу ерөөл

Тоолшгүй олон Чадагчийн эрхэм зарлигуудыг үзэгч ганц нүд хэдий ч
эрхэм ном бүхнийг
Ёсчлон сайтар мэдэх, мэдэл төгөлдөр бүхнээ баясал төрүүлэх энэ,
энэ адилын ёсноо маш мэргэшсэн
Буяны садныг шүтэж анхдугаар бурхан Манзушир алин,
алин түүнийг авралд сайтар бариваас
Түүний хүчээр болох мөн ахуй ёсыг ялган ухаарч ихэд мэргэшсэн,
мэргэдийн дээд тэрээр үргэлжид тэтгэхтүн

Замбуу тивийн мэргэд бүхний оройн чимэг
Яруу алдрын дуаз амьтан бүхнээ ив илхэн
Нагаржунай, Асанга хоёроос зэрэгчлэн явсаар
Сайтар дамжиж ирсэн *"Бодь мөрийн зэрэг"* нь

Хамаг амьтны горилыг хоцроолгүй хангагч болохоор
Их эрдэнийн увдисын эрхэт хаан буюу
Эрхэм зарлигийн мянган мөрөн хурсан учир
Цогт сайн номнолын далай буюу

Агуу их бандида Дивингарашризана бээр
Асарлах Цаст уулын орноо тодруулан зохисноор
Энэ л газарт Ялгуугсадын сайн мөрийг харах нүдэн
Өнө удаан хугацаанд сүүмийж аньсангүй иржээ

Тэр цагаас дээдийн номны аньс бүхнийг
Тэтгэн болгоосон мэргэд барагдсаар
